МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ ОРЧУУЛГА, ТАЙЛБАР

Зохиогч
Далантайн Цэрэнсодном

Редактор Д.Төмөртогоо

Үзэмжийг эрхэлсэн **Ц.Сүмбэр**
Хэвлэлийн эх бэлтгэгч **Г.Болд**
Зураач **Ц.Сүмбэр**

Мөнхийн үсэг хэвлэх үйлдвэрт хэвлэв.
Цаасны хэмжээ 60х90 / 16
Хх. 25

Шинжлэх Ухааны Академийн
Хэл зохиолын хүрээлэн

Д.Цэрэнсодном

Энэхүү сурах бичгийг Азийн Хөгжлийн Банкны туслалцаатайгаар хэрэгжиж буй "Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр"-ийн хүрээнд зохиож санхүүжүүлэв.

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОРЧУУЛГА, ТАЙЛБАР

Редактор, проф. Д.Төмөртогоо

Монголын Их Дээд Сургуулиудын Консорциум
Дээд боловсролын сурах бичгийн зөвлөлийн хамтарсан хурлаар хэвлэхийг зөвшөөрөв.

Улаанбаатар 2000

ACADEMY OF SCIENCES OF MONGOLIA
INSTITUTE OF LANGUAGE AND LITERATURE

by DALANTAIN TSERENSODNOM

TRANSLATION AND NOTES TO THE SECRET HISTORY OF THE MONGOLS

Edited by Prof. D. TÖMÖRTOGOO

ISBN 99929-5-174-5

БНМАУ
Н

II 6745/04

ГАРЧИГ

ОРШИЛ 5

УДИРТГАЛ 9

"МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО" 29
(*Орчин цагийн монгол хэлний орчуулга*)

᠊ *Нэгдүгээр бүлэг* 30
᠋ *Хоёрдугаар бүлэг* 43
᠌ *Гуравдугаар бүлэг* 56
᠍ *Дөрөвдүгээр бүлэг* 71
᠎ *Тавдугаар бүлэг* 83
᠏ *Зургадугаар бүлэг* 96
᠐ *Долдугаар бүлэг* 110
᠑ *Наймдугаар бүлэг* 124
᠒ *Есдүгээр бүлэг* 139
᠓᠐ *Аравдугаар бүлэг* 151
᠓᠊ *Арван нэгдүгээр бүлэг* 162
᠓᠋ *Арван хоёрдугаар бүлэг* 176

Үг хэллэгийн тайлбар 190

Тайлбарласан үг хэллэгийн хэлхээс 367

Ном зүй 377

TABLE OF CONTENTS

PREFACE 5

INTRODUCTION 9

THE SECRET HISTORY OF THE MONGOLS
/Scientific translation in modern Mongolian/ 29

᠑ Chapter One 30

᠒ Chapter Two 43

᠓ Chapter Three 56

᠔ Chapter Four 71

᠕ Chapter Five 83

᠖ Chapter Six 96

᠗ Chapter Seven 110

᠘ Chapter Eight 124

᠙ Chapter Nine 139

᠑᠐ Chapter Ten 151

᠑᠑ Chapter Eleven 162

᠑᠒ Chapter Twelve 176

Notes to the translation 190

Index to Footnotes Words 367

Bibliography 377

ОРШИЛ

Монгол туургатны оюуны бүтээлийн бахархал болсон "Монголын нууц товчоо" нь орчин үеийн соёлт хүн төрөлхтний сайн мэдэх эрхэм зохиолын нэг билээ. Эдүгээ энэхүү гайхамшигт дурсгал бичгийг монголын судлал хөгжсөн улс орнуудад өргөнөөр судлаж байгаагийн дээр англи, герман, орос, польш, солонгос, түрэг, унгар (мажаар), франц, хасаг, хятад, чех, япон зэрэг дэлхийн олон хэлээр орчуулсан байна.

Бас нэгэн бахархан тэмдэглэвээс зохих зүйл бол уг дурсгалын 750 жилийн ойг тохиолдуулан НҮБ-ийн боловсрол Шинжлэх ухаан, Соёлын асуудал эрхэлсэн байгууллагын (UNESCO) гүйцэтгэх товчооноос "Монголын нууц товчоо"-г Дорно дахины түүх, утга зохиолын агуу их дурсгал, уран сайхан, гоо зүй, яруу найргийн шинж чанар, хэлний баялгаараа монголын утга зохиолын түүхэн дэх хосгүй үзэгдэл, дэлхийн үгийн урлагийн нэгэн алтан сан хэмээн өндөр үнэлээд түүний орчуулгыг дэлхий дахины сонорт хүргэх тогтоол гаргасан явдал билээ.

Сүүлийн үед олон улсын "Нууц товчоо" судлалын цар хүрээ өргөжиж, эрдэм шинжилгээний чухал чухал бүтээлүүд гарч байгаагийн дотор нангиад галиг үсгийн эх бичгийн алдаа мадгийг нь ариутган шүүсэн сайн эх ч хэвлэгдэн гарлаа. Түүнээс гадна Өвөрмонголын Багшийн Их сургуулийн эрдэмтэд сүүлийн хэдэн жил сурвалжлан олсон "Нууц товчоо"-ны хэд хэдэн хуулбарыг манай хоёр орны "Монголын нууц товчооны иж бүрэн судлагаа" хэмээх хамтын төсөлд оруулахаар бэлтгэж байна. Ийм нөхцөл байдал нь "Нууц товчоо"-ны судлалыг урагш ахиулах сайхан бололцоог нээгдүүлж байгаа юм.

Эрдэм шинжилгээний залуу ажилтан, багш, оюутан нар хийгээд эртний түүх соёлоо мэдэхийг эрмэлзсэн хэн бүхнээ зориулж

бид "Нууц товчоо"-ны эрдэм шинжилгээний чанартай орчуулгыг хийхсэн гэдэг санааг хэдийнээс өвөрлөн явсан боловч чадал, завдал хоёрын аль аль нь дутагдсаар ирлээ. Харин 1987 онд олон улсын монголч эрдэмтдийн Үх их хурал хуралдахын өмнөхөн БНМАУ-ын ШУА-ийн дэргэд "Монголын нууц товчоо" судлах ажлын хэсэг байгуулагдаж , эл дурсгал бичгийн галиг үсгийн эх, утгын зүйл хуваасан толь, эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, "Нууц товчоо"- Монгол хэл шинжлэл, уран зохиол, түүхийн дурсгал болох тухай иж бүрэн судалгааны бүтээл туурвихаар шийдвэрлэсэн нь манай орны "Нууц товчоо" судлалын ажилд чухал түлхэц болсон юм.

Дээрх төлөвлөсөн ажлын II боть буюу Монголын нууц товчооны эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар гэсэн сэдвийг надад хариуцуулсан билээ. Өөрийн мэдлэгийн хэр хэмжээнээс хэтэрсэн ийм нарийн төвөгтэй ажлыг зориглон барьж авч 1988 оны эхээр арван бүлгийн орчуулгын анхны ноорогийг дөнгөж гаргаад байтал миний бие Бээжин Их сургуульд монгол хэл бичгийн багшаар томилогдов. Ийнхүү шинэ газар, шинэ ажилд шилжээд "Нууц товчоо"-ны судалгаа эхний хэдэн сард алгуурлаж байсан боловч яваа яваандаа Мин улсын нангиад галиг хадмал орчуулгын утга санааг таньж мэдэх таатай сайхан боломж нээгдэж дундад эртний монгол хэлний зарим дурсгалыг Турфаны олдвороор судалсан өчүүхэн туршлага дээр маань БНХАУ ын номын олон сайн нөхдийн хятад хэлний баялаг нь мэдлэг нэмэрлэж энэ хэрээс хэтэрсэн ачааг дааж давах хүч тэнхээ хайрлсаны ачаар "Монголын нууц товчоо"-ны орчуулга тайлбар хэмээх зохиолын ард нь гарч уг орчуулгын анхны эхийг "Цог" сэтгүүлийн 1990 оны эхний хэдэн дугаарт нийтлүүлж улмаар удиртгал тайлбар тэргүүтнийг хавсаргасан нэгэн иж бүрэн дэвтрийг 1993 онд Бээжин хотноо монгол үсгээр хэвлүүлсэн билээ.

1993 онд хэвлүүлсэн эл ном нэгэнт ховордсоны дээр манай өнөө үеийн уншигчдын олонхи нь хуучин монгол бичгээр уншихдаа

ядмагхан тул уг номыг өөрийн орны уншигчдын өргөн хэрэгцээг бодож тайлбар сэлтийг бага сага баяжуулан шинэ монгол үсгээр хэвлэлд бэлтгэв.

Эл оршил үгийн төгсгөлд "Монголын нууц товчоо"–ны хөрвүүлгийнхээ арга зарчмын талаар товч танилцуулъя.

Миний бие "Нууц товчоо"-ны орчин цагийн монгол хэлний хөрвүүлгийг монгол улсын их, дээд сургуулийн монгол хэл бичгийн багш, оюутан, эрдэм шинжилгээний ажилтан нар хийгээд ер монгол үндэстний түүх, утга зохиолыг сонирхон судлагч хэн бүхнээ зориулан бэлтгэхдээ Өвөрмонголын Багшийн Их сургуулийн проф. Баяр гуайн 1981 онд нийтлүүлсэн гурван ботийг гол тулгуур болгон Элдэнтэй, Оюундалай нарын 1980 онд хэвлүүлсэн хятад галиг үсгийн харьцуулсан эх, Цэнд гүн, акад. Ц.Дамдинсүрэн, Бөххишиг, Алтан-Очир, Дугаржав, Мансаан нарын орчин цагийн монгол хэлний хөрвүүлэг, Элдэнтэй, Ардаажав, Ш.Гаадамба, Б.Сумъяабаатар нарын "Нууц товчооны сийрүүлэг, тайлбар", проф. И.Рахевилзын "Монголын нууц товчооны үгийн цэс", проф. Ф.В.Кливезийн "Монголын нууц товчооны англи хэлний орчуулга" зэрэг олон бичиг дэвтрийг харьцуулан үзэж буулгав. Уг орчуулгыг хийхдээ аль болохоор нэг үг гээхгүй, нэг үг санаагаар нэмэхгүйгээр одоогийн уншигч нарт ойлгомжтой үг хэллэгээр буулгаж, танилцуулахыг гол зарчим болгов. Орчин цагийн монгол хэлний хэлзүйн байгуулал, өгүүлбэрзүйн онцлогоос шалтгаалж зарим тохиолдолд "Нууц товчоо"-ны эхэд байхгүй үг хэллэг нэмэх тохиолдолд дөрвөлжин хаалтанд, зарим үг ухагдахууныг тайлбарлаж нэмсэн үгийг дугуй хаалтанд оруулж бичсэнийг тэмдэглэе. Гэхдээ дундад эртний монгол хэл, орчин цагийн монгол хэлний өгүүлбэрийн зохиомж, найруулгаас шалтгаалж үгсийн байр солигдох, нэг үгийг заримдаа хоёр үгээр юм уу, нийлмэл үгээр хөрвүүлэх, аль эсвэл давтаж орсон ижил үгийг өөр адил утгат үгээр орлуулах зэргээр уул эхийн найруулгыг ямар нэгэн хэмжээгээр алдагдуулсан тал бий. Жишээлбэл "Нууц товчоо"-ны 56-р зүйлийн эхэнд: "...Чилэдү хурдан хубийн гуяыг нь дэлдэж огцом **дутааж**,

Онон мөрөн өөд **дутаав** " гэсэн маягтай өгүүлбэрт **дутаах** гэдэг үг хоёр орсоныг ойролцоо утгатай үгээр сольж, "...Чилэдү хурдан хулын гуяыг нь ташуурдан яаран зайлж, Онон мөрөн өөд дутаав" гэж найруулав.

"Монголын нууц товчоо" судлалын олон улсын эрдэмтдийн дийлэнх нь эдүгээ болтол хятад хадмал орчуулгыг шүтэж судлан шинжилсээр ирсэн тул 700 гаруй хуучирсан үг хэллэгт тайлбар бичихдээ юуны түрүүн хятад хадмал орчуулгад яаж буулгасныг нь тэр үеийн бичлэгээр нь хадаж, хятад хэл төсөөлөхгүй уншигч нарт зориулж хадмал орчуулгын утгыг монголчилж хаалтанд хийлээ. Гэхдээ "Нууц товчоо"-ны үгчилсэн хадмал орчуулгыг орчин цагийн монгол хэлнээ мөн үгчлэн буулгахад тэр бүр оновчтой, ойлгомжтой болсон биш байж болно. Ийм учраас эл хадмал орчуулгын утгыг шалган нягтлахад эрхбиш хятад үсгийн эхийг баримтлах нь зүйтэй гэдгийг уншигчдын сонорт толилуулж байна.

Энэ номын эхийг хэвлэлд бэлтгэсэн номын барилдлагат шавь ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Болд, нангиад үсгийг компьютерт суулгаж өгч тусалсан түүхийн хүрээлэнгийн магистрант Ян Хе-сүг (Ариунхишиг) нарт баярласан сэтгэлээ илэрхийлье.

Бас эл номыг хэвлүүлж оюутан, багш тэргүүтэн олны хүртээл болгоход санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Их, дээд сургуулийн консерциум, Дээд боловсролын сурах бичгийн зөвлөлд чин сэтгэлийн талархал дэвшүүлье.

Академич Д.Цэрэнсодном

Улаанбаатар 2000.6.6

УДИРТГАЛ

"Монголын нууц товчоо"-ны эхний арван дэвтэр Чингис (1162-1227) хааныг өөд болсоны хойтӧн шар хулгана жил (1228) зохиогдсон гэдэгт олонхи судлагчид санал нийлж байна. Мөн сүүлчийн хоёр дэвтрийг Өгөдэй (1186-1241) хааныг нас барсны дараа нэмж бичсэн гэж үзвээс "Нууц товчоо"-ны XI-XII бүлгийн зохиогдсон цаг хугацаа нь 1241 оны үест холбогдоно.

Монголын эзэнт улсын их хаадын алтан ургийн түүх "Нигуча тобчийан" хэмээх энэхүү дотоод шастир нь бидний мэдэж байгаа баримтаар Юань төрийг мөхөх хүртэл 140 гаруй жил нандин шүтээн мэт маш нууцаар хадгалагдаж байсан ажээ. Судлагчдын үзэж байгаагаар Мин улсын Хүнг Ү хааны үед эл дотоод шастирын нууцыг задруулсан цаг буюу барагцаалбал 1380-90-ээд оны үеэс "Монголын нууц товчоо"-г галиглах, орчуулах, барлах ажил эхэлсэн гэж үзвэл уг зохиолын судалгааг 600-аад жилийн тэртээгээс үүссэн гэж хэлж болно.

Бид энэхүү удиртгал өгүүлэлд "Монголын нууц товчоо"-ны эх бичгийн судлалд холбогдох зарим нэгэн асуудлыг хойно дурдах хоёр сэдвээр хөндөн ярихыг хичээв. Үүнд:

1. Нангиад галиг хийгээд хадмал орчуулгын түүхэн учир шалтгаан, түүний эрдэм шинжилгээний ач холбогдол,

2."Монголын нууц товчоо"-ны орчуулга, сэргээн буулгалтын товч тоймыг өгүүлэв.

1. "Нууц товчоо"-ны Нангиад галиг хийгээд хадмал орчуулга

Мин улсын үед монгол хэлийг сурч судлах нь удс төр, цэрэг, эдийн засгийн эрх ашгийн үүднээс зайлшгүй шаардлагатай

байсан учир "Монголын нууц товчоо"-г нангиад үсгээр галиглаж хадмал орчуулгатай барлаж, унших бичиг болгон хэрэглэж байжээ. Энэ үед "Нууц товчоо"-ноос гадна "Хуа и И ю" (華夷譯語), "Дэн тан би жиү" (登壇必究), "Жи мен фан ю кау" (蔪門防御考),"Бэй лио юи ю" (北虜譯語), "Лү лун сай лүе" (虜龍賽略) зэрэг мөн монгол үгийг нангиад үсгээр галигласан ба хадмал орчуулгатай толь бичиг гарч байсан нь монгол хэлийг суралцах хэрэгцээ ямар байсныг гэрчилж байна. Тэрчлэн "Мин улсын магад тэмдэглэл"-ийн дотор энэ ойлголтын талаар тодорхой өгүүлсэн байдаг байна. Жишээлбэл уг бичгийн Хүнг Ү-гийн 15-р оны (1882) цагаан сарын улаан нохой өдрийн тэмдэглэлд: "Бичгийн явдлын хорооны асран тайлбарлагч Хуо Йуан гиэ (Хуянгаа?) нарт "Хуа и И ю" бичгийг найруулагтун" хэмээн зарлиг буулгав. "... Хуо Йуан гиэ болон найруулагч Ма Ша Ихэ (Маш их?) нарт зарлиг болгон тэдний (монголчуудын) хэлийг хятадаар орчуулгав. Тийнхүү одон орон, газарзүй, хүмүүний явдал, бодисын зүйл, өмсөх идэх эдлэл хэрэгсэл тэргүүтнийг эс бүрдүүлсэн үгүй. Дахин "Юаны нууц товчоо"-г авчирж магадлал болгон үсгүүдийг нь таслан дуудлагад нь зохицуулав. Найруулан төгсмөгц зарлан хэвлүүлэн тархаажээ. Түүнээс элчин түшмэл умарт говь орноо одохуй ирэхүйд цөм тэдэнтэй нэвтрэлцэн чадах болов" (Хишигтогтох, 1988, 4, 22-23) гэж дурдсан байдаг байна. "Мин улсын магад тэмдэглэл"-ийн дээр иш татсан үгд Хуо Йуан гиэ, Ма Ша Ихэ нар Хүнг Ү хааны (1368-1398) зарлигаар "Хуа и И ю" толийг 1382 оноос найруулан зохиохдоо: **"Нууц товчоо"-г авч ирж магадлал болгон үсгүүдийг нь таслан дуудлагад нь зохицуулав"** гэсэн гойд сонирхолтой мэдээг бидэнд хэлж өгч байна. Гэтэл эл мэдээний утга санааг судлагчид харилцан адилгүй ойлгосоор иржээ. Жишээлбэл японы нэрт эрдэмтэн Нака Мичиё "Чингис хааны магад тэмдэглэл (1907)"[1] удиртгал өгүүлэлдээ "Нууц товчоо"-г урьдаар авианы галигаар тэмдэглэсэн гэж таамагласан бол БНХАУ-ын эрдэмтэн Ван Гүве веи "Нууц товчоо"-г 1369 онд хятад хэлээр орчуулсан

товчоо" хэмээх гурван боть зохиолынхоо оршил өгүүлэлд: "Хуо Йуан гиэ нар монгол хэлний авиаг хятад үсгээр буулгахдаа Нууц товчоогоор хяналт хийв гэж энэ мэдээ тодолж байхаар үзвэл Нууц товчоонд аль хэдийн авианы орчуулгатай (галигтай) болсон байна" гэж үзээд "Монголын нууц товчоо"-ны нангиад галигийг 1382 оны "Хуа и И ю" толиос бүр өмнө Юань улсын (1260-1368) үед зохиогдсон гэдэг санал дэвшүүлжээ. Хэдий иймэрхүү харилцан санал зөрөөтэй ойлголт бий боловч олонхи судлагчид яавч Монголчуудын ноёрхож байсан Юань төр мөхөж Тогоон Төмөр (1320-1370) хаан 1368 онд Бээжингээс зугадан гарч Барс хот буюу Инг Чанг фү яаманд нэг жил гаруй болоод 1370 оны цагаан нохой жил нас эцэслэх үест Мин улсын эрхтнүүд тэр уй гашуутай цалгар цагийг далимдуулан нэхэн довтлож эд агуурс элдэв зүйлийг ихээр олзлон авах цагт "Нууц товчоо"-ны уг эх Мин улсын гарт орсон болов уу гэж үзэж байгаа юм. Хэрэв үүнээс өмнө тухайлбал Тогоон Төмөр хааныг Дай дү (Бээжин) хотоос зугадан гарах үест (1368) "Монголын нууц товчоо" Мин улсын ноёрхогчдын гарт орсон байсансан бол Хүнг-Ү хааны 2-р онд (1369) хурдавчлан зохиосон "Юань улсын судар"-т эрх биш тэмдэглэсэн байх учиртай билээ. "Монголын нууц товчоо"-ны галиг үсгийн тухай нарийвчлан шинжилсэн проф. Чен Йүен (1982, 136) "Нууц товчоо"-г хятад хэлээр орчуулсан цаг үеийн талаар өгүүлэхдээ: "Авиа дуудлага тэмдэглэхэд хэрэглэсэн үсгийг авч үзвэл үйл үгийн өнгөрсөн цагийн хэлбэрийг заах "ба", "бэ" зэрэг нөхцлийг нарийн ялгасан" баримтыг дурдаад "Хуа и И ю" толиос хойш гарсан гэдэг дүгнэлт хийжээ. Проф. Хуан Зун Жиан багш мөн ийм саналтай байгаа юм. Тэрчлэн "Нууц товчоо"-ны галигт зөвхөн чихэнд сонсогдох авиаг тэмдэглэсэн төдийгүй бас нүдэнд буух үсгийн утгыг харгалзсныг проф. Чен Йүен гярхай ажиглан тэмдэглэсэн ажээ. Зохиогч бас "Нууц товчоо"-ны нангиад галиг, орчуулгын хэвлэгдсэн цаг үеийн талаар хөндөж бичихдээ 1933 оны үед Бээжин номын сангийн ажилтан Жеү Ван Ли, хааны ордны их сан хөмрөгийн хөглөрсөн цаасан овоон дотроос олсон "Хуа и И ю" толийн 26 хуудас, "Нууц

товчоо"-ны 45 хуудсыг бичвэрзүйн үүднээс эн тэргүүнээ харьцуулан шинжлэж энэ хоёр урагдсан дэвтрийн бар хэвлэлийн тиг маяг маш ойролцоо байхын гадна цаас нь ч хүртэл яг адил өнгөтэй болохыг дурдаад эдгээр зохиолын хэв сийлэх, барлахад оролцсон 27 хүнээс хоёр хүний овог нэр аль алинд нь гарч буй ноттой баримтыг зааж энэ хоёр ном ойролцоо үед хэвлэгднийг баталсан байна (Чен Йүен, 1982, 109-110).

Үүнээс гадна 1389 онд хэвлэгдсэн "Хуа и И ю" толь хийгээд мөн үүнтэй ойролцоо үед хэвлэгдсэн "Монголын нууц товчоо"-ны хятад галигийн аль аль нь монгол үгийн дуудлагад зориулсан " 舌, 中, 丁" гэх зэргийн нэмэлт тэмдгийг хэрэглэсэн хийгээд алдаа мадаг багатай нарийн нягт чанараараа Мин улсын үеийн монгол хэлний бусад толь бичгүүдээс ялгаатай юм.

Проф. Баярын (1981, 51-54) харьцуулалт хийсэн "Хуа и И ю", "Нууц товчоо" хоёрын галигт адил үгийг тэмдэглэсэн байдлыг авч хэлбэл тохирох хэсэг ч олон буй бас бага сага зөрөөтэй зүйл ч нэлээд буй. Гэхдээ энэ хоёр зохиолын галигчлалын зарчим нь адил тогтолцоотой гэдгийг судлагчид зөвшөөрч байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ хоёр зохиолын аль алиныг нь монгол үгийг хятад галиг үсгээр тэмдэглэх арга зарчмыг чадамгай эзэмшсэн, хэл шинжлэлийн өндөр боловсролтой монголч, нангиадч эрдэмтэд тууривсан болох нь тодорхой. Нэг үгээр хэлбэл "Хуа и И ю" толийг найруулан зохиосон ном хэвлэлийн туршлагатай мэргэжилтэн Хуо Йуан гиэ, Ма Ша ихэ нар шиг монгол, нангиад хэлний өв тэгш боловсролтой эрдэмтэд л "Нууц товчоо"-ны галиг, хадмал орчуулгыг тууривсан биз ээ гэж судлагчид үзэж байна.

Проф. Иринжин (1987, 16) "Монголын нууц товчоо"-ны уйгаржин монгол үсгээр сэргээсэн дэвтрийнхээ оршил өгүүлэлд: "Эдгээр галиглал, орчуулга цөм Мин улсын Ханлимын хэлмэрчдийн хийсэн зүйл. Бараг л 1382 онд хааны зарлигаар "Хуа и И ю"-г бичсэн Ханлимын түшмэд Хуо Йуан гиэ, Ма Ша ихэ, Махмад нарын бүтээл байгаа" гэж тэмдэглэжээ.

Эдүгээ хүртэл олон орны эрдэмтэд хүч мэдлэгээ өргөсөөр ирсэн "Монголын нууц товчоо"-ны нангиад галигийн хэд хэдэн хуулбар нь Мин улсын үеийн анхан барын эхээс юм уу тэр үеийн бусад эх бичгүүдээс хожим нь дам хуулж, хувилж авсан дэвтрүүд болно. Тухайлбал орчин үеийн олон улсын "Нууц товчоо" судлагчид "Гү Гуанг чийн дэвтэр", "Йе Де хуйн дэвтэр", "Чийан Да шиний дэвтэр" энэ хэдэн эхийг л эрдэм шинжилгээний гол хэрэгдлэгдэхүүн болгосоор иржээ. Ийм учраас бид эл гурван дэвтрийн талаар жаахан тодруулан ярилцая.

Гү Гуанг Чийн (1770-1839) дэвтэр ба Йе Де Хуйн (1864-1927) бар

1805 онд Жанг Шийанг йүний хувийн цуглуулгад байсан "Нууц товчоо"-ны нангиад галиг үсгийн эхийг Гү Гуан чи хянан хуулбарлан авчээ. Уг хуулбарыг хожим нь 1885 онд Вен Тинг ши (1856-1904) дам хуулж авсан бөгөөд энэ бичмэл XIX зууны сүүлчээр Йе Де хуйн гарт орж тэрээр 1908 онд модон бараар хэвлэн гаргажээ. 1908 оны энэ хэвлэлийг судлагчид Йе Де хуйн бар гэж нэрлэх болсон байна.

Гү Гуанг чийн хянан сийрүүлсэн уг бичмэлийг Бээжингийн хааны ордны номын хөмрөгөөс олдсон 45 хуудастай харьцуулан 1936 онд Шанхай хотноо хэвлүүлсэн нь "Нууц товчоо"-ны эх бичгийн судалгаанд чухал ач холбогдолтой ажил болсон байна. Өөрөөр хэлбэл Гү Гуанг чийн харьцуулан сийрүүлсэн эл дэвтрийг судлагчид Мин улсын Хүнг Үү хааны (1868-1938) үеийн уул барын эхийг яг дуурian хуулбарласан нэлээд найдвартай эх гэж үздэг юм (Хишигтогтох, 1988, 26). Ийм ч учраас сүүлийн үеийн "Нууц товчоо"-ны бичвэр судлалын нэр хүндтэй чухал бүтээлүүд алдаа мадаг багатай энэхүү Гү Гуанг чийн эхийг баримтлан судлах болсон нь санамсаргүй хэрэг биш болой. Тухайлбал проф. Баяр "Монголын нууц товчоо"-г нангиад, латин үсгийн галиг, монгол бичгийн хэлээр сэргээн буулгасан гурван боть бүтээлдээ, эрдэмтэн

Элдэнтэй, Оюундалай нар "Нууц товчоо"-ны нангиад галигийн эхийг харьцуулан алдаа мадгийг ариутган сийрүүлсэн дэвтэртээ энэхүү Гү Гуанг чийн хуулбарыг үндсэн эх болгон баримтлан судласныг дурдаж болно.

Арван таван бүлэгт "Нууц Товчоо" буюу Чийан Да Шиний (1728-1804) хуулбар

Мин улсын ёст Йүнг Ло хааны (1403-1425) анхдугаар оноос эхлэн зохиогдсон "Йүнг-Логийн их дүрэмлэх бичиг" (永樂大典) бичиг хэмээх олон боть нэвтэрхий толь таван дэвтэр болгон оруулжээ. Үүнээс уламжлан 15 бүлэгт "Нууц товчоо" гэдэг ойлголт гарч ирсэн байна. Гэвч 1860 оны Англи, Францийн холбоотны цэрэг Бээжинг довтлон "Йүэн Минг йүэн" хэмээх үзэсгэлэнт сайхан цэцэрлэгийг галдан шатаах, 1900 оны 6-р сард найман улсын холбоотон нар Бээжинд довтлон орох дайны хөлд энэхүү "Их дүрэмлэх бичиг"-ийн ихэнх нь үрэгдэж үгүй болоход "Нууц товчоо"-ны 15 дэвтэр ч түүнд бас өртжээ. Гэсэн ч энэ 15 дэвтэр ор тас үгүй болсонгүй 1770 хэдэн оны үед Бао Тин бо гэдэг хүн үүнийг "Их дүрэмлэх бичиг"-ийн дотроос хуулж авч өөрийн чацуутан нэрт эрдэмтэн Чийан Да шинд сонирхуулсанд тэрээр уг дэвтрийг үнэлж төгсгөлийн үг бичсэний улмаас "Чийан Да шиний эх" буюу "Чийан Да шиний дэвтэр" гэж нэрлэх болсон байна. Хожим нь эл дэвтэр ямар нэгэн шалтгаанаар Хан Тай хуа гэдэг хүний гарт оржээ.

Оросын христос шашны төлөөлөгч Архимандрите Паллади буюу Петр Иванович Кафаров (1817-1878) 1872 онд Бээжинд сууж байхдаа Хан Тай хуагаас эл 15 бүлэг "Нууц товчоо"-ны эхийг худалдан авчээ. Тэрээр уг хуулбараа 1878 онд А.Позднеевыг Бээжинд ирэхэд түүгээр дамжуулан Петербургийн Их сургуулийн номын санд илгээсэн байна. Эл дэвтрийг А.Позднеев (1851-1920) "Юаны нууц товчооны галиг үсгийн эртний бичвэр" (Транскрипция палеографического текста "Юань чао ми ши") гэсэн нэрээр чулуун бараар 1897 оны үед нийтлүүлжээ. А.Позднеевын "Нууц товчоо"-

ны эхний 96 зүйлийг кирил үсгийн галиг орос хадмал орчуулга, монгол үсгийн сэргээлттэй эл дэвтэр Монгол улсын номын санд хадгалагдаж байна (Сумъяабаатар, 1972, 378).

Чийан Да шиний дэвтэр буюу 15 бүлэгт "Нууц товчоо"-ны эл эхийг Б.И.Панкратов (1962) оршил өгүүллийн хамт бүрнээр нь гэрэл зургаар нийтлүүлсэн билээ. Зохиогч уул ажлаа үргэлжлүүлж орос орчуулга, дэлгэрэнгүй тайлбар, үгийн толь, монгол эхийг сэргээсэн галиг сэлтийг багтаасан гурван боть нэмэж хэвлүүлэхээр төлөвлөж байсан боловч завдал үгүй насан өөд болжээ.

Одоогоос хориод жилийн өмнө Өвөр монголын ахмад эрдэмтэн Элдэнтэй, Оюундалай (1980) нар бидний дээр өгүүлсэн "Нууц товчоо"-ны гол хэдэн эхийг харьцуулан нягтлаж алдаа мадгийг нь залруулсан нэг сонгомол эхийг нийтлүүлсэн билээ. Зохиогчид эл дэвтрийнхээ оршил өгүүлэлд хамгийн алдаа багатай Гү Гуанг чийн дэвтрээс 1200 үсгийн мадаг, Йе Де хуйн дэвтрээс 1230, хамгийн олон алдаатай Чийан Да шиний 15 бүлэгт бараас 3200 үг үсгийн мадаг илрүүлэн зөвтгөж бичсэнээс үзвэл эл хоёр өтгөс эрдэмтэн хичнээн хүч хөдөлмөр гаргасан нь тодорхой байна. Гэхдээ Чийан Да шиний дэвтэр дахь хятад галигт舌,中зэрэг нэмэлт үсэг орхигдсон бүхнийг бас алдаа мадаг хэмээн үзэж боломгүй санагдана. "Монголын нууц товчоо" -ны нангиад галигийн хажуугийн хадмал орчуулга хийгээд зүйл тус бүрийн ард дахь ерөнхий орчуулга нь бидний санахад энэхүү галигчлалыг туурвих цагт хамаарах бололтой. Үүнийг тэр үеийн газар орны нэрийн дуудлага, нангиад орчуулга тэргүүтэн гэрчилж байгаа юм. "Нууц товчооны хоёрдугаар утга орчуулсан цаг нь Хүнг Үгийн (1368-1398) анхдугаар оноос хойш, Йүнг Логийн (1403-1425) эхний онуудаас өмнө болохыг **Бэй-Пинг** (Бээжин) гэдэг нэр хүчтэй тодолж өгөв" гэж Баяр гуай (1981, 75) "Нууц товчоо"-ны оршил өгүүлэлдээ тэмдэглэжээ.

Ямар ч атугай Йүнг Логийн тэргүүн оноос зургадугаар оны (1403-1408) хооронд тууривсан "Их дүрэмлэх бичиг"-ийн дотор "Монголын нууц товчоо"-ны хятад орчуулгыг оруулснаас үзэхэд

XIY зууны сүүлчээр эл зохиолын нангиад орчуулга нэгэнтээ бэлэн болсон байсйан болов уу гэдэг сэтгэгдлийг төрүүлж байгаа юм. Ийм учраас "Монголын нууц товчоо"-г харь хэлээр орчуулсан түүхийг бид XIY зууны сүүлчээр эхэлсэн гэж үзвэл зохино. Чухам "Нууц товчоо"-г хятад хэлээр орчуулагч нь хэн бэ? гэдэг асуултанд олонхи судлагчид "Хуа и И ю" толийг тууривсан Мин улсын бичгийн мэргэдийн хүрээлэнгийн эрдэмтэн Хуо Йуан гиэ, Ма Ша ихэ хоёроос зайлахгүй болов уу хэмээн таамаглаж байна. Эл таамаглалыг дэвшүүлэх гол шалтгаан нь "Хуа и И ю", "Нууц товчоо" хоёрын монгол үгсийг галигласан зарчим, нангиад хадмал орчуулгад үг оноосон байдал, зарим нэгэн нэр томъёоны нэгдмэл шинж гэрчилж байгааг дээр товч өгүүлсэн билээ.

Харамсалтай нь Мин улсын үеийн Хуо Йуан гиэ, Ма Ша ихэ гэдэг энэ хоёр эрдэмтний талаар бид тун явцуухан зүйлийг мэдэж байгаа билээ. Хуо Йуан гиэгийн тухай "Хуа и И ю" толийн оршил өгүүлэлд, Мин улсын бичгийн мэргэдийн Хүрээлэнгийн түшмэл Лиү Сан вү хаанд өргөсөн үгэндээ товч танилцуулсан ажээ. Үүнийг Баяр гуайн (1981, 77) орчуулгаар сийрүүлбэл: "Бичгийн мэргэдийн Хүрээлэнгийн хичээлийн эрдэмтэн Хуо Йуан гиэ болбоос ар говийн угсаатан, хятад оронд төржүхүй. Уг язгуурын бичигт [түүнтэй] мөр зэрэгцэгсэд ховор. Дундад улсын Дөрвөн бичигт нэвтрээд утгыг нь бүрэн ойлгомой. Тийнхүү зарлиг тушаан хятад бичгээр монгол хэлийг орчуулгав" гэсэн байна. Лиү Сан вүгийн эл оршил үгийн дотроос бид хэдэн чухал мэдээг олж мэдлээ. Үүнд: **1**. "Хуа и И ю" толийг тууривсан эрдэмтэн Хуо Йуан гиэ бол хятад газар төрсөн монгол хүн ажээ. Өөрөөр хэлбэл Юань улсын үед Бээжинд сууж байсан монголчуудын нэгэн байв. **2**. Тэр төрөлх монгол хэлээ чадамгай эзэмшсэн тул түүнтэй мөр зэрэгцэх хүн ховор байсан байна. **3**. Энэ эрдэмтэн монгол хэлбичгээс гадна хятад ном бичигт сайтар суралцсныг "Дөрвөн бичгээр" жишээ болгон өгүүлэв. Энэ "Дөрвөн бичигт" Их суртхуй, хэв дунд бичиг, шүүмжлэл өгүүлэл буюу Күнзийн сургаал, Минзийн сургаал энэ дөрөв багтана. **4**. Ийм эрдэм чадвартай учраас зарлиг тушааж

монгол хэлний зүйлийг хятад хэлээр орчуулгаж буйг хаанд мэдүүлсэн ажээ.

"Хуа и И ю" толины энэхүү оршил үгнээс Хуо Йуан гиэ бол монгол, хятад хэлбичгийн аль алинд өв тэгш суралцсан хүн гэдгийг товойлгон хэлжээ. Энэ нь ч түүний тууривсан толь бичиг хийгээд "Нууц товчоо"-ны нангиад галиг, хадмал орчуулга тэргүүтнээс тодорхой харагддаг юм. Юань төрийн үед хааны зарлиг тушаал мэт албан хэргийн зүйл монгол бичгээр явдаг байсан тул Мин улсын үед Хуо Йуан гиэ мэтийн ийм хоёр хэлний тэгш мэдлэгтэй хүн чухал хэрэгцээтэй байсан нь ойлгомжтой хэрэг юм.

Эрдэмтэн Ма Ша ихэгийн намтар бүр ч бүдэгхэн байгаа юм. Түүнийг одоогийн Синзяны Уйгар хавийн хүн болов уу гэдэг ам яриа байх боловч тодорхой баримт олдохгүй байна. Проф. Баяр (1981, 76) оршил өгүүлэлдээ: "Баруун орны одон орны судлалын бичгийг орчуулсан гэдэг" мэдээ байдгийг цухас тэмдэглэжээ.

"Монголын нууц товчоо"-ны үг ухагдахуун бүрийг зөвөөр ойлгоход хажуугийн хятад хадмал орчуулга үнэлж баршгүй ач холбогдолтой юм. Учир нь энэхүү хадмал орчуулгыг туурвигч нь тэр үеийнхээ монгол нангиад хэлбичигт тэгш сайн байсны дээр "Нууц товчоо"-г зохиогдсоноос хойш дөнгөж 150-60-аад жилийн дараа орчуулсан гэдгийг бас санах учиртай. Ийм учраас уг хадмал орчуулгыг нягт нямбай баримтлан судалсан проф. Э.Хэниш, П.Пеллио, Ф.Кливез, И.Рахевилз нарын герман, франц, англи хэлний орчуулгад ноцтой алдаа бараг үгүй байдаг бололтой.

"Нууц товчоо"-ны нангиад хадмал орчуулгыг туурвигч нь монгол үг тус бүрийг голдуу үгчлэн орчуулж, заримдаа хятад үсгээр шууд онооход бэрхшээлтэй буюу монголчуудын ахуй амьдралтай холбогдол бүхүй нэр томъёоны шинж чанартай үг хэллэгийг **гайлбарлах** аргаар буулгажээ.

Хааяа заримдаа тусгай нэрийн чанартай мэр сэр үгсийг **бүдүүвчлэн** орчуулсан буй. Жишээ нь **тэнгэс** гэхийг "усны нэр", **хаблан** буюу **барыг** "араатны нэр", **сүдүн гичгинэ** гэдгийг "загасны **нэр**", **хуладу** гэдгийг "шувууны нэр", **кэйибүр (хаймуур)** гэдгийг

БИБЛИОТЕКА
НОМЕР
Н

"сумны нэр" гэж орчуулсан нь эрдэм шинжилгээний үүднээс авч хэлбэл хэтэрхий бүдүүвчилсэн буюу зарим нэг оновчтой биш орчуулгыг одоогоор яг нарийвчлан судалсан зүйл үгүй байна. Гэхдээ нангиад хадмал орчуулгын ач холбогдлын талаар эрдэмтдийн үнэлэлт цэгнэлт, ажиглалт судалгаа огт байхгүй биш юм. Проф. Баяр (1981, 83) "Хажуугийн орчуулганы онцлог нь ер бусын нарийн нямбай. Бодот үг нэг бүрд дэс дараалан тайлбар хийснээр зогсохгүй авиа байвч утга үгүй тэр олон дагаварууд болон сул үгийг ч алдал үгүй орчуулж гаргав" гэж үнэлжээ. Тэрчлэн проф. Чен Йүэн (1982, 136) "Нууц товчоо"-ны хадмал орчуулгыг судлаж үзээд хааяа зарим нэг үгийг ор тас орчуулаагүй орхисныг ажиглаж II дэвтрийн 6-р хуудсанд **хаулуха**, III дэвтрийн 19-р хуудсанд **хокир**, IY дэвтрийн 12-р хуудсанд **иктүнэжү**, Y дэвтрийн 37-р хуудсанд **аларта'асу**, YI дэвтрийн 16-р хуудсанд **абуй бабуй**, YII дэвтрийн 10-р хуудсанд **төрүлмиши** гэх зэргийн үгсийг орчуулаагүйг тэмдэглээд ""Нууц товчоо"-ны орчуулагч урт удаан хугацаагаар дотор газар сууснаас хуучирсан монгол үгсийг хөрвүүлж чадаагүй байна. Үүнээс нэлээд түрүүн орчуулсансан бол энэ мэт үгсийг мэдэхээр настан хүмүүс байсан биз" гэжээ. Бидний тооцож үзсэнээр "Нууц товчоо"-ны хадмал орчуулгад ердөө дөчин үг орчуулаагүй орхигдуулжээ (Цэрэнсодном, 1991, 3-6). "Монголын нууц товчоо"-ны үгсийн санг давхардсан тоогоор нэг түм орчим үгтэй гэж үзвээс энэ нь тун өчүүхэн хувийг эзлэх тоо юм. Гэхдээ "Нууц товчоо"-ны орчуулагч чухам ямар ямар үгсийг яагаад орчуулаагүй орхисон бэ гэдэг асуудал эрдэм шинжилгээний хувьд онцгой сонирхол татаж байна. Бидний ажиглалтаар "Нууц товчоо"-ны орчуулагч нь тухайн үеийн (XIII зууны үеийн) нутгийн аялгууны чанартай буюу хар ярианы үгс, аль эсвэл эртний өвөг алтай хэлнээс уламжлалтай монгол-түрэг дундын чанартай үг, харь гаралтай үг тэргүүтнийг хятад үсэг оноогоогүй орхисон буюу оноосон ч тэр бүр оновчтой биш болсон шиг санагдана. Үүнтэй холбогдуулж энэ номын үг хэллэгийн тайлбараас уншигч, судлагч та бүхэн 7, 12, 39, 59, 63, 87, 88, 89, 97, 113, 124, 155,

156, 157, 163, 170, 174, 192, 209, 211, 277, 309, 311, 328, 345, 348, 352, 372, 373, 391, 393, 421, 480, 481, 489, 492, 494, 496, 497, 509, 537, 552, 601, 615, 626, 649, 655, 675, 678 дугаар тайлбарыг харьцуулан үзэж болно. Дээр өгүүлсэн баримтаар "Нууц товчоо"-ны хадмал орчуулгад 40 үгэнд хятад үсэг оноогоогүй орхисон нь нэг талаас авч үзвэл проф. Чен Йүэний хэлсэнчлэн монгол үгийн утгыг бүрэн гаргаж чадаагүй дутагдалтай зүйл мөн боловч нөгөө талаас авч үзвэл "Нууц товчоо"-ны хадмал орчуулгыг туурвигч нь өөрийн баттай мэдэх үг хэллэгийг аль болох оновчтойгоор орчуулж эргэлзээтэй үгсийг үлдээсэн нь энэ орчуулагчийн судалгааны байр суурийг тодорхойлох нэг баримт болж байна. Өөрөөр хэлбэл Юань төрийг мөхсний дараах монгол хэлний байдал тэр үеийн зарим хуучирсан үг хэллэгийг судлахад энэ дөчин "цагаан толбо" бас үгүй зүйлийг өгүүлж буй сонин баримт болно.

Эл зүйлийн эцэст нэхэн тэмдэглэхэд XIY зууны үеийн хэлбичгийн эрдэмтэн Хуо Йуан гиэ, Ма Ша ихэ зэрэг бичгийн мэргэдийн нөр их хөдөлмөрийн ач гавъяагаар бид өнөө "Монголын нууц товчоо" хэмээгч эл гайхамшигт дурсгал бичгийг бараг уул төрхөөр нь бүрэн сэргээх бололцоотой болгосныг өнөө, ирээдүйн залуус ухан мэдтүгэй.

2. "Нууц товчоо"-ны орчуулга, сэргээн сийрүүлэлт

"Монголын нууц товчоо"-г европ дахины хэлээр эн тэргүүнээ танилцуулсан хүний нэг бол оросын шашны зүтгэлтэн П.Кафаров (1817-1878) юм. Тэрээр монгол хэл мэдэхгүй учир зөвхөн хятад орчуулгаас "Нууц товчоо"-г орос хэлээр орчуулж "Бээжин дэх Оросын шашны төлөөлөгчдийн газрын бүтээлүүд" хэмээх цуврал бичигт: "Чингис хааны тухай эртний монгол домог үг" (Кафаров, 1866) гэсэн нэрээр нийтлүүлжээ. Энэ нь хэдийгээр "Нууц товчоо"-ны бүрэн төгөлдөр орчуулга биш ч орос хэлтэн

уншигч, судлаач нарт эл дурсгал бичгийг ямар нэг хэмжээгээр танилцуулж өгсөн нь лавтай. Проф. Ф.Кливез (1982, XXYIII) "Монголын нууц товчоо"-ны англи орчуулгын удиртгал өгүүлэлдээ: Х.Ю.Клапрозын (1783-1835) 1824 оны франц хэлний орчуулгыг "би үүнийг өрнөдийн хэлээр гарсан "Монголын нууц товчоо"-ны анхны хэвлэл гэдэгт найдаж байна" гэж тэмдэглэснээс үзвэл П.Кафаровын орчуулга нь европ дахины хэлээр гарсан анхны орчуулга арай биш бололтой.

П.Кафаровын орчуулгаас 70 гаруй жилийн хойно академич С.А.Козин (1879-1956) "Монголын нууц товчоо"-г орос хэлээр орчуулж гаргав. С.А.Козины (1941) орчуулгад монгол үгсийн утгыг оросоор буулгахдаа нангиад орчуулгатай уялдуулж орчуулж чадаагүйгээс зарим нэгэн үг хэллэгийг ташаа ухаарсан зүйл нэлээд байвч "Нууц товчоо"-ны галиг, орчуулга, толь тэргүүтнийг багтааснаараа тухайн үедээ судлагчдын анхаарлыг татсан доривтой бүтээлийн нэг болсон юм.

Зөвлөлтийн хятадч, монголч эрдэмтэн Н.Ц.Мункуев 1970 —аад оны үед монгол галиг үсгийн эх, нангиад хадмал орчуулга аль алиныг нь уялдуулан судалсан эрдэм шинжилгээний орчуулгыг орос хэлээр хийж байсан боловч дуусгаж завдалгүй насан өөд болжээ.

"Монголын нууц товчоо"-ны 750 жилийн ойгоор Оросын холбооны улсын эрдэмтдээс акад. С.А.Козины орос орчуулга, эрдэмтэн Ч.Намжиловын Буриад орчуулга хоёрыг нэг дэвтэр болгон нийтлүүлжээ.

Өрнө дахины монголын судлалд германы нэрт монголч Э.Хэнишийн (1880-1966) "Монголын нууц товчоо"-ны герман хэлний орчуулга судалгаа их нөлөөтэй юм. Проф. Э.Хэниш (1948) нангиад монгол хэлний сайн мэдлэгтэй эрдэмтний хувьд "Нууц товчоо"-ны доторх олон адармаатай үг хэллэгийг герман хэлээр чамбай хөрвүүлсэн гэж судлагчид үздэг байна. Проф. В.Хайссиг (1982) Э.Хэнишийн орчуулгыг орчин үеийн уншигчдад зориулж бага зэрэг хялбарчлан төгсгөлийн үг бичиж нийтлүүлэв. Сүүлийн

үед доктор М.Таубе (1989) "Монголын нууц товчоо"-ны герман хэлний шинэ орчуулгыг хэвлүүлсэн байна.

Францын гарамгай монголч эрдэмтэн П.Пеллио (1878-1945) "Нууц товчоо"-ны судлалд том хувь нэмэр оруулсан эрдэмтэн юм. Тэрээр "Нууц товчоо"-ны эхний зургаан бүлгийг орчуулсан нь зохиогчийн таалал болсноос хойш хэдэн жилийн дараа нягт нямбай хийсэн эрдэм шинжилгээний галигийнх нь хамтаар хэвлэгдэн гарав (Пеллио, 1949).

Белгийн нэрт монголч эрдэмтэн А.Мостарт (1881-1971) бидний дээр өгүүлсэн Э.Хэниш, С.А.Козин, П.Пеллио нарын тууривсан герман, орос, франц хэлний орчуулгыг харьцуулан үзэж зарим нэгэн үг хэллэгийн талаар шинэ санал дэвшүүлсэн цуврал өгүүлэлүүдийг 1950-иад онд нийтлүүлж байв. Зохиогч эдгээр өгүүлэлээ нэгтгэн "Монголын нууц товчооны хэдэн орчуулга" гэдэг номыг 1953 онд хэвлэн гаргасан нь "Нууц товчоо"-ны орчуулгын судлагаанд гойд ач холбогдолтой бүтээл болсныг тэмдэглэе. Ийнхүү энэ зууны дунд үеэс "Монголын нууц товчоо"-ны судалгаа улам эрчимжиж өрнө дорнын олон хэлээр орчуулагдаж иржээ.

А.Темир "Нууц товчоо"-г түрэг хэлээр орчуулж 1948 онд Анкарад хэвлүүлэв. Энэ зууны II хагасаас дорнод европын хэд хэдэн хэлээр орчуулагдсан билээ. Тухайлбал 1955 онд проф. П.Поухагийн Чех хэлний орчуула, 1962 онд проф. Л.Лигетийн Мажаар хэлний орчуулга, 1970 онд проф. С.Калужинскийн Польш хэлний орчуулга тус тус хэвлэгдэн гарлаа.

Мөн энэ үеэр проф. И.Рахевилз "Нууц товчоо"-ны үгийн цэсийг нийтлүүлэхийн хамт англи хэлээр орчуулж 1971 оноос Австралийн "Алс дорнодын түүх" гэдэг сэтгүүлд бүлэг бүлгээр цуврууллан нийтлүүлэв.

Америкийн дорно дахины судлалын нэрт эрдэмтэн проф. Ф.Кливез "Монголын нууц товчоо"-г 1956 оны үед англи хэлээр орчуулсан боловч олон жилийн хойно 1982 онд нийтлүүлэв. В.Кливезийн англи хэлний орчуулга нь өрнө дахины хэлээр миний

олж үзсэн орчуулгуудаас хамгийн оновчтой хамгийн нарийн нь болно. Зохиогч энэхүү орчуулгадаа нангиад галигийн эхэд байхгүй нэмэлт тэмдэг буюу үг хэллэг нэмэж оруулахдаа дөрвөлжин хаалтанд бичиж зарим хуучирсан үг юм уу хадмал орчуулгад орхигдсон үг тэргүүтэнд товч тайлбар хийж зүүсэн байна.

"Монголын нууц товчоо"-ны харь хэлний анхны орчуулгыг Мин улсын үед хятад хэлээр буулгасан хадмал орчуулга, утгачилсан товч орчуулга мөн болов уу гэдгийг бид дээр өгүүлсэн билээ. Харин Манж Чин улсын үед (1644-1909) хятад хэлээр "Монголын нууц товчоо"-ны шинэ орчуулга гарсан эсэх нь тодорхойгүй юм. Сүүлийн үед БНХАУ болон өөр оронд хятад хэлээр хэд хэдэн шинэ орчуулга хэвлэгдэн гарлаа. Тухайлбал эрдэмтэн Сие Зай шан, "Монголын нууц товчоо"-ны Ц.Дамдинсүрэнгийн орчин цагийн монгол хэлний хөрвүүлгийг баримтлан өргөн олон уншигчдад зориулж эдүгээгийн хятад хэлээр орчуулж 1956 онд хэвлүүлжээ. Өвөр монголын түүхч проф. Гиваа (Дорнотив) "Нууц товчоо"-г нангиад галигийн эхээс хятад хэлээр орчуулж зарим үг хэллэгт товч тайлбар хавсарган 1979 онд Өвөр монголын ардын хэвлэлийн хороонд хэвлүүлсэн байна.

Эдүгээ АНУ-д суугаа монгол эрдэмтэн Захчидсэцэн "Нууц товчоо"-г мөн хятад хэлээр орчуулж дэлгэрэнгүй тайлбар сэлттэй 1979 онд Тайванд хэвлүүлжээ.

"Монголын нууц товчоо"-г судлах ялангуяа орчуулах талаар Японы эрдэмтэд олон жилийн баялаг туршлагатай юм. Япон хэлний анхны бүрэн орчуулгыг 1907 онд нэрт нангиадч эрдэмтэн Нака Мичиёо (1851-1908) хэвлэн гаргаснаас нааш проф. Кобаяши Токаширо, Ширатори Күракиши, Шиго Озава Шигэо нарын орчуулга, судалгааны олон шилдэг бүтээл гарсан билээ. Ялангуяа проф. Ш.Озава "Монголын нууц товчоо"-ны зургаан боть том бүтээлдээ Мин улсын үеийн нангиад хадмал орчуулга шиг үг нэг бүрийг японоор оноон орчуулсны дээр бас утгачилсан орчуулгыг зүйл бүрийн ард дагалдуулсан зэрэг нь "Нууц товчоо"-ны орчуулгын судлал, бичвэр судлал, хэлзүйн харьцуулсан судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсан чухал бүтээл болсон байна.

"Монголын нууц товчоо"-ны орчин цагийн монгол хэлний шинэ орчуулгын энэхүү удиртгал өгүүлэлд "Нууц товчоо"-г монгол хэлээр орчуулсан буюу монгол бичигт сэргээн буулгасан бүтээлүүдийн талаар уншигч та бүхнээ арай дэлгэрэнгүй танилцуулах нь зүйтэй болов уу гэж бодогдоно.

Богд хаант Монгол улсын Гадаад Явдлын Яамны дэд сайд асан дагуурын Цэнд (1875-1932) гүн 1917 нод Йе Де хуйн модон барын эхийг баримтлан монгол бичгийн сэргээн сийрүүлэл маягийн орчуулга, зүйл бүрийн ар дахь хятад товч орчуулгыг монгол хэлээр хөрвүүлсэн ийм хоёр дэвтрийг тууривжээ. Эл хоёр бичмэл дэвтрийн нэгдэх нь эдүгээ Оросын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн номын санд хоёр дахь дэвтэр буюу орчуулга нь Монгол улсын Номын санд хадгалагдаж байна.

Энэ хоёр дэвтрээс гадна уг орчуулгыг захиалж хийлгэсэн проф. Ж.Цэвээний мэдэлд байсан нэгэн иж дэвтэр эдүгээ Санкт Петербургийн номын санд хадгалагдаж байгаа ажээ. Уг дэвтрийг Цэнд гүнгийн охин Ц.Хандсүрэн (1997) оршил бичиж, гэрэл зургаар нийтлүүлснээр уншигч, судлагчид эл бүтээлтэй танилцах бололцоо нээгдэв.

Цэнд гүн "Нууц товчоо"-г монгол бичгийн хэлээр буулгахдаа аль болохоор хятад галигийг чанадлан баримталж, уг нэмж хасахгүй хөрвүүлэхийг хичээжээ. Энэ бүтээл нь "Нууц товчоо"-г сонгодог бичгийн хэлээр буулгах гэсэн анхны оролдлого байсан учир хятад галиг үсгийн нэмэлт тэмдгийн үүргийг бүрэн ухаагүй зэргээс газар орон, хүний нэр тэргүүтнийг хаая заримдаа хазгай тэмдэглэсэн зэрэг мадаг сэжиг байвч "Монголын нууц товчоо"-г өнөөгийн уншигч, судлагчид зөвөөр ухаж, ухаарахад чухал үүрэг гүйцэтгэсэн гавъяатай. Ялангуяа зүйл бүрийн төгсгөл дахь хятад товч орчуулгыг Цэнд гүнгээс өөр ямар ч судлагч одоо болтол монгол хэлээр орчуулаагүй байгаа билээ. Ийм учраас Цэнд гүнгийн "Юань улсын нууц түүх" хэмээх хятад галигийг монгол бичгээр сэргээн буулгасан орчуулга, зүйл бүрийн ар дахь хятад

товч орчуулгыг монголчилсон энэ хоёр иж бүтээл нь энэ зууны эхэн үеэр монгол хүний "Нууц товчоо" судлалд оруулсан хамгийн доривтой бүтээлд зүй ёсоор орох болно.

Монгол улсын нэрт эрдэмтэн акад. Ц.Дамдинсүрэн "Монголын нууц товчоо" зохиогдсны 700 жилийн ойг тохиолдуулан энэ алдартай дурсгал бичгийг уншигч олон түмэнд танилцуулах зорилгоор уран сайхны аргаар чөлөөтэй найруулж орчуулж "Шинжлэх ухаан" сэтгүүлийн 1941-1942 оны дугааруудад цуврууллан нийтлэж байгаад 1947 онд тусгай ном болгон хэвлүүлэв. Энэхүү орчуулга 1957, 1976, 1990 онд бас кирилл үсгээр хэвлэгдсэн байна.

Зохиогч орчуулгынхаа удиртгал өгүүлэлд "Долоон зуун жилийн урьд энэ зохиол анх зохиогдсон үедээ уншигчдад аль зэрэг уран сайхан сонирхолтой байсан бол мөн одоо цагт монголын уншигчдад тэр зэрэг уран сонирхолтой болгож үзэхийг чармайсан билээ" гэж хөрвүүлгийнхээ зорилго чиглэлийг тодорхойлжээ. Проф. Ц.Дамдинсүрэн "Нууц товчоо"-г орчуулахдаа өнөөгийн уншигчдад аль болох ойлгомжтой үг хэллэгээр яруу сайхнаар буулгахыг гол зарчим болгож чөлөөтэйгөөр үг нэмж, хассан боловч уг зохиолын ерөнхий утга санааг гажиж өөрчилсөн зүйл үгүй болно. Ийм учраас өргөн олон уншигчдын хүсэлтээр эл орчуулга монгол хэлээр дөрвөн удаа хэвлэгдсний дээр "Нууц товчоо"-г орос, польш, хасаг, чех, хятад зэрэг хэлээр орчуулсан хэлмэрчид Ц.Дамдинсүрэнгийн орчин цагийн монгол хэлний орчуулгыг баримтлан буулгасныг тэмдэглэе.

"Нууц товчоо"-г галиглах, сэргээн сийрүүлэх, тайлбар сэлт үйлдэх тэргүүтэн бичвэр судлалд монголын эрдэмтэн проф. Т.Дашцэдэн, Ш.Гаадамба, Б.Сумъяабаатар нарын судлагчид чухал бүтээлүүд тууривжээ.

Бас "Нууц товчоо"-г монгол бичгийн хэлнээ хөрвүүлэх, сэргээн сийрүүлэх үйлст Өвөр монголын эрдэмтэн, сэхээтэн нар үлэмжийн их гавъяа зүтгэл гаргасаар ирсэн билээ.

Хорчин нутгийн Бөххишиг (1902-1943) "Нууц товчоо"-г

монгол бичгийн хэлнээ нэлээд нягт нарийн хөрвүүлсэн хүний нэг юм. Тэрээр 1940 онд Кай Лү-д хэвлүүлсэн "Монголын нууц товчоо"-ны оршил өгүүлэлдээ: "Эн тэргүүнээс даруй монголчлон авч угсаатандаа тус нөхөөр болсугай хэмээх санааг өвөрлөсөн авч гагцхүү өөрийн сургууль мөчид хийгээд монгол утга ч мөн үндэс үгүйдээ биеэ жигшиж татгалзсаар хар бичин (1932) жилээс сая эхлэн монголчилж мөн бичсээр мөн саатсаар хэзээ улаан хулгана (1936) жилийн зуны тэргүүн сард сая арайхийн нэгэн иж бүрэн арван хоёр дэвтрийг монголчлон бичиж гаргабай" гэж тэмдэглэсэн байна.

Бөххишигийн орчуулгад энэ үеийн бусад монгол судлагчдын хөрвүүлэгт огт байхгүй нэг шинэ зүйл бол зарим нэг нэр томъёоны шинж чанартай юм уу хуучирсан үг хэллэгийг өөрийгөө хэрхэн орчуулсныг уншигч, судлагч нараар шүүлгэхийн тулд нангиад галиг ба хадмал орчуулгыг хаалтанд бичиж дор дор нь зүүж өгсөн нь эрдэм шинжилгээний чухал үнэ цэнтэй ажил болжээ. Тэрээр нангиад галиг үсгээс монголчлохдоо олон арван хуучирсан үг хэллэгийг нэлээд оновчтой орчуулсан нь олон буй. Үүний зарим нэгэн жишээг бид эл номын үгийн тайлбарт мэр сэр ашиглав.

Өвөр монголын Хөлөнбуйр аймгийн шинэ баргын Хуацай Дугаржав 1939 онд Япон улст суралцаж байхдаа нэрт монголч эрдэмтэн проф. Широ Хатторитай хамтран "Нууц товчоо"-ны нэгдүгээр дэвтэр буюу эхний 68 зүйлийг монголчилж тусгай нэрийн хэлхээстэй нийтлүүлжээ. Зохиогч энэ ажлаа 40 гаруй жилийн хойно үргэлжлүүлж 1984 онд "Монголын нууц товчоо"-ны харгуулан хянасан дэвтэр гэсэн нэрээр хэвлүүлсэн байна. Дугаржав гуайн эл орчуулга нь зарчмын хувьд бидний дээр өгүүлсэн Ц.Дамдинсүрэнгийн орчуулгатай төстэй уран сайхны аргаар буулгасан бүтээл юм.

Дараа нь Харчин баруун хошууны Алтан-Очирын орчуулгыг дурдъя. Алтан-Очирын орчуулсан "Монголын нууц товчоо"-ны төгсгөлд: "Богд Чингис хааны долоон зуун гучин зургадугаар оны (1942) 12-р сарын арван тавнаа Тэргүүн ноёны

ордны дармалын газар (Чуулалт хаалга) дарамлав" гэсэн байна. Алтан-Очирын орчуулгад зарим нэгэн тусгай нэрийн зүйл буюу нэр томъёог хайш хэрэглэсэн мадаг сэжиг байх боловч "Нууц товчоо"-ны нангиад галигийн эхийг чанад баримталснаараа эрдэм шинжилгээний ач холбогдолтой бүтээл юм.

Ордосын зохиолч Хишигбатын (1849-1916) уран сайхнаар найруулж орчуулсан "Юань улсын нууц товчоо" гэсэн дэвтрийг 1941 оны үед Жанчихүүгийн Монгол утга соёлын нарийвчлан нягтлах хороо хэвлэн гаргав. Хишигбатын орчуулга нь Бөххишиг, Алтан-Очир нарынх шиг "Нууц товчоо"-ны эхийг нарийн баримталсан бус ерөнхий утга санааг нь авч уран сайхнаар найруулан бичжээ.

Энэ мэт ахмад үеийн эрдэмтэн, сэхээтэн нарын "Монголын нууц товчоо"-г орчуулж судлах гэсэн анхны оролдлого нь хожмын судлаач нарын бүтээл туурвилд зам мөрий нь засч өгсөн ач буянтай гэдгийг тэмдэглэж хэлэх нь зүйтэй болов уу.

Сүүлийн хориод жилд БНХАУ-д монголын судлал ихээхэн эрч далайцтай хөгжиж байгаагийн дотор "Монголын нууц товчоо"-г орчин цагийн монгол хэлээр орчуулсан хийгээд дундад эртний монгол бичгийн эхийг сэргээн сийрүүлсэн, үг хэллэгийг тайлбарласан зэрэг хэд хэдэн чамбай бүтээл хэвлэгдэн гарлаа.

Юуны өмнө Өвөр монголын Багшийн их сургуулийн проф. Баярын 1981 онд нийтлүүлсэн "Монголын нууц товчоо"-ны судлалын гурван боть бүтээлийг дурдъя. Зохиогч "Нууц товчоо"-ны нангиад галиг, хадмал орчуулгыг алдаа мадаг харьцангуй бага Гү Гуанг чийн эхийг баримтлан сийрүүлж, эрдэм шинжилгээний латин галиг, хуучин монгол эхийн сэргээлт, сонгодог бичгийн хадмал орчуулгыг зэрэгцүүлэн нийтлүүлжээ. Зарим хүмүүсийн өөлж хэлдгээр монгол үсгийн сэргээн сийрүүлэлт, орчуулга хоёрын хоорондын ялгаа багатай болсон гэх шүүмжлэл байдаг ч проф. Баярын "Нууц товчоо"-ны судлалын III ботийн ард хавсаргасан 500 гаруй нангиад үсгийн дуудлагын толийг судлагчид дундад эртний монгол хэлний авиа зүй, үг зүйн судалгаанд онцгой ач

холбогдолтой шинэлэг ажил болсон гэж өндөр үнэлдэг байна.

Өвөр монголын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургуулийн проф. Мансаан "Монголын нууц товчоо"-г шинээр орчуулж, нийт 444 үг хэллэгт сонирхолтой тайлбар үйлдэж, хүний нэр, овог аймгийн нэр, газар усны нэрсийн толь хийж хавсаргажээ. Мансааны орчуулга бол "Нууц товчоо"-ны уг эхийг яг баримтлаагүй үг нэмэх, хасах зэргээр чөлөөтэй найруулсан тул зарчмын хувьд Ц.Дамдинсүрэн, Дугаржав нарын орчуулгатай адилавтар юм.

"Нууц товчоо"-г монгол бичгийн хэлнээ эн тэргүүнээ орчуулсан Цэнд гүнгийн үр, ач Элдэнтэй, Ардаажав нар эцэг дээдэс хийгээд ахмад үеийнхний үүтэгсэн ажлыг үргэлжлүүлж "Монголын нууц товчоон-сийрүүлэл тайлбар" гэдэг томхон бүтээлийг 1986 онд хэвлүүлэв. Зохиогчид "Монголын нууц товчоо"-г хуучин бичгийн хэлнээ сэргээн сийрүүлэхдээ нангиад галигийн эхийг бүтээлчээр харьцуулан оновчтой сайн буулгасны дээр зүйл бүрийн ард хуучирсан үг хэллэгт үг зүй болоод утга зүйн үүдээс тайлбар хийж хавсаргасан байна. Уул тайлбар өгүүлэлүүдэд Элдэнтэй, Оюундалай, Асралт нарын 1981 онд хятад хэлээр нийтлүүлсэн "Монголын нууц товчооны үгсийн сангийн сонгомол тайлбар" хэмээх дэвтрээс өргөн ашигласны дээр хуучирсан үг хэллэгийг монгол олон нутгийн аялгууны хэрэглэгдэхүүн хийгээд дагуур, манж, түрэг хэлний зарим баримт жишээтэй холбон үзэхийг чармайжээ. Өөрөөр хэлбэл эл номын хуучирсан үг хэллэгийн тайлбар өгүүлэлүүд нь "Нууц товчоо"-ны үгсийн сангийн судалгаанд чухал хувь нэмэр болох эрдэм шинжилгээний үнэ цэнтэй ажил болно. Гэхдээ уул тайлбар өгүүлэлүүдэд монгол хэлний эртний зарим нэгэн үг хэллэгийг орчин цагийн түрэг хэлний нутгийн аялгууны баримттай хүчээр холбох гэсэн хандлага хааяа цухалзаж буйг миний бие эл номын тайлбар өгүүлэлдээ мэр сэр шүүмжилснийг мэргэн уншигч, судлагч та бүхэн үзэж болгоох буй за.

Өвөр монголын Их сургуулийн проф. Ихмянгадай Иринжин "Монголын нууц товчоо"-г уйгаржин монгол үсгээр сэргээн сийрүүлж "Өвөр монголын Их сургууль" сэтгүүлийн 1984

оны III дугаараас эхлэн нийтлүүлж байгаад 1987 онд нэгтгэн тусгай ном болгон хэвлүүлэв. Зохиогч эх бичгийнхээ сэргээлэлтэд зарим үгийн бичлэгийг монголын түүхийн бусад сурвалж бичиг сэлттэй харьцуулан товч тайлбарласан нь "Нууц товчоо"-ны бичвэр судлалд энэ эрдэмтний оруулж буй хувь нэмэр болно.

"Монголын нууц товчоо"-ны орчуулга, сэргээн буулгалтын байдлыг энд товч төдий тоймлон өгүүлэв. Энэхүү удиртгалын эцэст тэмдэглэхэд бидний дээр нэр дурдсан, дурдаагүй олон эрдэмтэн, судлаачдын нөр их хөдөлмөрийн ач гавъяагаар өнөөгийн шинжлэх ухаан чухам "Нууц товчоо"-ны "нууцруу" амжилттай нэвтрэн орж байгаа билээ.

Уншигч Та бүхнээ бидний толилуулан буй "Монголын нууц товчоо"-ны эл орчуулга, тайлбар ч мөн л өмнөх судлаачдын бүтээл туурвилын үр шимээр боссон ажил гэдгийг тэмдэглэн хэлэхэд таатай байна.



МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО

(Орчин цагийн монгол хэлний орчуулга)



Нэгдүгээр бүлэг



Нэгдүгээр бүлэг

1. Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяат төрсөн **Бөртэ Чоно**[1] ажгуу. Гэргий нь **Хоо Марал**[2] ажээ. Тэнгэс гэтлэж ирэв. Онон мөрний эхэн **Бурхан Халдунд**[3] нутаглаж [байхад] төрсөн Батачи хан ажгуу.

2. Батачи ханы хөвүүн Тамача, Тамачагийн хөвүүн Хоричар мэргэн, Хоричар мэргэний хөвүүн Уужим Борхул, Уужим Борхулын хөвүүн Салихачу, Салихачугийн хөвүүн Их нүдэн, Их нүдэнгийн хөвүүн Сэмсочи, Сэмсочийн хөвүүн Харчу.

3. Харчугийн хөвүүн Боржигдай мэргэн , Монголжин гоо гэргийтэй ажээ. Боржигдай мэргэний хөвүүн Торголжин баян, Борогчин гоо гэргийтэй. Боролдай соёлби [гэдэг] **залуутай**[4] Дайр, Бор хоёр хүлэг морьтой бөлгөө. Торголжины хөвүүн **Дува-сохор**[5], Добун мэргэн хоёр бөлгөө.

4. Дува-сохор магнай дундаа ганц нүдэт гурван **нүүрийн газар**[6] харах бөлгөө.

5. Нэгэн өдөр Дува-Сохор, Добун мэргэн дүүтэйгээ Бурхан Халдун дээрээс харваас Түнхэлиг горхи уруу нэгэн бүлэг иргэн нүүж ирж айсуйг үзэж харж.

6. Өгүүлрүүн:"Тэр нүүж яваа иргэдийн дотор **нэгэн мухлаг тэрэгний**[7] өмнө **суудалд**[8] нэг сайхан охин [сууж явах] буюу. Хүнд эс очсон бөгөөс Добу мэргэн дүүдээ, чамд гуйя" гэж Добун мэргэн дүүгээ [охиныг] үзүүлэхээр илгээв.

7. Добун мэргэн тэр иргэдэд хүрч очвоос үнэнхүү гоо **сайхан**, алдар цуу ихтэй, Алан гоо нэртэй [агаад] хүнд очоогүй охин **ажгуу**.

8. Тэд бүлэг иргэн **Хөл Баргужин төхмийн**[9] эзэн Баргудай мэргэний охин Баргужин гоо нэрт охиныг Хорь Түмэдийн ноён

Хорилардай мэргэнд өгсөн ажээ. Хорь Түмэдийн газар Ариг уснаа Хорилардай мэргэний Баргужин гоогоос төрсөн Алангоо нэрт охин тэр [болно].

9. Хорилардай мэргэн Хорь Түмэдийн нутагтаа булга, хэрэм [ан] гөрөөст газраа хориглолдож муудалцаж Хорилар овогтон болж, Бурхан Халдуныг гөрөөс гөрөөлөхөд сайн газар хэмээн, Бурхан Халдуны эзэд **бурхан босгогсон**[10], Шинч баян урианхайн нүүж ирсэн ажээ. Хорь Түмэдийн Хорилардай мэргэний охин Ариг уснаа төрсөн Алангоог тэнд гуйж Добун мэргэний гэрлэсэн ёсон тийм.

10. Алангоо Добун мэргэнд ирж хоёр хүү төрүүлэв. [Тэд] Бүгүнүтэй, Бэлгүнүтэй нэрт бөлгөө.

11. Дува-Сохор ах нь дөрвөн хөвүүнтэй бөлгөө. Тэгэж байтал Дува-Сохор ах нь үгүй болов. Дува-Сохорыг үгүй болсны хойно, дөрвөн хөвүүд нь Добун мэргэн авгаа ураг [төрөлд] үл тооцон доромжилж, хагацаж гээж нүүв. Дөрвөн овогтон болж Дөрвөд иргэн тэд болов.

12. Түүний хойно нэгэн өдөр Добун мэргэн Тохоцаг өндөр дээр гөрөөлөхөөр гарав. Ой дотор урианхадай хүн **гунан буга**[11] алаад **хавирга, хошногыг**[12] нь шарж бүхүйд, золгож .

13. Добун мэргэн өгүүлрүүн: "**нөхөр шорлогдоо**[13]" гэж [махнаасаа] өгөхүү гэвэл **уушигт зүлд**[14], арьсыг нь авч гунан бугын мах цөмийг Добун мэргэнд өгөв.

14. Добун мэргэн тэр гунан бугыг ачиж явах зууpаа нэгэн ядуу хүн хөвүүнээ хөтлөж явахыг үзэж.

15. Добун мэргэн "Юун хүн чи" хэмээн асууваас, тэр хүн өгүүлрүүн: "Би Маалиг Баягудай [хүн], ядарч явна. Тэр гөрөөсний махнаас надад өг. Би энэ хөвүүнээ чамд өгье" гэжээ.

16. Добун мэргэн тэр үгэнд гунан бугын өрөөл гуяы нь таслаж өгч, тэр хөвүүний нь авч ирж гэртээ зарж суух бөлгөө.

17. Тэгэж байтал Добун мэргэн үгүй болов. Добун мэргэний үгүй болсны хойно Алангоо бэлэвсэн бөгөөтөл гурван хөвүүн төрүүлэв. [Тэд] Бугу Хатаги, Бугуту Салжи, Бодончар Мунхаг

нэртэй бөлгөө.

18. Урьд Добун мэргэнээс төрсөн Бэлгүнүтэй, Бүгүнүтэй хоёр хөвүүд нь эх юүгээ Алангоог далдуур өгүүлрүүн: "Энэ эх, бидний ах **Үеэлд хаяалд**[15] хүн үгүй, эр үгүй бөгөөтөл эд гурван хөвүүдийг төрүүлэв. Гэр дотор гагц Маалиг баягуудай хүмүүн буй. Эд гурван хөвүүд түүнийх буй за" хэмээн эх юүгээ эчнээ хэлэлцэхийг Алангоо эх нь ухаж [мэдээд]

19. Хаврын нэгэн өдөр хонины **борц**[16] чанаж Бэлгүнүтэй, Бүгүнүтэй, Бугу Хатаги, Бугуту Салжи, Бодончар Мунхаг энэ таван хөвүүдээ зэрэгцүүлэн суулгаж нижгээд **сумыг**[17] "хугалагтун" гэж өгөв. Ганц [сумыг] амархан хугачиж орхив. Бас таван сумыг хамт боож "хугалагтун" гэж өгөв. Тавуул, таваар [багцлан] боосон сумыг хүн хүн авч **тойруулж**[18] [оролдоод] хугалан ядав.

20. Тэрэнд Алангоо эх өгүүлрүүн:

21. "Бэлгүнүтэй, Бүгүнүтэй та хоёр хөвүүд минь намайг энэ гурван хүүхдийг төрүүлэв. Хэний юун хөвүүд вэ хэмээн сэрдэн хэлэлцэв. Сэрдэх чинь зөв. Шөнө бүр цэгээн шар хүн, гэрийн өрх, тотгын гэгээгээр орж [ирээд] хэвлийг минь **илбэж**[19] гэгээ [гэрэл] нь хэвлийд минь шингэх бөлгөө. Гарахдаа [тэр хүн] наран сарны **завсраар**[20] **шар нохой**[21] мэт шазвалзан гарах бөлгөө. Та нар дэмий яахан өгүүлнэ. Тэр тэмдгээр үзвэл тэнгэрийн хөвүүд буюу за

Хар тэргүүт хүнтэй
Ханисган (ижилсэгэн) яахан өгүүлнэ та нар
Хамгийн хаад болбоос
Харцас тэнд мэднэ" хэмээв.

22. Бас Алангоо таван хөвүүддээ **соёрхол**[22] уг өгүүлрүүн: "**Та** таван хөвүүд миний ганц хэвлийгээс төрөв. Та нар **саяын**[23] **таван** сум мэт ганц ганцаар болвол түрүүчийн сум мэт хэн бүхнээ **хялбархан** дийлэгдэнэ. Тэр багцалсан сум мэт хамт нэгэн эеэр **явбаас** та нар хэнд ч яахан хялбархан үл дийлэгдэнэ" хэмээв. Тэгэж **байтал** Алангоо эх нь үгүй болов.

23. Алангоо эх юүгээ үгүй болсны хойно ах дүү нар тавуулаа **адуу** [мал], идээ [хөрөнгөө] хуваалдахад, Бэлгүнүтэй, Бүгүнүтэй,

Бугу Хатаги, Бугуту Салжи дөрвүүл авч, Бодончар Мунхагийг бядуу (ядуу) хэмээн урагт үл тооцон хувь эс өгөв.

24. Бодончар урагт эс тоологдож энд юу хийж [сууна] гээд гол дайрт годил (суман) сүүлт орог шунхлыг (буган хээр) унаж, **"үхвэл үхье, сэхвэл сэхье"**[24] гэж Онон мөрөн рүү давхин одов. Балжийн аралд хүрч ирж, тэнд өвсөн **эмбүүл**[25] гэр барьж **ан суув**[26]

25. Тэгэж байтал борогчин харцага, хар хурыг барьж идэж байхыг үзэж гол дайрт годил сүүлт орог шунхлын хялгасаар урихдан барьж тэжээв.

26. [Бодончар] идэх идээн үгүй **агсанд**[27] чонын гууд хоргоосон гөрөөсийг мярааж харваж алж иднэ. [Бас] чонын барьж идсэн [сэгийг] түүж **идээд**[28] өөрийн ходоод, харцгаа тэжээсээр тэр он гарав.

27. Хавар болов. Нугас ирэх цагт харцгаа **сойж тавив**[29].

Нугас, галуудыг
Хожуул тутам
Хуршуулаад[30]
Ёзоор тутам[31]
Лэгшүүлээд[32]
Үнэрттэл дэлгэв.

28. Дүйрэн [уулын] хяраас Түнхэлиг горхи уруу [нэгэн] бүлэг иргэн нүүж ирэв. Бодончар тэр иргэнд харцагаа орхин одож өдөр эсэгчилж (айраг цэгээ ууж) шөнө өвсөн эмбүүл гэртээ ирж хонох бөлгөө.

29. Тэд иргэн Бодончарын харцагыг гуйваас эс өгөв. Тэд иргэн Бодончарыг "Хэн, юун [хүн] бэ" хэмээн асуух үгүй. Бодончар тэд иргэнийг "юун иргэн" хэмээн асуулцах үгүй явцгаав.

30. Бугу Хатаги ах нь Бодончар Мунхаг дүүгээ энэ Онон мөрөн рүү явлаа гэж эрж ирээд Түнхэлэг горхи уруу нүүж ирсэн иргэдээс "тийм морьтой, тийм тийм [маягийн] хүн [үзэгдэв үү]" хэмээн сураглаваас

31. Тэд иргэн өгүүлрүүн: "Хүн, морь нь чиний сураглахтай адил буюу. [Тэр хүн] харцагатай буюу өдөр бүр манд ирж эсэгчилж

одно. Шөнө [тэр] магад хаана хонох ажгуу? Баруун хойноос салхи салхилахад харцагаар бариулсан нугас, галуудын өд сөд нь цас бургинах мэт бутарч хийсэж ирнэ. Энд ойр буй за. Одоо ирэх цаг болов. Түр хүлээ" хэмээв.

32. Хоромхон атал Түнхэлиг горхи өөд нэгэн хүн айсуй буюу. Хүрч ирвээс Бодончар мөн ажгуу. Бугу Хатаги ах нь [дүүгээ] үзээд таньж дагуулж аваад Онон мөрөн өөд хатируулан зорчиж одов.

33. Бодончар Бугу Хатаги ахынхаа хойноос дагаж хатирч явах [зуур] өгүүлрүүн: "Ахаа ахаа! **Бие түрүүтэй, дээл захтай сайн**"[33] хэмээв. Бугу Хатаги ах нь тэр үгий нь юман тоонд эс бодов.

34. Бас мөн үгээ өгүүлбээс ах нь [мөн] юман тоонд үл болгон хариуд нь үл дуугарав. Бодончар [жаахан] явж [байгаад] бас мөнхүү үгээ өгүүлэв. Тэр үгний [хариуд] ах нь өгүүлрүүн: "Түрүүнээс [хойш] дахин дахин ямар үг өгүүлнэ чи" гэв.

35. Тэндээс Бодончар өгүүлрүүн: "Саяын Түнхэлэг горхиноо бүхий иргэн их бага, муу сайн, адаг түрүү үгүй [эн] сацуу буй. Хялбар иргэн буй. Бид тэднийг **дагуулья**[34] хэмээв.

36. Тэндээс ах нь өгүүлрүүн: "За тийм бөгөөс гэртээ хүрч, ах дүү нар **зөвлөлдөж**[35] тэд иргэнийг дагуулъя" гэлдээд

37. Гэртээ хүрч ирж ах дүү нартайгаа хэлэлцээд [буцаж] мордов. Мөн Бодончарыг **хошууч**[36] [болгон] довтолгов.

38. Бодончар хошууч [болон] довтолж [явах] дунд [нэгэн] жирэмсэн эмийг барьж "Чи юун хүн" хэмээн **асуув**[37]. Тэр эм өгүүлрүүн: "Би Жарчиуд аданхан урианхай **эмэгтэй**[38]" хэмээв.

39. Тэд иргэнийг ах, дүү тавуул дагуулж, адуу [мал] идээ [хүнс], ард боолыг [нь] **эзэгнэн**[39] суух болов.

40. Тэр дотор жирэмсэн эм Бодончарт ирж хүү төрүүлэв. "[Түүнийг] жад (харь) иргэний хөвүүн бөлгөө" хэмээн Жажирадай [гэж] нэрийдэв. Жадараны өвөг тэр болов. Тэр Жажирадайн хөвүүн Түгүүдэй нэрт бөлгөө. Түгүүдэйн хөвүүн Бури Булчиру бөлгөө. Бури Булчиругийн хөвүүн Хар Хадаан бөлгөө. Хар Хадааны хөвүүн Жамуха бөлгөө. Жадаран овогтон тэд болов.

41. Тэр эм бас Бодончараас нэгэн хөвүүн төрүүлэв. "Барьж авсан эм бөлгөө" хэмээн тэр хөвүүнийг Бааридай [гэж] нэрийдэв. Баарины өвөг тэр болов. Бааридайн хөвүүн Чидхул бөх, Чидхул бөх эмс олонтой бөлгөө. Хөвүүд нь **мэнэ**[40] мэт [олон] төрөв. Мэнэн Баарин овогтон тэд болов.

42. Бэлгүнүтэй бэлгүнүд овогтон болов. Бүгүнүтэй бүгүнүд овогтболов. Бугу Хатаги хатагин овогтон болов. Бугуту Салжи салжууд овогтон болов. Бодончар боржигин овогтон болов.

43. Бодончарын авааль эмээс төрсөн [хөвүүн нь] барим шийрт Хабичи нэрт бөлгөө. Тэр Хабичи баатрын эхийн инжид ирсэн [эмийг] Бодончар татвар [эмээ болгож] нэгэн хөвүүн төрүүлэв. [Тэр] Жэүрэдэй нэрт бөлгөө .Жэүрэдэй урьд **тайлгад**[41] орж байсан бөлгөө.

44. Бодончарыг үгүй болсны хойно тэр Жэүрэдэйн "гэрт **ямагт**[42] аданхан урианхадай [хүн] байлаа. Түүний [хөвүүн] буй за" хэмээн тайлгаас гаргаж Жэүрэйид овогтон болгожээ. Жэүрэйидийн овог тэр болов.

45. Хабичи баатрын хөвүүн Мэнэн тудун бөлгөө. Мэнэн тудуны хөвүүн Хачи хүлүг, Хачин, Хачиу, Хачула, Хачиун, Харалдай, Начин баатар долоо бөлгөө

46. Хачи хүлүгийн хөвүүн Хайду Номулун эхээс төрсөн бөлгөө. Хачины хөвүүн Ноёгидай нэртэй бөлгөө. Ноёнсог авиртай тул ноёхон овогтон болов. Хачиугийн хөвүүн Баруладай нэрт бөлгөө. Их биетэй, идээ [хоол] барах бөлгөө. [Тэр] Барулас овогтон болов. Хачулагийн хөвүүн [бас] идээн барах тул Их барула, Өчүүхэн барула [хэмээн] нэрийдэж барулас овогтон болгож эрдэмт барула, төдөгэн барула тэргүүтэн барулас тэд болов. Харалдайн хөвүүд будаа хутгалах [мэт] эх, түрүү үгүй тул будаад овогтон тэд болов. Хачиуны хөвүүн Адархитай нэрт бөлгөө. Ах дүү [өөр] зууpаа адралдагч тул адархин овогтон болов. Начин баатрын хөвүүд Уруудай, Мангудай нэрт бөлгөө. Урууд, Мангуд овогтон тэд болов. Начин баатрын авааль эмээс төрсөн [хүүхэд нь] Шижуудай, Доголадай нэрт бөлгөө.

47. Хайдугийн хөвүүд Бай Шинхор догшин, Чарахай Линху, Чаужин өртэгэй гурав бөлгөө. Бай Шинхор догшины хөвүүн Тумбинай сэцэн бөлгөө. Чархай Линхугийн хөвүүн Сэнгүм билгэ. Амбагайтан тайчууд овогтон болов. Чарахай Линхугийн [эхнэрээ болгосон] бэргэн эмээс төрсөн [хүү] Бэсүдэй нэрт бөлгөө. Бэсүд овогтон тэд болов. Чаужин Өртэгэйн хөвүүд: Оронар, Хонхотан, Арулад, Сөнид, Хабтурхас, Тэнигэс овогтон тэд болов.

48. Тумбинай сэцэний хөвүүн Хабул хаан, Сэм сэчүлэ хоёр бөлгөө.Сэм сэчүлэгийн хөвүүн Бүлтэчү баатар бөлгөө. Хабул хаан долоон хөвүүнтэй бөлгөө. Ууган их [хөвүүн] нь Охин Бархаг [удаах нь] Бартан баатар, Хутугту Мүнгүр, Хутула хаан, Хулан, Хадаан Төдөгэн отчигин (отгон) эд долоо бөлгөө.

49. Охин Бархагийн хөвүүн Хутугту Йүрхи бөлгөө. Хутугту Йүрхийн хөвүүд **Сэчэ-бэхи**[43] Тайчу хоёр бөлгөө. Йүрхи овогтон тэд болов.

50. Бартан баатрын хөвүүд **Мэнгэтү хиан,**[44] Нэгүн тайж, Есүхэй баатар Даридай отчигин энэ дөрөв бөлгөө. Хутагту Мүнгүрийн хөвүүн Бүри бөхө бөлгөө. Ононы балар **ойд**[45] хуримлахуй [цагт] Бэлгүдэйн мөрийг **ангас**[46] [хийтэл] цавчсан тэр бөлгөө.

51. Хутула хааны хөвүүд Жочи, Гирмау, Алтан гурав бөлгөө. Хулан баатрын хөвүүн Их Чэрэн бөлгөө. Бадай, Хишилиг хоёр Дархадын ноён тэр бөлгөө. Хадаан, Төдөгэн хоёр ураг [угсаа] үгүй бөлгөө.

52. Хамаг монголыг Хабул хаан мэдэлдээ авав. Хабул хааны дараа, Хабул хаан өөрийн долоон хөвүүдээ байтал Сэнгүм Билгэгийн хөвүүн Амбагай хаанд Хамаг Монголыг мэдүүлэх болов.

53. Буйр нуур, Хөлөн нуур хоёрын завсарт Оршуун мөрнөө бүхүй айригуд, Буйругуд, Татар иргэнээ Амбагай хаан охин өгч өөрөө охиноо үдэж очиход Татар **зүйн иргэн**[47] Амбагай хааныг барьж **Хятаны**[48] Алтан хаанд авч одохуйд Амбагай хаанд авч Амбагай хаан Бэсүдэйн Балахачи (Барахачи ?) [гэдэг] хүнийг

элчээр өгүүлэж илгээрүүн "Хабул хааны долоон хөвүүдийн дундах Хутулад өгүүлрүүн: [Миний] арван хөвүүдийн дотор Хадаан тайжид [очиж] хэл хэмээн өгүүлж илгээхдээ "Хамгийн хаан улсын эзэн байж охиноо өөрөө хүргэхийг надаар гэсгээгтүн! Би Татар иргэнд баригдлаа.

Таван хурууныхаа хумсыг
Тамтартал
Арван хуруудаа
Авчтал[49]
Ачий[50] минь авран тэмцэгтүн"

гэж илгээжээ.

54. Тэр цагт Есүхэй баатар Онон мөрнөө Шувуу агнаж явах зуур Мэргэдийн Их Чилэдү Олхунууд иргэнээс гэргий аваад буцаж явахад уулзаж [тэргийг] өнгийж үзвээс өнгө зүс **ижилгүй**[51] [үзэсгэлэнтэй] залуу хатан байсанд гэртээ харьж Нэгүн тайж ах юугаа Даридай отчигин дүүгээ тэргүүлэн [хүрч] иржээ.

55. Хүрч ирэхэд Чилэдү айжээ. [Тэр] **Хурдан хул**[52][морьтой] ажгуу. Хул юугаа гуяыг нь ташуурдаж **гүвээ даван**[53] дутаахад хойноос нь гурвуул удааралдан [нэхэв]. Чилэдү **хошуу тойрон**[54] тэргэндээ буцаж ирвэл тэнд Өэлүн үжин өгүүлрүүн: "Тэр гурван хүнийг ухаж [мэдэв үү] чи. [Тэдний] царай [гэж] царай биш буй. Аминд чинь хүрэх амьтад байна. Амь мэнд бөгөөс

Өлжиг (суудал) тутам
Охид
Хараа (мухлаг) тутам
Хатад буй.

Амь мэнд гарваас охид хатад олох буй за чи. Өөр нэртийг [авбал] чи Өэлүн **гэж**[55] нэрлээрэй. Амиа хоргоо! Үнэрий минь үнэрлэж яв хэмээн цамцаа мултэлж [өгөхөд] морин дээрээс **налсхийж**[56] авмагц, гурван [морьтон] хошуу тойрон гарч ирэхэд Чилэдү хурдан хулын гуяыг ташуурдан яаран зайлж Онон мөрөн өөд дутаав.

56.Гурвуул хойноос [нь] нэхэж долоон гүвээ давтал үлдэн [хөөж] буцаж ирж Өэлүн үжинг Есүхэй баатар **бурантагнаас**[57]

хөтлөж. Нэгүн тайж ах нь дагуулж , Даридай отчигон дүү нь [тэрэгний] **арал**[5/8] зэрэгцэж авахуйд Өэлүн үжин өгүүлрүүн:

"Чилэдү ах минь
Хий (салхи) өөд
Хөхлөө хийсэгсээр
Хээр газар
Хээлээ (гэдсээ) өлсөгсөөр буй заа

Одоо энэ хоёр **шивэргэл [гэзгээ]**[59] нэгний нь ар тийш нөгөөгий нь өвөр тийш хаяж, урагш хойш унжуулж яахан ингэж явна" гээд

Онон мөрнийг долгилтол
Ой **хөндийг**[60] дууристал их дуугаар уйлж явахуйд Даридай Отчигин зэрэгцэн явж өгүүлрүүн:

"Тэврэх [эр] чинь
Даваа олныг давав.
Уйлуулах [эр] чинь
Ус олныг гэтлэв.
Хайлж [уйлавч]
Харж үл үзнэ чамайг
Хайж [эрэвч]
Хаалга (зам)[61] нь үл олох чи чимээгүй бол" гэж ятгав. Өэлүн үжинийг Есүхэй гэртээ ингэж авч ирэв. Өэлүн үжинийг Есүхэйн авч ирсэн ёсон тийм.

57. Амбагай хаан, Хадаан, Хутула хоёрыг нэр зааж илгээснээр Хамаг Монгол, Тайчууд Ононы Хорхонагийн хөндийд цугларч Хутулыг хаан болгов. Монголын жаргалан нь бүжиглэн, хуримлан цэнгэх бөлгөө. Хутулыг хан өргөмжлөөд Хорхонагийн **саглагар мод**[62] орчин [тойрон]

Хавиргандаа
Ханчир [болтол]
Өвдөгөндөө
Өвчин ортол[63] бүжиглэв.

58. Хутула хаан болоод Хадаан тайж хоёул Татар иргэнд морилов. Татарын Хөтөн Бараха, Жали Буха хоёртой арван гурван

удаа хатгалдсан (тулалдсан) боловч Амбагай хааны
Өшил өшин
Хясал хясан ядав.

59. Тэнд Есүхэй баатар, Татарын Тэмүжин Үгэ, Хори Буха тэргүүтэн Татар [иргэдийг] дагуулж ирэх үед жирэмсэн байсан Өүлэн Үжин, Ононы Дэлүүн болдог [гэдэг газар] бүхийд **чухам тэнд**[64] Чингис хааныг төрүүлжээ. [Чингис] төрөхдөө баруун гартаа шагайн чинээ **нөж**[65] атган төржээ. Татарын Тэмүжин Үгээг авч ирэхэд төрөв хэмээн Тэмүжин нэр өгсөн [учир] тийм

60. Есүхэй баатрын Өүлэн Үжингээс Тэмүжин, Хасар, Хачиун, Тэмүгэ эдгээр дөрвөн хөвүүн төрөв. Тэмүлүн нэртэй нэгэн охин төрөв. Тэмүжинг есөн настай байхад Зочи Хасар долоон настай, Хачиун Элчи таван настай, Тэмүгэ Отчигин гурван настай. Тэмүлүн өлгийтэй [байсан] бөлгөө.

61. Есүхэй баатар Тэмүжинийг есөн настай байхад Өэлүн эхийн төрхөм Олхунууд иргэн нагац нараас нь охин гуйя хэмээн Тэмүжинийг аваад зорчив. Явах [замдаа] Цэгцэр, Чихургу хоёрын завсарт Хонгирадын Дэй Сэцэнтэй уулзав.

62. Дэй сэцэн өгүүлрүүн: "Есүхэй худ юунд зорьж явна" гэсэнд Есүхэй баатар өгүүлрүүн: "Энэ хөвүүндээ нагац нар Олхунууд иргэнээс охин гуйя хэмээн явна" гэжээ. Дэй сэцэн өгүүлрүүн: "Энэ хөвүүн чинь
Нүдэндээ галтай
Нүүрэндээ гэрэлтэй хөвүүн байна."

63. Есүхэй худ би энэ шөнө [нэгэн] зүүд зүүдлэв. **Цагаан шонхор**[66] нар, сар хоёрыг атган нисч ирээд гар дээр минь суув. Энэ зүүдээ бусдад өгүүлрүүн: Нар, сарыг [бид] харж, үздэг бөлгөө. [Харин] одоо энэ [зүүдэнд] шонхор атган авчирч гар дээр минь суув. Цагаан [гэрэл] буувааа. Ямар сайн [зүйл] үзүүлэх бол гэсэн нь Есүхэй худ чамайг эл хөвүүнээ дагуулж ирэхийг энэ зүүд минь мэдсэн ажээ. Зүүд мэргэн зүүдлэв.

Юун зүүд байх вэ? Танай Хиад иргэний **сүлд**[67] ирж заасан ажгуу.

64. Бид Хонгирад иргэн эрт өдрөөс
Зээгийн зүс
Охины өнгөтөн улс
Үл тэмцэлдэн
Хацар гоо охидыг
Хаан болсон танд
Хасаг тэргэнд[68] суулгаж
Хар буур хөллөж
Хатируулан одож
Хатан сууринд
Хамт суулгамуу
Бидний улс иргэн
Үл тэмцэлдэнэ бид
Өнгө сайт охидоо өсгөж
Өлжигт (суудалт) тэргэнд суулгаж
Өл буур хөллөж
Үүсгэж одож
Өндөр сууринд
Өрөөл талд нь суулгаж
Хонгирад иргэн
Бид эртнээс [нааш]
Хатан халхтан
Охид өчилтэн[69]
Зээгийн зүс
Охины өнгөөр [явж] бөлгөө бид.

65. Нуган хүүхэд маань
Нутгаа харъюу
Охин хүүхэд маань
Өнгө шилэгдьюү
Есүхэй худ гэрт минь очъё

Өчүүхэн охиныг минь худ үзтүгэй гэж Дэй сэцэн [Есүхэйг] гэртээ дагуулж [ирж] буулгав.

66. Охиныг үзвээс:

Нүүрэндээ гэрэлтэй

Нүдэндээ галтай охин [байсан тул] санаанд нь таалав. Тэмүжинээс нэг нас эгч аравтай ажгуу. Бөртэ нэртэй [ажээ].

Шөнө [тэндээ] хонож маргааш охиныг нь гуйваас Дэй сэцэн өгүүлрүүн:

Олонтаа гуйлгаж өгвөөс дээжлэгдэх

Цөөнтэз гуйлгаж өгвөөс доромжлогдох охин хүний заяа төрсөн үүдэндээ өтлөх үгүй [тул] охиноо ч өгье хөвүүнээ мөн **хүргэд талбиж**[70] од хэмээв. Зэ [зүү] бололцож Есүхэй баатар өгүүлрүүн: "Хөвүүнээ хүргэдэд талбия. Хүү минь нохойноос цочимтгой бөлгөө. Худ хөвүүнийг минь нохойноос бүү цочуул" гээд хөтөлгөө морио бэлэг өгч Тэмүжинийг хүргэдэд талбиж оджээ.


67. Есүхэй баатар замдаа Цэгцэрийн шар хээр талд татар иргэн хуримлаж бүхийд тааралдаад ундаасч [явсан тул] хуримд буув. Тэд татар танин "Есүхэй Хиан (Хиад овгийн ганц тооны хэлбэр) ирж" гээд уридны булаагдсан **хорсолоо**[71] дурдаж өшөөлдөн **хорлож**[72] идээнээ хор хольж өгжүхэй. Замдаа [бие нь] муудаж гурван хоног явж, гэртээ хүрээд [улам] дорой болж

68. Есүхэй баатар өгүүлрүүн: "Дотор минь муу байна. [Ойр] **зэргэлдээ**[73] хэн байна" гэвэл Хонхотаны Чараха овгөний хөвүүн Мунлиг ойр байна гэвэл [түүнийг] урьж ирүүлж өгүүлрүүн: "Мунлиг хүү минь! Хүүхдүүд [маань] балчир бөлгөө. Би Тэмүжин хүүгээ хүргэдэд талбиж ирэх зуур татар иргэдэд хорлогдлоо. Дотор минь муу байна. Нялх хоцорсон дүү нараа, бэлбэсэн бэргэнээ асрахыг чи мэд. Хүү минь Тэмүжинийг хурдхан явж авчир. **Мунлиг хүү**[74] минь" гээд нас нөгчив.



Хоёрдугаар бүлэг





69. Есүхэй баатрын үгийг [яаралтай] хэрэг болгон Мунлиг, Дэй сэцэнд очиж өгүүлрүүн: "Есүхэй ах Тэмүжинг маш [их] мөрөөдөж, санаа зовох [тул] Тэмүжинийг авахаар ирэв" гэжээ. Дэй сэцэн өгүүлрүүн: "Худ хөвүүнээ мөрөөдөх бөгөөс явтугай. [Харин] уулзаад үтэр [эргэж] иртүгэй" гэхэд Мунлиг эцэг Тэмүжинийг авч ирэв.

70. Тэр хавар Амбагай хааны хатад Орбай, Сохатай хоёр ихсийн **газар тайлга**[75] гаргасанд Өэлүн Үжин хожимдож хүрч очоод, хожимдуулсан Орбай, Сохатай хоёрт Өэлүн Үжин өгүүлрүүн: "Есүхэй баатрыг үхэв үү гэж хөвүүдийг минь том болоогүй гэж ихэсийн хишигээс [идээ] **шүүснээс**[76], сархадаас яахан хождуулав та нар

Үзтэл [амьхандаа] идэх
Үл сэрээн нүүх болов та нар" хэмээжүхэй.

71. Тэр үгэнд Орбай, Сохатай хоёр хатад өгүүлрүүн:

Урьж үл өгүүлэх жамтай чи
Учирваас идэх ёстой чи
Хүргэж үл өгүүлэх жамтай чи
Хүртэвээс идэх ёстой чи

Амбагай хааныг үхэв үү чи гэж Өэлүнд хүртэл ийн хэлэгдэх болов.

72. "**Аргацаан**[77] эх, хөвүүд эднийг нутагт орхиж нүүе. Та нар бүү авч явагтун" гээд маргааш өдрөөс Тайчуудын Таргудай Хирилтуг, Төдэйн Гиртэ тэргүүтэн тайчууд Онон мөрөн рүү хөдлөв. Өэлүн Үжинийг ихэс хөвүүдийг орхиж нүүсэнд Хонхотаны Чараха өвгөн [нүүгсэдийг] очиж ятгахуйд Төдэйн Гиртэ өгүүлрүүн:

"Цээлийн ус **тасарлаа**[78]

Цэгээн чулуу цуурлаа" хэмээн Чараха өвгөнийг "Чи хэрхэн ятгана" гээд зоо нурууг нь араас нь жадаар хатгаж [орхиод] нүүцгээв.

73. Чараха өвгөн шархтай болж гэртээ ирж , хүндэрч хэвтэхүйд Тэмүжин **уулзахаар**[79] оджээ. Тэрэнд Хонхотаны Чараха өвгөн өгүүлрүүн: "Сайн эцгийн чинь хураасан улсыг манай бүх иргэдийг авч нүүхийг [болиулахаар] ятгаж яваад ийм болов" хэмээжээ. Түүнд Тэмүжин уйлаад гарч явав. Өэлүн Үжин орхин нүүгсэд рүү туг барин биеэр мордож зарим иргэдийг няцаав (буцаав). Тэд буцсан иргэн үл тогтон Тайчуудын хойноос нүүжээ.

74. Ах, дүү Тайчууд [нар ингэж] бэлэвсэн Өэлүн Үжинийг их, бага хөвүүдтэй [нь] нутагт орхиж нүүцгээжээ.

Өэлүн Үжин эхнэр мэргэн төрж
Өчүүхэн хөвүүдээ тэжээхээр
Өхийтөл богтлож[80] **огдойтол бүслэж**[81]
Онон мөрний өөд уруу гүйж
Олирс, **мойлс**[82] түүж
Өдөр, шөнө хоолой тэжээв.
Сөстэй[83] төрсөн Үжин эх
Суут хөвүүдээ тэжээхээр
Цөөрсөн[84] шор барьж
Сүдэн гичгэнэ[85] ухаж тэжээв.
Эх Үжиний
Халиар мангираар тэжээсэн хөвүүд
Хаад болохуйд хүрэв.
Зарчимтай Үжин эхийн
Заргасаар[86] тэжээсэн хөвүүд
Засагтан сэцэд болов.

75. Гоо Үжиний
Гогод мангираар тэжээсэн
Хорчгор[87] [туранхай] хүүхдүүд
Хуультан[88] сайцуул болов.

Эрс сайд болон өсч
Эрхин омогтон эл болов.
Ээж юүгээ тэжээе хэмээлдэж
Эх Ононы эрэг дээр сууж
Өлгүүр гохыг засацгааж
Эрэмдэг зэрэмдэг загасыг
Өлгөж, гөхийлж [бариад]
Зүүгээр дэгээ матаж
Зэвэг, хадар[89] гөхийлдөж
Цалам гувчуур уяж
[Чадалгүй] заримы нь шүүж
Амраг эх юүгээн
Ачлан тэжээх [болов].

76. Нэгэн өдөр Тэмүжин, Хасар, Бэгтэр, Бэлгүдэй дөрвүүл хамт сууж, гөхий татаж гаргасанд нэг өнгөлөг **сугас**[90] [дэгээнд] оржээ. [Түүнийг] Тэмүжин, Хасар хоёроос Бэгтэр, Бэлгүдэй хоёр булааж авав. Тэмүжин, Хасар хоёр гэрт ирж, Үжин эхэд өгүүлрүүн: "Нэгэн өнгөлөг сугас гөхий зуусныг Бэгтэр, Бэлгүдэй ах дүү хоёр булааж авав" хэмээвээс Үжин эх өгүүлрүүн: "**Юү гэж**[91] ах дүү та нар яахан тийн хийлдэнэ?

Сүүдрээс өөр нөхөр үгүй
Сүүлнээс өөр **ташуур**[92] үгүй буй бид. Ах дүү Тайчууд нараас өшөөгөө бид хэрхэн авна хэмээж бүхийд эртний Алан гоо эхийн таван хөвүүд мэт та нар яахан [ингэж] эе үгүй буй? Бүү тэг" хэмээв.

77. Тэндээс Тэмүжин, Хасар хоёр үл таалан өгүүлрүүн: "Өцөгдөр нэг бялзуухай харвасныг тийнхүү булааж авлаа, Одоо бас тийнхүү булаав. Бид хамт хэрхэн **сууна**[93]" гээд үүд хаяж гарч одов. Бэгтэр **довцог**[94] дээр шарга агттан есөн морио харж сууж бүхүйд Тэмүжин араас далдлаж, Хасар өмнөөс далдлаж сумаа **онилоод**[95] ирэхийг Бэгтэр үзээд өгүүлрүүн: "Ах дүү Тайчуудын хөнөөлийг баран ядан, хэрхэн өшөөгөө авна хэмээж бүхүйд намайг яахан нүдний сормос, амны хахаас болгоно та нар?"

Сүүдрээс өөр нөхөр үгүй
Сүүлнээс өөр ташуур үгүйд яахан тийн сэтгэв та нар? Голомтыг минь бүү бүрэлгэгтүн! Бэлгүтэйг бүү тэвчигтүн! хэмээгээд завилан сууж хүлцэв. Тэмүжин, Хасар хоёр өмнө хойноос нь **үтэр**[96] харваж одов.

78. Үжин эх хоёр хүүхдээ гэрт орж ирэхэд царайг [нь үзэж] мэдээд өгүүлрүүн:

"[Ханиа] барагсад!
Халуунаас (хэвлий) минь халт
(гэнэт) гарруун
Гартаа хар нөж атгаж төрлөө энэ!
Харбисаа (хальс навчаа) хазах хасар
нохой мэт
Хаданд довтлох **хаблан (бар)**[97] мэт
Агураа даран ядах арслан мэт
Амьдаар залгис хийх мангас мэт
Сүүдрээ довтлох шонхор мэт
Сэмээр залгих цурхай мэт.
Ботгоныхоо борвийг хазах буур мэт
Бороонд өнгийх чоно мэт
Хөвүүдээ хөөн ядаж идэх ангир мэт
Хэвтэшээ хөндөвөөс өмөөрөх цөөвөр мэт
Барьж үл саарах барс мэт
Балмад довтлох **Баруг (нохой)**[98] мэт барав.
Сүүдрээс өөр нөхөр үгүйд
Сүүлнээс өөр ташуур үгүйд ах дүү Тайчуулын хөнөөлийг баран ядаж бүхийд хариугаа хэн [хэрхэн] авна хэмээж байхад юунд ийм юм хийцгээнэ та нар" хэмээн хөвүүдээ

Хуучин үгс **үндэслэж**[99]
Өтгөс үгс **ишлэж**[100] машид буруушаав.

79. Тэгэж байтал Тайчуудын Таргудай, Хирилтуг шилдэг [нөхдөө] удирдаж

"**Хулхи**[101] [нь] гуужиж

Шүлс[102] [нь] сэвэрчихлээ" хэмээн [довтлон] ирэв. Эх хөвүүд айцгааж ах дүү нар [цөм] ой шугуйд [орж] хоргодож, Бэлгүдэй мод хуга таталж, шивээ барьж, Хасар харвалдаж, Хачиун, Тэмүгэ, Тэмүлүн гурвыг [уулын ангал] зав зайд хийж, **тэмцэлдэн**[103] бүхүйд Тайчууд бархиран өгүүлрүүн: "Ахыгаа, Тэмүжинийг явуул! Бусад чинь хэрэггүй" хэмээн хашгиралдахад Тэмүжинийг буруулан гаргаж, ойд дутаан одохыг Тайчууд үзэж хөөхөд, Тэргүүн өндөрийн шугуйд шургаж орвоос Тайчууд шугуйд орж чадалгүй орчин сахижээ.

80. Тэмүжин шугуй дотор гурав хонож "гаръя" хэмээн морио хөтлөж явахуйд мориноос эмээл нь мултарч унажээ. Эргэж үзвээс эмээл хөмөлдрөг, олонцогтой [атал] мултарч унажээ. Олом [мултарч] болох боловч, хөмөлдрөг бас яахан мултрах бөлгөө? Тэнгэр ятган байна уу? хэмээн эргэж бас гурав хонов. Ахин гарч ирэхүйд шугуйн амсарт **хошлогиийн**[104] чинээ цагаан гүрү (чулуу) амсар бөглөн унажээ. Тэнгэр ятган байна уу? хэмээн буцаж бас гурав хонов. Нийт ес хоног хоол ундгүй ажээ. "Нэр үгүй хэрхэн [ингэж] үхнэ? Гаръя" хэмээж тэр амсар бөглөн унасан Хошлогийн чинээ цагаан гүрүүг тойрон гаръя гэтэл үл болох [тул] моддыг сумч (сум засдаг) хутгаараа огтлоод морио халтирч гулсуулан гарахын хамт, сахиж байсан тайчууд барьж авч одов.

81. Тэмүжинг Таргудай Хирилтуг авч явж улс иргэддээ засаглаж (таниулж), айл бүрт нэг нэг хонуулан хэсүүлэн явахуйд зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдөр тайчууд Ононы эрэг дээр хуримлалдаж нар шингэхэд тарцгаав. Тэмүжинийг тэр хуримд [нэг] хялбар (бядгүй) залуу хүн авч ирсэн бөлгөө. Хуримын ардыг тарцгаахад тэр хялбар хөвүүнээс дөнгөө татан авч толгойруу нь нэгэнтээ дэлдэн гүйж, Ононы балар ой дотор [орж] хэвтвээс [хүнд] үзэгдэх [болов уу] хэмээж усны харгианд гэдрэг [харж] хэвтээд дөнгөө усны уруу урсган нүүрээ ил [гарган] хэвтэв.

82. Тэр алдсан хүн их дуугаар "Барьсан хүнийг алдав" хэмээн хашгирахуйд тарцгаасан Тайчууд цугларч ирж өдөр мэт

саруул [шөнө] Ононы балар ойд [эрж] бэдрэв. Харгиад хэвтэж бүхүйг Сүлдүсний Сорхон шар яг таарч үзээд өгүүлрүүн: "Ийм мэргэн аргатайн тул "нүдэндээ галт, нүүрэндээ гэрэлтэй" гэж ах дүү тайчууд [чамд] тийн **атаархдаг**[105] ажгуу. Чи ингээд хэвт. Би зааж өгөхгүй" гээд өнгөрөв. Бас "эргэж эрцгээе" хэмээлдэхүйд Сорхон шар өгүүлрүүн: "Мөн мөр мөрөөрөө эс үзсэн газраа шалгаж ахин эрцгээе" хэмээв. "За" хэмээлдэв. Мөн мөр мөрөөрөө ахин эрэхэд бас Сорхон шар таарч өгүүлрүүн: "Ах дүү [Тайчууд] чинь ам, шүдээ билүүдэж айсуй. Тэсвэрлэн хэвт" гээд өнгөрөв.

83. Бас "дахин эрье" хэмээлдэхэд Сорхон шар мөн өгүүлрүүн:

Тайчууд, хүүхдүүд та нар гэгээн цагаан өдөр бүхэл хүн алдав. Одоо харанхуй шөнө яаж олох вэ? Бид бас мөн мөр мөрөөрөө эс үзсэн газраа эргэн шалгаад тарцгааж, маргааш өдөр цуглаж эрье. Тэр дөнгөтэй хүн хаа [хол] одох вэ?" хэмээв. "За" хэмээлдэж ахин хайхад Сорхон шар бас тааралдаж, өгүүлрүүн: "Одоо эрцгээгээд харьж маргааш эрье хэмээлдэв. Эдүгээ маныг тарж дуусмагц эх, дүү нараа эрж од! Хүн тааралдваас намайг үзэв хэмээн бүү хэл" хэмээгээд салж явав.

84. **Тэднийг**[106] тарж дуусмагц [Тэмүжин] дотроо бодов. "Өчигдөр айл хэсүүлж хонуулахад Сорхон шарын гэрт хоновоос Чимбай, Чулуун хоёр хөвүүд нь өр зүрх нь өвдөж, шөнө намайг асарч дөнгийг минь авч суллаж хонууллаа. Одоо бас Сорхон шар намайг үзээд зааж өгөлгүй явав. Эдүгээ мөн тэд намайг аврах болов уу" хэмээн Сорхон шарын гэрийг эрэн Онон мөрөн уруу явав.

85. [Сорхон шарын] гэрийн тэмдэг нь эсэгтээ [айргандаа] сүү **самарч**[107] үүр цайтал шөнөжин бүлэх бөлгөө. Тэр тэмдэгийг сонсож явбаас, бүлүүрийн дуу сонсдож гэрт нь хүрч [очиж] орвоос Сорхон шар: "Эх дүү нараа эрэн од гэж эс хэллүү би? Юунд ирэв чи?" хэмээв. Чимбай, Чулуун хоёр хөвүүд нь өгүүлрүүн: "Шувуухайг **туримтай**[108] бутанд хоргоовоос бут [түүнийг] авардаг. Эдүгээ бидэнд [хүрч] ирснийг яахан тийн хэлнэ та?" хэмээн эцгийнхээ үгийг үл ойшоон гавыг нь салгаж авч галд түлээд, гэрийн

ардах унгастай тэргэнд оруулж Хадаан нэртэй охин дүүгээ "Амьтан хүнд бүү хэл!" хэмээн асруулав.

86. Гуравдугаар өдөр "Хүн нуув"! хэмээлдэж "өөр зууpаа нэгжье" гэлцэж нэгжицгээв. Сорхон шарын гэр, тэрэг, **орны**[109] дор хүртэл нэгжиж, хойд унгаст тэргэнд орж амсар [талын] унгасыг чангаалж [Тэмүжиний] хөлд хүрэх [үед] Сорхон шар: "Энэ бас ийм халуунд унгасан дотор [амьд хүн] яаж тэсэх вэ?" гэвэл нэгжүүлийнхэн бууж явцгаав.

87. Нэгжүүлийг одсоны дараа Сорхон шар өгүүлрүүн: "Намайг үнсээр хийсгэн алдав [чи]. Одоо эх, дүү нараа эрэн од!" хэмээж ам цагаан эрмэг хулагч [гүүг] унуулж, тэлээ хурганы [мах] болгож, **хөхүүр намбуха**[110] бэлтгэж, эмээл хэт үл өгөн, нум хоёр сумтай өгч даруй төхөөрч явуулав.

88. Тэмүжин тэгж яваад шивээлж, хороолсон газартаа хүрч, өвсний налархайгаар Онон мөрөн өөд [мөр] мөшгиж, өрнөөс [урсах] Химурга горьхон уруу ирсэн ажгуу. Тэр өөд [мөн мөр] мөшгөөд Химурга горхины Бэдэр хошууны Хорчухуй болдог бүхүйд уулзалдав.


89. Тэнд нийлэлдэн явж, Бурхан Халдуны өвөр **Гүрэлгү**[111] дотор Сэнгүр горхины Хар зүрхний хөх нуурт нутаглаж ахуйд тарвага, **зурам**[112] алж идэж байв.

90. Нэгэн дөөр шарга агттан найман морьд гэрийн дэргэд байсныг дээрэмчин ирж харж байтал дээрэмдэж явав. Явган [учир] харсаар хоцров. Бэлгүдэй оготор, **нявтал**[113] [үст] хонгорыг унаж тарвагачилахаар явсан бөлгөө. Үдэш нар шингэсний хойно Бэлгүдэй нявтал [үст] оготор хонгорт тарвага нугсалзтал ачиж явган хөтөлж ирэв. "Шарга агттаныг дээрэм авч одов" хэмээвээс Бэлгүдэй өгүүлрүүн: "Би нэхье" хэмээв. Хасар өгүүлрүүн: "Чи чадахгүй би нэхье" хэмээв. Тэмүжин өгүүлрүүн: "Та нар чадахгүй би нэхье" хэмээж нявтал [үст] хонгорыг Тэмүжин унаж шарга агттаныг өвсний налархайгаар [мөрий нь] мөшгиж гурав хонож **өглөө**[114] эрт замд олон адуунд нэг **хөрслөг**[115] залуу хүн гүү сааж байхад уулзалдаж, шарга агттаныг сурваас тэр хөвүүн өгүүлрүүн:

"Энэ өглөө наран ургахын урьд шарга агттан найман морьдыг үүгээр хөөж өнгөрөв. Мөрий нь би зааж өгье" гээд оготор хонгорыг тавиулж Тэмүжинд орог Шунхулыг унуулав. Мөн өөрөө хурдан хулыг унав. Гэртээ очил үгүй намбух суулгаа хээр боож тавив. "Нөхөр чи маш [их] мунгинаж яваа ажээ. Эр хүний мунгинах адил буй за. Би чамд хань болъё. Эцгийг минь Наху баян гэнэ. Би ганц хөвүүн нь, Боорчу нэрт бөлгөө" хэмээгээд шарга агттаныг мөрөөр нь мөшгиж гурав хоног [яваад] үдэш наран гүвээ таших үесээр нэгэн хүрээ иргэнд хүрэв. Шарга агттан найман морьд тэр их хүрээний захад идээшлэж байхыг үзэв. Тэмүжин өгүүлрүүн: "Нөхөр чи эндээ бай. Би тэнд буй шарга агттаныг хөөж гарсугай" хэмээв. Боорчу өгүүлрүүн: "Би хань болоё хэмээн ирсэн билээ. Энд яахан үлдэнэ" гээд хамт довтлож ороод шарга агттаныг хөөж гарав.

91. Хойноос [нь] хүмүүс уван цуван нэхэж айсуй. Нэг уурга барьсан цагаан морьтой хүн ганцаараа гүйцэж ирэхэд Боорчу өгүүлрүүн: "Нөхөр нум сумаа надад аль би харвалдъя" хэмээв. Тэмүжин өгүүлрүүн: "Миний өмнөөс чи эрсдүүзэй! Би харвалдъя" хэмээн гэдрэг харан харвалдав. Тэр цагаан морьт хүн уургаараа тохиж үлдэв. Хойтох нөхөд нь [түүнийг] гүйцэж ирсэн [боловч] нар шингэж, **харуй бүрүй**[116] болсон [тул] хойд [нэхэж ирсэн] тэдгээр хүмүүс харанхуй болгож үлдэж [холдон] хоцров.

92. Тэр шөнө турш [тууж] гурван өдөр гурван шөнө зогсолтгүй явж хүрэв. Тэмүжин өгүүлрүүн: "Нөхөр [минь] би чамгүйгээр энэ морьдыг авч [чадахгүй] бөлгөө. [Тийм учир] хуваая хэдийг авах вэ?" хэмээсэнд Боорчу өгүүлрүүн: "Би сайн нөхөр чамайг мунгинаж явна хэмээн нөхөртөө тус болоё хэмээн дагаж ирэв. Олз олоё гэж [бодсонгүй] би. Эцэг минь Наху баян нэрт буюу. Наху баяны ганц хүү нь би бөлгөө. Эцгий минь хураасан [хөрөнгө] над үлэмж буй . Би авахгүй. [Тэгж] тус болвол юун тус болох [вэ?] авахгүй" хэмээв.



93. Наху баяны гэрт хүрч ирэв. Наху баян хүү Боорчугаа завхаж (алдаж) нус, нулимс болж байв. Гэнэт хүрч [ирсэнд] хүүгээ үзэж нэгэнтээ уйлж нэгэнтээ загнаж [байв]. Хүү Боорчу өгүүлрүүн: "Юу ч болоо үгүй! Сайн нөхөр мунгинаж явсанд би нөхөрлөж яваад одоо ирлээ" гээд мордож явж хээр боож орхисон намбух суулгаа авч ирэв. Тэмүжинд тэлээ хурга алж хүнс [болгож] өгөөд намбух дүүрэн хүнс төхөөрч бэлтгэв. Наху баян өгүүлрүүн: "Та хоёр залуу хүмүүс буй. Бие биенээ **мэдэж [яв]**[117] Мөнөө хойно бүү эвдрэгтүн!" хэмээв. Тэмүжин [тэндээс] гарсаар гурван шөнө гурван өдөр явж Сэнгүр горхинд [байгаа] гэртээ хүрэв. Өэлүн эх, Хасар хийгээд дүү нар нь санаа зовниж **суусан [тул]**[118] уулзалдаж [сэтгэл] баясав.

94. Тэндээс Тэмүжин, Бэлгүдэй хоёр Дэй Сэцэний Бөртэ Үжинийг эрэн Хэрлэн мөрөн уруу одов. [Урьд] есөн настай байхдаа үзэж ирснээс [хойш] уулзалдаагүй бөлгөө. Цэгцэр, Чихургу хоёрын завсар Дэй Сэцэн Хонгирадууд тэнд [нутаглах] ажгуу. Дэй сэцэн Тэмүжинийг үзэж маш их баясаж өгүүлрүүн: "Тайчууд ах дүү чамд атаархаж [байна] хэмээн мэдэж [миний] санаа машид зовнин цөхөрлөө. Чамтай арай **[ядан] уулзав**[119]" гээд Бөрт үжинийг нийлүүлж мордуулав. Мордуулан хүргэхэд Дэй Сэцэн [зам] зууpаа Хэрлэний ураг цөлийн нугаас буцав. Гэргий нь Бөртэ үжиний эх Цотан нэртэй болой. Цотан охиноо үдэж Гүрэлгү дотор Сэнгүр горхиноо бүхүйд хүргэж ирэв.

95. Цотаныг хариулаад Бэлгүдэйг Боорчуд нөхөрлөе хэмээн урьж илгээв. Боорчу Бэлгүдэйг очиход эцэгтээ хэлэлгүй бөгтөр хонгорыг унаад бор өрмөгөө бөгтрөөд Бэлгүдэйн хамт ирэв. Түүний нөхцөж нөхөрлөсөн ёсон тийм [ажээ].

96. Сэнгүр горхиноос нүүж Хэрлэн мөрний эх Бүрги эрэгт нутаглан буув. Цотан эхийн **бэлэг**[120] хэмээн хар булган дах авч ирсэн бөлгөө. Тэр дахыг Тэмүжин, Хасар, Бэлгүдэй гурав авч явжээ. Эрт өдөр (урьд цагт) Есүхэй хан эцэгтэй [нь] Хэрэйд иргэний Ван хан анд бололцсон ажгуу. Эцэгтэй минь анд бололцсон ажгуу. Эцэгтэй минь анд бололцсон [учир] эцэг мэт буй за хэмээн Ван ханыг Туулын хар шугуйд буй хэмээн мэдэж [авч] одов. Ван ханд

Тэмүжин хүрч өгүүлрүүн: "Эрт өдөр эцэгтэй минь анд бололцсон ажгуу. [Иймд] эцэгтэй [минь] адил буй за хэмээн гэргий буулгахад [ирсэн] өмсгөлийг танд авч ирэв" хэмээн булган дахаа өгөв. Ван хан ихэд баясаж өгүүлрүүн:

"Хар булган дахын [чинь] хариуд
Хагацсан улсыг чинь хамтатгаж өгсү
Булган дахын [чинь] хариуд
Бутарсан улсыг чинь бүрэлдүүлж өгсүү
Бөөрөө бөгсөнд
Цээрээ цээжинд **атугай**[121]" хэмээв.

97. Тэндээс харьж Бүрги эрэгт [нутаглаж] бүхийд Бурхан Халдунаас Урианхай иргэн Жарчиудай өвгөн хөөргөө үүрч, Зэлмэ нэрт хөвүүнээ дагуулж ирж Жарчиудай өгүүлрүүн: "Ононы Дэлүүн болдогт бүхийд Тэмүжинийг төрөхөд булган **өлгий**[122] өгч билээ би. Энэ хүү Зэлмийгээ өгюү [гэтэл] өчүүхэн [байсан] тул авч явлаа.

Эдүгээ Зэлмийг
Эмээлээ тохуул
Үүдээ сөхүүл" хэмээн өгөв.

98. хэрлэн мөрний эх Бүрги эрэгт [нутаглан] сууж бүхийд нэгэн өглөө эрт гэгээ орж, үүр цайж байхад Өэлүн эхийн гэрт зарагдах Хуагчин эмгэн босч өгүүлрүүн: "Эх, эх үтэр бос! Газар доргилж, төвөргөөн сонсдоно. **Гамшигт**[123] тайчууд айсуй яваа биз эх үтэр бос!" хэмээв.

99. Өэлүн эх өгүүлрүүн: "Хөвүүдийг үтэр сэрээгтүн!" гээд өөрөө яаран босов. Тэмүжин нарын хөвүүд түрэглэн босоод морьдоо барьж, Тэмүжин нэг морь унав. Өэлүн эх нэг морь унав. Хасар нэг морь унав. Хачиун нэг морь унав. Тэмүгэ Отчигин нэг морь унав. Бэлгүдэй нэг морь унав. Боорчу нэг морь унав. Зэлмэ нэг морь унав. Тэмүлүнг Өэлүн эх өвөртөө дүүрэв. Нэг хөтөлгөө морь гаргав. Бөртэ үжинд морь дутав.

100. Тэмүжин ах дүү нар эртлэн мордож Бурхан [Халдуныг] зүглэн гарав. Хуагчин эмгэн Бөртэ үжинг нууя хэмээн **битүү**[124] мухлаг тэргэнд суулгаж, бөөр алаг үхэр хөллөж, **Тэнгэли**[125] горхин

өөд хөдлөж явж байтал харуй бүрий [болж] үүр цайж бүхийд өөдөөс нь цэрэг хүмүүс хатируулан хүрч ирж "Юун хүн чи?" хэмээн асуув. Хуагчин эмгэн өгүүлрүүн: "Би Тэмүжиний [албат] буй. Их гэрт хонь хяргахаар ирлээ. [Одоо] гэртээ харьж явна" хэмээв. Тэднээс өгүүлрүүн: "Тэмүжин гэртээ бий юу? Гэр [чинь] хэдий [хол] байна?" хэмээв. Хуагчин эмгэн өгүүлрүүн: "Гэр ч ойр байна. Тэмүжиний байгаа, үгүйг мэдэхгүй юм. Би **хойд [гэрээс] босож ирэв**[126]" хэмээв.

101. Тэр цэргүүд төдөлгүй хатирч [одов]. Хуагчин эмгэн бөөр алаг үхрээ дэлдээд яаравчлан хөдлөх болоход тэрэгний тэнхлэг хуга тусав. Тэнхлэг хугарсан [тул] явганаар ойд гүйж оръё хэмээлдэж байтал **даруй**[127] мөнөөх цэргүүд Бэлгүдэйн эхийг сундалдаж хоёр хөлий нь сарвалзуулж хатирч хүрч ирээд: "Энэ тэргэн дотор юу тээж явна" хэмээв. Хуагчин эмгэн өгүүлрүүн: "Унгас тээж явна" хэмээв. Тэр цэргүүдийн ах нар нь өгүүлрүүн: "Хөвүүд дүү нараа бууж үзэгтүн" хэмээв. Хөвүүд дүү нар нь бууж хаалттай тэрэгний хаалга онгойлгохын хамт дотор нь хатан хүн сууж байсныг тэрэгнээс чирч буулгаж, Хуагчин [тэр] хоёрыг сундлуулж аваад Тэмүжиний хойноос өвсний налархайгаар [мөр] мөшгиж Бурхан [Халдуны] зүг гарав.


102. Тэмүжиний хойноос Бурхан Халдуныг гурвантаа тойрч [эрээд] олж ядав. Ингэж тэнгэн **займчин**[128] [явавч] **умбах**[129] шавар бэрх ой нь цатгалан могой шургаж үл болох шигүү шугуй [тул] хойноос нь хөөж эрж ядчухуй. Тэд [довтлогсод] гурван мэргид ажгуу. Удуйд мэргидийн Тогтоа, Увас мэргидийн Дайр Усун, Хаад мэргидийн Хаатай Дармала эд гурван мэргид эртний Өэлүн эхийг Чилэдүгээс булаалгаж автлаа хэмээн эдүгээ тэр өшил өшин ирцгээсэн ажээ. Тэр мэргид өгүүлэрүүн: "Өэлүний хариуг авахаар [ирээд] эдүгээ эмсийг нь авав. Хариугаа бид авав" хэмээлдэж Бурхан халдунаас бууж **гэрийн**[130] [зүг] ажрав.

103. Тэмүжин, тэд гурван мэргид магад гэртээ буцав уу? Бүгэж [отож] байна уу? хэмээн Бэлгүдэй, Боорчу, Зэлмэ гурвыг Мэргидийн хойноос **тагнан**[131] гурав хоног дагуулж, мэргидийг **холдуулж**[132] Тэмүжин Бурхан [халдун] дээрээс бууж өвчүүгээ

мэхийлгэж[133] өгүүлрүүн:

"Хуагчин эхийн"
Солонго болж
Сонссоны тул
Үнэ[134] болж
Үзсэний тул
Бүтэн биеэ буруулан
Бүхэл (дан)[135] морьт [болж]
Бугын жим **дагаж**[136]
Бургасан гэрт хоноглож
Бурхан дээр гарлаа
Бурхан халдунаа
Бүгсэний хүчээр
Булзааруулав би амиа.
Гагцхан амиа хамгаалж
Ганц морьт [болж]
Хандгайн жимийг дагаж
Халхасан[137] гэр гэрлэж
Халдун дээр гарлаа би
Халдун бурханаар
Харцын төдий амиа
Халхлуулав аа би
[Айхын] ихээр айлаа би
Бурхан халдуныг
Өглөө бүр мялаасугай
Өдөр бүр магтсугай
Ургийн ураг минь
Ухан мэдтүгэй!" хэмээн наран сөөрөг **[харж]** бүсээ хүзүүндээ эрхлэж малгайгаа гартаа сэнжлэн [өлгөж] **гараа** өвчүүндээ мэхийлгэж нарны зүг есөнтөө сөгдөж сацал **[сацаж]** өчил өгөв.

Гуравдугаар бүлэг



104. Тэмүжин, Хасар, Бэлгүдэй гурав тэр даруй хэлэлцэж Хэрэйдийн Тоорил Ван ханд Туул голын хар шугуйд [шутаглаж] бөхийд очиж өгүүлрүүн: "Гурван мэргэд гэндүүлэн [хүрч] ирж эмс хүүхдийг минь дагуулан автав. Хан эцэг минь эмс хүүхдийг аварч өгтүгэй хэмээн ирэв бид" хэмээв. Тэр үгийн хариуд Тоорил Ван хан өгүүлрүүн: "Би ноднин чамд эс хэллүү? Булган дах над авчраад эцэгтэй минь андалцсан эцэг мэт буй уа" хэмээн өмсүүлэхэд би тэнд өгүүлрүүн:

"Булган дахын [чинь] хариуд
Бутарсан улсыг чинь бүрэлдүүлж өгсүү
Хар булган дахын [чинь] хариуд
Хагацсан улсыг чинь хамтатгаж өгсүү
Цээрээ цээжинд атугай
Бөөрөө бөгсөнд атугай [гэж] эс хэллүү би?

Эдүгээ тэр үгэндээ хүрч

Булган дахын хариу
Бүгд мэргидийг бүрэлгэж
Бөртэ үжинийг чинь
Аварч өгсүү би
Хар булган дахын хариуд
Хамаг мэргидийг хальтчиж
Хатан Бөртийг чинь
Хариулж авч ирье бид

чи Жамуха дүүд хэл хүргэж илгээ. Жамуха дүү Хорхонаг Жубурт буй. Би эндээс хоёр түмэн [цэрэгтэй] морилж баруун гар болоё. Жамуха дүү хоёр түмийг авч зүүн гар болон морилтугай. Бидний болзоо Жамухаас [хамаарах] болтугай" хэмээв.

105. Тэмүжин, Хасар, Бэлгүдэй гурав Тоорил

хааныхаас гэртээ харьж ирж Тэмүжин Жамухад, Хасар, Бэлгүдэй хоёрыг илгээж Жамуха андад өгүүл хэмээн" хэлж явуулруун: "Гурван мэргид ирж

Ороо хоосон **болгуулав**[138] би
Өнөр нэгтэн бус уу бид
Өшлөө хэрхэн өшнө?
Өврөө эмтлүүлэв би
Элгэн ураг бус уу бид
Хорслоо хэрхэн авна бид?" хэмээж илгээв.

Жамуха андад хэлж илгээсэн үг ийм. Бас Хэрэйдийн Тоорил ханы өгүүлсэн үгсийг Жамухад хэлж илгээрүүн: "Эрт өдөр Есүхэй, хан эцэг мину сайхан тус хүргэснийг санаж би нөхөрлөж, хоёр түмэн [цэрэг] авч баруун гар болон морилсу. Жамуха дүүд хэлж явуул. Жамуха дүү хоёр түмэт [болж] морилтугай. Нийлэлдэх болзоо Жамуха дүүгээс [хамаарах] болно" хэмээв.

Эдгээр үгсийг [сонсож] дуусаад Жамуха өгүүлэрүүн: "Тэмүжин андыг

Орыг [нь] хоослов гэхийг мэдэж
Өр минь өвдөв.
Өврий нь эмтлэв гэхийг мэдэж
Элэг минь өвдөв.
Өшлөө өшин
Удуйд, Увас мэргидийг үлдэж
Үжин Бөртээ аваръя!
Өшлөө [өвөрлөн] авахад
Хамаг хаад мэргидийг хальт цохиж
Хатан Бөртэ юүгээ хариулан аваръя!
Эдүгээ тэд
Гүлэм давирахуй дор
Хэнгэргийн[139] дуу болгож
Хулчгар[140] Тогтоа [эдүгээ]
Буур хээрт буй за.
Дайзат[141] сум дэрвэлзэхүйд
Дайжигч Дайр усун эдүгээ

Орхон Сэлэнгэ хоёрын
Талхун аралд буй за.
Хамхуул [өвс] хийсэхүйд
Хар ой тэмцэн [зугтагч]
Хаатай Дармала эдүгээ
Харажи хээрт буй за.
Эдүгээ бид дөтлөн
Хилго мөрнийг **огтлон**[142]
Сахал [өвс] их атугай
Сал уяж ороё
Өнөөх хулчгар Тогтоагийн
Өрхөн дээр нь бууж
Эрхэн үүдий нь
Өм[143] дайрч
Эмс охиды нь
Эцэслэн дуусгая!
Хутаг үүдий нь
Хуга дайрч
Хотол улсы нь
Хоосон болтол талая "

106. Жамуха өгүүлрүүн: "Тэмүжин анд, Тоорил хан ах хоёрт өгүүл" хэмээн өгүүлрүүн:

Би болбоос
Хараат тугаа **тахив**[144] би
Хар бухын арьсаар бүрсэн
Бүрхрэн бүхий дуут хэнгэргээ дэлдэв би
Хар хурднаа унав би
Хатангу дээлээ өмсөв би
Хатан жадаа барив би
Хатгуурст сумаа онилов би
Хаад мэргидэд
Хатгалдан морилох буюу хэмээн өгүүл
Урт хараат тугаа тахив би
Үхрийн арьсаар бүрсэн

Өтгөн дуут хэнгэргээ дэлдэв би
Орог хурднаа унав би
Үдээст хуягаа өмсөв би
Онит сумаа онилов би
Удуйд мэргидтэй
Үхэлдэн [тэмцэлдэх] буюу хэмээн өгүүл.

Тоорил хан ах морилохдоо Бурхан халдуны өврөөр Тэмүжин андыг дайрч ирж Онон мөрний эх Ботохан Бооржид болзоцгооё. Эндээс Онон мөрөн өөд мордож, энд буй андын [Тэмүжиний] улсаас нэгэн түмийг [авч] би эндээс нэгэн түмийг [авч] хоёр түм болж Онон мөрөн өөд явж Ботохан Бооржид болзсон газраа нийлэлдье" хэмээн өгүүлж илгээв.

107. Жамухын эдгээр үгсийг Хасар Бэлгүдэй хоёр ирж Тэмүжинд өгүүлж, Тоорил хан хэл хүргэв. Тоорил хан Жамухын эдгээр үгсийг дуулаад хоёр түмэн [цэрэг авч] морилов. Тоорил хан морилохдоо Бурхан Халдуны өвөр Хэрлэний Бүрги эрэг зорин айсуй хэмээн Тэмүжин Бүрги эрэгт байх тул мөрт буй хэмээн [тэндээс] хөдлөж Түнхэлиг өөд нүүж Тана горхиноо бурхан Халдуны өвөрт бууж Тэмүжин тэндээс цэрэг үүсгэж Тоорил хан нэг түм, Тоорил ханы дүү Жаха Гамбу нэг түм [бүгд] хоёр түмэн [цэрэгтэй] Хиамурга горхины Айл харгантад бууж бүхий дор нийлэн буув.

108. Тэмүжин, Тоорил хан, Жаха Гамбу гурав хамтарч тэндээс хөдөлж Онон [мөрний] эх Ботохан Бооржид хүрвээс Жамуха болзоот газраа гурван өдрийн урьд хүрч [иржээ]. Жамуха, Тэмүжин, Тоорил, Жаха Гамбу нарын цэргийг үзээд Жамуха хоёр түмэн цэрэг жагсааж байжээ. Тэмүжин, Тоорил хан, Жаха Гамбу тан эд [нар бас] цэргээ жагсаагаад хүрэлцэн [ирж] харилцан танилцав. Жамуха өгүүлэрүүн:

"Бороотой боловч болзоондоо
Хуртай боловч хугацаандаа бүү хожимдъё [гэж] эс хэлэлцлүү бид? Монголчууд зээ **андгайтан**[145] бус уу?
Зээгээс хожимдсоны
Зэргээс гаргая хэмээлдлээ" гэв.

Жамухын үгний хариуд Тоорил хан өгүүлэрүүн: "Болзоот газар гурван өдөр хожимдов хэмээн яллах, **зэмлэхийг**[146] Жамуха дүү мэдтүгэй" хэмээв. Болзолын зэмийг ийн өгүүлэлдэв.

109. Ботохан Бооржиос хөдөлж, Хилого мөрөнд хүрч сал уяж гэтлээд Буур хээрт Тогтоа бэхийн өрх дээрээс

Эрхэн үүдий [нь]
Өм дайран орж
Эмс хүүхдий нь
Эцэслэн дагуулав
Хутаг үүдий нь
Хуга дайрч
Хотол улсы нь
Хоослон[147] дагуулав.

Тогтоа бэхийг унтаж байхад нь хүрэх [гэтэл] Хилго мөрнөө байсан загасчин, булгачин гөрөө хийгсэд "Дайсан айсуй" хэмээн шөнө дүл хэл хүргэн очжээ. Тэд хэл хүргүүлээд Тогтоа, Увас мэргидийн Дайр усун хоёр хамтарч Сэлэнгэ уруу Баргужин оронд цөөн биеэр дутааж буруулчухай.

110. Мэргидийн улс Сэлэнгэ уруу шөнө дүрвэж явахуйд Тэмүжин дүрвэж явах иргэдийн дотор "Бөртэ, Бөртэ" хэмээн дуудаж явсаар учирчээ. Бөртэ Үжин тэр дүрвэж [явсан] иргэдийн дотор байжухуй. [Тэр] Тэмүжиний дууг сонсож танигад тэргэнээс бууж гүйж ирж, Бөртэ Үжин, Хуагчин хоёр Тэмүжинийг шөнө таньж жолоо цулбуурыг [нь] барьж [авав]. [Шөнө] саруул бөлгөө. Үзмэгц Бөртэ үжинийг таньж тэврэлдэн **золголдов**[148]. Тэндээс Тэмүжин, Тоорил хан, Жамуха анд хоёрт мөн шөнөдөө [хэл] хүргэж, илгээрүүн: "Эрсэн хэргээ олов би. Шөнө бүү тулалдъя. Эндээ бууя бид" хэмээн илгээв. Мэргидийн улс дүрвэж явахдаа шөнө сандарч айсуй зуур мөн тэндээ бууж хонов. Бөртэ үжинтэй тийн уулзалдаж Мэргид иргэнээс аварсан ёсон ийм [ажээ].

111. Түрүүн урьд Удуйд мэргидийн Тогтоа бэхи, Увас мэргидийн Дайр Усун, Хаатай Дармала эд гурван мэргид гурван зуун хүнийг [дагуулж], эрт өдөр Тогтоа бэхийн дүү Их

Чилэдүгээс Есүхэй баатар Өэлүн эхийг булааж авав хэмээн түүний өсийг авахаар оджээ. Тэмүжинийг [эрж] Бурхан халдуныг гурвантаа бүслэхэд Бөртэ Үжинийг тэнд **олзлож**[149] Чилэдүгийн дүү Чилэгэр бөхөд асруулсан ажээ. Тэр асарч байсан Чилэгэр бөх дайжиж гарахдаа өгүүлэрүүн:

"Хар хэрээ
Хальс хөрс идэх заяатай бөгөөтөл
Галуу, тогорууг идсүү хэмээн **санах**[150] ажгуу
Хатиар[151] муу Чилэгэр би
Хатан Үжинд халдаж
Хамаг Мэргидэд **хөнөөл**[152] [болов]
Харц муу Чилэгэр
Хар толгойдоо хүрэх болов.
Гагцхан амиа хоргоон
Харанхуй хавцалд шургаюу
Халхалж хэнрүү бултна би
Хулд[153] муу шувуу
Хулгана, **хүчгэнэ**[154] идэх заяатай байтал
Хун тогорууг идьюү хэмээн санаархах ажгуу.
Хунар[155] муу Чилэгэр би
Хутагтай суутай Үжинийг
Хурааж [авч] ирээд
Хотол мэргэдэд хөнөөл болов.
Хохир[156] муу Чилэгэр би
Хохимой толгойдоо хүрэх болов.
Хорголын төдий амиа хоргоон
Хар[157] харанхуй хавцалд шургаюу
Хорголын төдий амиа
Хороолож хэнрүү бултна би" хэмээгээд
дайжин дутаав.

112. Хаатай Дармалааг олзлон авчирч
Хавтсан бугуй [гав] өмсгөж
Халдун Бурханаа зориулав.

Бэлгүдэйн эх тэнд айлд буй хэмээн заалгаж, Бэлгүдэй эх

юүгээ аврахаар одож, гэрт нь [хүрч] тэрээр баруун үүдээр ортол эх нь, навтархай нэхий дээлтэй зүүн үүдээр гараад гадна бусад хүмүүст өгүүлэрүүн: "Хөвүүдийг минь хаад боллоо гэцгээнэ. Би энд муу хүмүүстэй **төвхнөж**[158] эдүгээ хөвүүдийнхээ нүүрийг яаж харах вэ?" гээд ой шугуйд шурган оржээ. Тэгээд эрсэн [боловч] эс олджээ. Бэлгүдэй ноён мэргид яст хүнийг [үзмэгц] "эхийг минь авчир!" хэмээн харвах бөлгөө. Бурхан [Халдуныг] бүсэлсэн гурван зуун мэргидийг

Ургийн ураг хүртэл
Үнсээр хийстэл үлдэв.
Үлдсэн эмс хүүхдий нь
Өвөртлөх нэгийг [нь] өвөртлөв
Үүдэндээ оруулах нэгийг [нь]
Үүдэндээ оруулж [зарцлав].

113. Тоорил хан, Жамуха хоёрыг Тэмүжин бишрэн өгүүлэрүүн: "Хан эцэг минь Жамуха анд хоёр нөхөрлөж, тэнгэр, газарт хүч нэмэгдэж:

Эрхэт тэнгэрт нэрийдэж
Эх **этүгэнээ**[159] хүргэж
Эрийн **өшөөт**[160] мэргид иргэнийг
Өврий нь хоосон болгов
Элгий нь эмтлэв бид
Оры нь хоосон болгов.
Ураг элэгний нь үлэтгэв бид
Үлдсэн [хөрөнгий] нь хурааб бид

Мэргид иргэнийг төдий бусниулж [орхиод] буцъя " хэмээлдэв.

114. Удуйд мэргидийн дүрэвсэн [газар] булган малгайт марлын годон гуталт, илгэн **хөөмий**[161] усны булга [халиу] [хоёрыг] зүйсэн дээлтэй таван настай Хүчү нэрт нүдэндээ галтай хөвгүүнийг бидний цэргүүд нутагт хоцорсныг олж авчирч Өэлүн эхэд **осгүүлэхээр**[162] авч ирж өгөв.

115. Тэмүжин, Тоорил хан, Жамуха гурав хамтарч

мэргидийн

Цорган[163] гэрий [нь] цоолуулж
Цогтой эмий [нь] олзолж

Орхон, Сэлэнгэ хоёрын Талхун арлаас буцахдаа Тэмүжин, Жамуха хоёр хамтарч Хорхонаг Жубурыг зорин хөдлөв. Тоорил хан буцахдаа Бурхан Халдуны араар Өхөртү Жубур дайран, Гацуурт сүбчид, Улиа[с]тай сүбчид дайран, [ан] гөрөө авласаар Туулын хар шугуйг зорин эргэв.

116. Тэмүжин, Жамуха хоёр Хорхонаг Жубурт нийлэн бууж эртний анд бололцоноо дурдалцан, андаа **сэргээж**[164] амраглая хэмээлдэв.

Анх урьд бололцоход Тэмүжин арван нэгэн настай байхад Жамуха гурын шагай Тэмүжинд өгч, Тэмүжин **нүхт**[165] шагай арилжиж анд бололцож, анд хэмээлдээд Ононы мөсөнд шагалцахуйд тэнд анд болцгоов.

Түүний хойд хавар **алангир**[166] нумаар харвалдан байхад Жамуха бярууны хоёр эвэр нааж нүхэлж хийсэн **дуут сумаа**[167] Тэмүжинд өгч, Тэмүжиний арц [модон] толгойт годилтой арилжиж андлалдав. Ахин анд бололцсон ёсон тийм [ажээ].

117. Өтгөс дээдсийн үг сонсож:

"Анд хүн амь нэг
[Аль алинаа] үл дэвчилдэн
Амь [биений] арьч болюу" хэмээн
Амраглахуй ёсон тийм.

Эдүгээ бас андаа сэргээж, амраглая хэмээлдэж Тэмүжин мэргидийн Тогтоагаас олзолж авсан алтан бүсээ Жамуха андад бүслүүлэв. Тогтоагийн **эсгэл**[168] халиуныг Жамуха андад унуулав. Жамуха Увас Мэргидийн Дайр Усунаас олзолж авсан алтан бүсээ Тэмүжин андад бүслүүлэв. Дайр Усуны эвэрт **ишгэн цагааныг**[169] Тэмүжинд унуулав.

Хорхонаг Жубурын Хулдагар хуны өвөрт саглагар модноо анд бололцон амраглаж **хуримлан найрлан**[170] жаргалдаж шөнө нэгэн хөнжилдөө хоносон бөлгөө.

118. Тэмүжин, Жамуха хоёр нэгэн жилээс дараа оны хагас [хүртэл] андалдан эв аятай [байж] тэр суусан нутгаасаа нэгэн өдөр нүүе хэмээлдэж, нүүхдээ Зуны тэргүүн сарын арван зургааная, Улаан тэргэл өдөр нүүв. Тэмүжин, Жамуха хоёр хөсөгний урд хамт явж айсуй. Жамуха өгүүлрүүн: "Тэмүжин андаа! андаа!

Агуул шахан бууя
Адуучин бидний
Алучуха[171] (нөмөр) болтугай
Голд шахан бууя
Хоньчин хургачин бидний
Хоол болтугай" хэмээв.

Тэмүжин, Жамухын энэ үгийг ухан ядаж, сэмхэн байж хоцроод нүүдлийн [хөсөгний] дундах тэргийг хүлээж Тэмүжин, Өэлүн эхэд Жамуха анд өгүүлмүү:

Агууланд шахан бууя
Адуучин бидний
Алучуха (нөмөр) болтугай
Голд шахан бууя
Хоньчин хургачин бидний
Хоол болтугай" хэмээн өгүүлмүү. Би энэ үгийг нь ухан ядаж хариуд нь юу ч эс өгүүлэв. Би эхээс асууя хэмээн **ирэв** би" хэмээв. Өэлүн эхийг дуу гаргаагүй [байхад] Бөртэ үжин өгүүлрүүн: "Жамуха андыг уйдамтгай гэдэг бөлгөө. Эдүгээ биднээс уйдах цаг болсон [биз]. Саяын Жамуха андын хэлсэн зүйл биднийг туршсан үг буюу. Бид бүү бууя. Энэ хөдөлснөөрөө шөнө турш явж шулуухан хагацъя" хэмээв.

119. Бөртэ Үжиний үгийг зөвшөөж, үл буун шөнө турш нүүж явах зуур мөрт Тайчуудыг дайрав. Тайчууд **сочин**[172] [дайжиж] мөн шөнө Жамухын зүг зорчин хөдлөв. Тайчуудын бэсүдийн нутаг дээр Хөхөчү нэрт нэгэн өчүүхэн хөвүүн нутагт хоцорсныг манайхан **ивч** ирж Өэлүн эхэд өгөв. [Түүнийг] Өэлүн эх тэжээв.

120. Тэр шөнө турш [явж] үүр гийж үзвээс Жалайрын **Хачиун Тохураун**[173], Харагай Тохураун, Харалдай Тохураун, эд

гурван Тохураун ах дүү нар шөнө дүлид ирсэн ажгуу. Бас Таргудын Хадаан Далдурхан ах дүү нар таван таргуд хүрч ирсэн ажгуу. Бас Мүнгэтү хианы хөвүүн Үнгүр нар Чаншиуд Баягуудаараа айсуй ажгуу. Баруласаас Хубилай, Худус ах дүү нар ирэв. Мангудаас Жэтэй, Доголху **чэрби**[174] ах дүү хоёр ирэв. Боорчугийн дүү Өгөлэн чэрби Аруладаас салж ахдаа Боорчуд нийлэн ирэв. Зэлмэгийн дүү Чаурхан Сүбээдэй баатар урианханаас хагацаж Зэлмэд нийлэн ирэв. Бэсүдээс Дэгэй, Хүчүгүр ах дүү хоёр ирэв. Сүлдүсээс Чилгүтэй, Тахи, Тайчуудай ах дүү нар ирэв. Жалайрын Сэцэ Домог, Архай Хасар, Бала [нэрт] хоёр хөвүүдтэйгээ ирэв. Хонхотанаас Сүйхэтү чэрби ирэв. Сүхэхэний Жэгэй, Хонтахорын хөвүүн Сүхэхэй Жэүн ирэв. Нэүдэй, Цагаан Ува ирэв. Олхунодын Хингияадай, Горлосоос Сэчиүр, Дөрбэнээс Мөчи-бүдүүн ирэв. Ихирэсийн Буту энд хүргэн [болох гэж] явсаар ирэв. Ноёхоноос Жунсо ирэв. Оронараас Зургаан ирэв. Баруласаас Суху сэцэн, Харачар хөвүүнтэйгээ ирэв. Бас Баарины Хорчи Үсүн өвгөн, Хөхөчөс Мэнэн Баарингаараа нэгэн хүрээ [болж] ирэв.

121. Хорчи ирж өгүүлрүүн: "Бодончар богдын барьж авсан эмээс бид төрсөн [учир] Жамухатай

Хээл нэгтэн

Хэхий[175] гагцтан бөлгөө бид

Жамухаас үл хагацах [учиртай] билээ бид. **Заарин**[176] ирж миний нүдний өмнө үзүүлэв. Ухаагч үнээ ирж Жамухааг тойрч явж гэр тэргий нь мөргөлөөд Жамухааг мөргөж өрөөсөн эврээ хугалж солжир эвэртэй болж, "эврий минь аль!" хэмээн Жамухагийн зүг мөөрөн мөөрөн, шороо сацан баймой. Мугалзар **ухаа үхэр**[177] **их гэр тэргийг**[178] дээр өргөж хөллөж зүтгэж, Тэмүжиний хойноос **их царгиар**[179] [тэргэн зам] мөөрөн мөөрөн явахдаа

"Тэнгэр газар элдэж

Тэмүжинийг улсын эзэн болтугай" хэмээн

улс тээж авч айсуй гэж Заарингууд нүдэнд үзүүлж надад заав. Тэмүжин чи улсын эзэн болбоос намайг зааж [хэлсний] тул хэрхэн жаргуулна чи" хэмээв. Тэмүжин өгүүлрүүн: "Үнэн тийн улс

мэдүүлбээс түмний ноён болгоё" хэмээв. "Одоо [ингэж] төрийг заасан хүн намайг түмний ноён болговоос юуны жаргалан [байх] буй. Түмний ноён болгоод улсын гоо сайхан охидоос дархлан (эрх дураар) авахуулж [намайг] гучин эмтэй болго. Бас юу хэлснийг минь хариу сонс!" хэмээв.

122. Хунан тэргүүтэй Гэнигэс нэгэн хүрээ ирэв. Бас Даридай отчигин нэгэн хүрээ [болж] ирэв. Жадрангаас Мулхалху ирэв. Бас Сахайтын Унжин нэгэн хүрээ [болж] ирэв. Жамухаас төдий [олон] **ха**гацан нүүжээ. Химурга горхины Айл харганаа бууж бүхүйд бас **Жа**мухаас хагацан Жүрхиний Сорхату Жүрхийн хөвүүн Сача Бэхи, Тайчу хоёр нэгэн хүрээ [болж] бас Нэгүн тайжийн хөвүүн Хучар **бэ**хи нэгэн хүрээ [болж] эд бас Хутула ханы хөвүүн Алтан отчигин **нэ**гэн хүрээ [болж] эд бас Жамухаас хагацан хөдлөж Тэмүжинийг **Хи**мурга горхины Айл Харганад бууж бүхүйд нийлэн буув. Тэндээс **нүү**ж Гүрэлгү дотор Сэнгүр горхины Хар зүрхний Хөх нуур буув.

123. Алтан, Хучар, Сача бэхи бүгдээр зөвлөлдөж Тэмүжинээ **өг**үүлрүүн: "Чамайг хан болгоё. Тэмүжинийг хан болбоос бид

Олон дайнд

Оройлон довтлож[180]

Өнгө сайт

Охид хатад

Орд гэрийг

Оруулан **авчирч**[181]

Харь иргэний

Хацар гоо

Хатад охид

Харгам[182] сайн агт

Хатируулж авчирч өгье би

Ороо гөрөөс авлабаас

Отож [хашиж] өгье би

Хээрийн гөрөөсний

Хэвлий нь нийлтэл

Шахаж өгье [би]

Гууны гөрөөсний
Гуяы нь нийлтэл
Шахаж өгье би
Хатгалдахуй өдөр
Халы[183] чинь биш болгобоос
Харь ширээс[184]
Хатан эмээс минь хагацуулж
Хар толгойг минь
Хээр хөсөрт хаяж од!
Энх өдөр
Эеий чинь эвдвээс
Эрс **харцуулаас**[185]
Эм хөвүүдээс минь салгаж
Эзгүй газар орхин од!"
Өдий үгийг хэлэлцэж
Ингэж ам гарцгааж,

Тэмүжинийг **Чингис**[186] хаан хэмээн нэрийдэж хан болгов.

124. Чингис хаан [хан] болоод Боорчугийн дүү Өгөлэй Чэрбид хоромсого агсуулав. Хачиун Тохураунд [бас] хоромсого агсуулав. Жэтэй, Доголху чэрби ах дүү хоёрт [бас] хоромсого агсуулав. Өнгүр, Сүйхэтү чэрби, Хадаан Далдурхан гурав өгүүлрүүн:

"[Маргааш] өглөөн ундыг бүү
Мөхөсдүүлсүгэй
Үдийн ундыг бүү
Осолдуулсугай" хэмээн

буурч (тогооч) болов. Тэхэй өгүүлрүүн:

"**Шүдлэн**[187] иргийг
Шөл болгож
Маргааш бүү
Мөхөсдүүлье
Хоногт бүү
Хождуулъя

Алаглагч Хонидыг
Адгуулж
Хот дүүргэе
Хонгогч (хонгор) хонидыг
Адуулж
Арам (хот)[188] дүүргэе
Хоолондоо муу бөлгөө би
Хонид адгуулж
Хошого[189] идье би" [гээд] Тэхэй

хонь маллав. Түүний дүү Хүчүгүр өгүүлрүүн:

"Цуургат тэрэгний
Цуу нь эс цүүлэгдвээс
Тэнхлэгт тэргийг
Тэрэгний зам дээр бүү хэмхрүүлье" хэмээн "

гэр тэрэг **цэгцэлье**[190]" хэмээв. Додай Чэрби "гэр дотор эмс зарц [нарыг] **хамаарсугай**[191]" хэмээв. Хубилай, Чилгүдэй, Хархай Тохураун гурвыг Хасарын хамт илд агсааж

"Хүчирхийлэгсдийн
Хүзүүг гь хянгардагтун
Омгорхогсодын
Омрууг нь **онгилогтун**[192]" хэмээв.

Бэлгүдэй, Харалдай Тохураун хоёрыг

"Агт барьтугай
Агтчин болтугай" хэмээв.

Тайчуудын Хуту, Моричи, Мулхалху гурвыг адуу адуултугай гэв. Архай Хасар, Тахай, Сүхэхэй, Чаурхан дөрвийг

"Холын хоорцог
Ойрын **годил**[193] болтугай" хэмээв.

Сүбээдэй баатар өгүүлрүүн:

"Хулгана болж
Хураалцъя.
Хар хэрээ болж
Гадна [байх] бүхнийг

Харамлалдъя.
Нэмнээ[194] эсгий болж
Нөмөрлөж өгье.
Хэрсэг[195] эсгий болж
Гэр зүг[196] хороололдож өгье" хэмээв.


125. Тэнд Чингис хаан, хан болж, Боорчу, Зэлмэ хоёрт өгүүлрүүн: "Та хоёр намайг
Сүүдрээс өөр нөхөр үгүйд
Сүүдэр болж сэтгэлийг минь амруулав та[хоёр]
Сэтгэлд [минь] байтугай хэмээв
Сүүлнээс өөр ташуур үгүйд
Сүүл болж зүрхий минь амруулав та [хоёр]
Цээжин дотор минь байтугай" хэмээв.


"Та хоёр [хамгаас] урьд байснаараа эд бүхнийг ахлах, их ах нь та [нар мөн]" хэмээв. Бас Чингис хаан өгүүлрүүн: "Тэнгэр газарт хүч нэмэж ивээгдвээс, та [нар] Жамуха андаас [салж] намайг хэмээн бодож нөхөрлөе гэж ирсэн өвгөдийн өлзийтэй [итгэлт] нөхөд минь" хэмээн тэднийг зүг зүг [албанаа] тушаав.

126. Чингис хааныг хан болгов гэж Хэрэйдийн Тоорил ханд Тахай, Сүхээхэй хоёрыг элчээр илгээв. Тоорил хан: "Тэмүжин хөвүүнийг минь хан болгох нь зөв. Монгол хан үгүй хэрхэн сууна та [нар]
Энэ эеэ бүү эвдэгтүн
Эе зангиа бүү тайлагтун
Энгэр замаа бүү **таслагтүн**[197]" гэж [хариу] илгээжээ.



Дөрөвдүгээр бүлэг





127. Архай Хасар, Чаурхан хоёрыг Жамухад элчээр илгээбээс Жамуха өгүүлрүүн: "Алтан, Хучар хоёрт хэл" хэмээн өгүүлж илгээрүүн: "Алтан, Хучар та хоёр Тэмүжин анд бид хоёрын хооронд андын

Сүвээ сэжиж

Хавирга хатгаж юунд хагацуулав та нар! Анд бид хоёрыг салаагүй хамт байхад Тэмүжин андыг хан яахан эс болгов та нар? Одоо яахан эл санааг санаж хан болгов та нар? Алтан, Хучар та хоёр хэлсэн үгэндээ хүрч андын сэтгэлийг амруулж, андтай минь сайтар нөхөрлөж явагтун!" хэмээн илгээжээ.

128. Түүний хойно Жамухын дүү Тайчар Жалама [уулын] өвөр Өлгий булагт [нутаглаж] байхдаа Саарь хээрт байсан манай Жөчи Дармалагийн адууг дээрэмдэхээр одов. Тайчар [ингэж] Жөчи Дармалагийн адууг дээрэмдэж авч одов. Жөчи Дармала адуугаа дээрэмдэн одоход нөхөд нь зүрх алдан [шантрахад] тэр өөрөө нэхэн одож шөнө адууныхаа захад хүрч, мориныхоо дэлэн дээр элгээрээ хэвтэж очоод, Тайчарын нурууг нь хуга харваж алаад адуугаа авч иржээ.

129. "Дүү Тайчарыгаа алагдав хэмээн Жамуха тэргүүтэн Жадаран арван гурван **харитан**[198] нэгдэж гурван түмэт болж Алаггугууд, Турхагуудаар давж Чингис хаантай [дайтахаар] морилон айсуй" хэмээн Ихирэсээс Мүлхэ Тутаг, Боролдай хоёр Чингис хааныг Гүрэлгүд байхад хэл хүргэн иржээ. Чингис хаан арван гурван **хүрээд**[199] бөлгөө. Энэ хэлийг аваад [тэр] гурван түмэт болж Жамухын өөдөөс морилж Далан Балжудад байлдав. Чингис хаан Жамухад хөтлөгдөж Ононы Жэрэнэ хавцгайд хоргодов. Жамуха өгүүлрүүн: "Ононы Жэрэнэд хоргоов бид" хэмээн

буцахдаа Чингисийн хөвгүүдийг Далан **тогоодод буцалгаж (?)**[200] Нэгүтэй Цагаан Уагийн толгойг нь огтлож морины сүүлэнд чирч оджээ.

130. Жамухаа тэндээс хариулаад Уруудын Жүрчидэйг Уруудаа удирдаад Мангудын Хуйлдар Мангуудаа удирдаад Жамухаас хагацаж Чингис хаанд ирэв. Хонхотаны Мүнлиг эцэг тэнд Жамухад байжээ. Мүнлиг эцэг долоон хөвүүнтэйгээ Жамухаас салж, тэнд Чингис хаанд нийлэн ирэв. Жамухаас эдгээр хүмүүсийг ирэв гэж Чингис хаан өөртөө улс ирэв хэмээн баясаж, Чингис хаан, Өэлүн Үжин, Хасар, Жүрхиний Сача Бэхи, Тайчу нар хамтаар Ононы шугуйд хуримлая хэмээлдэж, хуримлахад Чингис хаан, Өэлүн Үжин, Хасар, Сача Бэхи нарт эхлэн нэгэн сөн **сөгнөжээ**[201]. Бас Сача бэхийн бага эх Эбэхэй тэргүүлэн нэгэн сөн сөгнөсний учир Хорижин хатан, Хуурчин хатан хоёр "Намайг үл тэргүүлэн юунд Эбэхэйд эхлэн сөгнөв?" хэмээн буурч (тогооч) Шихихүрийг **занчив**[202]. Буурч Шихихүр зодуулж өгүүлрүүн: "Есүхэй баатар, Нэгүн тайж хоёр үгүйн тул маныг ингэж занчив" хэмээгээд их дуугаар уйлжээ.

131. Тэр хуримыг манайхаас Бэлгүдэй засаад Чингис хааны морийг барьж байсан бөлгөө. Жүрхинээс Бүри бөх тэр хуримыг засаж байв. Манай [морьдын] **уяанаас**[203] хатгин хүн цулбуур хулгайлсны хулгай баригдав. Бүри бөх тэр хүнээ **өмөөрчээ**[204] Бэлгүдэй **үргэлж барилдах**[205] учир баруун ханцуйгаа мултлаж [гар] нүцгэн явах бөлгөө. Тийн мултлсан (сугалдаргалсан) нүцгэн мөрий нь Бүри бөх илдээр ангас [хийтэл] цавчжээ. Бэлгүдэй тийн цавчуулсан боловч юм эс болгон, үл анзааран цусаа цувуулж явахыг хуримын дотор сүүдэрт сууж [байсан] Чингис хаан үзэж гарч ирээд өгүүлрүүн: "Биднийг яагаад ингэх болов?" гэхэд Бэлгүдэй өгүүлрүүн: "**Гэмтсэн үгүй**[206] бөлгөө, миний төлөө ах дүүс муудалцах болуузай. Би алзахгүй. Би илаар болно. Ах дүүс сая ижилдэн бүхүйд ах битгий [муудалц!] Хоромхон тэвч!" хэмээв.

132. Чингис хаан,Бэлгүдэй хэдий ятгасан боловч [түүнийг] үл хайхарч, модны гишүү хуга татаж, айргийн бүлүүр сугачин авч

алхилалдаж Жүрхинийг ялж, Хорижин хатан, Хуурчин хатан хоёрыг булааж авав. Жич тэд зохилдоё гэлцэж, Хорижин хатан, Хуурчин хатан хоёрыг эргүүлж [өгч] эвлэлдэе хэмээн элч илгээлдэн бүхүйд хитан иргэний Алтан хан , Татаарын Мэгүжин сүүлт нар эе дор үл орохын тулд **Вангин Чинсанд**[207] Цэрэг засуулж "саарал үгүй яв" хэмээн илгээв. "Ванган Чинсан, Мэгүжин сүүлт тэргүүтэн татаарыг Улз өөд адуу [мал] ,идээ [хүнс] сэлттэй түрж айсуй" хэмээн хэл авав. Тэр хэлийг аваад:

133.Чингис хаан өгүүлрүүн:

"Эрт өдрөөс Татаар иргэн
Өвгөд, эцгийг барагсад
Өшөөтөн иргэн бөлгөө
Эдүгээ энэ **ханалга**[208]дор
Хамсая бид" хэмээгээд Тоорил ханд: "Алтан ханы Вангин Чинсан , Татаарын Мэгүжин сүүлт тэргүүтэн татаарыг Улз өөд түрж айсуй хэмээмой. Бидний эцэг , өвгөдийг барсан татаарыг хамсая бид. Тоорил хан эцэг үтэр иртүгэй" хэмээн энэ хэлийг хүргэж элч илгээв. Энэ хэлийг аваад Тоорил хан өгүүлрүүн: "Хөвүүн минь зөв үг хэлүүлжээ. Бид хамсая" хэмээгээд гуравдугаар өдөр цэргээ цуглуулж , Цэрэг үүсгэж Тоорил хан үтэрлэн **хөдөлжээ**[209]. Чингис хаан Тоорил хан хоёр Жүрхиний Сача бэхи, Тайчу тэргүүтэн Жүрхинээ хэлүүлж илгээрүүн:

"Эрт өдрөөс бидний
Эцэг өвгөдийг барсан татаарыг
Эдүгээ энэ ханалга дор хамсан
Хамт морилъё" хэмээн илгээв. Жүрхинээс [цэрэг] хүрч ирэхийг зургаан өдөр хүлээж ядаад, Чингис хаан Тоорил хан хоёр хамт цэргээ хөдөлгөж Улз уруу Вангин Чинсантай хамсахаар явахад **Улзын Хусту шүтээн, Нарату шүтээнээ**[210] Татаарын Мэгүжин тэргүүтэн татаарууд тэнд хороо [бэхлэлт] барьжээ. Чингис хаан Тоорил хан хоёр тийн хориглосон Мэгүжин сүүлтийг Хорооноос нь барьж түүнийг тэнд нь алж, мөнгөн өлгий, танат хөнжлийг нь Чингис хаан тэнд [олзлон] авлаа.

134. Мэгүжин сүүлтийг Чингис хаан, Тоорил хан хоёр алав хэмээв. Вангин Чинсан Мэгүжин сүүлтийг алав хэмээн мэдээд машид баясаж Чингис хаанд **Жаут хури**[211] нэр (цол) өгөв. Хэрэйдийн Тоорилд **ван**[212] (цол) тэнд өгөв. Ван хан нэрийг Вангин Чинсангийн нэрийдсэнээр тэндээс авав. Вангин Чинсан өгүүлрүүн: "Мэгүжин сүүлтийг хамсаж алсан тань Алтан ханд та нар маш их тус хийв. Энэ тусыг тань Алтан ханд өчинө би. Чингис хаанд үүнээс их нэр (цол) нэмэхийг **Жау тау**[213] цол өгөхийг Алтан хан мэдтүгэй" хэмээв. Вангин Чинсан тийн баясаж тэндээс бүцав. Чингис хаан, Ван хан хоёр тэнд татаарыг дагуулж хуваан авалцаж [гэр] гэртээ харьж буув.

135.Татарын хороолсон (бэхэлсэн) Нарату шүтээнээ буусан нутгийг талахуйд нэгэн өчүүхэн хүүхэд гээснийг бидний цэргүүд нутгаас олжээ. Алтан ээмэг, **дөрөвчит**[214], булгаар доторлосон таж торгон элгэвчит, бяцхан хүүхдийг авчирч Чингис хаан, Өэлүн эхэд асруулъя хэмээн өгөв. Өэлүн эх өгүүлрүүн: "Сайн хүний хөвүүн ажгуу. Язгуур сайт хүний ураг буй за" Таван хөвүүдийн дүү зургадугаар хөвүүн болгон Шигихэн Хутугу (Шигихутуг) хэмээн нэрийдэж эх асрав.

136.Чингис хааны **ауруг**[215] (ар гэр) Харилту нуурт [байсан] болой. Аурупт хоцорсон [хүмүүсийг] Жүрхин, тавин хүний хувцас тонож, арван хүнийг алжээ. Жүрхинээ тийн хөнөөгдөв хэмээн манай аурагт хоцрогсод Чингис хаанд мэдүүлбээс энэ хэлийг сонсоод Чингис хаан маш хилэгнэж өгүүлрүүн: Жүрхинээ бид яагаад ийн хөнөөгдөх болов? Ононы шугуйд хуримлахад тогооч Шихихүрийг мөн занчив. Бэлгүдэйн мөрийг бас цавчив. Зохилдоё хэмээж Хорижин хатан Хуурчин хоёрыг буцааж өгөв бид. Түүний хойно эртний өшөөтэй болсон., бидний эцэг өвгөдийг барагсад татаарыг хамсан морилъё хэмээн Жүрхинийг зургаан өдөр хүлээж эс ирцгээв. Эдүгээ бас дайсантай хамжиж мөн дайсан болов" хэмээгээд Чингис хаан Жүрхинд морилов. Жүрхинийг Хэрлэний Хөдөө арлын долоон болдогт байхад [ард] иргэнийг нь эзлэн авав. Сача бэхи, Тайчу хоёр цөөн биеэр дутаав. Хойноос нь нэхэж Тэлэтү

амсарт гүйцэж Сача бэхи, Тайчу хоёрыг барив. Барьж [аваад] Чингис хаан Сача, Тайчу хоёрт өгүүлрүүн: "Эрт өдөр бид юу хэмээлдлээ?" гэсэнд Сача, Тайчу хоёр өгүүлрүүн: "Өгүүлсэн үгэндээ бид эс хүрэв. Үгэнд минь хүрэг!" хэмээгээд [хэлсэн] үгээ мэдэрч [хүзүүгээ] **гудайж**[216] өгөв. Үгсий нь мэдрүүлж, үгэнд нь хүргэж **бүтэж**[217] [алаад] мөн тэнд хаяв.

137. Сача, Тайчу хоёрыг бүтэж [алаад] Жүрхиний иргэнийг хөдөлгөн буцаж ирэхэд Жалайрын Тэлэгэтү баяны хөвүүн Гүүн-Уа, Чулуун хайч, Жэбгэ тэр гурав Жүрхинд байжээ. Гүүн-Уа Мухали, Буха хоёр хөвүүнээ [Чингистэй] уулзуулж өгүүлрүүн:

"Босгын чинь
Боол болтугай
Босгоноос чинь
Бултваас
Боривий нь огтол
Үүдний чинь
Өмч боол болтугай
Үүднээс чинь
Ийлбээс[218] (зайлбаас)
Элгий нь эсгэж орхи!" гэж өгөв. Чулуун хайч, Түнгэ, Хаши хоёр хөвүүнээ бас Чингис хаантай уулзуулж өгүүлрүүн:

"Алтан босгы чинь
Сахиж байтугай хэмээн өгөв би
Алтан босгоноос чинь
Ангид одвоос
Амий нь тасалж гээгтүн
Өргөн үүдийг чинь
Өргөж өгтүгэй хэмээн өгөв би
Өргөн үүднээс чинь
Өөр [тийш] одвоос
Өрий нь **өшигләж**[219] гээгтүн" хэмээв.

Жэбгээг Хасарт өгөв. Жэбгэ Жүрхиний нутгаас Борохул нэрт

өчүүхэн хөвүүнийг авч ирж Өэлүн эхэд уулзан өгөв.

138. Өэлүн эх Мэргидийн нутгаас олдсон Гүчү нэрт хөвүүнийг, Тайчуудын дотор Бэсүдийн нутгаас олдсон Хөхөчү нэрт хөвүүнийг, Татаарын нутгаас олдсон Шигихэн хутугу (Шигихутуг) нэрт хөвүүнийг, Жүрхиний нутгаас олдсон Борохул нэртэй энэ дөрвөн хөвүүдийг гэрийн дотор тэжээхдээ Өэлүн эх хөвүүддээ:

"Өдөр үзэх нүд
Шөнө сонсох чих болгоё" хэмээн гэртээ тэжээвэй.

139. Эд Жүрхин иргэнийг "Жүрхин" [гэсэн] ёсон болбоос Хабул ханы долоон хөвүүдийн их ах Охин-барахаг бөлгөө. Хөвүүн нь Сорхату-Жүрхи бөлгөө. [Тэр] Жүрхин [овогтон] болов. Хабул ханы хөвүүдийн ах хэмээж иргэдийн дотроос ялгаж

"Элгэндээ сөст
Эрхийдээ ончтан
Уушиг дүүрэн зүрхт
Ам дүүрэн ууртан
Эр тутам эрдэмтэн
Бүх хүчтэнийг ялган өгч
Ууртан сөстөн
Омогтон зүрхтэн тул

Жүрхин хэмээгдэх [болсон] ёсон ийм". Тийм омогтон иргэнийг Чингис хаан доройтуулж Жүрхин овогтныг мөхөөж, ард иргэнийг нь Чингис хаан өөрийн өмч иргэн болгов.

140. Чингис хаан нэгэн өдөр "Бүри бөх, Бэлгүдэй хоёрыг барилдуулъя" хэмээв. Бүри бөх Жүрхинд [байсан] бөлгөө. Бүри бөх Бэлгүдэйг өрөөсөн гараар барьж өрөөсөн хөлөөр **ташиж**[220] унагааж, үл хөдөлгөн дарах [чадалтай] бөлгөө. Бүри бөх улсын бөх [юм]. Тэнд Бэлгүдэй, Бүри бөх хоёрыг барилдуулахад Бүри бөх үл ялагдах хүн атал унаж өгөв. Бэлгүдэй даран ядан мөрлөж саарь /зоон/ дээр нь гарч, Бэлгүдэй гилжис хийж Чингис хаан руу харвал хаан **хөмхийгөө**[221] зуув. Бэлгүдэй санаа авч, дээр нь агтлан [дарж] хоёр **захы нь**[222] солибон мэхийлгэн татаж нуруугий нь

өвдөглөж хугалж орхив. Бүри бөх нуруугаа хугалуулж өгүүлрүүн: "Бэлгүдэйд үл ялагдах бөлгөө би. Хаанаас айж

Аргадан унаж

Алмайран[223] байж

Аминдаа хүрэв би" хэмээгээд үхэж үлдэв.

Бэлгүдэй [ингэж] нуруугий нь хуга татаад чирч орхиж явав.

Хабул ханы долоон хөвүүдийн ах Охин-бархаг бөлгөө. Удаах [нь] Бартан баатар бөлгөө. Хөвүүн нь Есүхэй баатар бөлгөө. Түүний удаах Хутагт Мингүр бөлгөө. Хөвүүн нь Бүри бөлгөө. [Тэрээр] барилдсанд Бартан баатрын хөвүүдээс хол [илүү]. Бархагийн омогтон хөвүүдтэй нөхөрлөдөг байв. Улсын бөх Бүри бөх Бэлгүдэйд [ийнхүү] нуруугаа хугалуулж үхэв.

141. Түүний хойно тахиа жил (1201) Хатагин Салжиуд хамтарч Хатагины Баху Чороки тэргүүтэн хатагин Салжиудын Чирхидай баатар тэргүүтэн Дөрвөн [овгийн] Татаартай эвсэлдэж Дөрвөний Хачиун бэхи тэргүүтэн Татаарын Алчи, Татаарын Жалин Буха тэргүүтэн Ихирэсийн Түгэ маха тэргүүтэн, Хонгирадын Тэрхэг Эмэл, Алхуйтан, Горлосын Чонаг, Цагаан тэргүүтэн Найманаас Хүчүүд [бас] Найманы Буйруг хан, Мэргидийн Тогтоа бэхийн хөвүүд Хуту, Ойрадын Хутуга бэхи, Тайчуудын Таргудай Хирилтуг, Хотун Орчан, Аучу баатартан тайчууд эдгээр харь [омогтон] Алхуй Булагт чуулж Жажирадай Жамухыг хан өргөе хэмээн азрага гүү **хөндөлдөн**[224] цавчилалдаж андгайлалцаж тэндээс Эргүнэ мөрөн уруу нүүжээ. Эргүнэд цутгах **Гээн**[225] мөрний шинааны агуу [уудам] нугад Жамухыг тэнд гүр хан өргөв. Гүр хан өргөөд Чингис хаан, Ван хан хоёрт морилъё [довтолъё] хэмээлдэв. Морилъё гэснийг [нь] Гороласын Хоридай Чингис хааныг Гүрэлгүд байхад энэ хэлийг хүргэн илгээв. Энэ хэлийг аваад Чингис хаан, Ван ханд уг хэлийг хүргэж илгээвээс Ван хан хэл аваад яаравчлан цэрэг хөдөлгөж тэрээр Чингис хаанд хүрч ирэв.

142. Ван ханыг ирүүлээд Чингис хаан, Ван хан хоёр хамтарч Жамухын эсрэг морилъё" хэмээлдэж, Хэрлэн мөрөн уруу

морилоход Чингис хаан Алтан, Хучар, Даридай гурвыг манлайд (тэргүүнд) явуулав. Ван хан Сэнгүм, Жаха-Гамбу, Билгэ бэхи гурвыг манлайд явуулав. Эдгээр манлайчуудаас урагш бас харуулж илгээхдээ Энэгэн **Гүйлэтүд**[226] нэгэн суурин харуул тавив. Түүний цаана Цэхцэрт нэгэн суурин харуул тавив. Түүний цаана Чихурхуд нэгэн суурин харуул тавив. Бидний манлайд [явсан] Алтан, Хучар, Сэнгүмтэн Утхияа хүрч бууя хэмээлдэж бүхүйд Чихурхуд тавьсан харуулаас хүн довтолгож ирж "дайсан айсуй" хэмээн хэл [мэдээ] хүргэн ирэв. Тэр хэлийг аваад үл буудаллан дайснаас хэл авъя хэмээн явж хүрэлцэн [очиж] хэл авалцаж "Хэн хэн бэ?" хэмээн асууваас Жамухын манлайд монголоос Аучу баатар, найманы Буйруг хан, Мэргидийн Тогтоа бэхийн хөвүүн Хуту, Ойрадын Хутуга бэхи энэ дөрөв Жамухын манлай [болж] явжээ.

Бидний манлай тэдэнтэй [өндөр дуугаар] харилцан дуудалцаж [нэгэнт] **орой болжээ**[227]. Маргааш хатгалдъяа хэмээн эргэж голд нийлэн хонов.

143. Маргааш [нь] **Хүйтэнд**[228] хүрэлцэн ирж байлдаж, дорогш дээш [бие биенээ] түлхэлдэн **шөргөлцөн**[229] бүхүйд мөнөөх Буйруг хан Хутуга хоёр **зад**[230] мэдэх ажээ. Задлах болсонд Зад урваж нөгөөх нь [өөрсөн] дээр [нь] зад болжээ. Тэд хөдөлж ядан нурангид гулсан [орж] "Тэнгэрт эс таалагдав бид" гэлцээд бутарцгаав.

144. Найманы Буйруг хан Алтайн өвөр Үлүг таг (их уул)-ыг зорин салж хөдлөв. Мэргидийн Тогтоагийн хөвүүн Хуту Сэлэнгийг зорин хөдөлжээ. Ойрадын Хутуга бэхи ой тэмцэн **Шисгис (Шишгид)**[231] зорин хөдөлжээ. Тайчуудын Аучу баатар Онон зорин хөдөлжээ. Жамуха өөрөө хан өргөмжилсөн иргэдээ дагуулаад Эргүнэ уруу тэр харин хөдөлжээ. Эднийг тийн бутарцгаасанд Ван хан Эргүнэ уруу Жамухыг нэхэв. Чингис хаан Онон зүг Тайчуудын Аучу баатрыг нэхэв. Аучу баатар улсдаа хүрч очоод улс [амьтнаа] дүрвүүлэн хөдөлгөөд, Аучу баатар, Хотун Орчан [зэрэг] тайчууд Ононы цаад талд үлдсэн **бэхлэлтэт**[232] цэргүүдээ засаж хатгалдая хэмээн бэлтгэж байв. Чингис хаан хүрч очоод Тайчуудтай хатгалдав. Маш [ширүүн] ээрэлдэн хатгалдсаар

орой болж мөн тулалдсан газраа **сөргөлцөж**[233] хонов.

Дүрвэж ирсэн улс мөн тэнд цэргүүдтэй хамт хүрээлж хоноглов.

145. Чингис хаан тэр тулалдаанд **сужаа [махаа] шархдуулж**[234] цусы нь **тогтоовоос**[235] үл болон **тэвдүүлэхэд**[236] нар шингэмэгц мөн тэндээ сэрэмжлэн бууж бөглөрсөн цусыг Зэлмэ шимэн шимэн амаа цусдаж, тэр бусад хүнд үл итгэн сахин сууж, шөнө дүли болтол бөглөрсөн цусы нь амаар дүүрэн балгаж асгасаар шөнө дүли өнгөрвөөс Чингис хаан ухаан сэргэж өгүүлрүүн: "Цус **хагсаж**[237] гүйцэв. Би ундаасаж байна" хэмээв. Тэндээс Зэлмэ малгай, гутал, дээл хувцаа бүгдийг тайлж ганц дотоожтой (дотуур өмд) чармаа нүцгэн сөргөлцөн буусан дайсны дотуур гүйж, цаана хүрээлэн [буусан] иргэний тэргэн дээр нь гарч эсэг (цэгээ) эрж цөхөв. Дүрвэгсэд гүүгээ саал үгүй тавьсан ажээ. Эсэг олж ядаад нэг их бүрсэн тараг тэрэгнээс нь аваад өргөж ирэв. Замдаа очих, ирэхдээ хүнд үл үзэгдэв! Тэнгэр ивээсэн буй. Бүрсэн таргийг авч ирээд мөн Зэлмэ өөрөө ус хайж олж ирж, тараг зуурч хаанд уулгав. Гурвантаа амсхийж уугаад хаан өгүүлрүүн: "Дотор, нүд минь онгойв" хэмээгээд өндийж суутал үүр гийж гэгээ орж үзвээс тэр суусан орчин [тойронд] бөглөрсөн цусыг Зэлмийн шимэн шимэн асгасан газар намаг болсныг Чингис хаан үзэж өгүүлрүүн: "Энэ юу болов? Хол асгах нь ясан юм" хэмээв. Тэндээс Зэлмэ өгүүлрүүн: "Чамайг тэвдүүлэхэд хол явбаас чиний алжаахаас айж яарч залгихыг залгиж, асгахыг асгаж тэвдэхдээ хэвлийд минь бас хэдүй орсоныг мэдэхгүй" хэмээв. Чингис хаан бас өгүүлрүүн: "Намайг ийм болоод хэвтэж байхад нүцгэн яахан гүйж оров чи? Баригдваас намайг ийм болсныг үл зааж өгөх үү чи?" хэмээв. Зэлмэ өгүүлрүүн: "Миний бодлоор нүцгэн яваад хэрэв баригдваас "Би та нарын [талд] орох хүсэлтэй бөлгөө. [Үүнийг] мэдээд барьж алах гэж хувцыг минь бүгдийг тайлж ганц [дотуур] өмд тайлаагүй [байтал амь] мөлтөс мэдүүлж, та нарт ийн **завдан**[238] ирэв би хэмээх бөлгөө. Намайг үнэмшиж надад хувцас өгч асрах бөлгөө. Би морь[олж] унаад үзтэл энэ зуур үл ирэх гэж үү! Би тийн сэтгэж хааны

ундаассан хүслийг тайлсугай хэмээн **хар нүдээ**[239] хамхилгүй ийн хичээн одлоо би" хэмээв. Чингис хаан өгүүлрүүн: "Эдүгээ юу хэмээх вэ? Эрт өдөр гурван мэргид ирж Бурхан [Халдуныг] гурвантаа бүслэхэд амий минь нэгэнт авч гарлаа чи. Одоо бас хагсаж бүхүй цусыг амаараа шимж амий минь **тэнхрүүлэв**[240] чи. Бас цангаж амь тэмцэж байхад амь өрсөн дайсны хүмүүст хар нүдээ [хамхилгүй гүйж] орж унд олж ирж амийг минь аврав чи. Энэ гурван тус чинь сэтгэл дотор минь байтугай" хэмээн зарлиг болов.

146. Үүр цайж дуусахад [үзвээс] сөргөлцөн хоносон цэргүүд шөнөдөө бутарч [явжээ]. Хүрээлсэн иргэд шалмаг [хөдлөж] үл чадах учир хүрээлэн [буусан] газраасаа эс хөдөлжээ. Дүрвэсэн улсыг буцаая хэмээн Чингис хаан хоносон газраас мордож дүрвэгч иргэдийг буцааж явахуйд даваан дээр нэг улаан дээлтэй эм хүн "Тэмүүжин!" хэмээн их дуугаар уйлан хайлан байхыг Чингис хаан өөрөө сонсож "Юун хүний эм тийн хайлан байна?" хэмээн асуулгаж хүн илгээв. Тэр хүн очиж асууваас тэр эмэгтэй өгүүлрүүн: "Сорхон шарын охин. Би Хадаан нэртэй. Эрийг минь энд цэргүүд барьж алах [гэж] байна. Эрийгээ алуулахад Тэмүүжин эрийг минь авартугай хэмээн дуудан хайлж уйлав би" хэмээв. Тэр хүн ирж Чингис хаанд энэ үгийг өгүүлбээс, Чингис хаан энэ үгийг сонсоод хатируулан хүрч [мориноос] бууж Хадаантай тэврэлдэв. Эрийг нь манай цэргүүд уридан алчихсан [байв]. Тэдгээр иргэдийг буцаагаад Чингис хааны их цэрэг мөн тэндээ бууж хонов. Хадааныг урьж ирүүлж зэрэгцэн суулгав. Маргааш өдөр [нь] Тайчуудын Төдөгэгийн ард байсан Сорхон шар, Зэбэ хоёр ирэв. Чингис хаан Сорхон шард өгүүлрүүн:

"Хүзүүн дэх
Хүнд модыг
Хөсөр хаяулсан
Захан дахь
Зарбияал[241] модыг
Зайлуулсан та
Эцэг хөвүүдийн тус ачтай та яахан удаж [ирэв] та?" хэмээв. Сорхон

шар өгүүлрүүн: "Би дотроо бүрэн итгэн санаж [явсан] бөлгөө. [Иймд] би яахан яарна. Яарч урьд ирвээс Тайчууд ноёд миний хоцорсон эмс хүүхэд мал идээг минь тэд үнсээр хийсгэнэ хэмээн үл яаран эдүгээ хаандаа завдан [нийлж] ирэв бид" хэмээв. Хэлж дуусахад "Зөв" хэмээв.

147. Бас Чингис хаан өгүүлрүүн: "Хүйтэнд байлдаж түлхэлдэн бөргөлцөн бүхүйд тэртээ нуруун дээрээс сум ирж миний **зэвлэх**[242] (дайны) ам цагаан хулын аман хүзүүг нь хэн хуга харавлаа. Уулан дээрээс" хэмээв.


Тэр үгэнд Зэбэ өгүүлрүүн: "Уулан дээрээс би харавсан билээ. Одоо хаанд алагдваас алгын чинээ газар өмхийрч хоцоръё. Соёрхогдвоос хааны өмнө:


Цээлийн усыг тасалж
Цэгээн чулууг
Цууртан довтлож өгье
Хүр хэмээгсэн газарт
Хөх гүрийг хэмхлэж
Халд хэмээгсэнд
Хар гүрийг
Хамхартал довтлож өгье" хэмээв.

Чингис хаан өгүүлрүүн: "Дайсан болж байсан, хүн алсан, дайсагнаснаа [булж], биеэ нууж, үгээ буцах ажгуу. [Харин] энэ хэлснээс [үзвэл] алсан дайсагнаснаа үл далдлан [үнэн] мөнөөр заан [хэлэх] буюу нөхөрлөж [болох] хүн буюу. Зургаадай нэрт ажгуу. Мөн зэвлэх ам цагаан хулыг минь аман хүзүүг харавсны тул Зэбэ [хэмээн] нэрлэж зэв болгоё чамайг" хэмээн Зэбэ нэрийдэж "Дэргэд минь яв" гэж зарлиг болов. Зэбэ Тайчуудаас ирж нөхөрлөсөн ёсон тийм [ажээ].



Тавдугаар бүлэг





148. Чингис хаан тэнд Тайчуудыг дагуулж тайчууд яст хүмүүсийг Аучу баатар, Хотон орчан, Хутуудартан тайчуудыг ургийн ураг хүртэл үнсээр хийсгэн хядав. Улс иргэнийг нь нүүлгэж ирж Чингис хаан Хубахаяа [гэдэг газар] өвөлжив.

149. Ничигүүд **нүцгэн бааринь**[243] Ширээт өвгөн Алаг, Наяа хөвүүдтэйгээ [элбэн] тайчуудын ноён Таргутай Хирилтугийг ойд явсныг өст хүмүүн бөлгөө хэмээн морь унаж үл чадах Таргутайг барьж тэргэнд суулгажээ. Ширээт өвгөн Алаг, Наяа хөвүүдтэйгээ Таргутай Хирилтугийг барьж айсуйд Таргутай Хирилтугийн хөвүүд дүү нар нь булааж авъя хэмээн [нэхэн] гүйцэж ирэв. Хөвүүд, дүү нарыг нь гүйцэж ирэхэд Ширээт өвгөн, хөдөлж ядах Таргутайг тэргэн дээр унагаж гэдрэг [харуулж] дээр нь агтлан сууж хутга гарган өгүүлрүүн: "Хөвүүн дүү нар чинь чамайг булааж авахаар ирэв. Хан чамд халдав хэмээн эс алсан ч хан [эзэндээ] халдав гэж [Намайг тэд] ална. [Чамайг] алсан ч мөн би алагдана. Тэгэхлээр үхэхдээ **дэр аван үхье**[244]" хэмээгээд агтлан [сууж] том хутгаараа хоолойгий нь огтлоход хүрэхэд Таргутай Хирилтуг их дуугаар дүү нар хөвүүддээ хашгарч хэлсэн нь: "Ширээт намайг алах буюу. [Нэгэнт] алж дуусгавал үхсэн, амьгүй биеийг минь авч явж юу хийнэ та нар? Намайг алаагүй [байхад] хурдан харигтун! Тэмүжин намайг алахгүй. Тэмүжинийг бяцхан [байх] цагт:

Нүдэндээ галтай

Нүүрэндээ гэрэлтэй бөлгөө хэмээн эзгүй

нутагт хоцорч амуй хэмээн аврахаар одож, авчирч сургаваас сурах төлөвтэй буюу хэмээн **эмнэг**[245] үрээ даага сургах мэт сурган соёрхож

явлаа. [Түүнийг] үхүүлэх гэсэн бол үхүүлж ядах юу билээ. Би одоо [түүний] ой [ухаанд] нь орж, сэтгэлийг нь сэнхрээж байна гэлцэнэ. Тэмүжин намайг үл үхүүлнэ. Хөвүүд, дүү нар та минь хурдхан харигтун! Ширээт намайг алж явуулуузай!" хэмээн их дуугаар хайлав. Хөвүүд дүү нар нь өгүүлэлзрүүн: "Бид эцгийнхээ амийг аваръя хэмээн ирэв. Ширээт, амий нь алж орхивол, амь үгүй хоосон биеэр нь юу хийнэ бид? Алаагүй [дээр нь] мөн даруй харья" хэмээлдэн буцав. Тэднийг буцахад Алаг, Наяатан Ширээт өвгөний зугадсан хөвүүд нь ирэв. Тэднийг ирүүлээд хөдлөж явах зуур Хутухул нугад хүрвээс тэнд Наяа өгүүлрүүн: "Бид энэ Таргутайг барьж очвоос Чингис хаан биднийг "Өөрийн ханаа барьж ирэв" хэмээн тэр биднийг өөрийн [ханаа] барьж ирэгсэд ямар итгэлтэй ард [байхав]. Эд бидэнтэй бас яаж нөхөрлөнө. Нөхөрлөж үл чадах ард, өөрийн ханаа барьсан ардыг **мөхөөгтүн**[246] хэмээж алъюу. Бид харин Таргутайг эндээс тавьж явуулж өөрсдийн биесээ Чингис хаанд хүч өгөхөөр ирэв бид гэж очъё. Таргутайг барьж ирж яваад өөрийн ханаа харсаар [байж] тэвчин ядаж яаж алуулна гээд тавьж явуулж бид [Танд] бишрэн хүч өгье хэмээн ирэв бид гэцгээе" хэмээв. Наяагийн энэ үгийг эцэг хөвүүд зөвшөөрөлцөж Таргутай Хирилтугийг Хутухул нугаас тавьж явуулж тэр Ширээт өвгөн Алаг, Наяа хөвүүдтэйгээ [хүрч] ирвэл "яахан ирэв" хэмээв. Ширээт өвгөн Чингис хаанд өгүүлрүүн: "Таргутай Хирилтугийг барьж ирж яваад жич өөрийн ханаа харсаар [байж] хэрхэн алуулна хэмээн тэвчин ядаж тавьж явуулаад Чингис хаанаа хүч өгье хэмээн ирэв" гэв. Түүний хариуд Чингис хаан өгүүлрүүн: "Таргутай ханыг барьж ирсэн бөгөөс өөрийн ханаа барьсан ард та нарыг ургаар [нь] алах бөлгөө. Өөрийн ханаа тэвчин ядсан сэтгэл чинь зөв буй" хэмээн Наяаг соёрхов.

150. Түүний хойно Чингис хаанд Хэрэйдийн Жаха Гамбу Дэрсүтэд (Дэрст?) [нутаглаж] байхад нөхөрлөхөөр ирэв. Түүнийг ирсэнд мэргид довтлон ирсэнд Чингис хаан Жаха Гамбу нар хатгалдан няцаав. Тэнд Түмэн түбэгэн олон Донхайд Хэрэйдийн бутарсан иргэд Чингис хаанд нийлж иржээ.

Хэрэйдийн Ван хан бол урьд Есүхэй хааны (хан) цагт [түүнтэй] дотно сайхнаар ханилаж Есүхэй хантай анд бололцсон ажээ. Анд бололцсон ёс нь Ван хан Хурчахус буйруг хан эцгийнхээ дүү нарыг алсаны учир авга Гүр хантайгаа дайсан бололцож, Хараун хавцалд шургалдаж, зуун хүнтэй [зугадан] гарч Есүхэй ханд ирвээс Есүхэй хан түүнийг өөртөө ирсэнд өөрөө цэрэглэн мордож Гүр ханыг **Хашин [орны]**[247] зүг үлдэн [хөөж] **ард иргэдийг**[248] нь Ван ханд авч өгсний тул анд бололцсон [нь] тэр.

151. Түүний хойно Ван ханы дүү Эрхэхар Ван хан ахдаа алуулахаас буруулан явж, Найманы Инанча ханд [дагаж] оров. Инанча хан цэрэг илгээж, жич Ван хан гурван балгасаар бядан явж, хар Хитаны Гүр ханд одсон ажгуу. Тэндээс [бас] эвдрэл болон Уйгур, Тангадын балгадаар дайран таван ямаа шөрөглөн сааж, тэмээний цус ханаж идээд [арай] ядан Гүсэүр Нуурт ирвээс Чингис хаан урьд Есүхэй хантай анд байсан ёсоор Тагай баатар, Сүхэхэй Жэүн хоёрыг элчээр илгээгээд, Хэрлэний эхээс Чингис хаан өөрөө тосон мордож, өлсөж ядарч ирэв хэмээн Ван ханд гувчуур гувчиж өгч Хүрээн дотроо оруулж тэжээв. Тэр өвөл хамт нүүж Чингис хаан Хуба хаяад өвөлжив.

152. Тэнд Ван ханы дүү нар ноёдууд өгүүлрүүн:

"Энэ бидний хан ах
Өөдгүй авиртан
Өмхий элэг
Өвөртлөн явж
Ахан дүүсийг барав
Хар хитадад орж
[Хамаг] улсыг зовоов

Эдүгээ үүнийг хэр гэх вэ бид? Эрт өдөр [ямар явсан] гэвээс долоон настай мэргид иргэн дагуулж одож, хар алаг ишгэн дах өмсөж Сэлэнгийн Буур хээрт мэргидийн [тарианы] уур нүдэв.

Хурчанхус Буйруг хан эцэг нь жич Мэргид иргэнийг эзлэн хүүгээ тэндээс аварч ирэхэд мөн Татарын Ажай хан арван гурван настай [байхад] эхтэй нь хамт бас дагуулан одож тэмээгээ

хариулган явахуйд Ажай ханы хоньчин аваад оргож ирэв. Бас түүний хойно Наймнаас айж буруулан явж, Сартуул нутагт Чуй мөрнөө Хар Хитаны Гүр ханд одов. Тэндээ нэгэн он үл дуусган жич дайжин хөдлөж Уйгур, Тангадын нутгаар бядан явахдаа ядарч таван ямаа шөрөглөн сааж, тэмээний цус ханаж идэж, ганц сохор халиун морьтой ядарч [явж] Тэмүжин хөвүүнд ирвээс гувчуур гувчиж тэжээв. Эдүгээ Тэмүжин хөвүүнтэй тэгэж явснаа умартаж, өмхий элэг өвөртлөж явна. [Үүнийг] хэр гэх вэ бид" хэмээлдэв. Ингэж ярилцсан үгсийг Алтан ашух Ван ханд айлтгажээ. Алтан ашух өгүүлрүүн: "Би энэ эвсэлдээнд оролцлоо. Харин хан чамайг [муучлахад] тэвчин ядав" хэмээжээ. Тэнд Ван хан ийн өгүүлэлдсэн эл Хутур, Хулбари, Арин тайж тэргүүтэн дүү нар ноёдуудыг бариулав. Дүү нараас [нь] Жаха Гамбу зугадаж Найманд очив. Тэд баривчлагсдыг гэрт оруулж Ван хан өгүүлрүүн: "Бид Уйгур, Тангадын нутгаар явахдаа юу хэмээлдлээ? Та нар шиг юу бодож явах вэ би?" гээд нүүр өөд нь нулимж хүлээсий нь тавиулав. Ханыг нулимахад гэрт байсан хүмүүс бүгд босч нулимжээ.

153. Тэр өвөл өвөлжиж нохой жил (1202) намар нь Чингис хаан Цагаан Татаар, Алчи Татаар, Тутаут Татаар, Алухай Татаар, Тэтэ Татаруудтай **Далан нэмүргэст**[249] байлдаж тулалдахын урьд Чингис хаан цааз (хууль) [болгон] өгүүлэлдрүүн: "Дайсаныг даралцахад олзонд бүү хоргод. Даран дуусгаваас тэр олз биднийх болно. Бид хуваалдан [авна]. **Дайсан хүмүүнд**[250] няцаагдваас түрүүчийн довтлон [орсон] газартаа эргүүлье. Түрүүчийн довтолсон [газартаа] эс эрэгсэн хүнийг алтугай" хэмээн засаглалдав. Далан нэмүргэс тулалдаж Татаарыг дутаалгав? [Тэднийг] дарж **Улхуй шилүгэлжидэд**[251] улстаа нэгтгэн дагуулав. Цагаан Татаар, Алчи Татаар, Тутаут Татаар, Алухай Татаар [зэрэг] эрхт хүмүүсийг дарахад засаглан хэлэлцсэн үгэнд Алтан, Хучар, Даридай гурав үгэндээ үл хүрэн олзонд шуначухай. Үгэндээ эс хүрэв хэмээн Зэбэ, Хубилай хоёрыг илгээж олзлон авсан адуу [мал] юу хэ авсан бүхнийг хураалгав.

154. Татаарыг мөхөөн дагуулж дуусгаад улс иргэнийг нь

яах вэ хэмээн Чингис хаан **их эе (зөвлөл)**[252] ургаараа нэгэн гэрт орж зөвлөлдөв. Зөвлөлдсөн нь:

"Эрт өдрөөс татаар иргэн
Өвгөд эцгийг барсан бөлгөө
Өвгөд эцгийн
Өшил өшиж
Хясал хясаж
Цүүн дор үлэж[253] (чацуулж) хядаж
Алж өгье
Үлдэн хадъя
Үлдсэнийг нь боолчилъё
Зүг зүгт хуваалдъя"хэмээн зөвлөн тогтож

гэрээс гарваас Татаарын Их Чэрэн Бэлгүдэйгээс ямар үг зөвлөлдөв хэмээн асуужээ. Бэлгүдэй өгүүлрүүн: "Та нарыг бүгдийг булнаас үлсэнийг хядъя хэмээлдэв" гэжээ. Бэлгүдэйн энэ үгээр Их Чэрэн Татаарууддаа тунхаг тавьж [хориглон] хороолов. Хороолсон татаарууддад манай цэргүүд **дайран орох**[254] болоход маш [ихээр] шамшигджээ (хохирчээ). Хороолсон Татаарыг арай ядан оруулж [авч] үлдэн цүүнээс үлсэнийг хядахад татаар өгүүлэлдрүүн: "Хүн бүр ханцуйдаа хутга ханцуйлж дэр аван үхье" хэмээлдэж бас машид шамшиулжээ. Тэдний Татаарыг цүүнд үлэж, хядаж бараад тэнд Чингис хаан зарлиг болсон нь: "Бид ургаараа их эе хийцгээснийг Бэлгүдэй зааж [хэлсний] тул бидний цэргүүд маш [их] шамшиулав. Үүнээс хойш их эед Бэлгүдэй бүү ортугай. Эе бартал гаднах бүхнийг застугай. Хэрүүл, хулгай худал үйлстнийг засан заргалтугай! Эе барваас **архи оруулж**[255] уусны хойно Бэлгүдэй, Дааритай хоёр тэнд ортугай" хэмээн зарлиг болов.

155. Тэнд Татаарын Их Чэрэнгийн охин Есүхэн хатныг Чингис хаан авав. Есүхэн хатан [хаанд] таалагдаж өгүүлрүүн: "хаан соёрхвоос намайг хүнтэй [адил] бодож болгоож асарму. [Миний] эгч Есүй нэрт надаас дээр, хан хүнд зохистой ажээ. Саяхан хадамд урагласан бөлгөө. Эдүгээ энэ будлианд хаа нэгэн тийш явав" хэмээв. Энэ үгийг [сонсоод] Чингис хаан өгүүлрүүн: "Эгч чинь

чамаас сайн **байсан**[256] бөгөөс эрүүлье. Эгчээ ирвээс зайлж өгөх үү чи?" хэмээв. Есүхэн хатан өгүүлрүүн: "Хаан соёрхвоос, эгчтэйгээ **уулзвал**[257] эгчдээ зайлж өгнө" хэмээв. Энэ үгд Чингис хаан зарлиг тунхаглаж эрүүлбээс очсон хүргэнтэйгээ хамт ойд явахад [нь] манай цэргүүд уулзалдав. Эр нь дутааж, Есүй хатныг тэнд авч ирэв. Есүхэн хатан эгчээ үзээд урьд өгүүлсэн үгэндээ хүрэн босч суусан сууриндаа суулгаж өөрөө мөн доор суув. Есүхэн хатны үг үнэн болж Чингис хаан санаандаа таацуулж Есүй хатныг авч зэрэгт суулгав.

156: Татаар иргэнийг эзлэн дуусаад, нэгэн өдөр Чингис хаан гадаа сууж ундлаж байв. Есүй хатан Есүхэн хатан хоёрын дунд сууж ундлан бүхүйд Есүй хатан ихэд шүүрс алдав. Тэнд Чингис хаан дотроо бодож Боорчу, Мухалитан ноёдыг урьж ирүүлж өгүүлрүүн: "Та нар энд цугларсан ард бүхнийг аймаг аймгаар [нь] болгогтун! Өөр бусад аймгийн хүнийг тусгай гаргагтун!" хэмээн зарлиг болов. Тэднийг аймаг аймгаар нь болговоос нэгэн хөрслөг сайхан залуу хүн аймаг аймгаас ангид байв. "Чи юун хүн буй?" гэвэл тэр хүн өгүүлрүүн: "Татаарын Их Чэрэнгийн Есүй нэртэй охиныг авсан хүргэн хүн бөлгөө би. Дайсанд баригдахаас айж бууруулан явж одоо амгалан болов хэмээн ирж олон хүний дунд танигдахгүй хэмээн [бодож] явлаа" гэв. Энэ үгийг Чингис хаанд өчвөөс зарлиг болруун: "Мөнхүү дайсан муу санаалж **оорцог**[258] болж явжээ. Эдүгээ юу **мярааж [мэдэхээр]**[259] ирсэн байна? Энэ мэтийг цүүнд үлэж [үгүй хийсэн биш үү] Юунд сармагчилна. Нүднээс далд болгогтун" хэмээв. Төдхөн [түүнийг] мөхөөв.

157. Мөн нохой жил (1202) Чингис хааныг Татаар иргэнд морилсонд Ван хан Мэргид иргэнд морилж Тогтоа бэхийг Баргужин төхүмийн зүг үлдэж Тогтоагийн их хүү Төгүс бэхийг алж Тогтоагийн Хутагтай Чаалун хоёр охид хатдыг нь авч Хуту, Чулуун хоёр хөвүүдийг нь иргэд сэлтий [нь хамтаар] эзлэн аваад Чингис хаанд юу ч үл өгөв.

158. Түүний хойно Чингис хаан, Ван хан хоёр Найманы хүчүгүдийн Буйруг ханд морилж **Үлүг тагийн**[260] **Согог уснаа**[261]

бүхүйд хүрч [очиход] Буйруг хан байлдан ядаж Алтай даван хөдлөв. Согог уснаас Буйруг ханыг нэхэж Алтай давуулан Хумшингирийн Үрүнгү уруу үлдэж явахуйд Йэди Тублуг нэрт ноён нь харуулд явж [байгаад] манай харуулд хөөгдөж уул өөд дутаах болоход олом нь тасарч тэнд баригджээ. Үрүнгү уруу үлдээд Хишилбаши нуурт гүйцэж Буйруг ханыг тэнд мохоов.

159. Тэндээс Чингис хаан Ван хан хоёрыг буцаж явахад Найманы хатгалдагч Хөгсэү Сабраг **Байдараг Бэлчирт**[262] цэрэг засаж тулалдахаар зэхэж байсан ажгуу. Чингис хаан Ван хан хоёр хатгалдъя хэмээн цэрэг засаж хүрч [ирээд] орой боллоо маргааш хатгалдъя хэмээн зэрэгцэн хонов. Тэнд Ван хан **буйран**[263] дээрээ гал түлүүлж [орхиод] шөнө Хар сүүл (голын нэр) өөд хөдлөн явжээ.

160. Тэнд Жамуха Ван хантай хамт хөдлөж явахдаа Ван ханд Жамуха өгүүлэрүүн: "Тэмүжин анд маань эртнээс Наймантай харилцаатай бөлгөө. Эдүгээ [бидэнтэй] ирсэнгүй.

Хан хан ахуй[264]
Хайргана[265] би буюу
Ангижрах[266] **болжмор**[267]
Анд минь буюу

Наймантай очиж нийлэх гэж хоцров" хэмээв. Жамухагийн тэр үгэнд Убчигдай Гүрин (хүрэн?) баатар өгүүлрүүн: "Яахан тийн зусардаж шудрага ах дүү нарыгаа **хавлан хочлон**[268] өгүүлнэ" хэмээв.

161. Чингис хаан шөнө мөн тэндээ хонож хатгалдъя хэмээн маргааш [өглөө нь] эрт үүр гийлгээд Ван ханы буурийг үзвээс үгүй болсон байв. Эд биднийг **түлш [болгосон]**[269] ажгуу гээд тэндээс Чингис хаан хөдлөж **Эдэр Алтайн бэлчирээр**[270] гэтлэж, тэр хөдөлсөн чигээрээ явж Саарь хээрт буув. Тэндээс Чингис хаан Хасар хоёр Найманы [учир] төвгийг мэдсэн [боловч] хүмүүст эс дуулгав.

162. Хөгсэү Сабраг Ван ханы хойноос нэхэж Сэнгүмийн эмс хүүхэд, ард иргэн сэлтийг булаан авч, Ван ханыг Тэлэгэтү амсарт байхад зарим иргэн адуу [мал] идээ [хөрөнгийг] булааж аваад буцжээ. Тэр **хооронд**[271] мэргидийн Тогтоагийн Хуту, Чулуун хоёр

хөвүүд тэнд байсан иргэдээ авч салаад эцэгтэйгээ нийлэхээр Сэлэнгэ уруу хөдлөв.

163. Ван хан, Хөгсэү Сабрагт цохигдож, Чингис хаанд элч илгээрүүн: "Найман ард иргэн ба эмс хүүхдээ алдав би. Хөвүүнээсээ дөрвөн хүлгүүдийг чинь гуйж илгээв би. Ард иргэнийг минь аварч өгтүгэй!" хэмээн илгээжээ. Чингис хаан тэнд Боорчу, Мухали, Борохул, Чулуун баатар эдгээр дөрвөн хүлгүүдээ цэрэг засаж илгээв. Эдгээр дөрвөн хүлгийг хүрэхийн өмнө Улаан Хутад Сэнгүм байлдахдаа мориныхоо гуяыг харвуулж, автах болж байхад эд дөрвөн хүмүүд очиж аварч ард иргэн эмс хүүхэд бүгдийг аварч өгөв. Тэнд Ван хан өгүүлрүүн: "Эрт [цагт] сайн эцэг тань энэ мэт сарниж барсан улсыг минь аварч өглөө. Эдүгээ бас хөвүүн чи сарниж барсан улсыг минь дөрвөн хүлгүүдээ ирүүлж аварч өгөв. Ач хариулахыг Тэнгэр газрын ивээл мэдтүгэй" хэмээв.

164. Бас Ван хан өгүүлрүүн: "Есүхэй баатар анд минь саринан барсан улсыг минь нэгэнтээ аварч өгөв. Тэмүжин хөвүүн бас сарнисан улсыг минь аварч өгөв. Энэ эцэг хүү хоёр саринан барсан улсыг надад хурааж өгөхдөө хэний өмнө хурааж өгөн зүдрэв?

Өтлөв би - бэр эдүгээ
Өтлөж намайг
Өндөрт[272] гарваас
Хуучдав[273] би [эдүгээ]
Хуучдаж [намайг]
Хаданд[274] гарваас
Хамаг улсыг
Хэн мэднэ?

Дүү нар минь авир үгүйтэн буй. Гагц хүү минь үгүй [тэй] **адил**[275]. Сэнгүм гагц буюу. Тэмүжин хөвүүнийг Сэнгүмийн ах болгож хоёр хүүтэй болж [сэтгэл] амарсугай!" хэмээн Чингис хаантай Ван хан туулын хар шугуйд цуглаж , эцэг хүү хэмээлдэв. Эцэг хүү хэмээлдсэн ёсон [нь] урьд эрт өдөр Есүхэй хан эцэгтэй Ван хан анд бололцсон ёсоор эцэг мэт хэмээж эцэг хөвүүн гэлцсэн ёс тийм. Үг

өгүүлэлдрүүн:

"Олон дайсанд уулгалахад
Хамт нэгэн уулгалъя
Ороо гөрөөсийг авлахад
Хамт нэгэн авалъя" хэмээлдэв. Бас Чингис хаан, Ван хан хоёр өгүүлэлдрүүн:

"Бид хоёрыг **атаархаж**[276]
Шүдэт могой **шударваас**[277]
Шудраанд нь бүү оръёо
Шүдээр амаар өгүүлэлдэж биширье
Араат могой **хадарваас**[278]
Хадраагий нь бүү авалцъяа
Ам хэлээ ололцож биширье" хэмээн тийн үг барилдаж амраглан байв.

165. Амраг дээрээ давхар амраг болоё хэмээн Чингис хаан бодож Зөчид Сэнгүмийн дүү Чаур-бэхийг гуйхдаа Сэнгүмийн хөвүүн Тусахад манай Хожин бэхийг сольж өгье хэмээн гуйваас тэнд Сэнгүм өөрөө ихэмсэглэн бодож өгүүлрүүн: "Бидний ураг эдэнд очвоос үүдэнд сууж эгнэгт хоймор харах ажгуу. Эдний ураг бидэнд ирвээс хоймор сууж үүд харах ажгуу" хэмээн өөрөө ихэмсэглэн бодож биднийг доромжлон өгүүлж Чаур-бэхийг үл өгөн эс таалжээ. Тэр үгэнд Чингис хаан дотроо Ван хан, Нилха Сэнгүм хоёрт дур гутав.

166. Тийн дур гутсаныг Жамуха ухаарч гахай жилийн (1203) хавар Жамуха, Алтан, Хучар, Хартагидай, Өвөгжин, Ноёхон, Сэхээдэй, Тоорил, Хачиун бэхи тэд нэгэн эетэн болон нүүж явж, Жэжээр өндрийн хярд **Бэрхэ Элэтэд**[279] Нилха Сэнгүмд очиж олхин өгүүлрүүн: "Тэмүүжин анд минь Найманы Таян ханд хэлтэй элчтэй буюу.

[Аавтай чинь]
Ам нь эцэг хүү хэмээх аму
Авир нь өөр буюу
Итгэж [суух] амуй та

Эс **гэндүүлбээс**[280] танд юу болох?
Тэмүжин андад морилбоос би хөндлөнгөөс оролцоё" хэмээв. Алтан, Хучар хоёр ө Дүүгий нь тэвчиж өгсүгэй" хэмээжээ. Өвөгжин, Ноёхон, **Хартаад**[281] өгүүлрүүн:

"Гары нь гардаж
Хөлий нь хөлдөж өгсүгэй" хэмээв. Тоорил өгүүлрүүн: "Аргацаан явж Тэмүжиний улсыг нь авъяа. Улсаа автваас улс үгүй болбоос ягаахийнэ тэд?" хэмээв. Хачиун бэхи өгүүлрүүн: "Нилха Сэнгүм хөвүүн чамайг юу санаваас
Уртын үзүүрт
Гүний ёроолд хүрэлцье" хэмээжээ.

167. Эдгээр үгсийг өгүүлэлдэж Нилха Сэнгүм эцэг Ван хандаа тэдгээр үгсийг Сайхан Төдэнээр өгүүлж илгээжээ. Эдгээр үгсийг сонсоод Ван хан өгүүлрүүн: "Хөвүүнийг минь Тэмүжинд яахан тийн сэтгэх буюу та нар? **Эдүгээ**[282] түүгээр **түшиг тулгуур**[283] болгон бөгөөтөл одоо хөвүүнд минь тийн муу санаваас тэнгэрт үл таалагдана бид. Жамуха **үг зөөдөг**[284] бөлгөө. Зөв үү? **Тав уу?**[285] [юу] өгүүлж буй" хэмээн эс таалан илгээв.

Бас Сэнгүм өгүүлж илгээрүүн: "Амтай, хэлтэй хүмүүн өгүүлэн бөгөөтөл яахан үл тоомсорлоно?" хэмээн **байж даяанд**[286] өгүүлж илгээн ядаад өөрийн биеэр одож өгүүлрүүн: "**Бүр**[287] чамайг өдийд [амьд] байх цагт биднийг юу ч эс тоох буюу. Үнэхээр хаан эцэг чамайг

Цагаанаа цацваас
Хард **хахваас**[288]

Хурчахус Буйруг хан эцгийн чинь зовон өдий хурааж агсан улсыг чинь Манд мэдүүлэх үү? Хэнээр яахан мэдүүлэх [вэ]?" хэмээв. Тэр үгэнд Ван хан өгүүлрүүн: "Хүүхдээ, хүүгээ хэрхэн тэвчинэ! Эдүгээ түүгээр түшиг болгож [байж] муу санаваас зохих уу? Тэнгэрт үл таалагдана бид" хэмээв. Тэр үгэнд хүү Нилха Сэнгүм нь уурлаж үүд хаяж гарав. Жич хөвүүн Сэнгүмийнхээ дур [хүслийг] хайрлаж урьж ирүүлж Ван хан өгүүлрүүн: "Тэнгэрт магад таалагдана уу бид? Хөвүүнийг хэрхэн тэвчье хэмээмой та

нар? Чадвал үйлдэгтүн! Та нар мэдэцгээ" хэмээжээ.

168. Тэндээс Сэнгүм өгүүлрүүн: "Мөнөөхөн [тэд] манай Чаур бэхийг гуйсан бөлгөө. Эдүгээ **багалзуур идэхээр**[289] ирэгтүн хэмээн өдөр болзож урьж ирүүлж тэнд барья" хэмээлдэж "зэ" хэмээн үг зөвлөлдөж "Чаур бэхийг өгье. Багалзуур идэхээр ирэгтүн" гэж илгээв. Чингис хаан уригдаж арван хүнтэй явах зууpаа Мунлиг эцгийн гэрт хоноводс тэнд Мунлиг эцэг өгүүлрүүн: "Чаур бэхийг [түрүү] гуйхад мөнөө биднийг доромжилж үл өгсөн бөлгөө. Эдүгээ яахан **эргэж**[290] багалзуур идүүлэхээр урих [болов]. **Өөрсдөө**[291] ихэрхэгч хүмүүс яахан [гэнэт] эргэж өгье хэмээн урих бөлгөө? Зөв үү тав уу [ямар] сэтгэл буй. Хөвүүн ухаж бодох [биз]. Хавар болов. Бидний адуу туранхай буй. Адуугаа тэвээрүүлье хэмээн шалтаж илгээе гэж үл одон Бухатай, Хиратай хоёрыг багалзуур идэгтүн хэмээн илгээж Чингис хаан Мунлиг эцгийн гэртээс харив. Бухатай, Хиратай хоёрыг очихын хамт "бид сэрдэгдэв маргааш эрт бүслэн барья" хэмээлдэв.

169. Тийн бүслэж баръя хэмээн үг хэлэлцсэнийг Алтаны дүү Их Чэрэн гэртээ ирж өгүүлрүүн: "Маргааш эрт Тэмүжинийг баръя хэмээлдэв. Энэ үгийг Тэмүжинд хэл хүргэн очих хүнийг ямар [зэрэг] болгох буй?" хэмээжээ. Тийн өгүүлсэнд эхнэр Алагжид өгүүлрүүн: "тэр **чалчаа**[292] үг чинь юу болно. Эгэл бид ч үнэмших үү" хэмээв. Тийн хэлэхүйд адууч Бадай нь сүү хүргэхээр ирж энэ үгийг сонсож харив. Бадай явж адууч нөхөр Хишилигэд Чэрэнгийн өгүүлсэн үгийг хэлэв. Хишилиг өгүүлрүүн: "Би бас очиж лавласугай" хэмээж гэрт [нь] очиход Чэрэнгийн хөвүүн Нарин гэгэн гадаа сууж сумуудаа үрэн байж өгүүлрүүн: "Сая бид юу хэмээлдлээ?

Хэлий нь боож
Хэний амыг **таглах вэ?**[293]" хэмээв. Тэгээд Нарин Гэгэн бас адууч Хишилигдээ өгүүлрүүн: "Мэргидийн цагаан, ам цагаан хээр хоёрыг барьж авчир. Шөнө уяж эрт мордъё" хэмээв. Хишилиг явж Бадайд өгүүлрүүн: "Саяын үгийг чинь болгоов" магад [үнэн] болов. Эдүгээ бид хоёр Тэмүжинээ хэл хүргэн очъё хэмээн үг барилдаж, Мэргидийн цагаан, ам

цагаан хээр хоёрыг барьж ирж уяж, үдэш гэртээ нэгэн хурга алж ороороо болгож, Мэргидийн цагаан, ам цагаан хээр хоёр бэлэн уясан [морьдыг] унаж шөнө явж Чингис хаанд шөнөдөө хүрч гэрийн араас Бадай, Хишилиг хоёр өгүүлрүүн: "Их Чэрэнгийн өгүүлсэн үгс, хөвүүн Нарин Гэгэнийх нь сумуудаа үрэн сууж өгүүлсэнийг, Мэргидийн цагаан, ам цагаан хээр хоёр морьдыг барьж уя гэсэн үгс бүгдийг өгүүлж өгөв. Бас Бадай, Хишилиг хоёр өгүүлрүүн: "Чингис хааныг соёрхвоос **эргэлзэл үгүй**[294] буй. [Таныг] бүслэж барья хэмээн үг барилдав" хэмээв.



Зургадугаар бүлэг



170. Тийн өгүүлсэнд Чингис хаан Бадай, Хишилиг хоёрын үгэнд итгэж тэр шөнөдөө дэргэдэх бүх итгэлтэй [хүмүүстээ] хэл өгөөд хөнгөлөн юмаа орхиж буруулан мөн шөнө хөдлөв. Мау өндөрийн хяраар хөдлөхдөө Мау өндрийн хярд Урианхдай Зэлмэ гуаг итгэж хойноо цагдуул болгон харуул тавьж хөдлөв. тэр хөдөлсөнөөрөө маргааш өдөр турш [явж] нар хэлбийлгэн **Хар халзан элст**[295] хүрч үдлэн буув. Үдлэж бүхүйд Алчидайн агт адуулсан Чихитай Ятир зүйл зүйлийн ногоонд агтаа адуулан явахуйд хойноос Мау өндрийн өврөөр Улаан бургад [бургаст] дайран айсуй дайсны тоосыг үзэж "Дайсан хүрч ирэв" хэмээж адуугаа үлдэж ирээд "дайсан хүрч ирэв" гэхэд үзвээс Мау өндрийн өврөөр Улаан бургад дайран тоос гаргаж "Ван хан тэр нэхэж айсуй ажгуу" хэмээж, тэндээс Чингис хаан тоос үзээд моридоо бариулаад ачаалж морилов. Төдий эс үзсэн бөгөөс гэнэдэх бөлгөө. Тэр айсуй [дайсанд] Жамуха Ван хантай хамт ирэлцэж явсан ажгуу. Тэнд Ван хан Жамухаас асуусан нь : "Тэмүжин хөвүүнд хатгалдах [хүчтэн] хэн хэн буй?" хэмээхэд Жамуха өгүүлрүүн:

"Тэнд Урууд Мангууд хэмээх иргэн нь буй. Тэр иргэн нь хатгалдмуй за.

Тойрохуй тутам
Той[296]зохиож
Дэрэлхэхүй[297] тутам
Дэм[298] зохиож
Өчүүхэн [багаас]
Илд жаданд дадсан
Иргэн тэд
Харагчнууд, алагчнууд **тугтан**[299] буй тэд. Сэрэмжлэх иргэн буй за"

хэмээв. Тэр үгэнд Ван хан өгүүлрүүн: "Тийн бөгөөс бид тэдэнд Жиргин баатруудаа Хатагинаар толгойлуулан Жиргин баатруудаа довтолъё. Жиргиний араас Түмэн Түбэгэний Ачиг ширүнг довтолгоё. Түбэгэний араас олон Донхайдын баатруудыг довтолгоё. Донхайдын араас Ван ханы мянган шадар [цэргүүдийг] удирдан Хори шилэмүн тайж довтолтугай. Мянган шадар [цэргүүдийн] араас манай их гол [хүч] довтолтугай" хэмээжээ. Бас Ван хан өгүүлрүүн: "Жамуха дүү манай цэргийг чи зас!" хэмээв. Тэр үгэнд өөр [тийшээ] зайлан гарч нөхөддөө өгүүлрүүн: "Ван хан энэ цэргээ намайг зас хэмээв. Андтай (Тэмүжин) би хатгалдан ядаж [эмээж] явлаа. Энэ цэргээ намайг зас хэмээв. Ван хан надаас **илүүрхэх**[300] юмгүй ажгуу. [Тэр] ялихгүй нөхөр буюу. Андад хэл хүргэе. Анд хатуужтугай!" хэмээж Жамуха **далдуур**[301] Чингис хаанд хэл хүргэж өгүүлж илгээсэн нь "Ван хан надаас асуув. Тэмүжин хөвүүнд хатгалдаж чадах хэн хэн буй? Хэмээн асууваас би өгүүлрүүн: Урууд Мангуудыг **товойлгон**[302] өгүүлэв би. Миний үгэнд тэд Жиргинээ түрүүлж манлайлан засалдав. Жиргиний араас Түмэн Түбэгэний Ачиг ширүнг [оруулъя] хэмээлдэв. Донхайдын араас Ван ханы мянган шадар [цэргийн] ноён Хори Шилэмүн тайжийг [оруулъя] хэмээлдэв. Түүний араас мөн Ван ханы их гол цэрэг байсугай хэмээпдэв. Бас Ван хан өгүүлрүүн: "Жамуха дүү энэ цэргийг чи зас хэмээн намайг түшин өгүүлмүй. Үүнээс ухаж үзвэл [тэр] ялихгүй нөхөр буюу цэргээ засаж яаж чадна? Эрт [цагт] би анд [чамтай] хатгалдан ядаж явлаа. Ван хан надаас цаашгүй (дээргүй) ажгуу. Анд бүү ай, хатуужтугай!" хэмээн илгээжээ.

171. Энэ хэлийг ирүүлээд Чингис хаан өгүүлрүүн: "Урууд ын Жүрчидэй **эбин**[303] Чи юу хэмээмүү? Чамайг манлайд [явуулъя]" хэмээв. Жүрчидэйг дуугарахын урьд Мангуудын Хуйлдар сэцэн өгүүлрүүн: "Андын өмнөөс би хатгалдъя. Мөнөө хойно өнчин хөвүүдийг минь асрахыг анд мэдтүгэй" хэмээв. Жүрчидэй өгүүлрүүн: "Чингис хааны өмнө бид Урууд, Мангууд манлайлан хатгалдъя" хэмээжүхэй. Тэгээд Жүрчидэй Хуйлдар хоёр Урууд, Мангуудаа Чингис хааны өмнө засаж байв. Тэгэж байтал

Жиргинээр манлайлуулсан дайсан хүрч ирэв. Ирэхийн хамт Урууд, Мангууд эсрэг довтлож Жиргинийг дарав. Дарж явахуйд Түмэн Түбэгэний Ачиг ширүн довтлон [оров]. Довтлож Ачиг Ширүн Хуйлдарыг хатгаж [мориноос] унагажээ. Мангууд Хуйлдарын дээр ээрэлдэцгээв. Жүрчидэй Урууда араа довтлож Түмэн Түбэгэнийг дарав. Дарж хөөцөлдөж явахуйд олон Донхайд эсрэг довтлов. Жүрчидэй бас Донхайдыг дарав. Дарж явахуйд Хори Шилэмүн тайж мянган шадар [цэргүүдээрээ] довтлов. Жүрчидэй бас Хори Шилэмүн тайжийг няцааж дарж явахад Ван ханаас зөвшөөр үгүй Сэнгүм эсрэг довтлохдоо энгэсэг хацраа **харвуулж**[304] Сэнгүм мөн тэнд унажээ. Сэнгүмийг унахад хэрэйд бүгдээр Сэнгүмийн хээр ээрэлдэж байв. Тэднийг дарж шингэх наран гүвээний дээгүүр ташин бүхүйд бидний бөөгнөрсөн [хүмүүс] Хуйлдарыг унаж шархадсаныг авч харьж, Чингис хаан манайхан Ван хантай хатгалдсан газраас салж [тэр] үдэшдээ хөдлөж зайлж хонов.

172. Тэгэж хоноод үүр гийлгэн [хүнээ] бүрсгэвээс Өгэдэй, Борохул, Боорчу гурав үгүй ажгуу. Чингис хаан өгүүлрүүн: "Өгэдэйтэй итгэлт Боорчу, Борохул хоёр хоцорчээ. **Амьд ч**[305] үхсэн ч юунд хагацана тэд?" хэмээв. Манайхан шөнө морьдоо барьж хонож Чингис хаан өгүүлрүүн: "Хойнооос биднийг нэхэж ирвээс хатгалдъя" хэмээн [цэргээ] засаж байв. Өдөр гэгээ оруулж үзвээс хойноос нэг хүн айсуй. Хүрч ирвээс Боорчу ажгуу. Боорчууг хүрч ирүүлээд Чингис хаан өгүүлрүүн: "Мөнх тэнгэр мэдтүгэй" хэмээж өвчүүгээ мэхийлгэв. Боорчу өгүүлрүүн: "Довтлон [явахуйд] морио унатал харвуулж явган гүйж явтал мөн Хэрэйдүүд Сэнгүмийн дээр бөөгнөрч байх завсар чөлөөнд ачаатай морь ачаагаа **хөглүүлж**[306] байсныг ачааг нь огтолж янгирцаг дээр нь унаж гарч манайхны салж гарсан мөрийг мөшгин явж эдүгээ ирэв би" хэмээв.

173. Хоромхон байтал бас нэгэн хүмүүн айсуй. Ирж явахад доор нь хөл унжилзаж байв. Үзвээс ганц хүмүүн мэт буюу. Хүрч ирвээс Өгэдэйн араас Борохул сундалж амны завжиар цус цувруулж хүрч ирэв. Өгэдэйн сужаа [маханд] нь сум тусч цус нь

бүлэгнэхэд[307] Борохул амаараа шимж бөглөрсөн цусыг завжираа цувуулж ирэв. Чингис хаан үзэж нүднээсээ нулимс цувируулж сэтгэл алжаагаад, гал үтэр түлүүлээд [шархыг] халуун даруулаад Өгөдэйд унд авчирч өгүүлж, дайсан ирвээс хатгалдъяа хэмээсэн бөлгөө. Борохул өгүүлрүүн: "Дайсны тоос цаашаа Мау өндрийн өврөөр Улаан бургадын зүгт тоос үргэлжилж гарч цааш явав" хэмээв. Борохулын тэр үгэнд "Ирвээс хатгалдах болой. Дайсан буруулан хөдөлбөөс бид цэргээ [бэлтгэн] **зүгшрүүлж**[308] хатгалдъя" хэмээж хөдлөв. Хөдлөхдөө Улхуй, Шилүгэлжид өөд нүүдэллээд Далан нөмүргэс оров.

174. Тэнд [тэдний] хойноос Хадаан Далдурхан эмс хүүхдээсээ хагацаж ирэв. Хадаан Далдурхан ирж Ван ханы үг хэмээн өгүүлрүүн "Ван хан хүү Сэнгүмийг **нисгэгч суманд**[309] энгэсэг хацраа унатал шархдахад дээр нь ирж тэнд өгүүлжээ.

Тэмцэхүй[310] мэтэд
Тэмцэлдэв
Халдахуй мэтэд
Халдах бolж
Хайран хөвүүн минь
Хацартаа
Хадаас хадуулав
Хөвүүний амь өрсөн довтолъёо

Гэвээс түүнд Ачиг ширүн өгүүлрүүн:

Хан хан битгий
Эчнээ бүхүй хүү ирэхэд
Илбийн зангиа[311] хийж
Эвий бөвий хэмээн
Эрэн залбирмуй бид
Энэ төрж гарсан
Хүү Сэнгүмийг асаръя

Монголын олонхи Жамухад, Алтан Хучар [хоёрт] бидэнд буй. Тэмүжинтэй дайжиж гарсан монголчууд хаа одно тэд?

Морин унаатан

Модон нөмөртөн[312] болов тэд
[Өнөө] тэд эс ирвээс
Очиж морины **хомоол**[313] мэт
Хормойлж авчиръя бид тэднийг" хэмээв.

Ачиг ширүний энэ үгэнд Ван хан өгүүлрүү: "Зэ тийн бөгөөс хөвүүн [минь] алжаагуузай Хөвүүнийг [тэргэнд] үл **донсолгон**[314] асрагтун?" гээд хатгалдсан газраас харин буцъя хэмээв.

175. Тэндээс Чингис хаан Далан Нөмүргөөс Халх [гол] уруу хөдлөхдөө [цэргийн] тооллого тоолов. Тоолбоос хоёр мянга зургаан зуу болов. Нэгэн мянга гурван зуутыг Чингис хаан [авч] Халхын өрнө этгээдээр нэхэв. Нэг мянга гурван зуут Халхын Дорно этгээдээр Урууд, Мангууд нэхэв. Тийн нэхэж айсуйд хүнсэнд [ан] авлан явахуйд Хуйлдар шархаа эдгэрээгүй [байхад] Чингис хаан ятгасаар [байтал] үл болон гөрөөс хөөж явж үгдэрч [нас] нөгчив. Тэнд Чингис хаан Халхын **Ор нугын**[315] Хэлтгий хаданд ясы нь тавиулав.

176. Халхын Буйр нуурт цутгах [газрын] эхэнд Тэргэ, Амэлтан Хонгирад буй хэмээн мэдэж Жүрчидэйг Урууд тай илгээв. Илгээхдээ "Хонгирад иргэн эрт өдрөөс

Зээгийн зүсээр
Охины өнгөөр болговоос

[даган] элсэнэ. Тэд эсэргүүцэл хийвээс хатгалдъяа бид" хэмээж илгээвээс Жүрчидэйд элсэн оржээ. Элсэн орсон [учир] Чингис хаан юугий нь ч эс хөндөв.

177. Тэнд Хонгирадыг оруулан одож Түнхэ горхины дорно [талд] бууж Чингис хаан Архай Хасар, Сүхэхэй Жэүн хоёроор **үг бариулруун**[316]: "Түнхэ горхины дорно [талд] буув. Өвс [бэлчээрээр] сайн болжээ. Агтууд маань үелэв. Хан эцэгт минь өгүүл" хэмээн өгүүлрүүн: "Хан эцэг минь юунд **буруутгаж**[317] намайг айлгав чи? Айлгах бөгөөс муу хөвүүдээ муу бэрээцүүлээ нойр нь ханасан [хойно] яахан үл айлгав чи?

Дэн суух[318]ор богиносгож
Дээш гарах **утаа замхрааж**[319]

Яахан тийн айлгав чи? Хан эцэг минь
Хажуугийн хүмүүнээ
Хатгагдав уу чи
Хөндлөнгийн хүмүүнээ
Хөгжөөгдөв[321] үү чи
Хан эцэг минь бид хоёр юу хэмээлдлээ? Зоргол хуны Улаанууд, Болдагуудад бид эс өгүүлэлдлүү?
Шүдэт могой шударваас
Шудраанд нь бүү оръёо
Шүдээр амаар ололцож биширьеэ [гэж] эс хэлэлцлүү? Эдүгээ хан эцэг минь шүдээр амаар ололцож хагацав [уу] чи?
Араат могой хадарваас
Хадраанд [нь] бүү оръёо
Амаар хэлээр ололцож биширьеэ [гэж] эс хэлэлцлүү? Эдүгээ хан эцэг минь амаар хэдээр ололцож ангижрав [уу] чи? Хан эцэг минь Би цөөн боловч олныг үл эрүүлэх бөлгөө, муу боловч сайхныг үл эрүүлэх бөлгөө би. Хоёр аралтай тэрэг нөгөө арлаа мугарваас үхэр нь зүтгэн ядюу. Тэр мэт нөгөө арал чинь би биш гэж үү?. Хоёр хүрдтэй тэрэг нөгөө хүрдээ хугарваас хөдлөн ядна. Тэр мэт нөгөө хүрд чинь би биш гэж үү? Эрт өдөр гэвээс Хурчахус буйруг хан эцэг юүгээ [өнгөрсөн] хойно дөчин хөвүүдийн ах хэмээж хан болгожээ чамайг. Хан болоод ах дүү нараа Тай Төмөр тайж, Буха-Төмөр хоёрыг алав чи. Эрхэ хар дүү чинь алагдахаас амиа хоргоон гарч Найманы Инанча Билгэ ханд буруулж оржээ. Дүү нараа алагч болов хэмээн Гур хан авга чинь чамд морилж ирвээс чи зуун хүнтэй амиа хоргоон буруулж Сэлэнгэ уруу дутааж Хараун хавцалд шургалав чи. Жич тэндээс гарахдаа Мэргидийн Тогтоад Ужаур үжин охиноо **зусардан**[322] өгч, Хараун хавцлаас гарч Есүхэй хан эцэгт минь ирвээс чи тэнд өгүүлрүүн: "Гур хан авгаас улсы минь аварч өг" хэмээхэд Есүхэй хан эцэг минь чамд тэгье хэмээн ирж Тайчуудаас Хунан Бахажи хоёрыг удирдаж улсыг чинь аварч өгье хэмээн цэрэг засан одож, гурван **Дэрстэд**[323]

бүхүй Гур ханы хорь гучин хүнийг Хашин [орны] зүг үлдэж улсыг чинь аварч өгөв. Тэндээс ирж Туулын хар шугуйд Хан эцэг, миний Есүхэй хантай анд бололцож тэнд Ван хан эцгийг минь бишрэн өгүүлрүүн: "Энэ тусыг чинь [үр] ач ургийн урагт чинь ач хариулахыг дээр тэнгэр газрын ивээл мэдтүгэй" хэмээн бишрэгсэн ажгуу чи. Түүний хойно Эрхэ хар Найманы Инанча Билгэ ханаас цэрэг гуйж чамд морилж ирвээс чи амиа хоргоон улсаа орхиж цөөн хүмүүнтэй дутааж гарч, Хар Хитаны Гур ханд Чүй мөрнөө Сартуул нутагт одов чи. Нэгэн он илүү өнгөрөөгөөд бас Гур ханаас дайжиж гарч Уйгур, Тангудын нутгаар зүдэрч явахдаа таван ямаа шөрөглөж сааж идэж, тэмээний цус ханаж идэж ганц сохор халиун морьтой ирэв чи. Хан эцэг чамайгаа тийн зүдэрч явна хэмээн мэдэж, урьд Есүхэй хан эцэгтэй минь анд бололцсоны тул санаа тавьж Тахай, Сүхэхэй хоёрыг өөдөөс чинь илгээгээд бас би өөрөө Хэрлэний Бүрги эргээс угтан явж Гүсэүр нуурт золголдов бид. Чамайг зүдэрч ирэв хэмээн гувчуур татаж чамд өгөөд урьд эцэгтэй минь анд бололцсоны ёсоор Туулын хар шугуйд бид хоёрын эцэг хөвүүн болоцсон ёс тэр биш билүү? Тэр өвөл чамайг хүрээн дотор оруулж тэжээвээ. Өвөл өвөлжиж, зусаж, намар нь Мэргид иргэний Тогтоа бэхид морилж **Хатиглиг нурууны**[324] Мөрүчэ сүүл хатгалдаж Тогтоа бэхийг Баргужин төхүмийн зүг үлдэж Мэргид иргэнийг дагуулж олон адуу, орд гэрийг нь тариа [будааг] нь бүгдийг авч хан эцэгт өгөв өө би.

Өлссөнийг чинь
Өдөр дунд эс хүргэв ээ
Турсныг чинь
Сарын **талд**[325] эс хүргэв ээ би

Бас бид Хүчүгүртэй Буйруг ханыг Үлүг тагийн Сохог уснаас Алтай давуулан үлдэж Үрүнгү уруу одоод **Хичилбаши нуурт**[326] мохоож авав аа бид. Тэндээс буцаж айсуйд Найманы Хөгсэү Сабраг Байдаргийн бэлчирт цэргүүдээ засаж байлдахад үдэш орой болж маргааш эрт хатгалдъяа хэмээн засалдаж хоноовоос Хан эцэг минь чи буудалдаа гал түлүүлж шөнө Хар сүүл өөд хөдлөв чи. Маргааш

эрт үзвээс буудалдаа үгүй болоход чамайг хөдөлж [гэдгийг мэдээд] "Эд биднийг түлш болгосон ажгуу" хэмээж би бээр хөдөлж Эдэр Алтайн бэлчирээр гэтлэж ирж Саарь хээрт буув. Тэнд чамайг Хөгсэү Сабраг нэхэж Сэнгүмийн эмс хүүхэд, ард иргэн бүгдийг аваад Хан эцэг чиний Тэлэгэтү амсарт байсан зарим иргэд адуу [мал] идээ [хөрөнгийг] булааж одвоос Мэргидийн Тогтоагийн хөвүүн Худу, Чулуун хоёр ард иргэдээрээ чамтай [хамт] байснаа тэр хооронд эцэгтэйгээ нийлэн Баргужин орноо чамаас дайжин хөдөлжээ. Тэнд хан эцэг минь чи "Найманы Хөгсэү Сабрагт ард иргэдээ булаалгав би. Хөвүүн минь дөрвөн хүлгээ өгч ирүүл" хэмээн хэлэхэд чиний мэт үлсэтгэн тэнд би Боорчу, Мухули, Борохул, Чулуун баатар эдгээр дөрвөн хүлгээрээ цэрэг засуулж илгээвээс эл дөрвөн хүлгүүдийг минь [очихоос] урьд Улаан Хутад Сэнгүм байлдахдаа мориныхоо гуяыг харвуулж автах болж бүхүйд эдгээр дөрвөн хүлгүүд минь хүрч Сэнгүмийг авраад эмс хүүхэд ард иргэн сэлт бүгдийг аварч өгвөөс тэнд хан эцэг минь бишрэн өгүүлрүүн: "Хөвүүн Тэмүүжин дөрвөн хүлгээ илгээж үгүй болон одсон ард иргэнийг аварч өгөв" хэмээж бөлгөө чи. Эдүгээ хан эцэг минь ямар буруутайд минь буруутгав чи? Буруутгасан учирт элч илгээ. Илгээхдээ Хубарихури, Идүргэн хоёрыг илгээ. Энэ хоёрыг эс илгээвээс **нөгөөдөхийг**[327] илгээ" хэмээж явуулбаас

178. Эдгээр үгст Ван хан өгүүлрүүн:

Ай халаг[328] хөвүүнээсээ
Хагацахуйяа төрөөсөө
Хагацав [би]
Няцахуйяа[329] үйлээсээ
Няцав би

"Эдүгээ хүүгээ үзэж муу санаваас энэ мэт цусаа гаргатугай" хэмээн андгайлж чигчий хурууныхаа **өндгийг**[330] **онивч**[331] хутгаараа хатгаж цусы нь цувруулж, өчүүхэн **бортогот**[332] хийж "хөвүүнд минь өг" хэмээж илгээв.

179. Бас Чингис хаан "Жамуха андад өгүүл" хэмээн өгүүлрүүн: "Хан эцгээс минь [намайг] үзэн ядаж хагацуулав чи.

Урьд боссон бидний [хэн нэг нь] Хан эцгийн **хөх цомоог**[333] уух бөлгөө. Намайг урьд босч ууна [гэж] атаархав чи. Эдүгээ Хан эцгийн хөх цомоог барагтун. Хэдий хорооно та нар?" хэмээж илгээв. Бас Чингис хаан Алтан, Хучар хоёрт өгүүл хэмээн өгүүлрүүн: "Та хоёр намайг тэвчин **илээр**[334] орхих гэсэн үү та нар? **Аргацаан**[335] [нууж] орхих гэсэн үү та нар? Хучар чамайг Нэгүн тайжийн хөвүүн хэмээж биднээс "Чи хан бол" гэвээс эс болов оо чи. Алтан чамайг Хотула хан л мэдэж явлаа. Эцэг юугийнхээ мэдэж байснаар "Чи хан бол" гэвээс эс боловоо чи. Дээрээс Бартан баатрын хөвүүн хэмээж Сача Тайчу хоёрыг "Та нар хаад бологтун" хэмээж ядав аа би. Та нарыг хаад бологтун гэж ядаад, [харин] та нар чи хан бол хэмээсэнд би [улсыг] мэдэн ядав аа. Та нарыг хаад болсон бөгөөс:

Олон дайнд
Оройлон довтолбоос
Тэнгэрт ивээгдэвээс
Дайсан хүнийг
Дагуулахуй дор
Хацар гуа охин
Хатан эмийг
Харгам сайн агт
[Хатируулан] авчирч өгөх бөлгөө би.
Оройо гөрөөсөнд
Удиргуулдваас
Хадны гөрөөсний
Хаагий нь нийлтэл
Шахаж өгөх бөлгөө би
Гууны гөрөөсний
Гуяы нь нийлтэл
Шахаж өгөх бөлгөө би
Хээрийн гөрөөсний
Хэвлий нь нийлтэл
Шахаж өгөх бөлгөө би

Эдүгээ эцэгт минь сайтар нөхөрлөж өгөгтүн! Та нар уйдамхай хэмээгдүүзэй. Жаут хурийн түшиг тулгуур [нь] энэ ажгуу [гэж] бүү хэлүүлэгтүн! Гурван мөрний эхэнд хэнийг ч бүү буулгагтун" хэмээж илгээв.

180. Бас Чингис хаан Тоорил дүүд өгүүл хэмээн өгүүлрүүн: "Дүү хэмээх ёс Тумбинай Чархай Линху хоёрын Охта [нэрт] боолыг **олзлож**[336] ирэвээ. Охта боолын хөвүүн Сүбэхэй боол бөлгөө. Сүбэхэй боолын хөвүүн Хөхөчү Хирсаан бөлгөө. Хөхөчү Хирсааны хөвүүн Ехэй Хонтахар бөлгөө. Ехэй Хонтахарын хөвүүн Тоорил чи хэний улсуудыг өгье хэмээн зусардан явна чи? Миний улсыг Алтан Хучар хоёр хэнээр ч үл мэдүүлэх буй за. Чамайг дүү хэмээх [болсон] ёсон:

Буурлын[337] минь
Босгоны боол
Элэнцийн минь
Үүдний боол хэмээж илгээсэн минь ийм".

181. Бас Чингис хаан Сэнгүм андад өгүүл хэмэн өгүүлрүүн: "**Дээлтэй төрсөн хөвүүн**[338] би ажгуу. Нүцгэн төрсөн хөвүүн чи ажгуу. Бидний хан эцэг бид хоёрыг [эн] сацуу асрах бөлгөө. [Бидний] завсар [хүн] орсоноос Сэнгүм анд надад атаархаж үлдэв (хөөв) чи. Эдүгээ бидний хан эцгийн зүрхийг нь үл зовоон **оглөө үдэш**[339] орж гарч сэргээж яв.

Үжирхий[340] сэтгэлээ үл талбин хан эцгийг амьд бөгөөтөл хан болъё хэмээн бидний хан эцгийн сэтгэлийг бүү зовоож алгасуул!" гээд "Сэнгүм анд надад элч илгээ. Ирүүлэхдээ Билгэ бэхи, Төтөгэн хоёр нөхдийг явуул!" хэмээж илгээв. "Надад элч ирүүлэхдээ Хан эцэг хоёр элч илгээ. Сэнгүм анд хоёр элч илгээ. Жамуха анд хоёр элч илгээ. Алтан хоёр элч илгээ. Хучар хоёр элч илгээ. Ачиг Ширүн хоёр элч илгээ. Хачиун хоёр элч илгээ" хэмээн Архай Хасар Сүхэхэй Жэүн хоёроор өдий үгс үг бариулж илгээв. Эдгээр үгсийг өгүүлсэний хойно Сэнгүм өгүүлрүүн:

"**Хэзээ**[341] Хан эцэг гэдэг билүү?
Хядагч[342] өвгөн гэдэг эс билүү?

Намайг хэзээ анд гэдэг билээ?
Тогтоа бөөтэй Сартагчин хонины сүүл
Залгасан[343] [мэт] явдаг гэдэг эс билүү?
Эдгээр үгсийн арга [учрыг] ухаарав. Хатгалдааны тэргүүнд үгс [явдаг] буй. Билгэ бэхи, Төтөгэн хоёр хатгалдахуй туг босгогтун! Агт [морьдоо] таргалуулагтун! Эргэлзэл үгүй буй за" хэмээв.

Төдий Ван ханыхаас Архай Хасар харихад Сүхэхэй Жэүний эм хөвүүн хөвүүн (охин) тэнд Тоорилд [байсан] ажгуу. Сүхэхэй Жэүн [буцаж] одохоос зүрх шимширч Архай [Хасараас] хоцоржухуй. Архай [Хасар] ирж эдгээр үгсийг Чигис хаанд өгүүлэв.

182. Төдий Чингис хаан хөдлөж **Балжуна**[344] нуурт буув. Тэнд буухуйд Горуласын Чогос цагаан яг тэнд учралдав. Тэд Горулас үл эсэргүүцэн элсэн ирэв. Онгудын Алахуш-Дигидхуригаас цагаан тэмээт **Асан сартгатай**[345] мянган ирэг [хонь] тууж, Эргүнэ мөрөн уруу булга, хэрэм худалдаж авахаар айсуйд Балжуна [мал] услан явахуйд [Чингис хаан] учрав.

183. Чингис хаан мөн Балжунад [мал сүргээ] ундаалан бүхүйд Хасар эмийгээ [болон] Егү, Есүнгэ Тухутан гурван хөвүүдээ Ван ханд орхиж, цөөн бие, нөхдийн [хамт] гарч ах юугаа хэмээн Чингис хааныг эрэн **Хараун жидүний**[346] нуруудаар **хэрэж**[347], олон ядан ядсаар шир, шөрмөс идэж яваад Балжунад Чингис хаанд нийлэв. Хасарыг ирүүлээд баясч Чингис хаан Ван ханд элч илгээе хэмээн зөвлөж Жэүриэдэйн Халиудар, Урианхдайн Чахурхан хоёроор өгүүлж илгээрүүн: "Хан эцэгт Хасарын үг хэмээн өгүүлэгтүн!" хэмээн өгүүлрүүн:

"Ахаа харж (хайж)
Хараа минь завхав
Хайж мөрий нь
Олон ядав
Хайлаж дуугаа
Эс сонсгов
Од харж
Орвон[348] дэрт болж хэвтмүү би.

Эм хөвүүн минь Хан эцэгт буй. Итгэмжтэй эр (нөхөр) олбоос Хан эцэгтээ очно би хэмээн илгээв гэж өгүүлэгтүн!". Бас өгүүлрүүн: "Бид та [хоёрыг] залган хөдлөж Хэрлэний **Аргал Хөхийд**[349] [уулзахаар] болзолдъёо. Та нар тэнд ирэгтүн!" хэмээн болзолдож төдий Халиудар, Чахурхан хоёрыг илгээгээд Жүрчидэй Архай хоёрыг магнайчлуулж Балжуна нуураас Чингис хаан удааран хөдлөн гарч морилсоор Хэрлэний Аргал Хөхийд хүрэв.


184. Халиудар, Чахурхан хоёр Ван ханд хүрч Хасарын үг хэмээн эндээс (Чингисийн тэндээс) өгүүлж илгээсэн үгсийг өгүүлжүхүй. Ван хан **алтан тэрэм**[350] босгож ажиггүй хуримлаж байжээ. Халиудар, Чахурхан хоёрын үгд Ван хан өгүүлрүүн: "Тийн бөгөөс Хасар иртүгэй!" хэмээж итгэмж [болгож] Итүргэнийг илгээ хэмээн илгээлджээ. Төдий ирээд болзоот газар Аргал Хөхийд хүрэхийн хамт [сүр] бараа ихийг үзэж Итүргэн элч эргэн дутаажээ. Халиударын морь хурдан ажгуу. Халиудар гүйцэж барих зүрх алдаж урдуур хойгуур нь **хөрөөдөн**[351] явахуйд Чахурханы морь удаан ажгуу. Хойноос [нь] сум хүрэх [газрын] үзүүрээс Итүргэний алтан эмээлт хар агтын гуяны угийг суутал харавжээ. Тэнд Итүргэнийг Халиудар Чахурхан хоёр барьж Чингис хаанд авчрав. Чингис хаан Итүргэнтэй үл хэлэлцэн "Хасарт авч очигтун! Хасар мэдтүгэй" хэмээв. Авч очвоос Хасар Итүргэнтэй үл хэлэлцэн мөн тэнд цавчиж орхив.

185. Халиудар, Чахурхан хоёр Чингис хаанд өгүүлрүүн: "Ван хан ажиггүй алтан тэрэм босгож хуримлаж байна. Үтэрлэн **гүйлгэж**[352] шөнө дүлээр гэнэдүүлэн бүсэлье" хэмээв. Энэ үгийг зөвшөөж Жүрчидэй, Архай хоёрыг магнайчлуулж шөнө дүлээр хүрч **Жэжээр өндрийн Жэр Хавцгайн амсарт**[353] бүхүйд бүслэв. Гурван шөнө гурван өдөр тэмцэлдэн бүслэж байтал гудгаар өдөр тэд ядарч **[туйлдаад] орж өгөв**[354]. Ван хан Сэнгүм хоёрыг шөнө хэрхэн гарсаныг эс мэдэв. Энэ тэмцэлдэгч [нь] Жиргиний Хадаг баатар ажгуу. Хадаг баатар орж өгөөд өгүүлрүүн: "Гурван шөнө, гурван өдөр тэмцэлдэхдээ тус хан [эзнээ] үзсэр [байж] барьж хэрхэн алуулна? хэмээн тэвчин ядаж, амиа хоргоон **зайлуулгүгай**[355] хэмээн

сугаруулан тулалдлаа би. Эдүгээ үхүүлбээс үхье. Чингис хаанд соёрхогдвоос хүч өгье" хэмээв. Чингис хаан Хадаг баатрын үгийг зөвшөөж зарлиг болруун: "Тус хан [эзнээ] тэвчин ядаж амиа хоргоон зайлуулгүгай хэмээн тулалдах эр тэр [бусдаас] илүү буй. Нөхөрлөж [болох] хүмүүн бөлгөө" хэмээгээд соёрхож үл үхүүлэн "Хуйлдарын амь [алдсаны] тул Хадаг баатрыг зуун иргэний [хамт] Хуйлдарын эхнэр хүүхдэд нь хүч өгтүгэй! Нуган хөвүүн төрвөөс Хуйлдарын ургийн ураг хүртэл дагаж хүч өгтүгэй. Охин хүүхэд төрвөөс эцэг эх нь өөрийн дураар бүү **ураглатугай**[356]. Хуйлдарын эхнэр хүүхэд [нь] өмнө хойноо зартугай" хэмээн соёрхон зарлиг болов. Хуйлдар сэцний ам урьд хамгаас түрүү нээсний тул Чингис хаан соёрхож зарлиг болруун: "Хуйлдарын ургийн ураг хүртэл Хуйлдарын тусын тул өнчдийн **авлага**[357] [хишиг] аван атугай" хэмээн зарлиг болов.



Долдугаар бүлэг





186. Төдий Хэрэйд иргэдийг доройтуулж зүг зүг хувааж талуулав. Сүлдүдэй Тахай баатрын тусын тул нэг зуун иргэнийг өгөв. Бас Чингис хаан зарлиг болруун: “Ван ханы дүү Жаха Гамбу хоёр охидтой ажгуу. Эгчмэд Ибаха бэхийг нь Чингис хаан өөрөө авч дүүмэд Сорхагтани бэхийг Толуйд өгөв. Тэр шалтгаанаар Жаха Гамбууд **түүний**[358] харъяат өмч иргэнийг **цугаар [үлдээж]**[359] өрөөсөн арал бол” хэмээж соёрхож эс талуулав.

187. Бас Чингис хаан зарлиг болруун: “Бадай, Хишилиг хоёрын тусынх нь тул Ван ханы сууж байсан алтан тэрэм, алтан **хөнөг**[360] аяга сав, асарч байсан ард сэлт Онхожид (овог), Хэрэйдийг **хэшигтэн**[361] нь болтугай [гэж] нум сум, агсуулж идээ шүүс эдлүүлж ургийн ураг хүртэл дархлан жаргагтун [гээд]

Олон дайнд оролцвоос
Олз олбоос
Олсоноо авагтүн
Ороо гөрөөс албаас
Алснаа авагтүн” хэмээн зарлиг болов.

Бас Чингис хаан зарлиг болруун: “Бадай, Хишилиг хоёрын амин зуур тус хүргэсний тул мөнх тэнгэрт ивээгдэж Хэрэйд иргэнийг доройтуулж өндөр сууринд хүрэв ээ. Мөнөө хойно ургийн ураг минь [өндөр] сууринд сууж энэ мэт тус хүргэгсэдийг улам улам ухтугай!” хэмээн зарлиг болов.

Хэрэйд иргэнийг дагуулж

Хэнд ч дутаалгүй түгээлгэв
Түмэн Түмбэгэнийг түгээлдэж
Түгтэл[362] [цөмөөр] авалцав.
Олон Донхайдыг [хуваалцахад]
Огоот[363] өдөр үл хүргэн талуулав жэ.
Цуст тоног[364] авагч
Жирхин баатруудыг
Зүсэж хувааж хүргэлдэн ядав.

Хэрэйд иргэнийг төдий хороож тэр өвөл **Абжига хөдэхэрид**[365] өвөлжив.

188. Ван хан Сэнгүм хоёр биеэ дайжиж гарч одоод **Дидиг сахалын Нэгүн усnаа**[366] [хүрч] Ван хан цангаж [тэнд] буух болоход Найманы харуул Хорисубэчид орсон ажээ. Хорисубэчи Ван ханыг барихад "Би Ван хан буюу" гэвээс үл танин үнэмшил үгүй тэнд алсан ажгуу. Сэнгүм, Дидиг сахалын Нэгүн усnаа үл орон гадуур нь зорчиж цөлд орж ундаасахад хулан ялаархаж байхад, Сэнгүм [мориноос] бууж мяраажээ. Сэнгүмийн нөхөр Хөхөчү агтач эхнэртэйгээ Сэнгүмтэй гурвуул [явсан] ажгуу. Морио Хөхөчү агтачдаа бариулчухуй. Хөхөчү агтач морий нь хөтлөөд буцаж хатируулжээ. Эхнэр нь өгүүлрүүн:

"Алттыг өмсөхүйд
Амттыг идэхүйд
Хөхөчү минь гэдэг бөлгөө.
Хан Сэнгүмээ яахан тийн
Хаяж гээж одох буюу чи?" хэмээж эхнэр нь

хүлээж хоцроход Хөхөчү өгүүлрүүн: "Сэнгүмийг эрэлсүгэй хэмээх буюу чи?" хэмээжүхүй. Тэр үгэнд эхнэр нь өгүүлрүүн: "Эм хүмүүн **нохой нүүртэй хэмээгдьеэ би**[367] Алтан **домбы**[368] **нь өг! Ус утгаж уутугай**" хэмээжээ. Тэндээс Хөхөчү агтач алтан домбы нь "ав!" хэмээн арагш нь хаяад хатируулжээ. Тэгэж яваад Чингис хаанд Хөхөчү агтач ирж "Сэнгүмийг тийн цөлд орхиж ирэв би" хэмээн тэнд өгүүлэлдсэн үгээ бүгдийг бүрэн айлтгаж өгвөөс Чингис хаан зарлиг болруун: "Эмийг нь соёрхож, мөнөөх Хөхөчү Агтачийг тус

хан {эзнээ} тэвчиж иржээ. Ийм хүмүүн эдүгээ хэнд нөхөрлөж итгэгдэнэ?" хэмээгээд цавчиж орхив.

189. Найманы Таян ханы эх Гурбэсү өгүүлрүүн: "Ван хан эртний өтгөс их хан бөлгөө. Тэргүүнийг нь авчрагтун! Мөн бөгөөс бид тахьяа" хэмээж Хорисубэчид элч илгээж тэргүүнийг нь огтлож авчруулж, таниж цагаан **эсгийн**[369] дээр тавьж **бэрээдээ бэрлүүлж**[370], сархадлуулж, хуурлуулж, хундага барьж тайжухуй. Тэнд тэргүүн тийн тайж байтал инээжээ. Инээв хэмээн Таян хан [хилэгнэж] хэмх гишиглүүлжүхүй. Тэнд Хөгсэү Сабраг өгүүлсэн нь: "Үхсэн хан хүний тэргүүнийг нь та нар огтолж авчраад, тэгээд бас та нар хэмхлэх чинь хэрхэн зохино? Бидний **нохойн хуцах дуун муухай болов**[371] " [гэж] Инанча Билгэ хан өгүүлсэн билээ.

"Эхнэр {минь} залуухан
Эр би өтлөв.
Энэ Таяныг
Илбээр төрүүлэв.
Ай! **Дорой**[372] төрсөн хүү минь
Төрөлхи[373] олон {түмнийг}
Доорд муу улсыг минь
Асарч барьж чадна уу?" хэмээлээ. "Эдүгээ нохойн дуу **ойртож**[374] хуцал хуцмой.
Хатан бидний
Гурбэсүгийн засаг
Хурц болбай
Хан миний дорой Таян
Зөөлөн буюу чи
Шувуулах авлах хоёроос биш
Сэтгэл эрдэм үгүй буй" хэмээхэд тэнд Таян хан өгүүлрүүн: "Энэ дорно [зүгт] цөөхөн монгол буй хэмээмой. Тэд иргэн өтгөс их эртний Ван ханыг хор зэмсгээрээ айлгаж дайжуулж үхүүлэв. Эдүгээ мөн хан болоё хэмээн [санаж] байна уу тэд? Тэнгэрт нар, сар хоёр гэрэлтэн гэгээ болтугай хэмээн нар сар хоёр [байдаг] буй за. Газарт хоёр хаан хэрхэн [байж] болох? Би явж тэдгээр

монголыг авч ирье" хэмээжүхүй. Түүнд эх Гүрбэсү нь өгүүлрүүн: "Юу хийнэ тэдгээрийг? Монгол иргэн үнэр муухай хувцас **буртагтан**[375] бөлгөө. Ангид хол байж байтугай. [Харин] **шилдэг**[376] бэрээд охидыг нь магад авчруулж, гар хөлий нь угаалгаж гагц үнээ хонио саалгуулж [болох] л" хэмээжүхэй. Түүнд Таян хан өгүүлрүүн: "Тийн бөгөөс юу байхав? Тэд монгол руу одож хор [зэмсгий] нь хурдхан авчиръя" хэмээв.

190. Эдгээр үгст Хөгсэү Сабраг өгүүлрүүн: "Ай! [ямар] их үг өгүүлцгээнэ та нар! Ай дорой хан зохих болов уу **орхигтун**[377]" хэмээжүхэй. Хөгсэү Сабраг ятгасаар байсан [боловч] Торбиташи нэртэй элчийг Онгудын Алахуши Дигитхурид өгүүлж илгээрүүн: "Энэ дорно цөөхөн монгол буй хэмээгдмой. Чи баруун гар бол. Би эндээс хамсаж тэдгээр монголын хор [зэмсгий] нь авъяа" хэмээж илгээжээ. Тэр үгэнд Алахуши Дигитхури хариу өгүүлрүүн: "Би баруун гар болон үл чадна" хэмээн илгээгээд Алахуши Дигитхури Ёхунан нэрт элчээрээ Чингис хаанд илгээж өгүүлрүүн: "Найманы Таян хан хор [зэмсгийг] чинь авахаар ирмүй. Намайг баруун гар бол хэмээн ирэв. Би эс болов. Эдүгээ би чамд сэрэмжилж илгээв. Ирэх [дайсанд] хор [зэмсгээ] алдуузай чи" хэмээж илгээсүгэй. Яг [тэр үед] Чингис хаан Тэмээн хээрээр авлаад Түлгинчэгүдийг **Хомроголож**[378] бүхийд Алахуши Дигитхурийн илгээсэн Ёхунан элч энэ хэлийг хүргэн ирэв. Энэ хэл ав дээр ирсэн [учир] "Хэрхвэл зохино?" хэмээлдвээс олон хүмүүн өгүүлрүүн: "Манай агт [морьд] туранхай буй. Эдүгээ яацгаана бид?" хэмээлджүхэй. Түүнд Отчигин ноён өгүүлрүүн: "Морьд туранхай хэмээн яахан шалтгаална? Миний морьд тарган буй. Ийм үг сонсоод яахан [зүгээр] сууцгаана?" хэмээв. Бас Бэлгүдэй ноён өгүүлрүүн: "Амьд бөгөөтөл нөхөр [болсон] хоромсогоо алдваас амьд байсан юуны тус буй? Эр [болж] төрөөд үхсэн чиг хоромсого нумтайгаа ясаа нэгэн [дор] хэвтүүлбээс илүү сайн буй. Найман иргэн, улс ихтэй, иргэн олонтой хэмээн их үг өгүүлэх ажгуу. Бид эдний их үгэнд шавдан морилон одож, эдний хоромсогыг авбаас бэрхдэх [юун] ажгуу.

Одвоос олон адуу нь

Зогсож үл хоцруузай
Орд гэр нь
Өгөрч үл хоцруузай.
Олон улс нь өндөр газарт
Хурах бээр үл гаруузай!

Мөнөө ийм их үг хэлүүлж хэрхэн [зүгээр] сууцгаана? Даруй морилъё" хэмээв.

191. Бэлгүдэй ноёны энэ үгийг зөвшөөж Чингис хаан аваас буугаад Абжига хөдэхэригээс хөдөлж Халхын Ор нугын хэлтгий хаднаа бууж [цэргийн] тогоо тоололдож тэнд мянганыг мянгалаж, мянгатын ноён, зуутын ноён, аравтын ноёдыг тэнд тушаан [томилов]. **Чэрбинийг**[379]тэнд [бас] тушаан [томилов] Додай чэрби Дохолху чэрби, Өгэлэ чэрби, Толун чэрби, Бучаран чэрби, Сүйхэтү чэрби эдгээр зургаан чэрбийг тэнд тушаан [томилов]. Мянгатыг мянгалан, зуутыг зуулан, аравтыг аравлан барж наян **хэвтүүл**[380] далан **тургууд**[381] тэнд хэшигтэн (ээлжийн харуул) ялгаж оруулахад мянгат, зуутын ноёдын хөвүүд, дүү нарыг **үтэл сул ардын**[382] хөвүүд, дүү нарыг оруулруун. Бие **бялдар**[383] эрдэм сайтыг ялгаж оруулав. Тэнд Архай Хасарыг соёрхож "Баатруудыг ялгаж мянгалтугай! Хатгалдах өдөр минь байж хатгалдтугай! Олон өдөр тураг хэшигтэн минь болтугай" хэмээн зарлиг болов. "Далан тургуудыг Өгэлэ чэрби ахлаж байтугай! Хутусхалчантай зөвлөлдөж байгтун!" хэмээв.

192. Бас Чингис хаан зарлиг болруун: "Хорчин (сумчин), тургууд, хэшигтэн, буурч (тогооч), үүдэч, агтач өдөр хэшигт орж, нар шингэхийн урьд хэвтүүлд зайлж [өгч] морьтойгоо [гадагш] гаран хонотугай. Хэвтүүл шөнө гэр орчин хэвтэхээ (тойрон сахих) хэвтүүлж, үүдэнд байхаа хэшиглэн байгуултугай. Хорчин, тургууд маргааш нь биднийг [цай] шөл идэж [уусны] дараа хэвтүүлд хэлж, хорчин, тургууд, буурчин, үүдчин мөн мөн, мөр мөрийнхөө [ажилд] явтугай. Сууриндаа суутугай. Гурван шөнө, гурван өдөр хэшиг өдрөө дуусч мөнхүү ёсоор гурван шөнө хоноцгоож [ээлж] **солилцож**[384] шөнө [зөвхөн] хэвтүүл байтугай. Орчин хэвтэж

хонотугай!" хэмээн зарлиг болов. Төдий мянга мянгалан барж, чэрби томилж, наян хэвтүүл, далан тургууд, хэшигтэн оруулж Архай Хасар баатрууд ялгаж, Халхын ор нугын хэлтгий хаднаас Найман иргэнд морилруун.

193. Хулгана жил (1204) зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдөр туг тахиад морилруун. Хэрлэн өөд Зэбэ, Хубилай хоёр магнайчилж яваад Саарь хээрт хүрвээс Ханхар ханы эхэнд Найманы харуул тэнд ажгуу. Манай харуул [тэдэнтэй] үлдэн хөөцөлдөхөд манай харуулаас нэг муу эмээлтэй шунхалхан (зээрд) морийг найманы харуулд алджээ. Найманы харуул тэр морийг [барьж] өгүүлэлдрүүн: "Монголын морьд туранхай ажгуу" хэмээлджүхүй. Манайхан Саарь хээрт хүрч тэнд **түр түдэж**[385] "хэрхэн хийх вэ?" хэмээлдвээс тэнд Додай чэрби Чингис хаанд дурдан өгүүлрүүн: "Бид ч цөөн буй. Цөөн дээрээ [замд] чилж [зүдэрч] ирэв. Ийнхүү түр түдэж агтаа цадтал энэ Саарь хээрийг **тархан**[386] бууж амьд хүн бүр эрийн таван тусгай гал түлж, галаар хий **сүрдүүлье**[387] Найман иргэн олон хэмээгдмой. Хан нь гэртээсээ эс гарсан танхи хэмээгдмой. Галаар **гайхашруулж байтал**[388] бидний морьд цадму зэ. Морьдоо цадган найманы харуулыг үлдэн дарж, гол [хүчинд] нь нийлүүлэн тэр үймээнд хатгалдваас болох буюу" хэмээн дурдваас энэ үгийг зөвшөөж Чингис хаан зарлиг болруун: "Тийн бөгөөс гал түлцгээгтүн!" хэмээн цэргүүдэд зарлиг тунхаглав. Төдий Саарь хээрийг тархан бууж амьд хүн [болгон] таван ангид гал түлүүлэв. Шөнө Найманы харуул Ханхар ханы эхнээс шөнө олон гал үзэж "Монголыг цөөн гэсэн биш бил үү! Одноос олон галтан байна" хэмээн Таян ханд муу эмээлт шунхалхан морийг өгч илгээгээд: "Монголын цэргүүд Саарь хээрийг бүрхтэл бууцгаалаа. Өдөртөө ундран байна уу? [гэмтэр] одноос олон галтан буй" хэмээн илгээжүхэй.

194. Харуулын энэ хэл авахад Таян хан Хангайн Хачир уснаа [байсан] ажгуу. Энэ хэл хүргүүлээд Хүчүлүг хан хөвүүндээ хэлүүлж илгээрүүн: "Монголын агт [морьд] туранхай ажгуу. Одноос олон галтан хэмээмой. Монголчууд олон ажгуу. Эдүгээ бид

Хамтдаан барваас[389]
Хагацахуй бэрх болох уу?
Хамтдан барваас
Хар нүдээ
Ирмэс[390] үл хийнэ тэд
Хацраа хатгагдваас
Хар цусаа гарваас
Хальтрал үгүй
Хатангуй монголд
Хамтадваас болох уу?

Монголын агт [морьд] туранхай хэмээгдмой. Бид улсаа Алтай давуулан **сэгүүлэн**[391] хөдөлж, цэргээ [бэлтгэн] зүгшрүүлж тэднийг өдөөн явж, Алтайн **Өлгий**[392] хүртэл **нохой хэрэл хэрж явж**[393], [чулуу хөөлөгье]. Бидний агт тарган буй. Гэдсий [нь] **шивхрүүлэн**[394] монголын морьдыг **сульдуулан**[395] [улаан] нүүрэн дээр нь асган [оръё] бид" хэмээн илгээжүхэй. Тэр үгэнд Хүчүлүг хан өгүүлрүүн:

"Аанай [бас] ийн
Эм Таян зүрх алдан
Энэ үгсийг өгүүлжээ.
Монголын олон хаанаас ирэв [гэж]
Монголын олонхи Жамухатай энд бидэнд буй.
Хүнд эмийн[396] шээх газар эс гарсан
Хүрдний тугалын[397] бэлчээрт эс хүрсэн
Эм Таян зүрх алдан эс [зориглож]
Эдгээр үгсийг өгүүлж илгээжээ"

хэмээн [явуулсан] элчид [нь] эцэг юугээ өвдтөл, **хорстол**[398] хэлж илгээжүхэй. Энэ үгэнд Таян хан өөрөө эм мэтээр хэлэгдэж, Таян хан өгүүлрүүн:

"Хүчит омогт Хүчүлүг
Хүрэлцэхүй алалдахуй өдөр
Магад энэ омгоо бүү тавьтугай!
Хүрэлцэн хамтдан барваас

Хагацахуй магад бэрх буй”

Хэмээв. Тэр үгэнд Таян ханы удаахь их мэдлийн Ноён Хорисубэчи өгүүлрүүн: “Инанча Билгэ хан эцэг чинь [хүч] **сацуу**[399] нөхөртөө эрийн ар, агтын харгам (хондлой) эс үзүүлжээ. Эдүгээ чи [нас чинь] өглөө [мэт] эрт бөгөөд яахан зүрх алдана чи? Чамайг ийн зүрх алдахыг мэдсэн бөгөөс хатан хүн боловч эх Гүрбэсүүг чинь авчирвал цэрэг илүү засах бөлгөө. **Халаг!**[400] Хайран Хөгсэү Сабраг өтлөхөөр юунд бидний цэргийн цааз **сулрах**[401] болов. Монголчуудын цаг заяа буй за. Бүтэхгүй болов. Ай! дорой Таян чиний ядуу мэт энэ буюу” гээд хоромсогоо дэлдээд буцаж хатирав.

195. Түүнд Таян хан хилигнэж өгүүлрүүн: “Үхэх амь, зовох бие бүгд нэгэн буй за. Тийн бөгөөс хатгалдъя!” хэмээж Хачир уснаас хөдөлж Тамирын [гол] уруу яваад Орхоны гэтэлж **Наху хуны**[402] зүүн хормой дайран **Цахир Могод**[403] хүрч айсуйд Чингис хааны харуул үзэж “Найман ирж айсуй” хэмээн хэл хүргэвээс энэ хэл аваад Чингис хаан зарлиг болруун: “Олноос олон цөөнөөс цөөн хор [хохирол] болмуу зэ” гээд эсрэг морилж харуулыг нь үлдэн [хөөгөөд] цэргээ засахдаа “**Хамхуулын явдлаар явж**[404], **нуурын байдлаар байрлаж**[405], цүүцэн хатгалдаанаар хатгалдъя” хэмээлдэв. Тэгээд Чингис хаан өөрөө магнайчилж, Хасараар гол [хүчээ] засуулав. Отчигин ноёноор **хөтөлгөө [морьтныг]**[406] засуулав. Найман Цахир Могодоос буцаж Наху хуны овроор уулын хормой хэжин явж байжээ. Төдий Найманы харуулыг манай харуул үлдэн Наху хуны өвөрт их голд нь нийлтэл хоож хүрчээ. Тийн үлдэн хүрэхүйг Таян хан үзэж, Найманы цорготой төвд [цуг] морилож явсан Жамухаас Таян хан асуужээ. “Төд юун [хүмүүс] олон хонийг чоно үлдэж хотонд нь ортол үлдэж ирэх мэт төд юун хүмүүс тийн үлдэн айсуй?” хэмээн асуув. Жамуха өгүүлрүүн: “Төмүжин анд минь дөрвөн нохойдыг хүний махаар тэжээж, тинжилж, уяж байх бөлгөө. Тэд бидний харуулыг үлдэн айсуй яваа төд буй. Тэд дөрвөн нохой:

Ширмэн магнайтан
Цүүцэн хошуутан

Шивээ хэлтэн
Төмөр өртөн
Илд **ташуурtан**[407]
Шүүдэр идэж
Хий унаж явна тэд
Алалдах өдөр
Амьтны[408] мах иднэ тэд
Хүрэлцэх өдөр
Хүний мах хүнслэнэ тэд
Гинжээ мултлаж
Эдүгээ эс **торон**[409]
Баясан байгсад
Тийн шилбэлзэн
Айсуй тэд” хэмээжээ.
Тэд дөрвөн ноход
Хэн хэн [буй] гэвээс
“Зэбэ, Хубилай хоёр
Зэлмэ, Сүбээдэй хоёр
Тэд дөрөв буй” хэмээв.

Таян хан өгүүлрүүн: “Эл тэд доромж [муусайнаас] хол байя” хэмээж хойшоо ухарч уул аврин байв.

Түүний хойноос
Туйлан тойрон айсуйг үзэж бас Таян хан Жамухаас асуужээ. “Тэд юун
Эрт тавьсан унага
Эхийнхээ сүүг хөхөж
Эх юүгээ тойрон
Тоглон[410] гүйх унага мэт
Яахан тийн тойрон айсуй тэд?” хэмээн асуужээ. Жамуха өгүүлрүүн: “Тэд
Жадат эрийг зууж
Цуст тоног тоногчин
Илдэт эрийг үлдэж

Унагаж алж
Уб[411] тоног авагчин
Урууд, Мангууд хэмээгсэд тэд
Эдүгээ ийн баясаж
Тийн туйлан айсуй тэд хэмээв.

Тэндээс Таян хан өгүүлрүүн: "Энэ тийн бөгөөс тэд доромж [муусайнаас] хол байя" хэмээж бас хойшоо уул аврин байв. "Түүний араас айсуй уйссан шувуу мэт шилбэлзэж хошуурч яваа хэн буй?" хэмээн Таян хан Жамухаас асуужээ.

Жамуха өгүүлрүүн: "Энэ айсуй Тэмүжин анд минь
Хөвчин бие нь
Ширмээр ширэгдсэн
Шивээ хатгах
Чөлөө үгүй
Төмрөөр давтагсан
Тэвнэ хатгах
Чөлөө үгүй
Тэмүжин анд минь
Уйссан шувуу мэт
Шилбэлзэн айсуйг үзэв үү та?

Найман нөхөд [та нар] монголыг [үзвээс] ишигний год үл үлдээнэ [гэдэг] болой. [Одоо] та нар үзэгтүн" хэмээв. Энэ үгэнд Таян хан өгүүлрүүн: "Энэ амсар [дагаж] уул аврин байя" хэмээж уул авирч байжээ. Бас Таян хан Жамухаас асууруун: "Бас тэр хойноос айсуй зузаан хэн бэ?" хэмээн асуув. Жамуха өгүүлрүүн: "Өэлүн эх нэг хүүгээ хүний махаар тэжээж бөлгөө.

Гурван алд биет
Гунжин бод идэшт
Гурван давхар хуяг өмсөж
Гурван бух зүтгүүлж айсуй зэ.
Хоромсогот хүнийг хотлоор [нь] залгиваас
Хоолойд нь үл торюу
Хөвчин эрийг үмхвээс

Өл үл засаж[412]
Агуралваас
Ацат[413] сумаа дэлэж тавьбаас
Агулын алс бүхэн
Арав хорин хүнийг
Нэвтэлтэл[414] харваж
Хэрэлдэн [тэмцсэн][415] нөхрийг
Хээр хэтэс бүхнийг
Хаймуур сумаа[416] дэлж тавьбаас
Хэлхтэл нэвтэлтэл харваж
Ихэд дэлж харавбаас
Есөн зуун алд газар харавюу
Татуу дэлж харавбаас
Таван зуун алд газар харавюу.
Хүн хүнээс өөр
Гүрвэл мангас[417] [шиг] төрсөн
Зочи Хасар хэмээгдэх

тэр буй за" хэмээв. Тэндээс Таян хан өгүүлрүүн: "Энэ тийн бөгөөс уулын өндөр [өөд] тэмцье. Дээшээ авригтун!" хэмээж уул [өөд] аврин байв. Бас Таян хан Жамухаас асууруун: "Түүний хойноос айсуй хэн бэ?" хэмээжээ. Жамуха өгүүлрүүн: "Тэр Өэлүн эхийн бага хөвүүн **элгэмсэг Отчигин**[418] хэмээгдюү.

Эрт унтагч
Орой босогч [тэр]
Баргаас[419] үл хоцорюу
Байдлаас[420] үл хожидюу"

хэмээжээ. Таян хан өгүүлрүүн: "Тийн бөгөөс уулын оргил дээр гаръяа" хэмээв.

196. Жамуха, Таян ханд эдгээр үгс ийн өгүүлээд Найманаас хагацан булташ гарч Чингис хаанд хэл хүргэж илгээрүүн: "Андад өгүүл" хэмээн өгүүлж млгээрүүн:

"Таян хан
Үгэнд минь

Үхэдхийж
Өөдөө тэмцэн
Үргэж гарав.
Амаар алагдан
Аюуж (айж)
Агул авиран гарав.
Анд [минь] хатууж!

Тэд ууланд гарав. Эдэнд эсэргүүцэх царай үгүй буй. Би өөрөө Найманаас хагацав" хэмээн илгээжээ. Чингис хаан наран орой болгож, Наху хуны уулыг бүслэн байж хонов. Тэр шөнө Найман буруулан хөдлөх болохдоо Наху дээрээс гуласч дээр дээрээ **хутгалдан**[421] яс үсээ хэмх уналдаж **өмх хожуул**[422] болтол даралцаж үхэцгээв. Маргааш нь Таян ханыг мохоож авав. Хүчүлүг хан тусгаар байсаар цөөн хүнтэй дайжин хөдөлж гүйцэгдэхдээ Тамирт хүрээ байгуулж, тэр хүрээндээ байн ядаж, хөдлөн дутааж гарч одов. Найман иргэний улсыг Алтайн өлгийд мохоож хураав. Жамухатай цуг явсан Жадаран, Хатагин, Салжиуд, Дөрбэн, Тайчууд, Унгирад зэрэг тэнд [бас] оров. Таяны эх Гүрбэсүг Чингис хаан авчруулж өгүүлрүүн: "Чи монголын үнэр муухай гэдэг гэсэн билүү? Эдүгээ яахан ирэв чи?" хэмээж Чингис хаан авлаа.

197. Мөн хулгана жилийн (1204) намар Хар талын үгт Мэргидийн Тогтоа бэхтэй Чингис хаан байлдаж, Тогтоаг хөдөлгөж Саарь хээрт ард иргэн улсыг нь дагуулав. Тогтоа, Хуту, Чулуун хөвүүнтэйгээ цөөн хүнтэй амь зулбаж гарав. Төдий мэргид иргэн дагуулагдахад Увас мэргидийн Дайр Усун, Охин Хулан хатныг Чингис хаанд үзүүлье хэмээн авч ирэх зуур цэргүүдэд **хоригдож**[423] Бааридайн Наяа ноёнтой учирч Дайр Усун өгүүлрүүн: "Энэ охиноо Чингис хаанд үзүүлье хэмээн айсуй би" хэмээжээ. Тэнд Наяа ноён өгүүлрүүн: "Охиныг чинь бид хамт үзүүлье" хэмээн түр хүлээлгэв. Хүлээлгэхдэ Дайр Усуныг "Чи гацаар одвоос [зам] зуур цэргүүд самуун цагт чамайг **амар заяа үзүүлэхгүй**[424], охинтой чинь самуурна" хэмээж гурван өдөр, гурван шөнө хүлээлгэжээ. Тэндээс Хулан хатантай Дайр Усуныг аваад Наяа ноён хамт Чингис хаанд

хүрэв. Тэндээс Чингис хаан Наяаг "Яахан саатуулав чи?" хэмээн маш [ихэд] хилэгнэж "Хатуу **шаргаан асууж**[425] цааз болгоё" хэмээн байцаан бүхүйд Хулан хатан өгүүлрүүн: "Наяа өгүүллээ. Чингис хааны их ноён буюу би. Бид хамт [явж] охиныг чинь хаанд үзүүлье. [Зам] зуур цэргүүд самуурна хэмээн ятгалаа. Эдүгээ Наяагаас өөр цэргүүдтэй учирсан бол самуун **түүхийд**[426] орох [байсан] ажгуу. Хай энэ Наяатай учирсан минь сайн болов. Эдүгээ Наяагаас асууснаас хаан соёрхвоос тэнгэрийн заяагаар эцэг эхийн төрүүлсэн **махбодоос**[427] [минь] асууваас [ямар]" хэмээн өчжүхүй. Наяа асуугдан [өчсөн нь]:

"Хаанаас бусдад [би]
Нүүр тал үгүй буй за
Харь иргэний
Хацар гуа охин хатан
Харгам сайн агт учирваас
Хаандаа хэмээн аму би
Үүнээс өөр сэтгэл байваас
Үхье би" хэмээжүхэй.

Чингис хаан Хулан хатны өчлийг зөвшөөж мөн өдөртөө болгоон сорьж [үзвээс] Хулан хатны өчил зөв болж Чингис хаан Хулан хатныг соёрхож таалав. Наяагийн үг [мөн] үнэн болж зөвшөөж "үнэн үгт ажгуу" хэмээн "Их үйл [хэрэг] тушааж өгье" хэмээн соёрхов.



Наймдугаар бүлэг



198. Мэргид иргэнийг дагуулж Тогтоа бэхийн их хөвүүн Худугийн хатад Түгэй, Дөрэгэнэ хоёроос Дөрэгэнээг тэнд Өгэдэй хаанд өгөв. Мэргидийн зарим улс дайжиж **тайгад**[428] хороо хороолжухуй. Тэнд Чингис хаан зарлиг болруун: "Сорхон шарын хөвүүн Чимбай ноёлож зүүн гарын цэргүүдээр хороолуулсан мэргидийг довтолгон" илгээв. Тогтоа, Худу, Чулуун хөвүүдтэйгээ цөөн биесээр дайжиж гарсаныг Чингис хаан нэхэн Алтайн өвөрт өвөлжиж, үхэр жилийн (1205) хавар Арайгаар давж одвоос Найманы Хүчүлүг хан улсаа автуулж тэр дайжиж явсан цөөн хүмүүн Мэргидийн Тогтоа хоёул нийлж Эртисийн (Эрчис) Бухдурма [голын] угт хамтран цэргээ засаж байжээ. Чингис хаан хүрч [очиж] байлдваас Тогтоа тэнд **шивээн суманд**[429] оногдож унажээ. Хөвүүд нь ясыг нь барьж ядан биесийг нь авч явж завдал үгүй [зөвхөн толгойг нь огтлон авч явжээ. Тэнд найман, мэргид [хоёр нэг тал] болон хамтран байлдаж ядаж, буруулан хөдөлж Эртис гэтлэхдээ **цөмөрч унаж**[430] олонхоо усанд үхүүлжээ. Цөөн [амьд] гарсан Найман, Мэргид Эртис гэтлэн туулж хагацан хөдлөв.

Найманы Хүчүлүг хан Уйгурдай Харлугуудыг дайран Сарт уулын газар Чүй мөрөнд буй Хар Хятадын Гүр ханд нийлэн оджээ.

Мэргидийн Тогтоагийн хөвүүд Худу, Хал, Чулуун тэргүүтэн мэргид **Ханлин**[431], Химчагуудыг (Хипчаг) дайран явжээ. Тэндээс Чингис хаан эргэж Арайгаар давж аургтаа (ар гэртээ) [ирж] буув.

Чимбай тайгад хороо хороолсон мэргидийг мохоожээ. Тэнд мэргидийг Чингис хаан зарлиг болохдоо: "Хядахы нь хядуулж, үлдэгсэдийг нь цэргүүдэд талуулав. Бас урьд [дагаж] орсон мэргид ауругаас дайжиж босчээ. Аургт байсан бидний

хөтөч [нар] тэднийг даржээ. Тэнд Чингис хаан зарлиг болруун: "Бид цугаар нь байлгая хэмээлээ харин тэд дайжин [тэрслэх] ажгуу" хэмээн мэргидийг зүг зүг бутартал хуваалгав.

199. Мөн үхэр жил (1205) Чингис хаан зарлиг болж Сүбээдэйг **Төмөр тэрэгтэй**[432] Тогтоагийн Худу, Хал, Чулуун тэргүүтэн хөвүүдийг нь нэхүүлэн илгээжээ. Сүбээдэйд Чингис хаан зарлиг болж дуу бариулруун: "Тогтоагийн Худу, Хал, Чулуун тэргүүтэн хөвүүд нь:

Одон **ойлж**[433]
Харин **харвалцаж**[434]
Уургат хулан
Сумт буга болж одов
Тэднийг жигүүрт болж нисэж
Тэнгэрт гарваас
Сүбээдэй чи
Шонхор болж
Нисэж үл барих уу?
Тарвага болж
Хумсалж малтаж
Газарт орвоос
Царил[435] болж
Цохиж [авч] ирж
Үл гүйцэх үү Чи?
Загас болж [тэр]
Тэнгэс далайд орвоос
Сүбээдэй чи **өөш**[436], гувчуур болж
Шүүж гувчиж үл авах уу чи?
Бас
Өндөр даваа даван
Өргөн мөрөн гэтлэн
Илгээв чамайг

Газрын холыг бодож цэргийн улаа [морьдыг] тураагүйд нь хайрлагтүн! Хүнсээ дуусаагүйд нь **гамнагтүн!**[437] Агт [нэгэнт] турж

дуусваас хайрлаад [ашиг] үл болно. Хүнсээ баран дуусгаваас гамнаж үл болно. Мөрт чинь [ан] гөрөөс олон буй за. Алсыг бодож явахуйд цэргийн хүмүүнийг гөрөөс бүү **хөөлгөгтүн!**[438] Хэмгүй (ихээр) бүү авлагтүн! Цэргийн хүний хүнсэнд нэмэрлэж өгөх болтугай хэмээн авлабаас **хэмнэж**[439] авлагтүн! Хэмжээт аваас ангид, цэргийн хүний эмээлийн худрага бүү худрагалуул! **Хазаар**[440] үл нөмөргөн **амгайвчлаж**[441] явтугай! Тийн журамлаж явбаас цэргийн хүмүүн уулгалан [давхиж] хэрхэн чадна? Ийн цаазлах бөгөөд цааз давагсадыг барьж **балбатугай**[442]. Бидний зарлиг давагсадыг бидний танил мэт хүмүүсийг бидэнд өгч илгээгтүн! Бидний үл таних олныг мөн тэндээ [мэдэж] мөхөөгтүн!

Мөрний чанад
Морилогч[443] та нар
Мөн ёсоор явагтүн!
Уулсын чанад
Алслагч та нар
Ангид өөрийг бүү сэтгэгтүн!

Мөнх тэнгэрт хүч аугаа нэмэгдэж Тогтоагийн хөвүүдийг гартаа оруулбаас бидэнд авчрах [хэрэг] юун буй. Тэндээ та нар гээгтүн!" хэмээн зарлиг болов. Сүбээдэйд бас Чингис хаан өгүүлрүүн: "Чамайг явуулахдаа би өчүүхэн цагт [минь] гурван мэргидийн Удуйдад Бурхан Халдунд гурвантаа бүслүүлж айлгууллаа би. Тийм өштөн иргэн эдүгээ бас ам хэл гарч одов.

Уртын үзүүр

Гүний ёроол хүртүгэй хэмээн нэхүүлэн, **мухарлуулахаар**[444] төмөр тэрэг дэлдэж (хөдөлгөж) үхэр жил [цэрэглэж] **мордуулав**[445]. Биднийг далд бөгөөс ил мэт, хол бөгөөс ойр мэт санаж явбаас дээд тэнгэрт ивээгдмүй зэ та нар" хэмээн зарлиг болов.

200. Найман мэргидийг мохоон дуусгаваас Жамуха наймантай байж тэнд улсаа автахад мөн таван хүнтэй оорцог болж **Танлу (Тагна)**[446] дээр гарч угалз алж шарж идэхэд тэнд Жамуха нөхөддөө өгүүлжээ. "Хэний хөвүүд энэ өдөр угалз алж ингэж иднэ?"

хэмээв. Тэр угалзын мах идэж байх зуур таван нөхөд нь Жамухыг гардаж барьж Чингис хаанд авчирч өгөв. Жамуха нөхөддөө баригдаж ирээд:

“Хаан андад өгүүл
Хар хэрээ
Харалдай[447] нугас барих болов.
Харц боол
Хан [эзэндээ]
Гар хүрэх болов.
Хаан анд минь юу эндэх
Бор **хулд**[448]
Боорончин соно[449] барих болов.
Боол **зарц**[450]
Бодон[451] эзнээ
Босож гэндүүлж барих болов.
Богд анд минь юу эндэх

хэмээн өгүүлбээс Жамухагийн тэр үгэнд Чингис хаан зарлиг болруун: “Тус хан [эзэндээ] гар хүрсэн хүнийг хэрхэн **байлгана?**[452] Тийм хүн хэнтэй нөхөрлөнө? Тус хан [эзэндээ] гар хүрсэн ардыг ураг [төрлий] нь хүртэл мөхөөгтүн!” хэмээн зарлиг болов. Мөн Жамухагийн өмнө түүнийг гардаж барьсан хүнийг мөхөөж өгөв.

Чингис хаан “Жамухад өгүүл” хэмээн өгүүлрүүн: “Эдүгээ бид хоёр хамтдаа нөхөрлөе.

Өрөөсөн арал бололцож байхад
Өвөрмөц нэгийг санаму чи
Эдүгээ нэгэнт хамт ажгуу
Умартсанаа сэргээлцэж байя
Өөрөөр ангид явсан ч
Өлзий хутагт анд минь бөлгөө.
Үнэн үхэлдэн [тэмцэхүй] өдөр
Өр зүрхээ өвтгөх бөлгөө чи
Ангид өөрөөр явавч
Алалдан [тэмцэхүй] өдөр

Агушиг зүрхээ өвтгөх бөлгөө чи
Хэзээ [хэрхсэнийг] хэлбэл
Хэрэйд иргэнтэй
Хар халзан элстэд
Хатгалдахуйд
Ван хан эцэгт өгүүлсэн
Үгсээрээ сэргийлж
Илгээсэн тус чинь буй за.
Бас Найман иргэнийг
Үгээр үхүүлж
Амаар алж
Айлгаснаа адилтгатугай

хэмээж хэл илгээсэн чинь тус болов” хэмээн

201. өгүүлбээс Жамуха өгүүлрүүн: “Эрт өдөр өчүүхэн [бага] цагт Хорхонаг Жубурт хан андтайгаа анд бололцоход

Үл шингэх
Идээг идэлцэж
Үл мартах
Үгс өгүүлэлдэж
Хөнжлөө [хамт]
Хагаслан[453] [нөмөрч]
Хонож байлаа[454]
Хөндлөнгийн [хүнд]
Хөгжөөгдөж
Хажуугийн [хүнд]
Хатгагдаж
Хагацан салж
Халтай үгс
Өгүүлэлдлээ хэмээн
Хар нүүрээ
Хуулагдахаас
Хавьтан[455] ядаж
Хан андынхаа

Халуун царайг
Харан ядаж явав аа би
Үл мартах үгс
Өгүүлэлдлээ хэмээн
Улаан нүүрээ
Өвчигдөхөөс
Уужим сэтгэлт андынхаа
Үнэн царайг
Үзэн ядаж явав аа би

Эдүгээ хан анд минь соёрхож нөхөрлөе хэмээжээ. Нөхөрлөх цагт би эс нөхөрлөв. Эдүгээ анд

Төгрөг улсыг
Төвшитгөв.
Харь тутмыг
Хамтатгав чи
Хан ор
Чамд зорив.

Дэлхий эдүгээ бэлэн болсон [хойно] би нөхөрлөж ямар тус болно. Мөн андын

Харанхуй шөнө
Зүүдэнд чинь орно би
Гэгээн өдөр
Сэтгэлийг чинь зовооно би
Захын чинь бөөс
Заамны[456] чинь өргөс болно би
Арвин [их] **гэмтэй**[457] бөлгөө би
Андаас алсыг (өөрийг) сэтгэх болон
Алдас болов оо би

Эдүгээ энэ төрөлхийд анд бид хоёр ургах нарнаас шингэх наран дор хүртэл нэр минь хүрэв ээ. Анд сэцэн эхтэй, төрөлхий **зориг баатарлаг**[458] төржээ. Эрдэмтэн дүү нар, өрлөг нөхдөөрөө, далан гурван агтаас [нь] болж андад **ялагдваа**[459]. Би бол:

Эх эцгээс

Өчүүхэн хоцорч
Дүү нар ч үгүй
Эхнэр минь **чалчаа**[460]
Итгэл үгүй нөхөдтэй
Тэгүүнээс [болж]
Тэнгэрээс заяат андад ялагдваа.

Анд соёрхвоос намайг үтэр [нас] нөгчөөвөөс анд чи зүрхээ амруулмуу. Анд соёрхон алуулахдаа цус үл гарган алуул!

Үхэж хэвтвээс
Үхдэл[461] яс минь
Өндөр этүгэнд [газарт]
Үүрд **мөнхжиж**[462]
Ургийн ураг чинь хүртэл
Ивээж өгье [гэж]
Ерөөл болгоё би
Уг өөр төрөлхийт бөлгөө би
Үлэмж төрөлхийт андын
[Сүр] сүлдэнд дарагдав аа би
Өгүүлсэн үгсийг минь
Үл умартан
Өглөө үдэш дурсаж
Өгүүлэлдэгтүн та нар
Эдүгээ намайг үтрэлтүгэй"

хэмээн өгүүлбээс эдгээр үгст нь Чингис хаан өгүүлрүүн:

"Анд минь
Ангид явж бидэнд
Ам дүүрж хэлж [байвч]
Аминд хорлон санах нь
Эс сонсдов оо зэ

Сурах хүмүүн бөлгөө. Мөн [сургаалаар] үл болмой. Үхүүлье хэмээвээс [үзэл] **төлөгт**[463] үл ормой. Шалтгаан үгүй аминд хор хийвээс үл зохино. **Хүнд мөртэй** [464] хүмүүн буй. Энэ магад шалтгааныг нь [олж] үхүүлэгтүн. Эрт Чожи Дармала, Тайчар

хоёрын адуугаа дээрэмдэлцсэний тул Жамуха анд чи бурангуй санаа **өвөрлөж**[465] ирж Далан Балжудад хатгалдаж Жэрэнэ хавцгайд хоргоож намайг тэнд эс айлгалуу чи? Эдүгээ нөхөрлөе гэвээс үл болж, амий чинь хайрлавч эс болов чи хэмээн өгүүлэгтүн. Эдүгээ чиний үгээр цус үл гарган нөгчөөтүгэй хэмээн өгүүл!" гээд "цус үл гарган нөгцөөж ясыг нь ил бүү хаягтун! Сайтар оршуулагтун!" хэмээн зарлиг болов. Жамухыг тэнд нөгчөөж ясыг нь оршуулав.

202. Төдий эсгий туургат улсыг шулуутгаж (нэгтгэж) барс жил (1206) Ононы эхэнд хурж **есөн хөлт цагаан туг**[467] байгуулаад Чингис хаанд **хаан**[468] цол тэнд өгөв. Мухалид улсын **ван**[469] цол тэнд [бас] өгөв. Зэбийг Найманы Хүчүлүг ханыг нэхүүлэж тэнд [цэрэглэн] мордуулав.

Монголжин улсыг түвшитгэн барж Чингис хаан зарлиг болруун: "Улс байгуулалцан явалцагсдад мянган мянгалж мянгатын ноёд тушааж соёрхон үг өгүүлье" хэмээн зарлиг болов. Мянгатын ноёдыг тушаан нэрийдэхэд: Мунлиг эцэг, Боорчу, Мухули улсын ван, Хорчи, Илүгэй, Жүрчэдэй, Гунан, Хубилай, Зэлмэ, Түгэ, Дэгэй, Толун, Өнгүр, Чүлгэтэй, Борохул, Шигихутуг, Гүчү, Хөхөчү, Хоргосун, Үсүн, Хуйлдар, Шилүгэй, Жэтэй, Тагай, Цагаан гуа, Алаг, Сорхон шар, Булуган, Харачар, Хөхөчөс, Сүйхэтү, Наяа, Жүншөй, Хүчүгүр, Бала, Оронартай, Дайр, Мүгэ, Бужир, Мүнгүүр, Долоодай, Бөгэн, Худус, Марал, Жибгэ, Юрухан, Хөхө, Жэбэ, Удутай, Бала чэрби, Хэтэ, Сүбээдэй, Мөнх, Халжа, Хурчахус, Гэүги, Бадай, Хишилиг, Хэтэй, Чаурхай, Онгиран, Тогоон Төмөр, Мэгэту, Хадаан, Мороха, Дори-Буха, Идүгадай, Ширахуи, Даун, Тамачи, Хауран, Алчи, Тобсаха, Тунхуйдай, Тобуха, Ажинай, Түйдэгэр, Сэчүүр, Жэдэр, **Олар хүргэн**[470], Хингиадай, Буха хүргэн, Хорил, Ашиг хүргэн, Хадай хүргэн, Чигү хүргэн, Алчи хүргэн, гурван мянган Хонгирад Буту хүргэн, хоёр мянгат Ихэрэс, Онгудын Алахуш Дигид Хури хүргэн, таван мянгат Онгуд ойн иргэнээс ангид монгол улсын мянгатын ноёдыг Чингис хааны нэрийдсэн ерэн таван [хүн] мянгатын ноёд болов.

203. Хүргэдэд нэгэнтээ бас Чингис хаан зарлиг болруун:

Эдгээр нэрийдсэн ерэн таван мянгатын ноёдыг мянганаа тушаал болгоход тэр дотор Чингис хаан [бас] зарлиг болруун: "Тусгайд нь соёрхол өгье" хэмээн Боорчу, Мухули тэргүүтэн ноёдыг иртүгэй хэмээхүйд гэрт Шигихутуг [байсан] бөлгөө. "Урихаар яв" хэмээн Шигихутугт өгүүлбээс Шигихутуг өгүүлрүүн: "Боорчу, Мухулитан хэнээс илүү тус хийлээ? Хэнээс илүү хүч өглөө? Соёрхол өгөхүйд би юун дутуу тус эс боллоо? Юун дутуу хүч эс өглөө би?

Өлгийтэй бүхүйгээс
Өндөр босгонд чинь
Эрүүндээ сахал
Өдий ургатал өсч
Өөрийг эс сэтгэв би
Аландаа **шээгтэйгээс**[471]
Алтан босгонд чинь байж
Амандаа сахал
Өдий ургатал өсч
Андуу[472] эс **гишгэвээ**[473] би
Хөлдөө хэвтүүлж
Хүүчлэн өсгөв өө намайг
Дэргэдээ хэвтүүлж
Дүүчлэн өсгөвөө намайг

Эдүгээ надад ямар соёрхол өгнө?" хэмээжээ. Тэр үгэнд Чингис хаан Шигихутугт өгүүлрүүн: "Зургадугаар дүү [минь] бус уу чи? **Отгон**[474] дүү чамдаа соёрхол дүү нарын хувиар хувилна. Бас олон тусын чинь тулд есөн эндэгэлд бүү эндүүлтүгэй" хэмээн зарлиг болов.

"Мөнх тэнгэрт ивээгдэж гүр улсыг зүглүүлж бүхүй дор чи
Үзэх нүд
Сонсох чих болж
Гүр улсын эхэд, бидний дүү нар, хөвүүдэд иргэний нэрээр хувь [хүртээж]
Эсгий туургатныг
Салгуулж[475]
Хавтсан үүдтэнийг

Хагацуулж
Хувилж өг

Хэн ч чиний үгийг бүү буруу болготугай" хэмээн зарлиг болов. Бас Шигихутугийг

"Гүр улсын
Хулгайг гэсгээж
Худлыг мохоож
Үхүүлэх ёстойг
Үхүүл
Алуулах[476] ёстойг
Алуул" хэмээн гүр [улсын] дээд заргачаар (шүүгч) тушаав.

Бас "Гүр иргэний хувь хувилсаныг зарга шүүсэнийг хөх дэвтэрт бичиг бичиж дэвтэрлэж, ургийн ураг хүртэл Шигихутугийн надтай зөвлөж ёсоор [болгон] хөх бичиг цагаан цаасанд дэвтэрлэснийг бүү өөрчилтүгэй. Өөрчилсөн хүнийг яллах болтугай" хэмээн зарлиг болов. Шигихутуг өгүүлрүүн: "Миний мэт отгон дүү эн сацуу хувь хэрхэн авна. Соёрховоос шороон **туургат**[477] балгаснаас өгөхийг хааны соёрхол мэдтүгэй!" хэмээн өчжээ. Энэ үгэнд "Өөрийн биеэ чи **цаглав**[478]. Чи мэд" хэмээв. Шигихутуг өөрийгөө тийн соёрхуулан, гарч Боорчу, Мухулитан ноёдыг урьж оруулжээ.

204. Тэнд Чингис хаан зарлиг болж Мунлиг эцэгт өгүүлрүүн:

"Төрөхөд төрөлцсөн
Өсөхөд өсөлцсөн
Өлзий хутагт чиний
Тус ивээл чинь
Хичнээн [их] ажгуу жэ.

Тэр дунд Ван хан эцэг, Сэнгүм анд хоёр намайг аргадан урьсанд явах зууpаа Мунлиг эцгийн гэрт хоновоос Мунлиг эцэг чи эс ятгасан бөгөөс

Ойлон бүхий усанд

Улалзан[479] бүхии галд
Оруулах бөлгөө [тэд]

Тэр тусыг одоо санаж ургийн ураг хүртэл хэрхэн мартна? Тэр тусыг санаж эдүгээ энэ суурийн **эхэн талд**[480] суулгаж, он сар [бүрийд] саатаж өглөг соёрхол чамд өгч, ургийн ураг хүртэл мялаан атугай" хэмээн зарлиг болов.

205. Бас Чингис хаан Боорчуд өгүүлрүүн: "Өчүүхэн цагт шарга агттан найман морьд дээрэмдүүлж [зам] зуур гурав хонож нэхэж явахад [минь] золгов жэ чи. Тэнд [чи] өгүүлэхдээ "**Мэгдэж**[481] яваа нөхөрт нөхөрлөе" хэмээн гэртээ эцэгтээ хэл өгөлгүй **гүүгээ саангуут**[482] намбуха суулгаа хээр бүрхэж миний огтор хонгорыг тавиулж надад орог шунхлыг (буган хээр) унуулж, чи өөрөө хурдан хубийг унаж адуугаа эзэнгүй тавьж яарч хээр надтай нөхөрлөж, бас гурван хоног нэхэж шарга агттаныг дээрэмдсэн хүрээнд хүрвээс хүрээний захад байсныг дайран хөөж дутаан авч ирэв ээ бид хоёр. Эцэг чинь Наху баян ажгуу. Чи ганц хөвүүн нь юу мэдэж надтай нөхөрлөх болов? Сэтгэлийн хүлгээр нөхөрлөв зэ чи. Түүний хойно санаж явсаар би Бэлгүдэйг илгээн нөхөрлөе гэвээс чи

Бөгтөр хонгорыг унаж
Бор өрмөгөө бөгтөрч

нөхөрлөн ирвээс гурван мэргид бидэн рүү ирж Бурхан [Халдун]-ыг гурвантаа бүслүүлэхэд [хамт] бүслэгдэв ээ чи. Бас түүний хойно татаар иргэнтэй Далан нөмөргөст сөргөлцөж хоноводс бороо өдөр шөнө үргэлжлэн зүсрэхэд шөнө намайг нойрсуулъя хэмээн нөмрөгөө нөмөрсөөр миний дээрээс бороо үл гоожуулан шөнө турш байхдаа өрөөсөн хөлөө ганцхан [удаа] сольж билээ чи. Зориг [сэтгэлийн] чинь бэлэг ажгуу жэ. Түүнээс бусад аль зориг [сэтгэлийг] чинь өгүүлж дуусна.

Боорчу, Мухули хоёр зөв явдлыг минь **зүтгүүлж**[483], бурууг минь больтол ятгаж энэ оронд хүргэв. Эдүгээ бүхий дээр сууринд сууж есөн эндэгдэлд бүү эндүүлтүгэй. Боорчу баруун гарын Алтай **дэрлэн**[484] [нутаглах] түмнийг мэдтүгэй" хэмээн зарлиг болов.

206. Бас Мухулид Чингис хаан өгүүлрүүн: "Бид Хорхонаг

Жубурын Хутула ханы дэвсэх сагалгар модонд бууваас Мухулид тэнгэрийн заарин заасан үг тэмдгийн тул, би тэнд [чиний эцэг] Хүмүн гуаг санаж чамд үг хэлэлцлээ. Түүгээр суурь дээр сууж Мухулийн ургийн ураг хүртэл гүр иргэний улсын ван болтугай" хэмээн улсын ван нэр (цол) олгов. "Улсын ван Мухули зүүн гарын **Хараун Жидүнийг**[485] дэрлэн [нутаглах] түмнийг мэдтүгэй" хэмээн зарлиг болов.

207. Чингис хаан Хорчид өгүүлрүүн:

Өчүүхэн бүхүйгээс
Намайг зөгнөж
Өдий өнөд[486]
Нойтонд **норолцож**[487]
Хүйтэнд **хөрөлцөж**[488]
ариун хутаг[489] болж явав аа жэ чи.

Хорчи тэр цагт өгүүлрүүн: "Зөн зөв болбоос, тэнгэрт [таалагдаж] санаанд хүрвээс намайг гучин эхнэртэй болго хэмээлээ чи. Эдүгээ зөв [болсон] тул соёрхож эдгээр [дагаж] орсон иргэний сайн эмс, охидыг үзэж гучин эхнэр сонсож ав" хэмээн зарлиг болов. Бас "Хорчи гурван мянган Баарины дээр Тагай, Ашиг хоёртой адархины чинос, төөлөс тэлэнгүүдийг нэмэж түм дүүргэж [түүнийг] Хорчи мэдэж Эртис [мөрний зам] гудас ойн иргэнд хүртэл нутаг дархлан нутаглуулж, ойн иргэнийг даргалан Хорчи түмэнг мэдтүгэй" хэмээн зарлиг болов. "Хорчийн зөвшөөр үгүй ойн иргэн ийн тийн бүү явтугай! Зөвшөөр үгүй явахыг юунд сааруулна!" хэмээн зарлиг болов.

208. Бас Чингис хаан Жүрчидэйд өгүүлрүүн: "Эрхэм тус чинь Хэрэйдтэй Хар халзан элстэд хатгалдахуйд зүдэрч бүхүй дор Хуйлдар анд ам алдан [андгайлсан ч чухам] үйлий нь Жүрчидэй чи үйлдэв жэ. Үйлдэхдээ Жүрчидэй чи довтлон [орж] Жиргинийг, Түбэгэнийг, Донхайдыг, Хори шилэмүнийг, мянган турагуудыг, эрхт цэргүүдийг бүгдийг дарж, их гол [хүчинд] хүрч Сэнгүмийн энгэсэг хацрыг нисгэгч сумаар харавсаны тул мөнх тэнгэрт үүдэн жолоо нээгдэв ээ. Сэнгүмийг эс шархтуулсан бөгөөс бид магад ямар

болох бөлгөө? Жүрчидэйн эрхэм их тус тэр болов. Түүнийг салж Халх (гол) уруу нүүхэд Жүрчидэйг өндөр уулын нөмөр мэт санаж явах бөлгөө би. Тэр одож Балжун нуурт [малаа] услахаар хүрэв. Жич Балжун нууруас морилуулж Жүрчидэйг Хэрэйдэд магнайчлан мордуулж тэнгэр газар хүч нэмэгдэж Хэрэйд иргэнийг мохоож дагуулав.

Эрхт улс **цохигдож**[490] найман, мэргид царай алдан, байлдаж ядан бусницгаав. Мэргид, Найманыг бусних хооронд Хэрэйдийн Жаха Гамбу хоёр охидоороо шалтаглаж өөрийн харьяат улсаа цөмийг [эзэмшиж] байсан ажгуу. [Тэр] дахин дайсан болон хагацсаныг Жүрчидэй арга сэдэж Жаха Гамбу хагацан салсныг гардаж барьж [хэрэг] бүтээв. Тэр Жаха Гамбугийн улсыг дахин үлдэн талав. Жүрчидэйн нөгөө тус нь энэ буй жэ"

Алалдахуй өдөр
Амиа өргөсний тул
Үхэлдэхүй өдөр
Өрсөлдөгсний[491] тул

Чингис хаан Ибаха бэхийг Жүрчидэйд соёрхон өгөхдөө Ибахад өгүүлрүүн:


"Чамайг
Уудам цээжий[492] чинь голоогүй
Үзэсгэлэн тал муу эс хэмээв би
Өвөр түрийд орсон
Зэрэгтээ
Зэрэглэн буулгасан чамайг
Жүрчидэйд соёрхохдоо
Их төрийг санаж
Жүрчэдэйн
Хатгалдах өдөр
Халх болсныг
Дайсан хүмүүнд
Далдлагч болсныг


Хагацсан улсыг
Хамтатгасны
Бутарсан улсыг
Бүрэн болгосны

тусынх нь төрийн [үйлийг] санаж чамайг өгөв. Мөнөө хойно миний ураг бидний ор сууж, энэ мэт тус хийсэн төр [үйлийг] санаж, миний үгийг үл хувирган ургийн ураг хүртэл Ибахагийн ор бүү тасалтугай" хэмээн зарлиг болов. Бас Чингис хаан Ибахад өгүүлрүүн: "Жаха Гамбу эцэг чинь чамд хоёр зуун инж [бас] чамд Ашиг төмөр буурч, Алчиг буурч хоёрыг өгч бөлгөө. Эдүгээ Урууд иргэнд чи одоходоо гэрийнхээ инжнээс надад Ашиг төмөр буурчаа нэг зуун [хүнтэй] өгч яв" хэмээж авав. Бас Чингис хаан Жүрчидэйд өгүүлрүүн: "Ибахагаа чамд өгөв. Дөрвөн мянган Урууда чи мэдэж үл байх [буюу] чи" хэмээн соёрхож зарлиг болов.



Есдүгээр бүлэг





209. Бас Чингис хаан Хубилайд өгүүлрүүн:

“Хүчтийн хүзүү
Бөхийн бөгс
Дарж өгөв өө чи

Эд Хубилай, Зэлмэ, Зэбэ, Сүбээдэй та дөрвөн **нохдоо**[493] санасандаа зориулж илгээвээс

Хүр хэмээгсэнд
Гүр [чулуу] хэмхлэн
Халд хэмээгсэнд
Хад хагалан
Цэгээн чулуу цуулан
Цээлийн усыг **таслан**[494]

авай жэ та нар. Хубилай, Зэлмэ, Зэбэ, Сүбээдэй та дөрвөн нохдоо зорьсон газраа илгээж Боорчу, Мухули, Борохул, Чулуун баатар эд дөрвөн хүлгүүдээ дэргэдээ авъяа. Хатгалдах өдөр болбоос Жүрчидэй, Хуйлдар хоёрыг Урууд, Мангуудтайгаа урдаа байгуулбаас сэтгэлээ бүрэн амруулах бөлгөө би” хэмээв. “Хубилай чи цэргийн үйл бүхнийг ахлаж үл байх [буюу]?” хэмээн соёрхож зарлиг болов. Бас “Бэдүүн **өжүүн**[495] [зантай] тул би муучлан явж мянган эс өгөв. Чи түүнтэй эвсэг буй за. Чамтай мянгалж эелдэн явтугай” хэмээв. Бас “Мөнөө хойно Бэдүүнийг санаж [явъяа] бид” хэмээв.

210. Бас Чингис хаан Гэнигэтэйн Гунанд өгүүлрүүн: “Та нар Боорчу, Мухули тэргүүтэн ноёдод Додай Дохолхутан чэрбинуудад энэ Гунан

Хар шөнө

Цэгээн[496] чоно
Гэгээн өдөр
Хар хэрээ болж
Нүүхэд эс өнжсөн
Өнжихөд эс нүүсэн
Бусар[497] хүмүүнтэй
Буруу нүүр эс **гаргасан**[498]
Өшөөт хүмүүнтэй
Өөр нүүр эс гаргасан

Гунан, Хөхөчос хоёроос зөвшил үгүй бүү үйлдэгтүн! Гунан, Хөхөчос хоёртой зөвлөж үйлдэгтүн!” хэмээн зарлиг болов.

“Хөвүүдийн минь ах Зөчи буй за. Гэнигэтэйн Гунан тэргүүлж Зөчийн доор түмний ноён болтугай” хэмээн зарлиг болов. “Гунан, Хөхөчос, Дэгэй, Үсүн өвгөн эд дөрөв

Үзсэнээ
Үл нуун
Сонссоноо
Үл хавчих бөлгөө.
Эд дөрөв [итгэлтэй] буй за”.

211. Бас Чингис хаан Зэлмэд өгүүлрүүн: “Жарчиудай өвгөн хөөргөө (төмрийн) үүрч Зэлмэ [чамайг] өлгийтэй [байхад] Бурхан Халдунаас бууж ирэхдээ Ононы Дэлүүн болдогт намайг төрөхөд булган хөнжил өгч билээ. Тэр нөхөрлөсөөр

Босгын боол
Үүдний өмч болов оо

Зэлмэгийн тус нь олон буй за.

Төрөхөд [минь] төрөлцсөн
Өсөхөд [минь] өсөлцсөн
Булган хөнжил язгуурт
Өлзий хутагт Зэлмэ
Есөн эндэл эндэхэд
Яланд[499] бүү ортугай”

хэмээн зарлиг болов.

212. Бас Чингис хаан Толунд өгүүлрүүн: "Эцэг хөвүүн [хоёр] өөр [өөр] мянганыг хэрхэн мэдэх бөлгөө? Чи улс хураалцан эцгийнхээ өрөөсөн жигүүр болон зүтгэж улс хураалцсан тул чэрби нэр (цол) өгөв өө. Эдүгээ өөрийн олсон, зөөснөөрөө өөрийн мянга болгож Турухантай зөвлөлдөж үл байх [буюу] чи" хэмээн зарлиг болов.

213. Бас Чингис хаан Өнгүр буурчид өгүүлрүүн: "Гурван Тогурууд таван Таргуд, Мөнгөт хианы хөвүүн чи Өнгүр, Чаншууд, Баягуудтай та нар надад нэгэн хүрээ болж [ирж] Өнгүр чи

Буданд эс төөрөв өө чи
Будлианд эс хагацав аа чи
Нойтон новшилдож
Хүйтэн гөвшилдөж явав аа чи

Эдүгээ ямар соёрхол авна чи?" хэмээвээс Өнгүр өгүүлрүүн: "Соёрхол сонгуулбаас Баягууд ах дүү минь харь харь тутамд **бутран тарсан**[500] буй. Соёрховоос баягууд ах дүүгээ цуглуулсугай" хэмээвээс "За тэг! Баягууд ах дүүгээ цуглуулж чи мянганыг мэд!" хэмээн зарлиг болов.

Бас Чингис хаан зарлиг болруун: "Өнгүр, Борохул хоёр баруун, зүүн этгээдэд та хоёр буурч идээ түгээхдээ:

Баруун этгээд
Байсан, сууснаа
Үл дутаалган
Зүүн этгээд
Зэрэглэсэн **эссэнээ**[501]
Үл дутаалган

Та хоёрыг тийн түгээвээс миний хоолой үл **зангиран**[502] , сэтгэл амарюу. Эдүгээ Өнгүр, Борохул хоёр морилон явж идээ [бэлтгэн] олон түмнээ өгөгтүн" хэмээн зарлиг болов. "Суурь суурийн их сөнгийн баруун зүүн этгээдэд идээ **базаалгаж**[503] суугтун! Толунтантай төвлөн (голлон) суутугай" хэмээн суурь зааж өгөв.

214. Бас Чингис хаан Борохулд өгүүлрүүн: "Эх минь Шигихутуг, Борохул, Гүчү, Хөхөчү та дөрвийг

Хүний нутгаас
Хөсрөөс олж
Хөлдөө дүрж
(Хөнжилдөө хучиж)
Хүүчлэн асарч тэжээхдээ
Хүзүүнээс чинь татаж
Хүмүүний зэрэгт хүргэж
Эгэмнээс чинь татаж
Эрийн зэрэгт хүргэж

Хөвүүд маныхаа нөхөр сүүдэр болгоё хэмээн тэжээв ээ та нарыг. Тэжээлэгсэн ачаа эхэд минь магад хэдүй ач тус хариулав та нар? Борохул надтай нөхөрлөж

Хурдан аянд
Хуртай шөнө
Хоосон эс хонуулав аа чи
Бас
Өтгөс эцгийг барагсад
Өштөн хясалтан
Татаар иргэнийг
Доройтуулан [дарж]
Өшил өшин
Хясал хясан

Татаар иргэнийг Цүүнд үлэж (чацуулж) үлдэн хядахуйд татаарын Харгил шар алагдах [болоход] оорцог болон гарч, жич өлсөж, ядарч [явахдаа] эхийн гэрт орж ирж **Би сайн [тус] эрсэн буюу**[504] " хэмээжээ. "Сайныг эрсэн бөгөөс тэнд суу" хэмээж баруун орны үүдэн [талын] үзүүрт сууж бүхүйд таван настай Толуй гаднаас орж ирж, эргэж гүйж гарахаар явж байхад [нь] Харгил шар босоод хөвүүнийг сугандаа хавчиж гарч одож явахдаа хутгаа тэмтэрч сугалан явахад Борохулын гэргий Алтани эхийн гэрт зүүнтээ сууж [байсан] бөлгөө. Эх хашгирч "Хөвүүн аллаа!" хэмээхтэй [зэрэг] Алтани дагалдан гүйж гарч Харгил шарын хойноос гүйцэж [нэг гараар] шивэргэлээс (гээгэг) нь барьж нөгөө гараараа хутгаа сугалж

байгаа гары нь барьж [угз] татахын хамт хутгаа алджээ.

Гэрийн ард Жэтэй, Зэлмэ хоёр мугалзар хар үхрийг **мэслэн алж**[505] байхад Алтанийн дуугаар Жэтэй, Зэлмэ хоёр улаан [гартай] гүйж ирж татаарын Харгил шарыг сүхээр [цохиж] хутгаар [бүлж] мөн тэнд [нь] алжээ. Алтани, Жэтэй, Зэлмэ гурав хөвүүний амь аварсан **гавъяаг**[506] булаалдахад Жэтэй, Зэлмэ хоёр өгүүлрүүн: "Маныг үгүй бөгөөс хурдан гүйж очиж эс алсан бол Алтани эмэгтэй хүн яах билээ? Хөвүүний аминд хор хүргэх бөлгөө. Гавъяа биднийх буй за" хэмээв. Алтани өгүүлрүүн: "Миний дуу эс сонссон бол та нар хэрхэн ирэх бөлгөө? Намайг гүйж гүйцэж [ирж] шивэргэлээс нь барьж хутга сугалсан гары нь татаж хутгы [нь] эс алдуулсан бөгөөс Жэтэй, Зэлмэ хоёрыг хүрч иртэл хөвүүний аминд хор үл хүргэнэ гэж үү?" хэмээв. Өгүүлэн барваас гавъяа Алтанийх болов. Борохулын гэргий [Алтани] Борохулд өрөөсөн арал болон Толуйд аминд тус хүргэв. Бас Борохул Хэрэйдтэй Хар халзан элстэд хатгалдахуйд Өгөдэйн сужаа [махаар нь] сум тусч [мориноос] унахад Борохул дээр [нь] бууж бөглөрсөн цусы нь амаараа шимж шөнө [цуг] хонож, маргааш [нь] морь унуулж, сууж [явж] ядахад, сундалж Өгөдэйн араас тэвэрч бөглөрсөн цусыг шимэн шимэн амныхаа завьжийг улайлгаж Өгөдэйн амийг эсэн [мэнд] хүргэж ирж билээ. Эхийн минь тэжээж зовсон ач, хоёр хөвүүдий минь аминд тус болов оо. Борохул надтай нөхөрлөж

Дарвиан урианаас
Дуун дэмээс[507] эс хожимдов оо.

Борохул есөн эндэл эндвээс бүү эндүүлтүгэй хэмээн зарлиг болов.

215. Бас "охин ургийн соёрхол өгье" хэмээв.

216. Бас Чингис хаан Үсүн өвгөнд өгүүлрүүн: "Үсүн, Гунан, Хөхөчос , Дэгэй эд дөрөв

Үзсэн сонссоноо
Үл нууж хавчин
[Өгүүлж] зааж байх болой
Ухсан санаснаа
[Уламжлан] хэлж байх болой

Монголын төр ноён
Мөр бэхи[508] болохуй ёсон ажгуу
Баарин ахын ураг болой.
Бэхи мөр бидний дотроос
Бэхи Үсүн өвгөн болтугай!

Бэхи өргөөд цагаан дээл өмсөж цагаан морь унуулж суурь дээр суулган тахиж бас он сар тийн саатан атугай" хэмээн зарлиг болов.

217. Бас Чингис хаан өгүүлрүүн: "Хуйлдар анд хатгалдаанд амь өрж, урьд ам нээсний тусын тул ургийн ураг хүртэл өнчдийн авлага аван атугай" хэмээн зарлиг болов.

218. Бас Чингис хаан Цагаан гуагийн хөвүүн Нарин Тоорилд өгүүлрүүн: "Чиний эцэг Цагаан гуа миний өмнө хичээж хатгалдах болоход Далан Балжудад хатгалдахуйд Жамухад алагдлаа. Эдүгээ Тоорил эцгийнхээ тусад өнчдийн авлага автугай" хэмээхэд Тоорил өгүүлрүүн: "Соёрхвоос Нэгүс ах дүү [нар] минь харь тутамд бутран тарсан буй. Нэгүс ах дүү юүгээ цуглуулсугай" хэмээвээс Чингис хаан зарлиг болруун: "Тийн бөгөөс Нэгүс ах дүүгээ цуглуулж чи ургийн ураг хүртэл мэдэж үл байх уу?" хэмээн зарлиг болов.

219. Бас Чингис хаан Сорхон шард өгүүлрүүн: "Намайг өчүүхэн цагт Тайчуудын Таргудай, Хирилтуг ах дүүс атаархаж бариваас тэнд ах дүүдээ атаархагдлаа хэмээн Сорхон шар, Чулуун Чимбай хөвүүдээрээ, Хадаан охиноороо асруулж, нууж авч, намайг тавьж илгээвээ та нар. Тэр сайн тусыг тань санаж

Хар шөнө зүүдэндээ
Гэгээн өдөр цээжиндээ
Санаж явав аа би

Та [харин] надад Тайчуудаас удаж ирэв ээ. Эдүгээ би таныг соёрховоос ямар соёрхол таална та?" хэмээв. Сорхон шар, Чулуун Чимбай хөвүүдтэйгээ хамт өгүүлрүүн: "Соёрховоос нутаг дархална уу. Мэргидийн газар Сэлэнгэд нутаг дархалж өгнө үү. Бас бус соёрхолыг Чингис хаан мэдтүгэй" хэмээв. Түүнд Чингис хаан өгүүлрүүн: "Мэргидийн газар Сэлэнгэд нутаглаж нутгаа

дархлагтүн! Ургийн ураг хүртэл хоромсоголуулж идээ шүүс эдлүүлж дархлагтүн! Есөн эндэлд эрүүнд бүү ортугай" хэмээн зарлиг болов. Бас Чингис хаан Чулуун, Чимбай хоёрыг соёрхохдоо: "Эрт Чулуун, Чимбай хоёр өгүүлсэн үгсээ санаж [надад] хэрхэн хандана та [хоёр]? Чулуун, Чимбай та хоёр санаснаа өгүүлэх бөгөөс, дутуугаа гуйх бөгөөс завсрын хүнд бүү хэлэгтүн! Өөрийн биесээр, амаар надад та нар өөрсдийн бодсоноо хэлэгтүн! Дутуу юугаа өөрсдөө гуйгтүн!" хэмээн зарлиг болов. Бас "Сорхон шар, Бадай, Хишилиг та нарыг дархад дархлахдаа бас :

Олон дайсанд довтлож
Олз олбоос
Олсоноо авагтүн
Ороо гөрөөс авлабаас
Алсанаа авагтүн" хэмээн зарлиг болов.

Сорхон шар хэмээвээс Тайчуудын Төдэгэгийн [харъяат] ард ажгуу. Бадай Хишилиг хоёр хэмээвээс Чэрэний адуучин ажгуу. Эдүгээ миний тураг [болон] хоромсоголж идээ шүүс эдлүүлж дархлан жаргаагтүн хэмээн зарлиг болов.

220. Бас Чингис хаан Наяад өгүүлрүүн: "Ширээт өвгөн, Алаг Наяа хөвүүнтэйгээ тантай Таргудай Хирилтугийг барьж бидэнд айсуй зуур Хутухул нугад хүрч тэнд Наяа өгүүлрүүн: "Тус хан [эзнээ] хэрхэн тэвчиж барьж одно бид?" хэмээн тэвчин ядаж тавьж явуулж Ширээт өвгөн, Алаг Наяа хөвүүдтэйгээ ирж тэнд Наяа **бялзуухай**[509] өгүүлрүүн: "Тус хан [эзнээ] Таргудай Хирилтугийг гардаж (барьж) явахдаа жич тэвчин ядаж тавьж явуулж бид Чингис хаанд хүч өгөхөөр ирэв. Хан [эзнээ] барьж ирвээс өөрийн эзнээ барьсан ард мөнөө хойно хэрхэн итгэгдэнэ эд? хэмээгдэнэ" гэж "Хан [эзнээ] тэвчин ядав" гэвээс тэнд "тус хан [эзнээ] тэвчин ядсан их ёс төрийг санажээ" хэмээн үгийг минь зөвшөөж "Нэгэн үйлд түшьеэ" хэмээлээ. "Эдүгээ Боорчуд баруун гарын түмнийг мэдүүлтүгэй. Мухулид улсын ван цол өгч зүүн гарын түмнийг мэдүүлэв. Эдүгээ Наяа төвийн түмнийг мэдтүгэй" хэмээн зарлиг болов.

221. Бас "Зэбэ, Сүбээдэй хоёр өөрийн олсон зөөснөөрөө мянгалтугай" хэмээв.

222. Бас Дэгэй хоньчид **дарагдмал**[510] [иргэдийг] цуглуулж мянга мэдүүлэв.

223. Бас Гүчүгүр Модчинд иргэн дутагдаж энд, тэндээс гувчиж Жадаранаас Мулхалху зүгээр нөхөрлүүлэв. "Гүчүгүр Мулхалху хоёр нэгэн мянгалж зөвлөлдөж байгтүн" хэмээв.

224. Улс байгуулалцагсад [хамт] зүдрэгсдийг мянгатын ноёд болгож, мянга мянгалж, мянгат, зуут, аравтын ноёдыг тушааж, түмлэж, түмтийн ноёдыг тушааж, түмэт, мянгатын ноёдод соёрхол өгөх [ёстой] мэтэд соёрхол өгч, соёрхол зарлиг болоход [нь] болж, Чингис хаан зарлиг болруун: "Урьд наян хэвтүүл, далан тураг (торгон цэрэг) хэшигтэнд [байсан] бөлгөө. Эдүгээ мөнх тэнгэрийн хүчинд тэнгэр, газар хүч аугаа нэмэгдэж гүр улсыг шулуутгаж гагц жолоондоо оруулсанд эдүгээ надад хэшигтэн, тургийг мянгат мянгатаас ялгаж оруулагтун! Оруулахдаа хэвтүүл, хорчин, тураг оруулж түм дүүргэн (хүргэн) оруулагтун" хэмээн зарлиг болов. Бас Чингис хаан хэшигтэн ялгаж оруулахыг мянгат, мянгатад зарлиг тунхагласан нь "Бидэнд хэшигтэн оруулахдаа түмэт, мянгат, зуутын ноёдын хөвүүд, эгэл хүний хөвүүдийг оруулахад эрдэмтэн, шил сайтайг бидний дэргэд явах [энэ] мэтийн [хүмүүсийг] оруултугай! Мянгатын ноёдын хөвүүдийг оруулахад арван нөхөд нэг дүү нь дагалдан иртүгэй! Зуутын ноёдын хөвүүдийг оруулахад таван нөхөд нэг дүүгээ дагуулж иртүгэй! Аравтын ноёдын хөвүүдийг оруулахад эгэл хүний хөвүүдийг оруулахад, гурван нөхөд нэг дүүгээ дагуулж уг [газраас] улаа хүч бэлтгэж иртүгэй! Бидний дэргэд явуулах [хүмүүсийг] **чандлахдаа**[511] мянгатын ноёдын хөвүүдэд арван нөхдийг уг мянга, зуугаас гувчиж (татаж) өгтүгэй! Эцгийн өгсөн хувь хишиг [хэдий буй] бөгөөс өөрийн бие **хараар**[512] олсон зөөсөн эрс, агт хэдий [буй] бөгөөс түүний өмч хувиас ангид, бидний хэмжиж [тогтоосон] хэмээр гувчиж, тийн гувчиж бэлтгэж өгтүгэй! Зуутын ноёдын хөвүүдэд таван нөхөд, аравтын ноёдын хөвүүд, эгэл хүний хөвүүдэд гурван нөхөд мөнхүү ёсоор нь өмч

хувиас ангид мөн тийн гувчиж өгтүгэй" хэмээн зарлиг болов. "Мянгат, зуут, аравтын ноёд олон хүн бидний энэ зарлигийг хүргүүлээд сонсоод давах ард [гарваас тэр] гэмтэн болтугай! Бидэнд хэшиг оруулагч ард булгарч, үл бүтэгч ард [гарваас] бидний дэргэд явахаас бэрхшээвээс бусдыг оруулж тэр [зайлсхийгч] хүнийг яллаж нүднээс далд хол газар явуулъя" хэмээн зарлиг болов. Бидний дэргэд дотно явж суралцъя хэмээж бидэнд ирэгч ардыг бүү хориглотугай" хэмээв.

225. Чингис хааны зарлиг болсноор мянгатаас ялгаж, зуут аравтын ноёдын хөвүүдийг мөнхүү зарлигаар ялгаж гаргаж иржээ. Урьд наян хэвтүүл [байсан] бөлгөө. [Эдүгээ] найман зуу болгов. "Найман зуу дээр [нэмэж] мянга дүүргэтүгэй" хэмээв. "Хэвтүүлд орох [хүнийг] бүү хориглотугай" хэмээн зарлиг болов. "Хэвтүүлийг Их Нэүрин ахлаж мянганыг мэдэж байтугай" хэмээн зарлиг болов.

"Урьд дөрвөн зуун хорчин ялгав. Ялгасан хорчныг Зэлмэгийн хөвүүн Есүнтэгэ ахлаж Түгэгийн хөвүүн Бүгидэйтэй зөвлөлдөж байтугай" хэмээв. "Турагуудтай хорчин хэшиг хэшигт орохдоо Есүнтэгэ нэгэн ээлж хорчныг ахлаж ортугай! Бүгидэй нэгэн ээлж хорчныг ахлаж ортугай. Хорхудаг нэгэн ээлж хорчныг ахлаж ортугай! Лаблаха нэгэн ээлж хорчныг ахлаж ортугай! Хор асгагч тургуудын хэшиг хэшиг хорчноо тийн ахлаж оруултугай! [Нийт] хорчныг мянга дүүргэж Есүнтэгэ ахлаж байтугай" хэмээн зарлиг болов.

226. "Урьд Өгэлэ Чэрбитэй [цуг] орсон тургууд дээр [нэмэж] мянга дүүргэж Боорчугийн ургаас Өгэлэ Чэрби мэдтүгэй" хэмээв. "нэг мянган тургуудыг Мухалийн ургаас Буха нэг мянган тургуудыг мэдтүгэй!" хэмээв. Илүгэйн ургаас Алчидай "Нэг мянган тургуудыг мэдтүгэй!" хэмээв. "Нэг мянган тургуудыг Додай Чэрби мэдтүгэй! Нэг мянган тургуудыг Дохолху Чэрби мэдтүгэй!" хэмээв. "Нэг мянган тургуудыг Жүрчидэйн ургаас мэдтүгэй! Нэг мянган тургуудыг Алчийн ургаас Ахутай мэдтүгэй. Нэгэн мянган тургуудыг Архай Хасар нэг мянган ялгасан баатруудыг мэдэж олон өдөр тураг болтугай. Хатгалдах

өдөр өмнө [минь] байж баатар [бамбай] болтугай " хэмээн зарлиг болов. Мянгат, Мянгатаас ялгаж ирсэн [нийт] найман мянган тургууд болов. Хэвтүүл, хорчинтай хамт хоёр мянга болов. Түмэн хэшигтэн болов.

Чингис хаан зарлиг болруун: " Бидний хажууд түмэн хэшигтэнг чандлаж их гол [хүч] болон атугай" хэмээн зарлиг болов.

227. Бас Чингис хаан зарлиг болж тургуудын дөрвөн ээлжийн **ахлаачдыг**[513] тушаахдаа: "Буха нэгэн ээлж хэшигтнийг мэдэж, хэшигтнийг засаж ортугай! Алчидай нэгэн ээлж хэшигтнийг мэдэж, хэшигтнийг засаж ортугай! Тодай чэрби нэгэн ээлж хэшигтнийг мэдэж, хэшигтнийг засаж ортугай! Дохолху чэрби нэгэн ээлж хэшигтнийг мэдэж, хэшигтнийг засаж ортугай!" хэмээн дөрвөн ээлжийн ахлаачийг тушааж, ээлж орох зарлиг тунхаглахдаа "Ээлж орохдоо ээлжийн ноён өөртөө хэшиглэсэн хэшигтнийг бүрдүүлж, ээлж орж гурав хоноод солилцтугай! Хэшигтэн хүн ээлж **огоорвоос**[514] тэр ээлж огоорсон хэшигтнийг гурван бэрээ шүүтүгэй! Мөн хэшигтэн бас ахин ээлж огоорвоос долоон бэрээ шүүтүгэй! Бас мөн хүн бие хараа өвчин үгүй ээлжийн ноёд [хэл] зөвшөөргүй бас мөн хэшигт гурвантаа хэшиг огоорвоос гучин долоон бэрээ шүүгээд бидэнтэй явахаас бэрхшээсэн [ийм хүнийг] эчнээ хол газар явуулъя" хэмээн зарлиг болов. "Ээлжүүдийн ахлаач гурав гурван удаа ээлжид энэ зарлигийг хэшигтэнд сонсгогтун! Эс сонсговоос ээлжүүдийн ахлаач гэмтэн болтугай! Зарлиг сонссон атал [тэрслэж] давбаас зарлигийн ёсоор ээлж огоорвоос хэшигтэн гэмтэн болтугай!" хэмээн зарлиг болов. "Ээлжийн ахлаач, ахлагч гэдгээр сацуу орсон миний хэшигтнийг надаас зөвшөөр үгүй бүү **донгодогтун!**[515] Засаг [цааз] хөндвөөс надад зааж өгөгтүн! Мөхөөх ёстой бөгөөс бид мөхөөе. Балбах ёстой бөгөөс хэвтүүлж балбая. Ахлав гэдгээр сацуу [эрхт] хэшигтнийг минь өөрийн [дураар] гар хөл хүргэж бэрээдвээс бэрээний хариуг бэрээгээр, нударганы хариуг нударгаар хариултугай!" хэмээв.


228. Бас Чингис хаан зарлиг болруун: "Гаднах мянгатын ноёдоос миний хэшигтэн дээр [эрхтэй] буй за. Гаднах зуутын, аравтын ноёдоос миний хэшитний хөтөч дээр [эрхтэй] буй за.

Миний хэшигтэнд гаднах мянгатууд сацуутан болж, миний хэигтэнтэй тэнцэн хэрэлдвээс [тэр] мянгатын хүнийг яллаж байя" хэмээн зарлиг болов.

229. Бас Чингис хаан зарлиг болж ээлж ээлжийн ноёдод зарлиг тунхаглахдаа: "Хорчин тургуудын ээлж орж өдрийн явдалд зүг зүг мөр мөртөө явж нарны галтайд хэвтүүлд зай тавьж гадна гарч хонотугай! Бидэнтэй шөнө хэвтүүл хонож байтугай! Хорчин хоромсого [саадгаа], буурчин аяга саваа хэвтүүлд **даалгаж**[516] явтугай! Гадна хоносон хорчин, тургууд, буурч [нар] биднийг шөл идтэл уяан дээр сууж, хэвтүүлд хэлүүлж, шөл идэж дуусахаар хорчин хоромсого [саадгандаа], тураг [байр] сууриндаа, буурч аяга саваа **эзэмшин автугай!**[517] Ээлж, ээлж орохдоо мөн уг ёсоор энэ хуулиар тийн хийтүгэй!" хэмээн зарлиг болов. "Нар шингэсний хойно ордны хойгуур урдуур гэтэлзэн явах хүнийг барьж, хэвтүүл барьж хонож маргааш [нь] хэвтүүл ам өчгий нь асуутугай! Хэвтүүл ээлж солигдоход тэмдгээ шалгуулж орж иртүгэй! [Ээлж] солигдож гарахад хэвтүүл дагуулж гарч одтугай!" хэмээв. "Хэвтүүл шөнө орд орчин хэвтэж, үүд дарж байцгаасан хэвтүүл шөнө орж ирэх хүнийг **тархий нь далба**[518]**, мөрий нь мөлт**[519] цавчиж хаягтун! Яруу [үг] хэлтэй хүн шөнө ирвээс хэвтүүлд хэлж, гэрийн араас хэвтүүлтэй хамт байж хэлүүлтүгэй!" хэмээв. "Хэвтүүлээс дээр судалд хэн ч бүү суутугай! Хэвтүүлээс хэл үгүй хэн ч бүү ортугай! Хэвтүүлийн дээгүүр (дээд талаар) хэн ч бүү явтугай! Хэвтүүлийн **завсраар**[520] бүү явтугай! Хэвтүүлийн тоо бүү асуутугай! Хэвтүүлийн дээгүүр явагч ардыг хэвтүүл барьтугай! Завсраар явагч ардыг хэвтүүл барьтугай! Тоо асуусан хүнийг хэвтүүл уг хүнийг тэр өдрийн унасан эмээлтэй, хазаартай морь, өмссөн хувцас сэлтийг хэвтүүл автугай!" хэмээн зарлиг болов. "Элжигдэй итгэлтэй [хүн] бөгөөтөл үдэш хэвтүүлийн дээгүүр явж байгаад хэвтүүлд хэрхэн баригдлаа?"



Аравдугаар бүлэг





230.Чингис хаан өгүүлрүүн:
"Үүлтэй шөнө
Өрхтэй гэрий минь
Ээрэн хэвтэж (сахиж)
Энх амар[521] унтуулж
Энэ оронд хүрэгсэн
Өтгөс хэвтүүл минь
Одтой шөнө
Орд гэрий минь
Орчин хэвтэж
Орон дотор эс сочоосон
Өлзийт хэвтүүл мниь
Өндөр оронд хүргэв.
Шиврэн[522] бүхий бороонд
Чичиргэн[523] бүхий жихүүнд
Цутган бүхий хурд
Шилбэт[524] гэрий минь орчин
Цурам[525] үл хийн байж
Зүрхий [минь] амруулсан
Чин сэтгэлт хэвтүүл минь
Жаргалан оронд хүргэв.
Ивлэн бүхий дайсан дотор
Ирэгт[526] гэрий минь орчин
Ирмас үл хийн
Ятгаж (хориглож) байцгаасан
Итгэлт хэвтүүл минь!

Үйсэн хоромсого
Овоо хийхэд
Удал үгүй байралдах
Улиархан[527] **хэвтүүл минь**
Удан[528] хоромсого
Овос хийхэд
Хожимдож эс байсан
Хурдан явдалт хэвтүүл минь!
Өлзийт хэвтүүлийг минь
Өтгөс хэвтүүл хэмээгтүн!
Өгэлэ чэрбитэй орсон далан тургийг
Ихэс тургууд хэмээгтүн!
Архайн (Хасарын) баатруудыг
Ахмад баатрууд хэмээгтүн!
Есүнтүгэ, Бүгидэйтэн хорчныг ихэс хорчин хэмээгтүн!" хэмээн зарлиг болов.

231. "Ерэн таван мянгатаас миний биеийн захад (дэргэд) өмчлөн ялгаж ирсэн түмэн өмч хэшигтнийг минь мөнөө хойно миний ор суусан хөвүүд ургийн ураг минь эд хэшигтнийг гэрээс мэт санаж үл **гэмшүүлэн**[529] сайтар асрагтун! Эд түмэн хэшигтнийг миний ариун хутаг хэмээн **үлү атугай**[530]" хэмээв.

232. Бас Чингис хаан өгүүлрүүн: "Ордны чэрбийн охид, гэрийн хөвүүд тэмээчин, үхэрчнийг хэвтүүлд хамааруулж ордны гэр тэргийг хамгаалтугай. Туг, хэнгэрэг, **дөр жадыг**[531] хэвтүүл хамгаалтугай. Аяга савыг хэвтүүл [мөн] хамгаалтугай. Бидний идээ, ундыг хэвтүүл даргалтугай! Өтгөн, махан идээг хэвтүүл даргалж болготугай! Идээ ундаа хор хомс болвоос даргалсан хэвтүүлээс нэхье" хэмээв. "Хорчин идээ унд түгээхдээ даргалсан хэвтүүлээс зөвшөөр үгүй бүү түгээтүгэй! Идээ түгээхдээ урьд хэвтүүлээс эхлэн түгээтүгэй!" хэмээв. "Орд гэрт орох, гарахыг хэвтүүл застугай! Үүдэнд хэвтүүлийн үүдчин гэрийн хажууд байтугай! Хэвтүүлээс хоёр [хүн] орж их сөн түшиж байтугай!" хэмээв. "Хэвтүүлээс нутагчин явж орд гэр буулгатугай" хэмээв.

"Биднийг авлах, шувуулахад хэвтүүл бидэнтэй явлалцан, шувуулалцан [хамт] явтугай. Тэргэнд [хагас] заримуудаа цагдан талбитугай!" хэмээв.

233. Бас Чингис хаан өгүүлрүүн: "Бидний бие цэрэгтэй [цуг] эс гарваас хэвтүүл биднээс ангид цэрэгтэй бүү гартугай" хэмээв. "Ийн хэлэлцсэн зарлигийг давж хэвтүүлийг атаархан цэрэгт гаргасан цэрэг мэдэх чэрбин гэмтэн болтугай" хэмээн зарлиг болов. "Хэвтүүлийг цэрэг хэрхэн үл гарна хэмээмүү та нар? Хэвтүүл л миний алтан амийг сахимой. Шувуулан , авлан явахуйд [хамт] зүдрэлцэнэ. Орд [гэр] хадгалуулж нүүхэд, амар жимэр тэрэг асармой.

Миний биеийг сахиж хонох хялбар буюу? Гэр-тэргэн, их ауруг нүүх, суухад асрах хялбар буюу? Тийн давхар алгуу салгуу [ажил] явдалтан хэмээж биднээс ангид өөр цэрэгт бүү явтугай хэмээхүй тийм буй за" хэмээжүхэй.

234. Бас зарлиг болруун: "Шигихутуг зарга [шүүхэд] хэвтүүлээс заргыг сонсолцтугай" хэмээв. "Хэвтүүлээс хор, нум, хуяг, зэв асарч [хамгаалж] түгээтүгэй. Агт [морьдоо] асарч [хамгаалж] өгөөш (цалам) ачиж явтугай" хэмээв. "Хэвтүүлээс чэрбинтэй [хамт эд] агуурс түгээтүгэй" хэмээв. "Хорчин тургуудын нутаг заахдаа Есүнтэгэ, Бүгидэйтэн хорчин [нар] Алчидай, Өгэлэ Ахутайтан тургууд ордны баруун этгээдэд явтугай" хэмээв. "Буха, Додай чэрби, Доголху чэрби, Чанайтан тургууд ордны зүүн этгээдэд явтугай" хэмээв. "Архайн баатрууд ордны урд явтугай" хэмээв. "Бүх хэшигтэн, тургуудыг орд орчин, орд гэрийн хөвүүдийг адуучин, хоньчин, тэмээчин, үхэрчнийг Додай чэрби мэдэж орд байнга сахин атугай"хэмээн тушаав. "Додай чэрби байнга сахиж байж ордны хойноос

Хог идэж
Хомоол түлж явтугай"

хэмээн зарлиг болов.

235. Хубилай ноёныг Харлугуудад [цэрэглэн] мордуулав. Харлугуудын Арслан хан Хубилайд элсэн иржээ. Хубилай ноён

Арслан ханыг авч ирж Чингис хаантай уулзуулав. Эс тэмцэлдэв хэмээн Чингис хаан Арсланг соёхож "Охин өгье" хэмээн зарлиг болов.

236. Сүбээдэй баатар төмөр тэрэгт мэргидийн Тогтоагийн Худу, Чулуун тэргүүтэн хөвүүдийг нь нэхэн [цэрэглэн] мордож Чүй мөрнөө хүрч мохоож ирэв.

237. Зэбэ найманы Хүчүлүг ханыг нэхэж **Сариг хунд**[536] гүйцэж Хүчүлүгийг мохоож ирэв.

238. Уйгудын **Идүгүд**[537] Чингис хаанд элч илгээж Адкираг, Дарбай хоёр элчээрээ өчиж өгүүлрүүн:

"Үүл арилж
Эх наран үзсэн мэт
Мөс арилж
Мөрөн ус олсон мэт

Чингис хааны нэр алдарыг сонсож маш баясав. Чингис хаан соёрховоос

Алтан бүсний горхиноос
Ал [улаан] дээлийн үртэснээс

Олвоос тавдугаар хөүүн чинь болж хүч өгье" хэмээн өчиж илгээжээ. Тэр үгэнд Чингис хаан соёрхож хариу өгүүлж илгээрүүн: "Охиноо өгье. Тавдугаар хөвүүн болтугай. Алт, мөнгө, сувд, тана, **хоргой**[538], **таж магнаг**[539], торго аваад Идүгүд иртүгэй" хэмээж илгээвээс Идүгүд соёрхогдов хэмээн баясаж алт, мөнгө, сувд, тана, торго, хоргой, таж магнаг [зэрэг эд] агуурс аваад Идүгүд ирж Чингис хаантай уулзав. Чингис хаан Идүгүдийг соёрхож Ал Алтуныг өгөв.

239. Туулай жил (1207) Жөчийг баруун гарын цэргүүдтэй ойн иргэдэд мордуулав. Буха газарчилж явав. Ойрадын Хутуга бэхи түмэн ойрадын түрүүнд элсэн орж ирэв. Ирээд Жөчийг дагуулж түмэн ойраддаа газарчилж Шигшидэд (Шишгид?) оруулав. Жөчи Ойрад, Буриад, Баргун, Урсуд, Хабханас, Ханхас, Туба [нарыг] оруулаад түмэн Хиргисүүдэд хүрвээс Хиргисүүдийн ноёд Йэди, Инал, Алдихэр, Өрэ, Бэг Дигин [зэрэг] хиргисүүдийн ноёд элсэн орж, цагаан шонхорууд, цагаан морьд, хар булгад авч

ирж Жөчитэй уулзав. Шибир, Кэшдийм, Байид, Тухас, Тэнлэг, Төгэлэс, Таш, Бажигидаас нааш ойн иргэнийг Жөчи [дагаар] оруулж, хиргисүүдийн түмтийн мянгатын ноёдыг, ойн иргэний ноёдыг авч ирж Чингис хаанд цагаан шонхрууд, цагаан морьд, хар булгадаар [бэлэглэн] уулзуулав.

Ойрадын Хутуга бэхийг угтан [орж] урьд элсэн түмэн ойрадаа удирдан ирэв хэмээн соёрхож хөвүүн Иналчид нь Чэчэйгэнийг өгөв. Иналчийн ах Төрөлчид, Жөчийн охин Олуйханыг өгөв. Алаха бэхийг Онгуудад өгөв. Чингис хаан Жөчийг соёрхож өгүүлрүүн: "Хөвүүдийн минь ах чи гэртээс сая гарч одсон газраа мөр сайтай [явж] эр [хүн] агт [морьдыг] үл шархлуулж, үл зовоон ойн иргэнийг өлзийтэй оруулж ирэв ээ чи. Иргэдийг чамд өгье" хэмээн зарлиг болов.

240. Бас Борохул ноёныг Хорь Түмэдийн иргэнд [цэрэглэн] мордуулав. Түмэд иргэний ноён Дайдухул Сохорыг үхсэнээс [хойш] Ботохуй Таргун эхнэр нь түмэд иргэнийг мэдэж [байсан] ажгуу. Борохул ноён хүрч гурван хүнийг их цэргээс урьд явахаар одуулж, орой үдэш **ухаж [мэдэхэд]**[540] бэрх ойд ором [жимээр] явах болоход харуул нь хойнооос нь дайрч замы нь боож, Борохул ноёныг барьж алжээ. Түмэд Борохулыг алж хэмээн мэдэж, Чингис хаан маш [их] хилигнэж өөрөө морилон **дайлах гэвээс**[541] Боорчу, Мухули хоёр Чингис хааныг больтол ятгав. Жич Дөрбэдийн Дөрбэй догшныг тушаан: "Цэрэг чандлан засаж, мөнх тэнгэрт залбирч, Түмэд иргэнийг оруулахыг сорь!" хэмээн зарлиг болов. Дөрбэй цэргээ засахдаа урьд цэргийн явах харуулын сахих мөр жим сүвүүдэд **хий сүрдүүлж**[542] **улаан бухын**[543] авсан мөрөөр цэргүүдийг [оруулж] тушаахдаа цэргийн тоот хүмүүн [хэн нэгэн] зүрх шантарваас жанчих эрд арван сум үүрүүлж сүх, ооль, хөрөө, цүүц [зэрэг] эрийн зэвсэг бэлтгүүлж улаан бухын явсан мөрөөр мөрт байгаа модыг огтчин цавчуулж, хөрөөдүүлж мөр гаргаж уулан дээр гарваас Түмэд иргэнийг хуримлан суухуйд өрхөн (эгц дээрээс нь) дээрээс [нь] гэнэт [дайран орж] дагуулав.

241. Урьд Хорчи ноён, Хутуга бэхи хоёр Түмэдэд баригдаж

Ботохуй Таргуны тэнд [байсан] ажгуу. Хорчийн баригдсан түүх нь: "Түмэд иргэний охидоос гоо сайхан гучин эхнэр автугай" хэмээн зарлиг болсонд Түмэд иргэний охид авъя хэмээн одох болоход урьд элсэж [дагасан] иргэн жич дайсан болж Хорчи ноёныг барьжээ. Хорчийг Түмэдэд баригдаж хэмээн Чингис хаан мэдэж ойн иргэний явдлыг Хутуга мэдтүгэй хэмээн илгээвээс Хутуга бэхи бас баригджээ.

Түмэд иргэнийг оруулж дуусгаад Борохулын яс [цогцосны] тулд зуун Түмэдийг өгөв. Хорчи гучин охидыг авав. Хутуга бэхид Ботохуй Таргуныг өгөв.

242. Чингис хаан зарлиг болж "Эх, хөвүүд, дүү нартаа иргэн хуваж өгье" хэмээн өгөхдөө: "Улс хураан зовсон [хүн] эх буй за. Хөвүүдийн минь ах Жөчи буй за. Дүү нарын минь нялх Отчигин буй за" хэмээж эхэд, Отчигины хувь хийгээд түмэн иргэн өгөв. Эх **чамлаж**[544] эс дуугарав. Жөчид есөн мянган иргэн өгөв. Цагаадайд найман мянган иргэн өгөв. Өгөдэйд таван мянган иргэн өгөв. Толуйд таван мянган иргэн өгөв. Хасарт дөрвөн мянган иргэн өгөв. Алчидайд хоёр мянган иргэн өгөв. Бэлгүдэйд нэг мянга таван зуун иргэн өгөв. Дааритайг Хэрэйдтэй [нийлэх] бололцов хэмээн нүднээс далд **эцэслүүлье**[545] хэмээвээс Боорчу, Мухули, Шигихутуг гурав өгүүлрүүн: "Өөрийн гал [голомтоо] сөнөөх мэт өөрийн гэрээ эвдэх мэт сайн эцгийн чинь гэрээс [болж] ганц авга чинь үлдээн амуй. Хэрхэн тэвчнэ? Түүний эс ухаарсанд бүү тэг! Сайн эцгийн чинь нялхын нутагт утаа бургиулж байтугай" хэмээлцэж хамраас утаа **ханхилтал**[546] **ятган**[547] хэлсэнд "Зүйтэй" хэмээн сайн эцгээ санаж Боорчу, Мухули, Шигихутуг гурвын үгэнд [сэтгэл] амарлив.

243. Би эхэд, Отчигинд түмэн иргэн өгч ноёдоос Гүчү, Хөхөчү, Жунсай, Хоргасун дөрвийг [тэр хоёрт] тушаав.

Жөчид Хунан, Мөнхэүр, Хэтэ гурвыг тушаав. Цагаадайд Харачар, Мөнхэ, Идохудай гурвыг тушаав. Бас Чингис хаан өгүүлрүүн: "Цагаадай хэцүү [хүн] буюу. Нарийн зантай буюу. Хөхөчос өглөө үдэш дэргэд [нь] байж санаснаа хэлж байтугай" хэмээн зарлиг болов. Өгөдэйд Илүгэ, Дэгэй хоёрыг тушаав. Толуйд

Жэдэй, Бала хоёрыг тушаав. Хасарт Жэбэгээг тушаав. Алчидайд Чаурхайг тушаав.

244. Хонхотаны Мунлиг эцгийн хөвүүд долоо болой. Долоогийн дундах[нь] Хөхөчү **тэв тэнгэр**[548] бөлгөө. Тэд долоон Хонхотан Хасарыг **нийлж**[549] жанчжээ. Хасар долоон Хонхотан нийлж жанчлаа хэмээн Чингис хаанд сөгдвөөс Чингис хааныг бусдад хилигнэж байх зуур хэлсэн учир Чингис хаан ууранда Хасарт өгүүлрүүн: "Амьтанд үл ялагдах бөлгөө чи. [Одоо] хэрхэн ялагдана чи?" хэмээхэд Хасар нулимс унагаад босч явжээ. Хасар гоморхож гурав өдөр эс ирэв.

Тэнд Тэв тэнгэр Чингис хаанд өгүүлрүүн: "Мөнх тэнгэрийн зарлиг хан зааринууд өгүүлмүү. Нэгэнтээ Тэмүжин улс барьтугай хэмээмүү. Нэгэнтээ Хасарыг хэмээмүү. Хасарыг эс гэндүүлбээс мэдэх [болзош] үгүй буй за" хэмээлцэж Чингис хаан мөн шөнө морилж Хасарыг барихаар одвоос Гүчү, Хөхөчү хоёр "Хасарыг барихаар одов" хэмээн эхэд зааж [хэлэв]. Эх мэдээд хойноос [нь] цагаан тэмээ хөллөж, мухлаг тэрэгтэй шөнө туж явж, нар ургахад хүрвээс Чингис хаан Хасарын [хоёр] ханцуйг уяж, малгай, бүсийн авч ам хэлий нь асууж бүхүйд эхийг хүрч [очиход] Чингис хаан **хирдхийн**[550]эхээс эмээв. Эх уурлаж хүрч тэргэнээс буугаад эх өөрөө Хасарын уясан ханцуйг тайлж тавиад малгай бүсий нь Хасарт [авч] өгч эх хилэгнэж ууруа даран ядан завилан сууж, хоёр хөхөө гаргаж хоёр өвдөг дээрээ давуулан **тавьж**[551] өгүүлрүүн: "Үзэв үү? Хөхсөн хөх чинь энэ байна. Эд

Хадран[552] дуу [гаргаж]
Хальс навчаа хазагсад
Хүйгээ таслагсад
Хасар яав

Тэмүжин энэ нэг хөхий минь барах бөлгөө. Хачиун, Отчигин хоёул хамтаар нэг хөх үл барах бөлгөө. Хасар бол хоёр хөхий минь бүрэн барж, цээжий минь уудам болтол амруулж, цээж уужим болгох бөлгөө. Түүгээр [үзвэл] эрдэмт Тэмүжин минь цээж эрдэмт Хасар минь хав хүч эрдэмтэй тул

Хариуцан гарсныг
Харван оруулах бөлгөө
Ойлон гарсныг
Ондтож[553] оруулах бөлгөө

Эдүгээ дайсан хүмүүнийг мөхөөв хэмээж Хасарыг үзэн ядна уу та нар" хэмээв. Эхийн [сэтгэлийг] амарлиулан барж Чингис хаан өгүүлрүүн: "Эхийг хилигнүүлж айхын [ихээр] айв. Ичихийн [ихээр] ичив би" хэмээн "буцъя бид" хэмээж буцав. Эхэд үл мэдэгдэн далдуур Хасарын иргэнийг авч Хасарт мянга дөрвөн зуун иргэн өгөв. Эх мэдэж тэр сэтгэлдээ [шаналаж] үтэр **өтөлсөн**[554] ёсон тийм. Жалайрдайн Жэбгэ тэндээс хулжиж Баргужин орноо буруулав.

245. Түүний хойно есөн хэлтэн иргэн Тэв тэнгэрт хуран [цуглаж] Чингис хааны [морины] уяанаас Тэв тэнгэрт олон хурах болов. Тийн хурахуйд Тэмүгэ Отчигины харъяат иргэд Тэв тэнгэрт очицгоов. Отчигин ноён одсон иргэдээ гуйхаар Сохор нэрт элчээ илгээжээ. Тэв тэнгэр Сохор элчид өгүүлрүүн: "Отчигин та хоёр элчтэн болжээ" хэмээж Сохор элчийг нь алхиж явган эмээлийг нь үүрүүлж хариулжээ. Отчигин Сохор элчээ алхиж явган ирүүлээд маргааш нь Отчигин өөрөө Тэв тэнгэрт очиж өгүүлрүүн: "Сохор элчээ илгээвээс алхиж явган явуулжээ. Эдүгээ би иргэдээ гуйхаар ирэв" хэмээхэд долоон Хонхотан Отчигиныг энд тэндээс нь хааж "Сохор элчээ илгээх чинь зөв буюу" хэмээж барихаар цохихоор завдахад Отчигин ноён айж өгүүлрүүн: "Элч илгээсэн минь буруу" хэмээжээ. Долоон Хонхотан өгүүлрүүн: "Буруу бөгөөс наманчлан сөгд!" хэмээж Тэв тэнгэрийн хойноос сөгтгөжээ.

Иргэдээ эс өгсөнд Отчигин маргааш [өглөө] эрт Чингис хааныг босоогүй орон дотроо бүхүйд орж уйлаад сөгдөж өгүүлрүүн: "Есөн хэлтэн иргэд Тэв тэнгэрт цугларч би харъяат иргэдээ Тэв тэнгэрээс гуйхаар Сохор нэрт элч илгээлээ. Сохор элчийг минь алхиж явган эмээл үүрүүлж илгээхэд би өөрөө гуйхаар одвоос долоон Хонхотан энд тэндээс хааж, наманчлуулж Тэв тэнгэрийн хойноос сөгдүүлэв" гээд уйлав. Чингис хааныг дуу гараагүй [байхад] Бөртэ Үжин орон дотроо өндийж сууж,

хөнжлийн захаар өвчүүгээ **халхлан**[555] Отчигины уйлахыг үзэж, нулимс унагаан өгүүлрүүн: "Яасан [айхтар] Хонхотан тэд! Өцөгдөр Хасарыг хамжиж жанчсан болой. Эдүгээ бас Отчигиныг яахан хойноосоо сөгдүүлнэ? Ямар ёс болмуй? Тэгэж эд, цөөрс, нарс мэт дүү нарыг чинь ийн өшлөлдөнө

Үнэхээр мөнөө хойно
Нэгүл[556] мэт биеий чинь
Нэхс [хийж] одвоос
Нийтгэл[557] мэт улсыг чинь
Хэнээр мэдүүлнэ тэд
Тулгуур[558] мэт биеий чинь
Тулбас [хийж] одвоос
Туял [559] мэт улсыг чинь
Хэнээр мэдүүлнэ тэд?

Цөөрс, нарс мэт дүү нарыг чинь ийн өшлөлдөн [доромжлох] хүмүүс миний гурав дөрвөн өчүүхэн муусайныг минь **өсөж өндийхөд**[560] юу мэдүүлнэ тэд? Яасан [айхтар] Хонхотан бөлгөө тэд? Дүү нараа тэдэнд тийн дөнгүүлэхийг хэрхэн үзэж аму чи!" хэмээгээд Бөртэ Үжин нулимс унагав. Бөртэ Үжиний энэ үгэнд Чингис хаан Отчигинд өгүүлрүүн: "Тэв тэнгэр одоо ирнэ. Чадахын [хэрээр] хэрхэн үйлдэхийг чи мэд" хэмээв. Түүнд Отчигин босоод нулимсаа арчаал гарч гурван бөх бэлдэж байв. Хоромхон байтал Мунлиг эцэг долоон хөвүүдтэйгээ ирж долуул бүгд орж Тэв тэнгэр сөнгийн баруун этгээдэд суухад Отчигин Тэв тэнгэрийн заамнаас нь барьж "Өцөгдөр намайг наманчлуулж байлуу чи [хүчээ] сорилдъёо" хэмээн заамнаас нь барьж үүдний зүг чирэв. Тэв тэнгэр Отчигиныг эсрэг заамдан барьж барилдав. Тэв тэнгэрийн малгай барилдахад голомтны (тулганы) ард унав. Мунлиг эцэг малгайг нь авч үнсэж өвөр дээрээ тавив. Чингис хаан өгүүлрүүн: "Гарч бөх хүчээ сорилцогтун" хэмээв. Отчигин Тэв тэнгэрийг чирч гарахад үүд босгон зуур урьд бэлтгэсэн гурван бөх Тэв тэнгэрийг эсрэг бариад чирч гарч нурууг нь хугалж зүүн талын тэргэнүүдийн үзүүрт хаяж Отчигин орж [ирж] өгүүлрүүн: "Тэв тэнгэр намайг наманчлуулсан

бөлгөө. [Хүчээ] сорилдъёо гэвээс үл болон баширлан хэвтэнэ. Ялихгүй нөхөр ажтуу" гэвээс Мунлиг эцэг [учрыг] ухаж нулимс унаган өгүүлрүүн:

"Дайр этүгэнийг
Данласун[561] төдий бүхүйгээс
Далай мөрнийг
Горхин төдий бүхүйгээс

нөхөрлөв би" хэмээхүйд зургаан Хонхотан хөвүүд нь үүд [хаан] босч голомт тойрон байж ханцуйгаа шамлалдахад Чингис хаан **хирдхийн**[562] шахагдаж "Зайл! гаръя" хэмээгээд гарахын хамт Чингис хааныг орчин [байсан] хорчин, тургууд тойрон байв. Тэв тэнгэрийг тэргэнүүдийн үзүүрт нуруугий нь хугалж орхисныг Чингис хаан үзэж хойт уулаас нэгэн бор хошлог (гэр) авчруулж, Тэв тэнгэрийн дээр нь тавиулж "Хөлөг (хөсөг) оруулагтун! Нүүе" хэмээж тэндээс нүүв.


246. Тэвийг тавьсан хошлогийн **өрх бүтээж**[563] үүд дарж хүн сахиулбаас гурав дахь шөнө **үүр шарлахад**[564] гэрийн өрх нээж бие **сэлт гарчухуй**[565] . Болгоовоос магад Тэв нь тэнд [үгүй болсон нь] нотлогдов. Чингис хаан өгүүлрүүн: "Тэв тэнгэр дүү нарт минь гар хөл хүрсний тул дүү нарын минь хооронд оргүй **гүтгэн ховлосны**[566] тул тэнгэрт эс таалагдаж амь бие сэлтий [нь] авч одов оо" хэмээв. Чингис хаан Мунлиг эцгийг тэнд донгодруун: "Хөвүүдийнхээ авир [занг] үл ятган [бидэнтэй] тэнцэхийг бодож [явсаар] Тэв тэнгэрийн толгойд хүрэв та нар! Та нарын тийм авир [занг] ухаарсан бөгөөс Жамуха, Алтан, Хучартаны ёсоор болгох болой та нарыг" хэмээж Мунлиг эцгийг донгоджээ. Донгодож дуусаад жич

"Өглөө өгүүлснийг
Үдэш **задлабаас**[567]
Үдийн өгүүлснийг
Өглөө задлабаас

магад ичгүүр хэмээгдэх эл [гэж] урьд үг баригдлаа. **Зэ тэр**[568]" хэмээн соёрхож жич **тайтгарав**[569].

"Дээгүүр авираа татсан бөгөөс Мунлиг эцгийн урагт хэн тэнцэх бөлгөө" хэмээв. Тэв тэнгэрийг үгүй болгоод Хонхотан [нар] царай **алдчухуй**[570]

Арваннэгдүгээр бүлэг



ҮҮ

247. Түүний хойно Чингис хаан хонин жил (1211) Хятад иргэнд морилов. **Фү Жиүг**[571] авч, Үнэгэн даваагаар давж **Сөн дэи фүг**[572] авч Зэбэ, Гүйгүнэг баатар хоёрыг манлай [болгон] илгээв. Цавчаал хүрч, Цавчаал дабааанд (боомтод) **хаагдаж**[573], тэнд Зэбэ өгүүлрүүн: "Тэднийг өдөөж, хөдөлгөж ирүүлэн тэнд соръёо" хэмээж буцав. Буцахад хятадын цэргүүд "Нэхье"хэмээнуул **хөндий**[574] бүрхтэл нэхэж айсуй. Сөн дэи фүгийн хошуу хүрч, Зэбэ хойшоо [жолоо] **эргүүлэн татаж**[575] довтлон **ундарч**[576] айсуй дайсныг дарав. Чингис хаан гол цэргээ түргэлүүлж, хятадыг хөдөлгөн (хөөж) Хар хятад, Зүрчидийн харуулын эрэлхэг омогтон цэргүүдийг дарж, Цавчаал хүртэл өмх хожуул болтол хядаж, Цавчаалын хаалгыг Зэбэ авч даваад, булааж эзлэж, Чингис хаан **Шар тээгт**[577] буув. **Жүндүг**[578] довтлож, хот хот балгадад цэргүүд илгээж довтолгов. Зэбийг **Дүн-чан**[579] балгасанд довтолгон илгээв. Дүн-чан балгасанд хүрч эзлэн аван ядаж, буцаж зургаан хоногийн газар хүрч гэндүүлж жич [цэргээ] эргээн татаж гар хөтөлгөө [морьтой] шөнө дүллэж, гэнэт [ажиггүй] байхад [нь] хүрч [ирж] Дүн-чан балгасыг авав аа.

248. Зэбэ Дүн-чан балгасыг авч харьж ирж Чингис хаанд нийлэв. Жүн дүг довтлон [ороход] Алтан хааны их ноён **Вангин чинсан**[580] Алтан хаанд дуртгаруун: "Тэнгэр газрын заяан цаг их ор егүүтгэх (солигдох) цаг болов уу? Монгол маш хүчтэй ирж бидний эрэлхэг оморхог хар хятад, Зүрчидийн харуулын эрхэт цэргүүдийг дарж бүрэлгэн хяджээ. Итгэлт Цавчаалыг [бас] булааж авчээ. Эдүгээ бид бас цэрэг засаж гаргаваас ахин монголд дарагдваас **магад**[581] хот хотдоо бутарцгаана тэд. Жич бидэнтэй [хүчээр] **нийлүүлвээс**[582] үл зохицон бидэнд дайсан болж үл нөхцөнө тэд. Алтан хан соёрхвоос монголын ханд эдүгээ

элсэн эдьеэ. Эед орж монголыг буцваас буцсаны хойно бас бус санааг бид тэнд (тэр үед) зөвлөлдьеэ. Монголын эрс, агт [энэ] газар үл идээшин **хямралдмой**[583] хэмээлдэнэ. Ханд (хаанд) нь охин өгье. Алт мөнгө, эд агуурс цэргийн хүмүүст ихээр гаргаж өгье. Энэ арганд маань орох үгүйг хэрхэн мэднэ?" хэмээн дуртгаваас Алтан хан Вангин Чинсангийн энэ үгийг зөвшөөрч "Ийм бөгөөс болтугай" хэмээн элсэн, Чингис хаанд **Гүнжү**[584] нэртэй охиныг гаргаж, алт мөнгө, агуурс эд таваар цэргийн хүмүүнээ хүч мэдэн даахуйц Жүндүгээс гаргаж Чингис хаанд Вангин Чинсан хүргэж ирэв. Элсэн ирсэнд арганд нь орж, хот хотонд довтлон буусан цэргүүдийг хариулж буцаав. Вангин чинсан **Можиу**[585], **Фужиу**[586] нэрт хошуунд хүртэл Чингис хааныг үдэж харив. Эд агуурсыг манай цэргүүд даахуйц ачиж хивээр ачаагаа татаж явав.

249. Тэр [удаа] морилсоор Хашин (Тангуд) иргэнд зорчив. Зорчиж хүрвээс Хашин иргэний Бурхан (хан) элсэн "Баруун гар чинь болж хүчээ өгье" хэмээн Чаха нэртэй охиноо Чингис хаанд хүргэж өгөв. Бас Бурхан хан өгүүлрүүн: "Чингис хааны нэр алдрыг сонсож, **айж байлаа**[587] бид. Эдүгээ сүлдэт бие чинь хүрч ирж [сүр] сүлдээс [чинь] айв. Айж бид Тангуд иргэн баруун гар чинь болж хүчээ өгье" хэмээв. "Хүч өгөхөд:

Нунж[588] нутагтан
Нүдсэн [589] балгастан буй за.
Нөхцөж
Хурдан аян аялахад
Хурц дайн дайлалдахад
Хурдан аянд гүйцэж ядмуй зэ.
Хурц дайнд дайлалдаж ядмуй зэ бид.

Чингис хааныг соёрховоос бид Тангуд иргэн

Өндөр дэрсний нөмөрт
Өсгөж олон тэмээд бэлтгэж
Хааны [алба][590] болгож өгье
Ангийн[591] шувууд сургаж

Агуулж[592] сайныг нь хүргүүлэн атугай" хэмээн өчив. Өгүүлсэн үгэндээ хүрч Тангуд иргэдээсээ тэмээд гувчиж, багтаж ядтал авчирч өгөв.

250. Чингис хаан тэр [удаа] морилсонд хятад иргэний Алтан хааныг элсүүлж, олон [эд] агуурс авч, Хашин иргэний Бурханыг элсүүлж олон тэмээд авч, Чингис хаан хонин жил (1211) тэр морилсонд[оо] хятад иргэний Ахутай нэрт Алтан ханыг элсүүлж харьж, Саарь хээрт буув.

251. Бас түүний хойно **Жау гонд**[593]элсүүлэхээр илгээсэн Жубхан тэргүүтэн олон элч [нь] хятад иргэний Ахутай Алтан хаанаа хоригдож Чингис хаан нохой жил (1214) хятад иргэнд бас морилов. "Элсэн барж Жау гонд илгээсэн элчийг яахан хорих бөлгөө?" хэмээн морилохдоо Чингис хаан **Тун гуан**[594] амсар (боомт) зорьж, Зэбийг Цавчаалаар болгов. Чингис хааныг Тун гуан амсараар хүрэв хэмээн Алтан хан мэдэж Илэ, Хада, Хөбөгэтүр гуравт цэрэг мэдүүлж, цэрэг бөхлөж, **Улаан Дэгэлэнийг**[595] манлайлан засаж "Тун гуан амсарыг хамгаалан даваач бүү давуулагтун!" хэмээн Илэ, Хада, Хөбөгэтүр гурвын цэргийг хурдлан илгээжээ. Тун гуан амсар хүрвээс хятадын цэргүүд газар тулдаа дааж ирэв [гэмээр харагдана]. Чингис хаан Илэ, Хада, Хөбэгэтүр гуравтай байлдаж Илэ, Хадааг ухруулав. Толуй, Чүгү хүргэн хоёр хөндлөнгөөс довтлож, Улаан Дэгэлэнийг няцааж ирж Илэ, Хадааг хөөн дарж хятадыг өмх хожуул мэт хядав. Хятад цэргүүдээ хядаж барагдав хэмээн Алтан хан мэдэж Жүндүгээс гарч буруулан **Намгин (Нанжин)**[596]балгас оржээ. Үлдсэн цэргүүд нь турж үхэхдээ өөр зууpаа [алалдаж] хүний мах идэцгээв. Толуй, Чүгү хүргэн хоёр сайтар [үйл] үйлдэв хэмээн Чингис хаан Толуй, Чүгү хоёрыг машид соёрхов.

252. Чингис хаан **Хо си вүд**[597] **буугаад** [дараа нь] Жүндүгийн Шар хээр буув. Зэбэ Цавчаал хаалга эвдэж, Цавчаалыг хамгаалсан цэргүүдийг хөөж ирж Чингис хаанд нийлэв. Алтан хан Жүндүгээс гарахдаа Жүндүд Хада [ноёныг] **Лиү-Шиү (үлдэн хахигч)**[598] болгон тушааж одсон ажээ. Чингис хаан Жүндүгийн алт, мөнгө эд агуурс,

юмыг нь тоолуулахаар Өнгүр буурч, Архай Хасар, Шигихутуг гурвыг илгээв. Эд гурвыг айсуй хэмээн Хада эсрэг угтан алтат **артай**[599] [эд] агуурс бариад Жүндүгээс гарч угтан ирэв.

Хадад Шигихутуг өгүүлрүүн: "Урьд энэ Жүндүгийн эд [юмс] мөн Жүндү [ч] Алтан ханых [байсан] ажгуу. Эдүгээ Жүндү Чингис хааных буй за. Чингис хааны эд агуурсыг эчнээ яахан хулгайлж авчирч өгмүү чи? Би үл авна" хэмээж Шигихутуг эс авав. Өнгүр буурч, Архай [Хасар] хоёр авав. Эд гурав Жүндүгийн эд юмыг тоолж ирэв. Тэнд Чингис хаан Өнгүр [буурч], Архай [Хасар], [Шиги]хутуг гурваас "Хада юу өгөв?"хэмээн асуув. Шигихутуг өгүүлрүүн: "Алтат артай [эд] агуурс авчирч өглөө. Би өгүүлрүүн: "Урьд энэ Жүндү Алтан ханых [байсан] ажгуу. Эдүгээ Чингис хааных болов. Чи Хада, Чингис хааны эд [юмыг] эчнээгээр хулгайлж яахан өгмүү чи?"хэмээж би эс авав. Өнгүр [буурч], Архай [Хасар] хоёр өгснийг нь авлаа" хэмээв. Чингис хаан тэнд Өнгүр [буурч], Архай [Хасар] хоёрыг машид донгодов. Шигихутугийг "Их ёсыг сэтгэж чи" хэмээн машид соёрхож "үзэх нүд минь сонсох чих минь болж байх биш үү чи?" хэмээн зарлиг болов.

253. Алтан хан Намгин (Нанжин) орж өөрөө [саналааараа] элсэн мөргөж, Тэнгэр нэрт хүүгээ Зуун нөхдийн [хамт] Чингис хаанд тураг [цэрэг] болтугай хэмээн илгээжээ. Тэдний элссэнд Чингис хаан "буцъя" хэмээн Цавчаалаар тэнд буцахдаа Хасарыг зүүн гарын цэргүүдтэй далай хижин илгээхдээ: "**Буйгин (хойт нийслэл)**[600] балгас буугтун! Буйгин балгасыг элсүүлж, цаана нь Зүрчидийн Фуханүг дайран одож, Фухану дайсагнах санаарахваас дагуулагтун! [Даган] элсвээс түүний хязгаар балгадыг нь дайран Ула, Нау мөрнүүдийг хижин одож Таур мөрөн (Тоор гол) өөд давж их аурагт нийлэн ирэгтүн!" хэмээж илгээв. Хасартай, ноёдоос Жүрчидэй, Алчи, Толун чэрби гурвыг илгээжээ. Хасар Буйгин балгасыг оруулж Зүрчидийн Фуханүг элсүүлж мөр [дэх] балгас бүрийг [эзлэн] оруулаад, Хасар Таур мөрөн (Тоор гол) өөд ирж их аурагт бууж ирэв.

254. Түүний хойно Чингис хаан Сартуул иргэнээ Ухуна

тэргүүтэн зуун элчээ хөрьж алагдсанд Чингис хаан өгүүлрүүн: "Алтан аргамжаа Сартуул иргэнд яахан таслуулах бөлгөө?"хэмээн Ухуна тэргүүтэн зуун элчийнхээ [төлөө]өшил өшин, хясал хясан Сартуул иргэнд моилъёо хэмээн морилохуйд, тэнд Есүй хатан Чингис хаанд дуратхан өчрүүн:

"Хаан
Өндөр даваа даван
Өргөн мөрөн гэтлэн
Урт аян аялан
Олон улсаа түвшитгэхийг бодов.
Төрсөн эл амьтанд мөнх үгүй ажгуу.
Нэүл мэт бие чинь
Нэхэс [хийж] одвоос
Нийтгэл мэт улсаа
Хэнд [мэдүүлнэ] гэмүү?
Тулгуур мэт бие чинь
Тулбис [хийж] одвоос
Туял мэт улсаа
Хэнд [мэдүүлнэ] гэмүү?

Төрсөн дөрвөн хүлэг хөвүүд юүгээн хэнийг нь хэмээмүү? Хөвүүд дүү нар олон харцас мануус үл ухаарч сууна. Санаснаа дурдсан [минь энэ] билээ. Зарлиг мэдтүгэй" хэмээн өчвөөс Чингис хаан зарлиг болруун: "Хатан хүмүүн бөгөөтөл Есүйн үг зөвөөс зөв! Дүү нар хөвүүд та нар, Боорчу, Мухулитан хэн нь ч ийн эс дуртгабай. Би ч:

Урдахыг үл удаарахаас
Умартаж [явсан] ажгуу
Үхэлд үл эрэсдэхээс
Унтарч [санасангүй] ажгуу"хэмээгээд

"Хөвүүдийн минь ах Жөчи буй за юу хэмээмүү чи хэл"хэмээв. Жөчийг дуугарахын урьд Цагаадай өгүүлрүүн: "Жөчийг хэл хэмээхдээ Жөчийг юүгий [нь] түшиж өгүүлмүй? Энэ мэргэдийн **цулхалзуурт**[601] бид хэрхэн мэдүүлнэ?"хэмээхүйд Жөчи

босоод Цагаадайн заамнаас шүүрч өгүүлрүүн: “Хан эцэгт бусдын [гэж] эс хэлэгдлээ. Чи намайг хэрхэн ялгамуй? Ямар эрдмээр илүү [вэ] чи? Гагц хэцүүгээрээ (догшноороо) магад илүү [чинь] энэ [биз] чи!

Онтдож (харваж) чамд гартваас
Эрхийгээ огтлож **огоорсугай**[602]
Абалдаж барилдаж чамд ялагдваас
Унасан газраас бүү боссугай!

Хан эцгийн зарлиг мэдтүгэй!”хэмээв. Жөчи, Цагаадай хоёр заамаасаа барилцаж байн бүхүйд Жөчийн гараас Боорчу татаж Цагаадайн гараас Мухули татаж бүхүйд Чингис хаан [үзэж] сонссон [боловч] сэм сууж байв. Тэнд Хөхөчос зүүн этгээдэд сууж өгүүлрүүн: “Цагаадай яахан яарна чи? Хан эцэг чинь хөвүүдийнхээ дотроос чамайг эрмэлзэж [байсан] бөлгөө. Таныг төрөхийн урьд:

Одтой тэнгэр
Орчиж бөлгөө
Олон улс тулалдан бөлгөө
Орондоо үл орон
Олзлолдон бөлгөө
Хөрст этүгэн (газар)
Хөрвөж бөлгөө.
Гүрэн улс тулалдан бөлгөө.
Хөнжилдөө үл хэвтэн
Гөрлөлдөн[603] бөлгөө

тийм цагт:

Хүслээр эс явав зэ.
Гөрөлцэхүй дор хүрэв зэ
Буруулаж эс явав
Булхалдахуй (байлдахуй) дор хүрэв зэ
Амарч эс явав зэ
Алалдахуй дор хүрэв зэ
Богд, хатан эх юүгээ
Тосон санааг **царцуулж**[604]

Сүүн сэтгэлийг ээдүүлж өгүүлмүй чи!
Бүлээнээс бүлт [гэж]
Мөн хэвлийгээс эс төрлүү та?
Халуунаас халт [гэж]
Гагц хуухнагаас[605] эс гарлуу та?
Зүрхнээс төрсөн эх юүгээ буруутгаваас
Сэтгэл нь **хөрөж**[606] тайтгаруулж үл болюу
Хан эцэг тань
Хамаг улсыг байгуулахад
Хар тэргүүнээ ганзагалаж
Хар цусаа намбухлаж (савлаж)
Хар нүдээ ирмэс үл хийн
Хавтгай чихээ дэрэнд үл тавин
Ханцуйгаа дэрлэж
Хормойгоо дэвсэж
Шүлсээрээ ундлаж
Шигч [махаар][609] хоноглож
Магнайн хөлс
Уланд хүртэл
Улны хөлс
Магнайд гартал
Өрсөлдөн[610] хичээж явах цагт
Эх тань хамтаар зовохдоо
Горойтол[611] богтлож
Огдойтол[612] бүслэж
Нятайтал[613] богтлож
Нядартал (тасартал) бүслэж
Таныгаа өсгөхдөө
Залгих зуураа
Зармийгаа өгч
Хоолойгоо **хорчигнуулж**[614]
Хотлыгоо өгч
Хоосон явах бөлгөө
Эгэмнээс тань татаж

Эрийн сацуу болгох [гэж]
Хүзүүнээс тань татаж
Хүний сацуу болгох гэж
Бойг[615] тань тэнийлгэж
Эрийн эгэмд
Агтын харгамд хүргэж
Эдүгээ та нарынхаа
Сайныг үзье хэмээн
Санаж байгаа биш үү?
Богд хатан бидний [эх]
Наран мэт гэгээн
Нагур мэт дэлгэр сэтгэлт бөлгөө" хэмээв.

255. Тэндээс Чингис хаан өгүүлрүүн: "Жөчийг яахан тийн хэлнэ чи? Хөвүүдийн минь ах Жөчи биш гэж үү? Дараа тэгэж бүү хэлэгтүн!"хэмээн зарлиг болов. Энэ үгэнд Цагаадай мушилзаж өгүүлрүүн: "Жөчийн хүч, эрдмийн хариуг үл өгүүлэн
Амаар алсаныг
Ачиж үл болно
Үгээр үхүүлсэнийг
Өвчиж үл болно
Хөвүүдийн ах Жөчи бид хоёр буй за.
Хан эцэгтээ
Хамсан[616] хүчээ өгье
Дальдарснаа
Далба цавчилдъяа.
Хожимдсоныхоо боривыг
Хянгардан цавчилдъяа
Өгэдэй л эелдэг дөлгөөн буй
Өгөдэйг хэмээлдье.
Өгөдэй хан эцгийн дэргэд байж бараа их малгайн **байдал ёсыг**[618] таниваас болюу зэ" хэмээв. Энэ үгд Чингис хаан өгүүлрүүн: "Жөчи юу хэмээмүү хэлэгтүн!" хэмээв. Жөчи өгүүлрүүн: "Цагаадай нэгэнт өгүүлэв. Цагаадай бид хоёр хамсан хүчээ өгье. Өгөдэйг

хэмээлдье" гэв. Чингис хаан зарлиг болруун: "Хамсах [чинь] юу буй? Этүгэн эх агуу буй. Ус мөрөн олон буй. [Алгуу] салгуу шиг нутгаа уужимсгаж харь [орныг] даргалан салгая"хэмээгээд "Жөчи, Цагаадай хоёр үгэндээ хүрэгтүн!
Иргэдийн инээдэм
Амьтны **ханиадам**[619] бүү бологтүн!
Эрт Алтан, Хучар хоёр энэ мэтээр үг барилдаж, жич үгэндээ үл хүрсний тул хэрхсэн билээ? **Ямар** [юм] болсон билээ? Эдүгээ Алтан, Хучар хоёрын ургуудаас та нарт тасдан [өгье]. Тэднийг үзэж [явбал] юунд осолдоно та нар!" хэмээгээд "Өгөдэй юу хэмээмүү хэл" гэв. Өгөдэй өгүүлрүүн: "Хаан эцэг соёрхож өгүүл хэмээсэнд юугаа өгүүлнэ би? Үл чадна хэмээн хэрхэн өгүүлэх [бөлгөө]? Чадахаар хатуужсугай хэмээмүү зэ. Мөнөө хойно магад урагт минь
Өлөнд хучивч
Үхэр үл идэх
Өөхөнд хучивч
Нохой **үл идэхээр**[620] төрвөөс
Хандгай **байтугай**[621]
Хулгана **цөлж алд юу**[622]
Өдийд юугаа хэлнэ. Өөр юү өгүүлнэ би" хэмээв. Энэ үгэнд Чингис хаан зарлиг болруун: "Өгөдэй ийм үгс өгүүлэх бөгөөс болно зэ" хэмээв. Бас "Толуй юу хэмээмүү хэл" хэмээв. Толуй өгүүлрүүн: "Би хаан эцгийн нэрийдсэн ахынхаа дэргэд байж
Умартсаныг нь дуртгаж
Унтарсныг нь сэрүүлж
Зээгийн нөхөр
Зээрдийн ташуур болж
Зээгээс үл хоздон
Зэргээс үл хоздон
Уртын аянд аялж
Ойрын дайнд дайтаж өгье" хэмээн өгүүлбээс Чингис хаан зөвшөөж зарлиг болруун: "Хасарын ураг нэгнээрээ мэдүүл! Алчидайн ураг нэгнээрээ мэдүүл! Отчигины ураг нэгнээрээ

мэдүүл! Бэлгүдэйн ураг нэгнээрээ мэдүүл! Тэр ёсоор миний ургийг [мөн] нэгнээр нь мэдүүлж миний зарлигийг үл өөрчлөн эс задлабаас үл эндэн, үл алдана та нар.

Өгөдэйн урагт
Өлөнд хучивч
Үхэр үл идэх
Өөхөнд хучивч нохой үл идэхээр төрвөөс

миний ургийн [аль] нэгэнд сайн [хөвүүн] үл төрнө гэж үү?" хэмээн зарлиг болоод

256. Чингис хаан морилохдоо Тангуд иргэний Бурханд элч илгээрүүн: "Баруун гар чинь болъёо хэмээсэн бөлгөө чи. Сартуул иргэнтэй алтан аргамжаа тасалдаж [учир] ололцохоор морилов би. Баруун гар болон морил!"хэмээж илгээвээс Бурханыг дуугарахаас урьд Аша Гамбу өгүүлрүүн: "Хүч ядуу бөгөөтөл хан (хаан) юунд болов?" хэмээн цэрэг үл нэмэрлэн их үг өгүүлж илгээжээ. Тэнд Чингис хаан өгүүлрүүн: "Аша Гамбуд хэрхэн ийн хэлүүлэх бөлгөө?" хэмээн "Аргацаан эд нарруу **хольбирон**[623] зорьж хүрвээс юуны бэрхтэй бөлгөө. Чухам өөр хүмүүнд зорьж бүхүйд энэ тэрнийг [орхиё!] Мөнх тэнгэрт ивээгдэж алтан жолоо батдан татаж ирвээс [дараа] тэнд магад болтугай! Зэ тэр!" хэмээж

257. Туулай жил (1219) Сартуул иргэнд Арайгаар даван морилоход Чингис хаан хатдаас Хулан хатныг аван аялруун. Дүү нараас Отчигин ноёныг их аурагт түшиж [үлдээн] морилов. Зэбийг манлай [болгон] илгээв. Зэбийн араас Сүбээдэйг илгээв. Сүбээдэйн араас Тохучарыг илгээв. Энэ гурвыг илгээхдээ: "Гадуур [нь тойрч] одож Султаны цаана гарч биднийг хүрэхэд хамсагтун!" хэмээн илгээв.

Зэбэ тийн одож хан Мэлигийн [хот] балгасыг дайрч үл хөндөн гадуур нь өнгөрчээ. Түүний хойноос Сүбээдэй мөн ёсоор үл хөндөн өнгөрчээ. Түүний хойноос Тохучар хан Мэлигийн хязгаар балгадыг эзлэн тариачдыг нь дээрэмджээ. Хан Мэлиг балгадаа эзлэгдлээ хэмээн дайжин хөдлөж **Жалалдин султанд**[624] [ирж] нийлэв. Жалалдин султан, Хан Мэлиг хоёр Чингис хааны

эсрэг морилжээ. Чингис хааны урд Шигихутуг манлай [болж] явав. Шигихутугтай байлдаж Жалалдин султан, Хан Мэлиг хоёр Шигихутугийг дарж Чингис хаанд хүртэл довтлон айсуйд Зэбэ, Сүбээдэй, Тохучар гурав Жалалдин султан, Хан Мэлиг хоёрын хойноос орж жич тэднийг дарж хядаад, Бухар (Бухара), Сэмисгаб (Самарканд), Утарар (Утрар) балгасанд тэднийг үл нийлүүлэн дарж, Шин мөрөн хүртэл үлдэн [хөөж] явахад Шин мөрөнд жив тусч орох болоход олон Сартуулаа тэнд Шин мөрөнд **сөнөөв**[625]. Жалалдин султан, Хан Мэлиг хоёр амиа хоргоон Шин мөрөн өөд дутаав. Чингис хаан Шин мөрөн өөд зорчиж Бадхэсэнийг (Бадахшан) туулан одож Эх горхи, Гүүн горхинд хүрч Бараан хээрт бууж Жалайрдай Балааг Жалалдин султан, Хан Мэлиг хоёрыг нэхүүлэн илгээж Зэбэ, Сүбээдэй хоёрыг маш соёрхож "Зэбэ чи Зургаадай нэрт бөлгөө. Тайчуудаас ирж Зэбэ [нэртэй] болов оо чи" Тохучарыг "Хан Мэлигийн хязгаар балгадыг өөрийн дураар эзэгнэн түрэмхийлж Хан Мэлигийг дайжуулав [хэмээн]засаглан мөхөөе" хэмээн хэлэлцсэн [боловч] жич үл мөхөөн машид донгодож цэрэг мэдэх [эрх] ээс нь буцаан буулгав.

258. Төдий Чингис хаан Бараан хээрээс харьж Жөчи, Цагаадай.Өгөдэй гурван хөвүүдийг "Баруун гарын цэргүүдээр Амуй мөрөн гэтэлж Өрүнгэчи (Гурганж) балгас буугтун!" хэмээн илгээв. Толуйг "Ирү (Ирү буюу Мару), Исэбүр (Нисэбүр) тэргүүтэн олон балгадыг [эзлэн] буугтун!" хэмээн илгээв. Чингис хаан өөрөө Утарар балгасанд буув. Жөчи, Цагаадай, Өгөдэй гурван хөвүүд өчиж [элч] илгээрүүн: "Цэргүүд маань бүрдэв. Өрүнгэчи балгас хүрэв. Хэнийхээ үгээр явна бид?" хэмээн өчиж илгээвээс Чингис хаан зарлиг болруун: "Өгөдэйнхээ үгээр явагтун!" хэмээж илгээв.

259. Төдий Чингис хаан Утарар балгасыг оруулж [авч] Утарар балгасаас хөдөлж Сэмисгаб балгаст буув. Сэмисгаб балгасаас хөдөлж Бухар балгас буув. Тэнд Чингис хаан Балааг хүлээж Алтан горхины нуруунд Султаны зусланд зусаж Толуйд элч илгээв. "Халуун цаг болов. Бусад цэргүүд бууцгаажээ. Чи бидэнд [ирж] нийл!" хэмээж илгээвээс Толуй Ирү, Исэбүр зэрэг

балгадыг авч Систэн (Систан) балгасыг эвдэн бүхийд элч энэ хэлийг хүргэвээс Толуй Чухчэрэн балгасыг эвдээд эргэн бууж ирээд Чингис хаанд нийлэв.

260. Жөчи, Цагаадай, Өгөдэй гурван хөвүүд Өрүнгэчи балгАсыг оруулж гурвуул балгад иргэдийг хуваалцаж Чингис хаанаа хувь эс гаргасанд эд гурван хөвүүдийг бууж ирэхэд Чингис хаан Жөчи, Цагаадай, Өгөдэй гурван хөвүүдийг чамлаж гурван өдөр эс уулзуулав. Тэнд Боорчу, Мухули, Шигихутуг гурав өчүүн: "Өжин мэлзэж агсан Сартуул иргэний Султаныг доройтуулж, балгад иргэдийг нь [эзлэн] авав бид. Хуваагдаж автах Өрүнгэчи балгас, хуваалдан авах хөвүүд бүгд Чингис хааных буй. Тэнгэр газарт хүч нэмэгдэж Сартуул иргэнийг ингэж доройтуулсанд бид олон эрс, агт чинь баясч **бахдаж**[626] амуй. Хаан яахан ийн хилэгнэж буй? Хөвүүд буруугаа ухаарч айцгааж байна. Хойч хойчдоо суртугай! Хөвүүд авир [зангаа] алгасуузай! Соёрховоос уулзуулбал болно уу?" хэмээн өчвөөс Чингис хаан тайтгарч Жөчи, Цагаадай, Өгөдэй гурван хөвүүдийг уулзуулж донгодоход:

Өтгөс үгс ишлэж
Хуучин үндэслэж
Байсан газар
Багтан алдтал
Магнайн хөлс

Арчин ядтал **буруушааж**[627] [машид] зэмлэн соёрхол дуулган бүхийд Хонхай хорч, Хонтагар хорч, Чормахан хорч эдгээр гурван хорч Чингис хаанд өчүүн: "Бор шувуу **буйлаанд**[628] сая орох мэт хөвүүд сая өдий аялан сурч бүхийд хөвүүдийн [зүрхийг] шантлан **мэнэ**[629] мэт яахан ингэж донгодно? Хөвүүд айж сэтгэлээ алгасуузай! Наран шингэхээс ургах [зүг] хүртэл дайсан иргэн буй. Маныг **төвд**[630] ноход [мэт] тухирч илгээвээс дайсан иргэн [дарж] бид тэнгэр газарт хүч нэмэн, алт мөнгө, агуурс таваар, ард иргэдийг чамд авчирсугай! Аль иргэн хэмээвээс энэ өрнө Багдад иргэний Халибай султан (Багдадын эзэн Насир Калиф) гэгч буй хэмээмой. Түүнд бид аялсугай" хэмээн

өчвөөс хаан **сэхээрч**[631] эдгээр үгст тайтгарч Чингис хаан зөвшөөж зарлиг болруун: Хонхай, Хонтагар, Чормахан гурван хорчийг соёрхож Адаргидайн Хонхай, Долонгирдайн Хонтагар хоёрыг "Миний дэргэд байтугай!" [гээд] Өтэгэдэйн Чормаханыг Багдад иргэнд Халибай Султанд аялуулав.

261. Бас Хиндус (Энэдхэг) иргэн Багдад иргэн хоёрын завсарт Ару, Мару, Мадасари иргэний Абту балгасанд Дөрбэдийн Төрбэй догшныг аялуулав.

262. Бас Сүбээдэй баатрыг **умар тийш**[632] Ханлин, Кибчагууд, Бажигид (Башкир), Оросууд, Мажарууд, Асуд, Сасуд, Сэркэсүүд (Хиргис), Кэшимир, Болар (Болгар), Рарал (Лала) эдгээр арван нэгэн аймаг харь иргэнд хүртэл Адил (Ижил), Жаяг (Урал) ус мөрөн гэтлэж Кивамэн (Киев) Кэрмэн балгасанд хүртэл Сүбээдэй баатрыг аялуулав.

263. Бас Сартуул иргэнийг авч бараад Чингис хаан зарлиг болж балгад балгадад дарга тавьж [бүхүйд] Өрүнгэчи балгаснаас Ялавачи, Масхуд нэрт эцэг хөвүүн хоёр **Хурумши**[633] овогтон сартуул ирж Чингис хаанд балгасны ёс төр өгүүлжээ. Ёсыг [хэн хэн нь] адил [сайн] мэдэн өгүүлсэн [тул] хөвүүн Масхуд хурумшийг нь бидний дарга нартай Бухар, Сэмисгаб, Өрүнгэчи, Удан (Хотан), Кисгар (Кашгар), Уриян (яркан?), Гүсэн Дарил (Күсэн Тарили) тэргүүтэн балгадыг мэдүүлэн түшиж эцэг Ялавачийг нь авчирж хятадын Жүндү (Бээжин) балгасыг мэдүүлэн суулгав. Сартагтай хүмүүнээс Ялавачи, Масхуд хоёр [хот] балгасны төр ёсыг [мэдэж] чадахын тул хятад иргэнийг захируулан [манай] дарга нарыг түшүүлэв.

264. Сартуул иргэнд [Чингис хаан] долоон жил явж тэнд Жалайрдай Балааг бүхүйд Бала Шин мөрнийг гэтэлж Жалалдин султан, Хан Мэлиг хоёрыг Хиндүсийн газар хүртэл нэхэж Жалалдин султан, Хан Мэлиг хоёрыг алдаж, Хиндүсийн дунд хүртэл эрж ядаад буцаж Хиндүсийн хязгаар иргэнийг [эзлэн] дагуулаад олон тэмээ, олон сэрхийг [олзолж] аваад иржээ. Тэнд Чингис хаан харих зуур Эртис (Эрчис) [мөрөнд] зусаж долдугаар он тахиа жилийн (1225) намар Туулын хар шугуйн ордонд буув.

Арванхоёрдугаар бүлэг



265. Тэр өвөл өвөлжиж тангуд иргэнд морилъё хэмээн [цэргээ] шинээр тоо тоолж нохой жилийн (1226) намар Чингис хаан тангуд иргэнд морилов. Хатдаас Есүй хатныг авч одов. Зуур [замд] өвөл **Арбухын**[634] олон хуланг авлахад Чингис хаан **Зост борыг**[635] унаж [явсан] бөлгөө. Хулангууд дайрч ирэхэд Зост бор үргэж Чингис хаан мориноос унахад мариа [мах] нь маш [ихээр] өвдөж **Цоорхад**[636] буув. Тэр шөнө хоноод маргааш нь Есүй хатан өгүүлрүүн: "Хөвүүд ноёд хэлэлцэгтүн! Хаан шөнө бие нь халуурч хонов" хэмээв. Тэнд хөвүүд ноёд хурахад Хонхотадай Толун Чэрби дуратхан өгүүлрүүн:

"Тангуд иргэн
Нүдсэн балгастан
Нунж нутагтан буй
Нүдсэн балгасаа үүрч
Үл одно тэд
Нунж нутгаа гээж
Үл одно тэд. Бид буцаж хааны бие **халуун намдваас**[637] бас жич морилъё бид" хэмээвээс бүх хөвүүд ноёд энэ үгийг зөвшөөж Чингис хаанд өчвөөс Чингис хаан өгүүлрүүн: "Тангуд иргэн биднийг зүрх алдаж харив хэмээнэ. Бид магад элч илгээж, элчийг мөн энэ Цоорхадад [хүлээж биеэ] сувилж үгийг нь мэдэж [авч] буцваас болно" хэмээжээ. Тэнд элчээр үг бариулж илгээрүүн: "**Ноднин**[638] [жил нь] Бурхан чи өгүүлрүүн: "Бид тангуд иргэн баруун гар чинь болъё" хэмээв. Чамайг тэгэж хэлсэнд Сартуул иргэнийг эрхэндээ оруулахаар морилъё хэмээн гуйж илгээвээс Бурхан чи үгэндээ үл хүрэн цэргээ үл өгөн үгээр дайрч

ирүүлж билээ. Өөр [юманд] зорьсон тул хойно [учраа] ололцъё хэмээн Сартуул иргэнд морилж мөнх тэнгэрт ивээгдэж Сартуул иргэнийг зүгт оруулж эдүгээ Бурхан [чамтай] үг ололцъё хэмээн айсуй" хэмээж илгээвээс Бурхан өгүүлрүүн: "Дайрах үгийг би эс өгүүлэв" хэмээжээ. Аша Гамбу өгүүлрүүн: "Дайрах үгсийг би өгүүллээ. Эдүгээ монголчууд та нар бөгөөс хатгалдахыг сурч хатгалдъя хэмээвээс би бол Алаша нутагт

Тэрэм (ханан) гэрт
Тэмээн ачаат буюу

Алаша зорьж надад ирэгтүн! Тэнд хатгалдъя! Алт, мөнгө, агуурс, таваар хэрэгтэй бөгөөс **Яргай**[639] **Эрижэүг**[640] зоригтун" хэмээж илгээжүхэй. Энэ үгийг Чингис хаанаа хүргэвээс Чингис хаан ба бие халуунтай байсан [боловч ийн] өгүүлрүүн: "За тэр! Ийм их үг хэлүүлж [байж] хэрхэн няцаагдана? Үхсэнч [энэ] их үгэнд шавдан явъя!" хэмээж "Мөнх тэнгэр чи мэд!" хэмээн Чингис хаан Алаша зорьж хүрч Аша Гамбутай хатгалдаж, Аша Гамбуг дарж, Алаша [уулан] дээр хороолуулж [байсан] Аша [Гамбуг] авч тэрмэн гэрт, тэмээн ачаат иргэдийг нь үнэсээр хийстэл талуулав. Эрхин омогтон **эрс**[641] сайн тангудыг хядаж, ийм тиймхэн тангудыг цэргийн хүмүүст "Барьсан, олсоноо авагтун!" хэмээн зарлиг болов.

266. Чингис хаан **Цаст [уулан]**[642] дээр зусаж Аша Гамбутай ууланд гарагсад, дайжигсад тэрэм гэртэн тэмээн ачаатан тангудыг цэрэг илгээн **анасанаараа**[643] үлдэн талуулав. Тэндээс Боорчу, Мухали хоёрт соёрхохдоо: "Хүчээ мэдтэл автугай" хэмээн зарлиг болов. Бас Чингис хаан зарлиг болруун: "Боорчу, Мухали хоёрт соёрхол өгөхдөө "Хитан иргэнээс эс өглөө" хэмээн Хитан иргэний **зүйинийг**[644] та хоёр адил хувааж авагтун! Сайн хөвүүдээр нь шувуугаа бариулж дагуулж явагтун! Сайн охидыг нь өсгөж эмсийнхээ хормойг засуулж байгтүн! Хитан иргэний Алтан ханы итгэлтэн янагууд монголын эцэг өвгөдийг барсан хар хитаны зүйиң иргэн ажгуу. Эдүгээ миний итгэлт янагууд Боорчу, Мухали та хоёр буюу" хэмээн зарлиг болов.

267. Чингис хаан цаст [уулнаас] хөдөлж Яргай балгас

бууж Яргай балгаснаас хөдөлж **Дөрмэгэй**[645] балгасыг эвдэж байхад Бурхан Чингис хаантай уулзахаар ирэв. Тэнд Бурхан уулзахдаа алтан **суврага**[646] тэргүүлэн алт мөнгөн аяга сав есөн ес, хөвүүд, охид есөн ес, морь тэмээд есөн ес, элдэв [зүйлийг] ес есөөр зүслэн [барьж] уулзахад Бурханыг үүдэн **саравчинд**[647] уулзуулав. Тэр уулзахуйд Чингис хаан дотор дур гутав. Гутгаар өдөр Чингис хаан зарлиг болруун: "Илуху Бурханд "Шудрага" нэр өгч Илуху Бурхан "Шудрагыг" ирүүлж тэнд Чингис хаан "Илухууг нөгчөөгтүн!"хэмээн "Толун чэрби гардаж нөгчөөтүгэй" хэмээн зарлиг болов. Тэнд Толун чэрби "Илухууг гардаж бүтэж [алав]" хэмээн өчвөөс Чингис хаан зарлиг болруун: "Тангуд иргэнтэй үг ололцохоор айсуйд [зам] зуур Арбухын хулан авлахад бэртсэн биеийг минь анагаатугай хэмээн амь биеийг минь хайрлаж үг дуртгагсан [нь] Толун буй за. Нөхөр хүний хорон үгэнд ирж мөнх тэнгэрт хүч нэмэж гартаа оруулж өсөө авлаа бид. Илухугийн энэ авч ирсэн **нүүдлийн харш**[648] аяга сав сэлтийг Толун автугай" хэмээн зарлиг болов.

268. Тангуд иргэнийг дагуулж Илуху Бурханыг "Шудрага" [нэрт] болгож түүнийг бүтэж [алж] тангуд иргэний эх эцэг ургийн ураг хүртэл **мохол мушгил**[649] үгүй болгон "Идээ идэх зууraa [ч] мохол мушгил үгүй үхүүлэн барав хэмээн хэлж байгтун!" хэмээн зарлиг болов. Тангуд иргэн үг хэлэлцэж үгэндээ үл хүрсэний тул тангуд иргэнд Чингис хаан ахин аялаж тангуд иргэнийг мохоож ирж гахай жил (1227) Чингис хаан тэнгэрт халив. Хальсаны хойно Есүй хатанд тангуд иргэнээс маш [их] өгөв.

269. Хулгана жил (1228) Цагаадай, Бат тэргүүтэн баруун гарын хөвүүд Отчигин ноён, Егү, Есүнхэ тэргүүтэн зүүн гарын хөвүүд, Толуй тэргүүтэн голын хөвүүд, охид, хүргэд, түмэт мянгатын ноёд бүрэн болж [ирж] Хэрлэний **хөдөө аралд**[650] гүрэн [даяар] хурж Чингис хааны нэрийдсэн мөн зарлиг [ёсоор] Өгэдэй хааныг хан өргөв. Цагаадай ах, Өгөдэй хааныг дүү юүгээ хан өргөж Чингис хаан эцэг юүгээ хан алтан амийг сахиж байсан хэвтүүл, хорчин, найман мянгат тургууд хан эцгий минь биеийн

захад (дэргэд) явж байсан өмч түмэн хэшигтнийг нь Цагаадай ах Толуй хоёр Өгөдэй хаанд дагуулав. Голын улсыг мөн ёсоор дагуулав.

270. Өгөдэй хаан өөрийгөө хан өргүүлж [ойр] дотно явах түмэн хэшигтэн, голын улсыг өөртөө болгуулан барж, урьд Цагаадай ахтай зөвлөж Чингис хаан эцгийнхээ [дутуу] **дурган орхисон**[651] улсын Багдад иргэний Халибай Султанд аяласан Чормахан хорчийн араас Оготор, Мөнхөт хоёрыг аялуулав. Бас урьд Ханлин, Кибчагууд, Бажигид Оросууд, Асуд, **Сэсүд**[652], Мажар, Кэшимир, Сэркэсүүд, Бухар, Хэрэл иргэнд хүртэл Адил, Жаяг ус мөрөн гэтэлгэн Мэгэд Мэн-Кэрмэн, **Кэйибэ (Киев?)**[653] тэргүүтэн балгадад аялсан Сүбээдэй баатар тэдгээр иргэдэд **хүчирдэж**[654] Сүбээдэйн араас Бат, Бүри, Гүюг, Мөнх тэргүүтэн олон хөвүүдийг морилуулав. Эдгээр аялсан бүх хөвүүдийг "Бат ахалтугай!" хэмээн зарлиг болов. "Гол [улс] аас гарагсадыг Гүюг ахалтугай!" хэмээн зарлиг болов. "Энэ аялалд улс [иргэдийг] мэдэгч хөвүүд, [өөрсдийн] хөвүүдийнхээ их хүүг аялуултугай! Улс [иргэдийг] үл мэдэгч хөвүүд түмэт, мянгат, зуут аравтын ноёд олон иргэд хэн бөгөөс хөвүүдийнхээ ахмадыг аялуултугай! Охид, хүргэд мөн ёсоор хөвүүдийнхээ ахмадыг аялуултугай!" хэмээн зарлиг болоод бас Өгөдэй хаан өгүүлрүүн: "Энэ бидний хөвүүдийн ахмадыг аялуулах ёсыг Цагаадай ахаас [санал] болгов. Цагаадай ах хэл илгээхдээ: "Сүбээдэйн араас хөвүүдийнхээ ахмад бүрийг аялуулмуу. Хөвүүдийн ахмад аялбаас цэрэг арвин гарна. Цэрэг олон болбоос царайн дээрээ [харваас] хүчтэй явна. Цаана дайсан хүн олонтой харьтан [улс] буй. Тэр үзүүр [талын] хэцүү иргэн тэд [мөн]. Тэд хилэгнэвээс өөрсдийн мэсэндээ үхэх иргэн [гэнэ]". Бас мэс хурцтай хэмээгдмой" гэж илгээжээ. Өгөдэй хаан өгүүлрүүн: "Тэр үгэнд бид Цагаадай ахын хичээнгүй хүчээр хөвүүдийн ахыг гаргая хэмээн зүг зүг тунхаглаж Бат, Бүри, Гүюг, Мөнх тэргүүтэн дөрвөн хөвүүдийг аялуулсан ёс ийм буй за".

271. Бас Өгөдэй хаан Цагаадай ахад зөвлөж илгээрүүн: "Чингис хаан эцгийнхээ бэлэн [сууринд] суув. Ямар эрдмээр [хаан]

суув? хэмээн би өгүүлюү. Цагаадай ахыг зөвшөөрвөөс бидний хаан эцэг, хитан иргэний Алтан ханыг дутуу орхисныг [эзлэхээр] эдүгээ би хитан иргэнд морилъё" хэмээн зөвлөж илгээвээс Цагаадай ах зөвшөөж "Юу алзана. Аурагтаа сайн хүн түшин [үлдээж] морилогтун! Би эндээс цэрэг гаргаж илгээе" хэмээж [хариу] илгээжээ. Их ордонд Олдагар хорчийг түшиж

272. Туулай жил (1231) Өгөдэй хаан хитан иргэнд морилж Зэбийг манлайд илгээв. Төдий хитан цэргүүдийг дарж өмх хожуул мэт хядаад Цавчаалыг давж зүг зүг хот балгадад цэрэг довтолгон явуулж Өгөдэй хаан Шар тээгт буув. Тэнд Өгөдэй хаан өвчин хүрч ам хэл **алдран**[655] алжаахад бөө [нар] төлөгчинд төлөглүүлбээс хитан иргэний газар усны эзэд, хаад, ард иргэдээ эзлэгдэж, хот балгадаа эвдүүлсэнд даруй адлаж баймой. Ард иргэн алт, мөнгө, агуурс идээгээр золиос өгье хэмээн **аргадваас**[656] үл тавигдан улам түргэнээр адлав. Ургийн хүнээс болно уу? хэмээн аргадваас хаан нүдээ нээж ус гуйж ууж "Юу болов?" хэмээн асуусанд бөө нар өчрүүн "Хитан иргэний газар усны эзэн хаад газар усаа эвдүүлж ард иргэнээ эзлэгдэхэд даруй адлав. Өөр юмаар золио өгье хэмээн аргадваас улам түргэн **зууралдмой**[657]. Ургийн хүмүүнээс болно уу? хэмээвээс тавигдмой. Эдүгээ зарлиг мэднэ зэ" хэмээн өчвөөс зарлиг болруун: "Дэргэд хөвүүдээс хэн байна" гэвэл Толуй хөвүүн дэргэд байж өгүүлрүүн: "Суут Чингис хаан эцэг бидний дээр ах нар доор дүү нар [буй] бөгөөтөл хаан ах таныг

Агт мэт шинжиж
Ирэг мэт **ялгаж**[658]
Их ороо биед чинь **тохоож**[659]
Олон улсыг дээр чинь ачиж
Одов оо зэ
Намайг болбоос хаан ахын дэргэд байж
Умартсаныг [нь] дуртгаж
Унтарсаныг [нь] сэргээж яв

Хэмээсэн бөлгөө. Эдүгээ хаан ах чамайгаа алдваас би хэний
Умартсаныг дуртгана? Хэний

Унтарсаныг сэрээнэ?

Үнэхээр хаан ах минь зүгээр эс болбоос олон монгол улс өнчирч хитан иргэний **бах ханана**[660]. Хаан ахынхаа оронд би [золиос] болъё!

Тулын нуруу би **тулавлав**[661]
Хилмийн[662] нуруу би **хэсэглэв**[663]
Илийг би ялав.
Гадааг би хатгав (жадлав)
Нүүр гуа
Нуруу урт буй за би

Бөө нар ариулагтүн **зүхлээ зүхэгтүн!**[664]" хэмээж бөө нарын зүхэл зүхэж [таринадсан] усыг Толуй хөвүүн уув. Түр сууж өгүүлрүүн: "Согтов би. Согтууг минь сэрэгтэл өнчин өчүүхэн дүү нараа бэлбэсэн бэрээ бэргэдийнхээ **санаанд**[665] хүртэл асрахыг хаан ах мэдтүгэй! Аливаа үгээ хэлэв би. Согтов" хэмээгээд гарч одож зүгээр эс болсон (нас нас нөгчсөн) ёсон тийм.

273. Төдий Алтан ханыг мохоож **Шиао-си**[666] (өчүүхэн зарц) нэр өгч алт мөнгө, алтат арт [эд] агуурс, таваар **агт [мал]**[667], [албат] зарцыг нь эзэгнэж хошуучлагч **тамгачийг**[668] тавьж, Намгин, Жүндү [зэрэг] зүг зүгийн балгасанд даргалагч [нарыг] тавьж **амар түвшин**[669] харьж хар Хорумд буув.

274. Чормахан хорч Багдад иргэнийг эзэлжээ. Тэр газар сайхан эд [бараа] сайн хэмээгдмой гэхийг мэдэж Өгөдэй хаан зарлиг болруун: "Чормахан хорчийг мөн тэнд тамгачаар сууж шар алт, шармал алттан [эд] **нах алт**[670], хоргой, таж сувд, тана, хүзүү урт, хөл өндөр [аргамаг] **тоомсогууд**[671] хүрэн эрээн тохошт **гичид**[672] (тэмээд) ачааны **хачидуд (луус)**[673] Лууснуудыг [он] онд хүргүүлж илгээж байгтүн!"хэмээв.

Сүбээдэй баатрын араас аяласан Бат, Бүри, Гүюг, мөнх тэргүүтэн олон хөвүүд Ханлин, Хибчагууд, Бажигидыг оруулж Эжил Жаяг, Мэгэд, балгасыг эвдэж, оросуудыг хядаж, үлдэн талав. Асуд, Сасуд, Боларман, Кэрмэн, Кива (Киев?) тэргүүтэн балгадын иргэдийг дагуулж эзлэж даргач, тамгачныг тавьж харив. Урьд

Зүрчид, Солонгост аяласан Жалайрдай хорчийн араас Есүдэр хорчийг аялуулав. "[Түүнийг] тамгачаар суутугай" хэмээн зарлиг болов.

275. Бат Кибчагийн аянаас Өгөдэй хаанд элчээр өчиж илгээрүүн: "Мөнх тэнгэрийн хүчинд, хаан авгын сууд Мэгэд балгасыг эвдэж, орос иргэнийг дагуулж, арван нэгэн харь иргэнийг зүг зүгт оруулж алтан жолоо буцаан татаж салалцах хурим хуримлая хэмээлдэж их цацар босгож хуримлахад би эд бүх хөвүүдийн ах хан болсон болж нэг хоёр аяга өсөг (сархад) урьд уув хэмээн надтай Бүри, Гүюг хоёр муудаж хуримд үл хуримлан явав. Явахдаа Бүри өгүүлрүүн: "Бат [бидэнтэй] адил бөгөөтөл хэрхэн урьдаар уух бөлгөө?

Сахалт эмгэд
Сацуутан болжээ
Өсгийгөөрөө түлхэж
Өлмийгөөрөө гишиглэхсэн" хэмээв.

Гүюг өгүүлрүүн: "Тэд хоромсогот эмгэдийг өвчүүгий нь **цохиолдъё**[674] чи бид тэднийг" хэмээжүхэй. Элжигдэйн хөвүүн Аргасун өгүүлрүүн: "Тэдэнд модон сүүл зүүе!" хэмээв. Бид бүхэн хар элэгт дайсан иргэнд морилж зөв таваа [ололцож] болох болов уу хэмээж бүхийд Бүри, Гүюш хоёр ийн өгүүлээд [эв] эегүй тарав. Эдүгээ хаан авгын зарлиг мэдтүгэй" хэмээн өчиж илгээжээ.

276. Батын энэ үгэнд хаан маш хилэгнэн Гүюгийг үл уулзуулан өгүүлрүүн: "Энэ түрэмгий хэний үгэнд **долигсож**[675] ах хүнийг ам дүүрэн хэлнэ? Гагц өндөг **өмхөртүгэй**[676]. Мөн ах хүний өөдөөс **эсэргүүцсэн**[677] ажгуу.

Алгинчи (түрүүнд) тавьж
Арван хурууны нь хумсыг
Авчтал
Агуулс мэт балгадад
Авируулъяа
Тамгачаар талбиж
Таван хурууны нь хумсыг

Тамтартал
Давтмал хатангуй балгадад
Авируулъяа.

Чи өөдгүй[678] муу түрэмгий Аргасун хэнтэй **эн зэрэгцэж**[679] биднйи урагт ам дүүрэн их үг өгүүлэх бөлгөө? Гүюг, Аргасун хоёрыг хамт илгээе. Аргасуныг [зүй нь] алах [ёстой] бөлгөө. Алагчлав гэх [биз] та нар. Бүрийг яана хэмээвээс Батад өгүүл. Цагаадай ахад хэлүүлж илгээгтүн! Цагаадай ах мэдтүгэй!" хэмээв.

277. Хөвүүдээс Мэнгэй, ноёдоос Алчидай, Хонхордай, Жанги тэргүүтэн ноёд дуратган өчрүүн: "Чингис хаан эцгийн чинь зарлиг: Хээрийн хэргийг хээр **шийтгэх**[680] бөлгөө. Гэрийн хэргийг гэрт шийтгэх бөлгөө. Хааныг соёрхобоос хаан Гүюгт хилигнэж байна. Хээрийн хэрэг болохоор Батад тушааж илгээвээс болюу?" хэмээн өчвөөс энэ үгийг хаан зөвшөөж тайтгарч Гүюгийг уулзуулж соёрхол үг донгодон өгүүлрүүн: "Аялан явах зуур бөгстэй хүний бөгсий нь [эрүүл] эс үлдээв гэнэ үү чи! Цэрэг ардын царай **алдуулж**[681] явсан гэнэ үү чи! Орос иргэн тэд чиний уур хилинд айж дагаж орсон болгож бодов уу чи? Орос иргэдийг ганцаараа оруулсан мэт санаж, омог дураар [түрий] барьж ах хүнд авирлан ирэв үү чи! Бидний Чингис хаан эцгийн зарлигт буй. "Олны аюул, гүний үхэл" хэмээдэг эс билүү? Ганцаараа **бүтээсэн**[682] мэт [санана уу] Сүбээдэй, Бүжэг хоёрын далин дор явж олон бүгдээр хамсаж орос, Кибчагуудыг оруулж, ганц хоёр орос, Кибчагуудыг олж, ишигний шийр [ч] олж зөөгөөгүй эрэмшиж анх гэрээс гарч [байж] юунд гагцаараа бүтээсэн мэт үг хэл **үүсгэж**[683] ирнэ чи! Мэнгэй, Алчидай, Хонхордай Жанги нар:

Дэгдсэн зүрхний
Дэргэдэх нөхөр болж, түдээж
Дэврэх тогоог
Дэвэх шанага болж амарлиулав. За тэр!

Хээрийн хэргийг Батынх хэмээе. Гүюг, Аргасун хоёрыг Бат мэдтүгэй!" хэмээж илгээв. "Бүрийг Цагаадай ах мэдтүгэй!" хэмээв.

278. Бас Өгөдэй хаан зарлиг болруун: "Чингис хаан эцэгт

минь [бараа болж] явсан хэвтүүл, хорчин, тургууд, бүх хэшигтний явдлыг **шинээр**[684] дуулгах зарлиг" тунхагласан нь: "Хаан эцгийн зарлигаар урьд яаж явсан бол эдүгээ мөн ёсоор явтугай!" хэмээн зарлиг болруун: "Хорчин Тургууд, урьдах ёсоор өдөр мөр мөртөө явж нартай хэвтүүлд зайлж [өгч] гадна [гарч] хонотугай хэмээн зарлиг болов. "Шөнө бидэнтэй хэвтүүл хонотугай! Үүдэнд гэрийн орчин хэвтүүл байтугай! Ордны хойгуур урдуур хэвтүүл **эрэгтүгэй!**[685] Нар шингэсний хойно шөнө явах ардыг хэвтүүл барьж хонотугай! Олныг тарсаны хойно хоноглох хэвтүүлээс бусад дотогш зорчин орох хүнийг барьсан хэвтүүл толгойг нь тас цавчиж хаятугай! Шөнө яаруу [үг] хэлтэй хүн ирвээс хэвтүүлд хэлж гэрийн араас хэвтүүлтэй хамт байж хэлэлцтүгэй! Орд гэрт орох гарахыг Хонхордай, Ширахан нар засуул, хэвтүүлтэй хамт эрхэлтүгэй! Элжгидэй итгэлтэй [хүн] бөгөөтөл үдэш хэвтүүлийн дээгүүр явах болон хэвтүүлд баригдлаа хэмээн зарлиг бус үл болгогч хэвтүүл итгэлтэй буй за" хэмээн зарлиг болж "хэвтүүлийн тоо бүү асуутугай! Хэвтүүлийн суурь [суудлын] дээгүүр бүү явтугай! Хэвтүүлийн дээгүүр явах, захаар явах ардыг хэвтүүл барьтугай! Хэвтүүлийн тоо асуусан хүний тэр өдрийн унасан морийг эмээлтэй хазаартай [нь] өмссөн хувцас сэлтийг хэвтүүл автугай! Хэвтүүлийн суурин дээр хэн ч бүү суутугай! Хэвтүүл туг хэнгэрэг, дөр жад аяга сав хамгаалтугай! Идээ, ундаа, өтгөн махыг хэвтүүл даргалтугай!" хэмээн зарлиг болов. "Орд гэр тэргийг хэвтүүл асартугай!" Бидний бие цэрэг [дайнд] эс гарваас биднээс ангид өөр хэвтүүл цэрэг бүү гаргатугай! Биднийг авлах, шувуулахаар [явахад] заримы нь орд гэрт цагдан тавьж, бидэнтэй зарим хэвтүүл явтугай! Хэвтүүлээс нутагчин явж [газар үзэж] орд буулгаж байтугай! Үүд [сахих] цагт хэвтүүл үүдчин [гаргаж] байтугай! Бүх хэвтүүлийг Хадаан мянга [ны ноён] мэдтүгэй! хэмээн зарлиг болов. Бас хэвтүүлийн хэшиг хэшгийн ноёдыг [томилж] тушаасан нь "Хадаан, Булахадар хоёр нэгэн хэшиг болж зөвлөлдөж нэгэн ээлж орж ордны баруун зүүн этгээдэд салгуу сууж застугай! Амал, Чанар хоёр зөвлөлдөж нэгэн ээлж болж хэшигт орж ордны баруун зүүн этгээдийн завсар зайг

застугай! Хадай, Хорихачир хоёр зөвлөлдөж нэгэн хэшиг орж ордны баруун зүүн этгээдэд салгуу сууж застугай. Ялбаг, Хараудар, хоёр зөвлөлдөж нэгэн ээлж болж хэшигт орж ордны зүүн этгээдэд салгуу сууж застугай! Бас Хадаан, Булахадарын ээлж, Амал, Чанарын ээлж, энэ хоёр ээлжүүд ордны зүүн этгээдэд сууж хэшигт ортугай! Хадай, Хорихачир хоёрын ээлж, Ялбаг, Хараудар хоёрын ээлж, энэ хоёр ээлжүүд ордны баруун этгээдэд сууж хэшигт ортугай" хэмээв. "Эдгээр дөрвөн ээлж хэвтүүлийг Хадаан мэдтүгэй! Бас хэвтүүл миний биеийн хажууд ордны орчин байж үүд дарж хэвттүгэй!" Хэвтүүлээс хоёр хүн ордонд орж сөн барьтугай" хэмээн зарлиг болов. Бас "Хорчныг хоромсого саадагтан Есүн төгэ, Бүгидэй, Хорхудаг, Лабалха дөрвөн ээлж хэшиг болон хоромсого агсагч тургуудын дөрвөн ээлж хэшигт **дагалт**[686] хорчноо засаж оруултугай!" хэмээн зарлиг болов. Бас тургуудын ээлжийн ахлагчийг урьд [захирч] мэдэж байсан ургаас тушаахдаа: "Урьд [захирч] мэдэж басйан Алчидай, Хонхортахай хоёр зөвлөлдөж нэгэн ээлж тургуудыг засаж ортугай! Тэмүдэр, Жэгү хоёр зөвлөлдөж нэгэн ээлж тургуудыг засаж ортугай! Мангудай **ард үлдэгсэдийг**[687] захирч нэгэн ээлж тургуудыг засаж ортугай!". Бас хаан зарлиг болруун: "Бүх ноёд Элжигдэйгээр ахлуулж Элжигдэйн үгээр явагтүн" хэмээгээд бас зарлиг болруун: "Ээлжийн хүн хэшигт орохыг огоорвоос урьдах зарлигийн ёсоор гурван бэрээ шүүтүгэй! Мөн ээлжийн хүн бас дахин хэшиг огоорвоос долоон бэрээ шүүтүгэй! Бас мөн хүн өвчин шалтаг үгүй, ээлжийн ахлагчид зөвшөөр үгүй гурвантаа хэшиг огоорвоос бидэнтэй явахаас бэрхшээсэн гэж гучин долоон бэрээ шүүгээд хол газар нүднээс далд явуулъя!" Бас ээлжүүдийн ахлагч хэшиглэсэн хэшигтнийг үл бүрсгэн ээлж огоорвоос ээлжийн ахлагчийг яллуулъяа! Бас "Ээлжүүдийн ахлагчид гурав гурваар ээлж орох, солилцоход энэ зарлигийг хэшигтэнд сонсоготугай! Зарлиг дуулсан хэшигтэн ээлж огоорвоос зарлиг ёсоор ялалъяа! Энэ зарлигийг хэшигтэнд эс сонсговоос ээлжийн ахлагч буруутан болтугай!" Бас "Ээлжийн ахлагчид сацуу орсон миний хэшигтнийг биднээс зөвшөөр үгүй

ахлаж буй хэмээн бүү **донгодогтун**[688] Засаг (цааз, хууль) хөндвөөс бидэнд хэлтүгэй! Алах ёстой бөгөөс бид мөхөөрүүлье. Гэсгээн [шийтгэх] ёстой бөгөөс бид шийтгэе. Ахлаж буй хэмээн бидэнд хэлэлгүй өөрсдөө гар хөл хүрэгвээс нудрагын хариуг нудрага, бэрээний хариуг бэрээгээр хариултугай!" хэмээв. Бас "Гаднах мянгатын ноёдоос миний хэшигтэн дээр (илүү) буй за. Гаднах зуут, аравтын ноёдоос миний хэшигтэнтэй хэрэлдвээс мянгатуудыг ялалъяа" хэмээн зарлиг болов.

279. Бас Өгөдэй хаан өгүүлрүүн: "Чингис хаан эцгийнхээ зүдэрч байгуулсан улсыг бүү зовооё. Хөлий нь хөсөр гары нь газар тавиулж жаргуулъя. Хаан эцгийнхээ бэлэн [сууринд] сууж, иргэдийг үл зовоож, шөл [хоолонд] эл улсаас сүргийн нэг шүдлэн хонь он онд өгтүгэй! Зуун хониноос нэг хонь гаргаж өөр зуурын үгээгүү ядууст өгтүгэй! Бас ах дүүс олон эр, агт [морьд] хэшигтэн чуулбаас тэр бүрийд унд [хоолыг] иргэдээс хэрхэн гувчина? Зүг зүгийн мянгат мянгатаас гүү гаргаж саалгаад, саалчдаар адуулуулаад, нутагч нарыг **байнга**[689] **төлөөлөн**[690] гаргаж унагачин болготугай. Бас ах дүү чуулбаас өглөг соёрхол өгье. [Эд] агуурс, сүх, хоромсого, нум, хуяг, зэв [тэргүүтнийг] санд **тушааж**[691] балгадыг сахиулъяа. Зүг зүгээс балгасчин амучныг (аму таригч) ялгаж сахиултугай! Бас улс иргэдэд нутаг ус хувааж өгье. Нутаг нутаглуулахад мянгат мянгатаас нутагчин ялгаж гаргаваас болюу. Бас цөл газар гөрөөснөөс бус [амьтан] үл амуй. Иргэдийн уужим сууцгаахад Чанай, Уйгуртай хоёр нутагчин тэргүүлэн цөл [газраас] худаг эрүүлж хаштугай! Бас бидний элч зорчихдоо улс [амьтнаар] бядан [хэсэж] явмой. [Эдүгээ] зорчигч элчин тэдний явдал удаан, улс иргэнээ зовлон [болж] буй. Эдүгээ бид огоот оршуулан [тогтоож] зүг зүгийн мянгат мянгатаас замчин улаачин гаргаж суурь суурьд зам тавьж элчийг **хамаа** [692] үгүй улс амьтнаар үл бядан [хэсүүлж] замаар явуулбаас болюу. Эдгээр үйлсийг Чанай, Булахадар хоёр сэдэж бидэнд дурдсаныг зүйтэй болов уу хэмээн санасныг Цагаадай ах мэдтүгэй! Эл өгүүлсэн үйлс зохих бөгөөс Цагаадай ах зөвшөөрвөөс [ёсоор] болтугай!" хэмээж илгээвээс Цагаадай ахаас

асуулгаж илгээсэн эд эл үйлсийг бүгдийг зөвшөөж "Тийн бөгөөс хийтүгэй!" хэмээж [хэл] ирүүлжээ. Бас Цагаадай ах өгүүлж ирүүлсэн нь: "Би эндээс замыг сөрөг байгуулсугай! Бас эндээс Батад элч илгээсүгэй. Бат [мөн] сөрөг замаа байгуултугай" хэмээгээд бас өгүүлж ирүүлэхдээ: "Бүхнээс зам тавиулах үйл зөвөөс зөвийг дурджээ" хэмээн ирүүлэв.

280. Тэндээс Өгөдэй хаан өгүүлрүүн: "Цагаадай ах Бат тэргүүтэн баруун гарын хөвүүд ах нар бүгд, Отчигин ноён, Жэгү тэргүүтэн зүүн гарын ах нар дүү нар бүх хөвүүд, голын охид хүргэд түмэт, мянгат, зуут, аравтын ноёд бүгдээр зөвшөөрчээ. Зөвшөөрөхдөө: "**Далай хааны**[693] шөлөнд он онд сүргээс нэг шүдлэн ирэг гаргаваас ямар буй? Зуун хониноос нэг зусаг гаргаж үгээгүү ядууст өгвөл сайн буй. Зам тавиулж замчин улаачин гаргаваас олон улс амгалан [болж] элчээр явахад **дөхөмтэй**[694] буй хэмээвээс бүгдээрээ л зөвшөөрчээ" хэмээн хааны зарлиг: "Цагаадай ахтай зөвлөж, Цагаадай ахад зөвшөөрүүлж бүх улсаас зүг зүгийн мянгат мянгатаас хааны зарлигаар он онд шөлний сүргээс нэг шүдлэн ирэг, зуун хониноос нэг зусаг хонь гаргуулав. Гүү гаргуулж унагачныг суулгав. Унагачин, балгасчин, амучин гаргуулав. Замчин улаачныг гаргуулж суурин суурин газрыг хянаж зам тавиулахад Арачан, Тохучар хоёроор захируулж замын нэгэн сууринд хорин улаачин гаргав. Суурин тутамт хориод улаачин [буй] болгов. Улаачин агт шүүсний хонь, саалийн гүү, тэргэнд хөллөх үхэр, тэрэг[тэргүүтнийг] эндэс бидний хэмжиж [тогтоосон] хэмээс

Охор дээс[695] дутааваас
Оройгоор[696] [нь] таслан **шийтгэх**[697] болтугай!"
Халбага хигээс[698] дутааваас
Хамраар нь таслан шийтгэх болтугай


хэмээн зарлиг болов.

281. Өгөдэй хаан өгүүлрүүн: "Эцгийнхээ их сууринд сууж хаан эцгээс хойш үйлдсэн минь: **Зүрчид**[699] иргэнд аялаж Зүрчид иргэнийг мохоов би. Нөгөө үйл минь бидний хооронд элч хурдлан явуулахуй, бас **хэрэг чаргаа**[700] зөөлгөх зам тавиулав. Бас нөгөө

үйл [нь] усгүй газар худаг эрүүлж гаргуулж улс иргэдийг ус өвсөнд хүргүүлэв. Бас зүг зүг [хот] балгадын иргэдэд толгойлогч, тамгачийг тавьж улс иргэний хөл хөсөр, гар газар тавиулж байлгав би. Хаан эцгээсээ хойш [энэ] дөрвөн үйлсийг нэмэв ээ. Бас хаан эцгийнхээ их сууринд сууж улс [иргэдээ] би дээрээ тээж явж бөгөөтөл бор дарсанд дийлэгдсэн минь буруу болов. Нэг буруу минь энэ болов оо. Нөгөө буруу [нь] ёсгүй эм хүний үгэнд орж Отчигин авгын улсаас охид авчруулж алжаас болов оо. Улсын эзэн хаан бөгөөтөл ёсгүй алжаас үйлд **хазайсан**[701] миний нэгэн буруу энэ болов оо. Бас Доголхуг **хилсдүүлсэн**[702] нэгэн буруу. Хэрхэн буруу болов гэвээс Хан эцгий минь өмнө тус юугаа **өргөж**[703] [өгсөн] Доголхуг хилсдүүлсэн буруу алжаас [болов]. Эдүгээ миний өмнө хэн тэгэж [хүчээ] өрсөлдөж өгнө? Хаан эцгийн минь бүхний өмнө [ёс] төр хичээх хүнийг үл ухааран өшөөлдсөнийгөө өөрөө буруушаана би.

Бас тэнгэр газраас заяаж төрсөн гөрөөсийг ах дүүсийн зүг одуузай хэмээн харамлаж хороо хэрэм нүдүүлж хориг [саад] болгон, ах дүүгээс гомдлын үг сонсов би. [Энэ бас нэг] буруу болов. Хаан эцгээсээ хойш дөрвөн үйлс нэмэв би. Дөрвөн үйлс буруу болчухай!" хэмээв.

282. Их хуралдаан хурж **хулгана жил**[704] (1228) **гуран**[705] (долдугаар) сард Хэрлэний хөдөө арлын Долоон **болдог**[706] (дов) **Шилхэнцэг**[707] хоёрын зуур ордос бууж бүхүйд бичиж дуусав.



ҮГ ХЭЛЛЭГИЙН ТАЙБАР

1. Бөртэ-Чино гэдгийг хятад хадмал (хойшид хх –гэж товчлов) орчуулгад苍色狼(Хөх зүсмийн чоно) гэж тэмдэглэжээ. Үүнийг судлагчид голцуу хх. орчуулгыг баримтлан "саарал чоно" (С.Ю.Неклюдов) "орог хөх чоно" (Ф.В.Кливез) гэсэн утгаар орчуулсан байна.

Якут хэлний материалаас үзвэл "бөртэ, бөлтэ" гэж чонын урд хөлний хар цоохор бидрийг хэлдэг ажээ (Пекарский, 1917, 525). Өвөр монголын эрдэмтэн Элдэнтэй, Ардаажав (1986,3) нарын сийрүүлэн тайлбарласан "Нууц товчооны" үгийн тайлбарт "...буурал, цоохор, эрээн, сэвхтэй холимогийг бөртү гэнэ" гэжээ. Мөн шинэ баргын аман аялгуунд бөри, бүрү хэмээх нь цоохор гэсэн утгатай гэж хэлний шинжлэлтэн, проф. Ц.Норжин надад мэдээлэв.

Эртний түрэг хэлний зарим аялгуунд чоныг бас бөри-бүрү гэж хэлдэг нь бидний ойлголтоор урд савартаа бидэртэй чонын тусгай нэрээс үүссэн байж болох юм. Тэрчлэн буриадын домог үлгэрт гардаг бүртэ хэмээх нохойны нэр хийгээд монгол угсаатны анхны бөө (Ханян овогтны) нь Бүртэ гэдэг өвгөн байсан гэх ба тэр нь Хоредой, Хортон хэмээх хоёр хөвүүнтэй байсан нь тэд хойт зүгт зугадан явсан гэх зэргээр домоглодог нь (Гомбоев, 1890, 122, 125) мөн харьцуулан үзүүштэй сонин баримт юм. Өвөрмонголын эрдэмтэн Б.Булаг (1995, 95) "Бөртэ Чино хэмээх нэрийн гарал ба хувьсал" гэдэг өгүүлэлдээ: Бөртэ Чино буюу Хөх чоно нь монголчуудаас гадна бас Түрэгийн эртний онгон шүтээн байсныг аргын тооллын өмнөх 104-91-р онд зохиогдсон "Ши Зи" болон зүүн Хан улсын "Хан Шү" хийгээд Тан улсын үеийн "Бэй Ши" зэрэг хятад сурвалж бичгийг баримт болгон өгүүлжээ.

2. Хо'а Марал гэдгийг хх-д惨白色鹿(Цайвар буга) гэж тэмдэглэжээ. Бөртэ-Чиногийн гэргий Хоо Марал бол эртний монголчуудын буга гөрөөс онголон шүтэх зан үйл, домог-үлгэрийн ойлголттой холбоотой гэж бид үзэж байгаа билээ. Буга эрхэмлэх зан үйл зөвхөн монголчуудад төдийгүй Алтай, Урианхай, Киргизэд өргөн дэлгэр байдаг байна. Тухайлбал Киргизд эмэгтэй хүний өвөг нь Ак

Марал буюу "Цагаан буга" байдаг нь (Абрамзон, 1956, 199) монголчуудын эхийн онгон болох Хоо Маралтай адилавтар зүйл юм. Бас Алтай Урианхайчууд цагаан (цайвар) буга намнадаггүй заншилтайг судлагчид тэмдэглэсэн нь буй.

Монгол нутагт өргөн дэлгэр тохиолддог буган чулууны зураг эврээрээ жигүүрлэн тэнгэр өөд дүүлэн яваа буга тургийн дүрс хийгээд Хөхдэй мэргэний намнахаар хөөцөлдөж яваад тэнгэрт нисэж гарсан гурван марлын домог-үлгэр зэрэгтэй энэхүү Хоо Марал учир холбогдолтой ажээ. Сүүлийн үед олонхи судлагчид Бөртэ-Чино, Хоо Марал хоёрыг бодот хүний нэр бус, эрт балар цагийн домог-үлгэр, онгон шүтээний эрхэм нэр гэдэгт санал нэгтэй болж байна.

3. Бурхан Халдун гэдгийг хх-д 山名(Уулын нэр) гэжээ. Эл үгийн гарлын талаар эн тэргүүнээ проф. Б.Ринчен (1946, №8) бичсэн өгүүлэлдэ Дагуур угсаатан нар хөгшин уд модыг онголон тахисныг **Бурхан Халдун** гэж хэлдгээс уламжилж ирсэн нэр гэж үзжээ. Эрдэмтэн Х.Пэрлээ (1958,6) "Нууц товчоонд гардаг газар усны зарим нэрийг хайж олсон нь" гэдэг өгүүлэлдээ "Хэнтий уулын судал **Бурхан хада уул** маш өндөр, Хэрлэн, Онон, Туул гурван голын эх газар". Одоогийн Их Хэнтий, Бага Хэнтий хоёрын хоорондох Хэнтийн гол нуруунд оролцсон уулсыг ерөнхийд нь Бурхан Халдун гэж нэрлэж байсан байна гэж тайлбарлажээ.

4. Жала'уту гэдгийг хх-д後生(сүүлд төрсөн) гэж орчуулжээ. Эл үгийг судлагчдын нэг хэсэг нь **залуутай** гэж үгчлэн буулгаж, нөгөө зарим нь **залуу зарц** гэх буюу **зарцтай** гэж хөрвүүлсэн байна.

XIY зууны үеийн "Ибн-Муханнын толь"-д (Истанбул, 1921) залуу гэсэн үгийг "боол" гэж орчуулсан (Поппе, 1938, 439) жишээнээс үндэслэж дээрэх үгийг "зарц, боол" гэж ухаарахад хүрсэн бололтой. Гэвч энд нэг эргэлзмээр зүйл нь Торголжин баяны тухай өгүүлсэн энэ хэсэгт түүнийг туулийн баатрын гарал үүслийн магтаалын маягаар гэргий, хүүхэд, хүлэг морь тэргүүтнийг нь тоочин өгүүлэхэд зарц боолыг нь дурдах ёс баймааргүй юм. Эдүгээгийн ойрдын аялгуунд **залуу** гэх нь "хань нөхөр найз" (Цолоо, 1998, 236) гэсэн утгаар бас хэрэглэгдэж байгаагаасүзвэл Боролдай Соёлби гэдэг бол Торголжин баяны анд нөхөр нь байсан байж болно. Тэрчлэн НТ-ны хх. орчуулгад "хожуу төрсөн буюу сүүлд төрсөн" гэсэн утгаар орчуулсныг бас анхаарах хэрэгтэй юм. Ийм учраас бид энэ нь ямарч атугай зарц боол гэсэн

утгатай үг биш болов уу гэж үзэж байна.

5. Дува-Сохор гэдгийг хх-д 名 (нэр) гэж тэмдэглэжээ. НТ-г орчуулсан олонхи судлагчид (Э.Хэниш, Ц.Дамдинсүрэн, С.Калужинский, П.Поуха, Л.Лигети зэрэг) Дува-Сохорыг "нүдгүй, сохор" гэж ухаарчээ. Харин Ш.Гаадамба (1981, 76-77) "Нууц товчоо ба уран зохиолын харилцаа холбооны асуудал" гэдэг өгүүлэлдээ: Дува-Сохорын талаар шинэ санал дэвшүүлж үлгэр домгийн зүйлээс сэдэвлэсэн ганц нүдэт аварга амьтны (Полифем шиг) домогтой учир холбогдолтой гэж үзэв. Дараагаар нь Д.Цэрэнсодном (1983, 36-37) "Дува-Сохорын домог, ганц нүдэт аварга амьтны тухай өгүүлэмжтэй холбогдох нь" гэдэг өгүүлэлдээ: Дува-Сохорыг домог зүйн хувьд Якутын Дабы Сохор буюу ойн онгон сахиус ах дүү есийн нэгэнтэй холбоотой бөгөөд НТ-ны **сохор** гэдэг нь гарлын хувьд монгол, буриад хэлний **цох-сох** (дух) гэсэн үгнээс үүсэлтэй эртний монгол хэлний **ганц нүдэт** гэсэн үг гэж тайлбарлажээ. Адгуус амьтдын сэдэвтэй монгол домог-үлгэрт Хар хул, Бар хул зэрэг догшин араатан хийгээд Лалар зэргийг магнай дундаа ганц нүдтэй, асар холыг хардаг гэж домоглон өгүүлдэг юм. Лаларын тухай түүхч Зава Дамдин (1867-1937) "Алтан дэвтэр" гэдэг түүхэн зохиолдоо түүнийг "асар том биетэй, толгойгүй, мөрөндөө ганц нүдтэй, бэлхүүсэндээ амтай, гартаа төмөр шилбүүр барьсан" гэх зэргээр өгүүлжээ. Бидний тодорхойлж буй Дува-Сохорын домог бол ямар нэгэн бодот явдлын ердийн тэмдэглэл бус монгол аман зохиолд маш эртнээс уламжлагдан яригдсаар ирсэн ганц нүдэт аварга амьтны нэлээд хожуу үеийн хүнчлэгдсэн дүрийн уран сайхны найруулга гэж үзэж болно. Ийм хүнчлэгдсэн хожуу үеийн домог-үлгэрийн нэг жишээ бол Түнхиний буриадуудын дунд дэлгэрсэн "Сохор ноёны домог" болно (Чистохин, 1895).

Энэ нь хөгжлийнхөө үе шатны хувьд НТ-ны Дува-Сохорын домогтой бараг нэг үеийнх гэж үзэж болмоор юм.

6. Гурбан нэ'үрит гажара гэдгийг хх-д 三程地(Гурван буудал газар) гэж орчуулжээ. Эл хэллэгийн **нэ'үрит** гэдэг үгийг олонхи судлагчид хх. орчуулгыг баримтлан "нүүдэл, буудал, өртөө" гэх зэргээр, хөрвүүлсэн байна. Бидний санавал нүүрийн газар буюу нүүрт газар гэдэг нь хол ойрын хэмжээг заасан тодорхой нэгэн нэгжийн нэр болно. Угтаа энэ нь сумны тусгал үл хүрэлцэх газраас цэрэг нүүрлэн буух

цэцгийн бидэртэй бугыг хэлнэ" гэж тайлбарлав. Уг үг бас НТ-ны 12, 13, 16-р зүйлүүдэд гарна.

12. Абит гэдгийг хх-д 肚 (гүзээ, ходоод) гэж орчуулжээ. Үүнийг Э.Хэниш, В.Кливез зэрэг судлагчид хх. орчуулгыг баримтлан "гэдэс, дотор" гэсэн утгаар буулгасан байна. П.Пеллио "Широлга-ширалга" гэдэг үгийн тухай бичсэн өгүүлэлдээ энэхүү абид гэдэг үгийг эртний монгол хэлний хабид буюу хавирга гэдэг үгийн эхний "х" авиа гээгдсэн хэлбэрээр байж магадгүй гэж таамагласан ажээ. Мөн үгийг Лувсанданзаны "Алтан товчид" богино хавирга гэж тэмдэглэснийг Ш.Гаадамба зөв болов уу хэмээн ихэд олзуурхан "тэр урианхай хүн буга алаад богино хавиргаар нь галаа мялааж тахиж байсан ч байж магадгүй юм" (Гаадамба, 1976, 23) гэжээ. Бидний санавал гал тахих гэгч нь хаа хамаагүй хээр хөдөө ч гал түлж үйлдэх зүйл бус эрх биш өөрийн гал голомтонд ёс төртэй гүйцэтгэх заншил тул арай гал тахисан биш харин ангийн заншлаар хишиг хүртэж бэлэнчлэн шарж идэж байсан буй за. Монгол ан авын хишиг дээжлэх заншил ёсоор юуны өмнө гэдэс гүзээг шарж иддэггүй тул акад. Ц.Дамдинсүрэн энэ үгийг "цорой" гэж утгачлан хөрвүүлжээ. Сүүлийн үед Элдэнтэй, Ардаажав (1986, 24) нар "абид" гэдгийг өвөрлөгч нутгийн аялгууны дотроос хайн сурвалжилж хошного буюу цагаан махыг Ордост "абид", Урад аялгуунд "абис" гэж хэлдэгийг тодорхойлоод НТ-ны **абид** хэмээх нь үүнтэй зайлшгүй холбоотой гэж үзжээ. Мөн Ордосын Отог хошуунд бүдүүн хошногыг **авилга** гэх бөгөөд үүнийг гал тахихад оруулдаг гэж дэд профессор Солонгууд овгийн Жигмид эмч надад 1989 оны 9-р сарын 15-нд ярив. Эл үгийн хувьд бас нэг анхаармаар зүйл бол НТ-ны 124-р зүйлд гарч буй "хонжийасун" гэдгийг бид бас хошного буюу цагаан мах гэж ойлгож байгаа юм. Ингэхлээр абид-хонжийасун хоёр ямар ялгамжтай вэ? гэдэг асуулт гарна. Бидний санахад эл хоёр үг утгын хувьд ойролцоо байж болох боловч бас тус тусын өвөрмөц ялгаа бий. Тухайлбал эл хоёр үгийн хэрэглэж асан цаг хугацаа нь хэдэн зуун жилийн зөрөөтэй, нэг нь ойн иргэдийн нөгөө нь талын малчин хүний гэх мэт ялгаатай тал бий. Өөрөөр хэлбэл адил утгат (синоним) үгийн түвшинд авч үзэж болох юм.

13. Широлхада гэдгийг хх-д 燒肉臾 (Шарсан махандаа) гэж орчуулжээ. "Нөхөр шорлогодоо" гэдэг энэ хэллэгийн тухай эрдэмтэн Ж.Цэвээн "XYII зууны үеийн монгол түүхэн сурвалж бичиг" гэдэг

өгүүлэлдээ "сиролга" гэдэг нь "сиро" буюу "шор" гэсэн үгнээс үүсэлтэй болохыг тодорхойлоод ангийн олзноос хувь хүртээх заншилтай учир холбогдолтой гэж чухам яг голы нь олж хэлсэн ажээ (Жамцарано, 1936, №16). Гэвч уг хэллэгийн талаар П.Пеллио (1944, 105-109), А.Мостарт (1949, 470-476), Ш.Гаадамба (1961, 36-49) зэрэг судлагчид тусгай *өгүүлэл зориулсаар иржээ.* Дээрэх эрдэмтэдийн бичсэн өгүүлэл хийгээд бусад аман, бичгийн баримт сэлтээс үзвэл "нөхөр шорлогодоо" гэх эл хэллэг бол ангийн олз хишгийг шорлож хувилан түгээх заншлыг өгүүлсэн нь гарцаагүй ажээ. Элдэнтэй (1986, 26) нарын судлагааныас үзвэл "Монгол, Эвенк үндэстний анчдын заншлаар ав хийж олсон амьтдаа ганзгандаа уяхын өмнө тус газарт хүрэлцэн ирсэн аливаа хүн бүр алсан гөрөөсний махнаас хувь хүртэх заншилтай болой. Ингэж олгох хувь юугаа "широлга" хэмээжүхэй" гэсэн байна. "Чингис хааны их өчиг"-т

"Жаламан ханыг арлан явж

Заарьт тэхийг **шорлон** явж..." гэсэн нь мөнөөх ангийн хишиг шорлон хүртээх зан үйлтэй холбоотой үг болов уу гэж санаж байна. Энэчлэн монголын аль ч нутагт өвлийн цагт идэш гаргахад хүүхдүүдэд мах шорлож хувь хүртээдэг заншил түгээмэл байсан бөгөөд үүнийг зарим газар (Говь-Алтай зэрэгт) "шорлого" гэж нэрлэдэг байжээ.

14. <u>А'ушикиту жилду</u> гэдгийг肺有的半截腔子(Уушигтай цээжин бие) гэж орчуулжээ. Зүлд хэмээх нь ан гөрөөсний юм уу алсан малын толгой, багалзуурыг уушиг зүрхтэй нь үргэлж авсныг хэлнэ. Анчин хүн ан гөрөөсний уушиг зүрхийг дээр өгүүлсэнчлэн зүлдлэн авч гэрийнхээ баруун урд ханан толгойд буюу ацтай модонд өлгөж тавьдаг нь даруй ангийн тэнгэрт дээжлэн өргөж буй эртний уламжлалт зан үйлдэл болно. Тэрчлэн монголчууд хонины гэдэс дотор чанахад юуны өмнө уушиг зүрхний өөдөс үзүүрийг бурхандаа дээжлэн тавьдаг заншил нь мөн дээрэх ёстой холбоотой юм. Ийм учраас анчин хүн хишиг тараахдаа зүрх зүлдийг эрх биш авч үлддэг заншилтай болжээ. НТ-нд өгүүлж буй гунан буга алсан урианхай хүн ч мөн тэр заншил ёсоор зөвхөн уушигт зүлдийг өөртөө үлдээж бугын махны бусдыг цөмөөрөнг Добун мэргэнд өгч байна.

15. <u>Үйэ хайа</u> гэдгийг хх-д 房親 (Төрөл садан) гэж орчуулжээ. Эл үгийг олонхи судлагчид хх. орчуулгыг дагалдуулан "төрөл, садан, ойр төрлийн хүн" гэх зэргээр хөрвүүлсэн үзэгдэнэ. Монголын уламжлалт

ураг төрлийн ёсонд дээш долоон үе, хөндлөн долоон үе, доорогш долоон үе хэмээн гурав ангилдаг байсан ажээ. Үүний хөндлөн долоон үе нь: 1.дүү, 2.үе, 3.үеэлд, 4.хаяа, 5.хаяалд, 6.үеэнцэр, 7.хаяанцар эдгээр болно. Үүнээс үе хаяа гэдэг эл үг НТ-нд гарч буй утгаар ордос аялгуунд байдгийг А.Мостарт (1941, 3246) эн тэргүүнээ тэмдэглэсэн байна. Мөн Элдэнтэй, Ардаажав (1986, 32) нар ордос аялгуунд: төрсөн ах дүүгийн хүүхэд харилцан "гал үе" гэх түүний хүүхэд харилцан "үеийн ах дүү" гэх түүний хүүхэд нь харилцан "үенцэр ах дүү" гэх бас түүний хүүхэд нь харилцан "хаяа ах дүү" гэх зэргээр нэрлэдгийг тодруулан өгүүлжээ.

Алангоо эхийн хүүхдүүд өөрсдийн ах үеэлд, хаяалид үгүй буюу эр нөхөргүй атал эхийгээ жич гурван хүүхэд төрүүлснийг сэрдэн хэлэлцсэн эл үгнээс балар эртний нэгэн овгийн дотроос гэрлэх заншлын ул мөр ажиглагдаж байна.

16. <u>Көншилэмэл</u> гэдгийг хх-д 臆(Хатаасан мах) гэж орчуулжээ. Судлагчид голдуу хх. орчуулгыг баримтлан "хатсан мах", "хуршсан мах", "хуршиж хагссан мах" гэх зэргээр ерөнхийдөө ойролцоо утгатай үгээр буулгажээ. Хх. орчуулгын 臆 гэх нь загас, тахиа, нугас зэргийн махыг даршилж давсалсныг хэлэх тул монголчуудын борцлох мэт аргаар мах хагсаах аргаас өөр болох нь илэрхий. Харин уг үгийн гарлын хувьд гэвэл энэ нь якут хэлний **көнсү** буюу хол юманд авч явахаар бэлтгэсэн хүнсний нэртэй холбоотой байж магадгүй (Пекарский, 1917, 1149) юм. Якут хэлний "көнсү" нь угтаа монгол бичгийн хэлний "күнэсү" (хүнс) гэдэгтэй гарал нэгтэй билээ. Миний бие 1986 оны 9-р сард Дорнод аймгийн буриад ястны ардын аман зохиол судлаж явах үед нэгэн настан үхрийн борцыг "көнжү" гэхийг сонссон юм. Бидний бодлоор НТ-ны "көншилэмэл хонин" гэдэг бол хиншүүлж утах юм уу борцлох аргаар удаан хадгалахад зориулж бэлтгэсэн нөөц махыг өгүүлжээ. Ойрдын *зарим аялгуунд хиншүү гэхийг* **көнсүү-күншүү** (Цолоо, 1988, 552)гэдэг байна.

17. <u>Мүсүд</u> гэдгийг хх-д 篙鞍(Сумны гол) гэж орчуулжээ. Эртний монгол хэлд нум сумны сум буюу сум хийхээр цагаалсан нарийн модыг "мөсү-мүсү" гэдэг байснаа сүүлдээ сумны зөвхөн өд сөд наасан хэсгийг хэлдэг болсон бололтой (Цэвэл, 1966, 346). Тухайлбал: "Сумын ерөөлд"

Мөс нь болбол
Халин дэвж нисдэг

Хан гарьд шувууны

Хамгийн захын сод байна (Гаадамба, Цэрэнсодном, 1978, 118) гэсэн байна. Уг үг НТ-ны 19, 22, 240-р зүйлүүдэд гарна.

18. Бидү'үлжү гэдгийг хх-д 輪着 (Эргэлдүүлж) гэж орчуулжээ. Бидү'үлжү гэсэн хэлбэрээр гарч буй эл үгийн утга нь бидэн явах буюу хэрж, хэсэх гэдэгтэй нэг гаралтай юм. НТ-ны 84-р зүйлд: "Өчигдөр айл бидү'үлжү (хэсүүлж) хонуулахад Сорхан Шарын гэрт хоновоос Чимбай, Чулуун хоёр хөвүүд нь өр зүрх нь өвдөж шөнө намайг асарч гавыг минь авч суллаж хонууллаа" гэсэн буй. Харин бидний эл ярилцаж буй хэсэгт тойруулах, дамжуулах гэсэн утгаар гарч байгаа тул үүнийг бид "хүн хүн авч тойруулж /оролдоод/ хугалан ядав" гэж хөрвүүлэв.

Ийнхүү савх модоор үлгэрлэн эв найртай явахыг сургамжилсан ийм маягийн өгүүлэмж дэлхийн улс түмний утга зохиолд өргөн дэлгэр байдгийг акад. Ц.Дамдинсүрэн (1987, 178-183) "Алангуагийн таван хөвгүүдээ сургасан домог" гэдэг өгүүлэлдээ баримт гарган ярьсан байна.

19. Билижү гэдгийг хх-д 摩着 (Илбэж) гэж орчуулжээ. Энэ нь монгол хэлд халбага-хавлага, гурил-гулир гэх мэтээр авиа сэлгэх жам дагуу орчин цагийн монгол хэлний "илбэж" гэдэг үг дундад эртний хэлд "билижү" гэсэн дуудлагатай байжээ. Дагуур хэлд илбэх гэхийг "билхүхү" хэмээдэг нь (Элдэнтэй, Ардаажав, 1986, 36) эл үгийн НТ-ны дуудлагатай бараг тохирч байна. Бас **билижү** хэмээх үг нь НТ-ны 272-р зүйлд шилж, сонгож гэсэн утгаар гарч буйг тэмдэглэе.

20. Килийэр гэдгийг хх-д 透入光裏(Орж ирсэн гэрлээр) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний хил хязгаар гэсэн үг бөгөөд "нар сарны завсар заагаар" буюу үүр шөнийн хагацлаар гарч одно гэсэн утгатай ажээ. Жич энд өгүүлж буй "... гэгээ [гэрэл] нь хэвлийд минь шингэх бөлгөө" гэдэг бол гэрийн өрх тотгоор орж ирсэн гэрэл гэгээ хэвлийд минь шингэж жирэмсэн болсон гэсэн утгатай юм. Энэ нь үгтаа эртний хүмүүсийн наранд бишрэх үзэл санааны ойлголттой холбоотой зүйл болно (Шаракшинова, 1980, 20).

Монгол угсаатан Сянбийн гарлын домогт Мин Хэ хатан хээр унтаж байгаад "нар гэрт гийв" гэж зүүдлээд жирэмслэж 7-р сарын 7-нд хүү төрүүлсэн тухай "Вэй улсын түүх"-нд өгүүлсэн байдаг бол Хятан гүрнийг үндэслэгч Елүй Абожийн эх нь түүнийг төрүүлэхдээ "өвөртөө

нар орлоо" гэж зүүдэлснээс жирэмсэн болсон гэж "Ляо (Хятан) улсын Тай Зу хааны намтар"-т дурдсан байдаг байна.

Энэ мэт домгуудад нарны гэрлээр жирэмсэн болов гэх эртний хүмүүс амьдралыг тэтгэгч гэгээ гэрлийг эрхэмлэн биширч байсны дээр эгэл хүн бус тэнгэр язгууртан гэдгийг илэрхийлэх нэг уран сэтгэмжит өгүүлэлийн түгээмэл хэлбэр байжээ.

21. Шира нохаи гэдгийг хх-д 黃狗 (Шар нохой) гэж орчуулжээ. Алангоо эхийн домогт тэнгэр язгуурт эрхэм хүнээ шар нохойтой зүйрлэн өгүүлсэн нь маш сонирхолтой байна. Түүхч Лувсанданзаны "Алтан товч" зэрэг хожуу үеийн сурвалжид "Шар нохой болж шалмалзан гарч одном" гэсэн буй. Ийнхүү шар нохойтой зүйрлэх юм уу шар нохой болсон гэх нь санамсаргүй хэлсэн зүйл биш бөгөөд Хүннү, Хятан зэрэг эртний зарим монгол овог аймаг нохой тотемтой байсан (Толстов, 1935, 12-13) гэдэгтэй холбоотой байж болно. Монголчуудаас гадна Якут, Туркменчүүд бас нохой тотемтой байсан гэдэг.

Нүүдэлч малчин монголчуудын амьдралд эрт дээр цагаас нохой чухал үүрэгтэй байсан нь ардын аман зохиол хийгээд бичиг шастирт тэмдэглэгдсэн нь цөөнгүй буй. Монгол Гэсэрийн туужид Жур хөвүүн идээнийхээ дээжийг эцэг эхдээ барихдаа тогоо тулга, тооно бас шар нохойн толгойд дусааж байдаг. Монгол угсаатны хуримын зан үйлд бэр буулгахдаа хадам эцгийн галд, дараа нь нохойд нь мөргүүлдэг заншил түгээмэл байжээ. Энэ нь шинэ бэрийг өөрийн овгийн бүрэлдэхүүнд оруулж, гал голомт онгон шүтээндээ хүндэтгэл үзүүлж буй хэрэг юм. Үүнээс гадна нохойн үс, шүд зэргийг эм домын зүйлд хэрэглэх ялангуяа хүүхдэд их ээлтэй гэж үздэг заншил монгол киргизүүдэд өргөн дэлгэр байжээ. Мөн нар хиртэхэд улаан халтар нохой хуцуулж Рах тавь! Рах тавь! гэж хашгардаг байсан зэрэг элдэв сонин зан үйлдлийг дурдаж болно. Тэрчлэн НТ-ны 78-р зүйлд "Хасар нохой мэт хаданд довтлох", 194-р зүйлд "Нохой хэрэл хэрж явах", 209-р зүйлд "Хубилай, Зэлмэ, Зэбэ, Сүбэдэй та дөрвөн ноход" хэмээн өгүүлсэн үг хэллэгүүд нь тухайн үеийн монголчуудын ахуй амьдралд нохой ямар нөлөөтэй байсныг бас харуулах баримт болно.

Дээр өгүүлснээс дүгнэж хэлбэл шар нохойтой адилтган өгүүлсэн цэгээн шар хүн бол тэнгэр язгуурыг гэрлээр бэлэгдэн үзүүлсэн бол домгийн сэтгэлгээний нэгэн уран дүрслэл юм.

22. Сөйү'эр гэдгийг хх-д 教訓 (Сургаал) гэж орчуулжээ. Эртний

монгол хэлний "сөйү'эр" хэмээгч нь эдүгээгийн "соён-соёрхол" гэдэг үгтэй язгуур нэгтэй болов уу гэж бид таамаглаж байна. Эл үг НТ-ны 22-р зүйлээс гадна 260, 277-р зүйлд мөн "сургаал соёрхол" гэсэн утгаар гарч байна. Энэ үг мөн утгаар дундад зууны үеийн түүхэн зохоил хийгээд монгол орчуулгын зарим дурсгал бичгүүдэд гардаг байна. Тухайлбал "Эрдэнийн товч"-д "Ачит эцэг эхийн сургасан сүйүгэр үгс" гэсэн байхад "Тахимдагу ном"-д (Ачлалт ном) "Уридны богдс хаад эд сүйүгэрийг ухаж иргэн оргуныг сургуулилдах төр ажгуу" хэмээсэн байдгийг Элдэнтэй, Ардаажав (1986, 38) нар уг үгийн тайлбар өгүүлэлдээ тэмдэглэжээ.

23. Тугарун гэдгийг хх-д 恰機 (Саяын) гэж орчуулжээ. Эл үг НТ-ны 22, 34, 35, 118, 169-р зүйлүүдэд "саяын, сая, саяхан" гэсэн утгаар гарч байна. Энэ нь эдүгээгийн хуучин баргын аман аялгуу, буриадын зарим аялгуунд мөн утгаар одоо хүртэл идэвхитэй хэрэглэгдсээр байгаа билээ.

24. А'асу гэдгийг хх-д 活呵 (Амьд байваас) гэж орчуулжээ. Эл үг НТ-ны 200, 209-р зүйлд мөн үүнтэй ойролцоо утгаар "байхад, байлгаваас" гэсэн утгаар гарч байна.

Бодончар Мунхагийн "Үкү'эсэ ину үкүсүкэй, а'асу ину асугай" хэмээн өгүүлсэн хэллэгийг бид утгачлан "Үхвэл үхье, сэхвэл сэхье" гэж хөрвүүлэв.

25. Нэмбүлэ гэдгийг хх-д 庵 (Өвсөн өөвөн буюу овоохой) гэж орчуулжээ. Энэхүү өвсөн нэмбүлэ буюу эмбүүл нь хэдэн мод зөрүүлэн оройгоор нь холбож, дээгүүр нь өвс, хулсаар бүрсэн оромж гэрийг хэлнэ. Уг үгийн гарлыг Элдэнтэй, Ардаажав нар (1986, 42) бүрэх, хучих, нөмрөх гэсэн утгатай гээд нэмбэгэ-нэмнээ гэх мэтийн үгстэй язгуур нэгтэй гэж үзсэн байна. Хөх нуурын монгол Гэсэрийн туужид гардаг хар яба хэмээх овоохой, эдүгээгийн ойрдын аялгууны дэклэ зэрэг нь НТ-ны эмбүүлтэй ойролцоо маягийн оромж бололтой.

26. Аба са'уба гэдгийг хх-д 住了(Суув, байрлав) гэж орчуулжээ. Бидний бодлоор "аба суув" хэмээх нь монгол үлгэр домгийн төгсгөлд амар суув гэсэн утгаар хэрэглэгддэг "ан суув-ам суув" гэх юм уу "ам суун жаргав" гэх мэт өгүүлдэг хэллэгийн ам-ан гэсэн нь бидний ярилцаж буй аба гэдэгтэй нэг үүсвэртэй болов уу гэж санана. Монгол хэлд б-м авиа сэлгэх үзэгдэл нэлээд түгээмэл байдаг тул "Хуа и И ю" тольд " нэмэгдэгсэн" гэхийг "нэмбэгдэгсэн" гэдэг шиг ам юм уу ан гэдгийг "аба"

гэж хэлдэг байсан байж бүрэн болох талтай юм.

27. Арун гэдгийг хх-д 住時 (Байн суун) гэж орчуулжээ. Энэ нь НТ-ны 205, 265-р зүйлд мөн үүнтэй ойролцоо утгаар гарна. Уг үг "а" гэдэг мөхсөн язгуурт үйлдэх хэвийн –рун-рүн нөхцөл залгаж үүссэн ажээ. Өөрөөр хэлбэл орчин цагийн монгол хэлний "асан, агсан" гэдгийн эртний хэлбэр болно.

28. Тэмхүлдүжү гэдгийг хх-орчуулгад 拾着(Түүж) гэж оновчтой орчуулжээ. Эл үгийг Элдэнтэй, Ардаажав (1986, 45) нар "Мукаддимат Ал-адаб" тольд "темкү-темкүбе" (Поппе, 1938, 448) гэсэн хэлбэрээр гарахын зэрэгцээ бүр хожуу үеийн "Эрдэнийн товч" зэрэг зохиолд "тэмкүжү" гэсэн байдгийг тайлбар өгүүлэлдээ тодорхойлсон байна. Бидний санавал монгол сонгодог бичгийн "тэгүжү" хэмээх нь угтаа "тэмкүжү" буюу "тэмгүжү" гэсэн дуудлагатай байснаа "м" авиа гээгдэж хувьссан байдалтай юм.

29.Тэйилэ'үлжү о'орба гэдгийг хх-д 餓着放了 (Өлсгөж тавив) гэж орчуулжээ. Олонхи судлагчид хх. орчуулгыг баримтлан "уяж сойж, уйсгаж, өлсгөж тавив" гэх зэргээр ойролцоо утгаар орчуулжээ. Гарлын хувьд "тэйилэ'үлжү" хэмээх нь орчин цагийн монгол хэлний "дэлэх, дэрвэх" гэсэн үгтэй холбоотой байж болох бөгөөд "бүргэд буйлуулах" гэдэг шиг шувууг ан авд сургах нэг зүйлийн тусгай нэр томъёоны чанартай үг бололтой юм. Жич о'орба хэмээх нь орчин цагийн монгол хэлний огоорох (орхих) гэдгийн хуучин хэлбэр болно. Бас НТ-ны 249-р зүйлд "о'орху шиба'ун" гэж гарч байгааг тэмдэглэе.

30. Хонши'уд гэдгийг хх-д臭氣(Өмхийрсөн) гэж орчуулжээ. Үүнийг бид орчин цагийн монгол хэлний "хурших" гэдэг үгийн эртний олон тооны хэлбэр бололтой гэж үзээд "хуршуулаад" гэсэн үгээр буулгав.

31. Хүнжи'үлэс гэдгийг хх-д 乾樹(Хатсан мод) гэж орчуулжээ. Монгол шүлгийн эн эн зэрэгцүүлэлтийн хуулиар үзвэл энэ нь дээрэх мөрийн "хожуул" гэдэгтэй ойролцоо утгатай байх учиртай тул яавч нэг үжирч хуучирсан модыг өгүүлсэн болов уу гэж үзээд "ёзоор" гэсэн үгээр утгачлан хөрвүүлэв.

32. Хүнши'уд гэдгийг хх-д 腥氣(Шинхэг үнэр) гэж орчуулжээ. Элдэнтэй, Ардаажав (1987,47) нар эл үгийг орчин цагийн монгол хэлний "хэншүү" гэдэгтэй холбож тайлбарлаад дагуур хэлний зарим аялгуунд шатмаг өөхний үнэрийг "хоншүн" гэсэн маягаар хэлдгийг дурджээ.

Эдүгээгийн ойлголтоор "хэншүү" гэх нь мах, тос, өөх мэтийн зүйлийг түлж шатааснаас гарах үнэрийг өгүүлэх тул яг энэ үгээр буулгахад арай оновчтой биш тул "лэгших" гэдэг үгээр утгачлан хөрвүүлэв.

33. Орчин үеийн монгол аман зохиолд эл зүйр үгийг

"Хүн ахтай

Дээл захтай" гэж хэлдэг байна (Дашдорж, Ринчинсамбуу,1964,108).

34. Ха'улуйа гэдгийг 盡搆咱每 (Булаан эзэлье) гэж орчуулжээ. Эл үг НТ-ны 36,164-р зүйлд довтлох, эзлэх, уулгалан дайрах гэсэн утгаар бас гарна. Үүнийг орчин цагийн монгол хэлний "уулгалах" гэдэг үгийн эхэндээ "х" авиатай байсан хуучин хэлбэр гэж зарим судлагчдын (Элдэнтэй, Ардаажав, 1986, 55) үзсэнийг бид зүйтэй болов уу гэж санаж байна.

35. Эйэтүлдүжү гэдгийг хх-д 商量着(Зөвлөлдөж) гэж оновчтой орчуулжээ. НТ-ны 36, 121, 123, 191, 209, 212, 223, 225, 278-р зүйлд гарах эл үг нь орчин цагийн монгол хэлний "эе,эелэх" гэдэгтэй үүсэл нэгтэй бөгөөд "зөвлөлдөх,хэлэлцэх,тохиролцох" гэсэн утгатай болно.

36. Алгинчи гэдгийг хх-д 頭哨(Түрүү харуул) гэж орчуулжээ. НТ-ны 37, 38, 123, 179, 273, 276-р зүйлд гарах "алгинчи" хмээх нь дайн тулалдаанд довтлон одоход цэргийн магнайд явж мэдээ занги авах,сэргийлэх үүрэг бүхүй хошуучлагч хүнийг хэлдэг байна. Гарлын хувьд эл үг манж хэлний "сураг, чимээ,алдар цуу" гэдэг үгтэй холбоотой болов уу гэж үзэж байна. (Цинциус, 1975, 30; Элдэнтэй, Ардаажав, 1986, 55)

37. Хасахба гэдгийг хх-д 問了(Асуув) гэж зүйтэй орчуулжээ. Элдэнтэй, Ардаажав (1986,56) эл үгийн тайлбар өгүүлэлдээ Алаша нутгийн аман аялгуунд "асуух"гэхийг "**асага**" гэж хэлдэг баримтыг иш татан уг үгийн авианы хувьслын талаар сонирхолтой ажиглалт хийсэн байна.

38. Жарчи'уд Аданхан ури'анхажин гэдгийг хх-д種名姓(Овгийн нэр,эмэгтэй) гэж тэмдэглэжээ. Эл хэллэгийн талаар судлагчид янз бүрээр ойлгож иржээ. Бидний бодлоор Жарчиуд гэдэг нь тэр жирэмсэн эхнэрийн авааль эрийн овог, аданхан буюу аданха гэдэг нь урианхай аймгийн нэгэн овог бүлгийн тухайлсан нэр бололтой юм. Тэр эмэгтэй хүн учраас "Аданхан урианхжин" гэжээ. Ийм учраас хх.орчуулгад зориуд эмэгтэй гэж тэмдэглэсэн байна.Хэрэв эрэгтэй хүн бөгөөс "Аданха

урианхдай" хэмээх ёстойг бид НТ-ны 44-р зүйлээс мэдэж болно.

Урианхайчууд бол Мэргэд, Барлаг, Баягууд, Байран, Түмэд, Хорчин, Хонгираад, Хэрэйд, Жалайр гэх мэтчилэн .монголын түүхэнд 72 аймаг гэж дурдагддагийн нэг томоохон аймаг болно. XYII зууны үеийн монголын түүхэн сурвалж "Шар тууж" зэргээр уламжлан ирсэн "Зургаан түмэн монголын магтаал" шүлэгт:

"Хулан гөрөөсийг идэж
Хулгар тарвагаар зулам хийж
Хулгайч дээрмийн даруул болсон
Худгийн усыг гаргагч
Урианхай түмэн" гэж дурдсан байдаг.

Одоо **урианхайчуудыг газар нутгийн байршлаар нь Алтайн урианхай, Тагнын урианхай, Сиян урианхай гэж нэрлэж байна.**

39.Тутхара гэдгийг хх-д 使喚(Зарах,хэрэглэх) гэж орчуулжээ. Мөн эл үг нь НТ-ны 124-р зүйлд "гэргэн тутхари" гэж гарсныг хх. орчуулгад 人口 (Хүн ам) гэж орчуулсан байна. Уг үгийн гарлын хувьд гэвэл: эртний түрэг хэлний "тут" (барих,олзлох),"хара"(боол зарц) гэсэн нийлмэл үгнээс үүссэн шинжтэй юм. (Наделяев, 1969, 591, 423) Орчин үеийн якут хэлд "тут" гэж мөн эртний түрэг хэлний "барих олзлох" гэсэнтэй адил утгатай ажээ (Пекарский, 1917, 2864) Харин "хара" гэдэг үгийн хувьд бол нийт алтай хэлтний дундын чанартай үг учраас орчин цагийн монгол хэлд ч ядуу доорд иргэдийг "харцуул борцуул" гэж хэлдэг нь мөн эртний түрэг хэлний "боол зарц" гэдэгтэй ойролцоо утгатай байна."Тутхара" хэмээх нь дундад эртний монгол хэлд " олзны зарц, олзны боол" гэсэн утгатай байжээ. Ийм учраас бид НТ-ны "аран тутхара ахуй сагухуй-а күрбэ" хэмээхийг "Ард боолыг [нь] эзэгнэн суух болов" гэсэн утгатай болов уу гэж санаж байна.

40. Мэнэ гэдгийг хх-д繁多(Олон, арвин) гэж орчуулжээ. Баарины өвөг Бариадайн хөвүүн Чидхул бөхийг олон эхнэртэй байсан тул хөвүүд нь мэнэ мэт төрөв гэсэн эл сонирхолтой зүйрлэлийг судлагчид янз янзаар ухаарч ойлгосоор иржээ. Тухайлбал проф. Э.Хэниш (1948, 6) "Мэнэд төрөв" гэсэн маягаар галиглан буулгасан байхад В.Кливез (1982, 8) хх-орчуулгыг баримтлан "олноор төрөв" гэж утгачлан орчуулсан байна. Захчидсэцэн (1972, 32) Хөх хотын "Ин Шан" уулыг монголоор "манаг" гэдэг гэжээ. Гэтэл акад.Ц.Дамдинсүрэн үүнийг орчин

цагийн монгол хэлний дуудлага ойролцоо "манан" (будан) гэдэг үгээр буулгасан байхад Элдэнтэй, Ардаажав нар дорнод монголын алдарт их Мэнэнгийн талтай адилтган тайлбарласан зэргээс үзвэл эл үгийн хувьд судлагчид санал нэгдээгүй байна.

Монголын НТ-нд "мэнэ мэт" гэж дурдсан тул бидний бодлоор мэнэ гэдэг нь олон гэсэн утгатай тэмдэг нэр хараахан биш харин олноор төрж үрждэг ямар нэг үр зулзага мэтийн тусгай нэр бололтой байна. НТ-ны 260-р зүйлд "**мэнэ** мэтү йэкин эйин донхотуму" гэж өгүүлснээс үзвэл ямар нэг амьтан (шувуу?) болох нь илэрхий байна. Тэрчлэн монгол хэлний язгуурын тольд: "Бас олон үрт ургамал бодис ба хөдлөх бодисын үрсийг **мэнэ** ч гэж тайлбарлах буй" (Сэцэнцогт, 1988, 1384) гэсэн сонирхолтой баримт байгааг бас анхаарах хэрэгтэй юм.

41. Жүгэли гэдгийг хх-д以竿懸肉祭天(Модонд мах өлгөж тэнгэр тахих) гэж тайлбарлан орчуулжээ. Эл үгийг судлагчид янз бүрээр ойлгож, тайлбарласнаар ирснийг Л.Хурцбаатар (1986, 6) "Хатгин арван гурван тэнгэрийн тайлга" гэдэг номдоо дэлгэрэнгүй өгүүлсэн байна. Эрдэмтэдийн судалгаанаас үзвэл жүгэли гэдэг нь урт модны үзүүрт мах юмуу зүрх зүлд өлгөж тэнгэр тайх тайлгын ёслолыг хэлдэг ажээ.Харин уг үгийн гарлын хувьд яг нарийн тодорхойлсон зүйл хомс бөгөөд бидний бодлоор жүгэли буюу тахилга үйлдэхэд дээд тэнгэрт өргөл мөргөл хийх учиртай тул "**жүгэли** буюу **жүгэри** гэдэг нь эртний түрэг монгол хэлний дээд тэнгэрийг төлөөлсөн чанартай нэр байж болох юм. Эртний түрэг хэлд "жүгэрү (Өөд, дээш, дээр) [Наделяев, 1969, 284] гэсэн үг байдгийг бас харьцуулан үзэж болно. Проф. Пекарский (1917, 866) якут хэлний "жүгэли" хэмээхийг монгол хэлний "зүглэх" (зүг зүгт эргэх) гэдэг үгтэй гарал нэг гэж үзсэн сонин ажиглалт буй. Ингэж үзвээс бидний ярилцаж буй "жүгэли" хэмээх нь зүг зүгийн тэнгэрт эргэл мөргөл үйлдэх ёс заншлаас уламжлалтай байж бас болох талтай юм.

42. Дару'а гэдгийг хх-д 常川 (Үргэлж) гэж орчуулжээ. Олонхи судлагчид хх.орчуулгыг баримтлан "үргэлж, ямагт, байнга" гэсэн утгаар хөрвүүлжээ. Элдэнтэй, Ардаажав (1986,64) уг үгийн тайлбар өгүүлэлдээ "Ачлалт номын "IX бүлгээс "Хан мэт эцэгтээ **даруг-а** (үргэлж) асрагдсан ачаас хүнд үгүй" гэсэн жишээг иш татан утгыг тодорхойлоод орчин цагийн монгол хэлний "дараа дараагаар " юм уу үргэлж гэсэн үгийн хуучин хэлбэр гэж үзэв.

43. Сэчэ-<u>Бэки</u> гэдгийг хх. орчуулгад хамтад нь 名 (нэр) гэж тэмдэглэжээ. Харин НТ-ны 216-р зүйлд 官名(Ноён хэргэмийн нэр) гэж тайлбарласан нь зүйтэй бололтой. Эртний түрэг хэлд бег бек гэдэг нь жолоодогч, удирдагч, ван, ноён гэсэн утгатай (Наделяев, 1969, 91) байх ба якут хэлд монгол хэлний бэки гэдэгтэй ойролцоо дуудлагатай "бэги" гэх үг нь "өндөр, ахмад" гэсэн утгатай (Пекарский, 1917, 419) байгаа нь мөн сонирхууштай баримт юм. Эцэст нь тэмдэглэхэд бэки бэхи гэдэг үгийн НТ-нд гарч буй утга санаа нягтлан үзвэл ноён юмуу хатан хэргэм нэрийдсэн цол гуншинг илэрхийлж байна.

44. <u>Мэнгэтү Кийан</u> гэдгийг эл зүйлийн хх.орчуулгад 名 (нэр) гээд, 67-р зүйлд **Есүкэи Кийан**-ийг 人氏(хүний овог) гэж тэмдэглэжээ. Эл нэрийн гарлын талаар Рашид Ад-дин (1952, 1, 154) Мэнгэтү гэдгийг монгол хэлний "мэнгэ толбо" гэдэг үгтэй холбож , Кийан хэмээхиийг нь өндөр уулнаас буух хүрхрээний ширүүн урсгалтай зүйрлэж гарсан үг тул Киад хүн эрэлхэг баатарлаг, зүрх зоригтой байдаг гэсэн байна.Ямарч атугай Кийан хэмээх нь НТ-ны 63-р зүйлд гардаг Кийад гэдгийн ганц тооны хэлбэрболох нь тодорхой юм. Энэхүү Кийан (хиан) буюу Кийад (Хиад) хэмээх нь Чингис хааны язгуур угсааны боржгин овгийн доторх яс элгэнийг заасан нэр бололтой. Эрдэмтэн Сайшаал (1987, 1, 6)" Чингис хааны товчоон" гэдэг зохиолдоо "Эргүнэ Хунгийн домогт " гардаг Нүкүз, Киан хоёрын Кианы нэрээс Кийуд ястны нэр үүссэн гэж тодорхойлсон нь зүйтэй байна.

45. <u>Түн</u> гэдгийг хх-д 林 (ой, шугуй) гэж орчуулжээ. Уг үгийн гарал нь түрэг монгол хэлний "шөнө" буюу "балар харанхуй" гэдгээс үүсэлтэй ажээ. Эртний түрэг хэл (Наделяев, 1969, 597) хийгээд якут хэлд (Пекарский, 1917,2893) "түн" хэмээх нь "шөнө" гэсэн утгатай байна. Мөн монгол түрэг хэлний "түнэр түнэрэх" гэдэг үг ч түүнээс гаралтай нь илэрхий.Ийм учраас НТ-ны "түн" гэдэг бол балар ой шугуй гэсэн утгатай үг гэж үзэж болно.Халх аялгуунд ой мод гэсэн утгаар хэрэглэгдэхгүй боловч өтгөн ой модтой газрыг нэрлэсэн нэр болж үлдсэн нь бий.Улаанбаатараас баруун хойш 40 орчим км . газарт Түнхэл гэж их модтой газар буй.Харин Хорчин Зуу Одын аман аялгуунд түн гэдэг үг өтгөн балар ойг заасан утгаа хадгалсаар байгаа ажээ.(Элдэнтэй,Ардаажав,1986,77)

46. <u>Ханхас</u> гэдгийг хх-破開的(хагалах, ангайлгах) гэж орчуулжээ. Эл үгийг судлагчид орчин цагийн монгол хэлээр "хага цавчих,тас

цавчих,яран цавчих" гэх зэргээр ерөнхийдөө хх.орчуулгыг баримтлан ойролцоо үгээр хөрвүүлжээ.Бидний саналаар уг үгийн гарал нь орчин цагийн монгол хэлний "ангайх ангайлгах" гэдгийн эхэндээ "х"авиаг хадгалсан хуучин хэлбэрээс уламжлалтай болов уу гэж санаж байна. Ийм учраас бид энэ утгыг нь харгалзан буулгахыг эрмэлзэж "ангас1хийтэл1"гэж хөрвүүлэв. Бэлгүүтэйн мөрийг Бүри бөх илдээр цавчсан эл үйл явдлыг хойно 131-р зүйлээс танилцаж болно.

47. Татар жүйин иргэн гэдгийг хх-д 種姓 (аймгийн овог) гэж тэмдэглэжээ.Эл хэллэгийн "жүйин" гэдэг үгийг судлагчид янз янзаар төсөөлөн буулгаж иржээ. Жишээлбэл Алтан-Очир (1942, 13) "Татар чу-уд иргэн" гэсэн байхад проф.В.Кливез "the Tatar Juyin people" гэж тусгай нэрийн чанартай буулгасан байна. Гэтэл зарим судлагчид "жүйин" гэдгийг "Жа-ут хури" гэдгийг "жа" (劄) хэмээхтэй холбоотой болов уу гэж таамаглаж байна. (Иринжин, 1987, 32)

48. Китад-ун гэдгийг хх.орчуулгад契丹的(Хитаны) гэж тэмдэглэжээ. Үүнийг одоогийн "Хятад" буюу Нангиад гэдгээс ялгахын тул Хитан гэж бичвэл зохих юм. Энэ нь чухамдаа 1115-1234 оны үед тогтнож байсан Жүрчидийн Алтан улсыг өгүүлж байгаа юм. Энэхүү Алтан улсын өгүүлж байгаа юм. Энэхүү Алтан улсын бүрэлдэхүүнд Жүрчид хэмээх манж нараас гадна Хятан нар нэлээд хувийг эзлэж байсан тул ийнхүү нэрлэсэн билээ.Одоогийн хятад гэдэг үг ч Хятан гэсний олон тооны хэлбэрээс үүсэлтэй нь илэрхий. Уг нэр НТ-ны 151, 152, 177, 198, 247, 251, 263, 272-р зүйлүүдэд "Кидад-Китад" гэсэн хэлбэрээр гарч байна.

49. Хаүуттала гэдгийг хх-д磨盡了(Элэгдтэл барагдтал) гэж орчуулжээ. Бид эл үгийг орчин цагийн монгол хэлний "авчих-автах" гэдэгтэй гарал нэгтэй болов уу гэж үзээд НТ-ны хос мөр шүлгийг

"Арван хуруудаа
Авчтал" гэж буулгав.

50. Хачи гэдгийг хх-д佳誰(өшөө, өшөө хорсол) гэж орчуулжээ. НТ-нд "хачи" буюу "ачи" гэдэг үг 53, 77, 78, 102, 105-р зүйлүүдэд "өшөө хорсол" гэсэн утгаар гарахаас гадна "ач тус, элбэрэл" гэсэн утгаар 75,163,177,214-р зүйлүүдэд бас тохиолдож байна.

51. Буситаи гэдгийг хх别有的(өөр, бусад) гэж оновчтой орчуулсан боловч олонхи судлагчид "гоо үзэсгэлэнтэй, сайхан" гэсэн утгаар орчин цагийн монгол хэлээр хөрүүлсэн байх юм. Харин В.Кливез хх.орчуулгыг баримтлан "ер бусын үзэсгэлэнт эмэгтэй гэсэн маягаар англи хэлээр

орчуулсныг тэмдэглэе. Бид энэхүү "буситай" хэмээхийг "эгэл бус, өөр, адилгүй" гэсэн утгатай уг гэж үзээд "өнгө зүс ижилгүй, үзэсгэлэнтэй" гэж хөрвүүлэв.

52. Хурдун хуби гэдгийг хх-д 快黃馬(хурдан шарга морь), мөн 黃 (гүехэн шарга) гэж орчуулжээ. Эл үгийг Ц.Дамдинсүрэн багш, Хуацай Дугаржав, Мансаан нар "хурдан **ухаа** морь" гэж орчин цагийн монгол хэлээр хөрвүүлжээ. Гэтэл "ухаа" гэдэг зүсийг хх.орчуулгад慘白(цайвар) гэсэн үгээр буулгасныг бас харгалзалгүй болохгүй санагдана. Уг үгийн утгыг Элдэнтэй, Ардаажав (1986,94) нар "Эрдэнийн товч" зэрэг түүхэн зохиолоос иш татан хурдан хуби хэмээхийг "хурдан хул" болно гэж зөв тодорхойлжээ. Монгол хэлний б-л авиа сэлгэх тул эртний монгол хэлд "хуба" (хуби) байснаа сүүлдээ "хула" болсон ажээ. "Асрагч нэртийн түүхэнд": "Чилэдү хурдан **хуба** юугаа гуядан дутаабай" гэсэн буй. Энэ нь угтаа эртний түрэг хэлний шаргал, хул өнгийг заасан "хуба" (Наделяев,1969,462) гэдэгтэй нэг гаралтай ажээ.

Бидний ойлголтоор энэхүү "хурдан хуби" буюу "хурдан хул" нь зөвхөн зүс заасан төдийгүй аргамаг сайн хүлгийн шинжийг бэлэгдсэн утга бас байх бололтой. Тухайлбал "Морины шинжийн сударт" хурдан хубийг "Нүд хурц, чих нь шовх, сагагийн үс нүцгэн, самсаа үгүй шодон, үргэх, цуцах цагт сайн" гэж тодорхойлсон байдаггэж Х.Лувсанбалдан надад 1986 онд мэдээлж билээ. Үүнээс гадна монгол үлгэр туульд хул буюу хулагч зүсмийн морь гүүг онцгой эрхэмлэн өгүүлсэн зүйл цөөнгүй буй. Жишээлбэл адгуусны туулийн ул мөрийг шингээсэн "Цуутын цагаагч гүү" гэдэг үлгэрийн зарим хувилбарт "Далан гурван ижилтэй дархийн хул азрагатай Цуутын цагаан **хулагчин** гүүг" (Поппе,1955,112-122) маш онцгой байдлаар өгүүлсэн байдаг. Эдгээр баримтаас үзэхэд "хуби хул" хэмээх зүс нь монголчуудын эртний уламжлалт бэлгэдлийн өнгө бололтой байна.

53. Хубури намбалис гэдгийг хх-д 岡越過(дов толгод даван) гэж орчуулжээ. Үүнийг Ц.Дамдинсүрэн, Дугаржав, Мансаан нар "Уулын бэлээр дутаав","Уулыг даван дутаасан","Цаадах говийг даван буруулан дутаав" гэх зэргээр орчин цагийн монгол хэлээр бага сага ялгаатай хөрвүүлжээ. Харин Э.Хэниш, В.Кливез зэрэг эрдэмтэд хх.орчуулгыг баримтлан "гүвээ толгод даван дутаав" гэсэн утгаар ерөнхийдөө оновчтой буулгасан байна. Эл үг НТ-ны 56-р зүйлд "долоон гүвээ давтал" гэж мөн энэ утгаар гарна.

Хубури буюу губури гэдэг үгийн гарлын хувьд гэвэл Элдэнтэй, Ардаажав (1986,94) нар орчин цагийн монгол хэлний "гурив" гэдэг үгийн "р" "б" авиа солигдсон хэлбэр гэж үзсэн нь зүйтэй байна. Дөрвөд аялгуунд "гурив зуух" ховил, жалга, ганга, хонхор газрыг хэлдэг юм.(Цолоо, 1988, 367)

Намбалис гэдэг үгийн хувьд энэ нь орчин цагийн монгол хэлний "намнах" гэдэгтэй гарал нэгтэй байж магадгүй юм. Хөх нуурын монголчуудад нүх, гуу сувгийг үсрэн гарахыг мөн "намбалис" гэж хэлдгийг Элдэнтэй нар мөн үгийн тайлбар өгүүлэлдээ тэмдэглэсэн байна.

54. **Хучилис** гэдгийг хх-д 裹過 (дундуур нь өнгөрөх) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "хучих" гэдэгтэй үүсэл нэгтэй бөгөөд НТ-нд "ороож, тойрж" гэсэн утгаар оржээ. Эл үг мөн "ороох, тойрох, бүслэх" гэсэн утгаар 102, 111, 145, 199, 205-р зүйлүүдэд гарна.

55. **Таки** гэдгийг хх-д 也 (бас, гэж) гэсэн сул үгээр орчуулжээ. Үүнийг бид орчин цагийн монгол хэлний "мөн, бас, чиг" гэх мэтийн холбоо үгтэй утга ойролцоо болов уу гэж санаж байна. Эл үг НТ-ны 190, 197-р зүйлд мөн дээр дурдсан холбоос үгийн утгаар гарч байна.

56. Олонхи судлагчдын "**наруйитчу**" гэсэн байдалтай галигласныг Элдэнтэй, Оюундалай (1980, 55) нар "НТ-ны нангиад галигийн харьцуулсан сийрүүлэгтээ" уг үгийг納*魯亦惕拙налуйитжу) гэж галигласан нь уул үгийн дуудлагыг зөв сэргээсэн байдалтай юм. Бид үүнийг орчин цагийн монгол хэлний "налах, хазайх" гэсэн үгтэй холбоотой гэж үзээд "налсхийж авмагц" гэж хөрвүүлэв. Харин НТ-ны хх-д 探着 (өнгийж харах) гэж орчуулсан нь арай оновчтой биш болов уугэж санана. Учир нь НТ-ны 54-р зүйлд "өнгийж үзвээс" гэдгийг мөн ингэж орчуулсан учраас баахан эргэлзээтэй санагдана.

57. **Дэлбэгэ** гэдгийг хх-д 韁索 (уяа, жолоо) гэж ерөнхийдөөзөв орчуулжээ. Эл үг нь орчин цагийн монгол хэл аялгуунуудад мөн хэрэглэгдсээр байгаа ажээ. "Монгол хэлний товч тайлбар тольд":"дэлбэг" гэдгийг "тэрэгний морины жолоо" (Цэвэл, 1966, 224) гэж тайлбарласан байна. Эдүгээ хуучин баргын аман аялгуунд морин тэрэгний жолоог мөн "дэлбээ" гэдэг байна. Тэрчлэн алтай язгуурын дагуур, солон хэлд мөн "жолоо, цулбуур" гэсэн утгатай байдгийг тэмдэглэе (Элдэнтэй, Ардаажав, 1986, 99; Цинциус, 1975,232) Бидний санавал Есүхэй баатар морин тэрэг бус тэмээн тэрэг хөтлөж явсныг

өгүүлсэн тул орчин цагийн монгол хэлэнд "бурантагнаас хөтлөж" гэж хөрвүүлэх нь зүйтэй болов уу гэж үзэв.

58. **Килигу** гэдгийг хх-д 車轙 (тэрэгний арал) гэж орчуулжээ. Эл үг бас НТ-ны 177, 186, 200, 214-р зүйлүүдэд "килүгүн" гэсэн хэлбэрээр мөн тэрэгний арал гэсэн утгаар гарч байна. Ялангуяа 177-р зүйлд "хойар килүгүтэи тэргэн" (хоёр аралтай тэрэг) гэж тов тодорхой **өгүүлсэн буй.**

Ийм учраас "килигу дэргэчэжү" гэдгийг судлагчид голцуу "тэрэгний арал зэрэгцэж" хэмээн орчуулсан байна.

59. **Шибүлгэр** гэдгийг хх-д 練椎 (нуруу дагасан ?) гэж орчуулжээ. НТ-ны 56, 214-р зүйлд гарах "шибүлгэр-шибилгэр" хэмээх үг нь "гэзэг, үс" гэсэн утгатай юм. Галын тахилгын сударт:

"Шил сайт хөвүүд
Шибэргэл сайт охидын
Хишиг буян хайрла!" гэсэн байдаг. Тэрчлэн

"Жангарын туульд" **шибэргэл** гэдэг үг мөн гэзэг үс гэсэн утгатай байдгийг Мансаан (1985, 36) ажигласан байна. Харин орчин цагийн монгол хэлд "шивэргэл" хэмээх нь гэзэг үсний дүгтуй, гэрийг нэрийдэх болсон байна.(Цэвэл, 1966, 843, Цолоо, 1988, 776)

60. **Жубур** гэдгийг хх-д 川 (гол, хөндий) гэж орчуулжээ. Бидний санавал

Онан мүрэн ни долгистала

Ой жубур да'уристала хэмээн эн зэрэгцүүлэлтийн аргаар холбосон эл хоёр мөрийн "мүрэн" (мөрөн) "жубур" гэсэн хоёр үг нь утга ойролцоо байж болох үндэстэй учир хх.орчуулгыг оновчтой гэж үзэж болно. НТ-г орчин цагийн монгол хэлээр буулгасан эрдэмтэдийн дотроос Мансаан (1985, 16) "Ой хөндийг дууристал" гэж орчуулсныг бид зөв болов уу хэмээн баримтлав. Якут хэлд "жоборо" гэж хавцал, гангыг (Пекарский, 1917, 834) хэлдгээс үзвэл эртний монгол хэлний "жубур" гэдэг нь хавцал ганга, хөндий газрын тухайт нэр байж болно.

В.Кливез хх.орчуулгыг баримтлан англи хэлээр "жубури" гэдгийг "valley" (хөндий) гэж буулгахын хамт НТ-ны 57, 104, 115, 117, 201, 206-р зүйлд гарч буй "Хорхонаг жубур", "Хөкөртү жубур" гэх мэт газрыг "Хорхонаг хөндий" гэсэн утгаар нэгэн мөр болгож жигдэлсэн нь эрдэм шинжилгээний их туршлагатай эрдэмтний нарийн ажиглалтын нэг жишээ болно.

61. **Ха'улуха** гэдгийг хх-д 道路 (зам) гэж орчуулжээ. Бидний

бодлоор эл үгийн гарал нь орчин цагийн монгол хэлний "харгуй" гэдэгтэй гарал нэгтэй болоолтой. Монгол хэлд р-л аэвиа сэлгэх үзэгдэл түгэээмэл байх тул эртний монгол хэлний зарим аялгуунд "харгуй" гэдгийг "халугы" гэсмэн маягтай хэлдэг байсан байж болох юм. Одоогийн ойрд, халимаг аялгуунд "зам мөр" гэсэн үгийг "хаалх" гэж хэлдэг байна. (Муниев, 1977, 560). Үүнээс гадна НТ-ны 56, 183-р зүйлд гарч буй эл хэллэгийг сүүл үеийн зарим түүх шастирт **ормөр** гэсэн утгаар өгүүлснийг бас анхаарах хэрэгтэй юм. Тухайлбал "Чингисийн цадигт":

Гурван гол гэтлэв
Гурван гурви давуулав
Хайвал мөргүй
Харвал бараагүй
Хайлбал үл сонсдоно гэжээ.

Харин НТ-ны 57,75-р зүйлд гарч буй "ха'улуха" гэдэг үгийн хувьд бид үүнийг "зам,мөр" гэдгээс өөр утгатай гэсэн санал дэвшүүлсэн билээ.

62. <u>Саглагар модун</u> гэдгийг хх-д 遢糅樹(намаа мөчирлөг мод) гэж орчуулжээ. Монголын НТ-ны 57, 117, 206-р зүйлд гардаг "саглагар мод" бол ардын үлгэр туульд олонтаа тохиолддог "өнчин хайлс, удган мод, оройн ганц мод, захын мод" зэргийн нэгэн адил эртний хүмүүсийн мод эрхэмлэн дээдлэх зан үйлээс уламжлалтай зүйл бололтой байгаа юм. Бөөгийн дуудлагын шүлэг (Ринчен, 1959, 33) хийгээд зарим сацлын сударт:

"Дэлүүн болдогт дүүрэн ес
Дэвсэх саглагар модонд дүүрэн ес сацнам"

гэсэн буй. Үүнээс үзвэл эртний хүмүүс саглагар модыг тахиж тайж, сацал өргөж байжээ. Саглагар модны учир холбогдлын талаар Өвөр монголын эрдэмтэн Х.Буянбат (1988, 13-20), Улаан хад хотын монгол үндэстний багшийн тусгай мэрэгжлийн сургуулийн багш Хүүдагуул (1986, №-4) нар тусгай өгүүлэл бичжээ.

63. <u>Хабирха-та ха'улуха, эбүдүк-тэ өлкэг болутала</u> гэдгийг 没肋扇的路渠 没膝的灰土做了 (Хавиргандаа зам ховил, евдгөндөө тоос болголоо) гэж орчуулжээ. Энэхүү зүйр үгийн утгыг судлагчид янз бүрээр ойлгож харилцан адилгүй орчуулсаар иржээ. Тухайлбал Бөххишиг (1941, 24) "Хавирга дахь замыг өвдөг чинээ болтол дэвсэв", Э.Хэниш (1948, 9), С.Козин (1941, 85) нар "Хажуу хавиргаараа газар хонхойтол

өвдгөө тоос болтол бүжиглэв" гэсэн маягаар, Ц.Дамдинсүрэн (1976, 30) "Хавирга газрыг халцартал, өвдөг газрыг өлтертөл дэвхцэн бүжиглэв"гэж, В.Кливез (1982,14) "Хавиргандаа ховил гартал, өвдгөндөө тоос болтол бүжиглэв" гэсэн маягаар, Дугаржав (1984,16) "Хавирга газрыг халцартал, өвдөг дүүрэн тоос болтол бүжиглэн наадаж хуримлав" гэж, Мансаан (1985,17) "Хавирга тулам халцруулж, өвдөг давтал бужигнуулан бүжиглэж хуримлабай" гэх зэргээр хөрвүүлсэн байна.

Бидний бодлоор эл зүйр үгийн утга санааг зөвөөр ойлгоход эн зэрэгцүүлсэн мөрийн **ха'улуха, өлкэг** гэдэг хоёр үгийн утгыг юуны өмнө зөв тодорхойлох хэрэгтэй байгаа юм. Энэ хоёр үгийг хх. орчуулгад ха'улуха гэдгийг нь 路渠(зам ховил) гэж өлкэг гэдгийг нь 灰土(тоос) гэж буулгажээ. Уг нь монгол шүлгийн эн зэрэгцэүүлэлтийн хуулиар эл хоёр үг нь ойролцоо утгатай юм уу учир зүйн нарийн авцалдаатай үгс байх ёстой билээ. Гэтэл хх. орчуулгыг туурвигч нь ха'улуха гэдгийг 56-р зүйлд "зам" гэсэн утгаар гарсан адил дуудлагат үгийг мөн биз гэж таамгаар тавьсан бололтой юм. Эл хоёр үгийг харилцан өөр утгатай болохыг гэрчлэх баримт НТ-нд бас байна. Тухайлбал НТ-ны 75-р зүйлд

Гоо Үжиний
Гогод мангираар тэжээсэн
Ха'улуха хөвүүд

Хойира'ут (хуультан) сайд болов гэсэн шүлгийн "ха'улуха" гэ+дгийг хх. орчуулгад үг оноосонгүй орхижээ. Үүний нөгөө талаар утга агуулгыг нягтлан үзэхэд яавч зам харгуй гэсэн утгатай байж таармааргүй юм. Бидний саналаар НТ-ны 57, 75-р зүйлд гарч буй ха'улуха гэдэг нь орчин цагийн монгол хэлний "хуулах" гэдэг үйл үгээс үүсэлтэй **хуулга** (сонгодог монгол бичгийн **хагулг-а**) хэмээхийн хуучин хэлбэр бололтой байна. Энэ нь эдүгээгийн хальс, ханчир гэдэгтэй ойролцоо утгатай бөгөөд чухам шүлгийн санаа нь эцэж цуцтал бүжиглэв гэсэн ажээ.

Өлкэг гэдэг үгийн хувьд энэ нь эртний түрэг монгол хэлний "амьгүй, үхдэл, өвчин, эмгэг" гэсэн утгатай **өл-өлүг** (Наделяев, 1969, 383, 384: Севортян, 1974, 525, 526) гэсэн үгтэй гарал нэгтэй бололтой. Орчин цагийн монгол хэлд "өлөг өвчин" гэх нь "өвдөөд байх эвэршилгүй бөгөөтлөө доройтох өвчинг" (Цэвэл, 1966, 435) хэлдэг бол якут хэлд өлүк гэх нь мөн "хүч дорой, эцэж туйлдсан" (Пекарский, 1917, 1939) гэсэн утгатай ажээ. Дээр өгүүлсэн баримтаас үндэслэж бид эл зүйр

үгийг орчин цагийн монгол хэлд:

"Хавиргандаа ханчир [болтол]
Өвдгөндөө өвчин ортол бүжиглэв?" гэж хөрвүүлэв.

64. Жөб гэдгийг хх-д 正 (зөв, мөн) гэж орчуулжээ. Эл үг НТ-нд "зөв, зүйтэй" гэсэн гол утгаас гадна бас "чухам яг" гэсэн утгаар 59, 82, 182, 190-р зүйлүүдэд гарч байна. Ийм учраас хх. орчуулгад ч эл утгын ялгамжааг харгалзан зарим тохиолдолд 是 (тийм, зүйтэй) гэсэн үгээр орчуулсан байна.

65. Нөдүн гэдгийг хх-д 血塊 (бөөн цус) гэж оновчтой орчуулжээ. Чингис хааныг "төрөхдөө баруун гартаа шагайн чинээ нөж (нөдүн) атган төржээ" гэсэн нь чухамдаа монгол туульсын баатар эрсийн эр хар чулуу мэт атган төрдөг ер бусын төрөлтийн өгүүлэмжтэй холбоотой зүйл болно. Тухайлбал "Гэсэрийн туужийн" зарим хувилбарт түүнийг төрөхдөө: "Зүүн гартаа шагайн чинээ **хар нөж**, баруун гартаа эр хар чулуу атгаж гарсан" (Цэрэнсодном, 1987, 90) гэж байхад ойрд "Жангарын", "Догшин лам Хавхын бүлэгт":

"Нэг гартаа нудрамын (нудрага) чинээ
Хар чулуу атгасан
Нэг гартаа **шав цус** барьсан
Нэг хөлөө жийсэн
Нэг хөлөө тахийсан
Нэг хөвүүн гардаг жэ" гэх зэргээр туулийн баатрыг ер бусын маягаар төрсөн жишээг олныг дурдаж болно.

66. Чаган шинхор гэдгийг хх-д 白海青 (цагаан шонхор) гэж орчуулжээ. Хонгирадын Дэй сэцний "Цагаан шонхор шувуу нар сарыг атган нисэж ирээд гар дээр минь буув"гэж Есүхэй баатарт зүүд зөн болгож ярьсан үг бол монголчууд эрт дээр цагаас нар, сарыг эрхэмлэн шүтэж ирсэн домог-үлгэрийн ойлголттой холбоотой ажээ. Монгол домог-үлгэрт нар, сарыг тэнгэрийн эгч дүү хоёр дагина хэмээн төсөөлсөн өгүүлэмж буй. Ойрд монголчуудын хуримд шинэ бэрийг шар наранд эхлэн мөргүүлж, мөн аливаа найр цэнгэлээ нар гартал үргэлжлүүлдэг ("Нар халиатал найрлах") ёс заншил нь цөм нарыг эрхэмлэн дээдлэх үзлийн илрэл болно. Хүннү нарын хаан өглөө наранд, үдэш саранд мөргөдөг заншилтай байсан гэх мэдээ бий (БНМАУ-ын түүх, 1966, 1, 94). НТ-ны эл домгийн нар сарыг шонхор шувуу атган нисч ирсэн гэх нь ч санамсаргүй өгүүлсэн зүйл биш болно. Уг домгийн

төгсгөлд Дэй сэцэн "Юун зүүд байх вэ? Танай Хиад иргэний сүлд ирж заасан ажгуу" гэснээс үзвэл цагаан шонхор шувуу нь Хиад овогтны сүлд буюу онгон сахиус байсан бололтой. Өвөр монголын эрдэмтэн Сайшаал (1989,1) "Монголын нууц товчоо ба угсаа гарлын тухай" гэдэг өгүүлэлдээ Ордосын Хангин хошууны Ар цайдам гэдэг газраас олдсон булшны эдлэл хэрэглэлийн доторх малгайн чимгийг оюу толгойтой алтан шонхроор хийснийг судлаж үзээд "Энэ бол Хүннү нар шонхроор оройн чимэг болгож байсныг харуулж байна" гэжээ. В.Кливез (1982, 15) уг үгийн орчуулгын тайлбарт цагаан шонхрын утга чанарыг монголчууд цагаан өнгийг эрхэмлэдэг заншилтай холбож, тухайлбал НТ-ны 80, 189, 202, 216, 239-р зүйлүүдэд гарч буй "цагаан чулуу, цагаан эсгий, цагаан дээл, цагаан туг, цагаан шонхорнууд" зэрэгтэй харьцуулан өгүүлсэн байна.

67. Сүлдэр гэдгийг хх-д 吉兆 (сайн бэлэг) гэж утгачлан орчуулжээ. Эл үг бас НТ-ны 201, 249-р зүйлд мөн сүр сүлд, сахиус гэсэн утгаар гарч байна. Уг үгийн гарлын талаар бид тодорхой хэлэх баримт үгүй бөгөөд орчин цагийн монгол хэлний сүлд-сүнс гэдэгтэй нэг язгууртай болов уу гэж санана. Мөн якут хэлний "хүчирхэг аймшигт"гэсэн утгатай сүлэ (Пекарский, 1917, 2387) гэсэн үгтэй харьцуулан судлаж болох юм.

68. Хасаг тэргэн гэдгийг хх-д 大車 (их тэрэг) гэж орчуулжээ. Хасаг гэдэг нь эртний монгол хэлд дугуй, цагираг гэсэн утгатай байсан тул энэ нь хүрдэт тэрэг буюу дугуйт тэрэг гэсэн ойлголт бололтой. Үүний жишээ гэвэл орчин цагийн монгол хэлд тулганы цагриг төмрийг хасаг гэхээс гадна якут хэлд юм агуулах торх маягийн бөөрөнхий юм уу дугуй хэлбэртэй савыг хасаг гэдэг байна. (Пекарский, 1917, 3385)

69. Хатун халхатан, окид өчилтэн гэдэгзүйрүгийг娘子團牌每女子每奏事的(хатдаар бамбай болгож, охидоор учир мэдүүлдэг) гэж утга санааг нь нэлээд тодорххой тайлбарлан гаргажээ. Эл зүйр үгийн утга нь бидний ойлголтоор:

Хатдаар халхавч болгодог
Охидоор өчил хариу барьдаг гэх буюу өнгөөр илбэн засдаг заншилтай улс гэсэн утгатай ажээ. Уг зүйр үгийн утгыг НТ-ны энэ шүлэгт:

Зээгийн зүс
Охины өнгөөр [явж] бөлгөө бид хэмээн өгүүлж мөн

санааг бататгаж өгсөн байна. Энэ зүйр үгийн утгыг БНХАУ-ын Төвийн үндэстний дээд сургуулийн дэд проф. Хишигтогтох "Хуа-и И-ю" тольд халх-а гэдгийг "гэрч тэмдэг" гэсэн утгаар орчуулсан баримтыг үндэслэж "Хатан халх-а (гэрч) эрхлэн, охид учир мэдүүлдэг үүрэгтэй" гэсэн утгаар "Эртний монгол шүлгийн түүвэр" (Хишигтогтох, 1985, 44) гэдэг номынхоо тайлбар өгүүлэлд тодорхойлжээ.

70. Курикэт-тэ талбижу гэдгийг 做女婿放下着(хүргэнээр үлдээ) гэж оновчтой орчуулжээ.

Хүргэд талбих ёс бол хүргэний шинж чанарыг таниж, түүнийг шилж сонгох эрт цагийн эхийн эрхт ёсны уламжлалт зан үйлийн нэг болно. Ийнхүү хүргэн хүүг хадам ургийн газар суулгаж хөлс хүчий нь авдгаас уламжлаж монгол аман зохиолд:

"Хүргэн хүү хүчээ" гэх юм уу
"Хүргэн хүү хүчгүй
Хүзүүний мах амтгүй"
"Айлд орсон хүргэн
Авдран дээр залсан бурхан" гэх мэтийн зүйр үг гарчээ. Энэхүү хүргэд талбих ёс нь хүргэн хүү хүч хөдөлмөрөө хадмындаа зарцуулж хүч чадлаа үзүүлэхийн хамт шинэ ураг төрлийн гэр бүлд танилцуулан дасгах зорилттой юм. Монголын цаатангууд 9, 10 настай хүүхдийг туст нь жижиг урц барьж худгайн тал хооронд нь дасгадаг уламжлалтай байжээ (Нарантуяа, 1974, 115).

Монгол үлгэр туульд хүргэн болох хүний хүч эрдмийг сорьж, гадаад далайн цаад захаас гарьд шувууны өндөг авч ир, амьд чандмань эрдэнэ олж ир гэх зэргээр хэцүү бэрх ажил үйлст зарж явуулах нь уг таа мөн эхийн эрхт ёсны хүргэд сорих юм уу хүргэд талбих эртний зан үйлийн уран сайхны хэтрүүлэлтэй дүрслэл ажээ.

71. Кэкэсү гэдгийг хх-д 宪警 (өшөө хорсол) гэсэн хоршоо үгээр орчуулжээ. Уг үгийн гарлыг бид тодорхой мэдэхгүй боловч утга санааг нь хх. орчуулга хийгээд судлагчдын орчуулга, тайлбар сэлтээс мэдэж байна. Якут хэлд "хорсох, үзэн ядах" гэсэн утга бүхүй "кегесе" (пекарский, 1917, 1005) гэсэн үг байх нь бидний авч үзэж буй "кэкэсү" хэмээхтэй утга, дуудлагын аль аль талаар маш ойролцоо байгаа нь анхаарал татах сонин баримт юм. Мөн Лу.Алтан товчид "Кекесүлен" гэсэн байна.

72. Хуиржу гэдгийг хх-д 毒着(хорлож) гэж орчуулжээ. Эл үгийг бид хх. орчуулга хийгээд судлагчдын тайлбар сэлтийг үндэслэж "хорлож" гэсэн үгээр хөрвүүлэв.

73. Дэргэтэ гэдгийг хх-д 根前(өмнө, хажууд) гэж орчуулжээ. Эл үгийг НТ-ны нангиад галигийн эхэд "дэркэтэ кэн буи" гэсэн маягаар тэмдэглэж байгаа боловч орчин цагийн монгол хэлээр "дэргэд" гэж буулгавал хажуу талд нь юм уу өөрийнх нь дэргэд гэсэн утгатай болох тул "зэргэлдээ" юм уу "ойр хавь" гэсэн үгээр хөрвүүлэх нь зүйтэй болов уу гэж санана. В.Кливез (1982, 18) "гарын дор хэн байна" гэсэн утгаар орчуулжээ. Үүний нөгөө талаар НТ-нд "зэрэгцэх" гэхийг "дэрэгцэх" гэх мэтээр "з-д"авиа сэлгэх учир энэ нь бас "зэргэд" гэсэн дуудлагатай байсан байж ч болох талтай. Бас эл үгийг "дэргэдийн хүн" буюу шадар хүн гэсэн ойлголтоор ч ухаарч болох талтай.

74. Чаха гэдгийг НТ-ны хх-д 孩兒(хүүхэд) гэж орчуулжээ. Эл үг орчин цагийн монгол хэлд "нялх хүүхэд" гэсэн утгатай юм (Цэвэл, 1966, 785: Элдэнтэй, Ардаажав, 1986, 130). Мөн НТ-ны 167-р зүйлд "чаха" хэмээх нь бас хүүхэд гэсэн утгаар гарч байна.

75. Инэрү гэдгийг хх-д 燒飯祭祀(идээ бэлтгэх тэнгэр тахих) гэж тайлбарлан орчуулжээ. Элдэнтэй, Ардаажав (1986, 135) НТ-ны нангиад галигт 亦捏[ʂ]魯(инэрү) гэж тэмдэглэснийг мадагтай гэж үзээд "чинару" (чанар) гэдэг үгтэй холбож улмаар бөө мөргөлийн тахилгын ёс хэмээн тайлбарлажээ.

76. Бил'эүр гэдгийг хх-д 餘胙(тахилын махны үлдвэр) гэж орчуулжээ. Эл үг НТ-ноос гадна Лувсанданзаны "Алтан товч" зэрэг сүүл үеийн сурвалж бичигт бас гарна. Б.Ванжил (1987, 286) "Хөх түлхүүр" хэмээх хуучирсан үгийн тольдоо билэгүр хэмээхийг "тахилын идээ буюу тахилд хэрэглээд үлдсэн мах зэрэг" гэж НТ-ны хх. орчуулгатай ойролцоогоор тайлбарлажээ. Уг үгийн гарлыг бид нарийн мэдэхгүй боловч орчин цагийн монгол хэлний "бялуу-бялуурах" гэдэгтэй гарал нэгтэй байж магадгүй юм гэж таамаглаж байна.

77.Архача гэдгийг хх-д 論來(хэлэлцээд, зөвлөлдөөд) гэж орчуулжээ. Мөн Нт-ны 166, 256-р зүйлд 料來(тааварлах), 計量(хэмжих) гэх зэргээр эл үгийг хх-д өөр өөр утгаар орчуулсан буй. Чухамдаа энэ нь орчин цагийн монгол хэлний аргацаан гэдэгтэй ойролцоо утгатай юм.

78. Нидуралу'а гэдгийг хх-д乾了(хатаж, ширгэж) гэж орчуулжээ.

Энэ нь орчин цагийн монгол хэлний нядлах (сонгодог бичгийн нидулаху) гэдэгтэй гарал нэгтэй юм. Хонь мал алахад голыг (амин судлыг) нь таслаж алдаг учир нидулаху гэдэг үгийн таслах гэсэн утга нь аажмаар "алах" гэдэг утгаар солигдсон байна. МонголынНТ-ны энэхүү

Чэ'эл усун нидуралу'а

Чэгэн чила'ун чэ'үрэлу'а гэдэг зүйр үгийн тухай Ш.Гаадамба (1976, 142) "Монголын нууц товчоо монгол аман зохиолд холбогдох асуудалд" гэдэг өгүүлэлдээ дэлгэрэнгүй тайлбарласан буй. Эл үг бас НТ-ны 209, 254-р зүйлд нитулан, нидуратала гэсэн хэлбэрээр гарч байна.

79. Үжэрэ гэдгийг хх-д 看 (үзэх) гэж орчуулжээ. Эл үг НТ-ны 6, 73-р зүйлд хоёр удаа гарна. Бидний ажигласнаар эл 73-р зүйлийн "үжэрэ" хэмээх нь арай "үзэх, харах" гэсэн утгатай бус "эргэх, уулзах" гэсэн санааг илэрхийлж байх бололтой. Энэ нь одоогийн өвөрмонголын хорчин, баарин зэрэг аялгуунд "Таныг үжэхээр очно" гэх нь эргэх тойрох, амар мэндийг нь асуухаар очно гэсэн утгатай адилавтар юм. Тийм учраас НТ-г орчин цагийн монгол хэлээр хөрвүүлсэн зарим судлагчид эл 73-р зүйлийн "үжэрэ" гэдгийг 6-р зүйлийн "үзэх" гэдгээс ялгаатай буулгасан байна. Тухайлбал Дугаржав (1984, 23) "Түүнийг болгоохоор гэрт нь очжээ" гэсэн байна.

80. Үкитала гэдгийг хх-д 繫(чанга ороох) гэж, Бохталажу гэдгийг 箇姑冠帶着 (хөхөл титэм өндөр малгайт) хэмээн орчуулав. "Үкитала бохталажу" гэсэн эл холбоо үг нь гээгүй үсээ "өхийтэл юм уу модойтол чангаар ороож" гэсэн утгатай бололтой.

81. (Х)ожитала бүсэлэжү гэдгийг хх-衣短繫着 (хувцсаа богиносгон бүслэж) гэж орчуулжээ. Энэ нь хөөргөн бүслэхийг хэлсэн бололтой. **(Х)ожитала** хэмээх нь орчин цагийн монгол хэлний огдойтол гэдэгтэй гарал нэгтэй байж болох юм.

82. Олирсун, мойлсун гэдгийг 杜梨 ， 果名 (зэрлэг хар лийр, жимсний нэр) гэж орчуулжээ. Олир жимсийг одоогийн үрэл гэдэг жимс мөн болохыг Дугаржав (1984, 24), Мансаан (1985, 45), Иринжин (1987, 46) нарорчуулга тайлбартаа тодорхойлжээ. Монгол хэлд р-л авиа сэлгэх солигдох үзэгдэл буй тул эртний монгол хэлний олир гэдэг үг орчин цагийн аялгуунд үрэл болж хувиссан байж болох бүрэн үндэстэй юм. Дагуур хэлд үрэл гэхийг үлир гэж хэлдэг гэж Элдэнтэй, Ардаажав (1986, 148) нар тэмдэглэсэн байна.

Бид шүлгийн холбоц, айзам хэмнэлийг нь хэвээр хадгалах зорилгоор хуучин хэлбэрийг нь онц өөрчилсөнгүй "олирс, мойлс" гэж буулгав.

83. Сөлүстэй гэдгийг хх-膽有的 (сөстэй) гэж орчуулжээ. Энэ нь чухамдаа зориг зүрхтэй гэсэн утгатай юм. Эдүгээгийн өвөрлөгч зарим аялгуунд "зориг сөстэй" гэж хоршоо үгийн маягаар хэрэглэж байна. Бид мөн шүлгийн холбоцыг уул төрхөөр нь байлгах зорилгоор сөстэй гэдгийг хэвээр авав.

84. Чигөрсүн гэдгийг хх-д 檜木 (нарс мод) гэж орчуулжээ. Монгол,Төвд, Хятад хэлний толь бичиг шүүж үзэхэд төвдийн (зул мод) хэмээхийг нарс, жодоо, цөөрс, шар харгай, үхэр арц гэх мэтээр олон янзаар нэрлэсэн үзэгдэнэ. НТ-нд өгүүлж буй газар ухах шор хийсэн Чигөрсүн бол нарсны нэг төрөл болох хатуу өргөслөг цөөрс мод мөн биз. Энэ модны шинж чанар ялангуяа монгол эмнэлэгт ашиглаж байсан уламжлалын тухай "Монгол анагаах ухаан" (Нэвтэрхий толь, 1-р боть, 361) гэдэг толь бичгээс танилцаж болно.

85. Сүдүн чичгин-э гэдгийг хх-草根名 (өвс ургамалын үндэсний нэр) хэмээн тайлбарлах маягаар орчуулжээ. Бидний бодлоор сүдүн хэмээх нь монгол нутгийн хээр талаар өргөн дэлгэр ургадаг, өндөр иштэй улаан хүрэн өнгөтэй буурцаг хэлбэрийн толгойтой сөд гэдэг ургамал мөн бололтой (Сонгодог бичгийн хэлний сөдү). Эл ургамлын навч үндсээр нь цай хийх, өвчин эмгэг анагаахад эртнээс нааш ашиглаж ирсэн байна.

Чичгин-э хэмээх нь орчин цагийн монгол хэлний гичгэнийг хэлсэн бололтой. "Монгол хэлний товч тайлбар толь"-д гичгэнийг "...газраар наалдан ургадаг олон наст ургамал, навч нь нохойн хэлний адил, гадар цагаан, дотор хөх, навчаар уул хийнэ, үндсий нь иднэ, эмнэлэгт ч хэрэглэнэ, төрөл зүйл олон" (Цэвэл,1966, 145) гэж тодорхойлжээ.

86. Жагугасу гэдгийг хх-д 山丹根(Сарна [цэцгийн] үндэс) гэж орчуулжээ. Эл үгийг Мансаан (1985, 66) Хайлаас модны үр буюу "зогуга" (зого) гэдэг үг гэж Элдэнтэй, Ардаажав (1986, 151) нар сарна цэцгийн үндэсийг дагуур хэлд "жоогос" гэдэг хэмээгээд Мукаддимат- Ал- Адаб тольд гардаг "Чугасун цэцгийн" нэр (Поппе, 1938, 136) зэрэг жишээ баримттай холбож тайлбарласан байна. Бидний санахад Өэлүн эхийн хөвүүдээ тэжээж агсан зүйлийг НТ-нд өгүүлэхдээ голцуу гол мөрний

сав, хээр талаар ургадаг сөд, гогод зэргийг нэрлэсэн байхаас үзвэл хх. орчуулгад "Сарна [цэцгийн] үндэс" гэж тэмдэглэснийг эрх биш харгалзах хэрэгтэй юм.

"Эрдэнийн товч" зэрэг монгол түүхэн сурвалж бичигт эл үгийг "Жаргасун" гэж тэмдэглэснээс үзэхэд энэ нь халхын аялгуунд "заргас" гэсэн дуудлагатай байж болно. Акад. Ц.Дамдинсүрэн үүнийг "затгас төмс" гэж хөрвүүлсэн нь бас анхаарууштай баримт юм.

87. Ха'улуха гэдгийг хх-д орчуулаагүй байна. Эл үгийн утгыг бид "хальс, ханчир" (хуулга) гэсэн агуулгатай болов уу гэж таамаглаж байгаа юм. (63-р тайлбарыг үзнэ үү)

88. Хойир(л)а'ут гэдгийг хх-д орчуулаагүй байна. Ийм учраас эл үгийг судлагчид орчин цагийн монгол хэлээр янз бүрээр буулгаж иржээ. Тухайлбал Алтан-Очир (1942, 23) "Хуягт сайд", Ц.Дамдинсүрэн (1976, 37) "Хутагтан сайд", Дугаржав (1984, 25) "Хурц сайд", Мансаан (1985, 46) "Эзэн сайд" гэх зэргээр хөрвүүлсэн байх юм. Бидний санахад харин Бөххишиг (1941, 31) "**хуульт сайд**" гэж яг оновчтой үгээр буулгажээ. Учир нь НТ-ны хятад галигт 豁亦剌兀惕(хойира'ут) гэж тэмдэглэснийг нягтлан үзвээс монгол хэлд р-л авиа сэлгэхийн хамт хятад галигт бас монгол хэлний р-л авиаг их хутгадаг тул эл үг нь угтаа "**хойила'ут**" юм уу "**хуйила'ут**" гэсэн дуудлагатай байх бүрэн үндэстэй юм. Мөн үгийг утгын талаас нь авч үзвэл эн зэрэгцүүлсэн мөрийн үүнтэй адил утгат "**жасахтан**" гэдгийг хх-法度有的 (хууль ёстой) гэж орчуулсан нь уг үгийн утгыг тодорхойлох гол баримт болно. Дээр өгүүлсэн жишээ баримтаас үндэслэж бид үүнийг "хуультан сайцуул" гэж хөрвүүлэв.

89. Жэбүгэ, Хатара гэдгийг хх. орчуулгад 漁名(загасны нэр) гэж тэдэглэжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "Зэвэг (Зэвээ), Хадар" гэдэг загас мөн бололтой. Эл үгийн тухай Я.Цэвэл (1966, 294, 640), Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв (1982, 244), Элдэнтэй, Ардаажав (1986, 154)нарын тайлбар сэлтээс үзэж болно.

90. Сохосун гэдгийг хх-д 漁名 (загасны нэр) гэж тэмдэглэжээ. Энэ нь гол мөрний цэнгэг усанд орших алганын багт багтах загасыг одоогийн монгол хэлд "Сугас, согос, сагус" гэх зэргээр нэрлэдэг байна. Үүний талаар Я.Цэвэл (1966, 30), Мансаан(1985, 66), Элдэнтэй, Ардаажав (1986, 157) нарын тайлбар судалгааг үзэж болно.

91. Йэгу'үжэ'эи гэдгийг хх-д 休 (орхи, боль, битгий) гэж очуулжээ. Мөн 76, 131,174-р зүйлд гарч буй "бүтүкэи" гэсэн үгийг бас

дээрхийн нэг адил (休) үсгээр орчуулсан байна. Эдгээр үгс нь орчин цагийн монгол хэлний "яана (йагакина), битгий" гэдэгтэй гарал нэгтэй байж болох юм.

92. Чичу'а гэдгийг хх-д 鞭子(ташуур) гэж орчуулжээ. Олонхи судлагчид хх. орчуулгыг баримтлан "сүүлнээс өөр ташуур үгүй" гэсэн утгаар орчуулсан нь зүйтэй ажээ. Харин Элдэнтэй, Ардаажав (1986, 157) нар хх. орчуулгын "ташуур" гэснийг ташаарал гээд түрэг хэлний "Чичиг" буюу хонины сүүл гэсэн үгтэй холбож үзэх гэсэн нь үнэндээ авцалдаагүй эндүү зүйл болжээ. НТ-нд өгүүлж буй

"Сүүдрээс өөр нөхөр үгүй
Сүүлнээс өөр чичээ (ташуур) үгүй" гэдэг зүйр үг бол хань нөхөргүй, зэр зэмсэггүй, гар хоосон боллоо гэсэн утгатай юм. "Чичу,а" хэмээх нь гарлын хувьд "Чичих, хатгах, цохих" гэсэн үйлээс гарсан нэр болно. Орчин цагийн монгол хэлний ташуур гэдэг үг ч мөн "алга таших", "дэлэн таших" гэх мэт бас л цохих, балбах, алгадах гэсэн утга бүхий үйлээс үүсэлтэй билээ. Ийм учраас НТ-нд өгүүлж буй "чичу,а" буюу "чичээ" бол эдүгээгийн ойрдын аялгуунд ташуурыг "малиа" гэдэг шиг өөр дуудлагатай адил утгат үг болно.

93. Алдухун гэдгийг хх-д 相過(амьдрах, ханилах, суух) гэж орчуулжээ. Эл үгийн утгыг хх. орчуулгад оновчтой гаргасан бөгөөд энэ нь хамт амьдрах, суух, орших гэсэн утгатай ажээ. Үүний хэлбэр бүтцийн талаар Элдэнтэй, Ардаажав (1986, 161) нар задлан тайлбарласан байна.

94. (Х)улхун гэдгийг хх-д 小獨山(жижиг дов, толгой) гэж орчуулжээ. Эл үг орчин цагийн монгол хэлд эхнийхээ "х" авиаг гээж "улхан" (Сонгодог бичгийн хэлнээ улхун) гэсэн дуудлагатай болжээ. Өвөрмонголын номын сангийн "В-228-1" гэсэн тэмдэгтэй "Гал тэнгэрийн судар оршивой" хэмээх бичмэл дэвтэрт:

"Сүмбэр уулын **улхун** бүхүйгээс
Сүн далайн шалчиг бүхүйгээс
Гарьд шувууны өндөг бүхүйгээс
Ганга мөрний горхин бүхүйгээс" гэж шүлэглэсэн байна. Мөн монгол туульд энэхүү улхун гэдэг үг дов довцог гэсэн утгаар гардаг юм.

95. Самбажу гэдгийг хх-д抽着(татаж, тэлж) гэж орчуулжээ. Энэ нь чухамдаа онилон харвахыг хэлсэн бололтой юм. "Гэсэрийн тууж"-д

"Гэсэр өмнөөс дэлдэж, сумаа самбаж" хэмээн өгүүлсэн байдаг байна (Элдэнтэй, Ардаажав, 1986, 163).

96. Өтэрмэлэжү гэдгийг хх-近垛子般射着' (Ойрын бай харвах мэт) гэж орчуулжээ. Эл үг гарлын хувьд "Өтэр" буюу "Үтэр" гэдэгтэй холбоотой бололтой. Мукаддимат-Ал-Адаб тольд "өтер мөр өгбе түүндү" гэхийг "дал ему краткий путь" (түүнд богино зам өгөв) гэж орчуулсан байна (Поппе, 1938, 279). Тэрчлэн якут хэлний "үтүр" гэдэг үг ч орчин цагийн монгол хэлний "үтэр" (хурдан, түргэн) хэмээхтэй утга ойролцоо байгаа нь (Пекарский, 1917, 3204) бас анхаарууштай баримт юм. Энэ мэт баримтаас үндэслэж бид үүнийг "үтэр харваж" гэж хөрвүүлэв. Лу."Алтан товчид" эл үгийг өтүр мэлэжү гэж бичсэн байна.

97. Хаблан гэдгийг хх-д 獸名 (араатны нэр) гэж тэмдэглэжээ. Судлагчид чухам ямар араатны нэр болохыг оноож, тогтоохыг оролдож, В.Кливез (1982, 23), Мансаан (1985, 48) нар "ирвэс" гэж үзсэн байна. Эртний түрэг хэлд барыг "хаплан" (Наделяев, 1969, 421) гэж хэлдэгээс үзвэл энэ нь монгол, түрэг хэлний барын хувилбар нэр ажээ.

Өэлүн эхийн хөвүүдээ сурган соёрхсон эл шүлэгт: "Хаданд довтлох хаблан (бар) мэт" гэсний дараах мөрд "Уураа даран ядах арслан мэт" гэсэн нь монгол хэлний аман бичгийн зохиолд бар арсланг холбон өгүүлдэг уламжлалтай авцалдаж байна. Харин эл үгийг проф. И.Рахевилз /1971, 137/ англи хэлээр яг оновчтой орчуулсныг тэмдэглэе.

98. Баруг гэдгийг хх-д 獸名(араатны нэр) гэж тэмдэглэжээ. Эл үгийг Элдэнтэй, Ардаажав /1986, 172/, Иринжин /1987, 50/ зэрэг судлагчид урт үстэй нохойны нэр хэмээн тайлбарласан нь зүйтэй байна. Эртний түрэг хэлний тольд "барак" гэдгийг "саглагар урт үс, гайхалтай хурдан хөдөлгөөнөөрөө анч ноxдоос давуутай" /Наделяев, 1969, 83/ гэж тайлбарлажээ.

99. Хадалун гэдгийг хх-д 根尋着 (үндэслэн) гэж орчуулжээ. НТ-ны 244-р зүйлд "хадарун" гэдгийг дээрх "хадалун" гэдэгтэй яг адилаар галиглаад хадмал орчуулгад үг оноогоогүй орхив. (552-р тайлбарыг үзнэ үү). Харин 260-р зүйлд "Хадалжу" гэдгийг хх-д 分析着 (задлаж, нягтлаж) гэж орчуулжээ. Бидний бодлоор энэхүү "хадалун" гэдэг үгийн үндэс нь "бэх бат" гэсэн утга бүхүй "хад" (чулуу) гэдэг үгтэй үүсэл нэгтэй бололтой. Уг үгийн уул утга нь "бат бэх, үндэс суурьтай" гэсний баталгаа нь якут хэлд "хадаар-хадар" гэж хад чулууг хэлдэг бол /Пекарский 1917, 3227/ тунгус хэлд уулыг хэлдэг байна.

Ийм учраас "хадалун" гэдгийн хх. орчуулгыг бид ерөнхийдөө зөв гэж санаж байна.

100. Оркидун гэдгийг хх-д 引證着(иш татан) гэж орчуулжээ. Эл үгийн үндэс нь "ор мөр, эх сурвалж" гэсэн утгатай ажээ. Уг үгийн язгуур үндэснээс "оргил, орхиц, оршил" гэх зэргийн үгс салаалж гарсан бололтой байна. Мукаддимат-Ал-Адаб тольд "орхитба" гэснийг оросоор "положили" (тавьцгаасан) гэж орчуулсан байна /Поппе, 1938, 271/. Эл үг бас НТ-ны 260-р зүйлд оркиджу гэсэн хэлбэрээр гарч байгааг тэмдэглэе.

101. **Холухад** гэдгийг хх-д 惡的每(муухай юм) гэж тайлбарлан орчуулжээ. Үүнийг судлагчид янз бүрээр ухаарч, уг зүйр үгийн утгыг нарийн тайлбарлаж чадаагүй байв. Харин Элдэнтэй, Ардаажав /1986, 175/ "холухад" гэдгийг "хулхи" гэсэн үгийн олон тооны хэлбэр гэж үзсэн нь тун ч зүйтэй болов уу гэж санана.Учир нь монгол түрэг хэлнүүдэд чихийг "хулих-хулах, кулгах, кулгак" гэх мэтээр нэрлэхийн хамт монгол хэлд чихний дотор хуралдсан хаг мэт зүйлийг хулхи,булаг гэдэг билээ./ Цэвэл, 1966,728/. Ийм учраас бид НТ-ны "холухад хо,ожижу,у" гэдгийг "хулхи нь гуужиж" гэх буюу "чих нь онгойлоо" гэсэн утгатай гэж санаж байна.

Лу."Алтан товчид" эл хэллэгийг бидний уншсантай бараг адилаар qulaqad quciji silьsen siberьkь гэжээ.

102.Шилүгэд гэдгийг хх-д 涎收不的 (шүлсээ дэвтээгээгүй) гэж орчуулсны дээр бүлгийн төгсгөл дэх ерөнхий орчуулгад "жигүүртний зулзага өд сөд нь ургачихав уу, араатны зулзага өсч том болчихов уу" гэсэн утгаар уг зүйр үгийн санааг зөв тодорхойлжээ. Олонхи судлагчид "шилүгэд сэбэрижүхү" хэмээхийг "шүлс нь [нь] сэвэрчихлээ" гэх буюу амных нь шалиа гарч өсч том боллоо гэсэн санааг зөв гаргасан байна. Бидний бодлоор эл хос мөр шүлгийн санаа нь: "Чих нь онгойж ам нь эвэрчихлээ" гэх буюу Тэмүжин нарыг балчир хүүхэд биш боллоо гэж эмээн болгоомжилсон үг болно. Ордосын "Сарандалай" гэдэг үлгэрт **"салай** нь хатаа гүй муу зулбадаг" гэсэн хэллэг гарч байна.

103. Булхалдун гэдгийг хх-д 相鬪 (харилцан тэмцэх) гэж орчуулжээ. Уг үгийн үндэс нь "булха" буюу тэмцэх гэсэн утгаар олон удаа тохиолдох бөгөөд 185, 201, 249, 254-р зүйлд "булхалдарун, булхалдугчи, булхалдалу'а, булхалдахуй" гэх зэргийн хэлбэрээр гарч байна. Булха гэдгийг 176, 201, 213-р зүйлийн хх-д дээрхтэй

ойролцоогоор 反(эсэргүүцэх)反亂(эсэргүүцэл, самуурал) гэж орчуулжээ.

104. Хошилих гэдгийг хх-д 帳房(гэр) оновчтой орчуулжээ. Эл үгийн үндэс "хош" хэмээх нь эдүгээгийн ойрдын аялгуунд айл гэр гэсэн утгатай байна (Цолоо, 1988, 438). Мөн халх аялгууны "хороо хош" гэсэн хоршоо үг ч гэр хороо, орон байр гэсэн утгыг хадгалж байгаа юм. Якут хэлд "хос" гэх нь монгол түрэг хэлний "холбоо, хос, хошлон" гэх мэтийн түгээмэл хэлбэрийн утгатайгаас гадна байшингийн өрөө, тасалгааг хэлдэг байна (Пекарский, 1917, 3520). НТ-ны 169-р зүйлд "хош" гэдэг үг мөн гэр гэсэн утгаар гарахын хамт бидний өгүүлэн буй "хошилих" гэдэг үг ч бас гэр гэдэг утгаар 80, 245, 246-р зүйлд гарч байгааг тэмдэглэе.

105. Наитагдан гэдгийг хх-д 嫉妒(атаархах) гэж орчуулжээ. Уг үгийн үндэс "най" гэх нь орчин цагийн монгол хэлд дангаар хэрэглэгдэхгүй боловч "гүй-үгүй" гэсэн үгүйсгэх сул үгтэй хавсарч "хариугүй муу" гэсэн утгаар хэрэглэгдэж байна. Жишээ нь "найгүй муу, найгүй худалч" г.м. Тэрчлэн якут хэлний "найдан" гэдэг үг "хүчирдүүлэх, залхаах" гэсэн утгатай байх нь (Пекарский, 1917, 1667) анхааруулштай сонирхолтой баримт юм. Харин НТ-ны 94-р зүйлд "найтаму" гэсэн үгийг хх-д мөн "атаархах" гэсэн үгээр орчуулсан боловч энэ нь арай өөр утгатай мэт санагдана. 164, 219-р зүйлд "атаархах, хорсох" гэсэн утгаар мөн гарна. Шагж, Я.Цэвэл нарын тольд найдангуйг "атаа, жөтөө" гэж тайлбарлажээ. Харин Лу.Алтан товчид "Тайчууд нарыг Сорхон шар:

"Усанаа чилэмэй (ором) үгүй
Огторгуйд мөр үгүй хааш одов хэмээгээд ах дүү чинь шүд амаа билүүдэж айсуй" хэмээн Тэмүжинд өгүүлж байна. Дашрам тэмдэглэхэд **чилэмэй** хэмээх нь ойрдын аялгууны чилим (Цолоо, 1988, 856) гэдэг үгтэй гарал нэгтэй байж болох юм.

106. Ани гэдгийг хх-д 他每行 (тэдний) гэж орчуулжээ. Энэ нь гуравдугаар биеийн төлөөний олон тоог заасан утгатай үг болно. Эл үг бас НТ-ны 144, 171, 174, 194, 247, 257-р зүйлүүдэд гарна.

Акад.Ц.Дамдинсүрэн (1957, 63) "Биеийн төлөөний нэрс нилээд онцгой байдалтай байсныг НТ үзүүлж байна... Бас **таныг маныг** гэдгийн адилаар аныг (тэднийг) гэдэг байжээ. Жишээлбэл **ан-и даружу**. Энэ нь тэднийг дарж гэсэн үг болно (171-р зүйл). Нууц товчооны баримтаар үзэхэд **имада** (түүнд), **има-и** (түүнийг), **има-дача** (түүнээс), **има-бар** (түүгээр) гэх зэрэг хэлдэг байжээ" хэмээн харьцуулан тодорхойлсон

байна.(358-р тайлбарыг үзнэ үү)

107. Түсүрү'эд гэдгийг хх-д 傾了 (цутгаж) гэж орчуулжээ. Энэ нь айрганд сүү хольж самрах, цутгах гэсэн утгатай аж. Үгийн гарлын хувьд хожих, цутгах гэдэгтэй утга ойролцоо "дусаах, дусах" гэсэн үгтэй үүсэл нэгтэй байж болох юм. Якут хэлд "түс" гэх нь дээрээс доош буух, унах гэсэн утгатай байхад (Пекарский, 1917, 2917), эртний түрэг хэлд "түшүргү" хэмээх нь жижиг гол горхины нэгээс нөгөөд урсан орох цутгалыг хэлдэг байна (Наделяев, 1969, 601). Үүнээс үзвэл энэ нь монгол түрэг хэлтний дундын чанартай үг бололтой.

Элдэнтэй, Ардаажав (1986, 354) нар эл үгийн тайлбар өгүүлэлдээ Дагуур хэлд түсрээ хэмээх нь мөн цутгах юүлэх гэсэн утгатай болохыг тэмдэглээд "Хуа-и И-ю" тольд түсэр гэх нь бас цутгах гэсэн агуулгатай байдгийг дурджээ. Хожуу үеийн бичиг зохиолд ч эл үг "асгах, сүрчих" гэсэн утгаар гарч байна. Тухайлбал XIX зууны үеийн Буриадын эрдэмтэн Төгөлдөрийн Галсанжамбын орчуулсан Бурхан багшийн намтарт"...үнэрт усныг **түсүрү** галын үлэгдлийг сөнөөгөөд..." гэсэн буй.

108. Туримтай гэдгийг хх-д 龍多兒(Лун дүө эр) гэж орчуулжээ. Эл үгийг Элдэнтэй, Ардаажав (1986, 192) нар "Хорин нэгтийн тайлбар" толь тэргүүтнээс ишлэн "Турумтай хэмээх нь начинтай адилхан болоод маш бяцхан, толгой их, бие бяцхан, нүдний цэцгий бараан, бүднээ, бялзуухай зэргийг барина. Маш хурдан гавшгай, бас хар нүдэн хэмээнэ" гэж өгүүлжээ. Үүнийг Мин улсын үеийн "Лү лүн сай лүэ" гэдэг утгын зүйл хуваасан монгол хятад толь бичгийн шувууны аймагт нангиад галиг үсгээр "тулинтай" гэсэн дуудлагаар тэмдэглээд мөн НТ-ныхтай адил орчуулсан байна.

Эртний түрэг хэлний тольд "турумтай" гэгчийг оросоор дербник гэж орчуулав (Наделяев, 1969, 589). Дербник гэдгийг "Улсын нэр томъёоны комиссын мэдээ" цуврал бичгийн 1969 оны 78-80-рт "Хайргууна шонхор" гэсэн байна.

109. Исэри гэдгийг хх-д 床(ор) гэж орчуулжээ. Орчин цагийн монгол хэлд түшлэггүй мухар сандлыг исэр гэдэг байна (Цэвэл, 1966, 309). Энэ нь манж-тунгус хэлний "исэ" (Цинциус, 1975, 331) гэдэгтэй нэг гаралтай ажээ. Харин якут хэлд гэрийн дотор талыг "исиржэ" гэж хэлдэг байна (Пекарский, 1917, 969). Дээрэх жишээ баримтаас үзвэл "исэри" хэмээх нь гэрийн дотоод тавил, тухайлбал хүн суух, амрахад

зориулсан хэрэгслийн эртний уламжлалт (магадгүй өвөг алтайн хэлний) нэр ажээ. Эл үг НТ-нд ор гэсэн утгаар 169, 177, 214-р зүйлд гарч байна.

110. Намбуха гэдгийг хх-д 大皮桶 (том арьсан тулам) гэж очуулжээ. Эл үг бас НТ-ны 90, 93, 205, 254-р зүйлд гарна. Намбуха бол ус, унд хийж морь маланд тэгнэж, ганзгалж явахад зориулсан том арьсан тулам юм. Уг үгийн гарал одоогоор нарийн тогтоогдоогүйавч, эвенк хэлд "нама" хэмээх нь тэгнэх, эмээлд тэгнэх гэсэн утгатай байхаас үзвэл эл үгийн үндэс нь тэгнэх тулам, тэгнэх суулга гэсэн утгатай байж болох юм. Одоогийн Алаша нутгийн аман аялгуунд усны суулга, арьсан тулмыг мөн "намбух" гэх бөгөөд сүүлийн үеийн зарим бичиг зохиолд үүнийг "намаха" гэсэн хэлбэрээр хэрэглэж байгааг Элдэнтэй, Ардаажав (1986, 197) тэмдэглэсэн байна.

111. Гүрэлгү гэдгийг хх-д 山名 (уулын нэр) гэж тэмдэглэжээ. Эл үг 94, 122, 129, 141-р зүйлүүдэд газрын нэрийн утгаар гарах боловч 89, 94, 122-р зүйлүүдэд "гүрэлгү дотор" гэж өгүүлсэн нь гөрлөг мэт мушгирсан хамар хяр газрыг нэрлэсэн байж магадгүй гэсэн сэтгэгдэл төрнө.

112. Күчүкүр гэдгийг хх-д 野鼠(мэхээрийн хулгана) гэж орчуулжээ. НТ-ны 111-р зүйлд "күчүгэнэ" гэснийг хх-д 小鼠 (жижиг хулгана) гэсэн буй (154-р тайлбарт үзнэ үү). Ийм учраас "күчүкүр, күчүгэнэ" хоёр нь ондоо ондоо хулгана бололтой байна.

Халимаг Жангарын туульд эмийн ургамал таньж олж иддэг хүжлэг хулганын тухай өгүүлсэн буй. Эл хүжлэг хулганыг Шагжийн "Эрэхүйеэ хялбар болгон зохиосон чандманийн эрх" гэдэг бичмэл тольд "үнэр сайт хулгана" гэжээ. Я.Цэвэл (1966, 742) үүнийг "Эрхий хуруу мэт том бөгөөд нүх ухахдаа хурдан нэг зүйл хулгана" гэв. Үүнээс үзвэл НТ-нд өгүүлж буй күчүкүр бол дээр өгүүлсэн хүжлэг, хүчгэнээс арай биелэг махы нь хүнсэнд хэрэглэж болдог хулгана бололтой. Монголчууд жижиг мэрэгч амьтдаас тарваганаас гадна бозлог, зурын мах иддэг тул бид үүнийг зурам маягийн амьтан гэж төсөөлж байна.

113. Тарги гэдгийг хх-д орчуулсангүй зай орхижээ. Ийм учраас судлагчид янз бүрээр таамаглан буулгах буюу орхиж орчуулсан нь ч үзэгдэнэ.

Ордос аялгуунд "тачир ноостой" гэхийг "тарги унгастай", нявталхан үстэй дээлийг "тарги үстэй дээл", өвс тачир байна гэхийг "өвөс тарги беен" (Мостарт, 1942, 647) гэсэн маягаар хэлдэг байна.

Үүнээс үзвэл "тарги" хэмээх нь монгол түрэг хэлний "таруун, тархай, тачир" гэсэн үгстэй үндэс нэгтэй нявтал шингэн үстэй морь малыг нэрлэсэн үг бололтой байна. Үүнээс гадна оготор юм уу шингэн сүүлтэй морь голцуу тачир үстэй байх тул Тэмүжин нарын оготор хонгор ч мөн нявтал шингэн үстэй морь байж болох талтай. Монгол үлгэр туульд гардаг тархай хожгор хүү гэдгийн тархай хэмээх нь мөн л армаг тармаг үстэй гэсэн үг болно.

114. Манагар гэдгийг хх-д 明日(маргааш) 早 (өглөө) гэх зэргээр орчуулсан бйу. НТ-нд "манагар" гэх нь маргааш гэдгээс гадна өглөө гэсэн утгаар хэд хэдэн уда гарч байгаа юм. Энэ нь эдүгээгийн ойрдын аялгуунд маргааш гэхийг "мангадар, манагаар" гэдэгтэй үндэс нэгтэй байна (Цолоо, 1988, 610).

115. Күрүмэлэ гэдгийг хх-д 爽利(хурц сэргэлэн) гэж орчуулжээ. Эл үгийн утга санааг Элдэнтэй, Ардаажав (1986, 203) нар түрэг хэлний жишээ баримттай холбон үндсэндээ зөв тайлбарласан бололтой юм. Гэхдээ эртний монгол түрэг хэлний "күрүмэлэ", "көрүмлүг" (аятайхан) гэх мэт адилавтар үгсийг (Наделяев, 1969, 319) аль алинаасаа зээлдэн авсан гэж шууд хэлэхэд бэрхтэй. Учир нь уг үгийн көр-күр үндсэн дээр олон төрлийн нөхцөл залгаж "көрүс, көрүг" зэргийн шинэ үг үүсгэх арга эл хоёр төрөл хэлний аль алинд нь байх түгээмэл үзэгдэл болно.

Бид НТ-ны 90, 156-р зүйлд гарч буй "күрүмэлэ" буюу "көрүмэлэ" гэдгийг орчин цагийн монгол хэлний "хөрслөг" гэсэнтэй үндэс нэгтэй гэж үзэж байна. "Мукаддимат-Ал-адаб" тольд "көрк үгэи" гэдгийг оросоор "некрасивый" (муухай) гэж орчуулжээ (Поппе, 1938, 224). Тэрчлэн монгол ардын "Цагаан торгон цамц" гэдэг дуунд:

Хөгшин чамайг тиймхэн шиг байвал
Хөрстэй залуус хөлөөр хөшнө хэ гэсэн хос мөрийн хөрстэй залуус гэх гоё, сайхан чийрэг залуус гэсэн утгатай ажээ. Мөн НТ-ны 156-р зүйлд "күрүмэлэ" гэдгийн хх.орчуулгад энэхүү 90-р зүйлийнхээс өөрөөр 苗條(гоолиг, цэвэрхэн) гэж буулгасан нь бас анхааруштай баримт юм.

116. Тү'үшин гэдгийг хх-д 黃昏 (бүрий, шар бүрий) гэж орчуулжээ. Уг үгийн язгуур нь эртний монгол түрэг хэлний "түн" буюу харанхуй, шөнө гэсэн үгтэй гарал нэгтэй бололтой. Үүнийг тодруулахад манж-тунгус (Цинциус, 1975, 224), якут хэлний (Пекарский, 1917, 2893) материалтай харьцуулан судлах ажил тус дөхөм болж байна. Элдэнтэй,

Ардаажав (1986, 210) нар эл үгийн хожуу үеийн хэлбэр болох "түгүши" гэх нь мөн бүрэнхий гэсэн утгатай гэжээ.

117. Үжэлдүгтүд гэдгийг хх-д 想願 (харгалзах, санагалзах) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "үзэх" гэдэгтэй язгуур нэгтэй бөгөөд бие биенээ үзэж харж (мэдэж) яв гэсэн утгатай ажээ. Бид уг санааг нь гаргах зорилгоор "бие биенээ мэдэж [яв]" хэмээн утгачлан буулгав.

118. (Х)эр(л)үжү гэдгийг хх-д 愁着 (санаа зовж) гэж орчуулжээ. Бидний санавал эл үг нь эртний монгол хэлний "(х)элэхү" буюу "элэх" (шаналах, зовох) гэсэн үгийн хуучин хэлбэр ажээ. Элдэнтэй, Ардаажав (1986, 215) Дагуур хэлний зарим аялгуунд "(х)элэгү" гэж зовох, гуних гэсэн утгатай хэмээн тэмдэглэсэн байна. Уг үг НТ-ны 93, 94-р зүйлээс гадна 208-р зүйлд мөн зовох, зүдрэх гэсэн утгаар гарна.

119. Аран үжэбэ гэдгийг хх-д 僅得見了 (арай чарай уулзав) гэж орчуулжээ. Судлагчид "аран" хэмээхийг хх. орчуулгыг баримтлан "арай, арай ядан" гэсэн утгаар голчлон орчуулсан нь зүйтэй байна. Якут хэлд "арай" хэмээхээс үүссэн "аран" гэдэг үг "тэсэшгүй, өвдөх" гэсэн утгатай байхад түрэг хэлний зарим нутгийн аялгуу хийгээд, дагуур хэлд "аран" гэх нь мөн "арай, чарай" гэсэн утгатай (Элдэнтэй, Ардаажав, 1986, 217) байхаас үзвэл алтай хэлтний дундын чанартай үг бололтой. "Үжэбэ" гэх нь орчин цагийн монгол хэлний "үзэх, харах" гэдгээс гадна "уулзах, учрах" гэдэг утгатай болохыг бид 79-р тайлбарт өгүүлсэн билээ.

120. Шиткүл гэдгийг хх-д 見公姑的禮 (хадам эхэд золгох бэлэг) гэж тайлбарлах маягаар орчуулжээ. Эл үгийг Бөххишиг (1941, 48) одоогийн монгол хэлээр шибэд гэж хөрвүүлсэн байна. Уг үгийн утга санааг бид тодорхой мэдэхгүй боловч алт мөнгөн эдлэлийг урлан хийх хэв шибан (Сэцэнцогт, 1988, 1563) хэмээхтэй гарлын холбоотой байж магадгүй гэж таамаглаж байна. Лу "Алтан товчид" үүнийг "өмсгөл" гэж тайлбарласан байна.

121. Бөкөрэйин бөксэн-түр, чэкэрэйин чэгэжи-түр атухаи- г 腰子的小大兒裹, 脞子胸膛裹存着 (Бөөрний буланд, цээжний хөндийд байлгана) гэж орчуулжээ. Бидний бодлоор эл зүйр үгийн утгыг судлагчид одоо болтол зөв тогтоож хараахан чадаагүй байна. Үүний шалтгаан нь гэвэл: Уг зүйр үгийг хх. орчуулгад үгчлэн буулгахдаа "бөкөр", "чэкэр" гэдэг гол хоёр үгийг зөв ухаарч чадаагүйгээс болжээ. Ийм учраас юуны өмнө эл хоёр үгийн утгыг тодорхойлохыг хичээсүгэй.

1.1. Монгол хэлд **бөөр** хэмээх нь хүний биеийн усны тунгалагийг тунгаах үйлдэл бүхүй таван цулын нэгийг нэрлэхээс гадна "засаа, төмсийг" бас "бөөр бөлдөг" гэж нэрлэдэг юм. Тухайлбал орчин цагийн монгол хэлд "бөөр бөгс, бөөр бөлдөг" гэх зэргээр хоршоо үгийн маягаар хэлэхийн хамт хүүхдийг "бөөрий нь авна" (Цэвэл, 1966, 99) гэж алиалж наадах нь хурга мал хөнгөлөх шиг төмс засааг нь авна гэснээс бус таван цулын нэгэн дотор бөөрийг нь авна гэсэн үг биш гэдгийг хүүхэд ч ойлгоно. Тэрчлэн монголын уламжлалт анагаах ухааны бичиг сударт "гадар бөөр, дотор бөөр" хэмээн ялган өгүүлсэн байдгийг тэмдэглэе. Ингэхлээр НТ-ны "бөкөрэйин бөксэн-түр" гэдэг нь "бөөр бөлдгөө бөгсөндөө [байлга]" гэсэн утгатай ажээ.

2.2. "Чэкэрэ" хэмээх нь орчин цагийн монгол хэлний цээр (сонгодог бичигт **"чэгэр"**) буюу цээрлэж нууцлах зүйл гэсэн утгатай үг болно.

Одоо бидэнд эл зүйр үгийн утга нь "Бөөр (бөлдгөө) бөгсөндөө, цээр (нууцаа) цээжиндээ байлга" гэсэн агуулгатай болох нь тодорхой боллоо.

Чухамдаа Ван хан Тэмүжинээс булган дахаар бэлэг сэлт авч түүнд цэрэг зэвсгээр туслан хүч хавсрах болсон зэрэг үйл явдал ч тухайн үедээ цээжиндээ зөвхөн хадгалж явах нууц зүйлийн нэг байсан биз. Эл хэллэгийн талаар Бүрэнбатын (1990, 1, 1-17) өгүүлэлд **бөкөр, чэкэр** гэдгийг шагайны гүдгэр, хотгор хоёр талыг нэрийдсэн **бөкэ, чэкэ** гэсэн үгтэй холбож үзсэн нь бидний саналтай үл нийцнэ. Зохиогч мөн хэллэгийн талаар доктор Ш.Гаадамбын хийсэн сийрүүлэг, тайлбарын тухай шүүмж бичжээ (Цэрэнсодном, 1990, 71).

122. Нэлкэй гэдгийг хх-д 裹兒的袱([булган] дотортой дээл) гэж орчуулжээ. Үүнийг Мансаан (1985, 71), Элдэнтэй, Ардаажав (1986, 226) нар нөмрөг, хучлага, хөнжил гэсэн утгатай хэмээн тайлбарлажээ. Ялангуяа Элдэнтэй нар дагуур хэлд нялх хүүхдийг боох (өлгийдөх?) бяцхан хөнжлийг "нэлк" гэдэг гэж тэмдэглэсэн нь НТ-ны 97, 211-р зүйлд гарч буй "нэлкэй, нэлкэ" гэдэгтэй агуулга хэлбэрийн аль ч талаар яв цав тохирч байна. Бас якут хэлд үстэй буюу цэмбэн нөмрөг хэвнэгийг "нэлби" гэдэг байна (Пекарский, 1917, 1692). Эдгээр жишээ баримтаас үзвэл гарлын хувьд орчин цагийн монгол хэлний "нэмнээ" гэдэгтэй холбоотой байж болох бөгөөд чухамдаа хүүхдийн өлгий, хөнжлийг заасан утгатай ажээ.

123. Жалхамшигтан гэдгийг хх-д 擾怕了的(аймшигт хөнөөлт)

гэж орчуулжээ. Энэ нь гай гамшигт, гай түйтгэрт, хөнөөлт гэсэн утгатай агаад орчин цагийн монгол хэлний залхаалт (сонгодог бичгийн **жалхагалта**) гэдэгтэй язгуур нэгтэй байж болх юм.

124. Бөкэн гэдгийг хх-д орчуулаагүй байна. Ийм учраас судлагчид эл үгийн утга, гарлыг харилцан адилгүй таамаглан тайлбарласан байх юм. Жишээ нь Мансаан (1985, 71) "бэх, бөх" гэдэгтэй Элдэнтэй, Ардаажав (1986, 230) нар "бөгтөр" гэдэг үгтэй холбож үзсэн байна. Бидний бодлоор дотор нь хүн нууж суулгаж яваа учир цонх гэгээвч үгүй битүү тэрэг байлтай юм. Ингэж үзвээс уг үгийн үндэс нь орчин цагийн монгол хэлний "бөглөх-бөглөө" гэсэн үгтэй гарал нэгтэй байж болох юм. Үүнийг үнэмшилтэй болгох бас нэг баримт бол эртний түрэг хэлд "**бөкэн**" хэмээх нь "бөглөөтэй, таглаатай" гэсэн утгатай байгаа нь НТ-ны эл үгтэй хэлбэр, агуулгын аль ч талаар яг тохирч байна (Наделяев, 1969, 117).

125. Тэнгэли гэдгийг хх-д 河名 (голын нэр) гэжээ. Үүнийг судлагчид "Тэнкэри, тэнгэли, тэнгэри" гэх зэргээр харилцан адилгүй уншиж, галигласан байна. Ц.Дамдинсүэрн, Захчидсэцэн, Мансаан, Иринжин зэрэг судлагчид Түнхэлиг горхийг хэлсэн болов уугэж үзжээ. Энэ нь одоогийн Гурван нууруас Тэнхэлэг горхи мөн бололтой.

126. Хойинача босу'ад ирэби би гэдгийг 後自起了來了我 (хойноос босож ирэв би) гэж яг үгчлэн орчуулжээ. Энэхүү хэллэгийг П.Кафаров "Би арын сууцнаас хүрч ирэв", Э.Хэниш "Би гэрийн араас мордсон", П.Пеллио "Би ар этгээдээс ирлээ" гэсэн утгаар орос, герман, франц хэлээр орчуулсан хийгээд орчин цагийн монгол хэлд Ц.Дамдинсүрэн "Би хойд гэрээс гарч ирэв" хэмээн оновчтой хөрвүүлснийг Ш.Гаадамба (1976, 148-154) "Монголын нууц товчоо монгол аман зохиолд холбогдох асуудалд" гэдэг өгүүлэлдээ тодорхой танилцуулсан билээ. Зохиогч эл өгүүлэлдээ дээр үед хот айлын хойт талаар борцуул, зарц ядуу хүмүүсийн гэр байх тул "хойноос босоод ирэв би" гэх нь тэр утгаар өгүүлсэн хэрэг мөн гэсэн дүгнэлтийг бид зүйтэй гэж үзэж байна.

127. Даруча гэдгийг хх-д 隨即 (дараалан) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний хурдан, түргэн гэсэн утга бүхүй "даруй даруйгаар, дараа дараагаар" гэдэгтэй гарал нэгтэй бололтой. Эл үг бас НТ-ны 110, 193-р зүйлд "даручажу" гэсэн хэлбэрээр гарсныг хх-д 緊隨着 (дав даруйд) 緊逐着 (дараалан залгаж) гэж орчуулсан байна.

128. Булжи'асу гэдгийг 躲閃呵 (зайлах, бусгах) гэж орчуулжээ. Эл үгийн үндэс нь орчин цагийн монгол хэлний "булжих, бултах, бусгах" гэсэн үгстэй нэг гаралтай бололтой. Эдүгээгийн ойрдын аялгуунд "булжин" хэмээх нь зайлах бултах гэсэн утгатай ажээ. Тухайлбал баруун монголчуудын дунд өргөн дэлгэрсэн Сартагтайн домогт:

Буцаад урссан нь
Булжин толгой бол
Эргээд урссан нь

Эрэг толгой бол гэсэн буй. Мөн үгийн тухай тайлбар өгүүлэлдээ Элдэнтэй, Ардаажав (1986, 237) нар дөрвөд аялгуунд замаас салж явсан гэхийг "булжаад явсан гэнэ" гэж тэмдэглэжээ.

ухамдаа НТ-нд энэ үг шавар намгийн зайг олж ядан "энд тэнд **займчин** гишгэж явав" гэсэн утгаар орсон бололтой юм.

129. Умубу гэдгийг хх-д 陷 (шавардах) гэж орчуулжээ. Үүнийг Элдэнтэй, Ардаажав (1986, 237), Иринжин (1987, 68) нарын судлагчид монгол сонгодог бичгийн "эмбүрикү, өмү, өмүрэкү" гэсэн үгтэй холбож тайлбарласан нь зүйтэй бололтой. Бидний бодлоор орчин цагийн монгол хэлний усанд умбах, шумбах гэсэн үгийн хуучин утга ч мөн үүнтэй холбогдолтой байж болох юм.Ямар ч атугай НТ-нд эл үг "өмрөх, нурах, шигдэх, шигсэх" гэсэн утгаар орсон нь тодорхой байна.

130. Кэйид гэдгийг хх-д 家裏每 (гэрүүдэд) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "гэр" гэдэг үгийн "гэ" буюу "кэ" гэсэн язгуурт олон тооны "-д" дагавар залгаж үүсчээ. Эл үг НТ-ны 134-р зүйлд мөн гэр орон гэсэн утгаар гарч байна. Энэхүү "кэйид" хэмээхийн утгыг нягтлан үзвээс НТ-нд олон удаа гарч буй "гэр" гэдэг үгнээсээ гэр гэртээ гэх юм уу хам утга, олны утгыг илэрхийлсэн шинжтэй санагдана. Элдэнтэй, Ардаажав (1986, 239) нар кэйид гэдгийг монгол дөрвөлжин бичгийн дурсгалд "гэйид" гэсэн хэлбэртэй байдаг гэж тэмдэглэжээ. Орчин цагийн монгол хэлд "хийд" гэх нь олон хүн бөөнөөр чуулж хурал ном үйлдэх газрыг нэрлэх болсон байна.

131. Уха'ута гэдгийг хх-д 察探(тагнах, турших) гэж орчуулжээ. Уг үгийн гарал нь орчин цагийн монгол хэлний "ухах, ухаарах" гэдэгтэй үндэс нэгтэй бололтой. НТ-нд эл үг хх. орчуулгад тэмдэглэсэнчлэн "тагнах, турших" гэсэн утгаар оржээ.

132. Күнгкэ'үлжү гэдгийг хх-д 離遠着 (холдуулж, зайлуулж) гэж орчуулжээ. Энэ нь НТ-ны 146, 185-р зүйлд мөн "зайлах, хаацайлах"

гэсэн утгаар гарч байна. Уг үгийн гарал нь орчин цагийн монгол хэлний "хүнхээлэх-хүнхийлэх, хөндийлөх" гэдэгтэй үүсэл нэгтэй байж болох юм. НТ-нд хэд хэдэн удаа гарч буй "күнгкэ" гэдэг нь уудам цээл гэсэн утгатай "хүнхэр" гэсэн үгтэй мөн дуудлага агуулгын талаар адилтган үзэх үндэстэй юм.

133. Мө'элэтжү гэдгийг хх-д 椎着(дэлдэж, цохиж) гэж орчуулжээ. Бидний бодлоор эл үг орчин цагийн монгол хэлний "**мөхийх, бөхийх, мэхийх**" гэдэгтэй язгуур нэгтэй бололтой байна. Энд "өвчүүгээ мөхийлдөж" гэж өгүүлсэн нь хоёр гараа өвчүүнийхээ тус газар (намилхайн хавьд) мохийлгон барьж мөргөл ёслол үйлдэхийг хэлсэн нь магадтай. Харин олонхи судлагчид хх. орчуулгыг дагалдан "өвчүүгээ дэлдэх, цохих" гэсэн утгаар хөрвүүлсэн нь чухам байдалд арай нийцэмгүй санагдана. Тэрчлэн орчин цагийн монгол хэлний "тэрэгний **мөөр**" (сонгодог бичгийн **мөгэр**), якут хэлний дугуй, тойрог гэсэн утгатай "мөкөнүкэн - мөкөчүк" (Пекарский, 1917, 1603) гэдэг үгс ч НТ-ны "**мөкэлэтжү**" гэдэгтэй гарал нэгтэй гэж хэлэх үндэстэй юм. Бидний өгүүлж буй мө'элэтжү хэмээх нь бас НТ-ны 172-р зүйлд "мөкэ'элэтба" (мөхийлгөв) гэсэн хэлбэрээр гарч байна. Үүнийг Лу "Алтан товчид" мөкүлиджү гэж бичжээ. Үүнийг бид гараа өвчүүндээ авч мэхийн ёслох зан үйлтэй холбоотой хэллэг болов уу гэж санана.

134. Үнэн гэдгийг хх-д 銀鼠 (мөнгөн хулгана) гэж орчуулжээ. "Лү лүн сай лүэ" хэмээх утгын зүйл хуваасан хятад монгол тольд мөн "үнэнг" гэдгийг "мөнгөн хулгана" гэж орчуулсан байна. Эл үг орчин цагийн монгол хэлд үнэ гэсэн дуудлагатай болжээ(Цэвэл, 1966, 623). "Хорин нэгт" зэрэг монгол хэлний тайлбар толь бичигт үнэ хэмээхийг "Хүрэнэ дор адилхан бие нарийн, өнгө шар амьтан" гэж тодорхойлсон байна. Жигмиддорж (1986, 1557) нарын найруулсан "Амьтны зураг тольд" үүнийг "солонгын язгуур төрөл, хүзүү нь урт..." гэх мэтээр тодорохойлоод хятадаар 白鼬 (Цагаан солонго) гэж орчуулжээ. Харин Элдэнтэй, Ардаажав (1986, 242) нар үнэ гэдгийг халхын аялгуунд үен хэмээнэ гэж үзсэн нь арай ташаа болсон байна. Үнэ, үен хоёр аль аль нь солонгын төрөлд багтах боловч толь бичгүүдэд эл хоёр амьтныг зааглан тайлбарласан буй.

135. Бүкийа гэдгийг хх-д 韁繩絆蹄(жолоо чөдөртэй) гэж орчуулжээ. Нангиад орчуулгыг баримтлан судалсан олонхи эрдэмтэд эл үгийн уул утгыг нарийн гаргасангүй хх. орчуулгын үгчлэн буулгасныг

шууд дагалдуулан буулгажээ. Монгол галиг, нангиад галиг аль алиныг харгалзан судалсан эрдэмтдийн нэг хэсэг нь энэ үгнээс тойрч, утгыг нь тодорхойлсонгүй. Тодорхойлохыг эрмэлзсэн нэг хэсэг нь хх. орчуулгыг илэрхий ташаарал гэж үзээд "бүкийа" гэсэн үгтэй ойролцоо дуудлагатай ямар нэг үгтэй хүчээр холбохыг оролджээ. Жишээлбэл "болхи бокий-а" гэх мэт үгтэй холбож тайлбарласан үзэгдэнэ. Гэтэл НТ-ны эл шүлгийн эн зэрэгцүүлэл холбосон 15, 16-р мөрд:

"**Ганц** морьт [болж]
Хандгайн жимийг дагаж" гэсэн буй. Чухамдаа энэ "**ганц** морьт" гэх нь "бүкийа морьт" гэдгийн утгыг тодорхойлж байгаа билээ. Үүнээс гадна хх. орчуулгын "хазаарлаж, чөдөрлөх морь" гэсэн утгаар хөрвүүлснийг анхаарах хэрэгтэй байгаа юм. Бидний бодлоор хх. орчуулгад монгол хэлний "чөдрийн ганц, унаарын ганц" гэсэн утгатай хэллэгийг үгчлэн буулгасан байдалтай юм. Үүнээс үндэслэн бид эл үгийг орчин цагийн монгол хэлний "бүхэл, бүтэн" гэдэгтэй язгуур нэгтэй "дан ганц" гэсэн утгатай гэж үзэж байгаа юм.

136. Бугу-йин (х)орим (х)оримлажу гэдгийг хх-д 鹿的徑徑依着 (хугарч хэмхэрсэн бургас) гэж тайлбарлан орчуулжээ. Чухамдаа энэ нь бугын гаргасан ором мөрийг дагаж гэсэн утгатай ажээ. Тэрчлэн эл шүлгийн мөрийн утгыг эн зэрэгцүүлэн холбосон "хандгайн ором оромлож" гэдэг мөр бас тодотгон өгч байгаа билээ.

137. Халхасун гэдгийг хх-д 破開柳條的 (хугарч хэмхэрсэн бургас) гэж тайлбарлаж орчуулжээ. Энэ нь гэрийн хана, мухлаг тэрэгний мөөрөн мод зэргийг матаж хийх нэг зүйл бургасны нэр бололтой. Дорнод монголын Халхын гол хэмээх нэр ч эл үгтэй холбоотой байж болох юм. Уг үгийн утгын талаар Элдэнтэй, Ардаажав (1986, 245) нар ордос аялгууны жишээнээс баримт гарган:

"**Халхаст** тэргэнд нууж
Хамгийн хан болгож
Унгаст тэргэнд нууж
Улсын эзэн болгож" хэмээн "Чингисийн тахилгын өчигт" өгүүлсэн байдгийг дурджээ. Мөн шүлгийн эн зэрэгцүүлэх аргаар холбосон

"**Бургасан** гэрт хоноглож
Бурхан дээр гарлаа" гэсэн хоёр мөр ч бидний энэ санааг давхар баталж байна.

138. Оро-бан (х)охторху гэдгийг хх-д 位自的行空 (ор байраа хоосолж) орчуулжээ. Энэ нь "ор үндсийг нь таслах" гэсэн утгатай холбоо үг ажээ. Эл үг НТ-ны 105-р зүйлд "оро охторху", 113-р зүйлд "оро ба ану охторхуй болгаба" гэж гарч байгааг тэмдэглэе.

139. Кө'үргэ гэдгийг хх-д 鼓 (хэнгэрэг) гэж орчуулжээ. Уг үг гарлын хувьд орчин цагийн монгол хэлний "хөөрөг-хөөрөгдөх" (сонгодог бичгийн көгэргэ) гэдгээс үүссэн байж болох юм. Энэ нь одоо үеийн том хэнгэргийг хэлнэ. НТ-ны 106-р зүйлд Жамухагийн Тоорил, Тэмүжин хоёрт хэл хүргэн өгүүлсэн үгэнд:

"Хараату тугийан сачуба би
Хара буха-йин арасун-ийар бүргисэн
Бүркирэн бүкүи дагуту **көгүргэ** бэн дэлэдбэ би" гэж шүлэглэснээс бүр тодорхой мэдэгдэж байна.

140. Көкидэг гэдгийг хх-д 輕驚動的(өчүүхэн төдийд сочимтгой) гэж тайлбарлан орчуулжээ. Эл үгийн гарлын талаар бидэнд тодорхой хэлэх баримт үгүй юм. Утгын хувьд гэвэл НТ-ны 105-р зүйлд л "аймхай, хулчгар" гэсэн агуулгаар хоёр удаа гарч байна.

141. Табчиту гэдгийг хх-д蓋子有的(даруулгат, бүрээст, хавхагт) гэж орчуулжээ. Бидний таамаглалаар эл үг нь орчин цагийн монгол хэлний "бүрээс, бүрхүүл, бүрхэвч" гэсэн утгатай "тав" (хадаасны тав, тав гээг г.м. Цэвэл, 1966, 510) гэдэг үгтэй гарал нэгтэй бололтой байна. Якут хэлний "хавхаг, бүрээс, бүслүүр" гэсэн утгатай "**тап**" (Пекарский, 1917, 2559) гэдэг үгийг ч үүнтэй холбож үзэж болохоор санагдана. Өөрөөр хэлбэл бид эл үгийг дээр өгүүлсэн "таб" хэмээх үгэнд нэр үүсгэх "ч" нөхцөл залгаж "табчи" болж үүн дээр өх оршихын тийн ялгалын дагавараар хэлбэржсэн үг гэж үзэж байна. Орчин цагийн монгол хэлд сумны гэрийг "дайз" гэдэг тул "дайзат сум" гэж хөрвүүлэв.

142. Кингүс гэдгийг хх-д 横斷(хөндлөн огтлох) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "хянгар-хянгардах" (сонгодог бичгийн кингардаху) гэдэгтэй гарал нэг байж болох юм. Эл үг НТ-ны 124, 255, 272-р зүйлд мөн таслах, хэрчих гэсэн утгаар "кингүрү, кингүрүткүн, кингүлбэ" гэсэн хэлбэрээр гарч байна.

143. Эмбүрү гэдгийг хх-д 塌了 (нураах, өмлөх, цөмлөх) гэж орчуулжээ. Эл үг "өмлөх, цөмлөх, эвдэх" гэсэн утгаар 105, 109-р зүйлд хоёрхон удаа гарч байгаа юм.

144. Сачуба гэдгийг хх-д 祭了也 (тахиж тайх) гэж орчуулжээ.

Энэ нь цэрэг хөдөлгөхийн өмнө туг сүлдэндээ сацал сацаж, тахилга мялаалга хийх зан үйлдлийг өгүүлжээ. "Сачуба" хэмээх үг НТ-ны эл 106-р зүйлд хоёр удаа гарахаас гадна "сачули" гэсэн хэлбэрээр 103-р зүйлд гарсан билээ. Мөн 193-р зүйлд Чингис хаан хулгана (1204) жил Найман иргэнд дайлаар мордоход "Зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдөр туг **сачу'ад** (тахиад) морилруун" гэсэн байна.

145. Монхол жэ андахартан гэдгийг 達達每應許聲做誓有的每 (Монгол за тангарагтан) гэж орчуулжээ. "Эрхий мэргэний" домог-үлгэрээс үзвэл монгол угсаатанд андгайлах, тангараглах ёс маш эртний уламжлалтай ажээ. Энэхүү уламжлалт зан үйлийн үл мөр нь НТ-ны 108-р зүйлд "жэ андахартан" гэснээс гадна мөн 141, 178-р зүйлд азарга, гүү цавчилдуулан андгайлах, чигчий хуруунихаа цусыг гарган андгайлах ёсны тухай өгүүлсэн буй. Бидний санавал "Монгол зэ андгартан" гэдэг үг бол монголчууд за гэсэндээ заавал хүрэх андгайтан хүмүүс гэсэн утгатай ажээ. Ийм ч учраас монгол аман зохиол "за гэвэл ёогүй" гэсэн зүйр үг гарсан биз. Тэрчлэн НТ-ны 255-р зүйлдэх

"Зээгийн нөхөр
Зээрдийн ташуур" гэсэн зүйр үг бол мөн энэхүү "зэ андгайтаны" хэмээхтэй учир холбогдолтой байж болно.

146. Хотулаху, чимарлаху гэдгийг 罰的 , 怪的 (яллах, зэмлэх) гэж орчуулжээ. Эдгээр үгсийн гарлын талаар бид тодорхой мэдэхгүй боловч энэ нь орчин цагийн монгол хэлний "өдөх, хатгах, голох" гэсэн утгатай "годлох, чамлах" үгстэй учир холбогдолтой байж магадгүй юм. Бид ямар ч атугай хх. орчуулгыг баримтлан "яллах, зэмлэх" гэсэн үгээр хөрвүүлэв. Чимарлаху гэх нь мөн НТ-ны 177, 254-р зүйлд "чимар, чимарха'асу" гэсэн хэлбэрээр гарч байна. Чимарлаху гэдэг үгийн хувьд монгол хэлд р,л авиа сэлгэх тул "чимар" хэмээх нь бас "чимал" гэсэн үндэстэй байх бүрэн боломж бий.

147. Хокиратала гэдгийг хх-д 罄絶 (хоосортол, дуустал, бартал) гэж орчуулжээ. ОРчин цагийн монгол хэлэнд "хохирох" гэдэг нь "хоосрох, дуусах" гэсэн утгатай байсан бололтой. Учир нь эл шүлгийн эн зэрэгцүүлэн холбосон мөрийн ойролцоо утгатай байваас зохих үг нь "эцэслэтэл" юм уу "дуустал" гэсэн агуулгатай үг орсон байна. Тэрчлэн эдүгээгийн бичгийн болоод ярианы хэлд "хоосорч хохирох" гэж хоршоо үгийн байдлаар өгүүлдэг нь угтаа адил утгатай байсны гэрч биз.

148. Тусулчаба гэдгийг хх-д 猛到 (гэнэт унав, гэнэт тусав) гэж

орчуулжээ. Эл үгийн агуулга нь "унах, тусах" гэсэн утгатай бөгөөд НТ-ны эл зүйлд сөхрөн унаж туссан гэдэг санааг илэрхийлж байна. Бид үүнийг "тэврэлдэн сөхрөлцөв" гэж хөрвүүлэв.

149. Эрэсчү гэдгийг хх-д 得着 (олзлох, барих, туух) гэж орчуулжээ. Энэ нь гарлын хувьд орчин цагийн монгол хэлний хувьд "нэрвэгдэх, автагдах, хэлмэгдэх" гэсэн утга бүхий эрсдэх гэдэг үгтэй гарвал нэгтэй ажээ. Эл үг мөн НТ-ны 112-р зүйлд "эрүсбэ" (баригдав) гэсэн хэлбэрээр гарч байна.

150. Жэшин гэдгийг хх-д想望(хүсэх, санах) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "үлгэрлэх, харьцуулах" гэсэн утга бүхий "жиших" гэдэгтэй гарвал нэгтэй байж болох юм. Уг үг дундад эртний монгол хэлд "санах, эрмэлзэх" гэсэн утгатай байжээ. Энэ үгийг Лу "Алтан товчид" "**жэсэн**" гэж тэмдэглэсэн байна.

151. Хатар гэдгийг хх-д орчуулаагүй байна. Бидний таамаглалаар эл үг орчин цагийн монгол хэлний "хатаж шинэх" гэсэн утгатай "хатиар" гэдэгтэй гарвал нэгтэй бололтой. Өөрөөр хэлбэл энэ нь хатах гэдэг үйл үгэн дээр нэр үүсгэх "р" нөхцөл залгаж үүсчээ. Үүнийг бас якут хэлний хатах гэсэн утгатай "хатар" (Пекарский, 1917, 3400) гэдэгтэй харьцуулан үзэж болно. Эн зэрэгцүүлэн холбосон эл шүлгийн хойно гарах "хунар, хохир" гэдэг үгс ч мөн гундаж хатсан, шинэсэн гэсэн утгатай байгаа билээ. (155-156-р тайлбарийг үзнэ үү)

152. (Х)унта'у гэдгийг хх-д 禍 (гай, зовлон) гэж орчуулжээ. Уг үг нь гарлын хувьд орчин цагийн монгол хэлний "унтуу-унтууцах" гэдэгтэй үүсвэр нэгтэй байж болох юм. Гэхдээ НТ-ны 111-р зүйлд хоёр удаа гарч буй "(х)унта'у" гэдэг үг нь "хөнөөл, зовлон" гэсэн утгатай байна.

153. Хуладу гэдгийг хх-д 鳥名(шувууны нэр) гэж тэмдэглэжээ. Хуладу хэмээх шувууг Шагжийн "Эрэхүйеэ хялбар болгон зохиосон чандманийн эрх" гэдэг тайлбар тольд: "Элээтэй адил болоод бяцхан. Өнгө хөх, сүүлийн уг цагаан, нялцайсан тэнхээгүй цагаан нь бас буй" гэжээ. В.Кливезийн (1982, 36) англи хэлний орчуулгыг үзнэ үү.НТ-ны 200-р зүйлд бас Боро хуладу гэж гарна.

154. Күчүгэнэ гэдгийг хх-д 小鼠(жижиг хулгана) гэж орчуулжээ. Монгол аман бичгийн зохиолд хүчгэнэ хулганын талаар өгүүлсэн зүйл цөөнгүй буй. Жишээ ардын хурим найрын дуунд:

"Хүний газар хартай
Хүчгэний нүх бүдэргээтэй" гэж дуулдаг бол

"Чингисийн билиг" сургаалд:

"Хүчит арслан өтөлбөөс
Хүчгэнийн нүх сахинам
Хүмүүн сайд өтөлбөөс
Хөвүүдийн үг дагах ажгуу" гэсэн байдаг байна. (Мансаан, 1985, 99)

155. Хунар гэдгийг хх-д орчуулаагүй байна. Ийм учраас эл үгийг судлаачид янз бүрээр таамаглан тайлбарласаар иржээ. Бидний бодлоор энэ нь 151-р тайлбарт өгүүлсэн "хатар", 156-р тайлбарт өгүүлэх "хокир" гэдэг үгстэй ойролцоо утгатай хатаж хорчийсон, нүнжиг буянгүй гэсэн утгатай бололтой байна. Уг үгийн гарлын хувьд тодорхой хэлэх баримтгүй боловч орчин цагийн монгол хэлэнд "гундах, гулрах" гэсэн үгсийн язгууртай холбон судалбаас сонирхолтой байж болно. Үүнийг Лу. "Алтан товчид" **qujar** гэсэн байна.

156. Хокир гэдгийг хх-д орчуулаагүй байна. Энэ нь бидний дээр өгүүлсэн "хатар, хунар" гэдгийн нэгэн адил хатсан, шинэсэн, өгөрч хуучирсан гэсэн утгатай байна. Энэ нь монгол бичгийн хэлний **хокир**, ойрд аялгууны хокар (Цолоо, 1988, 420) буюу хатсан, шинэсэн гэсэн үгтэй утга нийлнэ. Хуучин Баргын аман аялгуунд хонины хатсан баас, шаринхийг "хохир" гэхийн хамт тэмээг "гувруу", ямааг "годрон" гэж муучлан хараах утгаар хонийг бас "хохир" буюу "хохирон" гэж хэлдэг хэмээн Бээжин Их сургуулийн монгол хэлний тэнхмийн дэд проф. Хурлаад овгийн Чүлтэм багш надад ярьж билээ. Энэ нь Агийн буриад аялгуунд:

Хонь чинь олон

Хокир чинь зузаан гэсэн зүйр үгтэй холбогдож байна. Үүнээс үндэслэж НТ-д өгүүлж буй "**хокир**" гэдэг үгийг бид малын баас, шивхиг, шарих гэсэн утгатай үг гэж төсөөлж байна. Үүнээс гадна эл **хокир** хэмээх үг нь уг шүлгийн удаах мөрний "хорголын төдий амиа" гэсэн хэллэгтэй бас утга авцалдаж байгаа юм.

157. Харату гэдгийг хх-д орчуулаагүй байна. Бидний бодлоор "**Харату** харанхуй хавцал" гэх нь "харанхуй хар хавцал" гэсэн үг болно. Өөрөөр хэлбэл уг шүлгийн аравдугаар мөрд "харанхуй хавцалд шургаюу" гэснийг 22-р мөрд эн зэрэгцүүлэх аргаар давтан холбохдоо хүч нэмэгдүүлэх, тодотгол үг нэмсэн байна. Эртний түрэг хэлд хар болгох юм уу, харлуулах гэдгийг "**харарт**" (Наделяев, 1969, 425) гэдэгтэй

ойролцоо хэлбэр бололтой.

158. Түбэжү гэдгийг хх-д 配着 (холбож) гэж орчуулжээ. Энэ нь сонгодог бичгийн хэлнээ "түбкэжү" буюу ханилах, нийлэх гэдэг үгийн хуучир хэлбэр ажээ. Үгийн гарлын хувьд эртний түрэг хэлний "түб-түп" буюу "үндэс" (Наделяев, 1969, 598), орчин цагийн монгол хэлний "түв-түвшин" гэсэн үгстэй язгуур нэг байж магадгүй юм. НТ-нд эл үг "ханилж, нийлж, нөхцөж" гэсэн утгаар зөвхөн ганц удаа гарч байна.

159. Этүгэнэ гэдгийг хх-д 地行 (газарт) гэж орчуулжээ. Энэ нь эртний монгол хэлний газар, дэлхий гэсэн утгатай үг болно. Монгол Сулхарнайн туужид "дэгэр-э тнгри-дэчэ этүгэ экэ жокийагсан инагшида...урида кэдүн-бэ хад төрэбэи" гэсэн буй. Этүгэн хэмээх үг НТ-ны 190, 201, 245, 254-р зүйлд мөн газар дэлхий гэсэн утгаар гарч байна.

160. (Х)ачиту гэдгийг хх-д 譬報 (өшөө авч) гэж орчуулжээ. (50-р тайлбарыг үзнэ үү)

161. Ичикин жархаг гэдгийг хх-д 粉皮 (илгэн арьс) гэж орчуулжээ. Энэхүү холбоо үгийг судлагчид харилцан адилгүй ойлгож орчуулж тайлбарласаар иржээ. Бидний санавал "Ичикин" (илэг) "жархаг" хоёр нь "шүлэг холбоо", "цэрэг цуух", "бараа таваар" гэдэг шиг адил утгат хоршоо үг бололтой байгаа юм. "Жархаг" гэдэг үгийн хувьд монгол хэлний илэг гэдэгтэй ойролцоо утгатай түрэг гаралтай үг гэж үзсэн Дугаржав (1984, 58), Элдэнтэй, Ардаажав (1986, 290) нарын саналыг дэмжиж байна. Мөн үгийг Сэцэнцогт (1988, 2253) "Монгол үгсийн язгуурын тольд" : "Үсийг нь хуссан зөөлөн арьс" гэжээ. Дээр өгүүлсэн баримт жишээг үндэс болгон бид эл холбоо үгийг орчин цагийн монгол хэлээр "Илгэн хөөмий" гэж хөрвүүлэв. Эдүгээгийн ойрд аялгуунд **зарган** гэнэ (Цолоо, 1988, 239).

162. Сауха гэдгийг хх-д 人事(хүн хийх) гэж орчуулжээ. Эл үг НТ-ны 135-р зүйлд мөн адил утгаар гарч байна. Монгол бичиг шастирт аян дайны бэлэг хийгээд алба гувчуурыг "саух-а" гэх тул олонхи судлагчид хх. орчуулгыг үл харгалзан "бэлэг" гэсэн үгээр голчлон хөрвүүлжээ. Нангиад хадмал орчуулгыг нарийн баримтлан судалсан проф. В.Кливез ч үүнийг "сауга" гэсэн маягаар галиглан сийрүүлээд товч тайлбартаа мөн л "бэлэг" гэж тэмдэглэсэн байна. Бидний бодлоор хх-д "хүн хийх, хүн болгох" гэж орчуулсан нь уг үгийн утгыг яг оновчтой гаргасан гэж санана. Учир нь Өэлүн эх хожим нь Мэргэдийн нутгаас

олдсон Гүчү, Бэсүдийн нутгаас олдсон Хөхөчү, Татаарын нутгаас олдсон Шигихэн Хитугу, Жүрхиний нутгаас олдсон Борохул энэ дөрвөн хөвүүдийг чухам "өдөр үзэх нүд, шөнө сонсох чих" болгох гэж тэжээж хүн болгосон тухайгаа өгүүлснийг бид НТ-ны 138-р зүйлээс мэднэ. Орчин цагийн монгол хэлд ч нялх нялзрай хүүхдийг өсгөж бойжуулахыг "хүн хийх, хүн болгох" гэж хэлэх ёс бий. үүний жишээнд:

Хүн болох багаасаа
Хүлэг болох унаганаасаа гэсэн ардын зүйр үгийг дурьдаж болно.

163. Чорхан гэдгийг хх-д орчуулаагүй байна. Ийм учраас эл үгийг судлагчид янз бүрээр таамаглаж байв. Эрдэмтэн Ж.Цэвээн (1910, 199) "Ордос дахь Чингисийн тахилга" гэдэг өгүүлэлдээ XIII зууны үеэс уламжлалтай хүзүүвчин тоонотой шомбогор оройт гэрийг цомцог гэж нэрлэдэг" гэж тэмдэглэсэн байна. Үнэхээр Ордосчуудын эдүгээ хүртэл "чомчог гэр", "эжний чомчог" гэж нэрлэдэг гозгор оройтой гэр бол (Мостарт, 1942, 712) НТ-нд өгүүлж буй "цорхан гэрийн" нэг загвар бололтой байна. Д.Майдар, Л.Дарьсүрэн (1976, 82) нар монгол гэрийн судалгаандаа цорхан, цомцог хоёрыг холбож өгүүлсэн зүйл бий. Бидний санавал "цорхан" гэдэг үг бол цорго хоолой мэт шомбогор оройтой учраас хэлбэр маягаар нь цорготой адилтгасан байж болох юм.

164. Тунхулдужу гэдгийг хх-д 共重新着 (дахин хийж, дахин сэргээж) гэж орчуулжээ. Ойрд аялгууны хэрэглэгдэхүүнээс үзвэл уг үгийн үндэс нь "анхан, угийн, мөн" гэсэн утгатай байсан бололтой. Жишээлбэл Баяд туульч Чулууны Дүүдээн хайлсан "Хан Харанхуйн" хувилбарт "мөн биедээ зохирч, угийн биедээ зохирч" гэхийг "тунхан биедээ зохирч" гэж хэлж байна. Тэрчлэн Халимагт "тунх" гэж тулгар буюу анхан унагалах гүүг хэлдэг байна (Муниев, 1977, 518). Ийм учраас НТ-ны "тунхулдужу" хэмээх нь угийн юм уу анхныхаа анд бололцсныг сэргээлцэж гэсэн утгатай бололтой байна. (684-р тайлбарийг үзнэ үү).

165. Чинкүлтүгтү гэдгийг хх-д 銅灌的(зэс цутгасан) гэж орчуулжээ. Бидний бодлоор эл үгийн гарал нь хөндийлж ухсан нүх, усны гүн хэсгийг цүнхэл, цүнхээл гэж хэлдэгтэй холбоотой байж магадгүй гэж үзэж байна. Учир нь монгол хүүхдийн тоглоомд шагайгаар "морь уралдуулж" наадахад шагайгаа "хурдан" болгохын тулд (морь босгох) гэж тавгий нь үрж тэгшлэхийн хамт тавган талаас нь хөндийлөн

ухаж, нүх гаргаад түүндээ тугалга мэтийг цутгаж, тавган талы нь хүндрүүлж, суурь сайтай болгох ёс одоо ч байдаг. Энэ талаар Мансаан (1985, 102) уг үгийн тайлбартаа бас өгүүлжээ. Үүнээс үндэслэн бид чинкүлтүгтү гэдгийг угтаа цүнхэл нүх гэдэг үгнээс гаралтай болов уу гэж таамаглаж байна.

166. Алангир гэдгийг хх-木做的 (модоор хийсэн) гэж орчуулжээ. Элдэнтэй, Ардаажав (1986, 301) нар "Хорин нэгтийн" тайлбар тольд "тосон харгай модыг элэг хадахгүй нум хийвээс алангир хэмээмэй" гэснийг иш татан өгүүлэхийн хамт Дагуур хэлд "алангэ" гэдэг гэжээ. Тэрчлэн эдүгээгийн Хөх нуурын монголчууд мод татаж цагиргалсан хүүхдийн тоглоомыг алангир гэдэг гэжээ. Я.Цэвэл (1966, 29) "Хорин нэгтийн" тайлбартай ойролцоогоор "тосон харгай модоор хийсэн элэггүй нум" гэв. Дээр өгүүлсэн жишээ баримтаас үзвэл матаж махийлгахад авсаар хугарахгүй зөөлөвтөр модоор хийсэн нумын нэр ажээ.

167. Йор гэдгийг хх-д 響髀頭 (чанга дуут ясан сум) гэж оновчтой тайлбарлан орчуулжээ. Манж хэлд ясан хошуутай годилыг **йоро** (Цинциус, 1975, 348) гэдгээс үзвэл алтай хэлтний эртний уламжлалт дундын чанартай үг бололтой. Эл үгийн тайлбар өгүүлэлдээ Элдэнтэй, Ардаажав (1986, 302) нар Мин улсын үеийн "Ден тан би жү" хэмээх монгол хэлний товч тольд (зэр зэвсгийн аймагт) ясан годилыг **ясан йоро** гэж тэмдэглэсэн байдгийг дурдаад дөрвөлжин болгоод дөрвөн нүд ухаж туулай харвахад хэрэглэх сум гэж тайлбарлажээ. Тэрчлэн Мин улсын үеийн "Лү лун сай-лүэ" гэдэг утгын зүйл хуваасан толийн зэр зэвсгийн зүйлийн сумны хэсэгт **йасужур (х)уо-йасуйиэур** хэмээх үсгийг хятадаар "ясан толгойтой сум" гэсэн утгаар орчуулсан байна. Энэхүү **йор** сумыг харван нисгэхэд хошууны нүхээр нь салхи исгэрч дуу гарах тул "дуут йор" гэж нэрлэсэн ажээ. Жич эл үгийг Т.Дашцэдэн (1985, 53) "дауту хор-ийан" гэж галигласан нь НТ-нд олон удаа гардаг сум буюу "хор" гэдэг үгтэй хутгасан бололтой юм.

168. Эсгэл гэдэг үгийг хх-幾年不生駒的(хэдэн жил унагалаагүй) гэж тайлбарлан орчуулжээ. Хэдэн жил дараалан гусарч байгаад унагалсан гүү юм уу эсвэл эх нь хэдэнтээ гусарч, гусран гүүний сүү хөхсөн үрээ шүдлэнг бас эсгэл үрээ гэдэг байна. Тухайлбал эдүгээгийн цахар аялгуунд гусран гүүний үрээг эсгэл үрээ буюу эсгэл хөхсөн үрээ гэдгээс үзвэл "эсгэл" хэмээх үг нь эхэд нь холбогдож байгаа нь тодорхой

байна. Эл үгийн тухай Элдэнтэй, Ардаажав (1986, 304) нар "эсгэлийн төрсөн унага нь гурван жил дараалан эх юугаа хөхдөг тул бие тарган, чийрэг байж сайн адуу болдог. Хоёр насандаа өдөрт гурван газар явж чаддаг" гэх мэтээр тодорхойлжээ.

Яукт хэлд "эскэл" гэж тарган, махлаг, өөхтэй (Пекарский, 1917, 310) гэсэн утгатай үг байхаас үзвэл энэ үг нь монголын бусад зарим төрөл хэлд байх бололтой. Уг үг нь монгло аман бичгийн зохиолд мөн "эмнэг хангал, тарган" гэсэн утгаар гардаг. Тухайлбал Жангарын туулийн торгууд хувилбарт:

"**Эсгэл** гүүнүүдийн үсүн (сүү)
Элбэг арзын суурьд
Умай цагаан умс нь
Урагдас хийж халаад
Хангал гүүнүүдийн үсүн
Хатуу хар арзын суурьд
Халанги мангараар (хөлчүү) суугаад" (Буянхишиг, Бадам, 1982, II, 810) гэж шүлэглэсэн буй.

169. Эбэртү үнүгүн чага'ан – 有角的牯犢羔兒般白馬(Эвэртэй эр ишиг мэт цагаан морь) гэж маш тодорхой тайлбарлан орчуулжээ. Гэвч судлагчид "эбэр" болоод "үнүгүн" гэдэг хоёр үгэн дээр маргалдсаар одоо болтол нэгдмэл ойлголттой болоогүй байна. Уг хэллэгийн талаар проф. А.Мостарт(1953,) ордос аялгуунд ишиг гэхийг "үнүгү" гэдгийг баримт болгон эн тэргүүнээ хамгийн зөв оновчтой тайлбар хийсэн билээ. А.Мостартын санал нэгэнт зөв болохыг НТ-ны хх. орчуулгаас гадна ишгийг ордос аялгуунаас гадна хорчин, мөн ойрдын зарим аялгуунд одоо болтол "үнүг" гэж хэлдэг амьд жишээ давхар баталсаар байгаа болно. Тэрчлэн "Мукаддимта-Ал-адаб" тольд ишигийг бас "үнүгүн" гэснийг (Поппе, 1938, 382) бэлхнээ үзэж болно. Гэтэл Х.Лувсанбалдан (1989, 73) "Эвэрт үнэгэн цагааны тухай дахин өгүүлэх нь" гэдэг өгүүлэлдээ монгол ардын зарим туульд "эвэрт азарга, эвэрт жороо морь" гэж өгүүлдэгийг олж үзээд "эвэрт үнэгэн цагааныг" "сахалтай морь гэсэн үг биш үү" гэсэн асуулт гаргасан байна. Гэвч НТ-нд гарч буй "эбэртү" гэдэг нь морь гэсний шууд тодотгол бус "эвэрт үнүг" буюу "эвэрт ишиг" гэсэн холбоо үгээр бүтсэн нэг ухагдахуун гэдгийг бодож үзэх байжээ.

Монголчууд хүлэг сайн морио хайрлаж, эрхэмлэж, өхөөрдөж

нэрлэхдээ "янзган зээрд", "туулай хүрэн", "буган халиун" гэх зэргээр амьтан, адгуусны дүр төрх, өнгө зүсээр үлгэрлэн өгүүлдэгийг малын захад өссөн мань мэтийн хүмүүс бол мэдэх учиртайсан билээ. ийм учир "эвэрт ишгэн цагаан" гэдэг нэртэй морь байна гэхэд эргэлзэх явдалгүй биз.

170. Тойилан гэдгийг хх-д орчуулаагүй байна. Ийм учраас эртний монгол хэлний эл үгийг судлагчид янз бүрээр ойлгож, орчуулж ирснийг бид "Монгол яруу найргийн зарим нэр томъёоны гарал үүслийн асуудалд" (1984, 32) гэдэг өгүүлэлд тодорхой тэмдэглэсэн билээ. Бид уг үгийн үндсийг орчин цагийн монгол хэлний найр хурим гэсэн утга бүхий "той" гэдэгтэй холбож үзэж байгаа юм. Монгол хэлний одоо үеийн толь бичгүүдэд "той" хэмээхийг гол төлөв "гэрлэхийн хурим" буюу "той хурим" гэж тэмдэглэсэн байна (Шагж, 1937, 604), (Лувсандэндэв, 1957, 404), (Цэвэл, 1966, 536).

Той хэмээх үг нь эртний монгол хэлд "дуу аялгуу" гэсэн утгатай байсан нь монголтой төрөл якут, узбек зэрэг хэлний баримтаас ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл бид "той" гэдгийг гарлын хувьд түрэг хэлтний "туйуг", "туюг" гэсэн үгтэсдй үүсэл нэгтэй гэж үзэж байгаа билээ. (Энэ тухай холбогдуулж И.В.Стеблевагийн "Туюг хэмээх төрлийн гарлын асуудалд" 1970, Х.Г.Короглын "Туйуг хэмээх төрлийн хувьсал" 1980) гэсэн өгүүллүүдээс харьцуулан үзэж болно.

171. Алачуха гэдгийг хх-д 帳房 (гэр оромж) гэж орчуулжээ. Эл үгийг бид НТ-ны хх. орчуулга дахь ерөнхий агуулгын баримжаанаас "халхавч, нөмөр" гэсэн утгатай гэж таамаглаж байгаагаас цааш гарлын хувьд тодорхой хэлэх баримт үгүй байна.

172. Көкижү гэдгийг хх-д 驚着 (цочиж буй) гэж орчуулжээ. Элдэнтэй, Ардаажав (1986, 313) дагуур хэлд "күкийэжү" хэмээх нь өдөөх, заан дохих гэсэн утгатай бөгөөд энэ нь бичгийн хэлний "хөхүүлэх" (урамшуулах, шагнах) гэдэгтэй гарал нэгтэй гэж үзсэн байна. Бид хх. орчуулгыг баримтлан "сочин [дайжиж]" гэж хөрвүүлэв.

173. Тохура'ун гэдгийг хх-д орчуулсангүй хүний нэрд хамааруулжээ. Бидний ажигласнаар энэ нь ямар нэгэн овог аймаг буюу яс элгэний нэр болотой байна. Эл үг бас НТ-ны 124-р зүйлд мөн энэ бүлэгт гарсан Жалайр аймгийн **"Хачи'ун Тохура'ун** хор ахсаба", **"Харгай Тохура'ун** ... үлдүс (илд) ахсажу", **"Харалдай Тохура'ун**... агта баритугай агтачин болтугай" гэж өгүүлсэн буй. Үүнээс үзвэл яав ч

хүний нэр биш гэдэг нь мэдэгдэж байгаа юм.

174. Чэрби гэдгийг хх-д орчуулсангүй хүний нэрд хамаарулсан байна. Харин НТ-ны 191-р зүйлд Чингис хаан Наймантай тулалдахын өмнө цэргийн зохион байгуулалтаа нарийсган эмхэлсэн тухай өгүүлсэн хэсэгт **чэрбинийг** хх. орчуулгад官名(ноён зэргийн нэр) гэж тэмдэглэжээ. Элдэнтэй, Ардаажав (1986, 315) нар Мин улсын үеийн "Ден тан би жиү" хэмээх хүний ишийн зүйлд "чэрбин- чэлбин хэмээх нь цэргийн түшмэлийн нэр, утга нь мянганы ноён болно" гэж тайлбарласныг иш татан өгүүлжээ. Их Мянганы Иринжин (1987, 86) уг үгийг "Хааны ордонд гэр тэрэг, зарц, эсвэл цэргийн манаанд ажил мэддэг түшмэл хэмээгээд хожим нь чэрби нар ханы ордонд харийн ван нар бараалах ажлыг мэддэг сул түшмэлийг хэлэх болсон бололтой" гэж тайлбарласан байна. Лу "Алтан товчид" үүнийг **"түрүү ноён"** гэж тэмдэглэжээ.

175. Кэкэ гэдгийг хх-д 胞裹 (хойтохын шингэн) гэж оновчтой зөв орчуулжээ. Гэвч эл үгийг судлагчид элдэв янзаар таамаглаж зөрүүтэй санал гаргасаар ирсэн нь хх. орчуулгыг нарийвчлан анхаарч зөв ухаж чадаагүйгээс болсон бололтой. Тухайлбал эл үгийн талаар тусгай өгүүлэл зориулан бичсэн Ш.Гаадамба (1976, 156) "кэкэ" гэдгийг "эх" гэж үзсэн нь илэрхий эндүүрэл болов. Харин проф. Э.Хэниш (1948, 32) хх. орчуулгыг баримтлан уг үгийн утгыг герман хэлээр зөв буулгасныг тэмдэглэе. НТ-г орчин цагийн монгол хэлээр хөрвүүлэгчдээс Мансаан "Гэгэ гэгч хүүхэд төрөхөд урьдаар ус гардаг. Орчин цагийн монгол хэлэнд **гэгэ** гэдэг гээх, орхихын утгатай нэр үг "хүүхэд агуулсан **ихэс** мэтийн зүйл болой" гэж тайлбарлажээ.

Хүн малын хойтохын шингэнийг (усыг) Хуучин Баргын аман аялгуунд "хэхий" гэдэг гэж Бээжин их сургуулийн дэд проф. Чүлтэм багшийн надад ярьсан нь Найманы аман яриандмөн хойтохын усыг "хэхи" гэж хэлдэг гэсэн мэдээтэй (Элдэнтэй, Ардаажав, 1986, 320) яг нийцэж байна. Тэрчлэн орчин цагийн монгол хэлний төрөхийн хойтохыг "эхэс" гэж хэлдэг нь уг үгийн эхний "х" авиа гээгдсэн олон тооны хэлбэр бололтой. Дээр өгүүлсэн баримт, жишээнээс үндэслэн бид эл зүйр үгийг:

"Хээл нэгтэн
Хэхий (эхэс) гагцтан" гэсэн үг гэж ухаж байна.

176. Жа'арин гэдэг үгийг хх-д 神告 (бурханы хэлмэрч) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний эрэгтэй бөө хүн буюу

зайран (сонгодог бичигт жайиранг) мөн болно. Бөөгийн шашны ойлголтоор зайран хүн бол тэнгэртэй хэл нэвтрэлцэн, тэнгэрийн зарлигийг дамжуулагч гэж өөрсдийгөө хэлдэг тул уг үгийн гарал нь монгол хэлний заах гэдгээс үүссэн байж болох юм.

177. НТ-ны 121-р зүйлд гарч буй Жамухаг мөргөж өрөөсөн эврээ хугалсан **солжир ухаагч үнээ**, их гэр тэргийг дээр өргөж, хөллөж, зүтгэж Тэмүжиний хойноос их царгиар мөөрч яваа **Мугалзар ухаа үхэр** хоёрын аль аль нь тэнгэрийн зарлигийг заан хэлэгч зайран бөөгийн төлөөлөгч дүрийн маягтай дүрслэгдсэн байна. Ийм санааг зохиолч Инжаннаши (1957, 288) "Хөх судар" хэмээх түүхэн шастиртаа: "Нэг мугалзар хар бухандай мэт юм цэргийн хүрээг тойрон манаж явсан тэргүүрээр гүйж нэг хүнийг мөргөж алав. Тэр мугалзар хар бухандайг очсоны хойно би тэр мөргөлдөж үхсэн хүнийг үзвээс миний ах Жамухагийн тэнсүүл, туршуулын тэргүүлсэн түшмэл Жара ажээ. Биеийн үзвээс тэнгэрийн аянга дор дайрагдсан мэт хөө дарийн үнэртэй байв" гэж тодруулан өгүүлжээ. Үүнээс гадна бидний иш татан өгүүлж буй **солжир ухаагч үнээ, мугалзар ухаа үхэр, хар бухандай** зэрэг нь монголчуудын эрт дээр цагаас үхэрт биширч, үхэр онголон дээдлэж ирсэн уламжлалт зан үйлтэй бас холбоотой байж болох юм. Хүннү нарын уг удмыг зарим судлагчид үхэр онгонтой байсан (Бернштам, 1946) гэх ба Тоба нарт үхэр дуутай амьтан зам зааж өгсөн гэдэг домог бий. Тэрчлэн үхэрт сүсэглэх ёс монголчуудын эртний уламжлалт зан үйлд ул мөрөө үлдээсэн зүйл цөөнгүй буй. Жишээлбэл Рашид-Ад-диний (1952, 1-1, 192) "Судрын чуулганд" монголчууд үхрийн эвэрт цус хийж тангарагладаг гэх ба монголын түүхийн өөр зарим сурвалжид цагаан морь хар үхэр алж тангарагладаг заншилтай байсан гэх мэдээ буй. Буриадын бөө мөргөлийн дуудлага болон "Бух ноёны домогт" буриад зоныг тэнгэрийн элч болох Бух ноёноос үүссэн гэдэг ойлголт бий билээ.

Бид 1986 оны 9 сард Дорнод аймагт Буриадын аман зохиол судлах ажлаар явах үед Чойбалсан хотын IX хорооны ард Норовсүрэнгийн Дарьзаваас (1898 онд төрсөн) тэмдэглэж авсан "Тэнгэрийн оёдолын тухай" домог-үлгэрт өгүүлсэн нь: "Эрт урьд цагт нэг өвгөн нас барахынхаа өмнө хүүхдүүддээ өмч хуваж өгөх болжээ. Тэр айлд нэг солжир ухаа үхэр байсан юм байна. Тэгсэн тэр солжир ухаа үхэр нь: -аавыгаа өмч хуваах үед чи намайг аваарай" гэж бага хүүд захижээ. Отгон хүү ч үхрийн захисан ёсоор аваасаа солжир ухаа

үхрийг гуйж авсаң гэнэ. Тэгээд байж байтал үхэр нь нэг өдөр хүүд хэлжээ.

"Өнөөдөр тэнгэрийн охид ирж Шар мөрний усанд орно. Тэр үед нь сэмхэн гэтэж очоод нэгнийх нь хувцсыг нуучихаарай!" гэжээ. Ийнхүү солжир ухаа үхрийн зааврааp явж тэр хүү тэнгэрийн дагинатай гэрлэх боловч хожим нь үхрийнхээ захиасыг дутуу биелүүлсний улмаас хоёр өнчин хүүхэдтэй хоцорсон тухай өгүүлдэг юм. Эл домог-үлгэрийн өгүүлэмжид хятадын Хурмаст тэнгэрийн 7-р гүнжтэй урагласан Ню Ланы домог-үлгэр буюу "Үхэрчин нэхмэлчин хоёрын домог-үлгэрийн" нөлөө байх болов**ч солжир ухаа үхэр** гэж өгүүлсэн нь сонирхолтой байна.

Тэрчлэн НТ-ны 240-р зүйлд Дөрвөдийн Дөрбэ догшин Чингис хааны зарлигаар ойн иргэдийг эзлэн авахдаа "**улаан бух**ын явсан мөрөөр" цэргүүдээ давшуулж явсан тухай өгүүлсэн буй. Бидний санавал энд гарч буй **улаан бух** ч бас л буриадын Бух ноёны домог зэрэгтэй ойролцоо домог-үлгэрийн өгүүлэмжтэй холбоотой ойлголт шиг байгаа юм. Дээрх баримт сэлтээс үндэслэж бид НТ-ны "**солжир ухаагч үнээ, мугалзар ухаа үхэр**" зэргийг эртний монголчуудын үхэрт сүсэглэх зан үйлтэй холбоотой зүйл гэж үзэж байгаа юм.

178. <u>**Гэрлүгэ**</u> гэдгийг хх-帳房下椿 (суурьт гэр?) гэж орчуулжээ. Судлагчид эл үгийн хх. орчуулгыг янз бүрээр ойлгосноос харилцан адилгүй орчуулж тайлбарласаар иржээ. Жишээлбэл Бөххишиг (1942, 77) "их гэрийн багана" гэж, В.Кливез (1982, 53) "a great stake under tent" (дороо багант том майхан) гэж, Дугаржав (1984, 63) "их гэрийг сууриар нь ..." гэх зэргээр орчуулсан байна.

Бид үүнийг XIII зууны үеийн монголчуудын их нүүдэл, аян дайнд олонтаа хэрэглэдэг байсан "гэр тэргэний" нэг хэлбэр болов уу гэж үзэв. Д.Майдар, Л.Дарьсүрэн (1976, 85-86) "Гэр орон сууцны түүхэн тойм" гэдэг зохиолдоо "**гэрлүгэ**" хэмээхийг "гэр" гэдэг дээр "лүгэ" дагавар залгаж үүссэн бололтой гэж үзжээ. Энэ нь аян дайнд явах үест хурал зөвлөгөөн болох, элч төлөөлөгчийг хүлээн авах мэт хэрэгцээнд зориулсан нүүдлийн сууц гэж тодорхойлоод хэлбэр, хэмжээний хувьд "гэр тэргэнээс" ялгаатай гэж тэмдэглэсэн байна. Лу "Алтан товчид" **Их гэр гэрлүгэ тэргэн өргөж** хэмээгээд **гэрлүгэ** гэдэг үгийг **бараа** хэмээн тайлбарлажээ.

179. <u>**Тэргэ'үр**</u> гэдгийг хх-д 車路 (тэргэн зам) гэж оновчтой орчуулжээ. Энэ нь хөсөг тэрэгний зам царгийг өгүүлсэн нэр томъёоны

чанартай үг болно. Баргын аялгуунд тэргэн зам царгийг "тэргүүр" гэж хэлдэг байна. Энэ нь дундад зууны үеийн монгол бичиг зохоилд цөөнгүй тохиолддог үг юм. Жишээлбэл Инжаннашийн (1957, 288) "Хөх сударт" "тэргүүр" гэдэг үг зам гэсэн утгаар гарахын хамт "Чингисийн тахилгын их өчигт":

"Хайр их овогтныг
Хайн явахуйд
Харгуй **тэргүүр** замыг
Гэтэн явахуйд" гэж шүлэглэсэн байдаг байна. Харин Дагуур хэлд ердийн зам, харгуйг "тэргү" гэдэг ажээ (Элдэнтэй, Ардаажав, 1986, 324).

180. Алгинчи ха'улжу гэдгийг бид шүлгийн холбоцод нийлүүлэн утгын үл өөрчлөн "оройлон довтлож" гэж хөрвүүлэв. (Эл үгсийн тухай 34, 36-р тайлбарт үзнэ үү)

181. Орожу абчиражу гэдгийг хх-入着將來着 (орж авчирч) гэж орчуулжээ. Энэ хэллэг НТ-ны нангиад галигийн зарим эхэд гээгдсэн бололтой. Учир нь бидний ажигласнаар Элдэнтэй, Оюундалай (1980, 210) нарын харьцуулан сийрүүлсэн НТ-ны нангиад галиг, Иринжиний (1987, 89) уйгаржин монгол үсгээр сэргээн буулгасан эхэд үгүй байна.

182. Харгам гэдгийг хх-д 臂節(бөгсний зураа, хондлой) гэж зүйтэй орчуулжээ. Я.Цэвэлийн (1966, 664) тольд "харгам" гэдгийг "морь, малын олон яс нийлэхийн хойтох хэсэг газар" гэж тайлбарлав. Монголчууд морь малыг шинжихэд бөгсний зураа, хондлой, ташааг ихэд эрхэмлэн үздэг уламжлалтай. Жишээ нь ойрдын баатарлаг туульд "Хангайн чинээ **хангал ташаа** хар хээр морь" гэж сайн хүлгийн шинж бүрдсэн морины тухай өгүүлсэн байдаг. НТ-нд энэ уламжлал ёсоор харгам буюу зураа, хондлой сайтай морийг эрхэмлэн өгүүлжээ.

183. Хала гэдгийг хх-號令(зарлиг, тушаал) гэж зүйтэй орчуулсан шиг банйа. Эл үгийг олонхи судлагчид **"хала"** гэж уншиж галигласан боловч Алтан-Очир (1942, 56) **"хара"** гэж буулгасныг тэмдэглэе. Элдэнтэй, Ардаажав (1986, 330) "Монголын баруун орны аман яриand хал хэмээх нь монголын ван, гүнгийн зарлигийг хэлнэ" гэжээ. Чухамдаа энэ нь хатуу чанга, зарлиг тушаал, заавар ёсыг нэрийдсэн бололтой.

"Халаа гаднаа
Хайраа дотроо" гэсэн монгол ардын зүйр үгийн утга нь гадна талдаа хатуу чанга загнаж байвч, дотроо өрөвдөж

хайрлаж явна гэсэн сургаалтай ажээ. Бидний санавал уг үгийн гарал нь орчин цагийн монгол хэлний "хал-халгаа-халтай" гэдэгтэй язгуур нэгтэй байж болох талтай. Проф. ИРинжин эл үгийг "тушаал, албадал, халгар, заавал, эрхбиш" гэж товч тайлбарлав.

184. Хари шири гэдгийг хх-家活 (гэрийн ажил) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "хар бор ажил" гэсэн утгаар ухаарсан болов уу гэж санагдана. Бас НТ-ны эл шүлгийн 28-р мөрд гарах "хара" (энэ нь эгэл хүн юм уу хар хүн гэсэн үг бололтой) гэдгийг мөн "хари ширийн" орчуулгатай нэг адил "гэрийн ажил" хөрвүүлснийг эрх биш анхаарах учиртай.

Элдэнтэй, Оюундалай (1980, 211) нарын харьцуулан сийрүүлсэн НТ-ны нангиад галигт "хари шири" гэдгийг "хахарик ширилик" гэсэн маягийн дуудлагатай үсгээр тэмдэглэснийг анхаарах буй за.

Ш.Гаадамба (1976, 124) "Монголын нууц товчооны зарим нэр томъёоны учир" гэдэг өгүүлэлдээ "...Ядрах цагт өмөг түшиг болдог ураг төрөл нь харь шир буюу тэр овгийн хүний эхнэр авах гэрээ хэлэлцээртэй харь овог мөн байсан биз. Нэг ястан буюу нэг өвгөөс гаралтай хүмүүс хоорондоо хүмүүс хоорондоо гэр бүл бололцож болохгүй, эрхбиш харь овгоос эхнэр авах экзогами гэр бүлийн ёс тогтсон үед тэрхүү эхнэр авч болох харь овгийг"харь шир" гэж нэлэж байсан болов уу гэж бид таамаглаж байна" гэсэн байна. Энэ сонирхолтой саналыг шууд зөвшөөрөхөд бас эргэлзэх зүйл бий. Юуны өмнө хх. орчуулгын "гэрийн ажил" юм уу "хар бор ажил" хийдэг хүнээс нь өөрөөр хэлбэл хамжлага албатаас нь салгах гэсэн ноцтой санааг буруу гэж хэлэх баримт үгүй билээ. Үүнээс гадна бидний ойлгож байгаагаар Чингис хааны цадигт:

"Хагучин дээл хагачин үжирбээс
Харгана бутанд торюу
Хари ширидээсээ хагацваас
Хан харц чацуу болюу

Шинэ дээл шинтрэн үжирбээс
Шоргоолжны бутанд торюу
Шири харидаасаа хагацваас
Шивэгчин хатан хоёр чацуу болюу" гэсэн нь харц

амжлагаасаа салвал хаан, харцын ялгаа үгүй болно гэсэн санаа илэрхий бөгөөд ерөнхий утга нь НТ- хх.орчуулгатай нийлж байна.

185. Эрэс хара гэдгийг хх-д 家人每家活(гэрийн хүмүүс, гэрийн ажилтан) гэж орчуулжээ. Бидний санавал эл үгийн утга нь хх. орчуулга хийгээд эн зэрэгцүүлэн холбосон шүлгийн санаанаас үзвэл гэр оронд зарагдаж, хар бор ажил хийдэг "эрцүүл, харцуул" буюу харц хүмүүс гэсэн утгатай үг бололтой. Өөрөөр хэлбэл эл хэллэгийг бид орчин цагийн монгол хэлний "харцуул, борцуул" гэдэгтэй бараг нийлэх утгатай болов уу гэж санаж байна. Гэхдээ эл хос холбоцын эн зэрэгцүүлсэн хоёр дахь мөрөнд "эмэ көбүд-эчэ ману" гэж хэлснээс үзвэл "**эрэс харадача**" гэсэн нь эр хүйстнийг заасан байлтай санагдана.

Харин Лу. "Алтан товчид" энэ хэллэгийг "**ирэн** хара-дача" гэж бичсэн нь маш сонирхолтой агаад НТ-нд "эрэс" гэж тэмдэглэгдсэн үг нь "**ирэн**" буюу "**ирэс**" гэсэн хэлбэртэй байсан юм биш байгаа гэсэн бодол төрүүлж байгаа юм. Учир нь дундад эртний монгол хэлд "**иргэн**" гэдэг үг бас "**ирэн**" гэсэн арай өөр хэлбэртэй утга нь ч явцуу хүрээний бүлэг хүмүүсийг нэрийдэж байсан байж болох юм. Үүнийг цаашид эрхбиш нягтлан судлах хэрэгтэй.

186. Чингис гэдгийг хх. орчуулгад 太祖帝號(Тайзу хааны цол) гэж тэмдэглэжээ. Чингис хэмээх нэрийг судлагчид үгийн гарлын үүднээс хийгээд утгын талаар олон үеийн турш тайлбарласаар ирсэн боловч энэ хэр хараахан нэгэн мөр саналтай болж чадаагүй байна. Бидний санахад юуны өмнө Персийн түүхч Рашид-Ад-дин (1952, Т.1-1, 167) уг үгийн утга санааг тун оновчтой тодорхойлсон юм. Тэрээр "Чин" гэдэг нь монгол хэлд "бөх бат" гэсэн утгатай агаад Чингис гэх нь олон тоог заасан учир перс хэлний Шахан шах (хаадын хаан) хэмээхтэй адилавтар агуулгатай гэж үзжээ. Мөн хятадын Гүр хааны нэр ч бас л "бат бэх" гэсэн утгатай гээд эл хоёр нэрийг уламжлалын холбоотой гэж үзсэн нь чухамдаа Чингис хэмээх цолыг хожмын судлагчид зөв тайлбарлах замыг зааж өгсөн гэж хэлж болно. Проф. Я.Шмидт (1892, 379) "Дорнод Монголын түүх" (Саган сэцэний "Эрдэнийн товч") гэдэг номондоо "Чинг" хэмээх үгийг "хатуу, хөдөлшгүй, бэх бат" гэсэн утгатай гэсэн нь чухамдаа уг үгийн язгуурыг "чилагу"-тай холбох санааг лавшруулж өгсөн билээ.

Дорно дахины сурвалж бичгийн хувьд шинжлэх ухаанд энэ хэр мэдэгдэж буй баримтаар хятадын Сүн улсын үеийн "Монгол татаарын

тухай бүрэн тэмдэглэл" (1221) гэдэг түүхэн зохиолд "Чингис хэмээгч нь тэнгэрээс заяасан гэсэн утгатай" гэж тодорхойлсон нь угтаа эл үгийн утга чанарыг домгийн сэтгэлгээний талаас авч үзсэнээрээ гойд сонирхолтой юм. Буриадын су билигт хүү Банзарын Дорж "Чингис гэдэг нэрийн гарлын тухай" (1846) гэсэн өгүүлэлдээ "Чингис" хэмээх нь утга санааны хувьд "тэнгэрийн хөвүүн" буюу хятад хэлний Хуан-ди гэдэгтэй ойролцоо гэж үзээд энэ цол нь эртний хүннү нарын **Чен-Ю** (Чаньюй?)-тэй уламжлалын холбоотой гэсэн маш сонирхолтой дүгнэлтийг хийсэн юм. Зарим түүхчдийн судалгаанд XIII зууны монголын эзэнт улс, хүннү хоёр төр ёсны залгамж холбоотой байсан гэдэг (Сүхбаатар, 1980, 57) дүгнэлтээс үзэхэд эртний монголчуудын хаадын өргөсөн нэр цол ч гарлын хувьд уламжлал нэгтэй байсан гэхэд эргэлзэх талгүй юм.

Нэрт монголч эрдэмтэн Б.Владимирцов, П.Пеллио, Хан рү лин зэрэг нэг хэсэг судлаачид Чингис хэмээх нэр нь түрэг хэлний Тенгиз (тэнгис, далай) гэдгээс гаралтай гэж үзээд агуу их буюу ертөнцийг эзлэгч их хаан гэсэн утгатай үг гэж тайлбарласан билээ. Алтан, Хучар, Сача бэхи тэргүүтэн ноёд зөвлөлдөж шаргачин тахиа жил (1189) Тэмүжинг хан цол өргөмжлөх үед монгол олон овог аймгаас Чингис хаан дөнгөж Мэргэд, Тайчууд, Жалайр тэргүүтэн цөөхөн овог аймгийг байлдан дагуулсан хийгээд зарим судалгчдын үзэж байгаагаар бүр хойно эсгий туургатан Хамаг монголчуудыг нэгтгэн улаан барс жил (1206) Онон мөрний эхэнд хуралдаж Чингис хаан цолыг өргөмжлүүлсэн байлаа ч гэсэн зөвхөн нүүдэлчин монголчуудын л хаан байсныг түүхийн баримт гэрчилнэ. Ийм учраас Чингис хааны энэхүү өргөсөн цолын утга учирыг зарим судлаачдын үзэж байгаагаар "Далай хаан" буюу ертөнцийг эзлэгч их хаан гэсэн утгаар төсөөлөхөд бас маргаантай, зөрчилтэй тал бий гэж тэмдэглэе.

Харин монголын түүхийн сурвалж бичгүүдэд Чингис хааны өргөсөн нэрийн учрыг ёгт утгаар тайлбарласан мэдээг эрт эдүгээгийн судлагчид домгийн чанартай зүйл хэмээгээд төдий л ойшоон нягтлан судалж үзсэнгүй өнөөг хүрчээ. Энэ нь юу гэвээс Лувсан данзаны "Алтан товч", "Хураангуй алтан товч", Саган сэцний "Эрдэнийн товч", "Чингис хааны цадиг", "Монголын Боржигон овгийн түүх", Лувсанлхүндэвийн "Билгийн зул" зэрэг түүхэн сурвалж бичгүүдэд өгүүлдэг адилавтар домгийг хэлж байгаа юм. Бид эл домгийн үйл явдлыг Лу. "Алтан товчид" байгаа эхээр сийрүүлье: "Чингис хаан төрөөд долоо хоносны хойно

далайн хойг **дотор харавтар шувуу гүр хар чулуун дээр наран зөвшөөрөхүй (зөвөөр) эргэж гурван өдөр донгодов**. Есүхэй баатар энэ нэгэн бэлэгт болов хэмээж тэр **хар чулуу**г хагалж үзвээс алтан тамга үзэгдээд тэнгэрт нисэж гарав. Мөн тэр чулуу урьд ёсоор бүтэж, тэр шувуу бас урьд ёсоор бас хагалбаас мөнгөн тамга үзэгдээд далайд оров. Бас тэр чулуу бүтэж тэр шувуу бас донгодвоос Есүхэй баатар өгүүлрүүн: -Энэ хөвүүн төрөөд энэ харавтар шувуу бэлэгт буй гэж бас тэр чулууг хагалж үзвээс дотор нь хасбуу (хаш) тамга ажгуу. Авч ирж ариунаа хүндэлж, хүж зул түлж суун атал тэр харавтар шувуу өрх дээр нь суугаад "Чингис, чингис" гэж донгодов. Тэр шувууны дуун гарсан шалтгаанаар Чингис хаан хэмээн нэрийдсэн нь тийм бөлгөө" гэжээ. Эл домгийг Чингис хааныг төрөхөд бус түүнийг хаан орноо суух үетэй зарим сурвалжид холбон өгүүлсэн нь бас бий. Жишээлбэл Ордосын түүхч лам Лувсанлхүндэвийн "Билгийн зул" хэмээх шастирт "Хорин найман насны шаргачин тахиа (1189) жил Хэрлэн мөрний арал дор хан орноо суув. Мөн өдөр гэрийн өмнө **их чулуун дээр урьд эс үзсэн нэгэн сайхан шувуу "Чингис" хэмээн гурвантаа дуугарснаар энэ нэрээр Чингис хаан хэмээгдэх буй"** гэжээ. Монголын түүхийн дээрх сурвалж бичгүүдэд Чингис гэдэг нэрийг нэгэн содон өнгийн шувуугаар хэлүүлсэн нь огт санамсаргүй зүйл биш юм. Монгол үлгэр домогт шувууг тэнгэрийн элч, төлөөлөгчийн дүрээр дүрслэн өгүүлсэн баримт цөөнгүй бий. Тэгвэл монголын түүхийн сурвалжуудад дээд тэнгэрээс заяат төрсөн хөвүүний нэрсийг хурмастын элч зарлага болсон шувуугаар "Чингис, Чингис" гэж хэлүүлсэн нь домогзүйн үүднээс авч үзвээс маш нарийн учир шалтгааны холбоотой ойлголт гэдэг нь тодорхой байна. Мөн домогт Чингис хэмээх нэрийг хүн төрөлхтний эрт балар цагаас эрхэмлэн дээдэлж ирсэн чулуутай холбож өгүүлсэн нь бас анхаарал татах сонин баримт юм.

Чулуу хүн төрөлхтний амьдралд олон мянган жилийн тэртээгээс хөдөлмөрийн багаж, дайснаас амь биеэ хамгаалах зэр зэмсэг болсоор ирсэн тул түүнийг тэнгэрээс бууж ирсэн ер бишийн зүйл гэж үздэг домог-үлгэрийн ойлголт дэлхийн олон үндэстэн угсаатанд буй болжээ. Тухайлбал Эвенкийн домог-үлгэрийн ойлголтоор тэнгэрээс газарруу нэвтэрсэн нүхээр ад шулмасыг дарахаар бурхан түүгээр халуун чулуу цутгаснаас янз бүрийн өнгө хэлбэртэй чулуу ертөнцийн энд тэнд буй болсон гэж үздэг бол Буриадын домогт: Тэнгэрийн хүү газрын ангал

нүхнээс асгарч буй усыг таглах гэж мөн удаа чулуу унагасны зөвхөн хамгийн сүүлийн ес дэх нь тэр нүхийг оной амсарыг нь бөглөсөн (Потанин, 1919, 15) хэмээн өгүүлдэг юм. Ийнхүү тэнгэрээс чулуу бууж ямар нэгэн аймшигт ангал нүхийг тагласан гэх энэ өгүүлэмж нь монгол бичгийн зохиолд ч уламжлан үлдсэн нь бий. "МНТ"-ны 80-р зүйлд "Тэмүжин Тайчуудаас дайжиж шугуйд шурган орж, зургаан хоног өл хоолгүй бүгж байгаад ахин гарч ирэх үед шугуйн амсарт хошлогын (гэрийн) төдий цагаан гүрү (чулуу) амсар бөглөн унажээ. Тэнгэр ятгаж байна уу? хэмээн буцаж бас гурав хонов" хэмээн мөн л тэнгэрийн соёрхолоор тэр гэрийн чинээ цагаан чулууг буулгаж Тэмүжинийг тайчуудад баригдахаас хамгаалуулах гэсэн санааг гаргажээ. Дээрх домгуудын аль алинд нь чулуу бол угаас газрын юм биш тэнгэрээс бууж ирсэн зүйл гэсэн санааг илэрхийлж байгаа билээ. Ийнхүү чулууг тэнгэрээс бууж ирсэн гэх үзэл буюу чулуу, тэнгэр хоёрыг холбож үзсэн ойлголт эртний энэтхэг европ хэлний баримтаас бас ажиглагддаг байна.

И.М.Дьяконов (1977, 13) "Эртний дэлхий дахины домог-үлгэрийн судлал" гэдэг номын удиртгал өгүүлэлдээ өвөг энэтхэг европ хэлний акмон нь орос камень (чулуу), самгардийн акман (тэнгэр), грекийн акмон (дөш) зэргийг харьцуулан үзсэн сонирхолтой баримт дурдсан байдгийг цухас тэмдэглэе. Үүнээс гадна Чингис гэдэг нэрийг чулуутай холбож тайлбарлах ноттой баримтыг монгол аман бичгийн зохиолын олдворуудаас иш татан өгүүлж болно.

"Алтан ордны голомтын их өчиг"-т:

"Чин төмөр эцэгт
Чингис чулуун эхт
Хатан төмөр эцэгт
Хайр чулуун эхт" гэж шүлэглэхдээ гал гаргагч хэт, цахиур хоёрыг "Чин төмөр", "Чингис чулуу", "Хатан төмөр", "Хайр чулуу" хоёроор адилтган дүрсэлсэн байна. Мөн эл санааг "гал тахих ёсон" хэмээх ерөөлд:

"Хайр чулуун эхт
Хатан төмөр эцэгт
Чин чулуун эхт
Чингил төмөр эцэгт" гэж шүлэглэсэн буй. Энэ хоёр бадаг шүлгийг харьцуулж үзвэл эхний шүлэгт төмрийг "галын эцэг", чулууг (цахиур) "галын эх" гэж үзсэн бол хоёр дахьд чулууг "галын эх",

төмрийг "галын эцэг" гэж байрыг сольж хэлснээс өөр онцын ялгаагүй юм. Харин хоёр дахь шүлгийн 3-р мөрийн "Чин, чингил" гэдэг хоёр үг *байраа сольсон байдалтай санагдана. Учир нь бидний бодлоор* "Чингил" хэмээх нь "Чингис" гэдгийн ганц тооны хэлбэр буюу мөн хад, чулуу гэсэн үг юм. Энэ нь дээр иш татсан шүлэг, ерөөлүүдэд "Чингис, Чингил" хэмээн адил утгын үүргээр сэлгэн өгүүлсэн баримт ч үүний нэг гэрч болно. Дашрамд тэмдэглэхэд Их эзэн хааны багын нэр Тэмүжин, өргөсөн цол "Чингис" хэмээх хоёр үг нь монголчуудын өөдлөн дэгжихийн бэлэг тэмдэг галыг үүтгэгч буюу түүний эцэг, эх болсон төмөр, чулуу хоёроор нэрлэсэн нь огт санамсаргүй хэрэг биш юм. Лу. "Алтан товчид" (1990, 12): "Татаарын Тэмүжин Үгээг авч ирсэн дор төрөв хэмээн Төмөр өлгийд өлгийдөж, Тэмүжин гэж нэрийдсэн ёс тийм бөлгөө" гэсэн байдаг. Энэ баримтаас үзэхэд Тэмүжин гэдэг нэр нь монгол бичгийн хэлний Тэмүр (төмөр) хэмээх үгтэй язгуур нэгтэй болох нь илэрхий. Ийм учраас багын нэр "Тэмүжин" буюу "Төмөр", өргөсөн цол "Чингис" буюу "Чулуу" (Чингил) гэсэн хоёр үг өөр хоорондоо бэлгэдэлийн нарийн учир холбогдолтой болохыг дээр өгүүлсэн баримтууд гэрчилж байна. Монгол сонгодог бичгийн хэлний чилагу, чинггис, чинггил гэдгийн аль алин нь "чи" язгууртай болох нь хэн бүхнээ илэрхий. Бидний ойлголтоор Чингис хэмээх цолын ганц тооны хэлбэр болох "Чингил-Чингэл" хэмээх үг эдүгээгийн олон монгол хэл аялгууны заримд "хадан хавцал, ганга, ирмэг" (Муниев, 1977, 652) гэсэн утгатай байгаа нь энэ хоёр үг зөвхөн дуудлагын хувьд төдийгүй агуулгын *холбоотой болохыг гэрчлэх баримт болж байна.* Мөн Тувагийн нутагт орших эртний сүг зураг бүхий Алды-Мозога гэдэг хадан хясаат уулын дундуур урсаж Енисей мөрөнд цутгадаг гол Чинге гэсэн нэртэй байгаа нь бас л анхаарууштай баримт юм. Үүнтэй холбогдох өөр нэгэн баримтыг өгүүлбэл: Синзяны монголчууд "Өндөр уулаас эх авч, хад чулуунд хавиргадан, хавцал тохойд мөргөн цохигдсон ширүүн урсгалтай усыг Чингис ус гэдэг" байна. Тэрчлэн Тэнгэр уулаас эх авсан "Чингис цагаан голын" тухай энэ нутгийн ардын дуунд:

"Чив чиг урсгалтай
Чингис цагаан ус..." хэмээн шүлэглэн дуулдаг ажээ.

Газарзүйн эрдэмтэн О.Сүхбаатар 1991 оны 7 сарын 20-нд радиогоор ярихдаа: "Монгол нутагт буй Чингис нэртэй газар голцуу уул, толгойг нэрийдсэн байдгийг дурдаад Говь-Алтай аймагт Их, бага

Чингис хэмээх хадтай толгой бий. Энэ хоёр толгойн хад нь зүгээр ч нэг хад биш эрднийн чухал чулуу гэдэг юм. Гэвч нутгийн ардууд геологич нарт энэ газрыг зааж хэлж өгдөггүй гэнэ" хэмээв. Дээр өгүүлсэн жишээ баримтууд нь "Чингил", "Чингис" гэсэн үгийн аль алин нь хад чулууны нэр болохыг гэрчилж байна. Тэрчлэн орчин үеийн монгол туулийн судлалын мэдээ сэлтээс үзэхэд "Чингил" хэмээх үг нь туулийн баатрын нэрээр: "Хан Чингл" (Владимирцов, 1926, 188), "Хаан Чингэл баатар" (Цолоо, 1982, 72), "Хан Чэнггэл тайжи" (Хайссиг, 1988, III, 552), "Догшин шар Чингэл" (Цэрэнсодном, 1987, 8) гэсэн хэлбэрээр тохиолдож байгаагаас үзэхэд эл үг хүлэг баатар эрсийн нэр цол болсоор ирсэн эртний уламжлалтайг харуулж байгаа юм.

Проф.Г.Рамстедт (1974, 135-153) хуучин Ханд Чин вангийн хошуунаас "Хаан Чингист богд" хэмээх жижгэвтэр тууль тэмдэглэж авчээ. Энэхүү Чингис хэмээх нэр нь бидний дээр өгүүлсэн Чингил гэдгийн нэгэн адилаар туулийн баатрын нэрээр гарч буй тун сонирхолтой агаад эл хоёр нэрийг холбож үзэх бас нэг шижим болж байгаа билээ. Ялангуяа Чингис гэдэг үг нь орчин цагийн монгол хэлний "Чингэлтэй" гэдэгтэй ойролцоо хэлбэрээр Чингист гэх нь "хадат, чулуут" гэдэгтэй адилавтар тэмдэг нэрийн маягаар гарч байгаа нь анхаарал татаж байна.

Монгол түүхэн сурвалж бичгүүдэд "Чингис" гэдэг нэрийг шувуу өгсөн мэт учир утгатай зүйл болов уу гэдгийг бид дээр өгүүлсэн билээ. Гэвч чухам хэрэгтээ Чингис гэдэг нэрийг "шувуу" өгсөн бус тухайн үед *монгол аймгуудын голлон шүтэж байсан бөөгийн шашины төлөөлөгч* өөрсдийгөө тэнгэрийн зарлигийг дамжуулагч гэж үздэг зайран бөө нар өгсөн байж болзошгүй юм. Учир нь Рашид-Ад-диний (1952, Т. 1, 167) зохиолд "Хөхөчү буюу монголчуудын нэрлэснээр Тэв тэнгэр (бөө) Чингис хаанд бурханы зарлиг ёсоор чиний нэр ийм байх ёстой юм гэж энэ нэрийг өгсөн" гэж тэмдэглэжээ. Энэ нь нэг алдартай удган бөө юм уу бөө мөргөлийн онгон сахиусын нэрээс уламжлалтай болов уу гэсэн сэтгэгдэл төрүүлж байгаа юм. Ийм учраас Банзарын Дорж (1846, 78) Монгол бөөгийн дуудлагын үгнээс ишлэн "Хажир Чингис тэнгэрийн" нэртэй холбож үзсэн саналыг эрхбиш анхаарах хэрэгтэй болно. Харин проф. П.Пеллио (1959, 302) "Хажир" хэмээх үгийг түрэг хэлний "хүчирхэг догшин" гэсэн утга бүхий "хадыр" гэдгээс гаралтай гэжээ. Монгол хэлний олон нутгийн аялгуунд үүнтэй ойролцоо утгатай "хахир хатуу" гэсэн үг

байхаас гадна бичгийн зохиолын дурсгалд "Хажир тас", "Хажир шувуу" гэж гарч байгаагаас үзвэл монгол, түрэг дундын чанартай үг болов уу гэж үзмээр санагдаж байгаа юм. О.Ковалевскийн (1846, 819) тольд Хажир шувууг оросоор "гриф птица" (тас шувуу) гэж оноосон байна. Үүнтэй холгдол бүхий бас нэг сонин ойлголт "Галын тахилын бичиг"-т байдгийг авч үзье. Акад. Ц.Дамдинсүрэнгийн (1959, 119) хэвлүүлсэн "Зуун билиг"-т орсон "Гал тахих ёсон" гэсэн бичигт:

"Цагаадай бөөгийн цахигсан
Чингэл удганы үлээгсэн
Торгон царайт
Тосон амьт
Өргөн царайт
Өөхөн амьт
Гал галайхан эх..." гэсэн байхад Х.Буянбатын (1985, 52) олж үзсэн галын ерөөлд:

"Цагаадай бөөгийн цахигсан
Чингин (Чингис) удганы үлээгсэн гал..." гэх зэргээр өгүүлжээ.

Гал тахилын эл шүлэгт бидний дээр холбон өгүүлсэн "Чингил (Чэнгил гэв)", "Чингис" хоёрыг адил утгаар хэрэглэсний дээр эл хоёр үгийг удганы нэр болгон өгүүлсэн нь маш сонин бөгөөд бидний бодлоор энэ нь Рашид-Ад-диний дээр өгүүлсэн мэдээтэй холбогдож байна. Чингис хааны ууган хүү Цагаадайн нэр ч "Галын тахилын ёсны" сударт өгүүлсэн монголын эртний алдарт Цагаадай бөөгийн нэр гуншинтай учир холбогдолтой байж тун магадгүй юм гэсэн сэтгэгдэл төрүүлж байна. Бидний өгүүлж буй "Чингил" хэмээх үг нь төвд сурвалж бичигт Чингис хааны нэрийг тэмдэглэдэгтэй адил "Чинггир" гэсэн хэлбэрээр монгол сонгодог бичгийн дурсгалд бас тохиолдож байгааг тэмдэглэе. Үүнийг бид төвд бичлэгийн нөлөө гэхээсээ юуны өмнө монгол хэлд "л, р" авиа сэлгэх үзэгдэлтэй холбоотой болов уу гэж санаж байна.

1308 онд Чойжи-Одсэрийн "Банзрагчийн төгсгөлийн" шүлэгт:

"Чингир хада мэтү омурхагчид-ун тэригүн-и
Чимэг-ийар багулжу инүхэн көл-дүр-и
Чинг-ийар тахигулугсан-у қойина алдар ину
Чинггис хаган хэмэн чамбутиб-дур чаб болжухуи" (Дамдинсүрэн, 1959, 153) гэжээ. Чойжи-Одсэр бандидагийн

Банзрагчийн төгсгөлийн шүлгийн энэхүү дөрвөн мөртөөс бид Чинггил хэмээх үг бас Чинггир гэсэн дуудлагатай байсныг олж мэдэхийн зэрэгцээ зохиогч Чингис хааны нэрийн гарлыг "Чинггир хад" буюу "Чинг" гэдэг үгийн үндэстэй холбож тайлбарласан нь аргагүй анхааруушгай сонин баримтын нэг болно. Харин зарим нутгийн аялгуунд энэхүү "чинггир буюу чингкир" хэмээх үгийг монгол сонгодог бичгийн хэлнээ "Чэнгкэр" (Цэнхэр) гэдэгтэй ойролцоогоор дууддаг бололтой юм. Жишээлбэл Эрдэмтэн Ринчиндоржийн (1988, 75) Ил Тарвагатайн монгол үлгэрт: Хан Харанхуйг төрөхөд тэнгэрийн савслага болж түүнийг хавчиж алах болсонд: "Чэнгкэр цагаан хад болж, үхэр хар-а чулуу болоод тэнгэртэй тэсэлцэж, газартай гадалцаж, үхэл үгүй мэнд гарчээ" хэмээн өгүүлдэг ажээ. Дээр өгүүлсэн баримтуудаас дүгнэж хэлвэл: "Монгол аман бичгийн зохиолд гарч буй Чингил-Чингин-Чингир-Чэнкэр-Чингис" хэмээх нь сонгодог бичгийн хэлний чилагу (чулуу) гэдэгтэй язгуур нэгтэй агаад маш эртний уламжлалтай эрхим цол гуншингийн нэр болох нь тодорхой байна.

Хэдэн жилийн өмнө Юань улсын түүх судлагч нэрт проф. Цай Ми Бо (1983, №2, 1-22) жа'ут хури гэдэг үгийн тухай нийтлүүлсэн өгүүлэлдээ: НТ-ны нангиад галигт тэмдэглэгдсэн гэдгийг "жа", "ча" гэсэн хоёр дуудлагатай хэмээгээд энэ нь чухамдаа Алтан улсын ар талаар нутаглаж байсан үндэстнүүдийг нэрийдсэн үг гэж үзсэн проф. Сау Сүэн жений нутаглаж байсан үндэстнүүдийг нэрийдсэн үг гэж үзсэн проф. Сау Сүэн Жений саналыг дэмжжээ. Чингээд "жа'ут" гэх нь нэг үндэстнийг нэр бус Алтан улсын бүрэлдэхүүнд орж байсан олон овог аймгийг нэгтгэсэн маягийн нэр томъёо учраас монгол хэлний олон тооны –уд гэдэг дагавар залгасан үг хэмээжээ. Ийм үндэслэл гаргаад зохиогч "жа'ут хури" гэдгийг "Хойд аймгуудын дарга захирагч" гэсэн утгатай гэж үзсэн байна. (Эл өгүүллийн утгыг проф. Хуан Зун жиан танилцуулж өгөв).

XYII зууны нэрт яруу найрагч Цогт хун тайж (1581-1637) эрэлхэг баатарлаг явдал гаргасан цэргийнхэнд олгодог "чүүхэр" гэдэг цолтой байжээ. Бид 1977 онд Цогт хун тайжийн домог мэдээ сурвалжилж Төв аймгийн Заамар сумын нутгаар явж настан хүмүүсээс асууж сурахад уг үгийн утгыг мэдэх хүн тааралдсангүй "Чүүхэр Цогт" зарим нь "Цуйхар Цогт л гэдэг байсан, бас номхон хун тайж ч гэдэг" байсан гэж хэлж байж билээ. Цогт хун тайжийн энэхүү "Чүүхэр" гэдэг цолыг НТ-ны "жа'ут

хури" гэдэгтэй холбоотой байж магадгүй гэж акад. Ц.Дамдинсүрэн таамаглаж байснаа надад ярихдаа: "Эртний монгол хэлний чүүхэр буюу цуйхар гэдэг үг нь шашин хүчтэй дэлгэрэх үед Далай Чүүхэр Вангийн хошууг Далай Чойнхор Вангийн хошуу гэж нэрлэсэний нэгэн адил энэ үгийн утга хувьссан бололтой байгаа юм гэж билээ" (211-р үгийн тайлбар үз) Үүнээс үзвэл Алтан улсаас Тэмүжинд өргөсөн Жаутхури гэдэг цол Чүүхэр, Цуйхар гэсэн дуудлагатай болсон байж болно.

187. Шилэгү гэдгийг хх-д二岁(хоёр наст) гэж орчуулжээ. Энэ нь сонгодог бичгийн хэлний **шилүлэнг** гэдэгтэй язгуур нэгтэй бөгөөд одоо үеийн төлгөн хонь, шүдлэн хонийг өгүүлсэн байна. Эл үг мөн НТ-ны 279, 280-р зүйлд "шүдлэн хонь, шүдлэн ирэг" гэсэн утгаар гарна.

188. Арам гэдгийг хх-д車底(тэрэгний тэвш) гэж орчуулжээ. Ийм учраас Бөххишиг, Алтан-Очир зэрэг судлагчид орчин цагийн монгол хэлээр "арал" гэж буулгасан үзэгдэнэ. үгийн гарлын хувьд "арам" хэмээх нь орчин цагийн монгол хэлний "арал-араг" гэх зэрэг үгстэй язгуур нэгтэй байж ч мэдэх юм. Эл шүлгийн эн зэрэгцүүлэн холбосон мөрд

Хонгогч хонидыг адуулж
Хот дүүргэе гэснээс үзвэл "арам" хэмээх үг нь хонь малын **хашаа хороо** гэсэн утгатай үг болов уу гэж бид таамаглаж байна. Эвенк хэлд "арама" гэж эргэн тойрон (хороотой ойролцоо) гэсэн утгатай байхад (Цинциус, 1975, 48), эртний түрэг хэлд морь малын хашааг "аран" (Наделяев, 1969, 51) гэдгээс үзвэл НТ-нд зөвхөн ганц удаа гарч буй "арам" хэмээх нь эртний өвөг алтай хэлнээс уламжилсан "хашаа, хороо" гэсэн үг байж болох юм.

189. Хонжийасун гэдгийг хх-д白腸(цагаан гэдэс) гэж орчуулжээ. Эдүгээгийн ярианы хэлд хошногыг "цагаан мах" гэж хэлдгийг хх.орчуулга санагдуулж байна. Элдэнтэй, Ардаажав (1986, 335) нар "манж хэлд **хонжосу** хэмээх нь бүдүүн гэдэсний доорд хэсэг хэмээгээд дагуур хэлд **хонжоос-чаган миаг** гэх нь цагаан мах (хошного) болно" гэжээ. Энэ мэт баримтаас үзэхэд "хонжийасун" гэдэг нь цагаан мах буюу хошного мөн болно.

Лу. "Алтан товчид" үүнийг бас "**цагаан мах**" гэж тэмдэглэжээ.

190. Тойасу гэдгийг хх-д整治(засах, цэгцлэх) гэж орчуулжээ. Бидний таамаглалд эл үг орчин цагийн монгол хэлний "асрах сувилах"

гэсэн утга бүхүй **тойвлох** гэдэгтэй язгуур нэгтэй байж магадгүй юм. НТ-нд өгүүлснээр "гэр тэргэн тойасу" гэсэн нь гэр тэргийг тэгтэрч хамгаалж арчилж явъя гэсэн утгатай байна. Энэ утга санааг хх.орчуулга ч тусгасан буй.

191. Гэргэн тутхари баса'аласухаи гэдгийг хх-人口行管攝(хүн амыг захиран хамаарах) гэж орчуулжээ. Гэргэн тутхари гэдэг үгийг өрнө дахины судлагчид хэрхэн ухаж, орчуулж ирсэн тухай Н.Ц.Мункуев (1984, 460) "Эртний монголчуудын тухай тэмдэглэл" гэсэн өгүүлэлдээ нэлээд дэлгэрэнгүй тэмдэглэжээ.

НТ-нд "гэргий" гэдэг үг 1, 3, 94, 96, 214-р зүйлд хэд хэдэн удаа гарах боловч **гэргэн** хэмээх үг харин эл 124-р зүйлд л ганц удаа гарч байна. Бидний ажигласнаар гэргэн гэх нь хүндэтгэсэн утгатай бус "эхнэр, хүүхэн, эмс" гэсэн агуулгатай ажээ. "Ачлалт номын" монгол орчуулгад "гэргэн тутхар" гэдэг эхнэр зарц гэсэн утгатай байдаг гэж Элдэнтэй, Ардаажав (1986, 337) нар тэмдэглэжээ. (Тутхар гэдэг үгийн тухай 39-р тайлбарт үзнэ үү).

Баса'аласукай гэдэг үгийн хувьд энэ нь орчин цагийн монгол хэлний "базаах, базаалгах" гэдэгтэй гарал нэг байж болох юм. Эл үг НТ-ны 213, 232-р зүйлд баса'алажу гэсэн хэлбэрээр бас гардаг юм. (503-р тайлбарыг үзнэ үү)

Бидний ойлголтоор "гэр дотора гэргэн тутхари баса'аласухаи" хэмээх нь "гэрийн дотор эмс зарц [нарыг] хамаарсугай" гэсэн утгатай ажээ.

Лу. "Алтан товчид" "Гэр дотор гэрийн дотхарыг бэхэлсүгэй" хэмээн орчин цагийн монгол хэлний ойролцоо утгатай үгээр тэмдэглэжээ.

192. Онглажитхун гэдгийг хх-д орчуулаагүй байна. Харин эл үгтэй утга, дуудлагын аль аль талаар ойролцоо **онгжалдажу** гэдгийг НТ-ны 208-р зүйлийн хх-被斷絶着 (таслагдаж, хуваагдаж) гэж орчуулжээ. Бидний таамаглалаар эл үг орчин цагийн монгол хэлний "ухах, сэндийлэх" гэсэн утгатай "онгилох" хэмээхтэй гарал нэгтэй байж магадгүй юм. Эн зэрэгцүүлэн холбосон энэ дөрвөн мөртийг бид

"Хүчирхийлэгсэдийн
Хүзүүг нь хянгардагтүн
Омгорхогсодын
Омрууг нь онгилогтүн" гэж хөрвүүлэв.

193. Холайин хо'очаг, ойирайин одор(л)а гэсэн зүйр үгийг судлагчид янз бүрээр ойлгож харилцан адилгүй орчуулсаар иржээ. Үүний гол шалтгаан нь "хо'очаг, одор(л)а" гэсэн хоёр үгийн утга тодорхой бус байгаад оршино. Эл хоёр үгийг хх-орчуулгад箭名(сумны нэр) гэж тэмдэглэжээ. Миний олж үзсэн НТ-ны хөрвүүлэг, орчуулгын дотроос Бөххишиг (1941, 82) авгай хх. орчуулгыг их л хянамгай үзсэн бололтой үүнийг "холын **хоб**, ойрын **годил**" гэж хөрвүүлжээ. Үнэндээ энэ нь хол, ойр тусгалтай сумны тусгай нэр гэдэг нь хх. орчуулга хийгээд уг зүйр үгийн утга санаанаас мэдэгдэж байгаа юм. Бидний бодоход НТ-ны "хо'очаг" гэдэг үг нь "хор" (сум) гэдэгтэй холбогдолтой байж мэдэх юм. Харин "одор(л)а" гэдгийн хувьд Бөххишигийн "годил" гэж буулгасныг оносон орчуулга болов уу гэж санаж байна.

Чухамдаа уг зүйр үгийн утга нь хол ойрын алба ажилд энэ мэт харавсан сум шиг хурдан хөдлөж түргэн залгуулж бай гэсэн учиртай ажээ. Энэ үүргийг хүлээсэн Архай Хасар, Тахай, Сүхэхэй, Чаурхан дөрөв бол Чингис хааны төлөөний итгэмжит элч, дуу баригч хүмүүс билээ. Ялангуяа Тахай, Сүхэхэй хоёр бол бүр Чингисийн эцэг Есүхэй баатрын элчээр явж байсан туршлагатай хүмүүс учир Чингис энэ тушаалд томилсон биз. Дээрэх дөрвөн хүнийг Чингис хаанд элч болж хол ойр явж байсан тухай НТ-ны 126, 127, 151, 177-р зүйлүүдэд өгүүлсэн буй.

"Нууц товчооны" эл зүйр үг нь нэлээд эрт цагийн хуучирсан хэллэг бололтой юм. Учир нь Лувсанданзан үүнийг "Холын хоноцог (хоног) ,ойрын отор (удирдах газарч) болтугай" гэсэн утгаар их л өөрөөр ухсан байна.

194. Нэмбэгэ гэдгийг хх-д盖 (нөмрөг) гэж орчуулжээ. Энэ нь сонгодог бичгийн хэлний "нэмнэгэ" гэдэг үгийн дунд орсон "н" авиа "б" авиа хоёр солигдсон хэлбэр болно. Орчин цагийн монгол хэлний "нэмнээ, нөмрөг" гэсэн үг.

195. Хэрисхэ гэдгийг хх-遮風 (салхины халхавч) гэж орчуулжээ. Эл үг орчин цагийн аялгуунд "хэрсэг" гэсэн дуудлагатай болсон байна. Үүнийг Я.Цэвэл (1966, 764) "Байшин барилгад янз болгож барьсан намхан хашаа, хайс" гэж тайлбарлажээ. Өвөр монгол 1976 онд хэвлэгдсэн "Монгол хятад тольд" "хэрэсхэ" гэдгийг хятадаар мөн хашаа гэж орчуулав. Энэ нь орчин цагийн монгол хэлний хэрэм гэдэгтэй үндэс нэгтэй ажээ.

196. Гэр жүк гэдгийг хх-家處 (гэр сууц) гэж орчуулжээ. Орчуулагч үүнийг "гэр орон" гэдэг шиг хоршоо үгийн утгаар ойлгожээ. НТ-нд "жүк" гэдэг үг 30 гаруй удаа гарахдаа орчин цагийн монгол хэлний "**зүг** чиг" гэсэн утгаар тохиолдож байна. Харин эл зүйлд гарч байгаа "гэр жүк" гэсэн холбоо үг нь "гэр зуур" "гэр хооронд" гэсэн утгатай шиг байна.

197. Тамтулутхун гэдгийг хх-д扯了您(урах, тастах) гэж орчуулжээ. Энэ нь сонгодог бичгийн хэлний "тамтулху" буюу "тамтуглаху" гэдгийн хоёрдугаар биеийн захирах тушаах төлвийн хэлбэр болно. (Шагж, 1937, 567)

198. Харин гэдгийг хх-д部(овог аймаг) гэж орчуулжээ. Үүнийг судлагчид гол төлөв харь буюу өөр овог аймаг гэсэн утгаар ухаж орчуулж тайлбарласан үзэгдэнэ. НТ-нд "(х) арбан хурбан **харин** нөкөчэжү" гэдэг бол "арван гурван харь [овгууд] нэгдэж" гэсэн утгатай ажээ. Эл үг бас НТ-ны 141, 262, 270, 275-р зүйлүүдэд харьтан буюу харь иргэн гэсэн утгаар гарч байна. Жич тэмдэглэхэд 262, 270, 275-р зүйлд гарч буй "харин" гэдгийг хх-д邦(улс орон, вант улс) гэж орчуулжээ.

199. Чингис хааны **арван гурван хүрээг** түүхч Сайшаал (1987, 207-209) "Чингис хааны товчоон" гэдэг доривтой бүтээлдээ: "Судрын чуулган", "Биеэр дайлсан тэмдэглэл" зэрэг монголын түүхийн сурвалж бичгээс үндэслэж тодорхойлсон нь:

1. Өэлүн хатны төрхөм Олхонууд аймаг болон ойр төрийнхөн
2. Чингис хаан хийгээд түүний хөвүүд
3. Хабул хааны ах Сэм Сачула түүний хөвүүд болон Аданхан, Түмэн түбэгэн, Хэрэйд, Горлос зэрэг
4. Сүйхэт чэрбийн хөвүүд болон түүний төрөл зэрэг
5. Архай Хасар хийгээд Жалайр овогтон
6. Жүржийн хөвүүн Сача бэхи болон түүний дүү Тайчу тэргүүтэн Жүрхин овогтон
7. Бартан баатрын дүү хутагт Мүнгүрийн хөвүүн Бүри бөх болон Хулан баатар, Их Чэрэн тэргүүтэн Хийуд ястан
8. Бартан баатрын их хүү Мэнгэт Хийун болон түүний хөвүүд хийгээд Чаншигуд, Баягуд овогтон
9. Бартан баатрын отгон хүү Даридай отчигин, Нэгүн тайж тэдний хөвүүд болон дөрвөн овогтноос бүрджээ.
10. Хотула хааны их хүү Жөчи түүний харъяат нар
11. Хотула хааны отгон хүү Алтан түүний харъяат нар

12. Тай баатар хийгээд Сүлдүс нар, Жэхэй Хонтахурын хөвүүн болон Сүхэхэн нар
13. Чинос овгийн Цагаан гуа болон Нэгүс овогтон зэрэг болно. Эдгээр нь Чингисийн 13 хүрээг бүрдүүлж байсан түүний гол хүч юм.

200. Чиносун кө'уди гэдгийг хх-地名的大王每行(газрын нэр, их вангуудыг) гэж орчуулжээ. **Далан тохо'од бучалхажу** гэдгийг хх-д 七十鍋每教浓着(далан тогоонуудад буцалгаж) гэж орчуулсан байна.

Чинос хэмээх нь чононоос үүсэлтэй гэдэг домогтой нэгэн монгол аймгийн нэр бололтой байдаг. Харин НТ-ны 207-р зүйлийн **Чинос** гэдгийг хх.орчуулгад 種名 (овгийн нэр) гэж тэмдэглэжээ.

Чинос овгийн Нэгүтэй Цагаан Уаг Сайшаал (1987, 209) "Чингис хааны товчоон" гэдэг зохиолдоо "Гэнтү чоно, өлөгчин чонын үр хойч" гэж тэмдэглэсэн байна. Ийм учраас бид **"Чиносун кө'уди"** гэх нь "Чинос [овгийн] хөвүүдийг" гэсэн утгатай болов уу гэж үзлээ.

Далан тохо'од бучалхажу гэдгийг хх-д "далан тогоонд буцалгаж, чанаж" гэсэн утгаар тодорхой орчуулсан учир энэ хачирхалтай хэллэгийг судлагчид яг энэ утгаар ойлгож орчуулсаар иржээ.

Гэтэл Рашид Ад-Диний (1952, 1-2, 88) "Судрын чуулганд" энэ хачирхалтай үйл явдлыг Жамухааг бус харин Чингис хаан урван дэрслэгч дайсан этгээдийг гал дээр далан тогоо тавьж буцалгах зарлиг болсон мэт өгүүлснээс үзэхэд чухам бодьтой явдал гэж үзэхэд баахан эргэлзээтэй санагдаж байгаа юм. Бидний санавал энэ нь НТ-нд хэдэнтээ гардаг "Далан Балжиуд, Далан-Нэмүргэс" гэдэг шиг "Далан Тогоод" юм уу "Далан Тохойд" гэсэн газрын нэрийг ямар нэгэн шалтгаанаар сүүлд гуйвуулсан байж магадгүй юм гэж үзээд миний бие эдүгээ НТ-ны газар орны нэрийг сонирхон судлаж байгаа өвгөн эрдэмтэн Хуацай Дугаржав гуайгаас эл учрыг асуусанд тэрээр 1988 оны 11-р сарын 14-нд надад бичсэн захидалдаа: "Таны хэлж байсан "Нууц товчооны" 129-р зүйлд байдаг "Чиносын хөвүүдийг далан тогоонд буцалгаж" гэх үгийн тухай би үгийн монгол үгийг хятад үсгээр галигчилж бичсэн дэвтрийг үзлээ. Гэхэд үүнээс өөрөөр хэлсэн зүйл үзэгдэх үгүй. Гагцхүү уг дэвтрийн "чиносын 赤那孫"гэх нэрийн хажуугийн хятад орчуулга нь "地名的"гэсэн байгаа гэхэд энэ "чинос" гэдэг бол газрын нэр биш, овгийн нэр болох нь тодорхой. Иймээс энэ нь ташаа болно. Харин "Далан тогоод"

гэхийн хажууд "газрын нэр" гэж бичих гээд байрыг нь буруу бичсэн байж магад гэхэд тус өгүүлбэр нь бүтэц муутай болох юм шиг. Одоо бидэнд олдож байгаа гол болох уг дэвтрээс монголчлон буулгахад өөрөөр хэлэхийн арга үгүй. Таны дурдсан шигээр "далан тогоод" гэгч нь олон хонхор газар байсан магадгүй гэдгийг үнэхээр судалж болох байна. Гэвч миний бие энэ талаар дурдах юм алга байгаа нь үнэхээр харамсалтай байна" гэж тэмдэглэсэн билээ.

НТ-нд өгүүлж буй энэ хачирхалтай хэллэгийн зөв, бурууг нотлох, үгүйсгэх аль алиных нь ноттой баримт бидэнд одоогоор олдоогүй учир хх.орчуулга хийгээд олон судлагчдын саналыг даган "Далан тогоод буцалгаж" гэж орчин цагийн монгол хэлээр хөрвүүлэхдээ "буцалгаж" гэх нь "буцаалгаж" гэсэн үгийн гуйвуулсан хэлбэр биш байгаа гэсэн асуулт тавив.

Судлагч Ж.Төмөрцэрэн /1995, 99-102/ "буцалгах" гэдэг үгийн утгыг "шоргоолж нүхнийхээ амсар дээр буцалж байна" гэх мэт хэллэг шиг эмх замбараагүй хөдөлгөөнийг заасан утгатай үг байж магадгүй гэсэн таамаглал дэвшүүлж "13 Хүрээний тулалдаанд Чонос овгийн тамлан тарчлаасныг Нууц товчоонд Чоносын хөвүүдийг далан тогоонд буцалга гэж тэмдэглэсэн бололтой. Түүнээс биш тогоонд хоол цай буцалган чанадгийн адил дайнд олзлогдсон хүмүүсийг чанасан мэтээр ойлгож хараахан болохгүй" гэж бичсэн байна.

201. Түсүргэ түсүржүхэн гэдгийг хх-斐倾 (ваар сав тонгойлгов) гэж орчуулжээ. Энэ нь сав суулганд ундаа хийж зоогийн ширээнд өрөх буюу айраг мэтийг сөгнөхийг хэлсэн бололтой юм. Учир нь НТ-ны 213, 232, 245, 278-р зүйлд түсүргэ гэдэг үг сөн буюу их сөн гэсэн утгатай байгаа билээ. Тэрчлэн Мин улсын үеийн "Лү лүн сай лүэ" гэдэг тольд 土俗兒(түсүр) гэдгийг мөн 傾 (тонгойлгох, хэлтийлгэх) гэж орчуулжээ. Эл үгийн гарлын талаархи бидний таамаглалыг 107-р тайлбараас үзнэ үү.

202. Ашихижухуи гэдгийг хх-打了(зодох, занчих) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **алхих** (зодох, занчих) гэдэгтэй нэг гаралтай ажээ. Шагжийн (1937, 40) тольд "ашгиху" гэдгийг занчих мэт хэмээн тайлбарласан байна. Эл үг НТ-ны 136, 245-р зүйлд "ашгиба, ашгиху" гэсэн хэлбэрээр мөн зодох, балбах гэсэн утгаар гарна. 132-р зүйлийн "ашхилалдужу" гэх нь мөн алхилалдаж гэсэн утгатай ажээ.

Саган Сэцэгний "Эрдэнийн товчид" "мэсээр **ашкин** даалгаж ядаад" гэж буй.

203. Күрү'эсэ гэдгийг хх-д 下馬處 (мориноос буух газар) гэж орчуулжээ. Уг үг гарлын хувьд орчин цагийн монгол хэлний дунд нь холбох, уях гэсэн утгатай **хэрээ** (сонгодог бичгийн **кэрүгэ**) гэдэгтэй гарал нэгтэй бололтой. Энэ нь бас НТ-ны 229, 245-р зүйлд морины уяа, сужиг, зэл гэсэн утгаар гарч байна. Харин эл зүйлийн хх-д 聚馬處 (морьд бөөгнөрөх газар) гэж орчуулжээ. Тэрчлэн "Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл", "Юань улсын судар" зэрэг түүхийн сурвалж бичгүүдэд "**кирүгэс**" гэдгийг ордны гадна морь уях газар, морь зэллэх газар, мориноос буух газар гэж хэлдэгтэй (Элдэнтэй, Ардаажав, 1986, 357) НТ-ны хх.орчуулга нийлж байна.

204. (Х)ойимасчу гэдгийг хх-д 護着 (өмгөөлөх, хамгаалж) гэж орчуулжээ. Монгол хэлд зарим тохиолдолд "р", "с" авиа сэлгэх ёс бий. Жишээлбэл "уймрах-уймсах" г.м. Үүнээс үзвэл энэ нь орчин цагийн монгол хэлний **өмөөрч** гэдэг үгтэй гарал нэгтэй байж болох юм.

205. Насуда абалдурун гэдгийг хх-如常相搏(үргэлж барилдах) гэж орчуулжээ. Насуда хэмээх нь насан туршид юм уу үргэлж, байнга гэсэн утгатай юм. **Абалдурун** гэх нь эдүгээгийн ойрдын аялгууны "абалдах" (барилдах), өвөр монголын Хорчин зэрэг аялгууны "авалцах" (барилдах, ноцолдох) гэдэгтэй гарал нэг болно.

XIY Зууны үеийн монгол Сулхарнайн туужид "Алтан натур дүүрэн тана сувд хийж өргүүлэгтүн. Түүний хойно мянган залуус сайд **абалдугчи бөхсийг** (барилдагч бөх нарыг) дагуулж..." хэмээн өгүүлсэн буй.

206. Мэр үдү'үи гэдгийг хх-д 傷未 (шархдаагүй, гэмтээгүй) гэж орчуулжээ. **Мэр** гэх нь орчин цагийн монгол хэлний **бэр**тэх гэдэг үгтэй үндэс нэгтэй ажээ. Учир нь монгол хэлний уруулын хэмжих гийгүүлэгч "б"- "м" авиа сэлгэх учир **бэртэх** гэхийг **мэртэх** гэж дуудаж болох бүрэн үндэстэй. НТ-ны 194-р зүйлд **бэрттэл** гэдэг үгийг хх-д "шархдах, гэмтэх" гэсэн утгатай үгээр орчуулжээ. Үүнээс үзвэл XIII зууны үед эл үг "мэрбэр" гэсэн маягийн хоёр дуудлагатай байсан бололтой юм.

Ингэхлээр НТ-нд өгүүлж буй **мэр үдү'үи** гэх нь "бэртээгүй, гэмтээгүй" гэсэн утгатай ажээ.

207. Онгин Чингсанг гэдгийг хх-人名(хүний нэр) гэж тэмдэглэжээ. **Онгин** хэмээх нь Алтан улсын Ван йэн Шианг (完顏襄丞相 1140-1202) буюу Баруун гарын түшмэдийн нэр цолны монгол дуудлага болно. Энэ түшмэдийн гавъяа зүтгэл, хэргэм зэргийн талаар "Хятадын түүхийн их

тольд" (1986, Ляо, Шиа, Жин, Юань улс) товч өгүүлсэн байна.

Чингсанг буюу Чэнг Шианг (丞相) гэдэг түшмэл хүний хэргэм зэргийг монголын зарим нутгийн аялгуунд (тухайлбал Харчинд) "шинсан-шинсаа" гэж дууддаг ажээ. Жишээ нь БНМАУ-ын Номын санд хадгалагдаж буй Юань улсын судрыг монгол хэлнээ орчуулсан эрдэмтэн Дандааг "Дандаа шинсан" гэж нэрлэдэг билээ.

208. Ханалха гэдгийг хх-д 機會(тохиол, завшаан) гэж оновчтой орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "ханамжтай, ханалттай" гэсэн үгстэй үндэс нэгтэй юм. Ханалха хэмээх нь НТ-ны 133-р зүйлд хоёр удаа гарахдаа "аятайхан далим, завшаан" гэсэн утгатай байна. Бид шүлгийн айзам хэмнэлийг хэвээр буулгахыг хичээж уг үгийг эдүгээчилсэнгүй.

209. Иктүнэжү гэдгийг хх-д орчуулаагүй байна. Эл үгийн гарал нь тодорхойгүй боловч НТ-нд "хөдлөх, гарч явах" гэсэн утгаар орсон гэж таамаглаж болохоор санагдана. Бидний бодоход эг үг одоо үеийн ярианы хэлд голчлон хэрэглэгддэг "үймэлдэх, хөлхөх" гэсэн утгатай "**ивтнэх игтнэх**" гэдэгтэй холбоотой бололтой. Тухайлбал Элдэнтэй, Ардаажав (1986, 364) нар "Хөлөнбуйр аймгийн шинэ баргын нутгийн аялгуунд буруушаагдан зэмлэгдсэнээс тэвдэн мэгдэх байдлыг" **игтүнэх** гэж хэлдэг гэж тэмдэглэсэн байна.

210. Хусуту шитү'эн, нара(с)ту шитү'эн гэдгийг хх-д 地名 (газрын нэр) гэж тэмдэглэжээ. Гэвч үүнийг зарим судлагчид эртний уламжлалт бөө мөргөлийн шүтлэгийн газар байсан байж магадгүй гэж үзжээ. (Пэрлээ, 1958, 5, Далай, 1959,).

211. Жа'ут хури гэдэг цолыг хх-д орчуулаагүй учир НТ-г судласан эрдэмтэд эл үгийг янз бүрээр таамагласаар иржээ.

Проф.Баяр, Элдэнтэй, Ардаажав зэрэг судлагчид "жа'ут" гэдгийг орчин цагийн монгол хэлний "зуут" гэсэн үг хэмээн таамаглаад "зуутын ноён" буюу "зуутын түшмэл"-ийг хэлсэн болов уу гэж үзжээ. Ингэж үзэхэд эргэлзмээр хэдэн шалтгаан байгаа юм.

1. Мин улсын үед НТ-г нангиад үсгээр галигласан, орчуулсан хүмүүс XIII зууны үеийн монгол цэргийн зохион байгуулалтын нэгж "зуут" гэдэг нэр томъёог мэдэхгүй байх учир үгүй билээ.
2. Алтан улсаас хайрласан эл цол нь Хэрэйдийн Тоорил ханы хүртсэн Ван цолоос онцын их зөрөө багатай байх учир бий. Тэгээд ч НТ-нд "Чингис хаанд үүнээс их нэр (цол) нэмэхийг

"**жаутау**" цол өгөхийг Алтан хан мэдтүгэй" гэж жүрчидийн Вангин чинсан хэлж байдаг. Энэхүү "жаутау" гэдгийг проф. В.Кливез Сүн улсын үеэс уламжлалтай "илбэн тохинуулагч комиссар" гэсэн утгатай үг гэж тайлбарласан юм. (213-р тайлбар үзнэ үү)

3. Уг цолыг Зүрчидийн Алтан улсаас олгосон тул эл үгийн гарал нь заавал монгол үг байх учиргүй болно. Алтан улсын түүх шастираас үзвэл өөрийн талд ашиг тустай үйлдэл үзүүлсэн буюу хүч хавсарсан этгээдийг элдэв цол хэргэмээр хөхүүлэн сайшаасан баримт олон үзэгдэж байна.
   Персийн түүхч Рашид Ад-диний (1952, т.1-2, 93) "Джаут Кури" гэдгийг хятадаар "Агуу ноён" (великий эмир) гэсэн утгатай гэж тэмдэглэсэн билээ.

Хятадын Юань улсын түүх судлагч нэрт проф. Цай Ми Био (1983-№-2, 1-22) жа'ут хури гэдэг үгийн тухай нийтлүүлсэн өгүүлэлдээ: НТ-ны нангиад галигт тэмдэглэсэн 札 гэдгийг "жа", "ча" гэсэн хоёр дуудлагатай хэмээгээд энэ нь чухамдаа Алтан улсын ар талаар нутаглаж байсан үндэстнүүдийг нэрийдсэн үг гэж үзсэн проф. Сау Сүэн Жений саналыг дэмжжээ. Чингээд "жа'ут" гэх нь нэг үндэстнийг нэрлэсэн нэр бус Алтан улсын бүрэлдэхүүнд орж байсан олон овог аймгийг нэгтгэсэн маягийн нэр томъёо учраас монгол хэлний олон тооны -уд гэдэг дагавар залгасан үг хэмээжээ. Ийм үндэслэл гаргаад зохиогч "Жа'ут хури" гэдгийг "Хойд аймгуудын дарга захирагч" гэсэн утгатай гэж үзсэн байна.

(Эл өгүүллийн утгыг проф. Хуан Зун Жиан танилцуулж өгөв)

XVII зууны үеийн яруу найрагч Цогт хун тайж (1581-1637) эрэлхэг баатарлаг явдал гаргасан цэргийн хүнд олгодог "чүүхэр" гэдэг цолтой байжээ. Бид 1977 онд Цогт хун тайжийн тухай домог мэдээ сурвалжилж Төв аймгийн Заамар сумийн нутгаар явж настан хүмүүсээс асууж сурахад уг үгийн утгыг мэдэх хүн тааралдсангүй "Чүүхэр Цогт" зарим нь "Цуйхар Цогт л гэдэг байсан, бас номхон Хун тайж ч гэдэг" байсан гэж хэлж байж билээ. Цогт хун тайжийн энэхүү "чүүхэр" гэдэг цолыг НТ-ны "жа'ут хури" гэдэгтэй холбоотой байж магадгүй гэж акад. Ц.Дамдинсүрэн таамаглаж байснаа надад бас ярьж байсан билээ. Цогт тайжийн "чүүхэр" буюу "чөөхүр" гэдэг цолыг шарын шашны лам нар гуйвуулан "Цоохор Цогт" гэж дуудаж байжээ. Энэ алдаатай ойлголтыг акад.

Б.Я.Владимирцов хүртэл "Халхын Цогт тайжийн хадны бичиг" гэдэг өгүүлэлдээ баримталсан тал бий. Харин "БНМАУ-ын түүхийн" дэд ботид (1968) "Мөн заримдаа цоохор Цогт гэсэн байдаг нь цоохор гэсэн үг биш, харин цөөхүр гэсэн цол бололтой" гэж зөвөөр тайлбарласан буй.

212. **Ван** гэдгийг хх.д 王 (хан, ван) гэж тэмдэглэжээ. Энэ нь хятад хэлнээс зээлдэн авсан хан, ван гэсэн утгатай үг болно.

213. **Жау тау** гэдгийг хх-д 官名分(ноёны хэргэм нэр) гэж тэмдэглэжээ. Судлагчид эл үгийн утгыг саяхан болтол нарийн тодорхойлж чадаагүй байлаа. Сүүлийн проф. В.Кливез (1982, 63) зэрэг эрдэмтэд уг үгийн гарлын талаар энэ нь "Сүн улсын үеэс Алтан улсад уламжлан ирсэн招討(чао тао) буюу илбэн тохинуулагч комиссар хэмээх цол хэргэмийн нэр" гэж тодорхойлов. Мөн үгийн түүхэн гарлыг Мансаан (1985, 131) өгүүлэхдээ: "Алтан улсын үед хил хязгаарын явдлыг хамаарахаар "жуу туу ши" хэмээх байгуулж урван тэрслэхийг дарангуйлах ба оруулж авах ажлыг хамаарч байлаа" гэсэн нь В.Кливезийн тодорхойлолттой нийцэж байна. Судлагчдын тодорхойлолтоос базаж хэлвэл "жау тау" буюу "жуу туу" хэмээх нь ноёлох гол улсаас харь орныг тохинуулан захирах төлөөний түшмэлийн хэргэм цол ажээ.

214. **Дөрэбчиту** гэдгийг хх-д 環子有的(дөртэй) гэж орчуулжээ. Энэ нь хүн малын хамар нүхлэж, дөрлөн зүүх цагираг маягийн зүйлийг хэлнэ. Олонхи судлагчид Татаарын нутаг дээрээс олдсон энэ хүүхдийг (Шигихутугийг) чих, хамартаа алтан ээмэг, дөрөвчтэй байжээ гэж үзсэн байна. Элдэнтэй, Ардаажав (1986, 371) нар эл үгийн тайлбар өгүүлэлдээ "Бүрэн бус байцаалтыг үндэслэвэл уг нутаг Баруун үзэмчинд бүхий энэ жил (1974) 83 настай Тогтунжав өвгөн багын үедээ хамартаа дөртэй байсан" гэдэг сонирхолтой мэдээг дурджээ.

Шигихутугийн өмссөн зүүсэн зүйлс хийгээд Өэлүн эхийн "Сайн хүний хөвүүн ажгуу. Язгуур сайт хүний ураг буй за" гэж хэлснээс үзвэл Татаарын нэг язгуурлаг хүний энхрий хүүхэд байсан болов уу гэдэг сэтгэгдэл төрнө.

215. **А'урух** гэдгийг хх-д 老小營(настан, нялхас, гэр бүл) гэж тайлбарлан орчуулжээ. Энэ нь одоогийн ар гэр буюу суурин, байран гэдэгтэй ойролцоо утгатай ажээ. Малчид отор, нүүдлээр явахдаа ачаа, бараа, хөрөнгө хогшлоо сахиулж настан, нялхасаа үлдээхийг "суурин суух", "сууринд суулгах" гэдэг билээ. Үүний нэгэн адил НТ-нд өгүүлж

буй "а'урух" бол аян дайнд хол ойр явахад ар талд үлдсэн суурин гэрийг өгүүлсэн байна. Уг үгийн гарлын талаар бид тодорхой мэдэхгүй боловч эртний түрэг хэлний "ачаа тээш, хөрөнгө зоорь" гэсэн утгатай **"агрух"** (Наделяев, 1969, 23) гэдэгтэй холбож судалбал сонирхолтой юм гэдгийг хожмын судлагчдад сануулах төдий тэмдэглэе.

Эртний монгол хэлний **ауруг** гэдэг үгийг акад. Ц.Дамдинсүрэн (1976, 15) одоогийн Хэнтий амйгийн Дэлгэрхаан сумын нутагт орших **Аврагын** рашаан гэдэг газрын нэртэй холбож, "Ауруг гэдэг үг хуучирсан учир монголын ярианы хэлэнд гуйвуулан агуу их гэсэн утгатай "аврага" гэдэг үг болж хувирсан банйа. Аваргын рашаан булгийн хойт дэнж дээрх туурийг 1969 онд археологич Х.Пэрлээ малтаж үзээд 13-р зууны үеийн хотын үлдэгдэл мөн гэж тогтоосон ба Чингисийн ауруг ордны үлдэгдэл мөн гэж үзсэн байна" хэмээн маш сонирхолтой санал дэвшүүлсэн билээ.

216. Түшижү гэдгийг хх-д 伸頸着 (хүзүүгээ сунгаж өгч) гэж орчуулжээ. Олонхи судлагчид хх. орчуулгыг баримтлан "хүзүүгээ сунгаж өгөв, хүзүүгээ гудуйж өгөв" гэх мэтээр өгүүлснийг бид бас даган баримтлав. Чухам эл үгийн гарлын хувьд гэвэл "биеэ **тушааж** өгөв, шилжүүлж өгөв" гэсэн утгатай байж тун магадгүй юм. Учир нь НТ-нд албан ажилд тохоох буюу тушаах гэдгийг яг үүнтэй адил үсгээр галигласан байдгийг анхаарах хэрэгтэй байгаа юм.

217. Бүтэ'эжү гэдгийг хх-д 完備着 (бүр мүсэн гүйцээж) гэж орчуулжээ. Энэ нь амьсгал авахуулахгүй бүтэж үхүүлэхийг хэлдэг байна. Эдүгээгийн Дорнод халхын аман ярианд хонь алахад "үхсэн үү?" гэхийн оронд "бүтэж үү?" гэж асуудаг.

218. (Х)эйилү 'эсү гэдгийг хх-д 離了呵(салбаас, зайлбаас) гэж оновчтой орчуулжээ. Энэ нь салж одох, цойлж гарах гэсэн утгаар одоо ч хэрэглэгдсээр буй юм. Тухайлбал Дарьгангын аман аялгуунд оро морь адуунаас цойлж гарч, зугтах, зулрахыг "морь ийлэх, морь ийлүүлэх" гэдэг юм. Тэрчлэн судлагчдын 13-р зууны үеэс уламжлан ирсэн гэж үздэг "Хоёр загалын тууж"-ид:

"**Ийлсэн** моринд уурга олон билээ
Эегүй хүмүүнд өстөн олон гэлээ" гэсэнд мөн л зугтах, цойлох гэсэн утгатай байгаа юм.

219. Митэрижү гэдгийг хх-д踢着(өшиглөж) гэж орчуулжээ. НТ-ны **өрэ инү митэрижү** гэдэг бол орчин үеийн "өрөвдөхөд **өр өшиглөх**"

гэдэг зүйр үгийн хэллэгтэй ойролцоо юм. **Митэрижү** хэмээх нь орчин цагийн монгол хэлний **нидрэх** гэдэг үгтэй гарвал нэгтэй бололтой. Угтаа эл үг нь "өшиглөх, тийрэх" гэсэн утгатай байжээ. Үүний нэг баримт нь эдүгээгийн дагуур хэлд "мидэрижү" хэмээх нь мөн өшиглөх, тийрэх гэсэн утгатай байна (Элдэнтэй, Ардаажав, 1986, 380).

220. Тоиджу гэдгийг хх-д 撥着(шилгээх, зайлуулах) гэж орчуулжээ. Якут хэлд "тойтот" хэмээх нь дээш өргөх, сөхөх (Пекарский, 1917, 2705) гэсэн утгатай байна. Энэ нь гарлын хувьд дундад эртний монгол хэлний "тойджу" гэдэгтэй холбоотой байж болох юм. Гэвч энэ мэт адил төстэй үзэгдлүүдийг монгол ,түрэг хэлний олон нутгийн аялгууны хэрэглэгдэхүүн зэргээр нягтлан шийдвэрлэх ёстой билээ. Ямар боловч НТ-нд өгүүлж буй "тойджу" гэх нь "таших, дэгээдэх, этэх" мэтийн бөхийн хөл мэхний нэр ажээ. Олонхи судлагчид "ташиж" гэж хөрвүүлснийг баримтлав.

221. Илүкэи гэдгийг хх-д下唇(доод уруул) гэж орчуулжээ. Энэ нь одоогийн хөмхий буюу доод уруул гэсэн үг болно. Зосотын аймгийн зарим газрын аман ярианд доод уруулыг "илиг" гэдэг хэмээн Элдэнтэй, Ардаажав (1986, 383) нар тэмдэглэсэн байна. Ойрд аялгуунд **имкэ** гэнэ (Цолоо, 1988, 489).

222. Жахас гэдгийг хх-д 鍎(зах заам) гэж орчуулжээ. Гэхдээ "хоёр **захас** ину солбин мэкэчилэн татаж" гэсэн нь арай дээлийн захыг хэлсэн биш бололтой. Харин хоёр захаас нь юм уу хоёр талаас нь хөл толгойг нь солбиулан мэхийлгэн татаж гэсэн утгаар хэлсэн байлтай юм. Ийм учраас бид Ц.Дамдинсүрэн, Дугаржав нар үүнийг "агдлан барьж, цээж бөгснөөс нь угзран татаж" хэмээн утгачлан орчуулахдаа эл **захас** гэдэг үгийн санааг зөв гаргасан гэж үзэж байна.

223. Арийаху гэдгийг хх-д猶豫(эргэлзэх, татгалзах) гэж орчуулжээ. Эл үг НТ-ны 169, 181-р зүйлд "арийал" гэсэн хэлбэрээр басгарна. Үүнийг бид гарлын хувьд орчин цагийн монгол хэлний "эрээлэх" (нэрэлхэх, цээрлэх) гэдэг үгтэй холбоотой байж магадгүй юм гэж таамаглаж байна.

224. Кэ'ус гэдгийг хх-横斷 (хөндлөнгөөр нь) гэж орчуулжээ. Эл үгийн утга төдий л тодорхой биш байгаа тул олонхи орчуулагч үүний утгыг огт гаргасангүй"чабчилалдужу" гэсэн дараах үгийн хх. орчуулгад共砍着(цуг цавчлалдаж)гэж тэмдэглэснийг баримтлан Жамуха нарын энэ

нэгэн үйлдлийг "азрага гүү **алж** андгайлан тангараглаж..." гэсэн утгаар орчуулсан байх юм. Бидний бодлоор эл хх. орчуулгын 共砍着" гэснийг алах гэж орчуулах нь арай таарамгүй юм. Үүний нөгөө талаар адуу мал алсан гэх ялангуяа азрага алсан гэх нь малчин монголчуудын ахуй амьдралын уламжлалт зан үйлд үл нийцэх хачирхалтай зүйл мөн. Ийм учраас эртний монголчуудын андгайлах зан үйлтэй холбон судлах нь зүйтэй бизээ. Бидний бодлоор **"ажирга гэ'үн кэ'үс чабчилалдужу андахалдужу"** гэсэн хэллэг бол азрага гүү сойж цавчлалдуулан сүр бадраах нэгэн өвөрмөц зан үйлийг өгүүлсэн байж магадгүй юм. Монгол ярианы хэлд гүү хээлтүүлэхийг "азрага гүү гишгэх" гэж хэлдэг шиг нэг өвөрмөц хэллэг байж болно.

225. Нангиад галигт 刊(кен) гэж тэмдэглэснийг Э.Хэниш (1948, 42) И.Рахевилз (1972, 61), Т.Дашцэдэн (1985, 73) зэрэг судлагчид "Кан, хан" гэсэн дуудлагаар буулгасан тул уг үг уул эхээсээ баахан холджээ.

Энэ нь одоогийн Өвөрмонголын Хөлөнбуйр аймгийн Эргүнэ зүүн, баруун хоёр хошууны нутгаар Их хянган даваанаас эх авч 270 орчим км газар урсаж Эргүнэ мөрөнд цутгах Гээн гол мөн болно. миний бие 1988 оны 7-р сард БНХАУ-ын Нийгмийн ШУА-ийн Цөөн тоот үндэстний Утга зохиолын хүрээлэнгээс хийлэгсэн "Алтай хэлтний бөө мөргөл хийгээд туульсын зохиол" гэсэн сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд оролцох завшаанаар Хайлаар хот очих үес Хөлөнбуйр аймгийн хойд талын зарим нутгаар аялан явах таатай боломж гарсан юм.

Энэ голыг XIII зууны үед "гэн" гэж дуудаг байсан бололтой. НТ-ны газар усны нэрийг судласан эрдэмтэн Х.Пэрлээ (1958, 7) үүнийг "Ган" гол гэж тэмдэглэсэн байна.

226. Х.Пэрлээгийн (1958, 10) олж тогтоосныг баримтлан эл газрын нэрийг сийрүүлэв.

227. Жилда болдажу гэдгийг хх-д 晚被做着(орой болчихлоо) гэж орчуулжээ. Эл үг бас НТ-ны 135, 159, 177, 196, 229, 240, 278-р зүйлд "орой, орой болох" гэсэн утгаар гарна.

Эл үг эдүгээгийн монгол хэлний зарим нутгийн аялгуу хийгээд төрөл хэлний дотор "орой болох" гэсэн утгаа хэвээр хадгалсаар байгааг Элдэнтэй, Ардаажав (1986, 297) нар баримт гаргахдаа Синзяны Бор талын монголчуудын нутгийн аялгуунд "жалда" хэмээх нь орой гэсэн утгатай бөгөөд дагуур хэлд "диалда" гэх нь орой, оройтох, удах,

хожимдох гэсэн утгатай гэж өгүүлжээ.

228. Энэ их тулалдаан болсон **Хүйтэн** гэдэг газрыг Х.Пэрлээ (1958, 8) Онон, Хэрлэн хоёр голын хооронд буй Хүйтэн гэдэг газар мөн бололтой гэжээ. Дугаржав (1984, 83) мөн эл газрыг одоогийн БНМАУ-ын нутагт орших Хүйтэн хэрэмтийн нуур буюу Өвөр монголын Шинэ барга баруун хошууны хойд захад буй Хүйтэн савт гэдэг газрын аль нэгэн байж магадгүй гэж таамаглав.

229. Ихурихалдун жибши' эрүлчэн гэдгийг хх-相梯共整搠 (харилцан бие биенээ сорилцон) гэж орчуулжээ. Бидний таамаглалд "ихурихалдун" гэдэг нь орчин цагийн монгол хэлний ёвиралдан (түлхэлдэн) хэмээх үгтэй гарал нэг байж магадгүй юм. Чингээд бид эл хэллэгийг "түлхэлдэн сөргөлцөн" гэж утгачлан буулгав. Судлагчид эдүгээгийн монгол хэлээр хөрвүүлэхдээ янз бүрээр ухааран буулгасан үзэгдэнэ. Тухайлбал Бөххишиг "зууралдан цавчилдан" гэсэн байхад Ц.Дамдинсүрэн "шахалцан, давших, ухрах" гэх зэргээр буулгажээ.

Эл хэллэгийн хоёр дахь үгтэй ойролцоо "жибшийэрүн" гэсэн үг НТ-ны 202-р зүйлд эмхэлж, цэгцлэж гэсэн утгаар гарч байна.

230. Жада гэдгийг хх-能致風雨的事 (салхи бороо оруулах бэрх ажилд чадвартай) гэж тайлбарлах маягаар орчуулжээ.

Энд өгүүлэх **Жада** буюу зад барих ёс нь монгол хийгээд төв азийн бусад улс үндэстний аман бичгийн зохиол, бөө мөргөлийн ёсонд эртнээс нааш ул мөрөө үлдээж ирсэн задын чулууны домогтой холбогдолтой ойлголт юм. Хүн төрлөхтөн чулууг хөдөлмөрийн багаж зэвсэг болгосон цагаас түүний үүргийг хэт дэвэргэн үнэлж ид шидтэй зүйл мэтээр үлгэр домог болгон өгүүлж ирсэн зүйлийн нэг сонирхолтой сэдэв нь энэхүү задын чулуу бол.

Зөвлөлтийн нэрт түрэгч эрдэмтэн акад. С.Е.Малов (1947, 151-160) "Өрнөд хятад дахь түрэгчүүдийн бөөгийн "Яда" чулуу" хэмээх өгүүлэлдээ задын чулууны тухай түрэг хэлтэн ард түмний аман зохиолын зүйлээс олон сонирхолтой жишээ гарган өгүүлсний дээр бичгийн баримтын хувьд бүр YII зууны үеийн сирийн түүх бичигт тэмдэглэгдсэн байдгийг өгүүлжээ.

Монгол домог - үлгэрийн ойлголтоор бол Элстийн Тогоон гэгч удган тэнгэрээс чулуу буулган ирж задын чулуу буй болсон гэж үздэг ажээ. Дөрвөд, Урианхайчуудын ойлголтоор задын чулууг өндөр уулын оройд юм уу аль эсвэл могойн толгой, ангир шувуу гөрөөсний биед

оршдог маш ховор зүйл гэж төсөөлдөг байна (Потанин, 1883, 189)

Хунг Сигэм (Иринжин?, 1978,1,126) "Зад" гэдэг өгүүлэлдээ үүнийг үхэр малын элэг цөсөнд хааяа байдаг гяванг мөн гэж үзжээ.

НТ-ны эл зүйлд Буйраг хан, Хутуга хоёрын барьсан зад нь урван өөрсөн дээр нь буухад "тэнгэрт эс таалагдав бид" хэмээн бутарцгаасан гэх нь задын чулуу нь тэнгэрээс бууж ирсэн зүйл учраас тэнгэрийн зоргоор болдог зүйл гэсэн санаа бас гарч байна. Тэрчлэн "Хан Харанхуй", "Жангар" зэрэг монгол угсаатны эртний уламжлалт туульд задын чулуу, зад барих үйлдлийг өгүүлсэн байхаас үзвэл маш эртний уламжлалтай зүйл болохыг гэрчилж байна.

Монгол түүхэн сурвалж бичигдэх задын чулууны ойлголтын талаар Хүрэлшаа (1989, 64-76) «Илбэт чулуу Задыг өгүүлэх нь» гэдэг өгүүлэлдээ нэлээд дэлгэрэнгүй өгүүлсэн буй.

231. Шисгис гэдгийг хх-д 地名(газрын нэр) гэж тэмдэглэжээ. Үүнийг Х.Пэрлээ (1958, 10) Соён уулаас эх авсан Шишгид гол мөн гэж үзсэн байна. НТ-ны 239-р зүйлд гарч буй **Шигшид** хэмээхийг Ц.Дамдинсүрэн багш мөн Шишгид гол гэж тэмдэглэжээ.

232. Турастан гэдгийг 方牌有的每 (дөрвөлжин хаалтнуудтай) гэж орчуулжээ. Энэ нь эртний монгол, түрэг хэлний хаалт, бамбай, бэхлэлт, цайз гэсэн утгатай үг ажээ. "Мукаддимат Ал-Адаб" тольд "тура" хэмээх үг "хуяг, бамбай, хаалт" (Поппе, 1938, 407) гэсэн утгатай байхад мөн үг эртний түрэг хэлд "гэр орны бэхлэлт цайз" (Наделяев, 1969, 587) гэсэн агуулгатай байна. Ийм учраас НТ-ны "турастан" гэдгийг бид Тайчуудын ар талд үлдээсэн хамгаалалт бэхлэлтийн цэргийг өгүүлсэн нь лавтай гэж үзнэ. Элдэнтэй, Ардаажав нарч эл үгийн тайлбар өгүүлэлдээ мөн яг ийм санал дэвшүүлсэн билээ.

233. Шитүлдүжү гэдгийг хх-д相抗着(харилцан эсэргүүцэлдэж) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний харилцан холбогдох, уялдах гэсэн утгатай "шүтэлдэх, шүтэлцээ" гэдэг үгтэй үндэс нэгтэй юм. Шитүлдүжү гэх нь НТ-ны 144, 145, 145-р зүйлд хэд хэдэн удаа дараалан гарахын хамт 205, 214-р зүйлд шитү'э'элдүжү гэсэн хэлбэрээр бас тохиолдож байна. Эл үгийн хэдэн удаа гарч буй утга санааг нягтлан үзвээс "сөргөлцөх, сэрэмжлэх, харилцан шүтэлцэх" гэсэн агуулгатай юм. Ийм учраас бид тухайн хэллэгт илэрхийлж буй утга санааг дагалдуулан уг үгийг жаахан ялгамжаатай хөрвүүлэв.

234. Сужийасу бан шилүртэжү гэдгийг 项颈脉自的行被傷着

(шилэн хүзүүний судсаа шархтуулж) гэж орчуулжээ. Энэхүү эртний монгол хэлний **сужийасу** хэмээх нь эдүгээгийн зарим нутгийн аялгуунд "сужаа-сужиг" гэсэн маягийн дуудлагаар уламжлан үлдсэн болоltой юм. Тухайлбал Үзэмчиний аман яриand "сужаа" хэмээх нь хүзүүний дээрэх булчин буюу далны булчинг өгүүлж (Элдэнтэй, Ардаажав, 1986, 407) байхад Дариганга аялгуунд "сужаа" гэвэл гүдгэр овгор газар, "сужиг" гэвэл уяа зэл гэсэн утгатай үг болно. Үүнээс үзвэл Чингис хаан энэ тулалдаанд хүзүүний сужаа махаа шархдуулсаныг өгүүлсэн ажээ. Зарим судлагчид хх. орчуулгад хүзүүний судал гэж буулгасныг баримтлан "хүзүүний судлаа шархдуулав " ялангуяа "гүрээний судлаа шархдуулав" гэсэн нь үнэн байдалд хараахан нийцэхгүй болно. Харин Бөххишиг (1941, 102) "Чингис хаан хүзүүгээ шархдаж" гэж хөрвүүлсэн нь ерөнхийдөө зөв юм. Мөн Алтан-Очир (1942, 72), Мансаан (1985, 124) "сужийасу", "хүзүүний сужаа" гэж хөрвүүлсэн нь яавч "гүрээний судал" гэж ойлгоогүй болоltой байна.

235. Төриткэ'эсү гэдгийг хх-教止呵(зогсоолгох) гэж орчуулжээ. Эл үг нь зогсоох, хориглох саатуулах гэсэн утгатай юм. Чухамдаа сонгодог бичгийн хэлний "түдэкү-түридэкү" азнах саатах гэдэгтэй сурвалж нэгтэй болоltой. Мөн НТ-ны 197-р зүйлд "хориглох, саатуулах" гэсэн утгаар гарч байна.

236. Амдуригдарун гэдгийг хх-д 被慌忙時 (мэгдүүлэхэд, тэвдүүлэхэд) гэж орчуулжээ. Уг үг гарлын хувьд орчин цагийн монгол хэлний "андуу, эндүү" гэсэн үгтэй үүсэл нэгтэй байж болох санааг Элдэнтэй, Ардаажав (1986, 408) нар эл үгийн тайлбар өгүүлэлдээ гаргажээ. Өөрөөр хэлбэл "амдурин" гэх нь сонгодог бичгийн зарим дурсгалд "сандарч, тэвдэх" гэсэн утгатай байдаг байна. Тухайлбал "Алтангэрэл" хэмээх судрын 25-р бүлэгт "уснаас ангижирсан тэд амдурин нааш, цааш гүйж..." гэх нь "уснаас салж тэд **сандран** нааш цааш гүйж" гэсэн утгатай юм.

237. Хагчу гэдгийг хх-д乾着(хатаж ширгэж) гэж орчуулжээ. Эл үг орчин цагийн монгол хэлний "хагсах, агших, эгших" гэсэн үгстэй язгуур нэгтэй болоltой. "Монгол үгсийн язгуурын толь"-д **хахага** хэмээхийг "цус гарч байх шарх зэргийг галаар бүлэгнүүлэх, зогсоохыг..." өгүүлдгийг тэмдэглэсэн буй (Сэцэнцогт, 1988, 896).

238. Итүрэжү гэдгийг хх-趕到着(завдан хүрч, амжиж хүрч) гэж орчуулжээ. Энэ нь сонгодог бичгийн хэлний "үтэрикү" гэдэгтэй утга болоод дуудлагын аль аль талаар ойролцоо юм. Жишээлбэл "Би наян

насандаа **үтэрижү**" гэх нь "Би наян насандаа **ойртож**", "Урт нь гурван алд **үтэрэм** буй" гэх нь "Урт нь гурван алд **шахам** буй " гэсэн утгатай (Сэцэнцогт, 1988, 299). Үүнээс үзвэл уг үгийн үндэс **итүр** хэмээх нь орчин цагийн монгол хэлний "үтэр" (түргэн) гэдэгтэй мөн гарлын холбоотой байж болох юм.

239. Нидүн хара гэдгийг хх-д 眼黑 (нүд хар) гэж яг үгчлэн орчуулжээ. Проф. В.Кливез англи орчуулгын товч тайлбартаа: "without winking the eye" (нүдээ цурам хийлгүй) хэмээн оновчтой тэмдэглэсэн байна. Монгол ярианы хэлд "**хар нүдээ** хуу татангаа", "Хар нүдээ хамхилгүй" гэх зэргийн хэвшмэл хэллэг байдгийг бид мэднэ. Үүнээс үндэслэн НТ-ны эл хэллэгийг бид "хар нүдээ [цавчилгүй]" гэх буюу маш анхаарал сэрэмжтэй, "хар нүдээ [хамхилгүй] " гэх буюу унтах нойр үгүй хичээж явлаа гэсэн утгатай үг гэж ухаарч байна..

240. Сэнтэлбэ гэдгийг хх-開豁了 (уужруулах, амарлиулах) гэж орчуулжээ. Бидний ажиглалтаар эл үг нь орчин цагийн монгол хэлний "сэнхрэх-тэнхрэх" гэдэгтэй язгуур нэгтэй бололтой. Монгол хэлд "т"-"с" авиа сэлгэх үзэгдэл ч уг үгийн хувьсалд нөлөөтэй байж болох юм. Гэвч энэ мэт адил төстэй үзэгдлийг хэл шинжээч эрдэмтэд нягтлах буй заа.

241. Жарбийал гэдгийг «Нууц товчоо»-ны 81-р зүйлд гардаг "бугу" буюу "гав" гэдэгтэй нэгэн адилаар хх-д 枷(дөнгө) гэж утгачлан орчуулжээ. Монгол шүлгийн эн зэрэгцүүлэх хууль ёсоор бодвол "жарбийал мод" гэх нь эл шүлгийн хоёр дугаар мөрийн "хүнд мод" гэдэгтэй ойролцоо утгатай үг байх учиртай билээ. Бидний санаваас энэ нь эртний түрэг хэлний "бөх бат, хатуу" гэсэн утгатай жарц (Наделяев, 1969, 243) гэдэг үгтэй үүсэл нэгтэй бололтой. Энэ нь түрэг монгол хэлний дундын чанартай буюу өвөг алтай хэлний хуучин уламжлалт үг байж болно. Ийм ч учраас Мин улсын үед эл үгийн утга тодорхойгүй байснаас НТ-ны хх. үгний орчуулагч "дөнгө" хэмээн утгачлан буулгасан бололтой.

242. Жэблэхү гэдгийг хх-戰的 (дайн байлдааны) гэж оновчтой орчуулжээ. Уг үгийн үндэс нь "зэв-зэвлэх-зэвсэглэх" гэдэгтэй үүсэл нэгтэй бөгөөд зэв хоромсого агсах юм уу дайн тулаанд унадаг морийг өгүүлсэн байна.

243. Ничүгүд ба'арин гэдгийг хх-д 種(овог) гэж тэмдэглэжээ. Эл үгийг зарим судлагчид орчин цагийн монгол хэлний "нүцгэн" хэмээхийн олон тооны хэлбэр гэж үзээд "нүцгэн баарин" гэж одоогийн

аялгуунд хөрвүүлсэн нь эргэлзээтэй санагдана. Элдэнтэй, Ардаажав (1986, 424) Өвөр монголын өнөөгийн Баарин хошуунд **ничүгүд** овог буй гэж тэмдэглэснээс үзвэл хх. орчуулгын овог гэж тэмдэглэсэн нь зүйтэй байна.

244. Дэрэ абун үхүсү гэдгийг хх-墊背要死我 "Дэр аван үхье" гэсэн эл хэллэг бас НТ-ны 154-р зүйлд "күмүн тутум ханчун-дур-ийан китуган ханчулажу **дэрэ абун үкүйэ** кэмэлдүжү" гэж гарч байна. Энэ нь эртний монголчуудад том язгууртан хүн буюу цэргийн их жанжин эрхтэн зэргийг нас нөгчихөд шадар зарц хүнийг нь дэрлүүлж оршуулдаг хуучин заншлаас уламжилсан үг ажээ. Ийнхүү дэр болгон хамт оршуулах хүнийг зовоолгүй хороодог байснаас

"Амьд хүний гэрч болохоор
Үхсэн хүний дэр бол" гэсэн зүйр үг гарсан бололтой.

Энэхүү "Дэр аван үхье" гэдэг хэллэгийн тухай тусгай өгүүлэлийг Ш.Гаадамба (1976, 166) бичсэн байна.

245. Сона гэдгийг хх-д 新(шинэ) гэж орчуулжээ. Эл үгийг проф. П.Пеллио, С.Козин, И.Рахевилз, Т.Дашцэдэн зэрэг олонхи судлагчид **сонин** гэсэн маягаар галиглаж иржээ. Харин Элдэнтэй, Оюундалай, Баяр, Иринжин нарын эрдэмтэд **сона** хэмээн залруулан галигласан нь уг үгийн зөвөөр ойлгоход түлхэц болж байгаа юм. Гэсэн ч эл үгийн утга агуулгын хувьд судлагчид одоо болтол санал нэгдээгүй байгаа билээ. Тухайлбал проф. Баяр хх. орчуулгыг баримтлан "шинэ" гэж буулгасан байхад Иринжин авгай "гуна үрээ (?)" байж магадгүй гэж таамаглажээ.

Бидний бодлоор эл үг орчин цагийн монгол хэлний сонор-**сорг**ог гэдэгтэй язгуур нэгтэй бөгөөд **эмнэг, хангал** гэсэн утгатай үг шиг байна. Үүнийг батлах баримт гэвэл "**сонор**" гэх нь шинэ, шинэхэн гэсэн утгатай байгаа нь НТ-ны хх. орчуулгатай утга нийлж байхын дээр "соногос" хэмээх нь унага, даага мэт бага залуу морь малыг хэлдэг байна. (Пекарский, 1917, 2279). Үүнээс үзэхэд эртний монгол хэлний **сона** гэдэг үг нь уналага эдлэгээнд сургаагүй эмнэг, догшин даага шүдлэн мэтийг заасан үг бололтой. Ийм учраас бид акад. Ц.Дамдинсүрэнгийн "эмнэг үрээ даага сургах мэт..." гэж хөрвүүлснийг зүйтэй гэж үзэв.

Солонгос хэлд "ач, зээ" гэсэн утгатай үгийг **соно**(孫)гэдэг хятад

ханзаас зээлдсэн ажээ. Уг үгийн гарлыг "Нууц товчооны" **сона** гэдэгтэй харьцуулан судалбал бас сонин юм.

246. Мекери'үлтэкүн гэдгийг хх-д 斬了 (алах, цавчих) гэж орчуулжээ. Эл үг бас НТ-ны 199, 200, 227, 257, 276, 278-р зүйлд мөн "алах, хөнөөх, үгүй хийх" гэсэн утгатай байна. Бидний таамаглалаар уг үгийн язгуур нь орчин цагийн монгол хэлний мөхөөх гэдэгтэй үүсэл нэг байж болох юм.

247. Хашин гэдгийг хх-д 地名(газрын нэр) гэж тэмдэглэжээ. Уг үгийн гарлыг Мансаан (1985, 158), Элдэнтэй, Ардаажав (1986, 434), Иринжин (1987, 122) нарын судлагчид хятад хэлний 河西(хэ ши) буюу "мөрний баруун тал" гэсэн үгнээс гаралтай гэж тайлбарласан байна. Чухамдаа энэ нь Хатан голын баруун этгээдээр нутаглах тэр үеийн Тангадын орныг өгүүлсэн ажээ. Эл нэр НТ-ны 177, 249, 250-р зүйлд бас гарна.

248. Иргэ орха гэдгийг хх-д 百姓人烟(айл гэр) гэж орчуулжээ. Энэ нь НТ-ны 162, 163, 177, 197, 272-р зүйлд "иргэ орха" юм уу "иргэн орха" гэсэн холбоо үгийн маягаар арваад удаа гарч байна. Уг үг мөн Турфаны цуглуулгын монгол бичгийн дурсгал хийгээд "Арван буянт номын цагаан түүх" зэрэг XIY зууны үеийн бичгийн дурсгалд "иргэн орган" (ард иргэн) гэсэн хэлбэрээр гардаг юм.

"Иргэ **орха**" буюу "иргэн **орган**" гэдгийн "орха-орган" хэмээх нь орчин цагийн монгол хэлний "ураг" (сонгодог бичгийн **уруг**) гэдэг үгтэй гарал нэгтэй бололтой байна. Ийм учраас эл үгийг Бөххишиг (1941, 113) орчин цагийн монгол хэлээр "уруг" гэдэг үгээр хөрвүүлжээ. Гэвч эл үгийн гарлыг судлагчид харилцан адилгүй ухаж, тайлбарласаар байгаа билээ. Жишээлбэл Мансаан (1985, 158) өөр овог аймгаас орж ирсэн хүмүүсийг хэлнэ гэсэн байхад, Элдэнтэй, Ардаажав (1986, 435) нар овог төрлийн нэгэн салааг заасан тусгай нэр томъёоны чанартай үг гэж үзжээ.

249. Далан нэмүргэс гэдгийг хх-地名(газрын нэр) гэж тэмдэглэв. Х.Пэрлээ (1958, 9) эл газрыг 119-р уртраг, 47-р өргөрөгт орших Халхын голын нэгэн цутгал болох **Нөмрөгийн** голын сав газрыг хэлж байна гэж тогтоосон байна.

250. Нөкөр күмүнэ гэдгийг хх-д 被敵 (дайсан хүмүүнд) гэж оновчтой орчуулжээ. Орчин цагийн монгол хэлний "нөхөр" хэмээх үг нь хэлхээ холбоотой болох буюу нөхцөх-нөхөрлөх гэсэн үгнээс гарчээ. Ийм учраас эртний хэлд "нөхөр" хэмээх нь хань нөхрөөс гадна

нөхцөлдөх, учралдах гэсэн утгаар дайсан этгээдийг бас хэлдэг байсан ажээ (Сэцэнцогт, 1988, 582-рт үзнэ үү).

251. Улжүй шилүгэлжид гэдгийг хх-д 地名 (газрын нэр) гэж тэмдэглэжээ. Х.Пэрлээ эл газрын тухай "П.Кафаров, НТ-ны орос орчуулгын тайлбарт Яр нуур буюу Номин гэж бичжээ. Энэ газар Хэрлэнд ойр 111-р уртраг, 48-р өргөрөгт байх бололтой" гэсэн байна.

252. Иэкэ эйэ гэдгийг хх-д 大商量(их зөвлөл) гэж орчуулжээ. Энэ нь чухал хэрэг явдлыг зөлэлдэн зөвлөдөг шадар хүмүүсийн холбоог өгүүлсэн байна.

253. Чи'үн түр үлижү гэдгийг хх-д 車轄行比着(тэрэгний цүүнд чацуулж) гэж орчуулжээ. Эртний монгол хэлний **чи'үн** гэх нь монгол бичгийн хэлний **чү** буюу тэрэгний тэнхлэгийг дугуйнд бэхлэсэн чагтыг хэлнэ. Ийм учраас хх. орчуулгад тэрэгний тэнхлэг, цүүнд чацуулж гэх нь уг хэллэгийн утгыг ерөнхийдөө зөв гаргасан байна.

Үлижү хэмээх нь эдүгээгийн ярианы хэлний **улих** (илүү гарах) гэдэгтэй холбоотой бөгөөд НТ-нд чацуулах, зэрэгцүүлэх гэсэн утгаар оржээ.

254. Э'эрэкүн гэдгийг хх-д 要攻(дайрах, дайран орох) гэж орчуулжээ. Энэ нь гарлын хувьд орчин цагийн монгол хэлний хориглох, сахих, саатуулах гэсэн утгатай "ээрэх, ээрүүлдэх" гэдэг үгтэй үндэс нэгтэй байж болох юм. Эл үг НТ-ны 230-р зүйлд **э'эрэн** гэсэн хэлбэртэй, сахиж хамгаалах гэсэн утгаар гарч байна. Гэхдээ дайрах, довтлох гэсэн утгаар бидний энэ өгүүлж буй 154-р зүйлээс гадна 247, 248-р зүйлд бас гарч байгааг тэмдэглэе.

255. Өтөг гэдгийг хх-д 進酒(архи оруулах) гэж орчуулжээ. Эл үг бас Нт-ны 275-р зүйлд мөн архи, сархад гэсэн утгаар гарахын хамт 187, 189, 219-р зүйлд "өтөклэ'үлжү" (идээ шүүс зооглуулж) гэсэн хэлбэрээр гарч байна.

Чингис хааны зарлигт эе (зөвлөлгөө) дуусч архи оруулж уусны хойно Бэлгүтэй, Дааритай хоёрыг ортугай хэмээн өгүүлснээс үзвэл татаарчуудыг хэрхэх тухай хэлэлцсэн зөвлөлгөөний нууцыг тэр хоёр өтөг (архи) зооглож ам халснаас задруулсан бололтой юм.

256. Бүксэн гэдгийг хх-д 有來(байх, байсан) гэж орчуулжээ. Энэ нь "байсан, агсан" хэмээх дутмаг үйл үгийн эм хүйс заах хэлбэр бололтой юм. (Элдэнтэй, Ардаажав, 1986, 452)

257. Үжэ'эсү гэдгийг хх-д 見呵(уулзах, учрах) гэж орчуулжээ.

Эл үг нь НТ-нд орчин цагийн монгол хэлний "үзэх, харах" гэсэн утгаар голчлон орохын хамт дээрэх хх. орчуулгад тэмдэглэсэнчлэн "уулзах, учрах, золгох" гэсэн утгаар бас гарч байна. Эдүгээгийн өөрлөгч зарим аялгуунд "үжэх" гэх нь "харах, үзэх" гэдгээс гадна мөн уулзах, эргэх тойрох гэсэн утгатай ойролцоо үзэгдэл болно.

258. О'орчаг гэдгийг хх-д 劫贼(дээрэм, хулгай) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний бөөгнөрөх, хэсэг бүлгээр нэгдэх гэсэн утга бүхий **оорцог-оорцоглох** (Цэвэл, 1966, 419) гэсэн үгийн хуучин хэлбэр болно. "Оюун түлхүүр" хэмээх сургаалын шүлэгт:

"Өнөр хүмүүн эвгүй болбоос
Өнчин хүний элэг болох
Олон хүмүүн эвгүй болбоос
Оорцог хүний идэш болох" гэсэн нь цөөн, бүлэг, хэсэг хэмээх утгатай байна. Чухамдаа эл үгийн утга нь НТ-нд өгүүлснээс үзвэл цөөн бүлгээр дэрслэгч этгээдийг хэлсэн ажээ. Үүнийг гэрчлэх бас нэг баримт гэвэл НТ-ны 200-р зүйлд Жамухагийн тухай "Улсаа автваас мөн таван нөхөдтэй **оорцог** болж Танлу (тагна) дээр гарч ..." гэх зэргээр өгүүлснийг харьцуулан үзэж болно.

259. Көрүрэ гэдгийг хх-д 窥伺 (далдаас ажих, гэтэх) гэж орчуулжээ. Уг үгийн гарлыг Элдэнтэй, Ардаажав (1986, 456) нар уйгар, түрэг хэлний **гөр-көр-күр** буюу үзэх, харах гэсэн үгтэй холбож тайлбарласан нь зүйтэй бололтой байна. Эртний хүмүүс ан авлахад голцуу далдаас хэтэж, мярааж гөрөөлөх учир **гөрөө-гөрөөс** хэмээх үгс ч үүнтэй учир холбогдолтой байж болох юм.

260. Үлүг таг гэдгийг хх-д 地名(газрын нэр) гэж тэмдэглэжээ. Энэ нь "Их уул" гэсэн утгатай түрэг гаралтай үг болно. Эл газрыг Х.Пэрлээ (1958, 5) одоо Булаг уул гэдэг болжээ гэж тэмдэглэсэн байна.

261. Согог гэдгийг хх-水名 (усны нэр) гэж тэмдэглэжээ. Согуг буюу Согог гэх нь эртний түрэг хэлний "согух" буюу "хүйтэн" гэсэн үг (Наделяев, 1969, 507) учраас энэ нь "Хүйтэн ус" гэсэн утгатай нэр бололтой юм. Х.Пэрлээ эл газрыг 90-р уртраг, 47-р өргөрөг. XYIII-XIX зууны үед Дайчин улсын цэргийн найман өртөөг Ховд хотоос **Согуг усу** хүртэл байгуулж байжээ. Одоо " Согог ус" гэдэг гэж тэмдэглэжээ. (Х.Пэрлээ, 1958, 5)

262. Байитараг бэлчирэ гэдгийг хх-д 地名(газрын нэр) гэж тэмдэглэжээ. Бидний саналаар энэ нь "бай тариг" буюу "баян тариа"

гэсэн түрэг гаралтай үг болно. (Наделяев, 1969, 79, 537). Түрэг хэлний "тариг" гэдэг үгийн "р" гийгүүлэгчийн арын "и" авиа нь өмнөх "а" авиатайгаа ижилсэж монгол хэлд "Байтараг" буюу "Байдараг" гэсэн дуудлагатай болжээ. Улмаар уг үгийн гарлыг "тараг" гэдэг үгтэй холбож тайлбарласан сонин домог яриа ардын дунд дэлгэрсэн ч буй. Үүний жишээ болгож эл домгийн нэгэн хувилбарын товч үйл явдлыг танилцуулъя. Халх Өөлдийн дайны үед одоогийн Байдарагийн голын сав нутагт их тулаан болж, олон хүний амь үрэгдэж голын ус улаанаар урсаж байж гэнэ. Нутгийнхан энэ бузрыг арилгахаар цусны улааныг цагаан идээ л дарж чадна гэлцэж нэг хүн ээдэж, гашилдаггүйгээр нь тараг хийе гэсэнд бүгд зөвшөөрчээ. Ингээд айл бүхэн таргаа хурааж хэлцсэн өдөр болмогц голын усанд таргаа хийцгээсэнд гол цагаанаар урсчээ. Ингээд **Баян таргийн** гол гэж нэрлэсэн гэнэ. Энэ голын цутгадаг нуурын усч өвөл хөлдөхдөө цав цагаан болдгийн учир тэр гэнэ. Тийм учир Цагаан нуур гэж нэрлэх болсон гэх зэргээр домоглодог байна (Сампилдэндэв, 1984, 199).

Бэлчир гэдгийг эл зүйлд газрын нэр гэж үзээд орчуулаагүй боловч 177-р зүйлд "Эдэр Алтайг" нь газрын нэр гэж тэмдэглээд "бэлчир" хэмээхийг нь хх-д 川 (гол хөндий) гэж орчуулжээ. Мөн **жубур** гэдгийг хх-д үүнтэй адил "гол хөндий" гэсэн утгаар орчуулсныг бид 58-р тайлбарт дурдсан билээ.

Орчин цагийн монгол хэлд **бэлчир** хэмээх нь ус голын уулзвар юм уу их замын уулзвар зэрэг бэл нам доор газрыг хэлдэг байна. Жишээлбэл Орхон Сэлэнгийн бэлчир г.м. (Цэвэл, 1966, 122; Сэцэнцогт, 1988, 705).

263. Байдал гэдгийг хх-д 立處(байр зогсоол) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "байр, буйр" гэсэн үгтэй язгуур нэгтэй бөгөөд буйр, ором, зогсоол гэсэн утгатай байна (Элдэнтэй, Ардаажав, 1986, 463).

264. Хан хан аху гэдгийг хх-д 皇帝皇帝存的(Хаан хаан байх буюу) гэж орчуулжээ. Энэ нь "Хан Хан байна уу" гэх буюу анхаарч байна уу гэсэн утгаар өөрийн хэлэх гэсэн үгийг сонордуулсан үг болно.

265. Хайируганa гэдгийг хх-д 白翎雀兒(хайргуучай буюу нялх бялзуухай) гэж орчуулжээ. Хайргана болбоос өглөө эртлэн жиргэдэг бялзуухайн төрлийн шувуу юм. "Чингис хааны эр хоёр загалын туужид":

"**Хайргана** шувуу

Хадан дээр суун жиргэв
Хан эзний хайран хоёр загал
Хагацан газарлав гэж жиргэв" хэмээн өгүүлдэг билээ.

Мөн "Хоёр загалын туужид":

"**Богшрого** шувуу босон жиргэв
Богд эзний хайран хоёр загал
Салан газарлав гэж жиргэв" хэмээн **хайргана, богшрого** хоёрын хөдөлгөөний байдлыг НТ-нд өгүүлсэнтэй ойролцоогоор дүрсэлсэн нь сонирхолтой юм.

Эдүгээгийн буриад хэлд эвэрт болжмор болоод цахлай шувууг **хайргана** гэдэг байна. (Черемисов, 1973, 534). Харин эдүгээгийн халх аялгуунд энэ нь **Хайргацай** гэсэн дуудлагатай болжээ. Үүнийг Я.Цэвэл (1966, 645) "богшрогоноос томхон, ар улаавтархан, өвчүү цагаавтархан ихэд жирэгдэг нэг зүйл бялзуухай" гэжээ. Мөн эл шувууны хэлбэр галбирын талаар Жигмиддорж (1986, 1455) нарын найруулсан "Амьтны *зураг толиос*" танилцаж болно.

266. Ажираху гэдгийг хх-д 散的(тарах, саринах) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлээр салах, ангижрах гэсэн утгатай юм. Монгол сонгодог бичгийн шашны ном сударт "сайн-бар ажирагсан-сайн-бар одугсан" гэсэн хэллэг олонтаа тохиолддог. Энэ нь бурханы сайн мөрөөр одсон, арилсан гэсэн утгатай ажээ. Жишээлбэл Чойжи-Од-сэрын бичсэн "Банзрагчийн" монгол орчуулгын төгсгөлийн шүлэгт:

"**Сайибар** одугсан бурхан-у номлагсан
Сакийан-у дегедү ене банчарагш- а ном-и ..."

гэх зэргээр өгүүлсэн буй. Я.Цэвэлийн (1966, 25) тольд *орчин цагийн* монгол хэлний **ажрах** гэдэг үгийг "ирэх, одох, орших, нөгцөхийн хүндэтгэл" гэж тайлбарласан байна.

267. Билду'ур гэдгийг хх-告天雀兒 (дуут болжмор буюу нялх бялзуухай) гэж орчуулжээ. Болжмор, богшоргын төрлийн энэ бяцхан шувуу нь нэг газар тогтвортой бараг байдаггүй байнга нэгээс нөгөөд үсчин одож агаарт нисэн жиргэж явах тул "ажираху билду'ур" (ангижрах болжмор) гэж дүрслэн өгүүлсэн болоолтой юм. Элдэнтэй, Ардаажав (1986, 464) нар үүнийг дагуур хэлд "биелдүр" гэж хэлдэг гэж тэмдэглэжээ.

268. Улкинчинкүн гэдгийг хх-д 讒譖 (хорон үг, гүтэглэг үг) гэж

орчуулжээ. Эл үгийн утгыг орчин цагийн монгол хэлээр Ц.Дамдинсүрэн (1976, 108), Мансаан (1985,148) нар оновчтой хөрвүүлсэн болоолтой байна. Бидний санавал "үлкин чинкүн" гэх нь эдүгээгийн дуудлагаар **олхин чинхэн** гэх буюу ховлон хатгах, ховлон хочлох гэсэн утгатай ажээ. Эл үгийн гарал түүхэн хувьслын талаар бас Элдэнтэй, Ардаажав (1986, 465-466) нар нэлээд нарийн тайлбарласан байна. Тухайлбал: "Чинкүн" буюу "жинкүн" гэдгийн утгыг "Цагаан түүх", "Эрднийн товч" зэрэг түүхэн зохиолд гарч буй жишээгээр баримт болгон үүнийг "хов үг, гүжирлэл, гутаах, муутгах, гүжирдэх, гөрдөх" гэсэн агуулгатай гэж тодорхойлжээ.

Дашрамд тэмдэглэхэд: Жамухагийн зусар зуйрган үгийг шүүмжилсэн Убчигдай Гүрин (хүрэн?) баатрын нэрийн талаар Рашид Ад-дин (1952, т.1-2, 113) "**Убчиртай** гэж энэ оронд ургадаг улаан жимсийг хэлэх бөгөөд энгэсгийн оронд эмэгтэйчүүд нүүрэндээ түрхнэ. Гүрэн баатрыг төрлөхийн улаан царайтай учир энэ жимстэй адилтган нэрлэжээ" гэж тэмдэглэсэн байна.

269. Түлэшилэн гэдгийг хх-做燒飯 (*өргөл шатаалга хийх*) гэж тайлбарлан орчуулжээ. Энэ нь тахилга, тайлга хийхэд галд түлш болгон өөх, тос, архи, мах тэргүүтнийг өргөхийг хэлнэ. НТ-ны эл зүйлд Чингис өөрсдийгөө галд өргөсөн түлш мэт дайсны аманд хаяж орхиод одсон Ван хан нарын хүний мөсгүй чанарыг урнаар зүйрлэн хэлсэн ажээ.

270. Эдэр Алтай-йин бэлчир гэдгийг хх-地名的谷口(газрын нэр, хоолойн ам) гэж орчуулжээ. Харин 177-р зүйлийн хх. орчуулгад бэлчир гэдгийг 川口 (гол хөндий) гэсэн буй. (262-р тайлбарыг үзнэ үү).

Х.Пэрлээ (1958, 4) Эдэр Алтайг одоогийн Архангай аймгийн Чулуут голын солгой этгээдэд орших Идэр, Алтайт голыг мөн гэж үзсэн байна.

271. Со'ор тур гэдгийг хх-д 引闕裏 (далимд завдаанд) гэж орчуулжээ. Энэ нь НТ-ны хх.орчуулгад тэмдэглэсэнчлэн "хооронд, завсар чөлөө, далимд" гэсэн утгатай юм. Эл үг бас 172, 208-р зүйлд мөн "завсар чөлөөнд" гэсэн утгаар гарч байна. Чухам үгийн гарлын хувьд гэвэл эдүгээгийн монгол хэлний "хооронд" гэдэг үгийн нэгдүгээр үеийн урт эгшиг үүсэх явцын эхэн үеийн байдлыг хадгалсан гэлтэй юм.

Монгол хэлний зарим аялгуунд тухайлбал буриадад "х" "с" авиа сэлгэх тул дундад эртний монгол хэлд "хо'ор" (хооронд) гэхийг "со'ор"

гэж хэлэх үндэстэй билээ. Эрдэмтэн Ш.Гаадамба (1990, 336).

Орчин цагийн буриад аялгууны жишээнээс үндэслэн х~с авиа сэлгэх үзэгдэл байдгийг санууллсан авч «Нууц товчооны» галиглагчийг шүүмжилж "Со'ор" гэж ташааран хэлж өгсөн буюу сонсогч алдаатай тэмдэглэсэн болов уу гэж таамагласан байна.

272. Өндүт гэдгийг хх-д 高處(өндөрт гарах, өөд явах) гэж орчуулжээ. Эл үгийн чухам утга нь өөд болох, тэнгэрт халих (нас нөгчих) гэсэн утгатай юм. Одоогийн ярианы хэлд нас барах гэхийг цээрлэх утгаар "өөд болох" гэж хэлдэгтэй ойролцоо хэллэг болно.

273. Ха'учитба гэдгийг хх-舊了 (хуучрав) гэж үгчлэн орчуулжээ. Уг үгийн илэрхийлэх утга нь өтлөх, хөгшрөх гэсэн агуулгатай ажээ. Энэ нь эл шүлгийн эн зэрэгцүүлэх холбосон түрүүчийн бадгийн

Өтлөв би бэр эдүгээ
Өтлөж намайг

Өндөрт гарваас гэж шүлэглэснээс үзэхэд тодорхой байна. Эдүгээгийн ярианы хэлд "хуучин хүй" гэх нь мөн настай хүн, их юм үзэж өнгөрөөсөн хүн гэсэн утгатай билээ.

274. Халдут гэдгийг хх-д 崖每 (аса, хад) гэж орчуулжээ. Эл үгийн чухам илэрхийлж буй санаа нь бидний 263-р тайлбарт өгүүлсэнчлэн өндөрт гарах, өөд болох гэдгийн нэг адил нас эцэслэх гэсэн утгатай юм. Өөрөөр хэлбэл монгол бичиг зохиолд "Ханат гэрээс холдож, хадан гэрт ойртов" гэдэгтэй адилавтар хэллэг болно.

Хэрэв **халдут** хэмээх нь **халдун** гэдгийн олон тооны хэлбэр болбоос НТ-ны 5-р зүйлд эхлэн гардаг "Бурхан халдун" гэдэг газрын нэрийн "Бурхан хад" юм уу "Бурхан аса" гэсэн утгатай үг гэж төсөөлөх боломж гарч ирж байна. Харин Ш.Гаадамба (1990, 336-37) «Нууц товчоог» орчуулагч хийгээд Лувсанданзан хоёрыг аль алины нь алдсан гэж үзээд уг үгийг хүүр оршуулах газрын нэр гэж таамагласантай бид санал нийлэхгүй байна.

275. Шитү гэдгийг хх-д 舣 (мэт, шиг, адил) гэж орчуулжээ. Эл үг бас НТ-ны 255-р зүйлд мөн "мэт, шиг" гэсэн утгаар гарч байна.

276. Шүдүртэ'эсү гэдгийг хх-д被挑唆(хатгагдах, өдөөгдөх) гэж орчуулжээ. Энэ нь шүдээр хатгах, хазах, шудрах гэсэн утгатай үг бололтой.

277. Адарта'асу гэдгийг хх-д орчуулаагүй байна. Бидний санахад энэ нь монгол шүлгийн эн зэрэгцүүлэлтийн ёсоор дээрэх

бадгийн "шүдүртэ'эсү" буюу "шудартваас" (шударваас) гэдэгтэй эрх биш адилавтар утгатай байх учиртай билээ. Үүнээс үндэслэн бид эл үгийг орчин цагийн монгол хэлний "хадрах" гэдэг үгийн эхний "х" авиа гээгдсэн хэлбэр байж магадгүй гэж таамаглаж байна. Учир нь олон монгол хэл аялгуунд үгийн эхний "х" авиа гээгдэх, хадгалагдах байдал харилцан адилгүй явж ирснийг одоо үеийн нутгийн аялгууны зарим үгс гэрчилнэ. Жишээлбэл халхын аялгууны "харвин" (цоройны өөх) гэдгийг ойрдын аялгуунд "арвин" гэдэг байна. Үүний бичгийн баримт гэвэл: "Убаши Хун тайжийн туужид"

"Артай цагаан **арвинд** нь
Арван хар савраа хүргэж
Будмал улаан хацарт нь
Буянт сайхан сахлаа хүргэж" гэх зэргээр шүлэглэсэн буй.

278. Ала'уна гэдгийг хх-д 門後行(үүдний ард) гэж орчуулжээ. Эл үгийн гарлыг сүүлийн үед Элдэнтэй, Оюундалай, Ардаажав, Сэцэнцогт зэрэг судлагчид түрэг хэлний **алай** буюу гал гэдэг үгтэй холбож тайлбарласан байна. Гэхдээ бидний бодлоор хх. орчуулга эл үгийн ерөнхий утгыг зөв гаргасан тул үүд босгоны ар тал юм уу **алхаж** орох газрыг өгүүлсэн байж болох юм. Эл үг бас НТ-ны 214-р зүйлд "исэрийин **ала'уна** үжү'үрэ са'ужу" гэх нь одоогийн ойлголтоор "Орны **үүдэн** талд сууж" гэсэн утгатай юм. Түүнээс гадна ала'уна гэдэг нь НТ-ны 165-р зүйлд орчин цагийн монгол хэлний "үүдэн хоймор" гэдэг эсрэг утгат холбоо үгийн харьцаагаар гарч буйг бас анхаарах нь зүйтэй биз.

279. Жэжэ'эр үндүрүн кэрүдэ бэркэ элэтдэ гэдгийг хх-д地名, 山名的陰行, 地名(газрын нэр, уулын нэр [түүний] хярыг, газрын нэр) гэж тэмдэглэжээ. Эл газрыг Х.Пэрлээ (1958, 8) Хэнтий аймгийн Баян Улааны өмнө байх бололтой гэж таамаглав. Энэ нь "Жэжээр өндрийн хярын Бэрх элст" гэсэн газрын нэр байж магадгүй юм. Бас НТ-ны 185-р зүйлд "Жэжэ'эр үндүрүн жэр хабчихай" гэдэг газрын нэр гарна. (353-р үгийн тайлбарыг үзнэ үү).

280. Нэндэ'эсү гэдгийг хх-д 攙先呵(гэндвэл) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "**гэндэх-эндэх**" гэдэг үгстэй нэг гаралтай юм. Эл үг бас НТ-ны 185-р зүйлд "нэндэн" (гэндэн, гэндүүлэн) 244-р зүйлд 166-р зүйлийнхтэй адил мөн "гэндүүлбээс" гэсэн утгаар гарч байна.

281. Эл нэрийг НТ-ны нангиад галигт*合舌兒答乞歹(хартагидаи) *合舌兒塔呵惕(харта'адгэж хоёр янзаар тэмдэглэсэн байна. Элдэнтэй, Ойундалай (1980, 353, 354) нарын харьцуулан буулгасан хэвлэлд ч мөн хоёр янз байна.

282. **Эжи'э** гэдгийг хх-д 到今(эдүгээ, өнөө болоход) гэж орчуулжээ. Эл үг НТ-ны 207-р зүйлд бас одоо болтол гэсэн утгаар гарч байна. "Хуа-и И-ю" тольд "эжигэ күртэлэ" гэдгийг мөн эдүгээ хүртэл гэсэн утгаар орчуулсан байдаг байна.

283. **Турух** гэдгийг хх-д倘仗(түшиглэж, тулгуурлаж) гэж орчуулжээ. Эл үг НТ-ны 179, 219-р зүйлд мөн дээрэхтэй ойролцоо утгатай байна. Харин 207-р зүйлд "эжи'э турух" гэдгийг 到今久遠(одоо болтол урт удаан) гэж хх-д дээрэхээс өөрөөр орчуулжээ. Чухам уг үгийн гарлын талаар бид тодорхой ойлголт үгүй байна. Эл үгийн хх.орчуулгад мөн "эрдэх, бардах" гэсэн утга байгаагаас үзвэл монгол бичгийн хэлний **туруг** (шилмэл, тураг сайхан) гэдэгтэй холбоотой байж магадгүй гэсэн сэтгэгдэл төрнө.

284. **Йабудаг кэлтү – г** 走作言語有的(явуулдаг хэлтэй) гэж үгчлэн орчуулжээ. Энэ нь үг хэл зөөдөг, ховлодог, хутгадаг гэсэн утгатай өвөрмөц хэллэг бололтой.

285. **Табу'у** гэдгийг хх-д 是麼(тийм үү) гэж орчуулжээ. Энэ нь эдүгээгийн ярианы хэлд түгээмэл хэрэглэгддэг **лав тав** гэдэгтэй ойролцоо утгатай юм. НТ-нд мөн "зөв үү тав уу" гэсэн хоршоо үгийн хэлбэрээр гарч байгаа билээ.

286. **Жичи гучи** гэдгийг хх-д 反復(ахин дахин) гэж орчуулжээ. Монголчуудын ураг төрлийн нэрд хүүгийнхээ хүүхдийг **ач,** ач хүүгийнхээ хүүхдийг **гуч,** гучийн хүүхдийг **жич** гэж нэрлэдэг байна. Үүнээс **жич, гуч** гэсэн хоёр нэр нь үгийн гарлын хувьд хэрхэн үүссэнийг судлагчид үзэхдээ: нэг нь эртний монгол хэлний **жир** (хоёр) гэдгийн жи язгуурт нэр үүсгэх "ч" залгаж, нөгөөх нь **гурав** гэдгийн гу язгуурт мөн "ч" дагавар залгаж үүссэн гэж үздэг байна. НТ-нд эл үг одоогийн "жич гуч" гэдэг утгаар бус хх. орчуулгад тэмдэглэсэнчлэн байн дахин юм уу хоёр дахь гурав дахь удаа гэсэн утгаар оржээ. (Элдэнтэй, Ардаажав, 1986, 484).

287. **Бэл** гэдгийг хх-д 且 (бас, мөн, бүр, бөгөөд) гэсэн сул үгээр орчуулжээ. Монгол бичгийн хэлний **бэл** хэмээх сул үгийг уг өгүүлбэрийн найрамжид нийцүүлэн "бүр" гэсэн сул үгээр буулгав. Энэ нь НТ-ны 245-

р зүйлд "мөн, бас" гэсэн утгаар гарч байна.

288. **Чаха'ана сача'асу, хара-да хаха'асу** гэдгийг 白行搶着呵黑行噎着呵 (цагаанд зангирвал, хард хахвал) гэж яг үгчлэн орчуулжээ. Эл зүйр үгийн санаа нь:

"Цагаан [идээнд] цацваас
Хар [маханд] хахваас" гэх буюу чухамдаа нас барахыг өгүүлжээ. Энэхүү "цагаанд цацаж, хард хахаж" үхэх заншил нь *үгтаа монгол домог-үлгэрт Муу мянганд өтөл болсон өвгөдөө хонины уураг сүүлээр хахааж алдаг байсан гэх* (Цэрэнсодном, 1989, 176), Рашид Аддиний (1952, т.2, 137) зохиолд хүний амаңд чулуу чихиж цаазалдаг ёс заншилтай учир холбогдолтой байж болох юм.

289. **Бу'улжар** гэдгийг хх-д 許婚筵席(хуримлахыг зөвшөөрсөн найр) гэж тайлбарлан орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний "багалжур" буюу халх аялгууны багалзуурын махыг өгүүлжээ.

Монгол хуримын эртний уламжлалт заншлаар эр эм болох залуус хийгээд ураг худ бололцож буй хүмүүс багалзуурын мах хуваж иддэг ёс заншилтай байсан нь шинэ тутам тогтоож буй ургийн холбоо хэлхээгээ хүзүү багалзуур мэт бат бэх барилдлагатай болохыг бэлэгдсэн учиртай бололтой юм. Дорнод халхын зарим нутгийн (Түдэн засгийн хошуунд) хуримд эр эм болж буй хос залуус дэр нийлэх үдшээ багалзуурын мах хуваж иддэг байсан гэнэ.

290. **Буру'уйа** гэдгийг хх-д 特地(онцгойлон) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний эргүүлэх, тойруулах, сэтгэх гэсэн утга бүхий **бургуй-бургуйдах** гэдэг үгтэй гарал нэгтэй бололтой юм. Якут хэлд **бургуй** гэдэг үг умбах, шумбах, нуугдах, далд орох гэсэн утгатай байх нь (Пекарский, 1917, 567) мөн НТ-ны **буру'уйа** гэдэгтэй агуулга хэлбэрийн аль аль талаар ойролцоо байгаа нь эдгээр үгс гарлын холбоотой байж болохыг гэрчлэх бас нэг баримт болж байна.

291. **Ө'эдийэн** гэдгийг хх-自每自的行(өөрсдөө) гэж орчуулжээ. Одоогийн өвөрлөгч зарим аялгуунд халхын аялгууны "өөрөө" гэхийг "өөсөө" гэж хэлдэг шиг дундад эртний монгол хэлд эл үгийн "р" авиаг "д-т" авиагаар дууддаг байсан бололтой. Учир нь монгол хэлд "с", "т" авиа сэлгэх учир ингэж үзэх үндэстэй билээ.

292. **Дэлэмэ** гэдгийг хх-д 泛濫(ус үерлэн тэлэх) гэж орчуулсан нь баахан эргэлзээтэй санагдана. Харин НТ-ны 21-р зүйлд энэхүү "дэлэмэ" хэмээх нь "дэмий үг, хэрэггүй үг" гэсэн утгаар гардгийг 造次

(ёсгүй, ёс бус) гэж орчуулсан нь уг үгийн утга санаанд яг нийцэж байгаа юм. Эл үг XIY зууны үеийн Турфаны монгол бичгийн дурсгалд мөн "дэмий, хэрэггүй" гэсэн утгаар гардаг билээ. Тухайлбал "Т-1 Д 155" гэсэн тэмдэгтэй бичмэл сургаалын шүлгийн дотор

"Балмад дэлэмэ хөдлөхүй сэтгэлээ
Барин хураан чадах эр ... " хэмээсний **дэлэмэ** гэдгийг проф. Н.Поппе (1960) герман хэлээр "ашиггүй, дэмий" гэсэн утгатай үгээр орчуулсан байна.

293. Кэлэ-бэн абтахун, кэнү ама итхахун -г 舌自的行被取的誰的口止當的 (хэлээ автааж, хэний амыг хориглоно) гэж орчуулжээ. Чухам эл зүйр үгийн утга санаа нь одоогийн ойлголтоор:

"Хэлий нь боож
Хэний амыг таглана" гэсэн агуулгатай ажээ.

294. Арийал үгэи гэдгийг хх-д 疑無(сэжиг үгүй) гэж орчуулжээ. Эл үг бас НТ-ны 181-р зүйлд "эргэлзэл үгүй, түдгэлзэл үгүй" гэсэн утгаар гарч байна. Бидний бодлоор энэ нь одоогийн зарим нутгийн аялгуунд нэрэлхэлгүй гэхийг "эрээлгүй" гэж хэлдэгтэй үндэс нэгтэй бололтой. Тэрчлэн бичгийн хэлний зүйлд ч "арийал" хэмээх нь "эргэлзэл, татгалзал" гэсэн утгатай байдгийг зарим судлагчид тэмдэглэсэн буй (Элдэнтэй, Ардаажав, 1986, 492).

295. Хара халжид элэт гэдгийг 沙磧名 , 沙磧(элсний нэр, элс) гэж тэмдэглэжээ. Энэ нь одоогийн дуудлагаар "Хар халзан элст" гэсэн газрын нэр бололтой. Үүнийг Х.Пэрлээ (1958, 10) "Нөмрөг голын бэлчрээс доош байсан бололтой. Энэ хавьд бий Хуучдын элс, Куран элс, Удаарт элс, Мойлт элсийг анхаармаар байна" гэж тэмдэглэсэн байна.

296. Той гэдгийг хх-д 陣勢(жагсаал цэрэгжил) гэж орчуулжээ. Эртний түрэг монгол хэлд **той** гэдэг үг хурим найр гэсэн утгаар голлон гардгийг бид 170-р тайлбарт өгүүлсэн билээ. Эл үгийн нэг салбар утга нь "дүрэм, журам, эмх цэгц" гэсэн агуулгатай ажээ. Тухайлбал "Цагаан түүх", "Эрднийн товч" зэрэг зохиолд "Арван хоёр их хаадуудыг **той**гоороо болгон" гэх буюу "Гэсэрийн туужид" "Хамаг амьтныг тойн дороо оруулсан", "Таван муж улсыг тойн дороо оруулаад" (Элдэнтэй, Ардаажав, 1986, 497) гэх зэргээр өгүүлсэнд **той** гэдэг үг эмх цэгцтэй болгосон буюу эрх мэдэлдээ авсан гэсэн утгатай байна. Үүнийг Ш.Гаадамба (1990, 511) "дори" гэж буулгасанд эргэлзэнэ.

297. Дэрэлкүкү гэдгийг хх-д 翻旋時(эргэлдэн урвалдахад) гэж орчуулжээ. Монгол шүлгийн эн зэрэгцүүлэлтийн ёсоор эл үг нь "тойрохуй" гэсэн эхний мөрийн үгтэй ойролцоо байх учиртай тул уг үгийн утгыг хх. орчуулгад оновчтой гаргасан бололтой байна. Ийм учраас бид эл үгийг "эргэлдэх, урвалдах, тойрох, дугуйрах" гэсэн утгатай гэж ухаарч байна. Үүнийг Гүн Цэнд (1997, 310) "Тэргэлэкү" гэж буулгасан нь тэргэл сар буюу бүтэн дугуйрах гэсэн утгатай үг хэмээн ухаарсных буйзаа.

298. Дэм гэдгийг хх-д 次序 (дэс дараа) гэж орчуулжээ. Уг үгийн гарал нь орчин цагийн монгол хэлний нэмэр тус гэсэн утгатай "дэм-дэмнэх" гэдэгтэй үүсэл нэгтэй байж болох юм. Тухайлбал монгол ардын зүйр үгд

"Дэм дэмэндээ
Дээс эрчиндээ" гэх нь аливаа ажил үйлс бүхэн нэг нь нөгөөгийнхөө тус дэмжлэгээр бүтдэг гэсэн санааг илэрхийлж байна. НТ-ны эл дөрвөн мөртийн утгыг ерөнхийд нь базаж хэлбэл:

Тойрох бүрийд
Эмхлэн дэглэж
Эргэлдэх бүрийд
Эв зүйг нь олдог гэсэн санааг илэрхийлж байх бололтой.

299. Тугтан гэдгийг хх-д 旋轉每 (тугтан, молцогтон) гэж орчуулжээ. "**Алагчнууд тугтан**"хэмээх нь Урууд, Мангууд овогтны туг сүлдний өнгийг өгүүлсэн байна. Орчин цагийн монгол хэлний туг (дарцаг, далбаа) гэдэг үг нь үүнтэй утгга тохирох бөгөөд харин үгийн гарлын хувьд адууны дэл сүүлнээс хэсэг хэсгээр буюу **туг тугаар** авч хийж байсан тул ийнхүү нэрлэх болсон ажээ. Эртний монгол овогтнууд бие биенээсээ ялгагдах тус тусын өнгийн туг сүлдтэй байснаас омог ясаа ч энэ заншилтайгаа холбон нэрлэдэг байсан бололтой. Тухайлбал эдүгээгийн Дөрвөд, Баяд угсаатанд "Хар тугтам" (Хар тугтан), "Цагаан тугтам" (цагаан тугтан) гэх мэтийн өнгөөр ялгасан яс элкэн (элгэн) буй билээ.

300. Дүлэд гэдгийг хх-д 越 (улам, нэн) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "турш, туж, дуустал" гэсэн утгатай **дүли-дүлин** гэдэгтэй холбоотой байж магадгүй юм. НТ-нд бас **дүли** хэмээх нь яг одоогийн утгаар хэд хэдэн удаа гардаг юм. Жишээлбэл 109-р зүйлд: "шөни **дүлин** келен күрген одчу'уи" гэжээ.

Энэхүү **дүлэд** хэмээх үг "Хуа-и И-ю" тольд: НТ-ныхтой адил утгаар гарна. Жишээлбэл уг толь бичгийн "Цаг улирлын зүйлд" **үдүр дүли** (өдөр дунд) гэж гарч байна. О.Ковалевскийн (1849, III, 1918) **дүлитү** хэмээхийг "дунд" гэсэн үгээр орчуулжээ.

301. **Торо'ун** гэдгийг хх-暗地 (далдуур, нууцаар) гэж орчуулжээ. Элдэнтэй, Ардаажав (1986, 500) нар дагуур хэлд **дороон** гэх нь "нууц, далд" гэсэн утгатай гэж тэмдэглэжээ.

302. **Тумбулан** гэдгийг хх-д 爲頭(эхлэн, тэргүүлэн) гэж орчуулжээ. Үүнийг бид орчин цагийн монгол хэлний "онцлон, чухалчлан" гэсэн утга бүхий **товойлгох** гэдэг үгтэй утга ойролцоо болов уу гэж үзэж байна. Эл үгийг Дугаржав (1984, 112) эдүгээгийн монгол бичгийн хэлд мөн **товойлгож** гэсэн үгээр хөрвүүлжээ. Бидний санахад уг үгийн үндэс нь **томбойх-товойх** гэдэгтэй холбоотой болов уу гэдгийг дээр тэмдэглэсэн билээ.

303. **Эбин** гэдгийг хх-д 伯父 (их авга) гэж орчуулжээ. Уг үгийн тухай Мансаан (1985, 190) тайлбар өгүүлэлдээ: Жүрчидэй Чингист ахмад үеийн авга удам болохыг түүхэн үүднээс өгүүлээд "**эбин** гэгч нэг талаар эцгээс ах насны их авгыг нэрийддэг боловч нөгөө талаар хүндэтгэхийн утга агуулагдаж байгаа юм шиг" гэж тэмдэглэв. Энэ нь үнэхээр эртний монгол хэлний авгын талыг дуудах хүндэтгэл үг байж болох юм. Якут хэлд нас ахимаг хүнийг "эбэн, эмэн" гэх ба энэ нь **эбигэ** буюу **өбүгэ** (өвөг) гэдэгтэй холбоотой гэж проф. Э.Пекарский (1917, 215, 219) тэмдэглэсэн байна.

304. **Хахтажу** гэдгийг хх-д 被射着 (харвагдаж) гэж орчуулжээ. Эл үгийг зарим судлагчид "хатгагдаж, жадлагдаж, шархдаж" гэж орчин цагийн монгол хэлээр хөрвүүлсэн боловч олонхи эрдэмтэд хх. орчуулгыг баримтлан "харвагдаж, харвуулж" гэсэн утгаар буулгасан нь зүйтэй бололтой. Учир нь НТ-ны 163-р зүйлд мөн Сэнгүм Наймантай тулалдахад мориныхоо гуяыг харвуулсан, 172-р зүйлд Боорчу морио унатал харвуулж явган гүйж явсан зэрэг баримтуудтай ойролцоо юм шиг санагдана.

305. **Ажу** гэдгийг хх-д 存着 (амьдарч) гэж орчуулжээ. Эртний монгол хэлд "а" гэсэн язгуурт "ж, ч, н, б" зэрэг нөхцөл залгаж "амьдрах, аж төрөх, суух" гэсэн утга санааг илэрхийлдэг байжээ. НТ-ны 24-р зүйл дэх "**аба** са'уба" гэдгийг бид "ан суув" гэж хөрвүүлсэн билээ. (26-р тайлбарыг үзнэ үү). Тэрчлэн эвенк хэлний "сайн сайхан, энх тунх, эрүүл

саруул" гэсэн утгатай **ажа** гэдгийг (Цинциус, 1975, 18) бидний ярилцаж буй **ажу** хэмээхтэй харьцуулан судалбаас сонирхолтой юм.

306. **Кэбэли'үлжү** гэдгийг хх-д歪了着(хэвийлгэж, хазайдгаж) гэж оновчтой орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "хэвийх-хэвийлгэх" гэдэгтэй нэг гаралтай юм. Тухайлбал НТ-ны 170-р зүйлд "манахарши үдүр дүли наран **кэбэли'үлүн** ..." гэх нь "маргааш өдөр дүл нар **хэвийлгэн**" гэсэн үг болно.

307. **(Х)аггарун** гэдгийг хх-д 被凝的 (цус бөглөрөх, бүлэгнэх) гэж орчуулжээ. Энэ нь одоогийн ойлголтоор цус агшрах, эгшрэх, хатаж бүлэгнэхийг хэлсэн нь хх. орчуулгаас мэдэгдэж байна.

308. **Жибши'эрчү** гэдгийг хх-д 整搠着 (засаж эмхлэх) гэж орчуулжээ. Энэ нь цэргээ тулалдаанд ороход бэлтгэж сургуулилахыг хэлсэн байна. Эл үгийг бид орчин цагийн монгол хэлний "зүгшрэх-зүгшрүүлэх" гэдэгтэй гарлын холбоотой байж магадгүй гэж таамаглаж байгаа юм. **Жибши'эрчү** хэмээх нь бас НТ-ны 194-р зүйлд цэргээ тулалдаан бэлтгэх, түвхнүүлэх гэсэн утгаар гарахын хамт 254-р зүйлд **жибши'эрүн** гэх нь улс орноо түвшитгэх гэсэн утгатай байна.

309. **Ӱчума** гэдгийг хх-д射名(сумны нэр) гэж тэмдэглэжээ. Бидний таамаглалаар эл үгийн язгуур нь эртний түрэг монгол хэлний **уч** буюу үзүүр, ёзоор, далавч (Наделяев, 1969, 603) гэсэн утгатай үгнээс үүссэн бололтой байна. Мөн дээр өгүүлсэн утгын аль нэгийг хадгалсаар буй түрэг хэлний **учух** (төгсгөх, дуусгах), орчин цагийн монгол хэлний **учиг** (утасны үзүүр буюу нарийсгасан хэсэг) гэдэг үгтэй бас холбож үзэж болно. Тэрчлэн эртний түрэг хэлд дээр өгүүлсэн **уч** хэмээх үгнээс үүсэлтэй "нисгэх, нисгүүлэх, тавих" гэсэн утга бүхүй "учур" (Наделяев, 1969, 604) гэдэг үгтэй харьцуулан судлаж үзвээс НТ-нд өгүүлж буй **учум, учумах** (учумаг ?) гэсэн үг нь "дуут сум" гэдэг шиг "нисэх сум" буюу "дүүлэх сум" гэсэн утгатай үг болов уу гэж төсөөлж байна. Эл үг НТ-ны 208-р зүйлд бас **учумах** гэсэн хэлбэрээр гардгийг тэмдэглэе.

«Чингис хааны Их өчиг» хэмээх сударт «Алаг адуутан Алтан учигтан» [Дамдинсүрэн, 1959, 86] гэсэн нь "алтан хор" гэдэгтэй ойролцоо утгатай үг болов уу гэж санаж байна.

310. **(Х)илухатхуйу** гэдгийг хх-д 惹的 (халдах, тэмцэх) гэж орчуулжээ. Үүнийг Алтан-Очир (1942,104), Элдэнтэй, Ардаажав (1986, 508) нарын судлагчид "**шилугадхуй - шилугадхуйу**" гэж сийрүүлжээ. Хэрэв эл үг дундад эртний монгол хэлд эхэндээ олонхи судлагчдын

тэмдэглэсэнчлэн балархай "х" авиатай бус "ш" авиагаар дуудагдаж байсан бөгөөс энэ нь орчин цагийн монгол хэлний "**шалгах - шалгаах**" гэдэг үгтэй холбоотой бай магадгүй юм.

311. Элбэсүн жалама гэдгийг хх-д орчуулаагүй байна. Ийм учраас тэр бүр судлагч нар эл холбоо үгийн утгыг нарийн тодорхойлж чадаагүй байв. Сүүлийн үед Элдэнтэй, Ардаажав (1986, 510), Мансаан (1985, 191) Иринжин (1987, 149) зэрэг судлагчид үүнийг монгол түрэг хэлтний бөө мөргөлийн ёс заншилтай холбоо бүхий **илбэ** (Ид шидийн) уяа дарцаг хийх зан үйлтэй холбон тайлбарласныг зүйтэй болов уу гэж санана.

Элбэсүн гэдгийг монгол бичгийн хэлний **илби** буюу ид шид үзүүлэх гэсэн утгатай үг болохыг судлагчид бараг санал нэгтэй зөвшөөрч байх бололтой.

Жалама хэмээх нь бидний бодлоор орчин цагийн монгол хэлний **зангиа, залгаа** гэсэн үгстэй үндэс нэгтэй бололтой. "Хорин нэгтийн тайлбар толь" хийгээд сүүл үеийн зарим толь бичгүүдэд ч үүнийг "Уд (модонд) уях цаасны зурвасыг **жалам** хэмээмой" гэх буюу "туг хийрт торго бүсээр хийсэн бүч " (Сэцэнцогт, 1988, 2326) гэх зэргээр тайлбарласан байна. Тэрчлэн Манахан тэнгэрийн тахилд:

"Улаан жалама-г барьж байнам
Урт сүүлт араатнаас өгөн соёрох" гэж дурдсан байдаг байна.

Монголчууд нялх нярай хүүхдийг энхрийлэн хөл цээрлэхдээ гэрийн үүдний хоёр талд улаан бүч даавуугаар хэл дарцаг унжуулсан урт дээсэн зэл татдаг заншилтай байж билээ. Энэ мэтийн зан үйлдэл нь НТ-нд өгүүлж буй "элбэсүн жалама" буюу "илбийн зангиа" гэдэгтэй учир холбогдолтой мэт санагдана.

312. Морин уну'атан модун нэмүрэтэн болбаи тэдэ гэдгийг хх-д 馬單騎的有木遮蔽的做了那每(морин уналагатай, модон нөмөртэй болов тэд) гэж яг үгчлэн орчуулсан байна. Эл зүйр үгийн утга нь монголчуудыг мориноос өөр унаагүй, модноос өөр нөмөр халх болох юмгүй чухам "Хээрээр гэр хийж, хэцээр дэр хийж" явагч гэдэгтэй адилавтар санааг илэрхийлж байна.

313. Жунда'ул гэдгийг хх-д 馬的乾糞(моринь хуурай баас) гэж орчуулжээ. Эртний түрэг хэлд морь гэхийг "жунд" гэдэг байна. Жишээлбэл морин жил гэхийг "**жунж** жылы" (Наделяев, 1969, 281) гэдэг

ажээ. Ийм учир **жунда'ул** хэмээх нь эртний түрэг хэлнээс уламжлан авсан үг ажээ: Уг үгийн бүтцийг ажиглахад "жунд" гэдэг дээр нэр үүсгэх-уул дагавар залгаж үүссэн нь тодорхой байна.

Элдэнтэй, Ардаажав (1986, 512) эл үгийн тайлбар өгүүлэлдээ буриад хэлд адууны хомоолыг **тонтогоол** гэх ба хуучин баргын аман аялгуунд мөн хомоолыг **тунтоли** гэдгийг харьцуулан тэмдэглэв.

314. Дэнсэлгэн гэдгийг хх-д 搖動(доргиох донсолгох) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "донсолгон" гэдэг үг болно. Харин эдүгээгийн монгол хэлд "дэнслэх-дэнсэлгэн" гэх нь сэтгэл тогтворгүй болох байдлыг өгүүлсэн утгатай болж утга шилжсэн ажээ.

Жишээлбэл Дариганга ардын "Жаахан шарга" гэдэг дуунд:

"Дэвээд байгаа дээврийг
Дээсээр даруулаад тогтооно
Дэнслээд байгаа сэтгэлийг
Одоо юугаар тогтоох вэ? " гэж дуулдаг билээ.

Тэрчлэн эл хоёр үг нь угтаа нэг гаралтай байж болохын нэг жишээ нь зарим тохиолдолд "дэнслэх донслох" гэж хоршоо үгийн байдлаар хамтаар хэрэглэдэг байна. (Цэвэл, 1966, 228)

315. Орну'у гэдгийг хх. орчуулгад 山名(уулын нэр) гэж тэмдэглэжээ. Үүнийг олонхи судлагчид "Өр нуга", "Ор нуга" гэж буулгасан байна. Харин Х.Пэрлээ (1958, 10) "Өрнө нуга" гэж таамаглажээ.

316. Да'у бари'улурун гэдгийг хх-д 教把話(үг бариулруун) гэж оновчтой орчуулжээ. Эл үгийн утга нь хх. орчуулгад тэмдэглэсэнчлэн "үг бариулах, үг хэлүүлэх" гэсэн утгатай байсан байна. XIII Зууны үеийн монгол хэлд "'дуу чимээ, үг хэл" гэсэн утгаар голлон хэрэглэгдэж байсан нь НТ-ны баримтаас харагдаж байна. Жишээлбэл 85-р зүйлд "бүлүүрийн **дуу**", 105-р зүйлд "хөөргийн (хэнгэргийн) **дуу**", 110-р зүйлд "Тэмүжиний дуу сонсч", 277-р зүйлд "үг **дуу** үлисчү (үүсгэж) ирж" гэх нь дуу авиа, үг дуу гэсэн утгатай байгаа билээ.

Эртний монголчуудын "дуу бариулах" ёс буюу элчээр үг илгээх тухай НТ-ны 181, 199, 265-р зүйлд гарч байна. Элчид дуу бариулж илгээх үгийг голцуу шүлэг найргийн хэлбэрээр хэлж байсан нь нэгдүгээрт цээжилж тогтооход дөхөмтэй, хоёрдугаарт элчийн хэлж очих зарим зүйл нууцлах ёстой учраас ёгт бүтүү утгаар хэлэх зүйлс орсон зэргээс шалтгаалдаг бололтой.

317. **Чимар** гэдгийг хх-д 嗔怪 (буруутгах) гэж орчуулжээ. Уг үгийн тухай 146-р тайрбараас үзнэ үү.

318. **Дэн са'ухуи** гэдгийг хх-д 坐的(суух) гэж орчуулжээ. Бидний бодлоор **дэн** гэх нь орчин цагийн монгол хэлний "маш, нэн, тун, үлэмж" гэсэн утгатай "**дэн**" (үүнээс дэндүү г.м. үг гарчээ) гэдэг хүч нэмэх үгтэй холбоотой байж магадгүй юм. Якут хэлд **дэн** хэмээх үг бас "үлэмж, маш, нэн" гэсэн утгатай (Пекарский, 1917, 690) байх нь анхаарал татаж байна. Чингэж үзвээс НТ-ны "**дэн суу**" гэдэг хэллэг бол "удаан суух" буюу "өнөд суух" өөрөөр хэлбэл амьдран суух гэсэн утгатай бололтой. Уг шүлгийн ерөнхий утга ч ийм байдалтай юм.

319. **(Х)уни дөлүсгэжү** гэдгийг хх-д 烟散着(утаа замхрааж) гэж оновчтой орчуулжээ. **(Х) уни** хэмээх нь эдүгээгийн монгол хэлний **униар** (утаа) гэдэг үг гэдэг нь бүхэнд тодорхой. Эл үг бас 242-р зүйлд мөн утаа униар гэсэн утгаар гарч байна. Харин **дөлүсгэжү** гэдэг үгийг бид зөвхөн хх.орчуулгаас л "замхраах, саринаах, дарах" гэсэн утгатай үг гэж мэдэж байгаа билээ. Эл үгийг орчин цагийн монгол хэлний "мултрах, салах, гажих" гэсэн утгатай **дөлрөх** (сонгодог бичгийн хэлний **дөлүрэкү**) гэдэг үгтэй холбоотой байж магадгүй гэж зөвхөн таамаглаж байна. Жишээлбэл Морины амгай **дөлрөх,** суулганы сэнж **дөлрөх** гэх мэт хэлдэгтэй харьцуулж болох мэт.

320. **Халжирхуйу** гэдгийг хх-д 莫是傍(хажуу дахь чинь бус уу) гэж орчуулжээ. Бид эл үгийг хх.орчуулга хийгээд эн зэрэгцүүлэн холбосон мөрийн "көндэлэтүжү" (хөндлөнгийн) гэсэн үгийн утга санааг харгалзан "**хажуугийн** хүмүүнээ" гэж хөрвүүлэв.

321. **Көки'үлдэбэ** гэдгийг хх-д 被挑了(едөөгдөх, хатгагдах) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний "хөгжөөх, урамшуулах, өөгшүүлэх" гэсэн утгатай **көкигүлэкү** гэдэгтэй гарал нэг бололтой. Үүнийг Бөххишиг (1941, 145) "көндүлэн дэки үү күмүн-э **көкигүлэгдэбэ**" гэж хөрвүүлсэн байна.

322. **Ни'урхан** гэдгийг хх-д 通面皮 (нүүрээр харьцаа тогтоох, нүүрээр нөхөрлөх) гэж орчуулжээ. Энэ нь "**нүүр тал харах**" буюу нүүр үзэж, зусардаж зулгуйдах гэсэн утгатай байна.

323. **Гурбан дэлэсүт** гэдгийг хх-д 地名(газрын нэр) гэж тэмдэглэв. Монгол бичгийн хэлний "**дэрэсүт**" (дэрст) хэмээхийг нангиад галигаар ингэж тэмдэглэсэн бололтой. Эл газрыг Элдэнтэй, Ардаажав (1986, 525) нар одоогийн Орхон голын Гурван Тээл хавь газрыг хэлсэн

бололтой гэж үзсэн байна.

324. **Хатихлиг ниру'ун** гэдгийг хх-д 地名 (газрын нэр) гэж тэмдэглэжээ. Эртний түрэг хэлд "хатиглиг" гэх нь "хатуу ширүүн, хүнд бэрх" гэсэн утгатай (Наделяев, 1969, 434) байхаас үзвэл энэ нь Хэцүү бэрхийн нуруу гэсэн нэртэй газар байж мэдэх юм. Чухам тулалдаан болсон газар нь "Хэцүү бэрхийн нурууны мөрүүэ (мөрөгцөг ?) сүүл" бололтой.

325. **Жарима** гэдгийг хх-д 半行(хагас) гэж орчуулсан нь зүйтэй юм. Энэ нь сарын тал, сарын хагас, сарын дундуур гэсэн утгатай байна. XIY Зууны эхэн үед Чойжи-Одсэрийн бичсэн Махагалийн магтаал шүлэгт:

"Залуу турихан царайтай
Зааны арьсан цамцтай
Заримлан үхрийн арьсанд
Залгасан илт нуруувчтай" (Цэрэнсодном, 1969, 130)

гэсний "**заримлан** үхрийн арьс" гэх нь үхрийн тал арьс буюу хагас арьс гэсэн утгатай юм. Энэ тухай Махагали буюу дөрвөн мутарт Лхамо бурханы бүтээлийн аргын ном сударт ч өгүүлсэн буй.

326. **Үрүнгү** гэдгийг хх-д 水名(усны нэр), **Кичилбаши** гэдгийг 海子名(нуур далайн нэр)гэж тэмдэглэжээ. Эл газрыг Х.Пэрлээ (1958, 8) Кишил баши нуур (Улаан толгойн нуур гэсэн түрэг нэр) гэж тэмдэглээд одоо **Үрэнгэ** буюу **Үлэнгүүр** нуур гэж нэрлэдэг гэжээ.

327. **Нөгөжи ий** гэдгийг хх-第二行(хоёрдугаарыг) гэж орчуулжээ. Үүний утга нь энэ хоёр хүн эс болбол нөгөө хүн юм уу өөр хүн илгээ гэсэн байна.

328. **Сойилух** гэдгийг хх-д орчуулаагүй байна. Ийм учраас судлагчид эл үгийг харилцан адилгүй үгээр буулгаж иржээ. Бид акад. Ц.Дамдинсүрэн (1976, 125) нарын судлагчдын "**халаг**" гэж хөрвүүлснийг зүйтэй болов уу хэмээн баримтлав. НТ-ны баримтаас үзвэл дундад эртний монгол хэлд үгийн эхний "х", "с" авиа сэлгэх үзэгдэл гарч байжээ. Жишээлбэл "хоор-хооронд" гэхийг "Со'ор" гэж хэлж байсан байна. (171-р тайлбарыг үзнэ үү). Энэ нь орчин үеийн буриад аялгуун сайн гэхийг "(х)айн" гэх зэргээр "с", "х" сольж хэлдэгтэй адил үзэгдэл юм. Ийм учраас эдүгээгийн "халаг" гэдэг үг эртний үед "сойилух" гэсэн маягийн дуудлагатай байсан байж болох юм.

329. **(Х)ирижэхүйу** гэдгийг хх-д үүнтэй ойролцоо утга бүхүй эн

зэрэгцүүлэн холбосон "хагацахуйу" (хагацхуйяа) гэдэгтэй яг адилаар 分離(салах, хагацах) гэж орчуулжээ. Бид эл бадаг шүлгийг

"Хагацахгүй төрөөсөө
Хагацав
Няцахгүй үйлээсээ
Няцав би" гэсэн утгатай гэж ухаарч байна.

330. Толи гэдгийг хх-д 指弹(хурууны өндөг) гэж орчуулжээ. Эл үгийн гарал нь орчин цагийн монгол хэлний **толигор** (гилигэр) гэдэгтэй үүсэл нэг бөгөөд эдүгээгийн ойлголтоор хуруу хумсны **толь - толио** гэх хумсны арын гилгэр толигорыг нэрлэх болжээ. (Сэцэнцогт, 1988, 1917) . Тэрчлэн эдүгээгийн түмэд, алашаа нутгийн аялгуунд хурууны өндгийг бас **толи** гэдэг байна. (Элдэнтэй, Ардаажав, 1986, 533).

331. Онучи гэдгийг хх-窊箭扣(сумны үзүүрийн тээглүүр ухагч) гэж тайлбарлан орчуулжээ. Энэ нь онь ухагч, онь гаргагч гэсэн утгатай *бөгөөд одоогийн дуудлагаар* **онивч** гэсэн үг юм.

332. Тагтаи гэдгийг хх樺皮小桶 (жижиг үйсэн сав) гэж орчуулжээ. Орчин цагийн монгол хэлэнд бичиг захидал хийх жижиг цаасан уутыг **тугтуи** гэдэг шиг эл үгийн гарал нь **таг - таглах** гэсэн үгнээс үүссэн байж болох юм.

Бөө нарын тахилын юмаа хийж тавих бяцхан үйсэн савыг **дахтай** гэдэг гэж Элдэнтэй, Ардаажав (1986, 534) нар "Хорь арван нэгэн овогтны язгуурын түүх" (1935) гэдэг зохиолоос иш татан өгүүлжээ. Ямарч атугай энэ нь таглаж бөглөөд хээр аян замд авч явахад зориулсан жижиг бортого савны нэр гэдэг нь тодорхой юм.

Эл үгийг бид бас эдүгээгийн монгол хэлний тагш (модон аяга) гэдэг үгтэй холбож үзвэл сонин санагдана. Бөххишиг (1941, 152) эл үгийг тагтай гэж сийрүүлээд хаалтанд **тагарчуг** гэж тайлбарласан байна.

333. Чун гэдгийг хх-д鐘 (хундага) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **цомоо** (сонгодог бичгийн хэлний чому) гэдэг үгний хуучин хэлбэр бололтой байна. НТ-г эдүгээгийн монгол хэлээр буулгасан хүмүүсийн дотроос Бөххишиг (1941, 152) эн тэргүүнээ **чуму** гэж хөрвүүлсэн билээ. Бидний бодвол Чингис хааны Жамухад хэлүүлсэн эл ёгт утгатай үгэнд Хааны хайр хишгийг түүний **хөх цомоо** буюу айргийн аягаар төлөөлүүлж хэлсэн бололтой байна.

334. Илэ'ү'ү гэдгийг хх-д對面(эсрэг тал) гэж орчуулжээ. Үүнийг

олонхи судлагчид "илээр, илт" гэсэн утгаар ухаарч орчуулж, хөрвүүлснийг бид баримтлав.

335. Жухажу'у гэдгийг хх-д對付着(аргалж, аргацаан) гэж орчуулжээ. Хорчин аман аялгуунд "аргацаах, эвлүүлэх" гэх зэргийн утгатай байдаг гэж Элдэнтэй, Ардаажав (1986, 537) нар тайлбар өгүүлэлдээ тэмдэглэжээ. Хэрэв үүнийг зүйтэй гэж үзвээс эл үг нь орчин цагийн монгол хэлний "зогоох" (дөнгөж аргацаах) гэсэн үгтэй ч холбоотой байж болох юм.

336. Арбилажу гэдэг үгийг И.Рахевилз (1972, 91, 6118-р мөр), Т.Дашцэдэн (1985, 115) зэрэг судлагчдын галигт эл үгийн эхний "ар" гэсэн үеийг өмнөх үгд нь нөхцөл мэтээр залгаж үүнийг "билажу" хэмээн сийрүүлсэн нь эндүүрэл болжээ. Эл үг НТ-ны 115, 117-р зүйлд мөн "арбилажу" гэсэн хэлбэрээр олзолж гэсэн утгатай гардаг юм.

Арбилажу гэдгийг хх-д 搌着 (олзолж, барьж) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "арвилах-аргилах" гэдэгтэй язгуур нэг бололтой.

337. Борхаи гэдгийг 高祖 (элэнцийн эцэг буюу хуланц аав) гэж орчуулжээ. Бидний бодлоор эл үгийн үндэс нь эртний түрэг, монгол хэлний "буурал, саарал" гэсэн утгатай "**бор**" гэдгээс үүссэн байж болох юм. Чухамдаа уг үгийн утга нь "өвөг дээдэс" буюу "буурлын үе" гэсэн утгатай бололтой. Бөххишиг (1941, 155) үүнийг орчин цагийн монгол хэлээр "өвөг" гэж хөрвүүлсэн байна. Монголчуудын өөрөөс дээших долоон үеийн тоололд : эцэг, өвөг, элэнц, хуланц, элэд, хулад, халабуха гэсэн байна.

338. Дэгэлту төрүксэн кө'үн гэдгийг хх-衣服有的生了的子 (хувцастай төрсөн хүү) гэж яг үгчлэн орчуулжээ.

Чингис хаан Ван ханы хүү Сэнгүмтэй анд бололцож ах дүү барилдсан тул үнэндээ Ван ханд Чингис бол сүүлд заясан хүү буюу НТ-нд өгүүлснээр "дээлтэй төрсөн хүү" болно.

Ойрд монголын туульд энэхүү "дээлтэй төрсөн" гэдэг хэллэг түгээмэл гардаг юм. Жишээлбэл Увс аймгийн Бөхмөрөн сумын туульч Цагаадайн Зодовын хайлсан "Бум Эрдэнэ", "Гунан хар Мэклээ" зэрэг туульд анд бололцсон баатруудыг "дээлтэй төрсөн ах дүүс" гэж өгүүлдэг билээ. (Зохиогчийн хувийн цуглуулга, Ц.Зодовын тууль)

339. Үдэ манахар гэдгийг хх-д 晚早 (орой эрт) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "өглөө үдэш" гэсэн холбоо үгтэй яг

тохирох хэллэг юм. Эл үг бас НТ-ны 201-р зүйлд Жамухагийн хэлсэн үгэнд гарна.

340. Үйэн гэдгийг хх-д 旧 (хуучин) гэж орчуулжээ. Үүнийг бид эдүгээгийн ойлголтоор хуучирч муудсан гэсэн утгатай үг болов уу гэж үзээд "үжирхий" гэсэн үгээр хөрвүүлэв. Элдэнтэй, Ардаажав (1986, 542) нар "хорчины аман ярианд хуучин хувцас хунар бүс барааны чанар нэгэнт үжрэх байдалд ойртсоныг **"үйэтэх"** хэмээмой" гэж тэмдэглэсэн байна.

341. Кэли гэдгийг хх-д 幾時 (хэзээ, аль үед) гэж орчуулжээ. Ибн-Муханны тольд кили гэж мөн "хэзээ хэдийд" гэсэн утгатай (Поппе, 1988, 440) байхаас үзвэл эл үгийн язгуур нь монгол бичгийн хэлний **кэжий-э** гэдэгтэй үүсэл нэг бололтой.

342. Кидугачи гэдгийг хх-好殺的(алаач, хядаач) гэж орчуулжээ. Ван хан, Тай-Төмөр тайши, Буха-Төмөр зэрэг дүү нараа алсанд Гүр хан авга нь дүү нараа алагч болов хэмээн морилон ирсэн тухайг Чингис хаан Архай Хасар нараар үг бариулж илгээхдээ дурдсан зүйлийг Сэнгүм энд өгүүлжээ.

343. Жубчижу гэдгийг хх-д 黏着 (залгаж зүүж) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн хэлний "зувчих-зувчиулах" гэсэн үгтэй язгуур нэг бололтой. Бидний санавал "Тогтоа бөөтэй сартагчин хонины сүүл залгасан /мэт/ явдаг" гэсэн эл хэллэг нь ардаа хонины сүүл зүүсэн юм шиг Тогтоа бөөг байнгын дагуул болгож явдаг гэсэн санааг урнаар ёгтлон өгүүлсэн ажээ. Эл үг 210-р зүйлд "жүбчигсэн", 275-р зүйлд "жүбчийа" гэсэн хэлбэрээр гарна. Мөн үгийн талаар Элдэнтэй, Ардаажавын (1986, 543) тайлбараас үзнэ үү.

344. Балжуна гэдгийг хх-д 海子名(нуур далайн нэр) гэж тэмдэглэжээ. Х.Пэрлээ (1986, 6) Балжунааг Халх голд цутгасан Балж булаг мөн бололтой гэжээ. Юань улсын судраас иш татан зарим сударт **Балтун наур** гэдэг гэжээ. Бөххишиг (1941, 157) үүнийг бас "Балдуна усун" гэж буулгасан байна.

Бидний бодлоор энэ нь буриадын Балжин хатны домогт гардаг Балжийн цагаан нуурыг өгүүлсэн байж магадгүй юм. Хуацай Дугаржав (1984, 128) Балжун нуурыг "Богд баатар биеэр дайлсан тэмдэглэлийн" тайлбар сэлтээс үндэслэн одоогийн Хөлөн далайн өмнөх Хавтгай нуур буюу Үзүүр далайг хэлсэн байх нь ерөнхий газрын чиглэл таарна гэх зэргээр харилцан адилгүй таамаглаж байна.

345. Асан Сартахтаи гэдгийг 人名 , 種 (хүний нэр, овог угсаа) гэж тэмдэглэжээ.

Бидний судалгаагаар НТ-г орчин цагийн монгол хэлээр хөрвүүлсэн олонхи судлагчид "Сартаулын (Туркестаны) Асан гэдэг хүн" гэж буулгасан нь үнэн байдалд хараахан нийцэхгүй мэт санагдана. Юуны өмнө НТ-ны хаямал орчуулгын зохиогч нь 181-р зүйлд "Сартагчин хонь" гэдэг үг回回羊(Хуй-Хуй ян) гэж тэмдэглэхийн хамт 152, 254, 256, 257, 260, 263, 264, 265-р зүйлүүдэд Сартаул гэдэг нэрийг回回 (Хуй Хуй буюу Хотон) гэж тэмдэглэснийг эрх биш анхаарах хэрэгтэй байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ баримт нь худалдаачин Асан Сартагтайг Сартаул буюу хотон хүн гэж үзэх үндэсгүй байна. Түүнээс гадна НТ-нд Асан Сартагтайг Онгуд угсааны хүн гэж зааж хэлснийг бас анхаарах хэрэгтэй болно. Чингэхлээр НТ-нд 種 (овог угсаа) гэж тэмдэглэж буй Сартагтай гэдэг нэр ямар утга учиртай үг вэ гэдэг асуулт гарна. Бидний бодлоор энэ нь монгол бичгийн хэлд "Сартвахи" гэдэг хэлбэрээр, ардын аман зохиол домгийн зүйлд "Сартагтай " гэдэг хэлбэрээр гардаг үг мөн бо лолтой байна.

Сартагтай хэмээх нь үгтаа самгарид хэлний "SARTHVAHI" буюу хэсэг бүлгийн ноён, удирдагч, жолоодогч гэсэн утгатай үг ажээ. Акад. Б.Ринчен (1966, 185) "**Сартагтай** баатар гэх мэтэд Энэтхэгээс эрт цагт орчин үеийн дундад азид оршин сууж байсан **худалдаачин** хүний нэр нь олон зуун жил дамжиж, монгол хэлнээ Энэтхэгийн зохиол буусан зүйлд далайгаар аялан худалдаа наймаа хийх хүний удирдагч Сартвахи гэж "Үлгэрийн далай" зэрэг сударт гардаг нь монгол бичиг судар аман бичгийн хэлнээ удирдагч, жолоодогч гэсэн утгатай ... " хэмээн тайлбарлажээ. Энэ нь НТ-нд "Мянган ирэг /хонь/ тууж, Эргүнэ мөрөн уруу булга, хэрэм худалдаж авахаар айсуй" **Асан_Сартагтайн** нэр гуншинг акад.Б.Ринчений дээр өгүүлсэн "Энэтхэгээс эрт цагт орчин үеийн дундад азид оршин сууж байсан **худалдаачин_хүний нэр** " гэж тодорхойлсонтой жишин үзэхэд агуулга хэлбэрийн аль аль талаар бүрэн нийцэж байгаа нь хэн бүхнээ тодорхой.

Үүнээс гадна монгол аман зохиолын зүйлд Сартагтайг ер бусын хүч чадалтай баатар эрийн байдлаар дүрслэн өгүүлдэг "Сартагтайн домог" (Гаадамба, Цэрэнсодном, 1978, 208) тэргүүтнээс үзэхэд эртний Энэтхэгийн энэхүү худалдааны ноёныг нэрийдсэн Сартагтай хэмээх үг монгол хэлд маш эрт цагт орж ирсэн бололтой байна.

346. Хара'ун жидүн гэдгийг хх-山名(уулын нэр) гэж тэмдэглэжээ. Эл нэрийг Дугаржав (1984, 128), Элдэнтэй, Ардаажав (1986, 549) нар одоогийн Хянган дабааг хэлж буйг баримтаар нотлоод үгийн гарлын хувьд ч утга нь яг тохирохыг тодорхойлжээ. Жишээ нь **жидүн** гэх нь манж хэлнээ уулын хяр нурууг хэлэх ба дагуур хэлд **жидэн** гэж даваа гэсэн утгатай учраас **Хара'ун жидүн** хэмээх нь Хянган даваа гэдэг нэрийн манж тунгус хэлний орчуулга маягтай нэр томъёо бололтой юм.

347. Кикүрижү гэдгийг хх-д 緣着(хярлаж хөвөөлдөж) гэж орчуулжээ. Олонхи судлагчид хэсэх, тэнэх, эрэх, бэдрэх гэсэн үгээр орчин цагийн монгол хэлээр хөрвүүлжээ. Бид үүнийг одоогийн монгол хэлний "хэрэх, хэгжих" гэсэн үгтэй язгуур нэгтэй байж магадгүй гэж таамаглаж байна.

348. Орбан гэдгийг хх-д орчуулаагүй байна. Бидний бодлоор энэ нь бут, сондиул гэсэн утгатай үг бололтой юм. Я.Цэвэл (1966, 420) орчин цагийн монгол хэлний **орвон** гэдэг үгийг "нэг бүхэл үндсээрээ байгаа ургамал, бутаараа байгаа ургамал" гэж тайлбарлажээ. Элдэнтэй, Ардаажав (1986, 551) нар "Үзэмчиний аман ярианд **орбон** хэмээх нь бут өвс буюу бутлаг модны үндэсний угийн овгор шороог хэлнэ" гэжээ. Дээр өгүүлсэн жишээ баримтаас үзвэл орчин үеийн монгол хэлниий **орвон** буюу бут сондиул гэсэн үг ажээ. Мөн эдүгээгийн монгол хэлд **оровонгоороо** гэх нь үндсээрээ, угаараа, бууриараа гэсэн утгатай байхаас үзвэл эл үгийн язгуур нь **ор - ором** гэдэгтэй үүсэл нэг байж болох юм.

Чухамдаа "Од харж, орвон дэрт болж" гэх нь "Хээр хонож хэц дэрлэж" гэдэг шиг зүйр үг бололтой байгаа юм.

349. Архал кэүки гэдгийг хх- 地名 газрын нэр) гэж тэмдэглэжээ. Х.Пэрлээ (1958, 7) эл газрыг "Одоо Ааруулт (долоон), Хүхт гэдэг болсон бололтой. Баян-Улааны баруун хойд үзүүрт бий" гэж таамагласан байна.

350. Алтан тэрмэ гэдгийг хх-д金散帳(хуримын алтан гэр) гэж орчуулжээ. Уг үгийн гарал нь эдүгээгийн ойрдын аялгууны гэрийн ханыг нэрийдсэн "**тэрэм**" гэдэгтэй холбоотой бололтой. Урианхайн туульч Чойсүрэнгийн хайлсан "Аргил цагаан өвгөн" гэдэг туульд:

"Тотго талд нь тогос гургуулыг
Тонголзуулан сийлсэн
Тэрэм талд нь тэх хуцыг

Мөргөлдүүлэн сийлсэн" гэсэн буй.

Энэчлэн халимаг хэлд гэрийн ханыг **терм** (Мучиев, 1977, 495) гэх ба ойрдын аялгуунд тэрэм (Цолоо, 1988, 814) гэдэг байна.

Бидний санахад Ван ханы хэрэглэж байсан алтан тэрэм гэгч нь нэгдүгээрт эдүгээгийн ойрд аялгуунд уламжлан ирсэн **тэрэм** буюу хана гэдэгтэй гарлын холбоотой бололтой. Хоёрдугаарт энэ нь дайн тулалдаанд орохоор аялан явахад зориулсан цацар маягийн хөнгөн орд сууцны нэр ажээ. Синзяны торгууд Жангарын туульд:

"Түмэн хүмүүн
Түлхэлцэл үгүй багтдаг
Түүхий **улаан цацар**
Далан хүмүүн
Давхцал үгүй суудаг
Далгай **цагаан цацар**" гэх зэргээр улаан, цагаан, хөх өнгийн цацрыг өгүүлснээс үзвэл Ван ханы "Алтан тэрэм" хэмээх нь "шар цацрыг" өгүүлсэн байж магадгүй юм.

351. (Х)охторихан гэдгийг хх-横斷(хөндөлдөж) гэж орчуулжээ. НТ-ны 141-р зүйлд кэ'ус гэдэг үгийг хх-д мөн эл хоёр үсгээр орчуулсныг тэмдэглэе. (224-р тайлбарыг үзнэ үү)

Эл үг нь НТ-ны 80-р зүйлд **(Х)охтори'ад**, 129-р зүйлд **(Х)охтолижу** гэсэн хэлбэрээр огтлох, таслах гэсэн утгаар гарч байна. Харин бидний ярилцаж буй 184-р зүйлийн **(х)охторихан** гэх нь хэрж, хөрөөдөн, хөндөлдөн гэсэн утгатай байгаа билээ.

352. Игүлгүжу гэдгийг хх-д орчуулаагүй байна. Ийм учраас судлагчид янз бүрээр таамаглан харилцан адилгүй ойлгож, орчуулж иржээ. Бидний санавал эл үг эдүгээгийн монгол хэлний **гүйлгэх** (давхиулах) гэдэг үгийн хуучин хэлбэр байж мэднэ. Үүнийг Алтан-Очир (1942, 116) "Үтэрлэн **гүйлгэж** шөнө дүли хүрч шавдуулан бүсэлье" гэж хөрвүүлснийг зүйтэй гэж үзэж байна.

353. Жэжэ'эр өндүр-үн жэр хабчихаи-йин амасара гэдгийг хх.орчуулгад 山名的地名的口行(уулын нэр, газрын нэр амсарт) гэж тэмдэглэжээ. Эл газрын нэрийг олонхи судлагчид "Жэжээр өндрийн Жэр хавцгайн амсар" гэсэн маягаар тэмдэглэсэн байна. Харин Алтан-Очир (1942, 117) монгол бичгийн хэлээр "Чэчэкэр өндүр-үн гэр хабчигаи-йин амсар-а" гэж буулгажээ. Х.Пэрлээ (1958, 8) "Энэ газар Баян-Улааны өмнөд хэсэгт байдаг бололтой. Баян-Улаан бол дугуйрсан

их уулсын нэр, түүний дотор талд олон нутаг бууцтай. Тэр нутаг бууцанд орж буух ганцхан хабчил ам (амсар) байдаг гэнэ. **Жэр Хавцгайн амсар** магад тэр хабчил ам мөн гэж бодогдоно" гэжээ.

354. Йадажу мут оробаи гэдгийг хх-д 窮乏着他每投入了(тэд туйлдаан хүртэл зүдэрч оров) гэж орчуулжээ. Эл хэллэгийн утга нь "тэд ядарч туйлдаад дагаж оров" гэсэн санааг илэрхийлжээ.

355. Күнкэтүгэи гэдгийг хх-д教離的遠者(хол зайлуултугай) гэж орчуулжээ. Үүнийг Бөххишиг (1941, 160) "амиа хөөтүгэй" (амиа хичээтүгэй) гэж хөрвүүлсэн байна. (132-р тайлбарыг үзнэ үү)

356. Худалатугаи гэдгийг хх-д聘者(харьд өгтүгэй) гэж орчуулжээ. Энэ нь **худ** (ураг худ) гэдэг үгийн үндсэн дээр үйл үгийн хоёр дугаар биеийн захирах тушаах төлөвийн дагавар залгаж үүссэн байна. НТ-ны эл зүйлд **худалатугаи** хэмээх нь "бү" гэсэн үгүйсгэх сул үг өмнөө авсан тул уг өгүүлбэр нь "Өөрийн дураар ураг худ бүү болтугай" гэсэн утгатай ажээ.

357. Аблиха гэдгийг хх-д請受(хүлээн авах) гэж орчуулжээ. Эл үг нь өнчрөгсөдөд хүртээх тэтгэмж, авлага хишгийн зүйлийг хэлсэн байна.

358. Имада гэдгийг хх-д 他行 (тэрэнд) гэж орчуулжээ. Эртний монгол хэлний "энэ тэр" гэдгийг заасан биеийн төлөөний эл нэр нь НТ-ны 101, 147-р зүйлд "имайи" буюу түүнийг гэсэн утгаар хэдэн удаа гарч байна. (106-р тайлбарыг үзнэ үү)

359. Тумта'а гэдгийг хх-д圓全行(бүрэн дүүрэн) гэж орчуулжээ. Үүнийг олонхи судлагчид хх. орчуулгыг баримтлан "бүгдийг цөмийг" гэсэн утгаар орчуулсан байна. Элдэнтэй, Ардаажав (1986, 561) нар "Синзяны дөрвөд аман аялгуунд "тумтаг" хэмээх нь хэсэг, бүрэн, бүтэн" гэсэн утгатай гэж тэмдэглэжээ. Эл үг бас НТ-ны 198, 208-р зүйлд **тунтаха** гэсэн хэлбэрээр гарна.

360. Күрү'э гэдгийг хх-д 酒局(архин сав) гэж орчуулжээ. Эвенк хэлд аяга шаазан агуулах хайрцаг савыг **көрнөк** (Цинциус, 1975, 420) гэж хэлдгээс үзэхэд орчин цагийн монгол хэлний **хөнөг** гэдэг үг үгтаа **көрнүгэ** юм уу **кө/ү/рүгэ** гэсэн хэлбэрээр хэлдэг байсан байж болох юм. Ийм учраас НТ-нд өгүүлж буй **күрү'э** гэдэг үг нь орчин цагийн монгол хэлний **хорго, хөнөг** гэсэн үгстэй язгуур нэгтэй байж болох юм. (Цэвэл, 1966, 694, 712)

361. Кэшиктэн гэдгийг хх-宿衛(байр хамгаалагч) гэж орчуулжээ.

Энэ нь ордны хэвтүүл, харуулын албанаа ээлж дараагаар гарах итгэлт хүмүүс болно. Гарлын хувьд эл үг орчин цагийн монгол хэлний **хиших,** ээлж (Цэвэл, 1966, 680) гэдэг үгтэй үүсэл нэг юм. НТ-ны 191-р зүйлийн хх. орчуулгад үүнийг護衛(хамгаалагч) гэж буулгасан байна.

Хэшигтэн гэдэг бол ээлж дугаараар хааны бие, орд өргөөг сахмин хамгаалагчдын ерөнхий нэр болно. Хэшигтэн дотор хорчин, хэвтүүл, тураг, буурч, агтач зэрэг тус тусын олон ажил мэрэгжлийн хүмүүс ордог байсан бололтой. Энэ тухай НТ-ны 191, 192, 224, 225, 226, 278-р зүйлээс үзэж болно.

Энэхүү **хэшигтэн** гэдгээс уламжилсан угсаатан нар эдүгээгийн Өвөр монголын өөртөө засах орны Зуу Од аймгийн Хэшигтэн хошуунд оршиж байна.

362. Түкэтэлэ гэдгийг хх-д勾了(хүртэл, гүйцтэл) гэж орчуулжээ.Энэ нь хүрэлцэх, хүртэлцэх гэсэн утгатай бөгөөд орчин цагийн монгол хэлний **түгэх** (дэлгэрэх) гэдэг үгтэй гарал нэг бололтой. Эл үг НТ-ны 92-р зүйлд儘勾(үлэмж, арвин) гэсэн утгаар гарсан билээ. Мөн үгийг гарлын хувьд эртний түрэг монгол хэлний бүхэл, бүтэн гэсэн утга бүхүй **түкел-түгэл** (Наделяев, 1969, 595; Цэрэнсодном, 1969, 135) гэдэг үгтэй харьцуулан үзэж болно.

363. Огуга гэдгийг хх-д 整(бүхэл бүтэн) гэж орчуулжээ. Энэ нь сонгодог бичгийн хэлний "ер, огт, эгнэгт, ямагт" гэсэн утгатай **"огугат"** (огоот) гэдэг үгийн хуучин хэлбэр бололтой (Сэцэнцогт, 1988, 340).

364. Чисуту тонох гэдгийг хх-血有的剝脫 (цуст тонолого, цуст дээрэмдлэг) гэж орчуулжээ. Судлагчид эл хэллэгийг гол төлөв хх.орчуулгыг баримтлан "цуст эд юмыг тонож дээрэмдэх" гэсэн утгаар ухаарч орчуулсаар иржээ. Харин Ш.Гаадамба (1976, 78-91) "Тоног гэдэг үгийн учир" гэдэг өгүүлэлдээ "цуст тоног авч" хэмээх нь цус нөж болсон хувцас хунар авч дээрэмдэх гэсэн үг биш дайсан этгээдийг ялж дийлсний баримт болгон цуст хуйхыг авахыг өгүүлсэн зүйл гэсэн шинэ санал дэвшүүлсэн юм. Гэтэл Ц.Шагдарсүрэн (1970, 315-320) "Монголын нууц товчооны тоног гэдэг үгийн тухай" гэсэн өгүүлэлдээ Банзарын Доржийн зохиолоос "Одон тэнгэрийг урих сударт": "Дайснаа дарж, цустай хувцсы нь тайлж авч ганзгалаад ялж дийлсний тэмдэг болгодог байсан" гэдэг бүтээлд нийтлэгдсэн "Мэлхий хүү" гэдэг үлгэрт нэгэн эмгэн өвгөн хоёрыг "хурааж тавьсан **өб тоноггүй**" гэж өгүүлсэн зэрэг хэд хэдэн ноцтой жишээ гарган өгүүлсэн нь яах аргагүй НТ-ны

хх.орчуулгыг зөв гэдгийг үнэмшүүлж чадсан байна. Харин НТ-ны 195-р зүйлд хятад галиг үсгээр "өб" гээгүй, "үб" 兀卜 гэсэн маягаар тэмдэглэсэн зэргийг цаашид мөн нарийвчлан үзмээр байгаа юм. (411-р тайлбарыг үзнэ үү)

365. Абжи'а көдэхэри гэдгийг хх-д山名(уулын нэр) гэж тэмдэглэжээ. Х.Пэрлээ (1958, 4) "XYII зууны үед Абчу (гол) гэж байсан бололтой Одоогийн Чойбалсан хотоос зүүн урагш газар" хэмээн таамагласан байна.

366. Дидиг сахалун нэкүн гэдгийг хх-д地名的水名(газар усны нэр) гэж тэмдэглэжээ. Үүнийг Х.Пэрлээ (1958, 11) "Марко Полын номд Тандүк тал (гэв). Тандүк тал бол Ван ханы хот гэж дурдсан байдаг. Энэ газар Ван ханы уул нутагт байх ёстой" гэж тэмдэглэжээ.

367. Эмэ кү'үн нохаи ни'уртаи гэдгийг хх-婦人狗面皮有的(эм хүн нохой нүүртэй байх) гэж үгчлэн орчуулжээ. Энэ нь нүрэндээ үстэй нохой мэт ичгүүр сонжуургүй хэмээгдье гэсэн утгатай бөгөөд чухамдаа Хөхөчү агтачийн эхнэр эр нөхөртөө гоморхож намайг юү гэж хэлэвч хамаагүй цөл газар хан эзнээ явгалан хаяхдаа ядаж ус утган уух савы нь үлдээ гэж нинжин сэтгэл гарган өгүүлсэн байна.

368. Жантаву гэдгийг хх-д盂(аяга, цомоо) гэж орчуулжээ. Олонхи судлагчид эл үгийг хх.орчуулгыг баримтлан "алтан аяга, алтан хундага" гэсэн үгээр орчуулсан байна. Бидний санавал энэ нь аяга хундага биш баймаар санагдана. Учир нь аягаа монголчууд өвөртлөх юм уу бүсэндээ зүүх зэргээр биендээ авч явдаг уламжлалтай билээ. Гэтэл энэ **жантаву** хэмээх сав нь эмээлийн ганзганд байснаас үзвэл эрх биш аяганаас томоохон, ус унд хадгалах буюу цай чанах мэтийн зориулалттай сав бололтой юм.

Энэ савыг бид одоо үеийн буриадын төмөр хувин данхыг нэрийдсэн **зантуу** (Черемисов, 1973, 250) гэдэг үгийн хуучин хэлбэрийн нэр болов уу гэж үзэж байна. Мөн Элдэнтэй, Ардаажав (1986, 570) эл үгийн тайлбар өгүүлэлдээ Синзяны торгууд аялгуунд "лам нарын цай хийдэг савыг **жантуу** хэмээдэг" гэсэн нь үүнийг батлах бас нэг баримт болно.

369. Толох гэдгийг хх-д 大毡(том эсгий) гэж орчуулжээ. Энэ нь аливаа хүндэтгэл ёслолын зүйлд хэрэглэх цагаан эсгий дэвсгэрийн нэр ажээ. Эдүгээгийн Ордос аялгуунд хурим найрын ёслол үйлдэхэд дэвсэх цагаан эсгийг **толок** (Мостарт, 1942, 666) гэдэг байна. Энэ нь

эдүгээгийн ойрд аялгууны **толаг** (эсгий) гэдэгтэй тохирно (Цолоо, 1988, 819).

Тэрчлэн орчин цагийн монгол хэлний **олбог-толбог** гэдгийн толбог хэмээх нь үүнтэй язгуур нэгтэй байж болох юм.

370. Бэринэд-ийэн бэрилэ'үлжү-г 媳婦自的行教　媳婦的禮行着 (бэрээцүүлээ бэрийн ёсоор ёслуулж) гэж орчуулжээ. Хуучин цагийн ёсоор бэр хүн хадам ургийн газар хүндлэх цээрлэх нарийн дэг журам олон байв. Энэ ёс заншлын дагуу Гүрбэсү хатан Ван ханы толгойг тайхдаа бэрээцүүлээрээ хүндлэл ёслол гүйцэтгэсэн бололтой байна.

371. Нохану бидану хучахуи да'ун ма'уи болбаи гэдгийг狗的咱的吠的聲歹做了(Нохойны бидний хуцах дуу муу болов) гэж үгчлэн орчуулжээ. "Бидний нохойн хуцах дуу муухай болов" гэх нь монголчууд нохой улин хуцахыг муу ёр хэмээн хориглох цээрлэх заншилтай холбоотой ойлголт юм. Монголчууд эдүгээ хүртэл нохдоо улин хуцах ялангуяа юмны бараа хараагүй анир чимээ аваагүй дэмий улин хуцахыг зэвүүцэн муу ёр хэмээн болиулдаг байлаа.

"Хураангуй алтан товчид" Чингис хааныг төвд оронд дайлаар очихыг Шудургу хааны хар хоншоорт шар хонгор Гүблиг нэрт нохой нь зөгнөн ёрлож гурван жил улин хуцахад нь төвдүүд нохой маань хөгширч ёр нь үгүй болж хэмээн ажиг сэжиггүй сууж байтал дайсан довтлон ирсэн гэх домгийг өгүүлсэн буй. Өвөр монголын Багшийн их сургуулийн проф. Булаг (1989, 336) "Хураангуй алтан товчийн" тайлбар өгүүлэлдээ: хүүхэд ээрч уйлах, нохой улин хуцах тэргүүтнийг муу ёрын шинж тэмдэг болгон түүхэн сурвалж бичгүүдэд өгүүлсэн байхаас гадна туульсын зохиолд "Тором нэрт шар өлөгчин нь тойрч байгаад долоон өдөр хуцахад" гэх зэргээр Буриадын "Алтан Сүмбэр абай хөвүүн" туульд гардгийг иш татан дурджээ.

372. Торлух гэдгийг хх-д орчуулаагүй байна. Эл үг НТ-ны 189, 190-р зүйлд гурван удаа гарахдаа "ядуу, дорой, өөдгүй" гэсэн утгатай байгаа юм. Бидний бодлоор энэ нь орчин цагийн монгол хэлний **"дорой, дорлог"** гэдэг үгтэй гарал нэг бололтой байна.

В.Кливез (1982, 117) уг үгийг ордос аялгууны торлог модны үр жимстэй холбож үзсэн нь эргэлзээтэй санагдана.

373. Төрүлмиши гэдгийг хх-д орчуулаагүй байна. Энэ нь монгол түрэг хэлний "гарах, үүсэх, төрөх" гэсэн утга бүхүй **төрүкү, тери, төрчи**

(Наделяев, 1969, 580, 581) гэсэн үгийн үндсэнд түрэг хэлний **-миш** гэх дагавар залгаж үүссэн байна. В.Кливез эл үгийн товч тайлбартаа уг үгийн үүслийн талаар Н.Поппе 1954 оны 8-р сарын 19-нд төрүлмиш гэдгийг "үүсэх, төрөх" гэсэн утгатай **төрү** (л) гэдэг үгэнд -миш хэмээх дагавар залгаж үүссэн гэж мэдээлснийг дурджээ.

374. Идүрэкүи гэдгийг хх-將近的(ойртох, дөхөх) гэж орчуулжээ. Эл үг НТ-ны 145-р зүйлд бас идүрэжү гэсэн хэлбэрээр хоёр удаа гарна. (238-р тайлбарыг үзнэ үү)

375. Баратутан гэдгийг хх-暗每有(хар бараан) гэж орчуулжээ. Бидний санавал эл үг нь чухамдаа хувцасны өнгийг өгүүлсэн бус хар хир буртагтай хэмээн муучлан хэлсэн бололтой юм.

376. Шили'ун гэдгийг хх-清俊(цэвэр цэмцгэр) гэж орчуулжээ. Энэ нь эдүгээгийн бичгийн хэлний **шилигун - шилилиг** гэх зэргийн үгстэй язгуур нэгтэй бололтой.

377. Ни'удхун гэдгийг хх-д орчуулаагүй байна. Эл үгийг Бөххишиг (1941, 168), Баяр (1981, II, 779) зэрэг судлагчид монгол бичгийн хэлээр **нигухтүн** гэж буулгасан ажээ. Үүнээс үзвэл орчин цагийн монгол хэлний "нуух" гэдэг үг нь дундад эртний монгол хэлд "болих, хориглох, зогсоох, таслах" гэсэн салаа утга бас байсан гэж үзмээр байна. Бид эл үгийг уг зүйлийн утга санаанд нийцүүлэн "орхигтүн" гэсэн үгээр хөрвүүлэв.

378. Хоморчу гэдгийг хх-圈合着(бүсэлж, нийлж) гэж орчуулжээ. Энэ нь "бүслэн хаах, хориглон хүрээлэх" гэсэн утгатай хомроголон авлах гэдэгтэй үүсэл нэгтэй үг болно. Шагжийн "Эрхүйеэ хялбар болгон зохиосон монгол үгний тайлбар чандманийн эрих хэмээгдэхээс ба, хагийн аймаг" (дэд дэвтэр) хэмээх бичмэл тольд **хомрого** гэдэг үгийг "хаан авлахыг" хэлнэ гэж тайлбарлажээ.

379. Чэрбин гэдгийг хх-д 官名(ноён зэргийн нэр) гэж тэмдэглэжээ. (177-р тайлбарыг үзнэ үү)

380. Кэбтэ'ул гэдгийг хх-宿衛(байр хамгаалагч) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "хэвтэх" гэдэг үгтэй гарал нэг бөгөөд хаан эзнийг шөнө унтаж хэвтэх цагт сэргийлэн хамгаалах хүмүүс болно. Үүнийг Ц.Дамдинсүрэн (1976, 140) "шөнийн манаач" гэж тайлбарласан бол В.Кливез (1982, 119) англи хэлээр "шөнийн хамгаалагч" гэсэн утгаар орчуулсан байна.

381. Турха'уд гэдгийг хх-д 散班(задгай ээлж) гэж орчуулжээ.

Олонхи судлагчид үүнийг "торгон цэрэг" буюу шилдэг цэрэг гэж ойлгож орчуулж ирсэн байна. Бидний санавал уг үгийн гарал нь монгол бичгийн хэлний шилмэл, сонгомол гэсэн утгатай "туруг" гэдэгтэй үүсэл нэгтэй бололтой. Проф.В.Кливез (1982, 119) англи хэлний орчуулгадаа **хэвтүүлийг** "шөнийн хамгаалагч" **турхагуудыг** "өдрийн хамгаалагч" гэж буулгасан нь тэдний ажлын үүргийг оновчтой гаргаж хэлсэн байна.

Якут хэлд **турук** хэмээх нь "бөх, бат,байнга" (Пекарский, 1917, 2849) гэсэн утгатай байхаас үзвэл "турхаг" гэдэг нь дундад эртний монгол хэлд байнгын буюу тогтмол харуулыг заасан утгатай байсан ч байж бас болох талтай юм.

382. Үтү дүрү-йин кү'үн гэдгийг хх-只那般白身的人(эгэл доорд хүмүүн) гэж орчуулжээ. Эл үг НТ-ны 224-р зүйлд бас "дүрийин кү'үн" гэж гарч байгааг тэмдэглэе. Мөн "Хуа-и И-ю" тольд "**уту** элэ (х) ажар ао'утки(х) үйин тула бусу" гэсэн өгүүлбэрийг хятад үсгээр "**зөвхөн** [энэ] газар уудамсгахын тул бус" гэсэн утгаар орчуулсан байна.

Олонхи судлагчид хх.орчуулгыг баримтлан "эгэл ард, эгэл хүн, сул хүн, үтэл ард" гэсэн утгаар хөрвүүлж иржээ.

Эдүгээгийн ойрд аялгуунд урт гэхийг ут (Муниев, 1977, 539) гэдэг баримтыг үндэслэн зарим судлагчид үүнийг "урт дурын хүн" буюу "чөлөөт иргэн" гэсэн утгатай үг гэж үзсэн санал бас бий. Тухайлбал түүхч Ч.Далай (1989, 12-15) "Урт дурын хүн" гэдэг өгүүлэлдээ энэхүү "үтү дүрү-йин кү'үн" гэдгийг хамжлага зарцаас ангид тухайн нийгмийн нэг давхрагын чанартай чөлөөт хүмүүс гэж үзсэн байна.

Бидний бодлоор **үтү** гэдэг нь гарлын хувьд орчин цагийн монгол хэлний "**үтэл**" гэдэгтэй язгуур нэгтэй бололтой байна. Ийм учраас бид Алтан-Очир (1942, 170) нарын судлагчдын "үтэл ард" гэж хөрвүүлснийг зүйтэй болов уу гэж үзэж байна.

383. Шил гэдгийг хх-模樣(дүр дүрс) гэж орчуулжээ. Энэ нь хүний бие бялдар чадал тэнхээг өгүүлсэн бололтой юм. Монголчууд бяр тэнхээт бөх хүнийг шинжихэд шилэн хүзүүг нь хардаг эртний уламжлалтай учраас "Галын тахилгад":

"**Шил** сайт хөвүүн

Шивэргэл сайт бэр хайрла" гэж өгүүлсэн бололтой.

Энэхүү хос мөр шүлгийн утга нь бие бялдар сайтай хүү, гэзэг үс сайтай бэр хайрла гэсэн санааг илэрхийлжээ. Эл үгийн тухай мөн Элдэнтэй, Ардаажав (1986, 585) нар бас ийм утгаар тайлбарласан байна.

384. Йэ'үткэлдүжү гэдгийг хх-替换着 (солилцож) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **юүлэх** (галав юүлэх, морь юүлэх г.м.) гэдэгтэй гарал нэг бөгөөд "өөрчлөгдөх, солигдох" гэсэн утгатай юм.

Эл үг бас дундад эртний болоод арай хожуу үеийн бичиг зохиолд мэр сэр тохиолддог байна. Тухайлбал: "Хуа-и И-ю" толийн зарлигийн зүйлд: "тэндэчэ тэнггири Даи-Йуан монгкол какано жайан-и **йэ'үткэжү**" гэсэн буй. Тэрчлэн Ширээт гүүшийн орчуулсан "Үлгэрийн далайн" (1986, 33) "Бидүн йабугчи ану шагшабад сакихсан-у жүйил" гэдэг үлгэрт: "... тэндэчэ төрүл **йэгүтгэжү** (солигдох) тнгри-йин көбэгүн болун төрүбэи" гэх зэргээр өгүүлсэн жишээг дурдаж болно.

Энэ үг бас НТ-ны 203, 205, 227, 229, 248, 278-р зүйлүүдэд мөн "солих, өөрчлөх" гэсэн утгаар гарч байна.

385. Төридчү гэдгийг хх-д 止着 (түр саатах, азнаж) гэж орчуулжээ. Энэ нь эдүгээгийн монгол хэлний түр түдэх гэдэг үгийн эртний хэлбэр болно. Эл үг НТ-ны 197-р зүйлд "төридкэжү'үи" гэсэн хэлбэрээр бас гарч байна.

386. Тэлкэн гэдгийг хх-д 展開 (тэлэн тархаж) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "дэлэх-дэлгэх" гэдэгтэй язгуур нэгтэй "таруун, тэлүүн" гэсэн утгатай юм. Дорнод халхын аман аялгуунд "дэлхэх" гэх нь таруун, тогтуун гэсэн утгатай билээ. Жишээлбэл "хонь сайхан **дэлхэж** байна"гэвэл хонь таруун сайхан бэлчээрлэж явна гэсэн утгатай.

387. Охжатхайа гэдгийг хх-虚驚 (хий сочоох, хоосон сүрдүүлэх) гэж орчуулжээ. Уг үгийн гарлыг бид орчин цагийн монгол хэлний гэнэт гэсэн утгатай **огзом** хэмээх үгтэй холбоотой байж магадгүй гэж таамаглаж байна. НТ-г орчин цагийн монгол хэлээр хөрвүүлсэн олонхи судлагчид хх.орчуулгыг баримтлан "галаар сочооё", "галаар сүрдүүлье" гэсэн үгээр эл хэллэгийг буулгажээ. (433-р тайлбарыг үзнэ үү) Мөн Ш.Гаадамбын (1990, 562) тайлбарыг үзэж болно.

388. (Х)үлүрикэ'үлтэлэ гэдгийг хх-悦惚間 (мэгдүүлэх, алмайруулах) гэж орчуулжээ. Эл үгийг Ц.Дамдинсүрэн, Элдэнтэй, Мансаан зэрэг судлагчид орчин цагийн монгол хэлээр "гөлрөх-гөлрүүлэх" (алмайран гайхах) гэсэн үгээр хөрвүүлжээ. Бид хх.орчуулга хийгээд урьд өмнөх судлагчдын орчуулга, хөрвүүлгийг харгалзан уг

хэллэгийг "галаар гайхашруулж" гэж буулгав.

389. Хамтутун бара'асу гэдгийг 相合了呵 (харилцан нийлүүлж барвал) гэж орчуулжээ. Энэ нь хамтран нэгдэх, хамтран нийлэх гэсэн утгатай байна.

390. (Х)ирмэс гэдгийг хх-д 轉 (ирмэх) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **ирмэх** гэдэг үгийн эхний "х" авиа гээгдээгүй эртний хэлбэр юм. "Хара нидүн-ийэн **(х)ирмэс** үлү кикүн тэдэ" гэх нь "Хар нүддэ **ирмэс** үл хийнэ тэд" гэсэн утгатай ажээ. Уг үгийн эхний "х" авиа эдүгээгийн зарим нутгийн аялгуунд гээгдээгүй буюу өөр авиагаар солигдсон байна. Жишээлбэл торгууд Жангарын туульд:

"Хайкирсан дуугаа таслал үгүй
Халиасан нүдээ **чирмэл** үгүй" (Буянхишиг, Бадам, 1982, 363) гэсэн буй.

391. Сэгү'үлүн гэдгийг хх-д卷退(эвхрэн ухран) гэж орчуулжээ. Эл үгийн талаар Бээжин хотын үндэстний Дээд сургуулийн проф.Хишигтогтох "Хишигтэн аялгуунд **сэгүүлэн гүйлгэх** гэх нь ергөхөөс дээгүүр цогих маягийн гүйдлийг өгүүлнэ гэж надад ярьж билээ. Хэрвээ эл үг уул утгыг уламжлан хадгалсаар ирсэн гэж үзвэл энэ нь даруй хурдавчлах юм уу гүйлгэн хөдөлж гэсэн утгатай байж болно. Харин үүнийг Алтан-Очир монгол бичгийн хэлэнд "нэхүгүлүн көдэлжү" гэж буулгасан байна. Гэтэл НТ-ны эл зүйлийн дотор мөн "кэ'эли сэгү'үлүн" гэснийг хх-肚皮教抽起(гэдсий нь хөнгөрүүлэх, датуулах) гэж орчуулжээ. Үүнээс үзвэл НТ-нд өгүүлж буй **сэгү'үлүн** хэмээх нь морь хөнгөрүүлэх, уяа оруулах буюу **шивхнүүлэх** гэсэн үг байж бас болох талтай юм. Уг үгийг НТ-ны хх.орчуулгад хоёр өөр янзаар орчуулсан хийгээд эл үгсийн утга агуулгын авцалдааг харгалзан бид мөн хоёр өөр утгатай үгээр хөрвүүлэв.

392. Алтаи-йин өлкэс гэдгийг хх-山名的山下 (уулын нэр, улын бэл) гэж тэмдэглэжээ. Х.Пэрлээ (1958, 4) эл газрын тухай: "Чингис богдын өчиг" гэдэг сударт **өлгэ** газар аялан явж онжияд дайсныг эрхэндээ орчуулж гэсэн үзэгдэнэ. Одоо **Өлгий хүй** гэдэг Алтайгаас буусан гурван хүй голын нэг, Эрчис голын эх болно гэж тайлбарлажээ.

393. Нохаи кэрэл кэрэжу йабужу гэдгийг хх-狗般圍圍着行着 (нохой мэт хэрүүл хийж явж) гэж орчуулжээ. Энэхүү хх.орчуулгын "хэрүүл, тэмцэл" гэсэн утгатай 鬥 (доу) гэдэг үгийн эртний бичлэг нь 鬪 байх ажээ. Энэ нь Юань улсын үеийн 玉篇(Ю-пиан) гэдэг товч толь

бичигт тэмдэглэсэнтэй тохирч байна гэж Бээжин Их сургуулийн Дорно дахины салбарын проф. Хуан Зүн жиан багш надад мэдээлэв. Гэсэн ч эл сонин хэллэгийг судлагчид хх.орчуулгыг голцуу баримтлан "нохойн тэмцлээр тэмцэх" гэх буюу "нохойн хэрүүлээр хэрэлдэж явж" гэсэн утгаар ухааран орчуулсаар ирсэн нь баахан эргэлзээтэй санагдана. Харин акад.Ц.Дамдинсүрэн (1978, 144) эл хэллэгийг "нохойн хэрэл хэрж, займруулан чирэгдүүлж" гэж утгачлан хөрвүүлсэн нь зүйтэй бололтой. Учир нь бидний санавал НТ-ны хх.орчуулгад монгол бичгийн хэлний **кэрүкү** гэдэг үгнээс үүсэлтэй **кэрэл** (хэрж сүлжин явах) гэсэн үгийг **хэрүүл** хэмээх ойролцоо дуудлагатай үгтэй ташааран хутгаснаас "хэрэл хэрж" гэсэн хэллэгийг "хэрүүл хийж" гэж эндүү ухаарсан бололтой юм. Эрдэмтэн Ш.гаадамба (1976, 114-115) "Монголын нууц товчооны зарим нэр томъёоны учир" гэдэг өгүүлэлдээ "Нохой хэрэл хэрж" гэдэг үг бол XIII зууны үеийн монголчуудын цэргийн арга ухааны холбогдолтой үг хэллэг буюу нэр томъёо болохыг тодорхойлж нохойны хэрж, сүлжиж гүйх явдалтай холбож ойлгосон Ц.Дамдинсүрэнгийн саналыг батлан тайлбарласан байна.

394. Сэгү'үлүн гэдгийг хх-д 教抽起 (гэдсий нь хөнгөрүүлж, датуулах) гэж орчуулжээ. Эл номын 391-р тайлбарыг үзнэ үү.

395. Чанхарта'улун гэдгийг хх-д 教疲乏(ядруулж, зүдрүүлж) гэж орчуулжээ. Бидний бодлоор эл үг нь орчин цагийн монгол хэлний **цанхир-цонхир** гэсэн үгтэй язгуур нэгтэй бөгөөд өнгө зүс, тамир тэнхэл алдуулах гэсэн утгатай юм. Цанхир хэмээх үгийн гарлын талаар Сэцэнцогтын (1988, 2168) "Монгол үгсийн язгуурын тольд" үзнэ үү.

396. Күндү эмэ-йин гэдгийг хх-重婦人的 (хүнд эм хүний)гэж үгчлэн орчуулжээ. Энэ нь бие давхар буюу жирэмсэн эм гэснийг цээрлэн өгүүлсэн хэллэг юм. Одоогийн ярианы хэлд ч жирэмсэн болох гэхийг хөл хүндтэй болох гэх зэргээр өгүүлдэг билээ.

397. Күрдүну тугул гэдгийг 車脚的犢 (тэрэгний дугуйны тугал) гэж үгчлэн орчуулжээ. Нялх тугалыг уяанд сургахад зэлэнд уяхаас өмнө тэрэгний дугуй мэт бат бэх зүйлээс уяж номхруулдаг нялх бага тугалыг "хүрдний тугал" гэжээ. Үүнийг акад.Ц.Дамдинсүрэн орчин цагийн хэлнээ:

"Жирэмсэн эмийн шээх газраас
Хол яваагүй
Жижиг тугалын билчих газраас
Гарч үзээгүй" гэж утга санааг нь маш оновчтой гаргаж

хөрвүүлсэн байна.

398. Эбэрэтэлэ бэртэтэлэ гэдгийг хх-痛傷 (өвдтөл, шархадтал) гэж орчуулжээ. Энэ нь эдүгээгийн ойлголтоор "өвдтөл бэрттэл" юм уу "өвдтөл хорстол" гэсэн холбоо үг бололтой. **Эбэрэтэлэ** хэмээх нь гарлын хувьд монгол бичгийн хэлний **эбэдтэл** (өвдтөл) гэдэгтэй үүсэл нэгтэй болов уу гэж үзэж байна. Тухайлбал зарим бичиг зохиолд "бие өвдөв" гэх нь "**бий-э эбэршийэбэ**" гэсэн хэлбэрээр тохиолддог байна. (Сэцэнцогт, 1988, 189)

399. Сача гэдгийг хх-д 一般(нэгэн адил) гэж орчуулжээ. Эл үг бас НТ-ны 275-р зүйлд мөн адил, тэгш гэсэн утгаар гарч байна. Энэ нь орчин цагийн монгол хэлний **сацуу** (сонгодог бичгийн **сачагу**) хэмээх үгтэй гарал нэгтэй ажээ. НТ-ны 181, 203, 214, 266-р зүйлд **сача'у** гэдэг үг монгол бичгийн хэлнийхтэй бараг адил гарч байгаагаас үзвэл эл үг дундад эртний монгол хэлд **сача, сача'у** гэсэн хоёр хэлбэрээр хэрэглэгдэж байсан бололтой.

400. Чима гэдгийг хх-嘆聲 (шүүрс алдах дуу) гэж тэмдэглэжээ. Бид хх. орчуулгыг харгалзан "халаг" гэсэн үгээр хөрвүүлэв.

401. Сүлбэркүи гэдгийг хх-д 怠慢 (сулрах, доройтох) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **сулрах-сулдах** гэсэн үгийн хуучин хэлбэр болно. Элдэнтэй, Ардаажав (1986, 600) нар Синзяны дөрвөд аман аялгуунд сулрах сулдахыг **сүлбэрхүй** гэдэг гэж тэмдэглэсэн байна.

402. Наху хуны гэдгийг хх-д 山名崖的 (хадат уулын нэр) гэж тэмдэглэжээ. Х.Пэрлээ (1958, 5) үүнийг "Одоо Лхаху буюу Лаху баян (уул) гэдэг. Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт бий" гэж тогтоосон байна.

403. Чакирма'уд гэдгийг хх-地名 (газрын нэр) гэж тэмдэглэжээ. Бид акад.Ц.Дамдинсүрэнгийн (1976, 145) "Цахир Могод" гэж буулгасныг зүйтэй гэж үзэж баримтлав. Х.Пэрлээ (1958, 9) "одоо Цахир мөөрс" гэдэг болжээ гэж тэмдэглэсэн байна.

404. Харахана йорчил йорчижу гэдгийг хх-叢草般行着去 (бөөн өвс мэтээр явж очиж) гэж орчуулжээ. Эл хэллэгийг олонхи судлагчид **харгана** хэмээх бутлаг ургамалтай шууд холбож үзсэн учраас голцуу харганын бут мэт бөөн бөөнөөр явах, эсвэл "цөөн цөөн хүнтэй бүлэг болж тарууу давшин явна (Гаадамба, 1976, 116)" гэх зэргээр таамаглан бичсэний аль аль нь төдий л оновчтой биш санагдана. Учир нь НТ-ны

"хархана ойрчижу" гэдгийг одоогийн аялгуунд үгчлэн буулгаваас "харганын явдлаар явж" гэсэн үг болно. Хэрэг дээрээ харгана "явдаггүй" болохоор судлагчид харгана бутны хэлбэр маягтай элдэв хоёроор холбон тайлбарлахад хүрчээ. Бидний санахад НТ-ны эхэд **харахана йорчил йорчиху** (харгана явдлаар явж) гэснээс үзсэн ч хх. орчуулгад "**бөөн өвс мэтээр явж**" гэснээс үзсэн ч эрх биш хөдөлгөөнийг өгүүлсэн нь илэрхий байгаа юм. Ийм учраас НТ-ны **харахана** гэдэг үгийг яг одоогийн **харгана** мэтээр ойлгож арай боломгүй санагдана. Харин харганын төрөлд хамаарах **хамхуул** өвсний хөдөлгөөнтэй үлгэрлэн өгүүлсэн байж болох юм. Харгана хэмээх нь өргөст бутлаг ургамалын ерөнхий нэр учраас XIII зууны үеийн монгол хэлд харгана, хамхуулыг аль алины нь эл ерөнхий нэрээр өгүүлдэг байсан байж болох талтай. Гэтэл НТ-ны 105-р зүйлд Жамухагийн элчээр илгээсэн үгд:

Хамха'улсан (хамхуул) хийсхүй дор
Хар ои тэмцэгч
Хаатаи Дармала эдүгээ
Харажи хээр буи за гэж өгүүлснээс үзвэл лав тэр үеийн хатгин аялгуунд **хамхуул** гэдэг үг яг одоогийн утгаар хэрэглэгдэж байсан нь илэрхий байна. Хэрэв тэр үеийн хэл аялгуунд харгана-хамхуул хоёрыг хутгаж байсан гэж үзвэл эл хэллэг нь "хамхуул мэт сэмээр хүрч очъё" гэсэн цэргийн давшилт хөдөлгөөнийг ёгт маягаар өгүүлсэн хэллэг байж болно. Ер нь Чингис хааны цэргүүддээ зарлиг болсон энэ үг бол дайсан этгээдрүү хэрхэн давших, байрлан орох, тулалдах аргыг тухайн үеийн цэргийн эрдмийн арга ухаанаар зааж сургасан үг учраас яг одоогийн ойлголтоор уг зүйлийн утга учир тайлбарлахад төвөгтэй гэдэг нь илэрхий билээ.

405. <u>**На'ур байиту байилдужу**</u> гэдгийг 海子般陣立着 (нуур мэт жагсааж) гэж орчуулжээ. Эл хэллэгийн байилдужу хэмээх нь байрлах, жагсаах гэсэн утгатайгаас гадна НТ-ны 129, 143-р зүйлд бас "байлдаж, тулалдаж" гэсэн утгаар гарч байгааг тэмдэглэе. Харин 195-р зүйлийн эл хэллэг нь "Нуур далай мэт өргөн жагсаалаар явж цүүц мэтээр дайсны голруу цөмрөн орж тулалдъя" гэсэн санааг илэрхийлж байна.

406. <u>**Көтөд**</u> гэдгийг хх-д 從馬(хөтөлгөө морьд) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний <u>**хөтөл-хөтөлгөө**</u> гэсэн үгийн олон тооны хуучин хэлбэр болно.

407. <u>**Мина'атан**</u> гэдгийг хх-做鞭有的(ташууртай) гэж орчуулжээ.

Энэ нь эдүгээгийн ойрдын аялгууны **малиа** (ташуур) гэдэг үгтэй язгуур нэгтэй ажээ. Эл үг НТ-ны 255-р зүйлд мөн ташуур гэсэн утгаар гарч байна.

Ибн-Муханны монгол үгст **мина** хэмээх нь гөрмөл суран ташуурыг хэлдгээс (Поппе, 1938, 441) үзвэл эл үг монгол хэл аялгуунуудад эртнээс нааш мина, малиа гэх зэргээр "н", "л" авиа сэлгэж дуудсаар иржээ. Бидний таамаглалаар малиа хэмээх нь гарлын хувьд **малига** буюу нэг зүйл тэнсэн модны нэрээс уламжлалтай байж магадгүй юм. (Сэцэнцогт, 1988, 1372-т үзнэ үү) Харин ойрд монгол, өөрлөгч зарим аялгуунд малиа гэх нь Ибн-Муханны монгол үгст гарч буй мина хэмээхтэй адилавтар утгаар голцуу гөрмөл суран ташуурыг хэлдэг байна.

408. <u>**(Х)арану**</u> гэдгийг хх-д 人的 (хүний) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний ард гэдэг үгийн ганц тооны хэлбэр юм. Эдүгээгийн ойлголтоор "хүн амьтны" гэсэн утгаар оржээ.

409. <u>**Бухсажу**</u> гэдгийг хх-д 拘束着俭 (хориглож, саатаж) гэж орчуулжээ. Эл үг гарлын хувьд эдүгээгийн монгол хэлний **буглах-бугших** гэдэгтэй үүсэл нэг бололтой. Энэ нь НТ-нд "торох, тээглэх" гэсэн утгаар гарч байна.

410. <u>**Торолун**</u> гэдгийг хх-疾癘 (түргэн шаламгай) гэж орчуулжээ. Элдэнтэй, Ардаажав (1986, 610) эл үгийн нангиад галигийг "ударулуны (斡脫ᵗᵃ羅俭)эндүү" гэж тэмдэглэжээ. Бидний ажиглахад уг үгийн утга нь нааш цааш сүлжин, тоглон гүйхийг илтэгсэн шинжтэй юм. XIII-XIY Зууны үеийн монгол бичигт "р", "га" үсгийг аль алины нь адилавтар хоёр богино шүдээр тэмдэглэх тул бичгийн хэлний **тогулан** гэсэн үгийг **торолун** (脫ᵗᵃ羅俭) гэсэн дуудлагаар галигласан байж магадгүй юм.

411. <u>**Уб**</u> гэдгийг хх-д 財物(эд хогшил) гэж орчуулжээ. Олонхи судлагчид эл үгийг хх.орчуулгыг баримтлан **өв** хөрөнгө гэсэн утгаар ухаарч "**үб тоног абугчин**" гэдэг хэллэгийг "өв хөрөнгө тонож дээрэмдэх" гэсэн утгаар ойлгож орчуулсаар ирсэн билээ. (364-р тайлбарыг үзнэ үү).

Бидний санавал эл үг нь орчин цагийн монгол хэлний улаан гэдэг үгийн хүч нэмэх тодотгол **уб** буюу **ув** гэдэг үг мөн бололтой. Уг шүлгийн холбоцын байдлыг ажиглахад "үб" (уб?) гэдэг үгийн өмнөх, хойтох мөрийн толгой холбон ижилсүүлсэн үг нь "**у**нагаж", "**у**рууд" гэдэг үгээр "у" авиагаар толгой холбосон тул бидний авч ярилцаж буй "үб

тоног" гэх нь яавч "өб тоног" биш "үб" юм уу "уб" гэсэн үг гэдгийг гэрчилж байна. Бас нангиад галигт "үб" 兀卜гэсэн дуудлагаар тэмдэглэсэн нь ч уг үгийн дуудлагыг нэлээд зөв гаргасан гэж үзмээр байгаа билээ. Тэрчлэн монгол шүлгийн эн зэрэгцүүлэн холбох зарчмын дагуу "**жадат** эр" гэсний дараа эн зэрэгцсэн мөр нь "**илдэт** эр" гэсний нэг адил "**цуст** тоног" гэдгийн эн зэрэгцүүлэн холбосон "**уб** тоног" хэмээгч нь "**цуст**" гэдэгтэй ойролцоо утга санаатай үг байх учиртай билээ. Ийм учраас "уб" хэмээх нь хурц улаан өнгийг илтгэх буюу цуст гэдгийг ёгт санаагаар илэрхийлсэн болов уу гэж санагдана.

Бидний хэлэлцэн буй шүлгийн энэ хэсгийг Бөххишиг (1941, 179) эдүгээгийн бичгийн хэлээр:

"Жадат эрийг зууж
Цуст тону тоногчин
Үлдэт (илд) эрийг үлдэж
Унагаж алж
Өвчин авагчин..." гэж хөрвүүлснээс үзвэл яавч уг үгийг "өв хөрөнгө" гэж ойлгоогүй нь тодорхой байна.

412. <u>**Өрэ-үлү жасажу**</u> гэдгийг хх-心不點有 (санаа сэтгэлд юу ч үгүй) гэж үгчлэн орчуулжээ. Өрэ хэмээх нь өр зүрх гэх буюу санаа сэтгэл гэсэн утгатай үг гэж хх. орчуулгыг туурвигч үзсэн нь магадтай. Гэвч өгүүлэн буй уг зүйлийн утга нь ходоод, гэдэс, хэвлийг нь үл засах буюу үл цадна гэсэн ойлголт гэдэг нь илэрхий байгаа билээ. Ийм учраас олонхи судлагчид "өр үл засрах" гэх юм уу ходоод гэдэс нь үл цадна гэж утгачлан орчуулж иржээ.

Монгол хэлд "р", "л" авиа сэлгэх тул бидний санавал "өрэ" хэмээх нь орчин цагийн монгол хэлний "өл" (өл хоол) гэдэгтэй холбоотой байж болох юм.

413. <u>**Анху'а**</u> гэдгийг 箭名(сумны нэр) гэж тэмдэглэжээ. Эл үг гарлын хувьд орчин цагийн монгол хэлний **ан** ац, **ан** завсар гэдгийн "ан" гэдэгтэй язгуур нэгтэй ажээ. өөрөөр хэлбэл "анху" буюу "анга" сум нь ан ац гаргасан сумыг хэлдэг байна. "Гучин зургаатын тайлбар толийн" цэрэг **зэвсгийн** зүйлд: "Ачатай сумыг **анга** суму хэмээмой. **Ачату** сум **анга** сумны адил бөгөөд доод хавчуу, өмнөх нь цалгар хойтох нь шувтан" гэж тайлбарлажээ. О.Ковалевскийн (1844, I, 17) "анга суму" хэмээхийг "Сэрээ шиг ац, салаатай сум" гэжээ.

414. <u>**Үлгэтэлэ**</u> гэдгийг хх-直穿了(шууд нэвтэлтэл) гэж орчуулжээ.

Уг үгийн хэлбэр агуулгыг ажиглахад энэ нь монгол бичгийн хэлний <u>элгүкү</u> гэдэгтэй холбоотой бололтой. Эл үг НТ-нд "нэвтлэх, шувтлах " гэсэн утгаар гарч байна.

415. <u>**Кэрэлдүксэн**</u> гэдгийг хх-д 相關的(хэрэлдэн тэмцсэн) гэж орчуулжээ. Энэ нь одоогийн монгол хэлний хэрэлдэх, маргалдах гэдэгтэй утга нийлнэ. Эл үг НТ-ны 228, 278-р зүйлд гаднах мянгатууд хишигтэн нартай мөчөөрхөн хэрэлдвээс хатуу цээрлэл үзүүлэх тухай өгүүлсэн байна.

416. <u>**Кэйибүр**</u> гэдгийг хх-д 箭名(сумны нэр) гэж тэмдэглэжээ. Мукаддимат Ал-адаб толины нэмэлт үгэнд **кэибүр** хэмээхийг оросоор "дротик" (хануур жад) гэж орчуулсан байна (Поппе, 1938, 404).

Эртний монгол хэлний кэйибүр гэдэг эл үг сүүлдээ **хайимугур-хаймур** гэж дуудагдах болсон бололтой юм. "Гучин зургаатын тайлбар толины" цэрэг зэвсгийн зүйлд: **Хайимугур** гэдгийг "Төмөр бяцхан иш нарийн хийж хаймсан харвахыг хайимугур хэмээнэ" гэжээ. (Лувсандэндэв, 1961, 1-9, 17). Мөн Шагжийн "Эрэхүй хялбар болгон зохиосон монгол үгний тайлбар чандманийн эрх хэмээгдэхээс ба, хагийн аймагт" эл үгийг "төмрөөр бяцхан нарийн үүсгэр хийж хаймсан харвахыг нь. Бас хайимур ч хэмээмой" гэжээ. Я.Цэвэл (1966, 644) "Монгол хэлний товч тайлбар тольдоо" **хаймуур** хэмээхийг "төмрөөр хийсэн хол харвах нарийн сум" гэж тайлбарласан байна. О.Ковалевскийн (1846, II, 711) тольд "гурван талт хошуу бүхүй нарийн сум" гэжээ. Монгол хэлд "б", "м" авиа сэлгэх учир **кэйибүр** гэсэн үг **хайимур** гэдэг дуудлагатай болж өөрчлөгдсөн гэхэд эргэлзэх шалтгаан үгүй бизээ.

417. <u>**Гүрүлгү мангус**</u> гэдгийг хх-д蟒名,蟒(аврага могойн нэр, аврага могой) гэж орчуулжээ.

Гүрүлгү хэмээх нь монгол бичгийн хэлний **гүрбэл** гэдэг үгийн хуучин хэлбэр ажээ. Чухамдаа энэ нь хүн амьтныг бүхлээр залгих аймшигт аврага гүрвэл буюу үлүг гүрвэлийг өгүүлсэн бололтой.

Одоогийн ойрдын зарим аялгуунд гүрвэл гэдэг үгийг НТ-нд өгүүлж буй **гүрүлгү** гэдэгтэй ойролцоо дуудлагаар хэлдэг байна. Жишээлбэл Синзяны Торгууд Жангарын туульд:

"Күмүний арьсан алгатай
Күрүл-үн арьсан сагалдрагатай
Айрастын хар товорцог" гэж Салхин Таваг баатрын ташуурыг дүрслэн өгүүлсэн буй (Буянхишиг, Бадам, 1982, 1, 449).

Дашрам тэмдэглэхэд орчин цагийн монгол хэлний **үлүг гүрвэл** хэмээхийн **үлүг** гэх нь эртний түрэг хэлний **улуг** буюу "агуу, том" гэсэн үгтэй гарал нэгтэй бөгөөд монгол бичгийн хэлний **үлү** (илүү) гэдэгтэй язгуур нэгтэй ажээ.

Мангус гэдэг нь үлгэр туульд гардаг аймшигт махчин амьтны тухай уран сайхны аргаар боловсруулсан дүр юм. Чухамдаа энэ нь үлүг гүрвэл, аврага могой мэтийн хөнөөлт амьтдын хүнчлэгдсэн дүр дүрслэл болно.

Үгийн гарлын хувьд мангус хэмээх нь Манж-Тунгус хэлний баримт сэлтээс үзвэл эвенк хэлний **Маңа** (хатуу, догшин, ховдог), солон хэлний **манде-манди** (хүнд хүчир), негидаль хэлний **манга** (хатуу, хүчирхэг, бөх) ороч хэлний **маңаси-манга** (хатуу, хүчирхэг, аймшиггүй), тэрчлэн удмурд, ульч, орок, нанай хэлнүүдийн ман,га (хэцүү бэрх, хүнд, бөх, хүчирхэг) гэдэг үгнээс эх сурвалжтай (Цинциус, 1975, 529) бөгөөд **маңга-маңгу** хэмээхийн олон тооны хэлбэр болно. Орчин цагийн монгол хэлд мангад, мангас гэх зэргээр олон тооны хэлбэрээр голчлон өгүүлэхийн хамт **Мангаа** гэсэн ганц тооны хэлбэрээр ч мэр сэр хэрэглэнэ. Энэ нь эдүгээгийн монгол хэлний тэнэг мулгуу гэсэн утгатай **мангар** гэдэг үгтэй холбоотой байж болох юм. Харин хятад хэлний аврага могой буюу (ман) гэдэг үгтэй ямар холбогдолтойг нарийвчлан судлах нь эл үгийн гарал, хувьсал хөгжлийн асуудалд чухал ач холбогдолтой болно.

418. Отчикин (х)эликэтү гэдгийг хх-д 人名肝有的 (хүний нэр, элэгтэй) гэж орчуулжээ. **(Х)элигэтү** хэмээх нь эдүгээгийн ойлголтоор элгэмсэг, энхрий, ойр дотно гэсэн утгатай юм. Өэлүн эхийн хамгийн бага хүү Отчигин ноёны нэр нь түрэг хэлний "от" буюу "гал" (Наделяев, 1969, 372) гэдэг үгтэй холбоотой, гал голомтоо сахих эзэн гэсэн утга санаагаар өгсөн нэр болно. Айл гэрийн гал голомтоор отгон хүүгээ нэрэлдэг энэхүү заншлын талаар Рашид Ад-дин (1952, т.1, 193) "Судрын чуулган" гэдэг түүхэн зохиолдоо мөн өгүүлсэн буй.

Монголчууд бага хүүгээрээ гал голомтоо залгуулна гэсэн эл уламжлалт санаагаар одоо ч хүртэл "Отгон, Отхон, Осгон" гэх зэргийн нэр өгсөөр байгаа билээ.

419. Бару'анача гэдгийг хх-д多處(олон зүйлээс, олон юмнаас) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний "хамаг, олонхи, ихэнх" гэсэн утгатай **баруг** гэдэг үгэнд гарахын тийн ялгалын "ача" дагавар

залгасан хэлбэр болно.

Дундад эртний монгол хэлд "г, х"-ээр төгссөн үгэнд харъяалагдах, гарах, өгөх оршихын тийн ялгалын дагавар залгахад тогтворгүй "н" нөхцөл гарах тохиолдол түгээмэл байжээ. Дундад эртний монгол хэлний үгийн эцсийн эл тогтворгүй "н"-ийн тухай проф. Хуан Зун жиан "Лү лун сай лүө" хэмээх толь бичгийн баримтанд судлагаа хийж 1987 онд Өвөр монголын Их сургуулиас зохион байгуулсан олон улсын монголын судлалын эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьсан байна.

420. Байдалача гэдгийг хх-立處 (жагсаалаас) гэж орчуулжээ. Энэ нь цэргийн байрлал, жагсаалыг өгүүлжээ. (405-р тайлбарыг үзнэ үү)

421. Хутахлалдужу гэдгийг хх-д орчуулаагүй байна. Үүнийг судлагчид голцуу "овоорох, дарагдах, давхарлалдах" гэх зэргээр утгачлан орчуулсан байна. Бидний бодлоор эл үг нь орчин цагийн монгол хэлний **хутгах-хутгалдах** гэдэгтэй гарал нэгтэй бөгөөд дээр дороо оролцох, даралцах гэсэн утгатай бололтой.

422. (Х)үнжи'ү байитала гэдгийг хх-д **(х)үнжи'ү** гэдгийг нь орчуулсангүй **байитала** хэмээхийг直到(болтол, хүртэл) гэж орчуулжээ. Харин эл хэллэгийг НТ-ны 247, 251, 272-р зүйлд爛木堆殺(өмх хожуул болтол) гэж орчуулсан байна. Энэхүү хадмал орчуулга нь уг зүйлийн утга санаанд яг нийлж байгаа учир бид үүнийг баримтлан дээрх хэллэгийг "**өмх хожуул болтол** даралцан үхцгээв" гэж хөрвүүлэв.

423. Жэткүкдэжү гэдгийг хх-д當着 (хоригдож) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний саад, тотогор гэсэн утгатай **зэтгэр** гэдэгтэй язгуур нэгтэй ажээ. Эл үг бас НТ-ны 251, 254, 281-р зүйлд "жэткүн, жэткүжү" гэсэн хэлбэрээр мөн хорих, саатуулах гэсэн утгаар гарч байна. Уг үг нь хожуу үеийн бичиг зохиолд ч мэр сэр тохиолддог ажээ. Жишээлбэл "Ирэхийг нь үл **зэтгэх,** одохыг нь үл түтгэх" гэсэн зүйр үгийг Сэцэнцогт (1988, 2367) "Язгуур үгийн тольд" иш татсан байна.

424. Үлү а'улху гэдгийг хх-不敎活(үл амьдруулна) гэж орчуулжээ. **А'улху** хэмээх нь одоогийн ойлголтоор "байлгах, суулгах, амар мэнд байх" гэсэн утгатай бололтой. Бид эл хэллэгийг утгачлан "амар заяа үзүүлэхгүй" гэсэн үгээр хөрвүүлэв.

425. Мара'ан асахжу гэдгийг хх-仔細問着(нарийн нямбай асууж) гэж орчуулжээ. Энэ нь нягтлан асуух, шаргаан асуух гэсэн утгатай

бололтой. **Мара'ан** гэдэг үгийг бид гарлын хувьд орчин цагийн монгол хэлний **махран** гэдэгтэй язгуур нэгтэй байж магадгүй гэж таамаглаж байна. Учир нь орчин цагийн монгол хэлд: "бархирах-бахирах, турхирах-тухирах" гэх мэтээр "р", "х" авиа байр солигдон хэлдэгтэй ойролцоо үзэгдэл байж болох юм.

426. Түйкуи-тур гэдгийг хх-生襄 (түүхийд) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний **түкүкэи** гэдгийг дундад эртний монгол хэлд ийм маягаар дуудаж байсныг хадгалсан байдалтай юм.

Орчин цагийн монгол хэлд эл үг хоёр гол утгатай:
1) Яр түүхий, 2) Чанаж болгоогүй зүйл. Жишээлбэл **түүхий** мах г.м. Харин НТ-нд өгүүлж буй "самуунд, түүхийд" гэх нь эл хоёр утгын аль алинаас нь арай ондоо "буруу бусцар, болчимгүй муу явдалд" гэсэн утгатай ажээ. Энэ нь одоогийн ярианы хэлний дутуу дулимаг гэсэн утгатай "**түргэн түүхий**" гэдэгтэй ойролцоо утгатай юм.

427. Марийан гэдгийг хх-д 皮膚(арьс, мах) гэж орчуулжээ. Энэ нь махбод бие, цогцос гэсэн утгатай бөгөөд орчин цагийн монгол хэлд унаган тарга хүчийг голчлон өгүүлдэг байна. Жишээлбэл **мариа** муутай хүүхэд гэвэл эцэнхий хүүхэд гэсэн утгатай үг болно. Мөн ярианы хэлд мах **мариа** гэж хоршин хэлэх (Цэвэл, 1966, 332) ч бий.

Эл хэллэгийг акад.Ц.Дамдинсүрэн "Одоо энэ Наяа ноёноос асуухын оронд хаан соёрохвол тэнгэрээс заяасан, эцэг эхээс төрүүлсэн **махбодыг** минь шалгаж үзтүгэй" гэж хөрвүүлсэн байна.

428. Таихал гэдгийг хх-山頂 (уул орой, царам) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний ой хөвч бүрхсэн аглаг уулын нэр буюу **тайга** гэдэг үгийн эртний хэлбэр ажээ. "Монгол үгсийн язгуурын тольд" Халил хадтай уул хөвч, **тайгал** ч гэнэ (Сэцэнцогт, 1988, 1757) гэж тэмдэглэсэн буй. Энэчлэн якут хэлд монгол хэлнийхтэй ойролцоо "тайга" гэдгээс үүссэн уул уурхай гэсэн утгатай "**тайгала**" (Пекарский, 1917, 2526) гэсэн үг байдаг нь бас анхаарууштай сонин баримт юм.

429. Шиба-йин сумуна гэдгийг хх-亂箭的箭 (зэрлэг сум, олон сум) гэж орчуулжээ. НТ-г орчин цагийн монгол хэлээр хөрвүүлсэн олонхи судлагчид эл үгийг хх.орчуулгын эхний утгыг баримтлан "зэрлэг сум", "самуун сум" гэсэн үгээр буулгасан байна. Бидний санахад хх.орчуулгад "олон сум буюу бутарч гарсан сум" гэсэн утгатай үг нэмэлт болгон оруулсан нь маш сонирхолтой бөгөөд энэ нь чухам эл үгийн утгыг зөв тодорхойлсон байдалтай санагдана. Чухамдаа **шиба-йин**

сумун гэх нь **шивэх** гэдэг үгнээс үүсэлтэй **шивээ** өвстэй адилтган өгүүлсэн бололтой юм. Шивээ өвс бол маш олноор хонь малын үсэнд шивж орж үр тоосоо дамжуулдаг ургамал билээ. Олон олноор бутран гарч шивэх сумыг эл шивээ өвстэй адилтган өгүүлсэн байж болно.

Хуучин цагт хүнд ялтай хүнийг цаазлах мэтэд олон хорчин эгнэн зогсож зэрэг зэргээр харавдаг байжээ. Ийнхүү олон олноор угсран гарах юм уу бутран гарах сумыг "**шивээн сум**" гэдэг байсан бололтой.

430. Чуб тусчу гэдгийг хх-д 沉落着(живж унаж) гэж орчуулжээ. Эл хэллэгийг олонхи судлагчид "живж орж", "живж унаж" гэж ухаарч орчуулсаар иржээ. Энэ нь нэг талаас хх.орчуулгыг баримталсан нөгөө талаас "**чуб**" хэмээх үгийг **живэх** гэдэг үгийн үндэс мэтээр ойлгосноос болсон бололтой. Тухайлбал Элдэнтэй, Ардаажав (1986, 630) нар үгийн язгуур нь "чиб-чибкү" гэдгээс "жиб-жибкү" болсон мэтээр үзэж усанд живэх гэж тайлбарласан байна. Бидний бодлоор **чуб** буюу **чөб** хэмээх нь орчин цагийн монгол хэлний **живэх** гэдэг үгтэй язгуур нэгтэй бус харин **цөмрөх** гэдэг үгтэй үндэс нэгтэй гэж үзмээр байна. Монгол хэлд хоёр уруулын "м", "б" авиа сэлгэх тул монгол бичгийн хэлний "**чөм** тусах" гэдгийг "чүб тусах", "чөб тусах" гэж хэлэх бүрэн үндэстэй болно.

Үүний нөгөө талаар Найман, Мэргид аймгийнхны Эрчис мөрөн гэтлэн зугадсан тэр цаг болбоос хаврын яг цас мөс гэсэх үе тул олон хүн цөмөрч унасан байж болох талтай. Энэ мэтээс үндэслэн бид эл хэллэгийг "цөм тусч" гэх буюу "цөмөрч унаж" гэсэн утгаар ойлгож байна.

431. Ханлин гэдгийг хх-д 種名(овог аймгийн нэр) гэж тэмдэглэжээ. Үүнийг Иринжин (1987, 183) "Төв азийн аймаг иргэний нэр, Ханлиныг Үнг улсын үеэс Хангин(杭斤) гэж өөрөөр бичдэг. Одоогийн Ордосын Хангин хошуу бас Хангин гэдэг монгол овог энэ Хангианаас үүсэлтэй" гэж тайлбарлажээ.

432. Тэмүр тэрэгэту гэдгийг хх-鐵車子有的(төмөр тэрэгтэй) гэж орчуулжээ. Одоогийн ойлголтоор ердийн хөсөгний тэргийг модон тэрэг, төмөр тэрэг гэж хоёр зүйл хуваах бөгөөд төмөр тэрэг нь дугуйны мөөр модыг цагираг төмрөөр бэхэлснийг хэлнэ. XIII Зууны үеийн аян дайнд хэрэглэж байсан "төмөр тэрэг" ч мөн иймэрхүү маягийн тэрэг байсан бололтой.

433. Охжаджу гэдгийг хх-д 驚着 (үргэж, сочиж) гэж орчуулжээ. Үүний язгуур нь орчин цагийн монгол хэлний **огцом-огзом** гэдэгтэй

холбоотой бололтой. Чухамдаа энэ нь "үргэж сочиж, ойлж цойлж одлоо" гэсэн утгатай юм. Эл үг НТ-ны 230-р зүйлд **охжадхахсан** гэсэн хэлбэрээр бас гарч байна.

434. Харбучажу гэдгийг хх-相射着 (харвалцаж) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний үйлдэх хэвийн нөхцөлд буй **"харвалцаж"** гэсэн үгийн хуучин хэлбэр болно.

435. Чалир гэдгийг хх-д 鐵鍬(төмөр хүрз) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **царил** гэдэг үгийн хуучин хэлбэр болно. Монгол хэлд "гурил-гулир" гэх мэтчилэнгээр "р", "л" авиа сэлгэх хуулиар дундад эртний монгол хэлд эдүгээгийн "царил" гэдэг үгийг **чалир** гэдэг байсан байна.

436. Гөлми гэдгийг хх-旋網 (цагираг тор) гэж орчуулжээ. Монгол хэлний одоо үеийн толь бичгүүдэд ч эл үгийг тайлбарласан буй.Тухайлбал Цэвэл гуай (1966, 153) үүнийг "загас агнахад хэрэглэх их өөш" гэсэн байхад Сэцэнцогт (1988, 1309) "загас шувуу агнах их өөш, **гөлмэ** ч гэнэ" гэсэн байна. О.Ковалевскийн (1849, III, 2606) тольд **"гүлми, гүлмэ"** гэдгийг "Загас барих том тор" гэжээ.

437. Хучи'атхун гэдгийг хх-д 省措您(аривлан хайрлагтүн) гэж орчуулжээ. Уг үгийн гарлыг бид эдүгээгийн **хучих-хучаас** гэдэг үгстэй язгуур нэгтэй байж магадгүй юм гэж таамаглаж байна. Учир нь НТ-ны 255-р зүйлд **"хучи'асу"** гэдэг үг монгол бичгийн хэлний **"хучибасу"** гэсэн утгаар хэдэн удаа гарч байгааг тэмдэглэе. Харин НТ-ны 199-р зүйлд эл үг "хямгадах, гамнах, аривлах" гэсэн утгаар гарч байна.

438. (Х)а'улхатхун гэдгийг хх-д 教走馬您(мориор гүйлгэгтүн, давхиулагтүн) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **уулгалан** хөөх, **уулгалан** дайрах гэсэн үгийн хуучин хэлбэр болно.

439. Кэмлэжу гэдгийг хх-д 限着 (хэмжиж, хязгаарлаж) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **хэмнэж** гэдэг үгийн "н" авиа "л"-ээр солигдсон хэлбэр юм. Энэ мэтээр үгийн дунд "н", "л" авиа сэлгэх үзэгдэл дундад эртний монгол хэлд түгээмэл байсан бололтой. Жишээ нь НТ-ны 140-р зүйл дэхь **кинжас** (гилжис), 199-р зүйлийн Танглу (Тагна) гэсэн үгсийг дурдаж болно.

440. Хада'ар гэдгийг хх-д 巖頭 (хазаар) гэж орчуулжээ. Энэ нь дундад эртний монгол хэлд үгийн дундах "д", "з" авиа сэлгэснээс монгол бичгийн хэлний **хажагар** гэдгийг **хада'ар** гэсэн маягаар дууддаг байсныг гэрчилж байна. Үүнтэй төстэй үзэгдлийг бид бас НТ-ны 56-р зүйлийн

дэргэчэжү (зэрэгцэж), 78-р зүйлийн **нөдүн** (нөжин) гэсэн үгсээс ажиглаж болно. Элдэнтэй, Ардаажав (1986, 638) уг үгийн тайлбар өгүүлэлдээ дагуур хэлд хазаарыг **хадал** гэдэг гэж тэмдэглэжээ.

441. Суталбижу гэдгийг хх-д 不開口着(амгайлах үгүй) гэж орчуулжээ. Эл үг гарлын хувьд орчин цагийн монгол хэлний "суллах-султгах" гэдэгтэй язгуур нэгтэй байж болно. Бидний бодлоор НТ-ны "хада'ар үлү нэмүргэн **суталбижу** (сул талбиж) йабутухаи" гэсэн хэллэг нь "хазаар үл нөмөргөн (өмсгөх, зүүх) **амгайвчилж** явтугай" гэсэн утгатай ажээ. Мөн эдүгээгийн дагуур хэлд морины амгай мултлахыг **содолбигу** гэдэг байна (Элдэнтэй, Ардаажав, 1986, 639).

442. Ниситухаи гэдгийг хх-д 打着 (цохитугай) гэж орчуулжээ. Энэ нь гарлын хувьд монгол бичгийн хэлний **нислаху** гэдэгтэй язгуур нэгтэй бололтой. Хуруугаар няслах нь цохих, зодохын нэг хэлбэр юм. Уг үг НТ-ны 227, 240-р зүйлд **нисигдахун, нисит-жэ, нисихуйа** гэсэн хэлбэрээр гарч байгааг тэмдэглэе.

443. Мөсэлдүкүн гэдгийг хх-д 分離(*салан одох*) гэж орчуулжээ. НТ-ны хх.орчуулгад:

Мүрэнү чина'ун
Мөсэлдүкүн та
Мүн йосу'ар йабутхун
А'улайин чина'ун
Алхасалтухун та
Ангкита өэр бү сэткиткүн! гэсэн шүлгийн "мөсэлдүкүн", "алхасалтухун" гэсэн хоёр үгийг яг адил (салан одох гэсэн утгаар) үгээр орчуулснаас үзвэл бидний ярилцаж буй "мөсэлдүкүн" хэмээх нь "алс зайтай явах, салгуу хол явах" гэсэн утгатай ажээ.

444. Үжү'үлэн гэдгийг хх-д 直到頭 (үзүүрт нь хүртэл) гэж орчуулжээ. Нангиад хадмал орчуулга хийгээд олонхи судлагчдын орчуулсан байдлаас үзэхэд энэ нь туйлд нь хүртэл гэх буюу эцсий нь үзүүлэхээр илгээв гэсэн утгатай бололтой. Харин үүнийг Бөххишиг (1941, 140) Алтан-Очир (1942, 141) нар "төмөр тэрэг" гэсэн дараах үгтэй нь холбон "үзүүрийн төмөр тэрэг" гэж хөрвүүлсэн байна.

445. Ча'ура'улбаи гэдгийг хх-д 教出征了 (дайнд мордуулав) гэж орчуулжээ. Энэ нь дайсан этгээдийг хөөн нэхүүлэх буюу эзлэн авахуулахаар аян замд цэрэг хөсөг хөдөлгөхийг заасан нэр томъёоны

шинжтэй үг бололтой. Эл үг бас НТ-ны 202, 235, 240, 254-р зүйлд дайн тулаанд мордох, аялах гэсэн утгаар гарна.

446. Танглу гэдгийг хх-д 山名 (уулын нэр) гэж тэмдэглэжээ. Энэ нь одоогийн ЗХУ-ын Тагна Тувагийн нутагт орших Тагнын уулыг өгүүлсэн байна. Х.Пэрлээ (1958, 9) "Одоо Тагна уул буюу Тагнын нуруу гэдэг" гэж тэмдэглэжээ.

447. Харамбаи гэдгийг хх-黑鴨名 (хар нугасны нэр) гэжээ. Энэ нугас гэдэг үгийн тодотголын үүргээр оржээ. Уг шүлгийн эн зэрэгцүүлэн холбосон бадгийн "борчин соно" хэмээхийн "борчин" гэдэг үг ч мөн бор борхон өнгө зүс заасан тодотголын үүрэгтэй байгаа юм. Гэхдээ **харамбай** гэх нь харын эр хүйсийг, борчин гэх нь борын эм хүйсийг заасан тодотгол бололтой.

448. Борчин хуладу гэдгийг хх-д 鳥名 (шувууны нэр) гэж тэмдэглэжээ. (153-р тайлбарыг үзнэ үү).

449. Борчин соно гэдгийг хх-д 鴨名(нугасны нэр) гэж тэмдэглэжээ. Элдэнтэй, Ардаажав (1986, 644) эл үгийн тайлбар өгүүлэлдээ: "Түрэг хэлний соно-сона хэмээх нь эм нугас (Радлов, 1898, IY, 539). Бичгийн хэлний боржин нугас нь тэжээвэр нугастай адилавтар, бас тармин нугас хэмээнэ" гэжээ. Бидний саналаар борчин гэх нь соно буюу бор нугасны зүс болоод хүйсийг ялгаруулан заасан тодотгол үг юм. Энэ нь орчин үеийн монгол хэлний борогч-борогчин гэдэгтэй адилавтар утгатай болно.

450. Нэкүн гэдгийг хх-家人 (гэрийн хүн, эгэл хүн) гэж орчуулжээ. Энэ нь зарц, шивэгчин, харц гэсэн утгатай үг бололтой байна. Эл шүлгийн эн зэрэгцүүлэн холбосон өмнөх бадагт:

"Хара кэри'э
Харамбай нугусу бариху болба
Харачу бо'ол
Хан дурийан гар күр экү болба" хэмээн

шүлэглэснээс үзсэн ч хх. орчуулгад эл үгийн утгыг зөв гаргасан нь мэдэгдэж байна.

Уг үг гарлын хувьд манж хэлний "боол, шивэгчин" гэсэн утгатай **нэху** (Цинциус, 1975, 617) гэдэг үгнээс гарсан болов уу гэж үзсэн саналыг бид бас зүйтэй бололтой гэж үзэж байна. Эл үгийг монгол хэлний "Хорин нэгтийн тайлбар тольд" "боол нэкүн" гэсэн хоршоо үгийн хэлбэрээр тэмдэглэсэн байдгийг Элдэнтэй, Ардаажав (1986, 644) нар

мөн дурджээ.

451. Будун гэдгийг хх-д 本 (уг, үндэс) гэж орчуулжээ. Хятад хэлний энэхүү 本(бэн) хэмээх үсэг нь уг, үндэс, тус, энэ, өөрийн гэх зэрэг олон утгатай тул чухам ямар утгаар нь онооснуг нь бид зөвхөн таамаг төдийгөөр "уг үндэс" гэж бичив. Үүнээс гадна НТ-ны 103-р зүйлд бидний ярилцаж буй энэхүү **будун** гэдэгтэй адил дуудлагатай "不敦" гэдгийг хх.орчуулгад мөн 本(бэн) гэсэн үгээр орчуулсан нь анхаарал татаж байна. Учир нь НТ-ны 103, 200-р зүйлд гарч буй **бүдүн** буюу **будун** эл хоёр үг нь дуудлага адил боловч утга ондоо үг шиг байгаа юм. Энэ өгүүлж буй зүйлийн ерөнхий утга санаа, шүлгийн холбоц, логик холбоо тэргүүтнээс тийм сэтгэгдэл төрж байгаа юм. Үүний нөгөө талаар НТ-г орчин цагийн монгол хэлээр буулгасан хүмүүс голцуу эл хоёр үгийг ялгахыг оролдсон байна. Тухайлбал: Алтан-Очир бүдүгүн-будун, Бөххишиг будун-бодуту, Ц.Дамдинсүрэн бүтэн-бодот, Баяр будан-будун, Дугаржав бүтэн-бүдүчэ гэх зэргээр ялгамжаатай авч үзжээ.

Харин эл үгсийг Элдэнтэй, Ардаажав (1986, 243, 644) аль алиныг нь "будун" гэж буулгаад уг үгийн утгыг "Цавчаал боомтын бичигт" гардаг "бүтэн, бүрэн, төгс" гэсэн утгатай **будан** хэмээх үгтэй холбон тайлбарласан байна. Бидний саналаар эл үг нь монгол үлгэр туульд гардаг Бодон-будан гэдэг үгтэй холбоотой байж магадгүй юм. Энэ нь одоогийн халимаг ойрдын хэл аялгуунд "баатар" гэсэн утгатай болжээ. (Муниев, 1977, 104)

452. А'үлтаху гэдгийг хх-教存的(байлгаж болох, багтааж болох) гэж орчуулжээ. Энэ нь "агуулах, багтаах" гэсэн утгатай юм.

453. Хахалдажу гэдгийг хх-д分着(хагасалж) гэж орчуулжээ. Эл хэллэг нь хөнжлөө хагасалж, хувааж нөмөрч гэсэн утгатай ажээ. Энэ нь гарлын хувьд орчин цагийн монгол хэлний **хагаслах - хагалах** гэдэгтэй нэг язгууртай бололтой.

454. Ахтажу'у гэдгийг 被住着有來 (хонож байлаа) гэж орчуулжээ. Угтаа эл үгийн үндэс нь монгол бичгийн хэлний ахү буюу байх, орших, суух гэсэн үгтэй язгуур нэгтэй болно.

455. Халитун гэдгийг хх-親近(ойртох дотносох) гэж орчуулжээ. Энэ нь монгол сонгодог бичгийн **хабитун** гэдэг үгийн дундах "б"- "л" авиа солигдсон хэлбэр болно. Элдэнтэй, Ардаажав (1986, 651) нар "дагуур хэлд **халидагү** хэмээх нь хавьцах, хяхах, албадах, шахах, ойртох, хавьтах гэсэн утгатай" гэж тэмдэглэжээ.

456. Жа(х)ин гэдгийг хх-д 庶襟(дотоод энгэр) гэж орчуулжээ. Уг шүлгийн эн зэрэгцүүлсэн холболт хийгээд ерөнхий утга санааг нь нягтлан үзвэл хх.орчуулгыг бид зүйтэй гэж үзэж байгаа тул Элдэнтэй, Ардаажав (1986, 653) нарын хятад орчуулгыг буруутгасантай санал нийлэхгүй байна. Учир нь Элдэнтэй, Ардаажав нарын гэрийн үүд хаалгыг заасан **жашин** хэмээх үг нь бидний санавал төвд хэлнээс монголд шарын шашин дэлгэрэх үеэс орж ирсэн үг шиг байгаа юм.

Хуацай Дугаржав (1984, 171) НТ-ны орчин цагийн монгол хэлний хөрвүүлэгтээ эл үгийг **жашим** гэсэн үгээр буулгаад үүнийгээ эгэм гэсэн утгатай гэсэн байна. НТ-ны "жаха-йин бө'эсүн, жахин-ун чину өрүгэсүн болху би" гэсэн эл үг нь одоогийн "нүдэнд орсон хог, шүдэнд орсон мах" гэдэгтэй адилавтар утгатай зүйр үг ажээ.

457. Эмэгэ гэдгийг хх-д 婆婆(эмэг эх) гэж орчуулжээ. Бидний саналаар эл үгийн хх.орчуулга нь баахан эргэлзээтэй санагдана. Эл үгийг бид монгол бичгийн хэлний **эмгэг** (гэм зовлон) гэдэгтэй гарал нэгтэй болов уу гэж таамаглаж байна. Ийм учраас эрдэмтэн Мансааны (1985, 246) "арга **гэм** арвин болой" гэж хөрвүүлснийг бид уг үгийн утгыг ерөнхийдөө зөв гаргасан гэж үзэж байгаа билээ.

458. Күлүк гэдгийг хх-д 俊傑(мэргэн сэцэн) гэж орчуулжээ. Энэ нь эртний монгол түрэг хэлний шандас сайт хүлэг морь, эрэлхэг баатар гэсэн утгатай үг бололтой (Пекарский, 1917, 1132; Наделяев, 1969, 314; Цэвэл, 1966, 709; Сэцэнцогт, 1988, 1166).

Олонхи судлагчдын 1308 онд Чойжи-Одсэр бандидагийн орчуулсан гэж үздэг "Банзрагчийн" төгсгөлийн шүлэгт Хайсан Хүлэг хааны нэрийн тухай

"Көбэгүн чаг-ачаган бүгэд уридус-тур
Көшигүркэгсэн-и күлүг-ийэн үлүтгэжү
Гүр улус-ун эжэн болгагдажу бүрин-э
Күлүг хаган кэмэн алдаршигсан кэн бүгэсү" гэж магтан шүлэглэсэн буй.

459. (Х)үлэкдэбэ гэдгийг хх-д 被勝了(дийлэгдэх, ялагдах) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний үлдэх (хоцрох) гэдэг үгтэй язгуур нэгтэй бөгөөд "дийлэгдэв, хоцрогдов, үлдэгдэв" гэсэн утгатай болой.

460. Домохчи гэдгийг хх-д好長話(муу амтай, муу хоншоортой) гэж оновчтой орчуулжээ. Уг үгийг олонхи судлагчид орчин цагийн монгол

хэлээр **домогч** (үлгэр домог хэлдэг хүн мэтээр) гэж хөрвүүлсэн нь чухам байдалд авцалдаагүй санагдана. Эл үгийн тухай Бээжингийн төвийн Үндэсний дээд сургуулийн дэд проф. Хишигтогтох надад "энэ нь Убаши Хун тайжийн туужид гардаг "домогч хүү" гэдэг үгтэй холбоотой байж магадгүй юм" гэсэн чухал санааг хэлж өгөв. "Убаши Хун тайжийн туужид" ойрдын нутгаас олдсон долоон настай хүү цаазлуулахдаа ерөөл хэлэх нэрийдлээр:

"Убаши Хун тайжийн
Хар цусыг асгаруулав
Харцага ясыг дэрлүүлэв
Хар тугийг нь
Хамгийн хаалганд (олны замд)
Хугачин хаяв" гэх зэргээр чухам хараал тавьж үхсэн тул түүнийг "домугчи көбэгүн" гэж нэрийдсэн нь үнэхээр "хараалч хүү" буюу "чалчаа хүү" гэсэн үг байж болох юм. Бидний санавал эл үгийн гарал нь **дом-домнох** гэдэгтэй язгуур нэгтэй бөгөөд үг хэлээр хүнийг эмээн сүрдүүлэгч хараалч, зүхэлч гэсэн үг бололтой байна.

461. Өлүг йасун гэдгийг хх-д 死骨 (үхдэл яс) гэж орчуулжээ. Үүнийг зарим судлагчид эдүгээгийн аялгуугаар өлүг-оруг, эрүгэ гэсэн дуудлагаар буулгасан үзэгдэнэ (Бөххишиг, 1941, 194; Алтан-Очир, 1942, 145). Монгол хэлд "р", "л" авиа сэлгэх үзэгдэл түгээмэл байх тул үнэхээр эл үгийг **оруг** юм уу **аруг** (араг яс?) гэсэн дуудлагаар уншиж болох юм.

462. Турух гэдгийг хх-д遠(удаан, өнөд) гэж орчуулжээ. Эл зүйлд өгүүлж буй э'үрэ турух хэмээх нь "үүрд мөнх, үүрд орших" гэсэн утгатай байна (Элдэнтэй, Ардаажав, 1986, 656).

463. Төлгэ гэдгийг хх-д 卦(мэрэг, төлөг) гэж орчуулжээ. НТ-ны эл зүйлийн "үкү'үлйа гэ'эсү **төлгэ-түр** үлү оромуи" гэсэн нь "үхүүье гэвээс мэрэг төлөгт үл бууна" гэсэн утгатай юм.

464. Күндү мөртү кү'үн буи гэдгийг хх-д 重道子有的人有(хүнд мөртэй хүн болой) гэж яг үгчлэн орчуулжээ. Эл хэллэгийг зарим судлагчид "дээд язгуурт хүн", "хүн ёсыг олсон хүн" гэх зэргээр Жамухааг эрхэмлэн хүндэтгэсэн утгатай үг мэтээр үзэж хөрвүүлсэн нь чухам байдалд арай таармааргүй санагдана. Бидний санавал "хүнд мөртэй хүн буй" гэх нь "хүнд ялтай, хүнд гэмтэй" гэсэн санааг илэрхийлсэн "хар мөртэй" буюу "муу явдалтай хүн" гэсэн утгатай ойлголт шиг байгаа юм. Учир нь Чингис хаан "шалтгаан үгүй аминд хийвээс үл зохино"

гээд "Хүнд мөртэй хүмүүн буй. Энэ магад шалтгааныг нь [олж] үхүүлэгтүн" гэсэн үг бол Жамухааг үхүүлэх шалтгаан бол түүний урьд өмнө хийсэн муу үйл буюу "хүнд мөр" нь мөн бололтой байна.

465. Буру'уйа булха көйиджү гэдгийг хх-д 特地行反謀起着 (санаатайгаар өдөөн тэмцэж) гэж орчуулжээ. Бид эл хэллэгийг хх.орчуулга хийгээд судлагчдын хөрвүүлгийг харгалзан "бурангуй санаа өвөрлөж" гэж буулгав.

466. Баридхун гэдгийг хх-д 拿您(хураах, авах) гэж орчуулжээ. Энэ нь "яс барих" буюу оршуулах гэсэн утгатай үг болно.

467. Йэсүн көлтү чага'ан туг гэдгийг九脿有的白旄纛 есөн хөлт цагаан их туг) гэж орчуулжээ.

Монголчуудын тооны бэлэгдэлд гурав болоод түүний үржвэр есийн тоог ихэд эрхэмлэн үздэг уламжлалтай билээ. Рашид Ад-диний (1952, 1, 146) "Судрын чуулганы" орос орчуулгын тайлбарт Б.И.Панкратов нар "Түрэг монголчууд есөн зүйлийн бэлгийг хэзээнээс эрхэмлэж ирсэн" гэж тэмдэглэсэн байна. "Есөн хөлт" гэх нь "Эрдмийн товч" зэрэг монгол түүхийн сурвалж бичигт тэмдэглэснээс үзвэл "есөн уяат" юм уу "есөн манжлагат" гэсэн үг шиг байгаа юм. Бас зарим судлагч "есөн хөлтийг" "есөн хөхөлт" гэж үздэг санал ч бий. Бидний бодлоор уяа унжлагыг монгол хэлд мөн **хөл** гэж өгүүлдэг учраас "есөн хөлт" гэдэгт эргэлзэх учиргүй бизээ. Харин туг гэдэг үгийн хувьд бол монголчууд эрт дээр цагаас сүлд тугаа адууны дэл сүүлийг туг тугаар (багц багцаар) боож хийх тул үүнээс гаралтай болох нь илэрхий.

468. Хан гэдгийг хх-д 皇帝(хаан) гэж орчуулсан нь зүйтэй ажээ. Чингисийг хамаг монголын хаанаар өргөмжилсөн тул "хан" гэх бус чухам хаан гэж тэмдэглэвэл зохих ажээ. Цэнд гүн [1997, 427] "Чингис хаанаа хаан нэр тэнд өгөв" гэж буулгасан байна.

469. Гүи онг гэдгийг нангиад гаралтай үг тул хх-д орчуулаагүй байна. Энэ нь хятад хэлний 國王 (гүө ван) буюу "улсын эзэн, улсын ван" гэсэн үг болно. НТ-ны чухам жинхэнэ эхэд тэр цагт Мухалид ийм цол олгосон тухай өгүүлсэн эсэхийг нягтлан судлах чухалтай юм.

470. НТ-ны 202-р зүйлд өгүүлж буй Олар күрэкэн, Буха күрэкэн, Аших күрэкэн, Хадан күрэкэн, Чикү күрэкэн, Алчи күрэкэн, Буту күрэкэн, Алахуш Дигид Хури күрэгэн гэсний аль алиныг нь хх.орчуулгад зөвхөн 人名(хүний нэр) гэж тэмдэглэжээ. Чухамдаа энд нэр дурдсан мянгатын ноёд бол Чингис хааны ураг төрлөөс бэр буулгасан хүргэд болно.

Эдгээр хүргэддээ Чингис хаан зарлиг соёрхол айлдсан тухай НТ-ны 203-р зүйлийн эхэд тэмдэглэсэн байна.

471. Ши'эктэ гэдгийг хх-д 尿壺 (шээсэн сав, шээсэн уут) гэж орчуулсныг бид ерөнхийдөө зөв гэж үзэж байна. Учир нь **ши'экэ** буюу **шээг** хэмээх нь малын бөгсөнд шээс баас холилдон чээгэрч нэг уут, сав мэт бөөн бөөн юм болох тул "шээсэн уут, шээсэн сав" гэж төсөөлж болох юм. Ийм учраас бид Элдэнтэй, Ардаажав (1986, 677) нарын "хадмал орчуулгад шээсний сав (尿壺) хэмээсэн нь зохимж үгүй" гэдэгтэй санал тохирохгүй байна.. Энэхүү **шээг** гэсэн үгийн салаа утгыг Сэцэнцогт (1988, 1577) 1. Хонь малын сүүлэнд наалдсан бөөн баас, 2. *Малын гэдсэн дотор хатууран бөөгнөрсөн үс ноосны бөөн гэх зэргээр* тайлбарлаад уйгар түрэг хэлд мөн "сигек-сийгек" гэнэ гэж тэмдэглэжээ. Тэрчлэн эдүгээгийн буриад хэлд **шээг** хэмээх нь эм мал адгуусны бэлэг эрхтнийг хэлдэг байна (Черемисов, 1973, 752).

НТ-г монгол бичгийн хэлээр хөрвүүлсэн буюу сэргээн буулгасан судлагчдаас Бөххишиг, Баяр, Элдэнтэй, Ардаажав, Иринжин нарын эрдэмтэд **"шигэг"** хэмээн зөвөөр сийрүүлснийг тэмдэглэе.

472. Алжи'ас гэдгийг хх-д 差(буруу, гажуу) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний алдаа (эндэгдэл) гэдгийн олон тооны эртний хэлбэр юм. Эл үг бас НТ-ны 281-р зүйлд хэдэн удаа гарахдаа одоогийн "буруу алдаа" гэдэг шиг "буру'у алжи'ас" гэсэн холбоо үгийн хэлбэрээр тохиолдож байна.

473. Гэткибэ гэдгийг хх-д 踏了 (гишгэв) гэж орчуулжээ. Энэ нь эдүгээгийн монгол хэлд "хасгах-хатгах, хавдах-хавсах, өвдөх-өвсөх"г.мэтээр "с", "т" буюу "с", "д" авиа сэлэгдгийн нэгэн адил "т", "ш" хоёр авианы хувирлаас шалтгаалсан байна. Одоогийн барга аялгуунд **гишиг** гэхийг **гэтги** гэдэг байна (Элдэнтэй, Ардаажав, 1986, 678).

474. Орочу гэдгийг хх-д 晚生的(орой төрсөн) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний "хэнз", "отгон" гэдэгтэй ойролцоо утгатай бөгөөд гарлын хувьд **орой** хэмээх үгтэй язгуур нэгтэй бололтой. Эл үгийг А.Мостарт (1942, 522) ордос аялгууны орой гарсан унага, тугал зэргийг **орочо** гэдэгтэй эн тэргүүнээ холбож үзсэн билээ. Мөн Элдэнтэй, Ардаажав, Мансаан нарын судлагчид эл үгийн тайлбар өгүүлэлдээ ордос аялгуунд орой гарсан төл малыг **орочу** хэмээдэг гэж тэмдэглэжээ.

Хэрэв Ш.Гаадамбын (1990, 138) "Орочи" гэж сийрүүлснийг зөв

гэж үзвээс энэ нь О.Кавалевскийн (1844, 460) тольд буй **оручи** гэдэгтэй холбоотой байж болох юм.

475. Иричэ'үлжү гэдгийг хх-分着 (салгах, хуваах) гэж оновчтой орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **хэрчих-хэрчүүлэх** гэдэг үгийн эхний "х" авиа гээгдсэн хэлбэр болно. XIII зууны үед эл үгийн эхний "х" авиа бүрэн гээгдээгүй байсны жишээс бас НТ-ноос олж үзэж болно. Жишээлбэл НТ-ны 123-р зүйлд

"Эм хүүдээс **минь (х)ирчэ'үлжү** (салгаж)
Эзгүй газар гээж од" гэснээс үзвэл тодорхой байна.

Эдүгээгийн хорчин аялгуунд "**ирчиүлхү** хэмээх нь эсэгсэн зөөхийг хүчтэй зуурч ус тосыг салгах хөдөлгөөнийг заана" гэж Элдэнтэй, Ардаажав (1986, 679) тэмдэглэжээ. Энэ нь дорнод халхын аман аялгуунд "сүү тос **эрчээх**" гэж ярьдагтай ойролцоо утгатай бололтой.

476. Алда'улдахун гэдгийг хх-д 可罰的(шийтгэхийг) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **алдах - алдуулах** гэсэн үгтэй гарал нэг бололтой юм. Эдүгээгийн ярианы хэлд хүн нас барахыг "**алдчихлаа**" гэж өгүүлдэгтэй адилавтар мэт санагдана.

Монгол шүлгийн эн зэрэгцүүлэлтийн ёсоор өмнөх мөрд "үхүүлэх ёстойг үхүүл" гэсэн тул бидний ярилцаж буй эл мөрийн утга нь "алуулах ёстойг алуул" гэж холбосон нь агуулгын хувьд нийцэж байна.

Эл үгийг Бөххишиг (1941, 200), Алтан-Очир (1942, 149) нар монгол бичгийн хэлнээ **алагдаху** гэж буулгасныг тэмдэглэе.

477. Йогурхату гэдгийг хх-д 墻有的(хэрэмтэй) гэж орчуулжээ. Эл үг гарлын хувьд эртний түрэг хэлний "нуух, далдлах" гэсэн утгатай жогурхан (йогурхан ?) гэдэг үгтэй холбоотой байж магадгүй юм (Наделяев, 1969, 270).

Шигихутуг, Чингис хааналс шороон туургат (байшинд суугч) сууршилт иргэдийг мэдэлдээ өгөхийг гуйсан тул "шороон йо'ургату балгас" хэмээх нь хх. орчуулгад тэмдэглэсэнчлэн "шороон хэрэмт хот" гэсэн утгатай ажээ. Уг үг ба НТ-ны 281-р зүйлд мөн хэрэм, туурга гэсэн утгаар гарч байгааг тэмдэглэе.

478. Чахлаба гэдгийг хх-д 斟酌 (няглтлах, хянамгайлах) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **цаглашгүй** гэдгийн эсрэг утгатай цаглах хязгаарлах, басах банжих гэсэн утгатай үг болно.

Цаглах гэдгийг Я.Цэвэл гуай (1966, 779) "мэдэж ухах" гэж

тайлбарлажээ. Эл үг мөн НТ-ны 170, 245, 232, 278, 280-р зүйлд **чахту, чахлажу, чахла'улжу** гэсэн хэлбэрээр гарч байна.

479. (Х)улалун гэдгийг хх-д 紅 (улаан) гэж орчуулжээ. Эл үгийг бид орчин цагийн монгол хэлний **улалзах** гэдэгтэй холбоотой болов уу гэж таамаглаж байна.

480. Ну'у гэдгийг хх-д 隅(зах, өнцөг) гэж орчуулжээ. Бидний санавал хх-д эл үгийг монгол бичгийн хэлний **нугу** буюу булан тохой өнцөг хоолой гэсэн утгатай үг мэтээр ухаарч буулгасан байна. НТ-г судалсан нэг хэсэг эрдэмтэд (Э.Хэниш, В.Кливез, Элдэнтэй зэрэг) эл үгийг хх.орчуулгыг баримтлан "булан, өнцөг" гэсэн утгатай гэж үзжээ.

Харин НТ-г орчин цагийн монгол хэлээр хөрвүүлсэн Ц.Дамдинсүрэн, Хуацай Дугаржав, Мансаан нар "ну'у (х) ужа'ура са'улжу" гэсэн эл хэллэгийг "эрхим сууринд суулгаж", "эхний суудалд эрхэмлэн суулгаж", "их суурины голд суулгаж" гэх мэтээр эрх биш хүндтэй суудалд суулгасан гэдэг санааг зөв гаргасан байна. Гэвч миний олж үзсэн зүйлийн хүрээнд "ну'у" гэдэг үгийн утгыг нарийн тайлбарласан буюу оновчтой орчуулсан зүйл тааралдсангүй.

Берлин хотын Турфаны цуглуулгын монгол бичгийн дурсгалын доторх Сулхарнайн туужийн эхэн хэсэгт: "Сулхарнаи сүмүр таг-ун дэгэрэ гарбасу дөрбэн **нугус** найиман хижайара далаи өтүгэни ..."(Хэниш, 1959, 40) гэж өгүүлсэн буй. Энэ нь "Сулхарнай Сүмбэр уулын дээр гарваас дөрвөн **зүг** найман хязгаар далай, газар ..." гэсэн утгатай юм. Үүнээс үндэслэн бид НТ-ны "ну'у" (нугу) гэдгийг **зүг, тал, чиг** гэсэн утгатай үг гэж үзэж байгаа юм (Гаадамба, 1990, 377).

481. Бэнглэнижү гэдгийг хх-д орчуулаагүй байна. НТ-ны 90, 92, 93-р зүйлийн эл үгтэй агуулга тохирох "**мунгтанижу**" (мунгинах) гэдэг үгийг хх-艱難着 (хэцүүдэж, бэрх болж) гэж орчуулсан байна. Ийм учраас бид "**бэнглэнижү**" хэмээхийг мунгинаж, тэвдэж гэдэгтэй ойролцоо утга бүхүй **мэгдэж** гэдэг үгийн эртний хэлбэр болов уу гэж таамаглаж байгаа юм. Монгол хэлд "б", "м" авиа сэлгэх үзэгдэл ялангуяа үгийн эхэнд элбэг тохиолдох учир эл хоёр үг гарлын холбоотой байж болох талтай.

482. Са'ан арун гэдгийг хх-擠有間(саах завсар) гэж орчуулжээ. **Арун** гэдэг нь НТ-ны 26, 265-р зүйлд гарч буй **аж , ажээ** гэсэн дутмаг үйл үгийн "а" язгуурт үйлдэх хэвийн –рун дагавар залгаж үүссэн үг юм (26-р тайлбарыг үзнэ үү).

483. **Жигтүжү** гэдгийг хх-д拽着(датаж, чангааж) гэж орчуулжээ. Энэ нь монгол сонгодог бичгийн **житкүжү** гэдэг үгийн "г"- "т" хоёр авиа байр солигдсон хэлбэр болно.

Элдэнтэй, Ардаажав (1986, 691) нар эл үгийн тайлбар өгүүлэлдээ: Л.Лигетийн эмхтгэн хэвлүүлсэн "Монгол бичгийн эртний дурсгал" гэдэг номоос "бэй-э-бэн аригун-а сакижу кичидэн уругши **жиктун** йабугад" гэсэн баримтыг иш татаж бидэнтэй адил санал гаргасан билээ.

484. **Дэрэлэкүнү** гэдгийг хх-д 枕 (дэр дэрлэх) гэж үгчлэн орчуулжээ. Энэ нь Алтайн уулын хажуу биеэр суух буюу Алтайн уул дэрлэн нутаглах гэсэн үг юм. Одоогийн ярианы хэлд "худэг дэрлэн буух" гэх нь худагт хэт ойр буух гэсэн утгатай юм.

485. **Хара'ун Жидүн** хэмээх нь одоогийн Өвөр монголын Хөлөн буйр аймгийн нутагт орших Хянганы нурууг өгүүлжээ. (346-р тайлбарыг үзнэ үү) Үүнээс үзвэл Мухули Ванд зүүн хязгаарыг эзэгнүүлэхээр зарлиг буулгасан байна.

486. **Эжи'э турух** гэдгийг хх-到今久遠(Эдүгээ болтол, урт удаан) гэж орчуулжээ. Эл хэллэг НТ-ны 167-р зүйлд бараг энэ утгаар гарсан билээ. Гэвч **турух** гэдэг үгийн хх.орчуулгын хувьд ялгаа байгааг харьцуулан үзэж болно. (282, 283-р тайлбарыг үзнэ үү)

487. **Нобшилдужу** гэдгийг хх-共濕着(хамт норж) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **норолцож** гэсэн үгтэй ойролцоо утгатай юм.

488. **Көбшилдүжү** гэдгийг хх-д 共寒着 (хамт хөрч, даарч) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **хөрөлцөж** гэсэн үгтэй ойролцоо утгатай юм.

489. **Нэндү хутух** гэдгийг хх-д "нэндү" хэмээхийг нь орчуулсангүй зөвхөн "**хутух**"-ыг л НТ-ны 105-р зүйл зэрэгт гарсантай нэгэн адил 福神(буян хутаг, буян сахиус) гэж орчуулжээ. Эл үг бас НТ-ны 231-р зүйлд **нэндэ'үд хутух** гэсэн хэлбэрээр гарсныг хх.орчуулгад мөн эл зүйлийнхтэй адил үсгээр тэмдэглэсэн байна. Ийм учраас НТ-г орчин цагийн монгол хэлээр хөрвүүлсэн олонхи судлагчид эл үгийг ор тас орхих буюу таамаглан тайлбарлах маягаар буулгасан буй.

Монгол бичгийн хэлний **мэнгдэкү** (мэгдэх) гэдгийг манж тунгус хэлний зарим аялгуунд **нэндэ** хэмээн (Цинциус, 1975, 622) уг үгийн эхний "м", "н" авиа сэлгэсэн үзэгдэнэ. Үүнээс үндэслэн бид эл үгийг

монгол бичгийн хэлний **мэндү** (амар) гэдэг үгтэй холбоотой байж магадгүй юм гэж таамаглаж байна. Элдэнтэй, Ардаажав (1986, 760) нар 231-р зүйлийн **мэндэ'үд хутух** гэдэг үгийн тайлбарт "Синзянд **нэндүгүд** хэмээвээс номт, ариун, хутаг гэсэн үг" гэж тэмдэглэжээ. Эдгээр баримтаас үзвэл "нэндү хутух" хэмээх нь "сайн хутаг" буюу "ариун хутаг" гэсэн утгатай үг гэж үзэх боломжтой юм.

490. **Онгжалдажу** гэдгийг хх-д 被斷絶着 (таслагдаж) гэж орчуулжээ. Энэ нь "хуваагдах, таслагдах", "унах, цохигдох" гэсэн утгатай бололтой. (192-р тайлбарыг үзнэ үү)

491. **Өлүмлэгсэнү** гэдгийг хх-鏖戰的 (ширүүн тулалдааны) гэж орчуулжээ. Эл үгийн утгыг хх.орчуулгад зөв гаргажээ. Уг үгийн гарал нь эртний түрэг хэлний "үхэл-үхэлдэх" гэсэн утгатай **өлүм - өлүмлүг** (Наделяев, 1969, 384) гэснээс гаралтай "үхэлдэн тэмцэх, үхэлдэн тулалдах" гэсэн утгатай ажээ. Монгол бичгийн хэлд эл үг **өлэмэлжэкү** гэсэн хэлбэрээр "дайрч довтлох" гэсэн утгаар тохиолдож байна. (Сэцэнцогт, 1988, 702). Мөн үүнтэй ойролцоо утга бүхүй "**өлүмлэн, өлүмлэкү, өлүмлэжү**" гэсэн үгс НТ-ны 254, 281-р зүйлд гарч байна.

492. **Үлигэ** гэдгийг хх-д орчуулаагүй байна. Ийм учраас судлагчид янз бүрээр таамаглаж, харилцан адилгүй орчуулж, хөрвүүлсээр иржээ. Тухайлбал НТ-г орчин цагийн монгол бичгийн хэлэнд буулгасан Бөххишиг (1941, 206) "хүлэг цээж" гэж, Алтан-Очир (1942, 154) Ш.Гаадамба (1990, 143) "элэг цээж" гэж, Ц.Дамдинсүрэн "зан авир" гэж, Дугаржав "оюун ухаан" гэж, Мансаан "ухаан санаа" гэх зэргээр харилцан адилгүй ухаж өөр өөрөөр хөрвүүлсэн байна. Бидний ойлголтоор эл үг нь НТ-ны 154, 156, 214-р зүйлүүдэд **үлижү, үлибэ** гэсэн хэлбэрээр гарч буй үлих буюу илүү гарах, илүүдэх гэсэн үгтэй гарал нэгтэй ажээ. Чухамдаа энэ нь өвөг алтай хэлнээс уламжлалтай монгол түрэг хэлний дундын чанартай үг бололтой юм. Тухайлбал эртний түрэг хэлний "овор хэмжээ" гэсэн утгатай **үлгү** (Наделяев, 1969, 624) гэдэг үг, мөн НТ-ны 144, 158, 177-р зүйлд гардаг "**Улух** Таг" гэдгийн "улух" (их, том, агуу) хэмээх үгтэй ч гарал үүслийн холбоотой ажээ. Ингэхлээр бидний ярилцаж буй "үлигэ чэ'эжи" гэдэг нь оюун ухааны овор төрхийг өгүүлсэн "агуу цээж, уудам цээж" гэсэн утгатай үг гэж бид ухаж байна. Элдэнтэй, Ардаажав (1986, 702) нарын тайлбар хийгээд "Монгол үгсийн язгуурын тольд" (Сэцэнцогт, 1988, 487) тэмдэглэснээс үзвэл Түмэд баруун хошууны аман аялгуунд хэнхдэг цээжийг **үлиг цээжи** гэх ба дөрвөд

аялгуунд сэцэн сэргэлэн хүнийг "үлигэ чээжтэй күмүүн" гэж хэлдгээс үзвэл НТ-ны эл хэллэг нь "уудам цээжтэй" буюу "цээж сайтай" (оюун билиг сайтай) гэсэн утгатай болох нь гарцаагүй санагдана. Тэрчлэн эдүгээгийн монгол ярианы хэлд ой ухаан сайтай хүнийг "цээж сайтай хүн" гэх ба шүлэг юм уншиж тогтоохыг "цээжлэх" гэж ярьдаг ч дээрх ойлголттой холбогдолтой гэж үзэж болно.

Дашрам тэмдэглэхэд орчин цагийн монгол хэлний үлэг гүрвэл буюу аврага гүрвэл хэмээхийн **үлэг** гэдэг нь одоогийн түрэг олон хэл аялгуунд "үлү-үлкен" (том, их) гэсэн дуудлагатай үгтэй мөн гарал нэгтэй бололтой байдаг. Орчин цагийн монгол хэлний **илүү** гэдэг үгийг зарим нутгийн аялгуунд **үлүү** гэж дууддаг нь эл үгийн монгол түрэг хэлний эртний дуудлагыг хадгалсан шинжтэй юм. Үүнээс үндэслэн бид монгол хэлний луу хэмээх домгийн аврага амьтны нэрийг **үлү** юм уу **улу** хэмээх үгийн эхний "у" авиа гээгдсэнээс буй болсон хэлбэр бололтой гэж үзэж байгаа билээ.

493. Нохас гэдгийг хх-д 狗每 (ноход) гэж орчуулжээ. Энэ нь нохой гэдэг үгийн олон тооны хэлбэр юм. Чухам утга нь эзэндээ нохой мэт үнэнчээр зүтэгдэг гэсэн санаагаар дотночлон өгүүлжээ.

494. Нитулун гэдгийг хх-д斷絶(таслан) гэж оновчтой орчуулжээ. Харин эл үгийн **нидуралу'а** (тасарлаа) гэсэн хэлбэрийг хх.орчуулгад "хатаж ширгэх" гэсэн үгээр буулгасан байна. (78-р тайлбарыг үзнэ үү)

495. Можирхахун гэдгийг хх-д орчуулаагүй байна. Гэвч эл үгийн утгыг олонхи судлагчид "гажуу зөрүү, мөчирхөг, можиуд" гэсэн үгээр монгол бичгийн хэлнээ буулгасан нь уг өгүүлэгдэхүүний агуулгад нийцэж байхын хамт үгийн гарлын хувьд ч орчин цагийн монгол хэлний "можих-мужих" гэсэн үгстэй холбоотой гэдгийг тодорхойлж чадсан байна.

496. Гэнтү гэдгийг хх-д 雄(эр, хүчирхэг) гэж орчуулжээ. Ийм учраас олонхи судлагчид хх.орчуулгыг баримтлан "эр чоно" буюу "эрэгчин чоно" гэж орчуулж тайлбарласан байна. Бас нэг хэсэг судлагчид хх.орчуулгад бүрэн итгэзгүй бололтой, уг үгийн дуудлагын дагуу "гэнтү чоно" хэмээн галигчлах маягаар буулгасан байх юм. Бидний санавал эл үгийн утга нь үүнтэй эн зэрэгцүүлэн холбосон

"Гэгээн өдөр

Хар хэрээ болж" гэсэн хос мөрийн **хар** гэдэг үгтэй сөрөг буюу эсрэг утгатай байх ёстой билээ. Өөрөөр хэлбэл бид

"Хар шөнө

Гэнтү чоно [болж] " гэдгийг "Хар шөнө, **бүгээн** чоно юм уу **цэгээн** чоно болж" гэсэн утгатай гэж ойлгож байна.

Дээр өгүүлсэн жишээ баримтаас үндэслэн бид "**гэнтү**" гэдэг үгийн үндсийг монгол бичгийн хэлний "**бүгэгэн, гэгэн, чэгэн**" гэсэн үгсийн "гэн" гэдэгтэй холбоотой гэж үзэж байна. Үүний нөгөөтэйгүүр манж хэлд **хөх** өнгийг **гэн** гэдгээс (Цинциус, 1975, 179) үзвэл "гэнтү чоно" хэмээх нь НТ-ны эхэнд гардаг **бөртэ чино** гэдэг шиг "бүгээн чоно", "цэгээн чоно" гэсэн маягийн хэллэг гэж үзмээр байгаа юм. Гэтэл хх.орчуулгад яагаад **эр чоно** гэсэн утгатай гэж тэмдэглэсэн бэ гэдэг асуулт гарч болно. Монгол хэлд бас барс, ирвэс, чоно, нохой зэрэг араатны эрэгчнийг нь **гэндү** гэх ба баарин аялгуунд "хэнт" гэж хэлдэг гэж "Монгол үгсийн язгуурын тольд" (Сэцэнцогт, 1988, 1248) тэмдэглэснээс үзвэл НТ-ны хх.орчуулгыг туурвигч нь үүнийг лав эл **гэндү** гэдэг үгтэй холбож үзсэн нь гарцаагүй болов уу.

497. Босу гэдгийг хх-д орчуулаагүй байна. Харин бүлгийн эцэс дахь товч орчуулгад "муу хүнийг дагаж явсангүй" хэмээн ерөнхийдөө эл шүлгийн санааг зөв гаргажээ. Бидний ажиглалтаар **босу** хэмээх нь монгол бичгийн хэлний **бусу** гэдэгтэй утгын хувьд ч дуудлагын хувьд ч бараг тохирч байна. В.Кливес НТ-ны англи хэлний орчуулгын тайлбартаа "дараах бадгийн **өшитү** гэдэг үгтэй адил утгатай байж болох юм" гэсэн нь монгол шүлгийн эн зэрэгцүүлэлтийн зарчмыг зөв анхаарсан зүйтэй ажиглалт болно. Хэрвээ НТ-ны эл

"Босу күүн лүэ

Бүши ни'ур эсэ жүбчиксэн" гэдгийг одоогийн аялгуунд үгчлэн буулгавал:

"Бус хүнтэй

Биш (өөр) нүүр эс гаргасан" гэсэн утгатай юм.

Эл хос мөрт шүлгийг бид орчин цагийн монгол хэлээр:

Бусар хүмүүнтэй

Буруу нүүр эс гаргасан

Өшөөт хүмүүнтэй

Өөр нүүр эс гаргасан гэж хөрвүүлэв.

498. Жүбчиксэн гэдгийг хх-д 安來 (тохируулсан, тааруулсан) гэж орчуулжээ. Эл үг 181, 210, 275-р зүйлд "жүбчижү, жүбчиксэн, жүбчийа" гэсэн хэлбэрээр гарна. (343-р тайлбарыг үзнэ үү)

499. Эрэ'үү гэдгийг хх-д 罪 (ял) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний **"эрэгү** цааз", **"эрүүгийн** хэрэг" гэх мэтийн эрүү гэдэг үгийн хуучин хэлбэр болно. Эл үг НТ-ны 224, 228, 257, 278-р зүйлүүдэд "эрэ'үлэжү, эрэ'үлэйа, эрэ'үлэйэ" гэсэн хэлбэрээр мөн "эрүүдэх, яллах" гэсэн утгаар гарч байна.

500. Бура тара гэдгийг хх-д 漫散 (зүг чиггүй тарсан) гэж орчуулжээ. Бид энэ хэллэгийг орчин цагийн монгол хэлний **бутрах, тарах** гэсэн үгстэй нэг язгууртай гэж үзэж байна.

501. Эсэксэнэ гэдгийг хх-д 不曾的(байгаагүй) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **эссэн** буюу сонгодог бичгийн хэлний **эсэ** агсан гэсэн үгийн хуучин хэлбэр болно.

502. Хучин гэдгийг хх-д 澉噎 (боох, бөглөрөх) гэж орчуулжээ. Эл үгийн гарал нь монгол бичгийн хэлний **хучиху** (боох, ороох) гэдэгтэй үндэс нэгтэй юм. Харин НТ-ны энэ 213-р "боох, зангирах" гэсэн утгаар гарч байна. Эдүгээгийн аман, бичгийн хэлд "зангирах" гэх нь "боох, тээглэх" гэсэн утгатайгаас гадна сэтгэл санаа зовиурлах, тавгүйрхахыг илэрхийлсэн бас салаа утга бий. Жишээлбэл "Жаахан шарга" гэдэг ардын дуунд:

Жаахан шаргыгаа унаж явлаа хө
Замынхаа ногоог зажлуулж явлаа хө
Жаахан хонгоры минь хэлсэн үг нь хө
Залгидаг хоолой дээр минь **зангируулаад** л

байна хө гэсэн байдаг. Бид НТ-ны **хучин** гэдгийг чухам зангирах хэмээхийн эл утга яг тохирох болов уу гэж санаж байна.

503. Баса'алажу гэдгийг хх-д知料着(бэлтгэж, хамааруулж) гэж орчуулжээ. Эл үгийг бид орчин цагийн монгол хэлний "зэхэж, бэлтгэх" гэсэн утгатай **базаах, базаалгах** гэдэгтэй гарал нэгтэй болов уу гэж үзэж байна. (192-р тайлбарыг үзнэ үү)

504. Сайн эри'үлсүн буйу би гэсэн хэллэгийг хх-д 好尋的有我 (сайн эрсэн болой би) гэж яг үгчлэн орчуулжээ. Эл хэллэгийг Бөххишиг, Ц.Дамдинсүрэн зэрэг нэг хэсэг судлагчид Харгил Шарыг өлсөж ядарч явж Өэлүн эхийн гэрт орж ирсэн тул "идээн эрэх хүмүүн буй би" гэх буюу "идэх юм гуйя" гэх мэтээр утгачлан хөрвүүлжээ. Гэтэл В.Кливез зэрэг эрдэмтэд хх.орчуулгыг шууд баримтлан "би болбоос сайн юмс эрж" гэсэн утгаар орчуулсан байна. Мөн Элдэнтэй, Ардаажав (1986, 718) "сайн эрэх хүмүүн, өглөг эрэх хүмүүн" гэж тайлбарлажээ. Гэвч

дээр өгүүлсэн орчуулга тайлбарын аль аль уг зүйлийн утга санаанд ч Харгил Шарын Өэлүн эхийн гэрийг эрж ирсэн зорилгод төдийлөн авцалдахгүй мэт санагдана. Бидний санахад "Сайн эри'үлсүн буйу би" гэх нь "Би сайн эрсэн буй" гэсэн буюу "Би их эрсэн бүй" хэмээсэн утгатай үг бололтой. НТ-ны хх.орчуулгын санаа ч мөн ийм байдалтай шиг байна. Жич тэмдэглэхэд НТ-ны бүлгийн эцэс дахь товч орчуулгад мөн үүнийг утгачлан өглөг бадар барих хүн гэсэн утгаар тэмдэглэсэн тул Бөххишиг, Ц.Дамдинсүрэн, С.Козин, Мансаан, Ш.Гаадамба зэрэг судлагчид хх.орчуулгыг огт баримтлаагүй бололтой.

505. Жэмлэн алажу гэдгийг хх-д 做喫的殺着(идшэнд алж) гэж утгачлан орчуулжээ. НТ-ны нангиад галигийн 咕連 гэсэн үгсийг олонхи судлагчид "тэлэн" гэсэн дуудлагаар тэмдэглэсэн тул Бөххишиг, Ц.Дамдинсүрэн, Дугаржав, Мансаан, Ш.Гаадамба зэрэг судлагчид "тэлэн алж" гэж эрт, одоогийн монгол хэлээр хөрвүүлжээ. Монголчууд үхэр алахдаа сүхээр духан дээр нь цохиж муужруулж унагаад хутгаар нугаслан алдаг билээ. Тийм учраас үхэр алахыг "үхэр цохих" ч гэж хэлдэг ёс бий. НТ-ны эл зүйлд: "Алтани-йин да'ун дур Жэтэй, Жэлмэ хойар сүкэ баримжу нудурхас-ийан (х)ула'атажу гүйижү ирэжү татарун Харгил Шира-йи сүкэ-бэр китухаи-бар мөн тэндэ алажу'уй" гэснээс үзвэл мугалзар хар үхрийг цохиж, нугасалж алсан бэлэн сүх, хутгаа шүүрч авч очсон хэрэг биз. Ийм учраас одоогийн хонь ямаа алах мэт **тэлэн** алж гэж арай ойлгож болмооргүй санагдана.

Сүүлийн үед проф.И.Рахевилз (1972, 123) Иринжин (1987, 204) нар НТ-ны нангиад галигийн咕連гэсэн үгсийн "жэмлэн" гэж буулгасан нь анхаарал татаж байна. Хэрэв эл үгийн дуудлага нь И.Рахевилз нарын уншсанчлан **жэмлэн** гэсэн дуудлага зөвтэй бөгөөс энэ нь **зэмсгээр** алах буюу **мэслэн алах** гэсэн утгатай үг байж болох юм.

506. Жүлдү гэдгийг хх-д 頭功 (тэргүүн гавъяа) гэж орчуулжээ. Энэ нь зүтгэл, гавъяа гэсэн утгатай бөгөөд гарлын хувьд монгол бичгийн хэлний **жүлдэ** (Цэвэл, 1966, 290) хэмээхтэй үүсэл нэгтэй байж болох юм.

507. Дарба'ан урийа-дача, да'ун дэм-эчэ-г 招喚行 聲應行 (уриа дуудлагаас дуун дэмжлэгээс) гэж уг хос мөр шүлгийн утгыг зөв гаргасан шиг байна. Чингис хааны үгэнд Борохулыг

Дарвиан урианаас
Дуун дэмээс ямарч үед хожимдолгүй хамт

зүтгэж ирсэн санааг өгүүлжээ. Эл зүйр үгэнд эртний монголчуудын овог аймгийг нэгтгэж байсан уриа дуудлагын тухай ойлголтыг дурджээ.

Эрт балар цагт хүмүүс овог төрлөөрөө ой мод, уул хаданд гарч ан ав хийх, гэр оромж барих тэргүүтэнд байгалийн гэнэтийн аюул гамшиг тохиолдох, зэрлэг араатан дайрах, эсвэл аливаа ажил хөдөлмөрт хүч мөхөсдөх тэргүүтэнд өөрийн овог төрлийнхөндөө өгөх тусгай **дохио тэмдэгтэй** байжээ. Энэ нь улам улмаар боловсронгуй болж уриа дуудлагын тусгай төрөл ай буй болсон байна. Энэхүү эртний уламжлалт уриа дуудлагын нэр томъёоноос эдүгээ зарим ястан угсаатан нарын дунд мэр сэр үлдсэн зүйл бий. Тухайлбал буриадын Ага найман эцгийн уриа нь бидний сурвалжлан олсноор: Галзууд-Дагаахан уриатай, Хуацай+Хандгай мэргэн уриатай, Хүгдүүд-Хар бүргэд уриатай, Шарайд-Хандгай мэргэн уриатай, Цагаангууд, Халбин, Бодонгууд нар-Чоно буюу Шо мэргэн уриатай, Харгана-Буялаа уриатай байжээ. Энэхүү эртний уламжлалт уриа дуудлагын үг шүлэг нь улам боловсронгуй болсоор дайсан этгээдийн эсрэг тэр овог аймаг, үндэстнийг зоригжуулан нэгтгэх дуулал болсон байна. НТ-ны эл зүйр үг хийгээд урианхай ардын

Дайнд уриа нэгтэй

Далайд сал нэгтэй гэсэн зүйр үг болбоос чухам үүнийг өгүүлжээ. Жуулчин Марко Поло (1956, 101) Монголчууд тулалдаанд орохын өмнө хэнгэрэг дэлдэж, бүрээ үлээн дуу дуулдаг заншилтай гэж өгүүлсэн нь чухамдаа мөн л уриа дуудлагыг хэлсэн бололтой байдаг.

НТ-ны 106-р зүйлд Жамухагаас Тэмүжин, Тоорил нарт элчээр дуу бариулан илгээсэн үг нь уриа дуудлагын шинжтэй шүлэг юм.

508. Мөр Бэки гэдгийг хх-道子官名(мөр, ноён хэргэмийн нэр) гэж орчуулжээ. Энэн нь уг шүлэгт **мөри бэки, бэки мөр** гэж сэлгэн орсноос үзвэл ноёны хэргэм цолыг нэрийдсэн хоршоо үг бололтой байна. (43-р тайлбарыг үзнэ үү)

509. Билжи'ур гэдгийг хх-д орчуулаагүй байна. Харин 160-р зүйлд **билду'ур** хэмээхийг 告天雀兒 (дуут болжмор) гэж орчуулжээ. (267-р тайлбарыг үзнэ үү)

510. Бүктэ'үл гэдгийг хх-д 埋没(нуугдмал, дарагдмал) гэж оновчтой орчуулжээ. Эл үгийг Мансаан, орчин цагийн монгол хэлээр "нуугдмал өрх" гэж зүйтэй буулгасан байна. Уг үг гарлын хувьд бүдэг,

бүрхэг гэсэн утгатай монгол бичгийн хэлний **бүктэ** гэдэгтэй нэг үүсэлтэй ажээ. Энэ нь чухамдаа мянганы ноёдын өрх амын бүртгэлээс завсардсан иргэдийг өгүүлсэн бололтой юм. Мөн НТ-ны бүлгийн эцэс дэх товч орчуулгад "өрх амын гаднах иргэн" гэж зөв тайлбарласныг тэмдэглэе.

Ш.Гаадамба (1990, 154) **бүгүдэгүлэ** гэж буулгасан боловч тайлбар дагалдуулаагүй тул хэрхэн ухсан нь тодорхойгүй юм.

511. Бөкэлэрүн гэдгийг 氣力做時 (бөхлөхөд) гэж орчуулжээ. Энэ нь бөхлөх, бөх бат болгох, чангалах, чандлах гэсэн утгатай болно.

512. Хад-ийар гэдгийг хх-獨自 (ганцаар) гэж орчуулжээ. НТ-ны энэхүү 224-р зүйл дахь "бэйэ хад-ийар олугсам жө'эксэн" гэсэн хэллэг нь одоогийн ойлголтоор "бие хараар олсон зөөсөн" гэсэн утгатай юм.

Бидний санавал "бэйэ хад" гэдгийн **хад** гэх нь орчин цагийн монгол хэлний бие **хар** гэдгийн олон тооны хуучин хэлбэр бололтой байна. Элдэнтэй, Ардаажав (1986, 738) нар уг үгийн тайлбар өгүүлэлдээ **бие хад** гэх нь хорчин, харчин, ордос аман аялгуунд бие махбод, бие цогцос гэсэн утгатай байдаг гэснээс үзвэл эдүгээгийн монгол хэлний зарим аялгуунд энэхүү олон тооны хэлбэр мөн уламжлан үлдсэн ажээ.

Бас НТ-ны 227-р зүйлд **бэйэ хад** гэснийг хх-д身體 (бие цогцос) гэж оновчтой орчуулсныг тэмдэглэе.

513. Өтөкүлэкүн гэдгийг хх-д爲長的(ахлах даргалах) гэж орчуулжээ. Эл үг гарлын хувьд өвгөд настан гэсэн утгатай **өтүгүс** гэдэгтэй холбоотой бөгөөд ахлагч, толгойлогч гэсэн утгатай юм.

514. (Х)о'ара'асу гэдгийг хх-д 脫了呵(салбал) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний гээх, орхих гэсэн утга бүхүй **огоорвоос** хэмээх үгийн хуучин хэлбэр болно.

515. (Х)ончидутхун гэдгийг 怪責者您 (зэмлэгтүн, буруушаагтүн) гэж орчуулжээ. Үүнийг бид донгодох, шийтгэх гэсэн утгатай болов уу гэж хх. орчуулга хийгээд уг үгийн өөр өөр нөхцөлд орсон байдлаас таамаглаж байна. НТ-ны 227-р зүйлийн төгсгөлд эл шийтгэлийн хэлбэрийг тодруулахдаа "бэрээний хариуг бэрээгээр, нудраганы хариуг нудрагаар хариултугай" хэмээн Чингис хаан зарлиг болжээ. Эл үг бас 278-р зүйлд **онжитухай** гэсэн хэлбэрээр гарч байна.

516. Та'улжу гэдгийг 分付着 (захиж, даалгаж) гэж орчуулжээ. Энэ нь даалгах, тушаах гэсэн утгатай болно. Мукаддимат Ал-адаб тольд "та'улба түүндү" гэдгийг оросоор поручил ему (түүнд даалгав) гэж

орчуулсан буй (Поппе, 1938, 343).

517. Та'аралдутухаи гэдгийг хх-復者 (дахигтүн) гэж орчуулжээ. Энэ нь уг ажилдаа эргэж ортугай, буцаж ортугай гэсэн утгатай юм. Үгийн гарлын хувьд монгол бичгийн хэлний таарах, тохиолдох гэсэн утга бүхүй **тагаралдуху** гэдэгтэй үүсэл нэгтэй бололтой.

518. Экит ану далбару гэдгийг хх-惱每他的打破(тархий нь хага цохиж) гэж орчуулжээ. **Экит** гэдэг нь эхин буюу толгой тархи, түрүү гэсний олон тооны хэлбэр юм. Далбару гэх нь орчин цагийн монгол хэлний **далбалах** гэдэг үйл үгийн үндсэнд -р дагавар залгаж үүссэн тэмдэг нэр болно.

519. Ба'утала гэдгийг 落下直到 (унатал, тустал) гэж рчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний **багуху** гэдэгтэй гарал нэгтэй бөгөөд НТ-ны эл зүйлд унжтал, санжтал гэсэн утгаар оржээ.

520. Жаха'ун гэдгийг хх-兩間 (дундуур) гэж орчуулжээ. Энэ нь завсар, хооронд, дундуур гэсэн утгатай бөгөөд гарлын хувьд бичгийн хэлний **жаха** гэдэгтэй язгуур нэгтэй байж болох юм. Эл үг НТ-ны 278-р зүйлд мөн энэ утгаар гарна.

521. Өрүг нута гэдгийг хх-д寫靜(нам гүм) гэж орчуулжээ. Уг үг гарлын хувьд монгол сонгодог бичгийн **өрүчэ** (өрц) гэдэгтэй язгуур нэгтэй бололтой. Якут хэлд **өрөгө** гэж "цээжин бие, гэдэс, хэвлий" гэсэн утгатай ажээ (Пекарский, 1917, 1959). Үүнээс үзвэл энэ нь сэтгэл санааг нут бат байлгаж гэсэн утгатай бололтой юм. Харин НТ-ны хх.орчуулгад эл үгийг тухай тухайн утгын байдалд нийцүүлэн өөр өөрөөр орчуулсан үзэгдэнэ. Тухайлбал эл үг 233, 255-р зүйлд дээрэхээс өөр утгаар гарах бөгөөд 255-р зүйлийн **өрүг** гэдгийг хх-д敦厚(үнэнч шудрага) гэж орчуулсан байна. Бид эл үгийг "энх амар" хэмээн утгачлан хөрвүүлэв.

522. Шилжирин гэдгийг хх-移動 (шилжин, нүүн) гэж оновчтой орчуулжээ. Эл үг гарлын хувьд монгол бичгийн хэлний **шилирэкү, шилжикү** гэдэгтэй язгуур нэгтэй юм (Сэцэнцогт, 1988, 1950). Энэ нь мөн өөрчлөгдөх солигдох гэсэн утгаар аман бичгийн бусад дурсгалуудад мэр сэр тохиолдоно. Тухайлбал: Ц.Дамдинсүрэнгийн нийтлүүлсэн "Монгол уран зохиолын дээж зуун билигт" хэвлэгдсэн "Гал тахих ёсон" хэмээх бичигт:

"Шинэ жил **шилжирэжү** ирэхүйд
Шилүүсэн зүс зүслэхүйд
Шар тэргүүт цагаан хонины өвчүүгээр тахинам

Шившиг зовлон арилтугай" хэмээн өгүүлсэн буй.

Ярианы хэлд бороо, салхи савир ихтэй шавхуурдан орохыг "бороо шилбүүрдэх" гэж хэлдгийг үлгэрлэн бид эл хэллэгийг

"Шилбүүрдэн бүхүй бороонд
Чичиргэн бүхүй жихүүнд" гэж хөрвүүлэв.

523. Шилгүтгэн гэдгийг хх-д敎顫(чичрэн, дагжин) гэж зүйтэй орчуулжээ. Уг үг гарлын хувьд орчин цагийн монгол хэлний шилгээх гэдэгтэй үүсэл нэгтэй бөгөөд чухам дагжих, чичрэх гэсэн утгатай байна. Эл үг Чойжи-Одсэрийн "Махагалийн магтаалд":

Чисутан дайисуд-ун жирүкэн-и
Чинар-ача шилгүтгэгчи Мах-а кали

(Цэрэнсодном, 1969, 131) хэмээн мөн **чичиргэн айлгагч** гэсэн утгаар гарч байна.

524. Шилтэсүтэи гэдгийг хх-д 編了壁子 (сүлжмэл хана) гэж орчуулжээ. Эл үгийг судлагчид ерөнхийдөө гэрийн хана гэж ойлгосон авч чухам гарал үүслийн талаар оновчтой тайлбар үгүй шиг байна. Уг үгийн гарлын тухай Элдэнтэй, Ардаажав (1986, 755) нар "Шилтэсү хэмээх нь **илтасу**-ийн эртний дуудлага бөгөөд төмөрлөг хавтгай гэсэн болмой" гэх мэтээр тайлбарлаж ялтас хавтгай төмөр мэтийг туурган завсраа хавчуулж хамгаалсан гэр гэж ухаарчээ. Бидний саналаар эл үгийн үндэс нь орчин цагийн монгол хэлний **шилбэ** (ханын) гэдэгтэй язгуур нэгтэйн дээр монгол бичгийн хэлний **шилтүгэн, шилтэгэн** (Сэцэнцогт, 1988, 1597) хэмээх үгтэй ч учир холбогдолтой байж болох юм. Тэрчлэн эл шүлгийн эн зэрэгцүүлэн холбосон бадгийн

"**Ирэгт** гэрий минь орчин
Ирмэс үл хийн" гэсэн хос мөрийн **ирэгт** гэдэг нь бидний ярилцаж буй **шилтэсүтэй** хэмээхтэй ойролцоо утгатай байх учир зүйлд яг таг нийцэж байгаа тул бид үүнийг **шилбэт** гэр буюу **ханат** гэр гэсэн үг гэж ухаарч байна. НТ-г монгол бичгийн хэлнээ буулгасан эрдэмтдийн дотроос эл үгийг Алтан+Очир (1942, 173) "**шилбэсү**-тэи гэр" гэж эн тэргүүнээ оновчтой хөрвүүлснийг тэмдэглэе. Ирэг хэмээх нь Ойрд, Ордос аялгуунд гэрийн ханын шилбийг хэлдэг байна.

525. Жирим гэдгийг хх-д略歇息(түр амс хийх) гэж орчуулжээ. Энэхүү **жирим** буюу **чирим** (нангиад галигт 只[ち]林 гэж тэмдэглэснийг Иринжин **чирим** гэж сэргээн буулгав) гэх нь бидний таамаглалаар орчин

цагийн монгол хэлний **цурам** хийх гэдэг үгтэй учир холбогдолтой байж магадгүй юм.

526. Үйилсүн хор гэдгийг хх-д 樺皮箭筒 (Хус модны үйсэн сум) гэж орчуулжээ. **Үилсү** хэмээхийг "Монгол үгсийн язгуурын тольд" "Хусны торос, уд үйс буюу тоос ч гэдэг" (Сэцэнцогт, 1988, 474) гэжээ. Харин Ш.Гаадамба (1990, 385) үүнийг **гүйлс** мод гэж үзсэн байна.

527. Урийархун гэдгийг хх-д 爽利 (хөнгөн, шаламгай) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **уриалаг, уриалагхан, улиархан** гэсний эртний хэлбэр бололтой. Эл үгийг Цэнд-гүн "Улиархан" гэж буулгасныг бид харгалзав.

528. (Х)удан гэдгийг хх-д 柳木 (уд мод) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **уд** (мод) гэдгийн хуучин хэлбэр болно. Уд модыг "Монгол үгсийн язгуурын тольд" зузаан торстой, навч зулгарах тураг мод гэж тайлбарласан байна (Сэцэнцогт, 1988, 416).

529. Гэмүриулүн гэдгийг хх-д 教怨 (хорсуулж гэмшээж) гэж орчуулжээ. Энэ нь гэмшээх, зовоох гэсэн утгатай бололтой. Эдүгээгийн үзэмчин аялгуунд зовох, дэнших гэдгийг **гэмрэх** гэдэг байна. Жишээлбэл зүүн үзэмчин хошууны гаралтай ерөөлч Жагараас бидний 1962 онд тэмдэглэж авсан "Цэвэр бүсгүйн холбоо" хэмээх шүлэгт:

Зуны цагийн эрвээхэй
Цэцгээ санаад эргэмээр
Жар дал хүрсэн настангууд
Залуугаа бодоод **гэмрэмээр** гэсэн байна.

530. Улү'ү гэдгийг хх-д 不 (үл, эс) гэсэн үгүйсгэх сул үгээр орчуулжээ. Монгол бичгийн хэлний **үлү** гэх нь юуны өмнө үгүйсгэх сул үгийн утгатайгаас гадна зарим тохиолдолд бас"мөн, тийм" гэсэн бататгах санаагаар хэрэглэгддэг бололтой (Сэцэнцогт, 1988, 487). Бидний санавал НТ-ны эл зүйлд ч мөн бататгах утгаар орсон бололтой юм. Энэ нь бас "аврага, том" гэсэн утгатай үлү-үлүг гэсэн үгтэй ч холбоотой байж болно.

531. Доро жида гэдгийг хх-д 下槍 (доор жад) гэж орчуулжээ. Эл үгийг зарим судалгчид хх. орчуулгыг баримтлан "**дөөр жад**" гэсэн утгаар орчуулсан авч Ц.Дамдинсүрэн, Баяр, Элдэнтэй, Ардаажав (1986, 761) эл үгийн тайлбар өгүүлэлдээ "хааны жагсаалд хэрэглэх дөрөө толгойтой жад" гэж тэмдэглэжээ. Эл үг бас НТ-ны 278-р зүйлд гарч байна.

532. Хахас гэдгийг хх-д 分離(салгуу) гэж орчуулжээ. Үүнийг НТ-ны эл зүйлд **хахас хахас** гэж давтан өгүүлсэн салгуу салгуу гэх юм уу алгуу алгуу гэсэн утгатай ажээ. Эл үг бас НТ-ны 278-р зүйлд **салгуу зай завсар** гэсэн утгаар гарч байна.

533. (Х)о'ошин гэдгийг хх-д 網索 (датлага) гэж орчуулжээ. Монгол хэлний толь бичгүүдэд **өгэши** гэх нь загас мэтийг шүүх тор гэсэн утгатайгаас гадна морь малыг бугуйлдан барих уурга, цалам, уяа сурыг бас хэлдэг бололтой (Сэцэнцогт, 1988, 446).

534. Дарун гэдгийг хх-д 常川 (үргэлж, хэзээд) гэж орчуулжээ. Энэ нь үгтаа монгол бичгийн хэлний **даруху, дарулту** гэдэгтэй гарал нэгтэй бөгөөд НТ-ны эл зүйлд сахих хамгаалах, харж хандах гэсэн утгатай байна.

535. Харлугуудын Арслан ханыг эс тэмцэлдэн элсэн оров хэмээн Чингис хаан соёрхож "охин өгье" гэснээс бус чухам ямар нэртэй охин өгснийг НТ-нд тэмдэглээгүй учир монголын түүхэнд холбогдох бусад сурвалж бичгүүдэд энэ тухай харилцан адилгүй тэмдэглэсэн байдаг байна. Тухайлбал Лувсанданзаны "Алтан товчид" Арсланд Алха бэхийг өгч

"Харайхад минь хөл болж
Хазайхад минь түшиг болж
Халтирахад минь тах болж
Халамж тус хүргэхдээ
Хайрт Алха минь мэдтүгэй..." гэх зэргээр

Чингис хааныг сургаал айлдсан гэж өгүүлсэн байхад "Юань улсын сударт" Толи агийг Арсланы хөвүүн Есүнбухад өгөв гэсэн байдаг байна. Эдгээр мэдээнээс үзвэл Харлугуудын хан Арслан хийгээд түүний хүү Есүнбух нарт аль алинд нь Алха бэхи, Толи аг нарыг өгсөн бололтой юм.

536. Сариг хүн гэдгийг хх-д 地名(газрын нэр) гэж тэмдлэглэжээ. Энэ нь "Шар хавцал" гэсэн утгатай түрэг хэлний орчуулгын товч тайлбартаа "Yellow cliff" (шар хавцал) гэж тэмдэглэжээ. Х.Пэрлээ (1958, 11) үүнийг "Лувсанданзаны Алтан товчид Хэрис гол гэжээ. Энэ газар Зөвлөлтийн нутаг Чүй буюу Чү голын хавьд байжээ" хэмээн тайлбарласан байна.

537. Идү'үт гэдгийг хх-д 人名(хүний нэр) гэж тэмдэглэсэн байна. Чухамдаа энэ нь түрэг хэлний (уйгар) Ыдух хут буюу "дархан эзэн"

гэсэн утгатай цол гуншин ажээ.

Чингис хаан 1210 онд Хар Хятангы эзлэн авахад түүний эзэмшилд байсан Уйгарын эзэн Идүх хут "тавдугаар хөвүүн чинь болъё" хэмээн Чингис хаанд шууд дагаар орсон байна. Тэр Идүх хутын ач Индүг 1331 онд 60 насандаа таалал болсонд түүнийг Ши нинг онг өргөмжлөв. Чингээд 1362 онд Ши нинг онг Индүд хөшөө босгожээ. Уг хөшөөний бичиг нь "Ши нинг онг бие ташийн бичиг" хэмээх нэрээр судлагчдын дунд дэлгэрсэн юм. Эл бичгийн талаар проф. П.Пеллио (1908) эн тэргүүнээ танилцуулжээ.

Энэхүү хөшөөний бичгийн гэрэл зураг хийгээд уг бичгийн учир холбогдлын тухай Добугийн (1983, 345-413) эмхтгэсэн "Уйгаржин монгол үсгийн дурсгалт бичгүүд", Хишигтогтохын (198, 98-100) нийтлүүлсэн "Эртний монгол шүлгийн түүвэр" зэрэг зохиолоос танилцаж болно. Тэрчлэн Турфаны цуглуулгын монгол бичгийн дурсгалаас Идихут-Шерийн монгол захиаг Г.Рамстедт (1909, 838-848) нийтлүүлсэн билээ.

538. **Нажит** гэдгийг хх-д 金段子(алтат торго) гэж орчуулжээ. Үүнийг Ц.Дамдинсүрэн, В,Кливез зэрэг судлагчид хоргой гэж үзсэнийг бид баримтлав. Ордос "Хонжин дэвтэр" зэрэг сударт гардаг "**Нади торго**" хэмээх (Дамдинсүрэн, 1959, 89) үгийг үүний нэг хэлбэр гэж санаж байна.

539. **Дардас** гэдгийг 渾金段子 (алтадмал торго) гэж орчуулжээ. Элдэнтэй, Ардаажав (1986, 770) нар "дарда нь ар дэвсгэрийг хоёр өнгийн ёнхороор ялгаруулан нэхсэнийг нь таж хэмээнэ" гэжээ. Дардас хэмээх нь монгол сонгодог бичгийн хэлний "дарда" гэдгийн олон тооны хэлбэр болно (Ковалевский, 1849, III, 1681, Сумадирадна, 1959, VI, 947).

540. **Ухамсар** гэдгийг хх-д 不覺(үл мэдэх) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний ухах, ухаарах гэдэгтэй гарал нэг бололтой.

541. **Ту'урби'асу** гэдгийг хх-要做呵(хийх гэвэл) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний тугурбиху гэдгийн хуучин хэлбэр болно.

542. **(Х)охторхуи эрбэгэлжэ'үлжү** гэдгийг 虛張形勢着 (хоосон айлгаж) гэж оновчтой орчуулжээ. Үүнийг одоогийн хэлээр яг үгчлэн буулгавал "огт оргүй эрвэлзүүлж" гэсэн үг болох бөгөөд чухамдаа хий сүрдүүлэх гэсэн утгатай үг болно.

543. **(Х)ула'ан буха** гэдгийг хх-д獸名(араатан) гөрөөсний нэр

гэж тэмдэглэжээ. Энэхүү "улаан бух" хэмээх нь тэнгэрийн цагаан бух, буриадын Бух ноёны домог зэрэг шиг эртний хүмүүсийн үхэрт бишрэх домог-үлгэрийн ойлголттой холбоотой зүйл бололтой. (177-р тайлбарыг үзнэ үү)

Тухайлбал Булгад овгийн буриадуудын гарлын домогт Тэнгэрийн улаан бух газарт бууж ирэх үед түүний явсан мөрөн дээр нэг эмэгтэй гишгиснээс жирэмсэн болж энэ овгийнхон үүссэн гэж үздэг байна.

544. **Чиматжу** гэдгийг хх-д 嫌少着(чамалж) гэж орчуулжээ. Эл үг НТ-ны 177-р зүйлд чимар-чиматба гэж буруутгах, айлгах, эмээлгэх гэсэн утгаар гарна. (146, 317-р тайлбарыг үзнэ үү)

545. **Эчиткэйа** гэдгийг хх-д 滅咱(сөнөөе) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний эцэслүүлье, эцэс болгоё гэсэнтэй адил утгатай байна.

546. **Ханшитала** гэдгийг хх-д 搶直到 (хахаж цацтал) гэж орчуулжээ. Эдүгээгийн олон монгол хэл аялгуунд хангинах гэхийг ханхинах гэж "г", "х" сэлгэдэг "х", "ш" авиа сэлгэсэн хэлбэр бололтой.

547. **Хахас** гэдгийг хх-д分明(тодорхой) гэж орчуулжээ. Энэ нь дундад эртний монгол хэлд яруу тодорхой гэхийг **хагархаи - хагархаи-йа** гэж хэлдэгтэй үндэс нэгтэй бололтой.

Чойжи-Одсэрийн Махагалийн магтаалд:

Хамуг-а гайихагулугсан эрдэм-и чину

Хагарахаи-а холбан магтасугаи (Цэрэнсодном, 1969, 129) гэсэн байхын дээр "Ачлалт номын" монгол орчуулгад энэ хагарахаи гэдэг үгийг хятад хэлний 明 (мин) гэдэг үгтэй тохиолдуулан хөрвүүлсэн байдаг байна (Лувсанбалдан, 1961). Тэрчлэн XIV зууны эхэн үед Шаравсэнгийн орчуулсан Банзрагчийн төгсөлийн шүлэгт: "**хагархаи-а** илэтдэ номлагсан" гэх нь мөн тодорхой гэсэн утгатай ажээ. Гэсэн ч бид уг үгийн утга найрамж хийгээд олонхи судлагчдын эдүгээгийн монгол хэлээр **ятгаж** гэж буулгасныг дагаж баримтлав.

548. **Тэб тэнгэри** гэдгийг хх-巫名 (бөөгийн нэр) гэж тэмдэглэсэн байна. Энэ нь монгол бичгийн хэлний **төб** (гол, төв) гэдэгтэй холбогдолтой "Төв тэнгэр" буюу "Дээд тэнгэр" гэсэн утгатай байж болох юм.

Якут хэлд **төбө - тэбэ** гэх нь оргил, толгой, дээд гэсэн утгатай байна (Пекарский, 1917, 2758). Үүнээс үзвэл монгол бичгийн хэлний **төб** хэмээх нь эрт үед **тэб** гэсэн дуулагатай байсан байж ч болно.

Тэб тэнгэр бол Чингис хааны эцгийн үеэс ойр шадар явсан Мунлиг эцгийн долоон хөвүүний дундах хөвүүн нь юм. Рашид-Ад-диний (1952, 1, 167) өгүүлснээр монголчуудын Тэб тэнгэри гэж нэрлэдэг Хөхөчү бөө бол Чингис хаантай маш ойр дотно явсан бөгөөд ялангуяа Мунлиг эцгийг Өэлүн эхтэй нийлснээс хойш улам шадарлаж "Бурхан надтай ярилцаж би тэнгэрийн зарлигийг дамжуулж байна" гэх зэргээр бөөгийн шашнаар тухирч түүнийг дүү нартай нь зөрчилдүүлэх зэрэг ил далд явуулсан тэмцэл нь илэрч тэрээр удалгүй Чингис нарт хөнөөгддөг юм.

549. Өмэрэжү гэдгийг хх-黨比着(бүлэглэн байж, нийлэн байж) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **омоорох** (бөөгнөрөх) гэдэг үгтэй гарал нэгтэй байж болох юм. Харин үүнтэй ойролцоо дуудлагатай **өмэркү** гэсэн үгийг НТ-ны 78-р зүйлийн хх. орчуулгад 黨護(бүлэглэн дайрах) гэж орчуулсан боловч бид үүнийг утгы нь дагуулан **өмөөрөх** гэдэг үгээр хөрвүүлсэн билээ.

550. Кэйэкжү гэдгийг хх-д驚駭着(сочин эмээж) гэж орчуулжээ. Элдэнтэй, Ардаажав (1986, 786) эл үгийн тайлбар өгүүлэлдээ "Эрдэнийн товчид" үүнтэй ойролцоо утгатай **кэйэгүгсэн** (сочин гайхах) гэсэн үг байдгийг тэмдэглээд гарлын талаар түрэг хэлний **кыжык** (уур хилин) гэдэг үгтэй холбож үзсэн байна. Эвенк хэлд **кийка** (Цинциус, 1975, 391) хэмээх нь хирд хийн сочоох, цухалдуулах гэсэн утгатай байх нь бидний ярилцаж буй **кэйэкжү** гэдэгтэй утга дуудлагын аль ч талаар адилавтар байна. Эдгээр баримтаас үзвэл эл үг нь монгол түрэг хэлтний дундын чанартай үг байж болно.

551. Бисари'улжу гэдгийг хх-盈滿着 (дүүргэж) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний **билхагаху** (бялхам дүүргэх) гэдэг үгтэй гарал нэгтэй бололтой. Хорчин аялгуунд **бисарах** хэмээх нь дүүрч гарах, үерлэх, бялхах, халих гэх зэргийн утгатай ажээ (Элдэнтэй, Ардаажав, 1986, 787).

552. Хадалун гэдгийг хх-д орчуулаагүй байна. Монгол хэлд "р, л" авиа сэлгэх үзэгдэл түгээмэл байх тул **хадалун да'ун** гэх нь **хадран дуу** буюу шүдний хадрах, шудрах дуу чимээг өгүүлсэн үг бололтой. Үүнийг уг шүлгийн дараах мөрний

Харбисаа (эхэс, хальс) хазагсад

Хүйгээ таслагсад гэсэн хэллэгтэй холбож бодвол **хадран дуу** гэх нь утгын хувьд яг таг нийцэж байгаа юм. НТ-г

орчин цагийн монгол хэлнээ буулгасан дотроос Бөххишиг, Алтан-Очир, Дугаржав нар үүнийг "хадран дуу" гэж хөрвүүлснийг тэмдэглэе.

553. (Х)онтужажу гэдгийг хх-д 遠箭射着(холоос харваж) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **онох-онуулах** гэдэгтэй гарал нэгтэй ажээ. НТ-ны 139-р зүйлд **(х)эрэкэй-түр (х)ончитан** гэхийг 大拇指行能發箭的 (эрхий хуруундаа харвах чадалтай) гэж орчуулсан байна. Эдгээр жишээ баримтаас ажиглахад эл үг нь эдүгээгийн **оньчтой, оновчтой** гэдэгтэй нэг язгуур бүхүй мэргэн харвах намнахыг илэрхийлсэн утгатай ажээ. Эл үг бас НТ-ны 254-р зүйлд мөн **харваж** гэсэн утгаар гарч байна.

1227 оны Чингисийн чулууны бичигт "гурбан жагуд гучин табун алдас-дур **онтудлага**" гэснийг судлагчид голцуу "гурван зуун гучин таван алд [газарт] онууллаа" гэсэн утгаар ухаарсан, уншсан байдаг. Тэрчлэн Чингис хааны "Эр хоёр загалын туужид": "баг-а жагал ану жэбэ **онгтудхуи**-йин тэдүи гажар-а байижу кэлэбэ" гэх нь зэв онох буюу сум тусах газар гэсэн утгатай ажээ.

554. Дөтөлэксэн гэдгийг 抄直了的 (дөтөлсөн) гэж орчуулжээ. ЭНэ нь **дөт өтөлсөн** бувюу түргэн өтөлсөн гэсэн утгатай юм. Үүнийг Цэнд гүн "үтэр өтрөгсөн" гэж буулгасныг зүйтэй гэж санаж байна.

555. Түйиджү гэдгийг хх-д 遮着(битүүлэх, халхлах) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний саад, тотгор гэсэн утгатай **түйдэх, түйтгэр** гэсэн үгтэй нэг гаралтай юм. Турфаны цуглуулгын "Билиг брамидын" тухай сургаал шүлэгт:

Гэгэгэн сэдкил-үн чинар-и
Гэрисгэ болун **түидүгчи**
Гэм-тү магуи нис-ванис-и

Гэйигүлүгчи билиг брамид буи гэжээ. Энд түйдэгч гэдэг үг мөн хаагч, боогч гэсэн утгатай байна.

556. Нэ'үлэ гэдгийг хх-д 古樹(хуучин мод) гэж орчуулжээ. Эл үгийг НТ-ны 254-р зүйлийн хх-д 大木(том мод) гэж хөрвүүлсэн байна. Нэ'үлэ буюу монгол бичгийн хэлний **нэгүл** хэмээх нь унанг бүдүүн мод, дүнз мод зэргийг хэлнэ. (Мансаан, 1985, 311; Элдэнтэй, Ардаажав, 1986, 797; Сэцэнцогт, 1988, 533)

557. Нэткэл гэдгийг хх-д 亂麻(саарсан олс) гэж орчуулжээ. Үүнийг бас НТ-ны 254-р зүйлийн хх-д 麻繩(олсон иш) гэж орчуулсан байна. Энэ нь чухамдаа эрчилсэн, нийтэгсэн дээс буюу эдүгээгийн

монгол хэлний **нийтгэл** гэсэн үгийн эртний хэлбэр бололтой. Эл үгийг проф. Баяр (1981,III, 289) орчин үеийн монгол бичгийн хэлээр "нэйидкэл" гэж буулгасан нь зүйтэй байна. Бидний санавал "нэткэл мэтү улус" гэх нь нийтгэл (нийтгэсэн утас, дээс) мэт нийлүүлж нэгтгэсэн улс гэсэн утгатай ажээ.

558. **Тулу** гэдгийг хх-д 柱腳 (тулгуур, суурь) гэж орчуулжээ. Энэ нь **тулах** гэдэг үйл үгээс гаралтай тулгуур, багана гэсэн утгатай үг юм.

559. **Туйал** гэдгийг хх-д 群鳥(сүрэг шувууд) гэж орчуулжээ. Бас НТ-ны 254-р зүйлийн хх-д эл үгийг 雀群(болжморын сүрэг) гэж бүр тодорхой болгож орчуулсан байна. Чухамдаа энэ нь бөөнөөр сүрэглэн явагч бялзуухайн төрлийн шувууг нэрлэсэн үг бололтой юм. Элдэнтэй, Ардаажав нар (1986, 799) нар "туйал хэмээх нь бялзуухайн нэр. Бор бялзуухайнаас бага цээжний өд сөдийн өнгө нь харилцан адилгүй Муни уулын ой шугуй дотор оршин сууна. Урадын аман яриand **туйал** хэмээмой" гэжээ. Якут хэлд **туйар** хэмээх нь болжморыг хэлдгээс үзвэл (Пекарский, 1917, 2795) эл үг монголын зарим төрөл хэлд байх бололтой.

560. **Мандутала** гэдгийг хх-д 長進間(мандтал, дээшилтэл) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний **мандуху** гэдэгтэй үүсэл нэгтэй бөгөөд НТ-ны эл зүйлд өсөж, торинох гэсэн утгатай байна.

561. **Данглasун** гэдгийг хх-д 土塊(хэсэг шороо) гэж орчуулжээ. Эл үг бас Мин улсын үеийн (1610) "Лү лүн сай-лүэ" хэмээх монгол-хятад утгын зүйл хуваасан тольд **дангна'усу** гэсэн хэлбэрээр гарч байна. Үүнийг эл толь бичигт 堆(овоолсон шороо) гэж орчуулжээ. Бидний бодлоор уг үгийн гарал нь орчин цагийн монгол хэлний "**данги** хөлдүү, **дангир** хөлдөх" гэдгийн **данги** буюу **дангинах** (Цэвэл, 1966, 187) хэмээхтэй язгуур нэгтэй бөгөөд хатуу, цул, бөөн гэсэн утгатай ажээ. НТ-ны эл зүйлийн

Дайр этүгэнийг
Данласун төдий бүхүйгээс
Далай мөрнийг
Горхин төдий бүхүйгээс гэсэн бадаг шүлгийн санаа нь

"Сүмбэр уулыг дов байхад
Сүн далайг шалбааг байхад" гэдэг шиг энэ газар дэлхийг нэг "бөөн шороон чигнээ" юм байхаас гэх юм уу аль эрт цагаас нөхцөж нөхөрлөж ирсэн гэсэн утгыг илэрхийлж байгаа

юм.

562. **Кэрэлжү** гэдгийг хх-д 恐着(айж эмээх) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний эмээн сочих гэсэн утгатай **хирд** хийх гэдэгтэй гарлын холбоотой байж болох юм.

563. **Түлижү** гэдгийг хх-д 蓋了着(бүтэж) гэж орчуулжээ. Эл үг монгол бичгийн хэлний **түлкикү** гэдэгтэй язгуур нэгтэй байж магадгүй байна. Одоо үеийн ярианы хэлд тарвага нүхээ бөглөх, таглахыг нүхээ **түлхэх** гэж хэлдгээс үзвэл эл үг дундад эртний монгол хэлд НТ-ны эл зүйлд гарсанчлан мөн бүтээх, таглах гэсэн утгатай байжээ.

564. **Өдүр шира да** гэдгийг хх-日黃行' (өдөр шард) гэж үгчлэн орчуулжээ. Энэ нь чухамдаа үүрийн шар гэгээг өгүүлсэн бололтой байна.

565. Мүнлиг эцгийн хөвүүд Тэб тэнгэрийн цогцосыг ямар нэг нууц аргаар авсан буюу эсвээс Отчигин нар түүний хүүрийг сэм зайлуулсныг Чингис хаан тэнгэрт эс таалагдан үгүй болов гэж олонд зарлиг тунхаг тараасан бололтой.

566. **Жингүү-ийн** гэдгийг хх-讒譖的 (муу үгээр гүтгэх) гэж орчуулжээ. Эл үг "Цагаан түүх", "Эрдмийн товч" зэрэг бусад түүхэн сурвалж бичгүүдэд **жэнггүжү , йэнггүкэн** гэсэн хэлбэрээр мөн гүтгэх, ховлон гутгах гэсэн утгаар гардаг байна. Элдэнтэй, Ардаажав (1986, 804-805) нар эл үгийн гарлыг монгол бичгийн хэлний **инггүкэн, йэнггүкэн** гэдэг үгстэй холбож үзсэн ажээ.

567. **(Х) Удару'асу** гэдгийг хх-解折呵 (тайлбарлаж задлах) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний **ударху** (задрах, урагдах) гэдэгтэй язгуур нэгтэй бөгөөд НТ-ны эл зүйлд нууц зүйлийг задруулах, нууц алдах гэсэн утгатай байна. Уг үг НТ-ны 255-р зүйлд мөн ийм утгаар гарч байгааг тэмдэглээ.

568. **Жэ тэли** гэдгийг хх-罷那事 (тэр учир болно) гэж орчуулжээ. Монгол хэлд "Р", "Л" авиа сэлгэх учир энэ нь "Жэ тэри" гэх буюу "за тэгье, ингэе" гэсэн утгатай үг бололтой.

569. **Жалираба** гэдгийг хх-д 息怒了.(уур тайтгарав) гэж орчуулжээ. Энэ нь сэтгэл амрах, тайтгарах гэсэн утгатай бөгөөд эл үг НТ-ны 254, 260, 277-р зүйлд мөн утгаар, **жалира'улу'асу, жалиражу** гэсэн хэлбэрээр гарч байна. **Жали** хэмээх нь (Мукаддимат Ал-Адаб) тольд "Амар, тайван" гэсэн утгатай байна. Тухайлбал **жали олба гажарту** гэхийг оросоор "нашел покой в земле" (Поппе, 1938, 200) гэж

орчуулжээ. Мөн үгийн талаар Элдэнтэй, Ардаажав (1986, 806), Сэцэнцогт (1988, 2332) нарын тайлбараас харьцуулан үзэж болно.

570. Жибтуражу'уи гэдгийг хх-д 消滅了有 (арилав, устав) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **шувтлах-шувтрах** гэдэгтэй үүсэл нэг болно. Дариганга аман аялгуунд шувтлах гэдгийг **жувтлах** гэж хэлдэг нь монгол сонгодог бичгийн хэлнийхээс НТ-д ойр дуудлагатай байна.

МНТ-г орчин цагийн монгол хэлээр буулгасан эрдэмтдийн дотроос Бөххишиг (1941, 247) эл үгийг монгол бичгийн хэлнээ **шибтуражухуй** гэж хөрвүүлснийг тэмдэглэе. Шувтлах, шувтрах гэх нь эдүгээгийн ярианы хэлд хэтрэх, дэндэх гэсэн утгаар бас хэрэглэгдэнэ. Жишээлбэл уралдааны морины уяа сойлгыг хэтрүүлэхийг "уяа шувтлах" гэж хэлдэг билээ.

Ц.Норжин, Ман Мөрөн (1999, 2939) нарын тольд "жибтэрэгэ" гэдэг үгийн тайлбарт " ... эсвэл үйл хөдөлгөөн дээрээ илэрсэн үл мэдэгдэм сэв сэжиг" хэмээсэн байна. НТ-ны **чираи жибтуражу'уи** гэсэн хэллэгийг энэ утгаар бодож үзвэл энэ нь одоогийн ойлголтоор "царай алдав" гэсэн утгатай шиг санагдана.

571. Фү жиү гэдгийг хх-д 州 (орон муж) гэж тэмдэглэжээ. Энэ нь чухамдаа 撫州(фү жоу) гэсэн нэртэй газар бөгөөд эдүгээгийн БНХАУ-ын Хэ-бэй мужийн умард хэсэгт орших Жан жиа көү-гээс (монгол дуудлагаар Жанчхүү) хойш байх газар бололтой.

572. Сөндэифү гэдгийг хх-д 府(хуучин засаг захиргааны нэгж) гэж тэмдэглэжээ. Үүнийг Захчидсэцэн, В.Кливез, Иринжин нарын судлагчид 宣德府(шүан те фү) хэмээх газрын нэр гэж сэргээн тайлбарлаж, энэ нь одоогийн Цахрын хуучин мужийн шууд харьяа 口北道гэдэг газрыг мөн болно гээд Манж дайчин улсын үед монголчууд Баян сүм гэж нэрлэж байсан байна. (Элдэнтэй, Ардаажав (1986, 809) нарын тайлбараас дам авав)

573. Бэкилэкдэжү гэдгийг хх-д 被守禦着 (бэхлэн барьж) гэж орчуулжээ. Энэ нь хаагдаж, бэхлэгдэж, хориглогдож гэсэн утгатай юм.

574. Чөлгэ гэдгийг хх-д 川(хөндий) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **чөлөө** зай гэсэн үгтэй гарал нэгтэй бөгөөд уулын хоорондын завсар чөлөө буюу хөндий газрыг өгүүлсэн байна. Үүнийг харин Цэндгүн "жалга" гэж үзжээ.

575. (Х)урба датажу гэдгийг хх-翻了掉着(эргүүлэн датаж) гэж

орчуулжээ. **(Х)урба** хэмээх нь орчин цагийн монгол хэлний **урвах, урвуулах,** (эргэх, эргүүлэх) гэдэг үгийн хуучин хэлбэр бөгөөд **(Х)урба датажу** гэх нь морины жолоог гэдрэг эргүүлэн татахыг хэлжээ.

576. Сундурчу гэдгийг хх-д 陸續(залгаа залгаагаар, хойно хойноосоо) гэж орчуулжээ. Бидний санавал уг үгийн гарал нь монгол бичгийн хэлний **сундалаху** гэдэг үгтэй язгуур нэгтэй бололтой. Гэхдээ уг үгийн утга нь хх орчуулгад тэмдэглэсэнчилэн ар араасаа залган гарч ирэх буюу орчин цагийн монгол хэлний **ундрах** гэдэгтэй ойролцоо агуулгатай байгаа тул бид эл хэллэгийг "**ундарч** айсуй дайсныг дарав" гэж одоогийн аялгуунд хөрвүүлэв.

577. Шира тэг гэдгийг хх-д 龍虎臺 (луу, барсын давцан) гэж тэмдэглэжээ. Үүнээс үзвэл Шира тэг (шар тээг) хэмээх эл газар нь давцан мэт тэгш талбар сайхан газар учраас Мин улсын үеэс Хятадаар Лон ху тай буюу "Луу барсын давцан" гэж нэрлэх болсон бололтой. Өгөдэй хаан 1231 онд Хятанчуудад довтлоход мөн энэ Шира тэгт буудалласан нь санамсаргүй зүйл биш биз ээ.

578. Жүн дү гэдгийг хх-д 大都(Их нийслэл) гэж тэмдэглэжээ. Жүн дү (中都) хэмээх нь хятадаар "Дундад нийслэл" гэсэн утгатай үг бөгөөд одоогийн Бээжин хотыг Алтан улсын үед ингэж нэрлэж байв. Харин Мин улсын үеэс Да дү буюу "Их нийслэл"гэж нэрлэх болсон тул НТ-ны хх орчуулгад 大都 (Да дү) гэж тэмдэглэсэн байна.

579. Дүн чан гэдгийг хх-д 郡名(орон нутгийн нэр) гэж тэмдэглэжээ. Эл газрыг Элдэнтэй, Ардаажав (1986, 813) нар "Чин улсын үед Шан дүн мужид харьяалагдаж байсан эдүгээгийн聊城縣(Лю чен шен) хэмээх газар мөн болно" гэж үзжээ.

580. Эл зүйлд өгүүлж буй Вангин Чинсан бол НТ-ны 132-р зүйлд гарсан Вангин Чинсангаас өөр хүн болно.Энд өгүүлж буй нэрийн талаар В.Кливез (1982, 184) Мансаан (1985, 353), Иринжин (1987, 240) нарын тайлбарыг үзнэ үү.

581. Хала-ар гэдгийг хх-д 必然(зайлашгүй) гэж орчуулжээ. **Халагар** хэмээх үг "Хуа-и И-ю " тольд мөн зайлашгүй, гарцаагүй гэсэн утгаар гарч байна.

582. Хура'улу'асу гэдгийг хх-д 收呵(хурааваас) гэж рчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **хураах, хураалгах** гэдгийн хуучин хэлбэр бөгөөд НТ-ны эл зүйлд нэгтгэх, нийлүүлэх гэсэн утгатай байна.

583. (Х)э'үшийэжү көлчиркэмүи гэдгийг хх-д 不宜着瘟病了有

(үл зохицон өвчлөв) гэж орчуулжээ. Энэ нь чухамдаа монгол хүн морьд халуун газрын уур амьсгалд үл нийцэн хямарч байсныг өгүүлжээ. Уг хэллэгийн утга агуулгыг нягтлан үзвээс орчин цагийн монгол хэлний "эгшиж (эгших, эврэх) хөлчүүрмүй" гэсэн үгтэй холбоотой санагдана. Эдүгээгийн халх монголчуудын ярианы хэлд архи дарсанд халж согтуурахыг **хөлчүүрэх** гэхийн хамт ордос аялгуунд халуурснаас болж ухаан мэдрэл самуурахыг мөн **күлчигүрнэ** гэдэг байна. (Элдэнтэй, Ардаажав, 1986,817)

Бид эл хэллэгийг утгачилан "үл идээшин хямралдмой" гэж хөрвүүлэв.

584. Гүнжү гэдгийг НТ-д хүний нэрийн маягаар дурдсан боловч хятад хэлний 公主(гүн жү) хэмээх нь хааны охиныг нэрийдсэн үг болно. Чухамдаа НТ-д Гүнжү нэртэй охин гэж өгүүлсэн нь учиртай хэлсэн зүйл байж болох юм. Вангин Чинсан Чингис хааныг мэхлэх аргандаа зориуд Гүнжү нэртэй охиныг сонгож авсан байж болно.

585. Можиу гэдгийг хх-郡名 (орон нутгийн нэр) гэж тэмдэглэжээ. Энэ газрыг Фан Лин-гүй (1986, 269) "Ямарч атугай Фү жиүгийн ойролцоо одоогийн Шин Хо Шианы (興和縣) нутагт байж болох бололтой" гэж таамаглав. Элдэнтэй, Ардаажав (1986, 817) одоогийн Рин чиу шианы (任丘縣)хойно гучин газарт буй хэмээн "БНХАУ-ын эрт эдүгээгийн газрын нэрийн их толь бичгээс" иш татан өгүүлсэн байна.

586. Фү жиү гэдгийг хх-д 郡名 (орон нутгийн нэр) гэж 247-р зүйлд гарснаас арай өөрөөр тэмдэглэжээ. 572-р тайлбарыг үзнэ үү.

587. Ала'аи ба гэдгийг хх-有來俺 (байлаа бид) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний агсан, ажгуу хэмээх дутмаг үйлийн "а" язгуурт үйл үгийн өнгөрсөн цагийн утга заах –ла'а нөхцөл залгаж хэлбэржүүлсэн бололтой байна. "Ба" хэмээх нь орчин цагийн монгол хэлээр бид гэсэн утгатай тул эл хэллэгийг одоогийн аялгуунд "айж байлаа бид" гэж хөрвүүлэв.

588. Нунжи гэдгийг хх-д不動的(хөдөлгөөнгүй) гэж орчуулжээ. Эл үг орчин цагийн монгол хэлний **нунж, нунжрах** (сул дорой, удаашрах) гэдэг үгтэй гарал нэгтэй байж болох юм (Цэвэл, 1966, 388). Уг үг бас НТ-ны 265-р зүйлд мөн ийм утгаар гарч байна.

589. Нөдүгсэн гэдгийг хх-д築的(барьж байгуулсан) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний **нөдүкү** гэдэгтэй нэг гаралтай бөгөөд хотын хэрэм буюу байшин сууцаа шавар тоосгоор **нүдэж** цохиж барьж байгуулсан гэсэн утгатай ажээ. Эл үг мөн НТ-ны 265-р зүйлд

гарна.

590. Ха гэдгийг хх-д 係官 (ноёны алба, хааны алба) гэж орчуулжээ. Лувсанданзаны "Алтан товчид" үүнийг "**санг** болгажу өгсү" гэсэн байна. Бид хх. орчуулгыг баримтлан "хааны [алба] болгож өгье" гэж хөрвүүлэв.

591. О'орху гэдгийг хх-放的(тавих) гэж орчуулжээ. Энэ шувуу ан гөрөөсний хойноос тавих, нисгэх гэсэн утгатай юм. (29-р тайлбарыг үзнэ үү)

592. Хура'улжу гэдгийг хх-聚着 (хурж, цуглуулж) гэж оновчтой орчуулжээ. Бид шүлгийн толгой холбоцод нийцүүлэн "агуулж" гэдэг үгээр хөрвүүлэв.

593. Жау гон хэмээхийг хх. орчуулгад 宋(сүн) гэж тэмдэглэжээ. Энэ нь дорнод Сүн улсын Нинг Цүнг (寧宗 1195-1224) хааны овгийг хэлсэн бөгөөд чухамдаа Сүн улсыг өгүүлсэн бололтой юм.

594. Түн гуань гэдгийг хх-關名 (боомтын нэр) гэж тэмдэглэжээ. Энэхүү Түн гуань (潼關) боомт нь одоогийн БНХАУ-ын Сан-ши мужийн дорнод хязгаарт орших бөгөөд Сан-ши, Шан-ши, Хэ-нан гурван мужийн уулзвар газар болно.

595. (Х)ула'ан дэгэлэн гэдгийг хх-д 種 (омог төрөл) гэж тэмдэглэжээ. НТ-ны 170, 171-р зүйлд Ван хан, Чингис хоёрын Хар халзан элстэд хийсэн тулалдаанд Ван хан цэргээ Жиргин омогтноор, Чингис цэргээ Урууд, Мангууд омогтноор манлайлуулан дайтсан тухай өгүүлсэн байдаг билээ. Үүнээс үзвэл Алтан ханы цэргийн манлай болсон Улаан дэгэлэн хэмээх нь НТ-ны хх. орчуулгад тэмдэглэсэнчлэн нэг овог угсааны нэр буй заа.

596. Намгин хэмээхийг хх-. орчуулгад 汴梁(Биань Лиан) гэж тэмдэглэжээ. Энэ нь одоогийн БНХАУ-ын Хэ-нан мужийн Кай-фэнг (開封) хот мөн бололтой. Уг хотын жинхэнэ нэр нь Дүн жин Кай фэнг фү гэдэг байв. Алтан улсын үед умарт Сүнгийн хуучин нийслэл Кай фү-г хожим нь Бийань жин гэх болжээ. Сүн улсын Же-Йуаны анхдугаар оноос (1153) Нанжин(南京)буюу "Өмнөд нийслэл" хэмээн өөрчлөн нэрлэх болсон байна. Хожим нь Юань улсын үеэс Биань, Лиан хоёрыг нийлүүлэн дуудаж Нанжин хотыг нэрлэх болсог Мин улсын үеийн НТ-ны хх-д **Намгин** (Нанжин) хэмээхийг "Биань Лиан" гэж тэмдэглэсэн учир ийм ажээ.

Миний бие Дариганга нутагт аман уламжлалаар дэлгэрсэн "Их Жүнхэн хатан" гэдэг бэнсэн үлгэрийн хоёр хувилбарыг 1963 онд

хэвлүүлсэн билээ. Уг үлгэрийн эхэнд "Дүн жин мин лан Хай пи хотын долдугаар шан гүрний эзэн хаан..." гэж өгүүлдэг нь бидний дэр тэмдэглэсэн "Дүн жин Бианьлиан Кай фэнг фү"-г өгүүлсэн ажээ.

597. Хо си вү хэмээхийг хх-д 鎭名 (хот суурины нэр) гэж тэмдэглэжээ. Хо си вү (河西務) хэмээх нь одоогийн Тиан жин хотын баруун хойд этгээдэд байх бололтой. Энэ нь Чингисийн цэрэг Жүн дүгийн (Бээжин) дорнод этгээдээс орж ирсэн газрын чиглэлтэй таарч байна.

598. Лиү шиү 留守 хэмээх нь нангиад үг учраас хх-д орчуулаагүй байна. Энэ нь хотыг үлдэн сахигч буюу хамгаалагч гэсэн утгатай ажээ.

599. (Х)артаи гэдгийг хх-д 紋有的(артай) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний торгоны **ар** гэдгийн эртний хэлбэр болно.

600. Буйгин буюу одоогийн дуудлагаар **Бэй жин** гэдгийг хх-д 大寧(Да нин) гэж тэмдэглэжээ. Энэ нь одоогийн Өвөрмонголын өөртөө засах орны Зуу Од аймгийн төв Улаан хад хотоос урагш орших 寧城(Нин чэн) хот мөн бололтой.

601. Чулулжа'ура гэдгийг хх-д орчуулаагүй байна. Ийм учраас уг үгийг судлагчид янз бүрээр таамагласаар иржээ. Эл үгийг НТ-ны нангиад галигт "чул улжа'ура" гэсэн маягаар галигласан учир Баяр, Мансаан, Иринжин нарын судлагчид "цул олзвор" юм уу "цул олдвор" гэсэн үг болов уу гэж үзсэн байна. Ингэж үзэхэд бас авиа зүйн хувьд жаахан зөрчилтэй юм шиг санагдана. ОДоогийн ойголтоор "цул олзвор" гэсэн үг юм аа гэж үзвэл НТ-ны нангиад галигт "чулу олжа'ура" гэсэн байдлаар тэмдэглэх байсан болов уу гэж санана.

Проф. П.Пеллио "Түрэг монгол хэлний зам гэдэг үгийн тухай" (1930, 192-195) гэдэг өгүүлэлдээ энэхүү чулулжа'ура гэдгийг НТ-ны 134-р зүйлд гардаг **жа'утхури** гэдгийн **жа** (纠) буюу холимог, хольж хутгалдсан хэмээх үгтэй холбоотой байж магадгүй гэсэн сонирхолтой санал дэвшүүлжээ. Бөртэ үжин мэргэд аймагт олзлогдож тэдэнтэй хольцолдон Жөчи төрсөн тул ингэж үзсэн бололтой.

Бид эл үгийг орчин цагийн монгол хэлний цулхагар-цүлхэгэр гэдгээс үүсэлтэй **цулхалзуур** буюу **цүлхэлзүүр** гэдэг үгтэй учир холбогдолтой болов уу гэж таамаглаж байгаа юм. Энэ нь Жөчийг гадуурхан муучилсан утга санаанд ч дуудлагын хувьд ч тохирох мэт санагдана.

Элдэнтэй, Ардаажав (1986, 830) нар эл үгийг "чулгул жагура"

гэж буулгасан нь үндсэндээ бидний саналтай нийцэж байна.

602. (Х)онтучажу чимада харта'асу. (х)эрэкэи-йэн (х)охтолжу о'орсухаи гэдгийг хх-д 賽遠射着你行被勝呵 大拇指自的行割斷着去我 (харвалдаж чамд дийлэгдвэл том хуруугаа огтлож хаяьяа би) гэж орчуулжээ. Эл хос мөрт шүлгийн **эрхийгээ огтлох** гэх нь эртний монголчуудын андгай тангараг тавих зан үйлтэй холбоотой ойлголт юм. Тухайлбал "Эрхий мэргэний" домог-үлгэрт тэрээр долоон нарыг долоон сумаар нэг харваж унагааж чадахгүй бол **эрхий хуруугаа огтлоод**, эр хүнээ байгаад хар ус уухгүй, хагд өвс идэхгүй амьтан (тарвага) болоод харанхуй нүхэнд амьдарна гэж ам алдаж андгай тангараг тавьж байдаг. Жөчи энэ ёсоор Цагаадайд ам гарч андгай тангараг тавьж:

Онтдож (харваж) чамд гартваас
Эрхийгээ огтлож огоорсугай
Абалдаж (барилдаж) чамд ялагдваас
Унасан газраас бүү боссугай гэж өгүүлж байдаг.

Эр хүний хүчин чадал, сүнс сүлд нь эрхий хуруундаа байдаг гэдэг ойлголтын тухай Ш.Гаадамба (1966, №3, 66-69) "Эрхий мэргэний домгийн учир" гэдэг өгүүлэлдээ өгүүлсэн буй. Тэрчлэн проф. В.Хайссиг 1987 онд Өвөрмонголын Их сургуулиас зохион хийлгэсэн олон улсын монголын судлалын эрдэм шинжилгээний бага хуралд тавьж хэлэлцүүлсэн илтгэлдээ: "Нум сум хэрэглэх нь шинэ чулуун зэвсгийн үеэс эхэлсэн бөгөөд түүнийг хэрэглэхэд хүний эрхий хуруу тун чухал үүрэгтэй болжээ. Ийм учраас монгол туульд эрхий хурууны тухай мотив өргөн дэлгэрсэн байна. Тэр үеийн хүмүүс эрхий хурууг сүнс буюу амиа орших орон гэж үздэг" хэмээн зөв зүйтэй тодорхойлсон байна.

603. Гэрулэлдүн гэдгийг хх-相攻(довтлолцож) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **гөрлөх-гөрдөх-гөвших** гэдэгтэй язгуур нэгтэй бололтой (Сэцэнцогт, 1988, 1309).

604. Хору'улжу гэдгийг хх-教凝了着(царцуулж) гэж оновчтой орчуулсан байна. Уг үгийн язгуур нь орчин цагийн монгол хэлний бөөгнөрөх, овоорох гэсэн утга бүхүй **хорох** (Цэвэл, 1966, 696) гэдэгтэй гарал нэгтэй бололтой. Дагуур хэлд тос царцаж хатуурахыг **хоро** гэдэг байна (Элдэнтэй, Ардаажав, 1986, 839). Энэ нь орчин цагийн монгол хэлний **хөр** цас гэдэгтэй холбогдолтой байж болох юм.

605. Хахунаг гэдгийг хх-д 衣胞 (?) гэж орчуулжээ. Мэргэжлийн

хүмүүсийн үзэж байгаагаар хх. орчуулгын '衣胞' гэсэн хоёр үсгийн байр солигдсон бололтой юм. Хэрэв 胞衣' Байваас хүний хэвлий дэх хүүхдийн гэр, хальс гэсэн утгатай ажээ. "Ци хай" (1979, 3453) буюу "Үгсийн далай" хэмээх их толь бичигт эл үгийг "жирэмсэн эмэгтэй болон хөхтөн амьтны хэвлий дэх хүүхэд, үр төлийн хальс, гэр" гэж тайлбарласан байдаг байна. **Хахунаг** хэмээх нь гарлын хувьд орчин цагийн монгол хэлний эр амьтны үр булчирхайн хүүдий хуух, хуухнаг (Цэвэл, 1966, 739) гэдэгтэй утгаа сурвалж нэгтэй бололтой. Харин дундад эртнйи монгол хэлд эл үг эхийн хэвлий дэх хүүхдийн хальс гэрийг хэлдэг байсан санагдана.

606. Чинар ину жэкэйирэкү гэдгийг хх-情他的冷着 (сэтгэл нь хөрч) гэж оновчтой орчуулжээ. Эл хэллэгийн **жэкиржү** хэмээх нь монгол бичгийн хэлний **жэкэйирэкү** (хөрөх, зэлгээн болох) гэдэг үгтэй гарал нэгтэй болно. Ийм учраас уг хэллэг нь хх. орчуулгад тэмдэглэсэнчлэн "сэтгэл нь хөрч" гэсэн утгатай байна.

607. Гэнү 'эр гэгийг хх-д 怨悔(гомдол, гэмшил) гэж орчуулжээ. Энэ нь эдүгээгийн монгол хэлний **гэмших, гэмрэх** гэдэг үгтэй язгуур нэгтэй бөгөөд НТ-ны 231-р зүйлийн **гэмүри'үлүн** хэмээхтэй утга ойролцоо юм. (529-р тайлбарыг үзнэ үү)

608. Хантухалажу гэдгийг хх-馬上捎着 (морин дээр унжуулж) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний **ганжугалажу** гэдгийн хуучин хэлбэр болно. Эл үгийг И.Рахевилз (1972, 151) **ханжухалажу** гэж галигласан байна. Утгын хувьд энэ нь орчин цагийн монгол хэлний "толгойгоо ганзагалах" гэдэг хэллэгтэй тохирно.

609. Шики гэдгийг хх-д 牙縫中肉 (шүдний завсрын мах) гэж орчуулсан нь зүйтэй байна. Эл үг гарлын хувьд монгол бичгийн хэлний **шикикү** гэдэгтэй үүсэл нэгтэй бөгөөд шүдэнд шигсэн буюу орсон махыг өгүүлжээ.

610. Өлүмлэн гэдгийг хх-д 向前 (урагшлан) гэж орчуулжээ. Харин НТ-ны 207-р зүйлийн хх-д эл үгийг "өрсөлдөн, тэмцэлдэн" гэсэн утгатай үгээр орчуулсан байна. (491-р тайлбарыг үзнэ үү)

611. (Х)ораитала гэдгийг хх-聚 (чангартал) гэж орчуулжээ. Мөн НТ-ны 73-р зүйлийн **үкитала** гэдгийг хх-д үүнтэй адил "жин" гэсэн үгээр орчуулсан буй. (80-р тайлбарыг үзнэ үү)

612. (Х)о'ожитала гэдгийг хх-д 短(огдойтол) гэж орчуулжээ. Үүнтэй холбогдуулж 73-р зүйлийн **(х)ожитала** гэсэн үгийн тухай 81-р тайлбарыг үзнэ үү.

613. Нийитаитала гэдгийг хх-д 80-р тайлбарын **үкитала**, 611-р тайлбарын **(х)ораитала** гэдэгтэй нэгэн адилаар 聚(чангартал) гэж орчуулжээ. Эл гарлын хувьд орчин цагийн монгол хэлний **нятгар** гэдэгтэй үүсэл нэгтэй байж болох бөгөөд НТ-ны эл зүйлд "атиртал, чанагартал" гэсэн утгаар оржээ.

614. Хучижу гэдгийг хх-д 咽着 (залгиж) гэж орчуулжээ. Эл хх. орчуулгын咽(иэ) гэсэн үгийг Өвөрмонголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн монгол хэл бичиг судлах газраас хэвлүүлсэн "Хятад-Монгол тольд" (1983, 1985) "бэгтрэх, бүгших" гэж орчуулснаас үзэхэд эл үг нь хахирах буюу хоолой гэсэн утга бас байх бололтой.

615. Буи гэдгийг хх-д орчуулаагүй байна. Энэ нь орчин цагийн монгол хэлний бохир, халтар, хултар гэсэн утга бүхүй **бой** гэдгийн хуучин хэлбэр ажээ. Монгол ардын зүйр үгд "**Бой** нь арилаагүй, борви нь тэнийгээгүй хүүхэд" (Цэвэл, 1966, 88) гэж хэлдэг нь НТ-ны эл зүйлийн

Буй тану арилгажу
Бурбуи тану эркү'үлжү гэдэгтэй адилавтар

утгатай юм.

616. Холбаран гэдгийг хх-д 並行(зэрэгцэн явж) гэж орчуулжээ. Эл үг монгол бичгийн хэлний **холбуг-а** гэдэгтэй язгуур нэгтэй бөгөөд "холбоотой явж, цуг явж" хүчээ өгье гэсэн утгатай байна.

617. Өрүг гэдгийг хх-д 敦厚(үнэнч шударга) гэж орчуулжээ. Эл үг гарлын хувьд монгол бичгийн хэлний **өрү - өрүчэ** гэдгээс үүсэлтэй **өрөвч зөөлөн** гэх буюу номхон дөлгөөн гэсэн үгтэй холбоотой бололтой. Үүнийг Бөххишиг (1941, 261) монгол бичгийн хэлээр "номухан дөлгөн" гэж хөрвүүлсэн нь зйүтэй бололтой. Уг үг НТ-ны 230-р зүйлд "бөх тайван" гэсэн утгаар гарсан билээ. (521-р тайлбарыг үзнэ үү).

618. Махалаи-йин баулийа гэдгийг хх-д 皮帽的教訓(малгайн сургаал) гэж орчуулжээ. Энэхүү холбоо үгийн **махалаи** гэх нь орчин цагийн монгол хэлний **малгай** гэсэн үг гэдэг нь тодорхой. Эдүгээгийн ойрд, халимаг хэл аялгуунд малгайг **махла** (Муниев, 1977, 344) хэмээн хуучин хэлбэрээр өгүүлсээр буй. **Баулийа** гэдэг үгийн гарлын талаар бид тодорхой мэдэхгүй юм. Утгын хувьд байдал ёс, дүрэм сургууль гэсэн агуулгатай бололтой байна. Бидний бодлоор "Бара'а йэкэ махалаи-йин баулий-а тани'улубасу болу жэ" хэмээх нь сүр бараа ихт малгай буюу хааны титмийн дүрэм ёсыг таниулж болно гэсэн утгатай ажээ. Монголчуудын эртний уламжлалт заншлаар ямар ч хүн аливаа

хүндэтгэлийн ёс журамд малгай өмсөж, ёс төр гүйцээдэг байв. Ийм учраас Жөчи, Өгөдэйг хаан эцгийн дэргэд байлгаж төрийн ёс эрдэмд суралцуулъя гэсэн санааг гаргажээ.

Тэрчлэн НТ-ны 260-р зүйлийн "боро шибау'ун **баулийа** дур сайи оруху мэтү" гэх нь бор шувуу буйлаанд (амьтан барих сургуульд) сая орох мэт гэсэн утгатай байна. (628-р тайлбарыг үзнэ үү)

619. **(Х)аран-а бү (х)абхари'улутхун** гэдгийг 人行休教大咲您 (хүний элэг доог бүү бологтун) гэж оновчтой орчуулжээ. **(Х)абхари'улутхун** гэдэг нь гарлын хувьд орчин цагийн монгол хэлний **авирлалдах** (аашлалдах) гэдэг үгтэй холбоотой байж магадгүй юм. Дээрх хэллэгийг Бөххишиг (1941, 261) монгол бичгийн хэлээр

Иргэн-э бүү элгэлэгүлүгтүн
Күмүн-э бүү кэлэгүлүгтүн гэж хөрвүүлсэн нь нэлээд оновчтой болсон гэж бид санаж байна. Бид эл хос мөр шүлгийг эдүгээгийн аялгуунд утгачлан:
Иргэдийн инээдэм
Амьтны ханиадам бүү бологтун гэж буулгав.

620. Эл зүйр үг нь орчин цагийн монгол аман зохиолд:

"Өвсөнд ороовч үхэр идэхгүй
Өөхөнд ороовч нохой шиншихгүй" (Гаадамба, Цэрэнсодном), 1978, 16 гэсэн хувилбартай болсон байна.

621. **Кэтүс** гэдгийг хх- 横越着 (хөндлөн гаргаж) гэж орчуулжээ. Уг үг гарлын хувьд монгол бичгийн **кэтү, кэтүрэкү** гэдэг үгстэй язгуур нэгтэй бололтой. Чухам уг зүйлийн илэрхийлж буй санаа нь "хандгай байтугай" гэх юм уу "хандгай ч ярилтгүй" гэсэн утгатай шиг байна. Ийм ч учраас хх-д эл үгийг "хөндлөн өнгөрөх, гарах" гэсэн утгатай үгээр орчуулжээ.

622. **Чөлэс** гэдгийг хх-д 順應着 (шулуун шууд, хэтрүүлж) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний зайлуулах, үгүй болгох гэсэн утга бүхүй **чөлэкү** гэдэг үгтэй язгуур нэг бололтой. Бидний бодлоор

Хандахан кэтүс
Хулухуна чөлэс алдахуйу гэсэн зүйр үг нь "Хандгай хэтрээж (өнгөрөөж), хулгана цөлж алдана" гэсэн утгатай ажээ.

623. **Кэлбэс** гэдгийг хх- 翻着 (эргүүлж, урвуулж) гэж орчуулжээ. Энэ нь гарлын хувьд орчин цагийн монгол хэлний **хэлбийх, хэлтийх** гэдэгтэй язгуур нэгтэй бөгөөд хувьсах, өөрчлөх гэсэн утгатай үг юм.

Турфаны цуглуулгын нэгэн сургаалын шүлэгт:

Кэрэгүр худал хулагаи үилэ-түр
Кэлбүр жусур магуи үгэ-түр
Кэн-бэр эс-э халдабасу

Гэмшил үгэгү сайин эрэ болан буйу (Поппе, 1960, 257) хэмээсний "кэлбүр жусур магуи үгэ" гэсэн нь хувирамтгай, эргэж урвасан зусар муу үг гэсэн утгатай ажээ.

624. **Жалалдин Солтан** хэмээхийг хх- 王名 , 王(Вангийн нэр, ван) гэж тэмдэглэжээ. Жалалдин Султаны нэр гуншинг перс дуудлагаар нь: **Жалалуддин Харазм шах** гэдэг байна. Хорезм улсын эзэн Мухамед Чингисийн цэргийг 1218 онд довтлон ороход улсаасаа дутаан гарч яваад Каспийн тэнгисийн нэгэн жижиг арал дээр өвчнөөр нас нөгцөв. Тэрээр насан эцэслэхийн өмнө хөвүүдээсээ Жалалдинийг султан (эзэн) суулгажээ. Жалалдин монгол цэргийн довтолгооноос дайжиж эхлээд Газнад дутаан очиж, цэрэг бүрэлдүүлэн байгуулж, зургаан түмэн хүний хүчээр монгол цэргийн өмнөөс сөрөн тулалдаж, эхний удаа сүрхий ялсан боловч 1221 оны 12 сарын 24-нд Индү голын хөвөөнд Чингисийн цэрэгтэй тулалдахад тэднээс хатуу цохилт авч арга мухардахдаа морьтойгоо голын усанд орсонд золоор амь гарч цааш дутаан одоогийн Азербайжан, Грузиний нутгаар дайжиж явахад нь 1231 оны 8 сард Чормаханы удирдсан монгол цэрэг нэхэн очиж мөхөөсөн ажээ.

625. **Сө'эбэ** гэдгийг хх-д 絶了 (мөхөөв) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний "сөкүрэкү", "сөнүгэкү" гэдэг үгстэй язгуур нэг бололтой. Үүнийг Цэнд гүн "шигэб" гэж буулгасан байна.

626. **Махаижу** гэдгийг хх-д орчуулаагүй байна. Ийм учраас судлагчид уг үгийн утгыг янз бүрээр ойлгож, орчуулж тайлбарласан үзэгдэнэ. Тухайлбал НТ-г орчин цагийн монго хэлээр хөрвүүлсэн Ц.Дамдинсүрэн эл үгийг өмнөх **байасчу** гэдэгтэй нь холбон "баясаж бахдаж" гэж, Бөххишиг "байасчу махшижу" гэж, Алтан-Очир "байасужу махтажу" гэж, Дугаржав "байасун бахдажу" гэж, Мансаан "байарлан байасчу" хэмээн үүнийг холбоо үгийн маягаар ойлгож орчуулсан нь зүйтэй шиг санагдана. Ийм учраас бид уг үгийн язгуур үндсийг орчин цагийн монгол хэлний **магтах, бахдах** гэдэг үгтэй холбоотой болов уу гэж үзэж байна. Харин эл үгийн гарлыг Элдэнтэй, Ардаажав (1986, 867) махайиху буюу махрах гэдэгтэй холбож үзсэн билээ.

627. Бадаркижу гэдгийг хх-д說着(хэлж) гэж орчуулжээ. Энэ нь гарлын хувьд орчин цагийн монгол хэлний **бадрах, бадраах** гэсэн үгтэй холбоотой байж болох бөгөөд сүр бадруулан хэлэх юм уу омог догшин хэлэх гэсэн утгатай ажээ.

628. Баулийа гэдгийг хх-д調習 (тухирч сургах) гэж орчуулжээ. Үүнийг бид "тэжээсэн нохой, шувуу зэрэг амьтан бусад амьтдыг барьж сургахыг" (Цэвэл, 1966, 104) нэрийдсэн **буйлах** гэдэг үгтэй холбоотой болов уу гэж үзэж байгаа билээ. (618-р тайлбарыг үзнэ үү)

629. Мэнэ гэдгийг хх-д 頰煩 (олон) гэж орчуулжээ. (40-р тайлбарыг үзнэ үү)

630. Төбөд гэдгийг хх-西番 (төвд) гэж тэмдэглэжээ.

631. Со'оражу гэдгийг хх-解釋着 (тайлбарлаж) гэж орчуулжээ. Эл үг гарлын хувьд монгол бичгийн хэлний **чогуруху** гэдэгтэй үүсэл нэг байж магадгүй юм. Учир нь өдгөөгийн буриад аялгуунд цоорох гэхийг **соорохо** (Черемисов, 1973, 392) гэж хэлдэг шиг дундад эртний монгол хэлд "ч, с" авиаг мөн хутгаж ярьдаг байсан байж болно. Тэрчлэн НТ-ны **со'оражу** хэмээх нь одоогийн ярианы хэлд хүний ухаан бодол нэмэгдэх, онц сайжрахыг "цоорох" гэж ярьдагтай ойролцоо утгатай "сэхээрч, сөхөөрч, ухаарч" гэсэн санааг илэрхийлж байх бололтой. Ийм учраас эл үгийг зарим судлагчид (Алтан-Очир зэрэг) орчин цагийн монгол бичгийн хэлнээ **сэхээрч** гэж хөрвүүлсэн байна.

632. Үмэкши гэдгийг хх-逶北 (хойд зүг) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний умар зүг гэсэн үг болно.

633. Хурумши гэдгийг хх-д 姓 (овог) гэж тэмдэглэжээ. Үүнийг В.Кливез (1982, 203) Xwar(i)zm гэдэг үгнээс гаралтай гэж тэмдэглэсэн байна. Угтаа энэ нь перс хэлний муж тойрог гэсэн утгатай **Харазм** буюу **Харазами** (Хорезм) монгол дуудлагаар Хурумши гэсэн үгээр нэрлэсэн овог аймгийн нэр ажээ. Өрүнгэчи хотоос ирсэн Ялавачи, Масхуд эцэг хөвүүд хоёр болбоос эл Хурумши овогтон хүмүүс ажээ.

634. Арбуха гэдгийг хх-д 地名 (газрын нэр) гэж тэмдэглэжээ. Х.Пэрлээ (1958, 10) үүнийг Алшаа нутагт байлтай гэж үзэв.

635. Жосоту бору гэдгийг хх-д馬名(морины нэр) гэсэн авч зүйлийн арын товчилсон орчуулгад點軍馬(улаан толбот морь) гэж тодруулан хэлсэн байна. Энэ нь зос мэт улаан толбот морийг зүслэн өгүүлсэн нэр болно. Лувсанданзаны "Алтан товч" зэрэг түүхэн зохиолоор уламжлан ирсэн "Гурван зуун тайчуудыг дарсан домогт"

Чингис хааныг "Толбот бор морины дэл дээр ташуураа тулж унтаад нэгэн зүүд зүүдлэв" гэснээс үзвэл "Зост бор", "Толбот бор" хэмээх нь Чингис хааны ан авд унадаг морины тухай өгүүлсэн бодит зүйл бололтой. Чухамдаа "Зост бор, Толбот бор" хоёр нь нэг морь болов уу гэсэн санааг өгүүлж байна.

636. Чо'орхад гэдгийг хх-д 地名(газрын нэр) гэж тэмдэглэжээ. Үүнийг Бөххишиг (1941, 272) **согурхада,** Алтан-Очир (1942, 208) **сохургад** гэх зэргээр монгол бичгийн хэлнээ буулгасан байна.

637. Сэри'үтү 'эсү гэдгийг хх-д凉了呵(сэрүүн болгох) гэж орчуулжээ. Энэ нь монгол сонгодог бичгийн **сэригүтүбэсү** гэдгийн хуучин хэлбэр бөгөөд халуун намдах буюу бие нь сэрүүн болбоос гэсэн утгатай юм.

638. Нитони гэдгийг хх-去年 (ноднин жил) гэж орчуулжээ. Энэхүү ноднин гэх нь Чингис хааныг Сартуулд дайлаар одохын өмнөхөн (1219) Тангадын Бурханд элч илгээснээ нэхэн өгүүлжээ. Түүнээс бус энэ удаа элч илгээж үг бариулсан үе нь түрүүчийн элч илгээснээс хойш долоон жилийн дараа буюу 1226 оны үйл явдал болно.

639. Эригайа гэдгийг хх-甯夏 (Нин шиа) гэж тэмдэглэжээ. Энэ нь одоогийн БНХАУ-ын Хотон үндэстний өөртөө засах орны Ин чуан хотыг (銀川) өгүүлжээ. Үүнийг монголчууд **Яргай** хот гэж нэрлэдэг тул проф. Т.Дашцэдэний (1985, 199) **Эригайа** гэж галигласныг зүйтэй гэж баримтлав.

640. Эрижэ'ү гэдгийг хх-西涼 (Ши лиан) гэж тэмдэглэжээ. Энэ нь одоогийн Ган-Сү мужийн武威(Вү вэи) хот мөн бололтой.

641. Эрэбик гэдгийг хх-男子 (эрэгтэй) гэж орчуулжээ. Эл үгийн язгуур нь **эр** (хүч, чадал) гэсэн үгтэй үүсэл нэгтэй бөгөөд **эрэбин сайид** хэмээх нь "сайн эрс, сайн эрчүүл" гэсэн утгатай юм. Жангарын туульд:

"**Эрвэн** дэлтэй
Эгц сүүлтэй" гэсэн хэллэг буй нь мөн "Эрэвгэр цэцэн хүлэг" гэсэн хэллэгтэй ойролцоо утгатай болно.

642. Часуту гэдгийг хх-雪山名(цаст уулын нэр) гэж тэмдэглэжээ. Эл газрыг Элдэнтэй, Ардаажав (1986, 887) нар Хе-Лан шан уулын нэг даваа гэж үзсэн байна.

643. Онохса'ар гэдгийг хх-д 算計了的依着(анасан ёсоор) гэж орчуулжээ. Уг үг гарлын хувьд монгол бичгийн хэлний бодож төлөвлөснөөрөө гэсэн утгатай **онуху** гэдгээс үүсэлтэй байна. Бид хх.

орчуулгыг баримтлан орчин цагийн монгол хэлнээ **анаснаараа** гэж хөрвүүлэв.

644. Жуйин гэдгийг хх-д 種名(аймгийн нэр) гэжээ. (47-р тайлбарыг үзнэ үү).

645. Дөрмэгэи гэдгийг хх-д 靈州 (Лин жоу) гэж тэмдэглэжээ. Мансаан (1985, 394) "Юань улсын судраас" иш татан: "Тан улсын үед Лингжеү гэж, бас Лийанг эу Жийүнг гэдэг. Сүн улсын эхэнд Тангадад харъяалагдаж Лийанг чинг жийүнг гэж нэрлэв" гэж дурдсан байна. Энэ нь одоогийн БНХАУ-ын Гансү мужийн Лин эү шианд (靈武縣) байх бололтой.

646. Сүмэс гэдгийг хх-д 佛每(бурхад) гэж орчуулжээ. Эл үгийг олонхи судлагчид сүм дугана гэсэн утгаар ойлгож орчуулж, тайлбарласан байх юм. Чухамдаа энэ нь сүм дуганын хэлбэрээр хөрөг шуумал хийж урласан одоогийн суврага маягийн зүйл бололтой. "Мукаддимат Ал-адаб" тольд тэмдэглэснээр үзвэл **сүм** хэмээх нь угтаа зурах, урлах гэсэн үгтэй холбоотой шиг байна (Поппе, 1938, 327). Тэрчлэн Элдэнтэй, Ардаажав (1986, 889) нар эл үгийн тайлбар өгүүлэлдээ"Жаруудын аман ярианд бурхан шүтээний хөргийг урлан барьж бараад тахихын өмнө ёслолявуулахдаа тэрхүү баримал хөргийн хөндий хэсэгт элдэв зүйлийн сувд эрдэнэ чихэж оруулахыг **сүмээ** хэмээмой. Энэхүү ёслолыг **сүмэлэх** хэмээмой" гэжээ. Энэ нь орчин үеийн халхын аялгууны бурхан, суврага **шүншиглэхтэй** адил зүйл бололтой байна.

647. Бүтэ'үнэ гэдгийг хх-暗行 (далд харанхуй) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний **бүтүгэкү** гэдэгтэй гарал нэгтэй үүдний хаалт, саравч гэсэн үг бололтой.

Ямар ч атугай Чингис хаан Бурханыг үл хүндлэн орд өргөөнд ёс төртэй уулзсангүй зөвхөн үүдний саравч зайд хөнгөн маягаар уулзсаныг өгүүлжээ.

648. Нэ'үкү харши гэдгийг хх-起的行宮 (аяны нүүлгэх орд) гэж орчуулжээ. Энэ нь орчин үеийн дуудлагаар "нүүх харш" гэсэн үг бөгөөд аян нүүдэлд зориулсан цацар майхан маягийн сууц бололтой.

649. Мухүли мушхули гэдгийг хх-д орчуулаагүй байна. Ийм учраас судлагчид эл хэллэгийг янз бүрээр таамаглан орчуулж, тайлбарласан буй. Бидний бодлоор энэ нь орчин цагийн монгол хэлний "мохох мушгих" гэсэн үгтэй холбоотой бөгөөд ор үлдэгдэл гэсэн утгатай

ажээ. Өөрөөр хэлбэл **мухули мушхули-йи үгэи болхан** хэмээх нь ор үндсийг үгүй болгон-гэх буюу өчүүхэн үлдэгдлийг ч үгүй болгон гэсэн утгатай ажээ. Энэхүү өвөрмөц төрхийн хэллэгийн хэлбэрийг хэвээр үлдээхийг хичээж бид орчин цагийн монгол хэлнээ "мохол мушгил үгүй болгон" гэж хөрвүүлэв. Эл үгийн талаар Элдэнтэй, Ардаажав (1986, 891), Иринжин (1987, 266) нарын тайлбарыг харьцуулан үзнэ үү.

650. Көдэ'ү арала гэдгийн хх-地名 (газрын нэр) гэж тэмдэглэв. Эл газрыг Х.Пэрлээ (1958, 7), Ц.Дамдинсүрэн (1976, 229) нар эдүгээгийн Монгол улсын-ын Хэнтий аймгийн нутагт орших өнтэй дулаан Баян улаан гэдэг газрыг мөн гэж үзэж байна.

651. Дорхуд талбихсад гэдгийг хх-未完留下的 (дутуу дурган үлдээсэн) гэж оновчтой орчуулжээ. **Дорхуд** хэмээх нь монгол бичгийн хэлний **дургун** буюу **дургум** хэмээхийн олон тооны хэлбэр болно. Эл хэллэгийн агуулга нь хаан эцгийн бүрэн эзэмшиж амжаагүй **дутуу дурган орхисон** улс иргэдийг эзлэж авах гэсэн утгатай юм.

652. Сэсүд гэдгийг хх-д 種名(аймгийн нэр) гэж тэмдэглэжээ. Үүнийг НТ-ны 262-р зүйлд **сасуд** гэж галигласан буй.

653. Кэйибэ гэдгийг хх-д 城名(хотын нэр) гэжээ. Энэ нь НТ-ны 262-р зүйлд **кивамэн** (Киев) гэж галигласан үг мөн болов уу гэж таамаглаж байна. Эл үг бас 274-р зүйлд **Кива** гэсэн дуудлагаар гарч буйг тэмдэглэе.

654. Бэркэлүгдэжү гэдгийг хх-д 難攻着(дийлэн ядаж) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний **бэркэ** (хэцүү, хүчир) гэдэгтэй язгуур нэг бөгөөд бэрх болж, хүчирдэж гэсэн утгатай байна.

655. Жабхан гэдгийг хх-д 失了(алдан) гэж орчуулжээ. Эл үг НТ-ны 93, 183, 264-р зүйлд жабхажу, жабхаба гэсэн хэлбэрээр мөн алдах, завхах, цохрох гэсэн утгаар гардаг билээ. Харин энэхүү 272-р зүйлийн **ам хэл жабхан** гэх нь ам хэл алдрах, ам хэл сулрах гэсэн утгатай бололтой юм.

656. Абитла'асу гэдгийг хх-卜呵 (төлөглүүлбээс) гэж орчуулжээ. Олонхи судлагчид эл үгийг хх. орчуулгыг баримтлан төлөг үзүүлэх, мэрэглүүлэх гэсэн утгаар хөрвүүлсэн байна. Бидний ажиглахад НТ-ны эл зүйлд **төлгэчинэ төлгэлэ'үлү 'эсү** (төлөгчинд төлөглүүлбээс) гэж нэгэнт дээр өгүүлсэн учир жолий-а өккүй-э кэмэн **абитла'асу** гэх нь "золио өгье" хэмээн **мэрэглүүлбээс** гэсэн утгатай үг байж арай таармааргүй юм. Учир нь уг зүйлийн учир шалтгааныг тодруулах гэж

нэгэнт мэрэг төлгөө үзүүлээд одоо харин ямар нэгэн золио өгч бөө нарын зөвлөсөн дагуу хятан иргэний газар усны эздийг **аргадаж** байгаа тухай өгүүлж буй тул **абитла'асу** хэмээх нь эртний түрэг хэлний амарлиулах, тайвшруулах, тайтгаруулах, баясуулах гэсэн утгатай **абыт** (Наделяев, 1969, 2) гэдэг үгтэй гарал нэгтэй болов уу гэсэн сэтгэгдэл төрүүлж байна.

657. Жи'үрмэтэмүи гэдгийг хх-д愈甚有 (улам хэцүүднэ) гэж орчуулжээ. Эл үгийн язгуур нь монгол бичгийн хэлний **жигуралдаху** гэдэгтэй холбоотой бөгөөд зууралдах, барьцалдах гэх буюу амь тэмцэж сандаргана гэсэн утгатай байна. Учир нь эл үгийн эсрэг утгат нь "уруг-ун күмүн-эчэ болхуйу? Кэмэбэсү **талбирамуи**" гэсэн өгүүлбэрийн **талбирах, тавигдах** гэдэг үг болохыг харьцуулан шинжилж болно.

658. Билижү гэдгийг хх-д揣摩着 (эргэж нягтлах, бодох) гэж орчуулжээ. (19-р тайлбарыг үзнэ үү)

659. Чүчүжү гэдгийг хх-д指着(найдаж, тушааж) гэж орчуулсан нь уг зүйлийн утга санаанд нийцэж байна. Эл үгийг НТ-г орчин цагийн монгол хэлээр буулгасан судлагчид харилцан адилгүй ойлгосны дотроос Бөххишиг (1941, 281) **жишижү** гэж, Алтан-Очир (1942, 217) **өгчү** гэж хөрвүүлсэн нь ерөнхийдөө зүйтэй мэт санагдана. Бид үүнийг хх. орчуулга хийгээд утга санааг харгалзан **тохоож** гэдэг үгээр буулгав.

660. Киб ханхүн гэдгийг хх-д意快足(сэтгэл ханана) гэж орчуулжээ. Эл хэллэгийн **киб** гэх нь орчин цагийн монгол хэлний **хав (бах)** гэдгийн эртний хэлбэр бололтой. Ямар ч атугай энэ нь эдүгээгийн монгол хэлний **бах ханана** гэсэн хэллэгтэй тохирох мэт санагдана.

661. Тулбалба гэдгийг хх-劈破了 (зүсэв, эвдэв) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний эвдэх, төхөөрөх гэсэн утга бүхүй **шулбалах** гэдэг үгийн хуучин хэлбэр болно.

662. Килэмэ гэдгийг хх-д 漁名(загасны нэр) гэж тэмдэглэжээ. Шагжийн "Эрэхүй хялбар болгон зохиосон монгол үгний тайлбар чандманийн эрх" гэдэг тольд: "**Килимэ** загасыг "Мөрөн голд төрөх загасны нэр. Аврага [загас] дор адил болоод хамар нарийн өнгө цэгээн, махны амт аврагад хүрэхгүй. Хэдий их нь гэвч зургаан тохойноос өнгөрөхгүй" гэж тайлбарласан байна.

663. Кингүлбэ гэдгийг хх-д横斷了(хөндлөн огтлов) гэж орчуулжээ. (142-р тайлбарыг үзнэ үү).

664. Арбатхун, жүкэрүтхүн гэдгийг хх-呪您詛您 (шившлэг шившигтүн, дуудлага дуудагтүн) гэж орчуулжээ. Уг хэллэг гарлын хувьд

орчин цагийн монгол хэлний "ариулах, зүхэх" гэдэгтэй язгуур нэгтэй бололтой юм. Чухамдаа энэ нь бөө нарын шивших, тарнидах, дуудлага дуудаж тамлага зүхэл хийх ёсыг хэлсэн байна.

665. Бэрүдэ гэдгийг хх-д орчуулаагүй байна. Ийм учраас судлагчид "бэри-йэн **бэрүдэ** ойина күртэлэ асараху" гэсэн хэллэгийг харилцан адилгүй ойлгож орчуулсан үзэгдэнэ. Бид эл хэллэгийг "бэр бэрээцүүлээ сэтгэлд [нь] хүртэл асрах" гэсэн утгатай гэж үзэв.

666. Сэ'үсэ гэдгийг хх-д小厮(бяцхан зарц) гэжээ. Энэ нь хятад хэлний **шиао-си** буюу насанд хүрээгүй эрэгтэй зарцыг нэрийдсэн үг болно.

667. Алашас гэдгийг хх-д淮馬(Хуай [голын] морь) гэж тэмдэглэжээ. Үүнийг Элдэнтэй, Ардаажав (1986, 910) нар манж хэлний **алашан** буюу хашин хойрго морь гэсэн үгтэй холбож тайлбарласан нь зүйтэй байна. Манж-Тунгус хэлний тольд **алатан** хэмээхийг манж хэлд адсага турсага гэхээс гадна хашин хойрго гэсэн утгатайн дээр **алаша** хэмээх үг азербайджан хэлд адсага турсага гэсэн утгатай байхад туркмен хэлд **алаша** гэх нь азрагыг хэлдэг байна. Харин чуваш хэлд эл үгийн эхний "а" авиа гээгдсэн хэлбэрээр **лаша мерин** гэх нь хашин морь гэсэн утгатай ажээ (Цинциус, 1975, 30). Эл үгийг солоон хэлний **лөөс,** нанай хэлний **лоос,** монгол хэлний **луус,** манж хэлний **лоосэ,** хятад хэлний **лозы** (騾子) гэдэг үгтэй холбоотой эсэхийг харьцуулан судалбал сонин юм.

668. Таммачин гэдгийг хх-д官名(ноёны нэр) гэж тэмдэглэжээ. Энэ нь тамгач буюу эрх баригч гэсэн утгатай үг юм. Эл үгийн тухай Элдэнтэй, Ардаажв (1986, 910) нар нангиад сурвалж бичиг иш татан тайлбарласан буйг үзнэ үү.

669. Түбшин түгэл гэдгийг хх-平安 (амар түвшин) гэж орчуулжээ. Эл хэллэгийн **түгэл** хэмээх нь бүхэл бүтэн гэсэн утгатай бөгөөд НТ-ны энэ зүйлд бүрэн бүтэн, эсэн мэнд гэсэн утгатай гарч байна. Энэ нь дундад эртний монгол бичгийн бусад дурсгалуудад бүхэл, бүтэн гэсэн утгаар гардаг билээ. Тухайлбал Турфаны цуглуугын "Махагалийн магтаалд":

Дөрбэн гар-таи нигэн нигуртаи
Төгүриг улаган гурбан нидүтэи
Төрүлки ургугсан шира үсүтэи
Түгэл күмүн-и жагугсан араг-а таи гэсний сүүлчийн

мөр нь "бүхэл хүнийг зуусан араатай" гэсэн үг болно. Гарлын хувьд эл үг нь эртний түрэг хэлний бүрэн, бүтэн гэсэн утга бүхүй **түкел** хэмээх үгтэй холбоотой ажээ (Наделяев, 1969, 595).

670. Нахуд гэдгийг хх-д渾金(холимог алт) гэж орчуулжээ. В,Кливез (1982, 214) эл үгийг "алтат хоргойн нэг төрөл" гээд уг үг гарлын хувьд перс хэлний **нах** гэдэгт монгол хэлний олон тооны **уд** нөхцөл залгаж үүссэн болов уу гэсэн проф. П.Пеллиогийн саналыг иш баримт болгон өгүүлжээ.

671. Тобчиа'уд гэдгийг хх-西馬每 (баруун [зүгийн] морьд) гэж орчуулжээ. Мукаддимат Ал-Адаб тольд "тобчах морин" хэмээхийг араб адуу (Поппе, 1938, 350) гэжээ. Мөн "Чингис хааны их өчиг" хэмээх сударт:

"Аргамаг **тобчагийг** унан явж
Алтат мөнгөтийг өмсөн явж..." (Дамдинсүрэн, 1959, 7) гэж гарч байна. Эртний бичиг сударт тобчаг морийг аргамаг гэдэг учраас акад. Ц.Дамдинсүрэн эл үгийг орчин цагийн монгол хэлнээ "аргамаг морь" гэж хөрвүүлсэн байна. Үүнийг Дугаржав (1984, 254) тоомсог гэж, Я.Цэвэл (1966,542) томсог гэдэг үгийг "сайн угсааны эрлийз адуу" гэж тайлбарлажээ. Ш.Гаадамба (1990, 408) "тамчих" гэсэн үг гэж үзсэн байна. "Нууц товчоонд" гарах **тобчаг, тоомсог** гэсэн хоёр үг ямар холбоотой болохыг нягтлан үзвээс сонин юм. Оросын холбооны улсын Камерово мужийн хотын Томск хотын нэрээр нэрлэсэн хөл урт эрлийз адууг монголчууд тоомсог гэх ба эл үгийн үндсийг "том" (их) гэсэн монгол үгнээс гаралтай гэх санал бий.

672. Күринг эрэ'уд да'уши кичидүд гэдгийг хх-д зөвхөн "күринг кичидүд" гэдгийг нь駝名(тэмээний нэр) гэж тэмдэглээд "эрэ'үд да'уши" хэмээхийг орчуулаагүй байна. Ийм учраас эл хэллэгийг судлагчид янз бүрээр таамаглах, эсвэл хх. орчуулгыг баримтлан товчлон орчуулсан байна. Бидний санавал энэ нь үүний өмнөх тоомсог морины тухай өгүүлсэн "хүзүү уртус, хөл өндөр **тобча'уд**" гэдэг шиг **гичир** бөхт тэмээг тодотгон өгүүлсэн "хүрэн эрээн тохошт гичир [тэмээд]" гэсэн утгатай байж болох юм. НТ-г орчин цагийн монгол хэлээр буулгасан судлагчдын дотроос Хуацай Дугаржав авгай ингэж ойлгосон билээ.

673. Хачидуд гэдгийг хх-騾名 (луусны нэр) гэж тэмдэглэжээ. Энэ нь түрэг хэлний луус буюу **качир** (Радлов, 1898, 2-340) гэдэг үгэнд

монгол хэлний олон тооны **уд** нөхцөл залгаж хэлбэржсэн үг бололтой. Элдэнтэй, Ардаажав (1985, 915) нар мөн ингэж үзсэн байна.

674. Жорхалдайа гэдгийг хх-柴打(зодъё, цохьё) гэж орчуулжээ. Эл үг орчин цагийн монгол хэлний "**зоргоор** загнах, **зоргоор** аашлах" гэдэгтэй учир холбогдолтой байж магадгүй юм. Элдэнтэй, Ардаажав (1986, 920) нар "Синзяны дөрвөд аман аялгуунд **жорхалда-жоргалду** хэмээх нь зодолдох, цохилдох, жанчилдах" гэсэн утгатай гэж тэмдэглэсэн байна.

675. Дөлүсгүжү гэдгийг хх-д趯翼着(догширч) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **долгисох** (догшрох) гэдэг үгтэй язгуур нэгтэй бололтой. Эл үг 281-р зүйлд дөлэсгэкү гэсэн хэлбэрээр гарч буйг тэмдэглэе.

676. (Х)ү'үтүгэи гэдгийг хх-д臭爛者(илжрэх) гэж орчуулав. Энэ нь орчин цагийн монгло хэлний **Үүх** буюу **өмхийрөх** гэдэг үгтэй гарал нэгтэй байж болох юм. НТ-ны эл зүйлд хх. орчуулгад тэмдэглэсэнчлэн илжрэх, өмхийрөх гэсэн утгатай байна. 147-р зүйлд **(х)о'эжү** гэдгийг хх-д мөн "илжрэх" гэж орчуулжээ.

677. Эбчи'үн дур дайисурхан гэдгийг хх-胸前裹做敵人(өвчүүн дотор нь дайсан хүн болж) гэж үгчлэн орчуулжээ. Чухамдаа энэ нь өөдөөс тэмцэлдэх, эсэргүүцэх гэсэн утгатай хэллэг бололтой юм. Ийм учраас бид Ц.Дамдинсүрэн багшийн "өөдөөс эсэргүүцсэн" гэж утгачлан хөрвүүлснийг баримтлав.

678. Бэтэр гэдгийг хх-д орчуулаагүй байна. Эл үг гарлын хувьд эртний түрэг хэлний "өөдгүй, доор" гэсэн утгатай **бетер** (Наделяев 1969, 90) гэдэг үгтэй үүсэл нэгтэй байж болох юм. Элдэнтэй, Ардаажав (1986, 924) нар мөн ийм санал дэвшүүлж Харчин, хорчин аялгуунд **бэтэр** хэмээх нь зовних, энэлэх, гашуудах гэсэн утгатай ба үзэмчин аялгуунд **бэтрэх,** сандрах, бачимдах, яарах, цухалдах гэсэн утгатайг өгүүлсэн байна.

679. Энггэшигэжү гэдгийг хх-д學着(дагаж, дуурияж) гэж орчуулжээ. Бидний бодлоор энэ нь "эн гишгэх" буюу "эн зэрэгцэх" гэсэн нийлмэл үг бололтой байна.

680. Нойалаху гэдгийг хх-д 斷 (тогтоох, шүүх) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **ноёлох** гэдэгтэй язгуур нэгтэй бөгөөд НТ-ны эл зүйлд хх. орчуулгад тэмдэглэсэнчлэн шүүх, шийтгэх гэсэн утгатай байна.

681. Хугулжу гэдгийг хх-折挫着(хугалж) гэж орчуулжээ. Чухамдаа энэ нь царай гутаах, царай алдуулах гэсэн утгатай байна.

682. Тунигсам гэдгийг хх-д 完備了(бүрэн төгс болгосон) гэж орчуулжээ. Эл үгийн гарлыг Элдэнтэй, Ардаажав (1986, 928) нар орчин цагийн монгол хэлний тонилох, тонилгох гэдэг үгтэй холбож үзсэн байна. Гэхдээ энэ нь хийх, бүтээх, байгуулах гэсэн утгатай болох нь хх. орчуулга хийгээд уг зүйлийн ерөнхий агуулгаас мэдэгдэж байна. Ийм учраас бичгийн хэлний **туурвих** гэдэгтэй язгуур нэгтэй байж болох юм.

683. Улисчу гэдгийг хх-惹帶着(үүсгэж, гаргаж) гэж орчуулжээ. Эл үг гарлын хувьд хэмжих, жиших гэсэн утга бүхүй **ули** гэдэгтэй язгуур нэгтэй байж болох юм. (Сэцэнцогт, 1988, 486). Бид хх.орчуулгыг баримтлан орчин цагийн монгол хэлнээ "үүсгэж" гэж хөрвүүлэв.

684. Тунгхун гэдгийг хх-д作新(шинээр) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **тунхаглах** гэдэгтэй гарал нэгтэй шинээр тогтоох, сэргээх гэсэн утгатай ажээ. (164-р тайлбарыг үзнэ үү)

685. Мухуритухаи гэдгийг хх-д 巡者(эрэгтүгэй, тойртугай) гэж орчуулсан нь зүйтэй бололтой. Бидний санавал уг үгийн гарал нь монгол бичгийн хэлний **мухур, муруи** гэдэгтэй язгуур нэгтэй бөгөөд эргэх тойрох гэсэн утгаар НТ-ны эл зүйлд орсон байна.

686. Ачид гэдгийг хх-д 貼班(дэргэдийн ээлжүүд буюу шадар хишиг) гэж орчуулжээ. Эл үгийн утга нь дагалт хиа, гоцго, шадар бараа бологч нарыг өгүүлсэн бололтой. Үгийн гарлын хувьд монгол бичгийн хэлний **ачи** (ач тус) хэмээх үгтэй холбоотой байж магадгүй гэж бид таамаглаж байна. Гэхдээ орчин цагийн монгол хэлний ач гэдэг үг дундад эртний монгол хэлд **(х)ачи** гэсэн дуудлагатай үгийн эхний "х" авиа бүрэн гээгдээгүй байсан нь НТ-ны 75, 163, 177, 214-р зүйлээс мэдэгдэж байгаа билээ (50-р тайлбарыг үзнэ үү). Ийм учраас монгол бичгийн хэлний **ачи** хэмээх үгийн эхний "х" авиа бүрэн гээгдсэн гээгдээгүй хоёр хэлбэртэй байсан байж болох юм.

Элдэнтэй, Ардаажав (1986, 941) эл үгийн тайлбартаа "ачид-ун хэмээх нь дөрвөдийн аялгуун дор хамжлагын эздийн хиа хэмээмой. Урадын аялгуун дор **ачиту** хэмээбээс феодалын эздийн өдөр тутмын амьдралд олгон өгөх албадалгын хөдөлмөр бологч. Жишээлбэл *хооллохыг асрах, бурханы тахилын юмыг бэлтгэх зэрэг сул албанд зарагдах хүмүүсийн ерөнхий нэрийдэл болмой*" гэж тэмдэглэсэн байна.

687. Гэжигэлэ'үли гэдгийг хх-後援 (туслах хүч) гэж орчуулжээ. Хүний гэзэг үс ар нуруунд байдгаар үлгэрлэж НТ-ны 170, 257, 270, 274-р зүйлүүдэд **тэжигэ** хэмээх нь ард, хойно, дараа гэсэн утгатай байдгийг үндэслэн бид үүнийг орчин цагийн монгол хэлнээ **ард үлдэ**гсэд гэж хөрвүүлэв.

688. Онжитухаи гэдгийг хх-罰者 (торгох, яллах) гэж орчуулжээ. Эл үг 227-р зүйлд **(х)ончидутхун** гэсэн хэлбэрээр гарсан билээ. (515-р тайлбарыг үзнэ үү)

689. Орошин гэдгийг хх-д 常川(үргэлж) гэж орчуулжээ. Энэ нь орчин цагийн монгол хэлний **орших** гэдэгтэй язгуур нэгтэй бөгөөд НТ-ны эл зүйлд үргэлж, байнга, тогтмол гэсэн утгаар оржээ.

690. Төлэд гэдгийг хх-д 替頭(орлох) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний **төлүгэ** гэдэг үгийн олон тооны хуучин хэлбэр бололтой. (Сэцэнцогт, 1988, 1978). НТ-ны эл зүйлд хх.орчуулгад тэмдэглэсэнчлэн орлох, солих, сэлгэх гэсэн утгатай байна.

691. Түсүрчу гэдгийг хх-д 注着(оруулж) гэж орчуулжээ. (201-р тайлбарыг үзнэ үү).

692. Хадаха гэдгийг хх-д 緊要事(чухал хэрэг) гэж орчуулжээ. Энэ нь монгол бичгийн хэлний **хамий-а** гэдэгтэй язгуур нэгтэй байж болох юм. НТ-ны эл зүйлд чухал хэрэг, хамаарах зүйл гэсэн утгатай байна. Эл үг 201-р зүйлд **хадахату үгэс** гэж гарсныг эн зэрэгцүүлэн *холбосон шүлгийн утга санаа холбоц тэргүүтэнд нийцүүлэн* **хавтгай үгс** гэж буулгасан билээ.

693. Далаи-йин хаган-у гэдгийг хх-海內的皇帝 (далайн доторх хаан) гэж орчуулжээ. Энэ нь агуу хаан буюу ертөнц дахины эзэн хаан гэсэн утгатай ажээ. Акад. Ц.Дамдинсүрэн (1957, 35) "**Далай хаан** гэдэг бол хамгийн их ерөнхий хаан гэсэн үг. Монгол хэлэнд хамгийн их юмыг далай гэдэг" гэж 1246 онд Гүюг хаанаас европ дахины Пап ламд илгээсэн бичиг дахь тамгын үсэгт: "йэкэ монггул улус-ун **далаи-ин хану** жарлиг" (их монгол улсын далайн хааны зарлиг) хэмээх бичигт буй "далайн хаан" гэдгийг ингэж тайлбарласан байна. Мөн эл үгийн талаар Элдэнтэй, Ардаажав (1986, 959-960) нар нэлээд дэлгэрэнгүй тайлбарласан буй.

694. Илүбтэ гэдгийг хх-順便 (дагуу тууш) гэж орчуулжээ. Эл үг "Хуа-и И-ю" тольд үүнтэй ойролцоо утгаар гарах бөгөөд эл үгийг хятадаар НТ-ны хх.орчуулгатай адил үсгээр буулгасан байна.

Тухайлбал уг толийн III-дэвтрийн 6-р хуудсанд буй "мэдэ'үлжү алиба албан болу'асу гажрун **йилүбдэ** дахан асу" гэсэн хэллэгийг харьцуулан үзэж болно.

695. Бүги гэдгийг хх-д 繩(дээс) гэж орчуулжээ. Энэ нь хх.орчуулгад тэмдэглэсэнчлэн тэрэгний татлага, дээсийг нэрийдсэн үг болно.

Эдүгээгийн хорчин аялгуунд тэрэгний дээс татлагыг бүг гэдэг байна. (Элдэнтэй, Ардаажав, 1986, 963).

696. Орхол гэдгийг хх-д腦項(тархи, толгой) гэж орчуулжээ. Эл үгийг Ц.Дамдинсүрэн (1976, 237), Дугаржав (1984, 262) нарын судлагчид монгол бичгийн хэлний **уругул** (уруул) гэж ухаарсан нь ташаарал болсон бололтой. Харин проф.Баяр (1981, III, 1456) **оргил** гэж буулгасан нь чухам байдалд нэлээд дөхүү болсон гэж үзэж болно. Бидний саналаар эл үгийн гарал нь орчин цагийн монгол хэлний **оргил, орой** хэмээхтэй язгуур нэгтэй гэж үзмээр байгаа юм. Уг үгийг Бөххишиг (1941, 295) авгай **уулзуур** гэж буулгасныг утгын хувьд яг оносон хөрвүүлэг гэж санаж байна. Учир нь монгол үлгэр туульд дайсан этгээдийг алж хорооход аман хүзүү хатан хүзүүнийх нь уулзвар юм уу завсраар цавчин алсан тухай өгүүлсэн байдаг билээ.

697. Хахас алдалтан гэдгийг хх-д 劈破斷没 (таслан шийтгэх, цавчин шийтгэх) гэж оновчтой орчуулжээ. Бидний санавал **хахас** хэмээх нь орчин цагийн монгол хэлний **хагаслах** (хуваах, таслах) гэдэгтэй язгуур нэгтэй бөгөөд **алдалтан** гэх нь одоогийн монгол хэлний **алдах** (буруудах) гэдэгтэй үүсэл нэгтэй буруутан, зэмтэн гэсэн утгатай бололтой. Бүхэлдээ уг хэллэгийн утга нь хх.орчуулгад тэмдэглэсэнчлэн "таслан шийтгэх, цавчин шийтгэх" гэсэн утгатай ажээ.

698. Халбуга кэгэсүн гэдгийг хх-匙般車輻 (халбага мэт тэргэн хигээс) гэж орчуулжээ. Олонхи судлагчид уг хэллэгийг "халбага хигээс" буюу "халбага мэт хигээс" гэж ойлгож орчуулж тайлбарласан байна.

699. Жахуд гэдгийг хх-д 金人每 (Алтан [улсын] иргэд) гэж орчуулжээ. Энэ нь Зүрчидийн Алтан улсыг өгүүлсэн нь магад биз. Алтан улсын тухай 48-р тайлбарт үзнэ үү.

700. Кэрэг жараг гэдгийг хх-д 所用需 (хэрэг чухалчлага) гэж оновчтой орчуулжээ. Эл хэллэг нь орчин цагийн монгол хэлний "арга чарга, хэрэг чарга" гэсэн хоршоо үгтэй ойролцоо утгатай юм. Уг үгийн гарлыг Элдэнтэй, Ардаажав нар (1986, 967) түрэг хэлний **жарак**

(тохиромж, зохист, бололцоотой гэсэн утга бүхүй) гэдэг үгтэй холбож тайлбарласан нь бидний саналтай нийцэж байна. Эртний түрэг хэлний **жараг** хэмээх нь тохиромжтой нөхцөл, эгээгтэй үе, арга маяг гэсэн утгатай ажээ. (Наделяев, 1969, 239).

701. Дөлэскэжү гэдгийг хх-д НТ-ны 276-р зүйлд гарсантай адилаар 趨諛的 гэж орчуулжээ. Гэвч 276-р зүйлийн **дөлөсгүжү** хэмээхээс утга арай ондоо **хазайх, хэлтийх** гэсэн агуулгатай шиг байна. (677-р тайлбарыг үзнэ үү).

702. Кэгэсүлэкү гэдгийг хх-д 陰害的 (далдуур хорлосон) гэж орчуулжээ. Уг үгийн үндэс **кэгэсү** хэмээх нь 67-р зүйлд гарсан билээ. (71-р тайлбарыг үзнэ үү). Эл үг НТ-ны эл зүйлд хийцлэх, хилсдүүлэх гэсэн утгатай байна.

703. Өлүмлэкү гэдгийг хх-д向前的(урагшлах) гэж орчуулжээ. (491-р тайлбарыг үзнэ үү).

704. Хулухана жил гэдгийг鼠兒年(хулгана жил) гэж орчуулжээ. НТ-ны төгсгөлийн эл үгэнд жилийн махбодыг заагаагүй учир судлагчид энэ оныг харилцан адилгүй үзэж байна. Тухайлбал Г.Ледярд (1964, 1-22) Есүдэр мэргэнийг Гуулин (Солонгос) улсад илгээсэн тухай мэдээг 1240 оноос хойших хэрэг явдал гэж үзээд үүнийг 1252 буюу 1264 оны хулгана жилд хамааруулах нь зүйтэй гэж үзэв.

Сүүлийн үед проф.В.Кливез, И.Рахевилз, Мансаан нар НТ-ны зохиогдсон он цагийг 1228 онд хамааруулах нь зүйтэй гэсэн нэлээд үндэслэлтэй санал дэвшүүлсэн билээ. Тухайлбал эрдэмтэн Мансаан (1981, 2, 15-21) "Монголын нууц товчоог бичиж дуусгасан оны шинжлэл" гэдэг өгүүлэлдээ түүнийг 1240 онд зохиосон гэж үзэх нь гурван зүйлийн талаар эргэлзээтэй байна гэж үзжээ. Энэ нь 1. Зохиогдсон цаг хугацаа, 2. Газар орон, 3. Түүхэн бодит байдлын хувьд зөрчилтэй байгааг хэд хэдэн ноцтой баримт гарган өгүүлсэн байна.

Ялангуяа НТ-ны төгсгөлийн үгэнд "Их хуралдаа хурж" хэмээн өгүүлснийг өлгөж авч 1240 онд их хуралдаан болоогүй гэдгийг нотлоод НТ-ны XI-XII бүлгийг Өгөдэй хааныг 1241 онд нас нөгчих үед нэмж бичиж оруулсан гэдэг санал нь эл хоёр бүлгийн найруулга, бичлэгийн шинж байдлыг үзэхэд үнэхээр тийм сэтгэгдэл төрүүлдэг юм. Үүний дээр "Их хуралдаа хурж хулгана жил хуран сар Хэрлэний Хөдөө арлын Долоон болдог, Шилхинцэг хоёрын зуур ордос бууж бүхүйд бичиж дуусгав" гэдэг төгсгөлийн үгийг "Монголын нууц товчоог" сийрүүлэн бичигч юм уу

нангиад үсгээр буулгасан хүмүүс сүүлд нэмэж бичсэн XI-XII бүлгийн ард оруулж бичсэн хуучин төгсгөлийн үгийг сэргээн сийрүүлсэн байх үндэстэй билээ. Учир нь "Ганжуур", "Данжуур" тэргүүтэн ном шастирыг орчуулсан хэлмэрч нар зарим тохиолдолд хуучин эх судрын төгсгөлийн үгийг иш татан өгүүлэх буюу шууд түүнийг сийрүүлэн буулгасан байх нь цөөнгүй байдаг. Энэ бол өмнөх бүтээн туурвигчдынхаа хөдөлмөрийг эрхэмлэн хүндэтгэдэг эртний мэрэгцүүлийн нэг сайхан заншил бөлгөө.

705. Хуран сара гэдгийг хх-д七月 (долоон сар) гэж орчуулжээ. Судлагчид үүнийг "хулан сар", "хуран сар", "гуран сар" гэх зэргээр арай өөр өөрөөр тесөөлж ирсэн байна. Тухайлбал Дорнотив, Ш.Гаадамба нарын судлагчид долдугаар сарыг хур борооны цаг гэж үзээд "хуран сар" гэж таамагласан байна. Гэтэл Буриад, Ордос зэрэг монгол угсаатан нарын дунд хэрэглэгдсээр ирсэн монголын уламжлалт сарын нэрийн зүйлийг ажиглаж үзэхэд гол төлөв амьтан ургамалын үйл хөдлөл, ургах төлжих, орооны цаг үе тэргүүтэнтэй холбоотой нэрлэсэн шинж мэдэгдэж байна. Жишээлбэл Буриадад IY сарыг хуа хагдани (х)ара ("месяц ветоши"), Y сарыг хүхүин дууни (х) ара ("месяц кукования") гэсэн байхад Ордост YIII сарыг бугу сар-а, IX сарыг хуца сар-а гэх зэргээр нэрлэдэг байна. Бидний санавал дээр дурьдсан сарын нэрсэд IY сарыг ухаа хагдны үе, Y сарыг хөхөө донгодох цаг YIII сарыг буга гөрөөсний орооны цаг IX сарыг хуц сар гэсэн нь хуц тавих буюу хонь малын ороо хөөлгийн үеэр нэрийдсэн ажээ. Өөрөөр хэлбэл энэ нь эртний монголчуудын мал маллах, ан агнуурын ажил голлон эрхлэж байсан аж ахуйн зан үйлдэлтэй учир холбогдолтой болох нь илэрхий байна.

Өвөр монголын Их сургуулийн проф.Иринжин (Араднагарба, 1978, 1, 122) "Арван хоёр сарын эртний монгол нэрийдэл" гэдэг өгүүлэлдээ энэхүү сарын хуучин тоололын зарим нэрийн утга учрыг тайлбарлахдаа: **Худар** буюу **хужир** сарыг "тэр үеийн тавдугаар сар одоогийн нийтийн хуанлийн зургадугаар сартай тохирно. Энэ сард яргуй болон мангираар усан тарга авуулсан бог мал хужир санаж хужирлах цаг болдог байна. Мал аж ахуйн амьдралын энэ чухал ажилгаагаар сарыг нэрийдэж **худар** сар гэсэн билээ" гэжээ. Зохиогч энэчлэн долоо, наймдугаар сарыг нэрийдсэн **гуран** сар, **бугу** сар гэдгийг монгол ан авын ёс, уг амьтдын орооны цаг үетэй холбож тайлбарласан нь зүйтэй байна.

Буриадын эрдэмтэн Д.Банзаров (1955, 42) "Монголчуудын шинэ

жилийн баяр цагаан сар" гэдэг өгүүлэлдээ "Буриадад наймдугаар сарыг сүү сар гэдэг нь юуны өмнө цагаан гэсэн санаатай байж болох юм" гэжээ. Эл сүү сартай холбогдуулан Г.Румянцев буриадын хуучин сарын нэрийг сийрүүлэхдээ YII сарыг **үбөөлжиний (х)ара** ("месяц удода"), XI сарыг гури (х)ара ("месяц диких коз") гэдэг хэмээн Дорно дахины судлалын хүрээлэнгийн архиваас авч өгүүлжээ. (Банзаров, 1955, 253). Энэ нь Ордосчуудын одоо хүртэл уламжлан хадгалсаар ирсэн монгол сарын нэрийн зүйлд YII сарыг **гуран сар** гэж хэлдэгтэй тохирч байгаа нь сонирхолтой.

Өвөр Монголын Их сургуулийн дэд проф.Y.Мандах 1990 оны 3-р сарын 28-нд надад бичсэн захидалдаа: " ... Товч хэлбэл **гуран** гэдэг нь зөв шиг байна. Уйгаржин монгол үсэг хадсан "Хуа-и И-югийн" нөхвөр хийсэн дэвтэрт古[illegible]闌撒剌(хуран сара 七月) гэж буй. Энэ нь **гуран** сар болно. Бусад материалын тухай Иринжиний өгүүлэлд бүр дурдаж өнгөрөв. Түүнийг үзэж болно. Харин нэгэн зүйлийг хэлэхэд Иринжиний өгүүлэлд хятад-монгол толь "Хэ юван И-ю-д" (Бас "Монгол И-ю" гэдэг) 兀闌撒剌(гуран сара)гэж байгаа гэв.Гэтэл миний ашигласан мөн номд 兀赤撒剌(гучи сала)гэж буй.Энэ нь хуц сар болно. Эртний нэрэлсэн заншлаар үзэхэд бүр амьтны нэрээр сарыг нэрлэжээ. Иймээс **хуран** (хур бороо) сар байх боломж бага юм. Харин **гуран** (зүр гур) сар байх нь итгүүлэх хүчин их байна гэжээ. Дээр өгүүлсэн мэдээ баримтаас үндэслэн Мансаан (1985, 417), Иринжин нарын (1987, 287) судлагчдын **гуран сар** гэж үзсэн саналыг зүйтэй болов уу хэмээн баримтлав.

706. Доло'ан болдага гэдгийг хх-七孤山 (долоон ганц уул) гэж тэмдэглэжээ. Энэ нь НТ-нд Долоон дов буюу Долоон толгой гэсэн газрын нэрийг өгүүлсэн байдалтай юм. Одоогийн халх, буриад аялгуунд **болдог** хэмээх нь "дов довцог, гүвээ, сондуул" гэсэн утгатай юм (Цэвэл, 1966, 89; Черемисов, 1973, 100). Тухайлбал буриадын "Жороо үг" буюу хэл зүгшрүүлэх үгд:

Хааны хар морь
Морины мухар тэрэг
Тэрэгний тэр **болдог** (гүвээ, дов)
Болдгийн бор начин
Начны найман төлөг
Төлгийн төвгөр уул гэх зэргээр шүлэглэсэн буй (Гаадамба, Цэрэнсодном, 1978, 93).

Энэхүү Долоон болдог гэдэг газар одоо хаана байгааг Ц.Дамдинсүрэн (1957, 53) таамаглаж: "Хөдөө арал гэдэг бол тал хээрийн арал гэсэн утгатай юм. Ой модтой хөвч ба тал хээр газрын завсарт байгаа Баян улаан уулыг цөм Хөдөө арал гэж болох юм. Түүнээс гадна Хөдөө арлын Долоон болдогт "Нууц товчоог" бичсэн гэж байдаг. Тэр Долоон болдог хаа байна гэвэл Баян улааны өвөрт 30-40 км уужим их тал байдаг. Үүнийг одоо Баян хар тал гэж нэрлэдэг байна. Энэ талын баруун хойт өнцөгт Баян улаан уулын баруун өмнөт бэлд Хэрлэний хөвөөнд одоо **Долоод** гэдэг нэртэй долоон довцог толгой байдаг Энэ бол жижигхэн боловч сонин хэлбэртэй довцгууд юм. Энд хуучны Их шавийн нэгэн отог байсан. Түүнийг Долоодын отог гэдэг байлаа. Энэ долоон уулыг тэр нутгийн ардууд тахидаг байжээ. Эртний Долоон болдог болбол одоогийн Долоод мөн бололтой" гэж өгүүлсэний дээр "Монголын нууц товчооны" удиртгал өгүүлэлдээ эдгээр долоон толгойн нэрийг

1. Дөрвөлжин
2. Сүүл
3. Их Улаан толгой
4. Бага Улаан толгой
5. Олон овоо
6. Тахилгат
7. Гацаа хэмээн жагсаасан байна.

Мөн Х.Пэрлээ (1958, 7) үүнийг "109-р уртраг, 47-р өргөрөг. Одоо Хэрлэний Долоод (уул)" гэж тэмдэглэжээ.

707. Шилгинчэг гэдгийг хх- 地名 (газрын нэр) гэж тэмдэглэжээ. Эл газрыг Ц.Дамдинсүрэн (1957, 54), Х.Пэрлээ (1958, 7) нар одоогийн Хэнтий аймгийн Баян улаан уулын өвөрт орших Долоодоос зүүн урагш 4-5 км газарт буй Замагт нуурыг мөн бололтой гэж таамагласан байна.

ТАЙЛБАРЛАСАН ҮГ ХЭЛЛЭГИЙН ХЭЛХЭЭС

А'асу 24
Аба са'уба 26
Абжи'а көдэхэри 365
Абит 12
Абитла'асу 656
Аблиха 357
Адарта'асу 277
Ажираху 266
Ажу 305
Ала'аи ба 587
Алангир 166
Ала'уна 278
Алачуха 171
Алашас 667
Алгинчи 36
Алгинчи ха'улжу 180
Алда'улдахун 476
Алдухун 93
Алжи'ас 472
Алтаи-йин өлкэс 392
Алтан тэрмэ 350
Амдуригдарун 236
Ани 106
Анху'а 413
Арам 188
Аран үжэбэ 119
Арбатхун, Жүкэрүтхүн 664
Арбилажу 336
Арбуха 634
Арван гурван хүрээ 199
Арийал үгэи 294
Арийаху 223
Арун 27
Архача 77
Архал Кэүки 349
А'ултаху 452
А'урух 215
А'ушикиту жилду 14
Асан Сартахтай 345
Ахтажу'у 454
Ачид 686
Ашихижухуи 202
Бадаркижу 627
Баидал 263
Баидалача 420
Байитараг бэлчирэ 262
Балжуна 344
Баратутан 375
Бару'анача 419
Баруг 98
Баридхун 466
Баса'алажу 503
Баулийа 628
Ба'утала 519
Бидү 'үлжү 18
Билду'ур 267
Билжи'үр 509
Билижү 19, 658
Билэ'үр 76
Бисари'улжу 551

Боро хуладу 448
Борхаи 337
Борчин соно 449
Босу 497
Бөкөрэйин бөксэн-түр
Чэкэрэйин чэгэжи-түр атухаи 121
Бөкэлэрүн 511
Бөкэн 124
Бөртэ-Чино 1
Бугу-йин (Х)орим (Х)оримлажу 136
Будун 451
Буи 615
Буйгин 600
Булхалдун 103
Булжи'асу 128
Бура тара 500
Буру'уйа булха көйиджү 465
Буру'уйа 290
Бурхан босхахсам 10
Бурхан Халдун 3
Буситаи 51
Бу'улжар 289
Бухсажу 409
Бүги 695
Бүкийа 135
Бүксэн 256
Бүктэ'үл 510
Бүтэ'үнэ 647
Бүтэ'эжү 217
Бэкилэкдэжү 573
Бэл 287
Бэнглэнижү 481
Бэринэд-ийэн бэрилэ'үлжү 370
Бэркэлдүгдэжү 654
Бэрүдэ 665
Ван 212
Гөлми 436
Гөрүлэлдүн 603
Гурбан дэлэсүй 323
Гурбан нэ'үрит гажара 6
Гүи онг 469
Гүнжү 584
Гүрүлгү 417
Гүрэлгү 111
Гэжигэлэ'үли 687
Гэнү'эр 607
Гэмүри'үлүн 529
Гэнтү 496
Гэргэн тутхари баса'аласухаи 191
Гэр жүк 196
Гэрлүгэ 178
Гэткибэ 473
Далаи-йин хаган-ц 693
Далан нэмүргэс 249
Далан тохо'од бучалхажу 200
Дангласун 561
Дарба'ан урийа-дача
Да'ун дэм-эчэ 507
Дардас 539
Дару'а 42
Дарун 534
Даруча 127
Да'у бари'улурун 316
Дидиг сахалун нэкүн 366
Доло'ан болдага 706
Домохчи 460
Доро жида 531
Дорхуд талбихсад 651
Дөлүсгүжү 675
Дөлэскэжү 701
Дөрмэгэи 645
Дөрэбчитү 214
Дөтөлэксэн 554
Дува-Сохор 5
Дүлэд 300
Дүн чан 579
Дэгэлтү төрүксэн кө'үн 338
Дэлбэгэ 57
Дэлэмэ 292
Дэм 298
Дэн са'ухуи 318
Дэнсэлгэн 314
Дэргэтэ 73
Дэрэ абун үхүсү 244
Дэрэлэкүнү 484
Дэрэлкүкү 297
Жа'арин 176
Жабхан 655
Жагугасу 86
Жада 230
Жалалдин Со(у)лтан 624
Жала'уту 4
Жалираба 569
Жалхамшигтан 123
Жантаву 368
Жарбийал 241
Жарима 325
Жарчи'уд Аданхан ури'анхажин 38
Жау гон 593
Жаха'ун 520
Жахуд 699
Жау тау 213
Жа'ут хури 211
Жа(х)ин 456
Жибтуражу'уи 570
Жибши'эрчү 308
Жигтүжү 483
Жилда болдажу 227
Жингүгү-йин 566
Жирим 525
Жи'үрмэтэмүи 657
Жичи гучи 286
Жорхалдайа 674
Жосоту бору 635
Жөб 64
Жубур 60
Жубчижу 343
Жунда'ул 313
Жухажу'у 335
Жүбчиксэн 498
Жүгэли 41
Жүйин 644
Жүлдү 506
Жүндү 578
Жэблэхү 242
Жэбүгэ, хатара 89
Жэжэ'эр үндүрүн кэрүдэ 279
Жэжэ'эр өндүр-үн
Жэр хабчихаи-йин амасара 353
Жэмлэн алажу 505
Жэткүкдэжү 423
Жэ тэли 568
Жэшин 150
Игүлгүжү 352
Идүрэкүи 374
Идү'үт 537
Иктүнэжү 209
Илүбтэ 694
Илүкэй 221
Илэ'ү'ү 334
Имада 358
Инэрү 75
Иргэ орха 248
Иричэ'үлжү 475

Исэри 109
Итүрэжү 238
Ихурихалдун жибши'эрүлчэн 229
Ичикин жархаг 161
Йабудаг кэлтү 284
Йадажу мүт оробаи 354
Йогурхату 477
Йор 167
Йэгү'үжэ'эи 91
Йэкэ эйэ 252
Йэсүн көлтү чага'ан туг 467
Йэ'үткэлдүжү 384
Кен 225
Киб ханхун 660
Кидугачи 342
Кикүрижү 347
Килигү 58
Килийэр 20
Килэмэ 662
Кингүлбэ 663
Кингүс 142
Кирү 'эсэ 203
Китад-цн 48
Кичидүд 672
Көбшилдүжү 488
Көдэ'ү арала 650
Көкидэг 140
Көкижү 172
Көки'үлдэбэ 321
Көншилэмэл 16
Көрүрэ 259
Кө'үргэ 139
Көтөл 406
Күлүк 458
Күнгкэ'үлжү 132
Күндү мөртү кү 'үн буи 464
Күндү эмэ-йин 396
Күнкэтүгэи 355
Күрдүнү тугул 397
Күрикэт-тэ талбижу 70
Күрүмэлэ 115
Күрү 'э 360
Күчүгэнэ 154
Күчүкүр 112
Кэбтэ'үл 380
Кэбэли'үлжү 306
Кэгэсүлэкү 702
Кэйибүр 416
Кэйибэ 653
Кэйид 130
Кэйэкжү 550
Кэкэ 175
Кэкэсү 71
Кэлбэс 623
Кэли 341
Кэлэ-бэн абтахун
Кэнү ама итхахун 239
Кэмлэжү 439
Кэрэг жараг 700
Кэрэлдүксэн 415
Кэрэлжү 562
Кэтүс 621
Кэ'үс 224
Кэшиктэн 361
Лиү шиү 598
Манагар 114
Мандутала 560
Мара'ан асахжу 425
Марийан 427
Махаижу 626
Махалаи-йин баулийа 618
Мина'атан 407
Митэрижү 219
Можирхахун 495
Можиу 585
Монгол жэ андахартан 145
Морин уну'атан
Модун нэмүрэтэн болбаи тэдэ 312
Мөкөри'үлтэкүн 246
Мөр Бэки 508
Мөсэлдүкүн 443
Мө'элэтжү 133
Мухули мушхули 649
Мухуритухаи 685
Мүсүд 17
Мэнгэтү Кийан 44
Мэнэ 40, 629
Мэр үдү'үи 206
Нажит 538
Наитагдан 105
Налуйитжу 56
Намбуха 110
Намгин 596
Насуда абалдурун 205
На'ур байиту байилдужу 405
Нахуд 670
Наху хуны 402
Нидуралу'а 78
Нидүн хара 239
Нийитаитала 613
Ниситухаи 442
Нитони 638
Нитулун 494
Ни'урхан 322
Ни'үдхүн 377
Ничүгүд ба'арин 243
Нобшилдужу 487
Нойалаху 680
Нохаи кэрэл кэрэжү йабужу 393
Нохану бидану хучахуи дау'ун ма'уи болбаи 371
Нохас 493
Нөгөжийин 327
Нөдүгсэн 589
Нөдүн 65
Нөкөр күмүнэ 250
Нунжи 588
Ну'у 480
Нэкүн 450
Нэлкэи 122
Нэмбүлэ 25
Нэмбэгэ 194
Нэндү хутух 489
Нэндэ'эсү 280
Нэткэл 557
Нэ'үкү харши 648
Нэ'үлэ 556
Огуга 363
Олирасун, Мойлсун 82
Онгжалдажу 490
Онгин Чингсанг 207
Онглажитхун 192
Онжитухаи 688
Онохса'ар 643
Онучи 331
О'орху 591
О'орчаг 258
Орбан 348
Оркидун 100
Орну'у 315
Оро-бан (х)охторху 138
Орожу абёиражу 181
Орочу 474
Орошин 689

Орхол 696
Отчикин (к)эликэтү 418
Охжатхайа 387
Өдүр шира да 564
Өлжигэ-дэ 8
Өлүг йасун
Өлүмлэгсэнү 491
Өлүмлэкү 703
Өлүмлэн 610
Өмэрэжү 549
Өндүт 272
Өрүг 617
Өрүг нута 521
Өрэ үлү жасажу 412
Өтөг 255
Өтөкүлэкүн 513
Өтэрмэлэжү 96
Ө'эдийэн 291
Са'ан арун 482
Саглагар модун 62
Сайи эри'үлсүн буйу би 504
Самбажу 95
Сариг хун 536
Сауха 162
Сача 399
Сачуба 144
Согог 261
Сойилух 328
Солжир ухаагч үнээ 177
Сона 245
Со'оражу 631
Со'ор-тур 271
Сохосун 90
Сөйү'эр 22
Сөлүстэй 83
Сөндэифү 572
Сө'эбэ 625
Сужийасу-бан шилүртэжү 234
Ёундурчу 576
Суталбижу 441
Сүдүн чичгин-э 85
Сүлбэркүи 401
Сүлдэр 67
Сүмэс 646
Сэгү'үлүн 391, 394
Сэнтэлбэ 240
Сэри'үтү'эсү 637
Сэсүд 652
Сэ'үсэ 666
Сэчэ бэки 43
Та'аралдутухаи 517
Табу'у 285
Табчиту 141
Тагтаи 332
Таки 55
Таихал 428
Таммачин 668
Тамтулутхун 197
Танглу 446
Тарги 113
Татар жүйин иргэн 47
Та'улжу 516
Тобича'уд 671
Тои 296
Тойасу 190
Тоиджу 220
Тойилан 170
Толи 320
Толох 369
Торлух 372
Торолун 410
Торо'ун 301

Тохура'ун 173
Төбөд 630
Төлгэ 463
Төлэд 690
Төридчү 385
Төриткэ'эсү 235
Төрүлмиши 373
Тугарун 23
Тугтан 299
Туйал 559
Тулбалба 661
Тулу 558
Тумбулан 302
Тумта'а 359
Тунгхун 684
Тунигсам 682
Тунхулдужу 164
Турастан 232
Туримтаи 108
Турух 283, 462
Турха'уд 381
Тусулчаба 148
Тутхара 39
Ту'урби'асу 541
Түбшин түгэл 669
Түбэжү 158
Түйиджү 555
Түикүи-түр 426
Түкэтэлэ 362
Түлижү 563
Түлэшилэн 269
Түн 45
Түн гуань 594
Түсүргэ түсүржүхэи 201
Түсүрү'эд 107
Түсүрчү 691
Тү'үшин 116
Түшижү 216
Тэб тэнгэри 548
Тэйилэ'үлжү о'орба 29
Тэлкэн 386
Тэмүр тэрэгэтү 432
Тэмхүлдүжү 28
Тэнгэли 125
тэргэ'үр 179
Улхун шилүгэлжид 251
Урийархун 527
Ухамсар 540
Уха'ута 131
Учума 309
Үб 411
Үдэ манахар 339
Үжү'үлэн 444
Үжэлдүгтүд 117
Үжэрэ 79
Үжэ'эсү 257
Үйилсүн хор 526
Үйэн 340
Үйэ хайа 15
Үкитала 80
Үлгэтэлэ 414
Үлигэ 492
Үлисчү 683
Үлкинчинкүн 268
Үлү а'улху 424
Үлүг таг 260
Үлү'ү 530
Үмүбү 129
Үмэкши 632
Үнэн 134
Үрүнгү 326
Үтү дүрү-йин кү'үн 382

Фү жиү 571, 586
Ха 590
Хаблан 97
Хабирха-та ха'улуха
Эбүдүк-тэ өлкэг болутала 63
(Х)агтарун 307
Хагчу 237
хада'ар 440
Хадалун 99, 552
Хадаха 692
Хад-ийар 512
Хайиругана 265
Хала 183
Хала'ар 581
Халбуга кэгэсүн 698
Халдут 274
Халжирхуйу 320
Халитун 455
Халхасун 137
Хамтутун бара'асу 389
Хан 468
Ханалха 208
Ханлин 431
Хан хан аху 264
Ханхас 46
Хантухалажу 608
Ханшитала 546
Харату 157
Хара'утай тэргэн 7
Харахана йорчил йорчижу 404
Хара халжид элэт 295
(Х)аран-а бү (х)абхари'улутхун 619
(Х)арану 408
Харанбаи 447
Хара'ун жидүн 346, 485
Харбучажу 434
Харгам 182
Хари шири 184
Харин 198
(Х)артан 599
Хартагидаи (харта'ад) 281
Хасаг тэргэн 68
Хасахба 37
Хатар 151
Хатихлиг ниру'ун 324
Хатун халхатан окид өчилтэн 69
Ха'улуйа 34
Ха'улуха 61, 87
(Х)а'улхатхун 438
Ха'уттала 49
Ха'учитба 273
Хахалдажу 453
Хахас 532, 547
Хахас алдалтан 697
Хахтажу 304
Хахунаг 605
Хачи 50
Хачидуд 673
(Х)ачиту 160
Хашин 247
(х)илухатхуйу 310
(Х)ирижэхүйү 329
(Х)ирмэс 390
Хо'а Марал 2
(Х)о'ара'асу 514
(Х)ожитала бүсэлэжү 81
(Х)ойимасчу 204
Хойинача босу'ад ирэби би 126
Хойир (л?)а'ут 88
Хокир 156
Хокиратала 147
Холбаран 616

Холайин хо'очаг
Ойирайин одор(л)а 193
Холухад 101
Хоморчу 378
Хонжийасун 189
Хонши'уд 30
(Х)онтужажу 553
(Х)онтучажу чимада харта'асу, (х)эрэкэи-йэн (х)охтолжу о'орсухаи 602
(Х)ончидутхун 515
(Х)о'ожитала 612
(Х)о'ошин 533
(Х)ораитала 611
Хору'улжу 604
Хо си вү 597
Хотулаху, чимарлаху 146
(Х)охторихан 351
(Х)охторхуи эрбэгэлжэ'үлжү 542
Хошилих 104
Хөл Баргужин төхөм 9
Хубури намбалис 53
Хугулжу 681
(Х)удан 528
Худалатугай 356
(Х)удару'асу 567
Хужиржү 72
(Х)ула'ан буха 543
(Х)ула'ан дэгэлэн 595
Хуладу 153
(Х)улалун 479
Хулухана жил 704
(Х)улхун 94
Хунар 155
(Х)уни дөлүсгэжү 319
(Х)унта'у 152
Хуран сара 705
Хура'улжу 592
Хура'улу'асу 582
(Х)урба датажу 575
Хурдун хуби 52
Хурумши 633
Хусуту шитү'эн
Нара(с)ту шитү'эн 210
Хутахлалдужу 421
Хучин 502
Хучижу 614
Хучи'атхун 437
Хучилис 54
Хүйтэн 228
(Х)үлүрикэ'үлтэлэ 388
(Х)үэкдэбэ 459
(Х)ү'үтүгэи 676
(Х)үнжи'ү байитала 422
Хүнжи'үлэ 31
Хүнши'уд 32
(Х)эйилү'эсү 218
Хэрисхэ 195
(Х)эр(л)үжү 118
(Х)э'үшийэжү көлчиркэмүи 583
Чаган шинхор 66
Чакирма'уд 403
Чалир 435
Чанханта'улун 395
Чаха 74
Чаха'ана сача'асу 288
Чахлаба 478
Часуту 642
Ча'ура'улбаи 445
Чигөрсүн 84
Чима 400
Чиматжу 544

Чимар 317
Чинар ину жэкэйирэкү 606
Чингис 186
Чинкүлтүгтү 165
Чисуту тонох 364
Чи'үн-түр үлижү 253
Чичу'а 92
Чо'орхад 636
Чорхан 163
Чөлгэ 574
Чөлэс 622
Чө'э буга 11
Чулулжа'ура 601
Чун 333
Чүб тусчу 430
Чүчүжү 659
Чэрби 174
Чэрбин 379
Шиба-йин сумуна 429
Шибүлгэр 59
Шики 609
Шил 383
Шилгинчэг 707
Шилгүтгэн 523
Шилжирин 522
Шили'үн 376
Шилтэсүтэи 524
Шилүгэд 102
Шилэгү 187
Шира тэг 577
Шира нохаи 21
Широлхада 13
Шисгис 231
Шиткүл 120
Шитү 275
Шитүлдүжү 233
Ши'эктэ 471
Шүдүртэ'эсү 276
Эбин 303
Эбчи'үн-дүр дайисурхан 677
Эбэртү үнүгүн чага'ан 169
Эбэрэтэлэ бэртэтэлэ 398
Эдэр Алтаи-йин бэлчир 270
Эжи'э 282
Эжи'э турух 486
Эйэтүлдүжү 35
Экит ану далбару 518
Элбэсүн жалама 311
Эмбүрү 143
Эмэгэ 457
Эмэ кү'үн нохаи ни'уртаи 367
Энггэшигэжү 679
Энэхэн Гүилэтү 226
Эригайа 639
Эрижэ'ү 640
Эрэбин 641
Эрэс хара 185
Эрэсчү 149
Эрэ'ү 499
Эсгэл 168
Эсэксэнэ 501
Этүгэнэ 159
Эчиткэйа 545
Э'эрэкүн 254



НОМ ЗҮЙ

С.М.Абрамзон, К.Характеристике шаманство в старом быту у Киргизов. "Краткие сообшения. Института этнографии АН.СССР", вып. 30, 1956.

/Алтан-Очир 1942/ "Монголын нууц товчоо", Орчуулсан хүн. Харчин баруун хошууны Алтан-Очирын Жүн Чин, Богд Чингис хааны 736-р оны 12-р сарын 15. Дармаллан гаргасан нь тэргүүн нөёны ордны дармалын газар.

Араднагарба (Ринжин), Арван хоёр сарын эртний монгол нэрийдэл, "Өвөрмонголын Их сургууль", Эрдэм шинжилгээний сэтгүүл. 1978, 1.

Асрагч (Жамба) нэртийн түүх, Хэвлэлд бэлтгэсэн Х.Пэрэнлэй, УБ.1961

Т.Д.Баялиева, Доисламские верования и их пережитке у Киргизов. Фрунзе, 1972

Баяр, "Монголын нууц товчоо" (Тэргүүн, дэд, гуравдугаар дэвтэр), Өвөрмонголын Ардын хэвлэлийн хороо, 1981

А.Бернштам, Социально-экономическии строй Орхоно-Енисейских тюрок YI-YII веков. Москва-Ленинград, 1946

Ш.Бира, Монгольская историография (XII-XYII вв) Ответственный редактор И.Я.Златкин, Москва, 1978

Ш.Бира, Монголын нууц товчооны тухай "Шинжлэх ухаан амьдрал", УБ.1990, №1

/Бөххишиг, 1941/ "Монголын нууц тууж", монголчилсон Бөххишиг, Дармаллан гаргасан монгол утга сургаалын хурал, Энх эрдэмтийн найдугаар он, 3-р сарын 20

/Булаг, 1989/ "Хаадын үндсэн хураангуй алтан товч", Булаг харьцуулан тайлбарлав. Өвөрмонголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1989

Х.Буянбат, Монголын бөөгийн шашны учир, Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо, 1985

Х.Буянбат, Нууц товчоон дахь саглагар модны шүтлэгийн нууц, "Өвөр монголын Багшийн Их сургууль, эрдэм шинжилгээний сэтгүүл", 1988, №4

/Буянхишиг, Бадам, 1982/ "Жангар", Буянхишиг, Д.Бадам эмхтгэв.

Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 1982
БНМАУ-ын түүх, Тэргүүн боть, (Нэн эртнээс 17-р зуун), редактор акад. Ш.Нацагдорж, УБ. 1966
Бүрэнбат, "Цээрээн цээжинд атугай, Бөөрөөн бөгсөнд атугай"-н тухай, Өвөрмонголын Их сургууль, 1990, №1

Б.Ванжил, Хөх түлхүүр, Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1987
/Бан Лин гүй, 1986/ 方齡貴. "元朝秘史通檢", 中華書局, 1986
Б.Я.Владимирцов, Образцы монгольской-народной словесности, Ленинград, 1926,
Б.Я.Владимирцов, Общественный строй монголов. Монгольский кочевой феодализм, Ленинград, 1934
Ш.Гаадамба, Нөхөр широлгад гэдэг үгийн учирт, Монгол судлалын III боть, 9-р дэвтэр, УБ , 1961
Ш.Гаадамба, Эрхий мэргэний домгийн учир, "Шинжлэх ухаан амьдрал" сэтгүүл, 1966, №3 (66-69)
Ш.Гаадамба, Нууц товчооны нууцаас, УБ, 1976
Ш.Гаадамба, "Сокровенное сказание" и проблема литературных связей, Литературные связи монголии, Москва, 1981
/Ш.Гаадамба, 1990/ "Монголын нууц товчоо", (Худам монгол бичгээр монгол бичиг утга судлалын үүднээс Шанжмятавын Гаадамбын төсөөлөн нягтлаж сэргээсэн сийрүүлгэ, эх тайлбар), УБ, 1990
Ш.Гаадамба, Д.Цэрэнсодном, Монгол ардын аман зохиолын дээж бичиг, ред. Акад. Ц.Дамдинсүрэн, УБ, 1978
/Гомбоева, 1890/ Сказания Бурят издано на средства. Д.Т.Гомбоева, Иркутск, 1890
Ч.Далай, Монголын бөө мөргөлийн товч түүх, "Угсаатны зүйн судлал", I боть, 5-р дэвтэр, УБ, 1959
Ч.Далай, Урт дурын хүн, "Өвөр монголын Нийгмийн шинжлэх ухаан", 1989, №1
/Дамдин/ "Сэржи дэвтэр" (Алтан дэвтэр), Төвд барын хэвлэл
А.Дамдинсүрэн, Монголын зэвсгийн товч түүх, УБ, 1990
Ц.Дамдинсүрэн, Монголын уран зохиолын тойм" (XIII-XIY зууны үе), УБ. 1957
Ц.Дамдинсүрэн, Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой, УБ.

1959 / Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1982 (Дахин хэвлэгдсэн)
Ц.Дамдинсүрэн, "Монголын нууц товчоо", ред. Ш.Гаадамба, УБ. 1976
Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв, "Орос-Монгол толь" нэмж зассан хоёр дахь хэвлэл, Ред. Ш.Лувсанвандан, УБ. 1982
/Ц.Дамдинсүрэн, 1986/ "Гэсэр" сонгомол эхийг боловсруулж, удиртгал тайлбар бичсэн акад. Ц.Дамдинсүрэн, УБ. 1986
Ц.Дамдинсүрэн, Монголын уран зохиолын өв уламжлалын асуудалд, 1, УБ. 1987
Ж.Дашдорж, Г.Ринченсамбуу, Монгол цэцэн үгийн далай, 1-р дэвтэр, эрхэлсэн Б.Содном, УБ. 1964
/Т.Дашцэдэн, 1985/ "Монголын нууц товчоо" галиглаж хөрвүүлсэн Т.Дашцэдэн, ред. Ц.Дамдинсүрэн, Н.Ишжамц, УБ. 1985
/Дов, 1983/ Уйгуржин монгол үсгийн дурсгалт бичгүүд, Дов эмхтгэж, одоогийн монгол үсгээр буулгаж, тайлбар хийв. Үндэсний хэвлэлийн хороо, 1983
Дорж Банзаров, Собрание сочинений. Ответственный ред. Г.Д.Санжеев, Подготовка к печати и примечания Г.Н.Румянцева, Москва. 1955
/Дорнотив, 1979/ 道潤梯步. "新譯簡注〈蒙古秘史〉", 內蒙古人民出版社, 呼和浩特, 1979.
/Дугаржав, 1939/ "Монголын нууц товчоо" (Нэгдүгээр дэвтэр), 68-р зүйл дуустал буулгав. Тусгай нэрийн хэлхээс хавсаргав. Хаттори Широ, Дугаржав, Токио. 1939 онд хэвлэв.
/Дугаржав, 1984/ "Монголын нууц товчоо"-ны харьцуулан хянасан дэвтэр, Харьцуулан хянасан нь Элдэнтэй, Оюундалай, буулгасан нь Хуацай Дугаржав, Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо, 1984
Ц.Жамцарано, Монгольские летописи XYII века, Труды Института востоковедения XYI. Москва-Ленинград, 1936
Ц.Жамцарано, Культ Чингиса в Ордосе. Из путешествия в южную Монголию в 1910 г. "Central asiatic journal" Vol. YI, Wiesbaden, 1961
Жигмиддорж, Урт, Амьтны зураг толь, Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1986
/Захчидсэцэн, 1979/ 札奇斯欽. "蒙古秘史新譯幷譯註釋", 臺灣, 聯經出版事業公司, 中華民國 六十八年 二月初版
В.Инжаннаши, "Хөх судар" (Тэргүүн дэвтэр) Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1957
/Иринжин, 1987/ "Монголын нууц товчоо" (Их Мянгадай Иринжиний

сэргээлт) , Өвөр монголын Их сургуулийн хэвлэлийн хороо, 1987
П.И.Кафаров, Старинное монгольское сказание о Чингис хане, Труды членов Российской духовной Миссии в Пекине, Том IY, Санкт Петербург, 1866
/Кливез, 1982/ "The Secret History of the Mongols" Translated and by F.W.Cleavis, London, 1982
О.Ковалевский, "Монголо-русско-французский словарь" Том I-III, Казань. 1844, 1846, 1849
С.А.Козин, "Сокровенное сказание" Монгольская хроника 1240 г. под названием Монггол-ун нигуча тобчийан Юань чао би ши - Монгольский обы - денный изборник, Том 1, Москва-Ленинград, 1941
Х.Г.Короглы, Трансформация жанра туйуг (К проблеме фольклорных связей тюркоязычных народов) "Типология и взаимосвязи фольклора народов СССР" Москва, 1980
/Левицки, 1964/ M.Lewicki. La Languae Mongole des transcriptions chinoises du XIY e Siecle Le Houa-yi Vi-yu de 1389, Wroclaw, 1949
/Ледяард/ G.Ledyard. The Mongol Campaigns in Korya and the Dating of the Secret History of the Mongols, CAJ. Vol. 9 1964
/Лигети/ L.Ligeti, A Mongolok titkos tortenete, "Mongol Nyellvemlékár" Budapest, 1964
/Ломи, 1989/ "Монголын Боржигон овгийн түүх" Ломи зохиов. Нагуйсайнхүү тулган харьцуулж тайлбарлав. Чойжи хянав. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 1989
Х.Лувсанбалдан, "Ачлалт ном"-ын тухай, Монголын судлал III боть, 12-р дэвтэр, УБ. 1961
Х.Лувсанбалдан, Монголын нууц товчоон дахь эвэрт үнэгэн цагааны тухай дахин өгүүлэх нь, "Өвөр монголын нийгмийн шинжлэх ухаан", 1989, 1 (73-75)
/Лувсанданзан, 1937/ "Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршвой", Монгол улсын Хорин долоон он, УБ
/Лувсанданзан, 1990/ "Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршвой", Оршил бичсэн Ш.Бира, УБ. 1990
А.Лувсандэндэв, Монгол-Орос толь, УБ. 1975
Д.Майдар, Л.Дарьсүрэн, Гэр (Гэр, орон сууцны түүхэн тойм), УБ. 1976

С.Е.Малов, Шаманский камень "яда" у тюрков западного Китая, Советская этнография, №1, 1947
/Мансаан, 1981. 2/ 滿昌. "蒙古秘史"成書年代考辨, "西北民族學院"
Мансаан, Шинээр орчуулж тайлбарласан "монголын нууц товчоо", Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1985
/Марко Поло, 1956/ Книга Марко Поло, перевод старо французского текста И.П.Минаева, ред. и вступ. Статья И.П.Магидавича, Москва 1956
/Мингийн магад тэмдэглэл/ "明實錄・太祖實錄", 中央研究院歷史語言研究所校印本, 第四冊, 2223-2224
Г.И.Михайлов, О.Некоторых параллелях в мифологи бурят и тюрских народов Сибири. "Мифология народов Якутии" Якутск, 1980
Монгол утгын Юань улсын нууц товчоо, (Дээд бүлэг), Богд Чингис хааны 735-р оны 6-р сарын нэгэнд дармалдав. (1941) Монголын утга соёлыг нарийвчлан нягтлах хороо. Үүнд эхний таван бүлгийг багтаажээ.
/Монгол хятад толь, 1976/ Нэмж засварласан дэвтэр, Хөх хот, 1976
/Мостарт, 1942/ A.Mostaert, Dictionnaire Ordos, -Monumenta serica, Monograph V. Peking, 1942
/Мостарт, 1949/ A.Mostaert, A props du mot sirolga de L'Histoire secr te des Mongols, –HJ of Asiatic Studies, Vol. 12, 1949
/Мостарт, 1959/ Sur quelques passages de L'Histoire secrite des Mongols, Harvard Yenchin Institute, 1953
/Муниева, 1977/ Кальмыцко-Русский словарь, под редакцией Б.Д.Муниева, Москва. 1977
Н.Ц.Мункуев, Эртний монголчуудын тухай тэмдэглэл, "Монгол-татаарууд Ази, Европд", УБ, 1984, (430-464 тал)
/Наделяев, 1969/ "Древнетюрский словарь" редакторы В.М.Наделяев, Д.М.Насилов, Э.Р.Тенишев, А.М.Шербак, Ленинград. 1969
Р.Нарантуяа, Монголын нууц товчоонд "хүргэдтээ талбих" ёс заншил тэмдэглэгдсэн тухай, "Аман зохиол судлал" YIII боть, 10-р дэвтэр, УБ. 1974 (115-122 тал)
/Норжин, Ман.Мөрөн, 1999/ "Монгол хэлний толь" эрхлэн найруулагч Ц.Норжин, Ман.Мөрөн, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1999
/Ошанин, 1955/ "Китайско-русский словарь" под редакцией проф. И.М.Ошанина, Москва, 1955
/Озава Шигэо, 1984, 1985, 1986, 1987, 1988, 1989/ 小澤重男."元朝秘史全釋"(上中下 1984, 1985, 1986), "元朝秘史全釋續(上中下 1987, 1988,

1989), 6 vols, 風間書房
/Панкратов, 1962/ "Юань-чао Би-ши (Секретная история монголов)" Том I, Текст. Издание текста и предисловия Б.И.Панкратова, М. 1962
/Пекарский, 1917/ "Словарь якутского языка", составленный Э.П.Пекарским, Издание императорской академий наук Петроград, 1917
Н.Н.Поппе, "Монгольский словарь Мукаддимат-Аль-адаб" Часть I-II, Труды института востоковедения, XIY, Москва-Ленинград 1938
/Н.Н.Поппе, 1955/ N,Poppe. Mongolische Volksdichtung, Wiesbaden, 1955
/Н.Н.Поппе, 1960/ Ein mongolische Gedicht aus den Turfan-Funden, CAJ, vol. 5, No.5, 1960
/П.Пеллио, 1944/ P.Pelliot. **Široi γ a -Širai γ a**, "T'oung pao", XXXVII,3-4, 1944
/П.Пеллио, 1949/ Histoire secrete des Mongols, (chapiter I-VI), Paris, 1949
/П.Пеллио, Л.Анбис, 1951/ P.Pelliot, L.Hambis. Histoire des campagnes de Gengis Khan, Leiden, 1951
/П.Пеллио, 1959/ Notes on Marco Polo, I, Paris, 1959
/Н.Потанин, 1919/ Монгольские сказки и прадния, Семиполатинс, 1919
/Поуха, 1956/ P.Pougha. Die geheime Geschichte der Mongolen als Geschtsquelle und Literaturden kmal, Prag, 1956
/ В.В Радлов, 1893-1911/ Опит словаря тюркских наречий,I-IY, Санкт Петербург, 1893-1911
/Рамсдет, 1974/ G.J.Pamstedt, Nordmongolische Volksdichtung, Bearbeitet, ьbersetzt und herausgegeben von Harry Halйn, Band II, Helsinki, 1974
/Рахевилз, 1971/ Igor de Rachewiltz. The Secret History of the Mongols, "Papers on far eastern History", 1971.4
/Рахевилз, 1972/ By Igor de Rachewiltz, Index to the Secret History of the Mongols, Bloomington, 1972
Б. Ринчен,Бурхан халдун гэгч үгийн тайлбар, "Шинжлэх ухаан",1944, №7
Б.Ринчен, Из культурного наследство Монголии,УБ, 1958
Б.Ринчен, 1959/ B.Rinchen. Les matérian pour I, étude de chamanisme mongol, - Asiatische Forschungen, Bd.3 und Bd.8, Wiesbaden, 1959
Б.Ринчен, Монгол бичгийн хэлний зүй, хоёрдугаар дэвтэр, УБ, 1966

/Сайшаал, "Чингис хааны товчоон" Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1987
Саган Сэцэн, "Эрдэнийн товч" хэвлэлд бэлтгэсэн Ц.Насанбалжир, УБ. 1960
/Х.Сампилдэндэв, 1984/ "Монгол домог" эмхтгэн боловсруулж, удиртгал тайлбар бичсэн Х.Сампилдэндэв, ред. Д.Цэрэнсодном, УБ. 1984
Э.В.Севортян, "Этимологический словарь тюрских языков" Москва, 1974
/ Смидт, Мостарт, 1933/ Dictionnare Monguer-Francais par A De Smedt, A.Mostaert, Pei-p'ing, 1933
Солонгуудын Л.Хурцбаатар, "Хатагин арван гурван атаа тэнгэрийн тайлга" Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо, 1986
/Сумадирадnaa, 1959/ Sumatiratna. Bod-Hor-gyi brda yig min chigl don gsum dsal bar byed-pa'i munsel sgron me, Ulaanbaatar, 1959
Б.Сумъяабаатар, "Монгол хэл, утга зохиол, аман зохиолын ном зүй" 1. Монгол хэл, УБ. 1972
Б.Сумъяабаатар, "Монголын нууц товчооны галиг", УБ. 1990
Г.Сүхбаатар, "Монголчуудын эртний өвөг", УБ.1980
Г.Сүхбаатар, "Сяньби нарын угсаа гарал, соёл, аж ахуй, нийгмийн байгуулал (Нэн эртнээс МЭ-ий 4-р зуун)" УБ. 1971
И.В.Стеблева, "К вопросу о происхождений жанра туюг" / Тюркологический сборник/ Москва, 1970
/Сэцэнцогт, 1988/ "Монгол үгсийн язгуурын толь" Сэцэнцогт найруулав. Ринчингаваа, Соёлт хянав. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1988
/Таубе, 1989/ Die geheime Geschichte der Mongolen, Übersezt und herausgegeben von M.Taube, Leipzig, 1989
С.П.Толстов, Пережитки тотемизма и дуальной организации у Туркмен- проблеми истории докапиталистических обшеств, 1935, №9-10
/Токарев, 1980/ "Мифы народов мира" Том 1, Главный ред. С.А.Токарев, Москва, 1980
Ж.Төмөрцэрэн, "Далан тохоот бучалхажу гэдэг хэллэгийн учир", / Монголын нууц товчооны 750 жилийн ойд зориулсан олон улсын бага хурал/ I, Ерөнхий ред.Ш.Бира, УБ. 1995

Үлгэрийн далай, Ширээт гүүш Цорж орчуулав. Эрхэмбаяр харгъцуулан буулгаж тайлбарлав. Үндэсний хэвлэлийн хороо, 1986
/Хайссиг, 1982/ Die Geheime Geschichte der Mongolen, Herausgegeben von W.Heissig, 1982
Ц.Хандсүрэн, "Цэнд гүн ба Монголын нууц товчоо", УБ, 1997
/Хишигбат, 1941-1942/ Хишигбатын орчуулсан "Юань улсын нууц товчоо" Хөх хот дахь монголын утга соёлыг нарийвчлан нягтлах хороо, Богд Чингис хааны 736-р оны 12-р сарын нэгэнд дармаллав. (1942)
Ц.Хишигтогтох, "Эртний монгол шүлгийн түүвэр" Хишигтогтох сонгон тайлбарлав. Өвөрмонголын багачууд, хүүхдийн хэвлэлийн хороо, 1985
Ц.Хишигтогтох, "Монгол хятадаар зохиогдсон монголын судлалын бүтээлүүдийн тойм" /Монгол хэл бичиг/ 1987, №5 (46-55), 6 (41-50), 7 (50-57), 8 (70-78), 9 (38-45), 10 (47-54), 11 (37-46), 12 (51-56), 1988 №1 (48-55)
Ц.Хишигтогтох,,"Монголын эртний уран зохиолын судлал" Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо, 1988
Ц.Хишигтогтох, "Монголын нууц товчооны барын хэвлэлийн товч түүх", Өвөр монголын багшийн их сургууль, 1988, 4 (21-33)
Хун Шигм, (Иринжин?) "Зад" Өвөр монголын Их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 1978, №1
/Хураангуй Алтан товч, 1980/ "Хаадын үндсэн хураангуй алтан товч", Хөх хот, 1980
Хүрэлшаа, Илбэт чулуу задыг өгүүлэх нь, "Өвөр монголын Их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл ", 1989, 1
Хүүдагуул, Монголчуудын саглагар модны шүтлэг, "Өвөр монголын Багшийн их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл ", 1986, 4
/Хэниш, 1948/ E.Henisch. Die geheime Geschte der Mongolen, Lepzig, 1948
/Хэниш, 1962/ E. Henisch Wörterbuch zu Manghol un niuca tobca'n (yuan-ch'ao pi-shi), Wiesbaden, 1962
Хятад монгол толь (Нэмж засварласан дэвтэр), Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1983
/Хятадын түүхийн их толь, 1986/ 中國歷史大辭典, 上海辭書出版社,
/Цай Меи Био, 1983/蔡美彪.纪與纪軍之演變,"元史論叢",第二期, 中華書局
/Цинциус, 1975/ "Сравнительный словарь Тунгусо-маньчжурских языков" Материалы к этимологическому словарью, Том I, Ответственный ред. В.И.Цинциус, Ленинград, 1975
/Ци Хай/ 辭海, 下冊, 上海辭書出版社, 1979
/Цолоо, 1982/ "Монгол ардын баатарлаг тууль" эмхтгэж хэвлэлд бэлтгэсэн Ж.Цолоо, УБ. 1982
Цолоо, "БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг" I. Ойрд аялгуу, ред. Х.Лувсанбалдан, УБ. 1988
Я.Цэвэл, "Монгол хэлний товч тайлбар толь", ред. Х.Лувсанбалдан, УБ. 1966
Д.Цэрэнсодном, "14-р зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр" ред. Ц.Дамдинсүрэн, УБ. 1969
/Д.Цэрэнсодном, 1981/ Ein mongolisches gedichtfragment über die Prajnaparamita aus der Berliner Turfansammlung, Altorientalische Forschungen, VII, Berlin, 1981
Д.Цэрэнсодном, "Дува-Сохорын домог ганц нүдэт аварга амьтны тухай өгүүлэмжтэй холбогдох нь" ШУА-ийн мэдээ, 1983, №2
Д.Цэрэнсодном, "Хан Харанхуй туулийн нэрийн гарал үүслийн асуудалд" /ШУА-ийн мэдээ/, 1984, №2
Д.Цэрэнсодном, "Монголын нууц товчоо"-н доторхи домог үлгэрийн зарим нэгэн ойлголтын тухай, Өвөр монголын багшийн их сургууль, 1988, 4 (5-12)
Д.Цэрэнсодном, "Бөөрөө бөгсөнд, цээрээ цээжинд атугай" /Ардын эрх/ , 1990. №71
/Д.Цэрэнсодном, 1987/ Zur frage des Titles der mongolischen Epen, Fragen der mongolischen Heldendichtung, Teil. IV, Wiesbaden, 1987
Д.Цэрэнсодном, "Монгол ардын домог үлгэр", УБ, 1989
Д.Цэрэнсодном, "Монголын нууц товчооны хятад хадмал орчуулгад орхигдсон үг хэллэгийн учир", Монголын судлалын бичиг, УБ, 1991
/Чен Иүэн, 1982/ 陳垣學術論文集, 第二集, 陳垣撰, 中華書局, 1982
К.М.Черемисов, "Бурятско-русский словарь", Москва, 1973
Ч.Чистохин, "Сохор-Ноин, местное предание Тункинских бурят- Известия Вост. Сиб. отд. русс. геогр. обшества, Том XXY, №1-3, 1895
/Чой Ки-ху, Нам Санг-гиг, Пак Вонь- кил, 1997/최기호, 남상긍,박원길 공역, "몽골비사역주(1) ", 두솔, 서울(Seoul), 1997
Ц.Шагдарсүрэн, "Монголын нууц товчооны тоног гэдэг үгийн учир" Хэл зохиол судлал, YIII боть, 9-р дэвтэр, УБ. 1970
Шагж, "Монгол үсгийн дүрмийн толь бичиг" УБ, Монгол улсын хорин

долоон он, (1937)
Шагж, найруулан зохиов. "Монгол үгний тайлбар толь", Монгол улсын соёлын сан, Дундад улсын үндэсний хэвлэлийн хороо, 1994
Н.О.Шаракшинова, "Мифы Бурят", Иркутск, 1982
/Ши Ши-же/ 施世杰. "元秘史山川地名考", 青・光緒年間 (проф. Хуан Зун Жаны номын санд буй)
/Элдэнтэй, Оюундалай, 1980/ 額尓登泰，烏云達來. "蒙古秘史校勘本" 內蒙古人民出版社，1980
/Элдэнтэй, Оюундалай, Асралт, 1981/ 額尓登泰，烏云達來，阿薩拉圖著，"<<蒙古秘史>>詞匯選釋"，內蒙古人民出版社，1981·
/Элдэнтэй, Оюундалай, Асралт, 1991/ /Элдэнтэй, Оюундалай, Асралт нар зохиов. Ардаажав, Сэцэнгуа монголчлов. "Монголын нууц товчооны зарим үгсийн тайлбар" Үндэсний хэвлэлийн хороо, 1991
/Элдэнтэй, Ардаажав, 1986/ "Монголын нууц товчооны сийрүүлэл, тайлбар", Элдэнтэй, Ардаажав нар сийрүүлэн тайлбарлав. Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1986
Юань улсын судар, /Монгол улсын төв номын сангийн бичмэл номын хөмрөг (Дандаа Чинсангийн орчуулга)/
/Якобсон,1977/ "Мифологии древного мира", перевод с английского Отв. Редактор В.А.Якобсон, Москва, 1977





ДАЛАНТАЙН ЦЭРЭНСОДНОМ

Сүхбаатар аймгийн Халзан сумын "Ар булаг" хэмээх газар төрсөн. Монгол Улсын ШУА-ийн жинхэнэ гишүүн, хэлбичгийн ухааны доктор, профессор. 1962 онд МУИС-ийг төгсөж, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнд 37 жил ажиллаж байна.

1972 онд Оросын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнд дэд эрдэмтний, 1983 онд БНАГУ-ын Хумбольдтын Их сургуульд докторын зэрэг хамгаалж, 1997 онд профессор, 1998 онд ШУА-ийн жинхэнэ гишүүнээр сонгогджээ.

Академич Д.Цэрэнсодном "XIY зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр" /1969/, "Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал" /1978/, "Монголын уран зохиол" /1987/, "Берлин хотын Турфаны цуглуулгын монгол бичиг" /М.Таубен хамт, 1993/, "Монголын нууц товчооны орчуулга, тайлбар" /1993/, "Монголын бурханы шашны уран зохиол" /1997/ зэрэг судалгааны ганц сэдэвт зохиол, сурах бичиг зэрэг хориод ном, 100 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэлийг өөрийн оронд болон гадаадад нийтлүүлжээ. Д.Цэрэнсодном нь иргэний болон шашны уран зохиолын хоймсон бүтээлээрээ 1998 онд Монгол Улсын төрийн шагнал хүртсэн юм.